



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (346)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай*
- *Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны дөрөвдүгээр сарын 6 №13 (346)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

153. Жөн Мон Гү-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай — Дугаар 25 — 254

154. Леонид Васильевич Потаповыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай — Дугаар 26 — 254

155. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай — Дугаар 29 — 254

156. Дагвын Бадамд хошууч генерал цол хүртээх тухай — Дугаар 35 — 255

157. Гүрийн Рагчаад хошууч генерал цол хүртээх тухай — Дугаар 36 — 255

158. Журам батлах тухай — Дугаар 37 — 255

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

159. Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай — Дугаар 34 — 256

160. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай — Дугаар 36 — 258

161. Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай — Дугаар 37 — 269

162. Хөрөнгө гаргах тухай — Дугаар 38 — 271

163. Тогтоолд нэмэлт оруулах тухай — Дугаар 39 — 271

164. Мөнгөн төлбөрийн суурь хэмжээг тогтоох тухай — Дугаар 40 — 271

165. Хөрөнгө гаргах тухай — Дугаар 41 — 272

166. Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай — Дугаар 42 — 272

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 25** | **Төрийн ордон. Улаанбаатар хот**

Жөн Мон Гү-г "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын эдийн засаг, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын иргэн, "Хендэ-Киа" группийн эзэн Жөн Мон Гү-г "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 26** | **Төрийн ордон. Улаанбаатар хот**

Леонид Васильевич Потаповыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцааг бэхжүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Ерөнхийлөгч Леонид Васильевич Потаповыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 4-ний өдөр | **Дугаар 29** | **Төрийн ордон. Улаанбаатар хот**

Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтыг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1. Зөвлөлийн бүрэлдэхүүнд "Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга", "Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга" гэж шинээр нэмэх.

2.Зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаа "Төрийн хяналт шалгах хорооны ерөнхий нарийн бичгийн дарга" гэснийг "Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч", "Хилийн цэргийг удирдах газрын дарга" гэснийг "Хил хамгаалах ерөнхий газрын дарга", "Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн захирал" гэснийг "Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийн захирал", "Монголын залуучуудын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга" гэснийг "Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч" гэж тус тус өөрчлөх.

Хоёр. Мөн зарлигийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.Журмын "Нийтлэг үндэслэл" бүлэгт "9.Зөвлөл нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад жил бүр тайлагнаж байна" гэж, "Зөвлөлийн үүрэг, эрх" бүлэгт "6.Зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4-т заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийн тэргүүн түшмэл байна." гэж, "Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай" бүлэгт "4.Засгийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль, бусад хууль, Улсын Их Хурал, Засгийн газраас батлагдан хөтөлбөрүүдэд заасны дагуу эдгээр хууль, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Зөвлөлийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ" гэж тус тус шинээр нэмэх.

2.Журмын "Нийтлэг үндэслэл" бүлгийн 7-д "албан бичгийн хэвлэмэл хуудас" гэснийг дараа "тамга" гэж, "Зөвлөлийн үүрэг, эрх" бүлгийн 2 дахь

хэсгийн 4-т "Шаардлагатай гэж үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн зарим хэсгийг Зөвлөлийн мэдэлд төвлөрүүлж, улсын хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хенгөрүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнд зарцуулах;" гэж, мөн бүлгийн 4 дэх хэсгийн "в"-д "Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих" гэсний дараа "холбогдох асуудлаар захирамж, албан даалгавар гаргах;" гэж тус тус нэмэх,

3.Журмын "Зөвлөлийн үүрэг, эрх" бүлгийн 4 дэх хэсгийн "б" -г "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлийн 1-д заасны дагуу Зөвлөлийн ажлын албаны бүтэц, нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний санхүүжилтийн хэмжээг тогтоож, эрхлэх асуудлын хүрээнийяам, агентлаг, байгууллагуудын орон тоо, цалингийн сангийн хязгаарт багтаан орон тоог нь зохицуулах, албаны дүрэм, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, албаны дарга, ажилтныг томилох, чөлөөлөх" гэж; "Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн тухай" бүлгийн 3-ыг "Зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг Засгийн газрын Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнийтөсвийн багцад жил бүр бие даалган төлөвлөж, санхүүжүүлнэ. Хууль зүй, дотоод хэргийн яам Зөвлөлийг ажлын байраар хангаж, ажлаа хэвийн явуулах бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлнэ" гэж; "Аймаг, нийслэл, сум дүүргийн салбар зөвлөл" бүлгийн 4-ийг "Орон нутгийн салбар зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгайлан тусган санхүүжүүлж байна. Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг тухайн ИТХ, Засаг даргын Тамгын газрын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ" гэж тус тус өөрчлөх.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 35** **Төрийн ордон. Улаанбаатар хот**

Дагвын Бадамд хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, Ар талын газрын дарга Дагвын Бадамд хошууч генерал цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 36** **Төрийн ордон. Улаанбаатар хот**

Гүрийн Рагчаад хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, Энхийг сахиулах ажиллагааны газрын дарга Гүрийн Рагчаад хошууч генерал цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙЧ ЗАРЛИГ

2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 37** **Төрийн ордон. Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэргийн дээд цол олгох ёслолын журмыг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 37 дугаар зарлигийн хавсралт

ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

НЭГ. Ерөнхий заалт

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээсэн цэргийн дээд цолыг олгохдоо энэ журмыг баримтлана.

2. Цэргийн дээд цол олгох ёслолыг Төрийн ордны "Соёмбо" танхимд гүйцэтгэнэ.

3.Цэргийн дээд цолны батламж бичиг, мөрдэсийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч гардуулна.

4. Цэргийн дээд цол олгох ёслолд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчийн цэргийн бодлогын зөвлөх, цэргийн дээд цол хүртэгчийн шадар захирагч /дарга/ байлцана.

Хоёр. Ёслол үйлдэх журам

5.Цэргийн дээд цол хүртэж буй офицер цэргийн ёслолын дүрэмт хувцастай цол олгох ёслол үйлдэх танхимд хүрэлцэн ирнэ.

6. Цэргийн дээд цол хүртээх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтан уншина.

7.Зарлиг уншсаны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч генерал цол хүртээсэн батламж бичгийг, генерал цолны мөрдэсийн хамт цэргийн дээд цол хүртэгчид гардуулж, баяр хүргэнэ.

8. Цэргийн дээд цол хүртэгч Монгол Улсын Ерөнхийлөгчид цэргийн дүрэмд заасны дагуу талархал илэрхийлнэ.

9. Цэргийн дээд цол хүртэгч генералын ёслолын дүрэмт хувцаа өмсч, цэргийн дээд цол хүртсэн тухайгаа Ерөнхийлөгчид илтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 34** **Улаанбаатар хот**

Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17, 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бий болсон цагийн байдалтай уялдуулан гамшгийн хор уршгийг арилгах, голомт тэлэхээс урьдчилан сэргийлэх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Гамшигтай тэмцэх комиссын ажиллах журмыг 1 дүгээр хавсралт ёсоор батлуулсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтыг 2 дугаар хавсралт ёсоор өөрчилж, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 166 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХОДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

Засгийн газрын 2004 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гамшигтай тэмцэх комисс /цаашид комисс гэх/-ооос хэрэгжүүлж буй гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

2. Комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

3. Комиссын үйл ажиллагаа нь Ерөнхий сайдын шийдвэрээр эхэлж гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч дуусган үр дүнг Ерөнхий сайдад илтгэснээр дуусгавар болно.

4. Комиссыг эрхлэх ажлын хүрээнд нь гамшиг болсон сайд даргална.

5. Комисс нь гамшгийн цагийн байдалтай холбоотой асуудлыг хэлэлцэж олонхийн саналаар шийдвэр гаргана. Шийдвэр нь протоколын хэлбэртэй байна.

Хоёр. Комиссын бүрэн эрх

6. Комисс дараахь үүргийг гүйцэтгэнэ:

6.1. Гамшгийн цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээ, ажиллах техник хэрэгсэл, материалын болон мөнгөн хөрөнгийн асуудлаар санал, төсөл боловсруулж Ерөнхий сайдад танилцуулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

6.2. Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах;

6.3. Гамшгийн цагийн байдлын талаар төр, засгийн удирдлагад шуурхай мэдээлэх, тэдний өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх.

7. Комисс дараахь эрхтэй байна:

7.1. Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, иргэдийг зохих хууль тогтоомжийн дагуу татан оролцуулах;

7.2. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгааг гаргуулан авах;

7.3. Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

Гурав. Комиссын чиг үүрэг

8. Комисс нь гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулахдаа дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. Гамшгийн цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

8.2. Хорио цээрийн дэглэмийг сахиулах, харуул, хамгаалалтын ажлыг зохион байгуулах;

8.3. Гамшгийн голомтод ажиллах бүрэлдэхүүнийг тогтоож, дэд бүтцийн асуудлыг зохих байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж, зохицуулах;

8.4. Гамшгийн голомт, түүний орчинд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

8.5. Нэрвэгдэгсдэд туслах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, зохицуулах;

8.6. Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зохих журмын дагуу төэврийн хэрэгсэл, ажиллах хүчийг дайчлан гаргах ажлыг зохион байгуулан зохицуулах, байршуулах;

8.7. Шаардлагатай гэж үзвэл гамшгийн голомттой харилцах дундын цэгийг байгуулах, гамшгийн голомт болон түүний орчны бүсэд ажиллаж байгаа хүмүүс, автомашин, техникийн хангалт, үйлчилгээний асуудлыг шийдвэрлэж зохион байгуулах, зохицуулах.

Дөрөв. Бусад

9. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг Гамшгаас хамгаалах ерөнхий газраас гаргасан тооцоог үндэслэн гамшгийн эрсдэлийн сангаас санхүүжүүлнэ.

Засгийн газрын 2004 оны 34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	- Эрхлэх ажлын хүрээнд нь гамшиг болсон сайд
Орлогч дарга	- Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга
Гишүүд	- Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх улсын албаны дарга; - Эрүүл мэндийн улсын албаны дарга; - Хүнс, хөдөө аж ахуйн улсын албаны дарга; - Дэд бүтцийн улсын албаны дарга; - Хэв журам сахиулах улсын албаны дарга; - Суртalчилгаа, мэдээллийн улсын албаны дарга; -Цацрагийн аюулаас хамгаалах улсын албаны дарга; - Мэргэжлийн хяналтын улсын албаны дарга; -Газрын улсын албаны дарга; - Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; - Нийслэлийн Засаг даргын орлогч; - Нутаг дэвсгэр дээр нь гамшиг болсон аймаг, сумын Засаг дарга;
Нарийн бичгийн дарга	- Гамшгаас хамгаалах ерөнхий газрын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 36** **Улаанбаатар хот**

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж, хөгжүүлэх уралдаант шалгаруулалтын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээ"-г 1 дүгээр, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Тендерийн зар мэдээг дотоод, гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж сурталчлах, холбогдох хууль тогтоомж болон энэ тогтоолоор батлагдсан журмын дагуу тендерийг зохион байгуулж явуулах, тендерт ялсан стратегийн хөрөнгө оруулагчтай тендерийн баримт бичигт заасан болзол, нөхцөлийн талаар харилцан тохиролцож менежментийн гэрээ байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2004 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР МЭДЭЭ

Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг үндэслэн үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний (казиног оролцуулан) гэсэн үндсэн 3 хэлбэрээс бүрдэх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчдыг олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалт (цаашид "тендер" гэх)-д Монгол Улсын Засгийн газар урьж байна.

Тендерийг Засгийн газрын энэхүү тогтоолоор батлагдсан "Уралдаант шалгаруулалт (тендер)-ын журам"-д тусгагдсан болзол, нөхцөлийн

дагуу Үйлдвэр, худалдааны яамнаас зохион байгуулж явуулна.

"Замын Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн байршил

Чөлөөт бүс нь Улаанбаатараас 780 км, Дорноговь аймгийн төв Сайншандаас 230 км, БНХАУ-ын Эрээн хотоос 8 км-т орших Монгол Улсын өмнөд хилийн байгийн ажиллагаатай боомт Замын-Үүд тосгоны нутаг дэвсгэрт байрлана.

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн тухай

"Замын-Үүд" нь 47.8 мянган га нутаг дэвсгэртэй, 7000 орчим хүн амтай Монгол Улсын урд хил дээр оршдог хилийн боомт тосгон болно. Замын-Үүдээр олон улсын галт тэрэг дайран өнгөрдөг бөгөөд, ачаа бараа, шингэн түлш шилжүүлэн ачих орчин үеийн сэлгээний станцтай. Уг тосгонд өдерт 2000 хүн, 300 автомашин нэвтрэх хүчин чадалтай хилийн иж бүрэн цогцолбор, тоон системийн сансарын холбоо болон шилэн кабель, авто болон төмөр зам, холбоо мэдээлэл, эрчим хүчний хангамж зэрэг дэд бүтэц харьцангуй сайн бүрдэж байгаа. Монгол Улсын эдийн засгийг БНХАУ, улмаар Азийн орнуудтай холбосон тээвэр-газар зүйн тохиромжтой байрлалтай, манай орны гадаад худалдаа, зорчигч тээврийн зонхилох хэсгийг нэвтрүүлдэг гол боомт тул чөлөөт бүс байгуулах үндсэн нөхцөл бүрдсэн гэж үзэж болно.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуульд "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс нь үйлдвэрлэл, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний гэсэн үндсэн 3 хэлбэртэй байхаар тусгагдсан. Хэлбэр тус бүрт үйлдвэрлэл, үйлчилгээний дараахь чиглэлийг бариманд ажиллах юм. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн хэсэгт

Усны хэрэглээ багатай, байгаль орчинд халгүй, ялангуяа хөрсний эвдрэлд нөлөөлөхгүй үйлдвэрлэлийг байгуулж хөгжүүлнэ. Тухайлбал гадаадын пүүс, компанийн захиалгаар аудио, видео тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, цахим төхөөрөмж угсрах үйлдвэрүүд, экспортын чиг баримжаатай оёмол, сүлжмэл болон модон эдлэл, бэлэг дурсгалын зүйлийн үйлдвэрлэл гэх мэт.

2. Худалдааны хэсэгт

Биржийн арилжаа, үзэсгэлэн-худалдаа зонхилон эрхлэх худалдааны цогцолбор байгуулах бөгөөд бараат ангилж савлах, сав баглаа, боодлыг сайжруулах нэмэгдэл үйлчилгээ үзүүлнэ. Худалдааны хэсэгт банк, санхүүгийн байгууллага, холбоо мэдээллийн төвийг байгуулах.

3. Аялал жуулчлал-үйлчилгээний хэсэгт

Аялал жуулчлалын бааз, зочид буудал, ресторан, кафе, түргэн хоолны газар, мини гольфын талбай, морин уралдааны талбай, тэмээн поло, казино байгуулах, шоу бизнесийг хөгжүүлэх зэрэг төслийг хэрэгжүүлэх.

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх

Тендерт оролцохыг хүссэн сонирхогч "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний хэлбэрүүдийг иж бүрнээр байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэхээр тендерт саналаа ирүүлж болно. Стратегийн хөрөнгө оруулагч нь эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх мастер төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт дэд бүтцийн барилга, байгууламжийг барьж байгуулах үүрэг хүлээнэ.

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох хүсэлтэй этгээд /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг англи эсхүл монгол хэл дээр дараахь материалын хамт Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ. Үүнд:

1. Өргөдөл;

2. Зохих журмын дагуу үйлдэж, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ;

3. Бүцааж төлөгдехгүй нөхцөлтэй 1000 / нэг мянган/ ам.долларын тендерийн хураамж төлсний нотлох баримт;

4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг баталгаажуулсан итгэмжлэл;

5. Өргөдөл гаргагчийн тухай танилцуулга.

Үүнд дараахь зүйлийг оруулсан байх шаардлагатай:

- Тендерт оролцох сонирхлоо илэрхийлж байгаа компанийн албан ёсны нэр, хаяг

болон үйл ажиллагааны талаархи танилцуулга /консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,

· Эдийн засгийн чөлөөт бүсийн болон тухайн бизнесийн үйл ажиллагааны талаар түршлага хуримтлуулсныг батлах мэдэгдэл,

· Тендерт оролцож байгаа компанийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд,

· Санхүүгийн сүүлийн 3 жилийн эцсийн байдлаар гаргаж, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл буюу нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан сүүлийн жилийн тайлан /энэхүү мэдээллийг консорциумд оролцож байгаа компани тус бүрээр гаргаж өгнө/,

· Өргөдөл гаргагч компанийн нийт гаргасан хувьцааны 5 /тав/-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн жагсаалт / консорциумаар оролцож байгаа тохиолдолд энэхүү мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргаж өгнө/,

· Тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ, гаргасан шийдвэрийн баталгаа.

Өргөдөл болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг интернет дахь Үйлдвэр, худалдааны яамны www.mit.pmis.gov.mn вэб хуудаснаас буюу энэхүү зар мэдээнд бичигдсэн хаягаар авч болно.

Тендерийн хураамжийг Монгол банк дахь Үйлдвэр, худалдааны яамны дараахь дансанд төлнө.

Банкны нэр :	Монгол Улсын Монгол банк
SWIFT код :	BOMUMNUB
Дансны нэр :	Үйлдвэр, худалдааны яам
Дансны дугаар :	3309001
Монгол банкны харилцагч банк :	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код :	FRNYUS33
Дансны нэр :	Монгол банк
Дансны дугаар :	021088506

Өргөдөл гаргагч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тохиолдолд түүний төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд тэд эвхэн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Тендерт оролцох хүсэлтээ илэрхийлсэн өргөдлийг 2004 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 16.00 цаг (Улаанбаатарын цагаар)-аас өмнө Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ.

Урьдчилан шалгаруулалтын шалгуур

Өргөдөл гаргагч нь тендерт оролцох эрхтэй болж, тендерийн баримт бичгүүдийг хүлээж авахын тулд компани, эсхүл тэдгээрийн оролцоотой консорциум байхын зэрэгцээ дор дурдсан шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Эдийн засгийн чөлөөт бүсийн менежментийн арга барил зэммшсэн, чөлөөт бүсэд тухайн бизнесийн чиглэлээр тав /5/-аас доошгүй жил ажиллаж тодорхой туршлага хуримтлуулсан байх;

2. 150.0 /нэг зуун тавин/ сая ам.долларааc доошгүй өөрийн хөрөнгөтэй байх;

3. Санхүүгийн байдал нь тогтвортой; үйл ажиллагааны туршлагатай байх /үүнийг аудитаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/.

Урьдчилан шалгаруулалтын үр дүнг мэдэгдэх

Үйлдвэр, худалдааны яам өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 /арван/ өдөрт багтаан урьдчилан шалгаруулалтын шалгуурыг хангаж тендерт оролцох болж, тендерийн баримт бичгүүдийг авах эрхтэй болсон эсэх талаар өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдлийг бичгээр үйлдэн буухиа шуудан, баталгаат шуудан, факс буюу электрон шуудангаар явуулна.

Урьдчилан шалгаруулалтын шалгуурыг хангасан оролцогдод тендерийн баримт бичгүүдийг мэдэгдлийн хамт буухиа шуудангаар хүргүүлнэ.

Тендерийн баримт бичгүүд

Тендерийн баримт бичиг гэдэгт дараахь иж бүрдлийг ойлгоно:

1. Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам;
2. Ерөнхий мэдээлэл;

3. Менежментийн гэрээний төслийн иж бүрдэл.

Тендерийн зорилго

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд хөрөнгө оруулах сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагч Засгийн газраас дэвшүүлсэн дор дурдсан зорилтыг тусгасан бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай. Үүнд:

1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орчин үеийн чөлөөт бүсийн жишиг хүргэж Монгол Улсын төвийн бүсийг хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүхий бүс болгоход хувь нэмэр оруулах замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд нөлөөлөх.

2. Дэлхийн өндөр хөгжилтэй үйлдвэрлэл, технологийн чиглэлээр төрүүлэгч орнуудтай худалдаа, аялал жуулчлалын болон үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт харилцан ашигтай хамтын ажиллагаагаа хөгжүүлж "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орос, хятадын хоёр том зах зээлийг холбосон худалдааны томоохон гүүр болгох, улмаар Зүүн Өмнөд Азийн орнуудын зах зээлд нэвтрэх гол гарцын нэг болгох.

3. Экспорт, импортын зохистой харьцааг хадгалах, гадаад худалдаагүр ашигтай хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх замаар улс орны зах зээлийн хангамж нийлүүлэлтийг сайжруулах.

Тендерийн ажиллагаа

Тендерт оролцогчид нь тендерийн саналаа тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 16.00 цаг (Улаанбаатарын цагаар)-аас өмнө Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлнэ.

Тендерийн дэнчин нь 500000 /таван зуун мянган/ ам.доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламж байна. Тендерт оролцогчид дэнчинг Монгол Улсын Монгол банк дахь Үйлдвэр, худалдааны яамны 3309001 дугаартай валютын дансанд төлнө.

Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг /дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заасан/ тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын 7 /долоо/ өдөрт багтаан бүрэн буцаан олгоно.

Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн дэнчинг үйл ажиллагаагаа эхэлсний дараа түүний хүсэлтийн дагуу ажлын 7 (долоо) өдөрт багтаан Монгол Улсын аль нэг арилжааны банкинд нээсэн валютын харилцах дансанд нь шилжүүлнэ.

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендерт оролцогчдыг Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон эдийн засгийн чөлөөт бүсийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана. Тендерт оролцогчдыг менежментийн гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах бололцоогоор хангана.

Тендерийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдээр шалгаруулна:

1. Эдийн засгийн чөлөөт бүсэд болон тухайн бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, нэр хүнд, бизнесийн ур чадвар;

(0-30 оноо)

2. Санал болгож байгаа бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, түүнд Засгийн газраас дэвшүүлсэн зорилтыг хүлээн авч тусгасан байдал;

(0-25 оноо)

3. Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын практикийг хэрэгжүүлэх амлалт;

(0-10 оноо)

4. Хөрөнгө оруулалтын санал

(0-35 оноо)

Нийлбэр дүнгээр хамгийн өндөр, гэхдээ 85-аас доошгүй оноо авсан тендерийн санал ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна. Тендерт оролцох албан ёсны өргөдөл болон тендерийн саналуудыг дараахь хаягаар ирүүлнэ үү.

Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг
Танаа

Үйлдвэр, худалдааны яам
Засгийн газрын П байр, А корпус
210646 Улаанбаатар хот, Монгол Улс
Утас : 976-11-327912
Факс : 976-11-327914

Засгийн газрын 2004 оны 36 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ(ТЕНДЕР)-ЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг үндэслэн үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний (казиног оролцуулан) гэсэн үндсэн 3 хэлбэрээс бүрдэх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр нь байгуулж хөгжүүлэх үйл ажиллагаат менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад энэ уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

2. Үйлдвэр, худалдааны яам нь уралдаант шалгаруулалт (тендер)-ын комисс томилон зөвлөхүүдийн тусламжаатайгаар тендерийг зохион байгуулна.

Хоёр.Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1. "Эдийн засгийн чөлөөт бүс" гэж гаалийн болон бусад татварын зүвьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлал- үйлчилгээний цогцолбор бүхий хэлбэрийг хосолсон хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.

2.2. "Стратегийн хөрөнгө оруулагч" гэж эдийн засгийн чөлөөт бүсийн менежментийн арга барил хэмжээ, чөлөөт бүсэд тухайн бизнесийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, 150 (нэг зуун тавин) сая ам.доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй, санхүүгийн тогтвортой байдалтай, үйл ажиллагааны туршлагатай /үүнийг аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцлээр нотолно/ компани, эсхүл тэдгээрийн оролцоотой консорциумыг хэлнэ.

2.3. "Ерөнхий мэдээлэл" гэж тендерт оролцогч бүрт хүргэх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс болон Монгол Улс, түүний бизнесийн орчны талаарх мэдээллийн баримт бичгийг хэлнэ.

2.4. "Дэнчин" гэж хөрөнгө оруулалт, менежментийн гэрээг байгуулах ямлалт, санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос төлөх 500000 /таван зуун мянган/ ам.доллартай тэнцэх хүүгүй мөнгөн хадгаламжийг хэлнэ. Дэнчинг Монгол банк дахь Үйлдвэр, худалдааны яамны валютын дансанд төлнө.

2.5. "Зөвлөх" гэж эдийн засгийн чөлөөт бүсийн асуудлаар мэргэшсэн, олон улсын тендер зарлах, сонгон шалгаруулах арга барил, туршлага хуримтлуулсан зөвлөх эрхтэй, Үйлдвэр, худалдааны яамнаас томилсон хувь хүн эсхүл хуулийн этгээдийг хэлнэ.

2.6. "Нууцыг хадгалах тухай гэрээ" гэж Монгол Улсын Засгийн газар, Үйлдвэр, худалдааны яам болон зөвлөхүүдээс өгөх "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүстэй холбоотой аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр тараах болон мэдээлэхийг хориглосон гэрээг хэлнэ.

2.7. "Өргөдөл" гэдэгт тендерт оролцогчоос ирүүлэх өргөдөл, өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ болон тендерийн хураамж төлснийг нотлох баримтын аль бүрдлийг ойлгоно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөх эрхийг бичгээр үйлдэж, өргөдөлд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна. Өргөдөл гаргач тендерт оролцохын тулд урьдчилан шалгаруулалтад шаардагдах өөрийн компанийн болон консорциумын талаарх мэдээллийг өргөдөлд хавсаргасан байна.

2.8. "Тендерийн баримт бичиг" гэдэгт:

1/Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам;

2/Ерөнхий мэдээлэл;

3/Менежментийн гэрээний төслийн иж бүрдлийг тус тус ойлгоно.

2.9. "Тендерт оролцогч" гэж тендерт оролцохоор өргөдөл гаргасан, урьдчилан шалгаруулалтын шатанд үйлчилгээний хураамж төлснийг болон тендерт оролцогчоос Үйлдвэр, худалдааны яамт өргөдлийг нь хүлээн авч шалгаруулсан хуулийн этгээд буюу тэдгээрийн хамтарсан консорциумыг хэлнэ.

2.10. "Тендерийн санал" гэж тендерт оролцогчоос тендерт оролцохоор ирүүлсэн саналыг хэлнэ. Тендерийн саналд үр ашигтай, бодит хөрөнгө оруулалтын хэмжээ тодорхой тусгагдсан байна.

2.11. "Тендерийн хураамж" гэж тендерийн баримт бичгээр хангах үйлчилгээний хураамж болгон тендерт оролцогчоос Үйлдвэр, худалдааны яаманд төлөх 1000 /нэг мянган/ ам.долларын бүцааж төлөгдөхгүй төлбөрийг хэлнэ.

2.12. "Уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/" гэж тендерт оролцогдоос ирүүлсэн

тендерийн саналуудыг хянан үзэж, ялагчийг тодруулан, түүнтэй менежментийн гэрээ байгуулах үйл ажиллагаат хэлнэ.

2.13. "Менежментийн гэрээний төсөл" гэж Үйлдвэр, худалдааны яамнаас санал болгож байгаа, тендерт оролцогчдод тэдний саналыг авахаар хүргүүлэх менежментийн гэрээний төслийн эхний хувилбарыг хэлнэ.

2.14. "Менежментийн гэрээний шинэчилсэн төсөл" гэж менежментийн гэрээний төслийн эхний хувилбарт тендерт оролцогчдын өгсөн саналыг тусгасан шинэчилсэн хувилбарыг хэлнэ.

2.15. "Менежментийн гэрээний эцсийн төсөл" гэж менежментийн гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Үйлдвэр, худалдааны яамнаас эцэслэн бэлтгэсэн төслийг хэлнэ.

2.16. "Хөрөнгө оруулалтын хэмжээ" гэж "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг барьж байгуулан санхүүжүүлэхэд зориулах тендерт оролцогчоос санал болгож байгаа хамгийн оновчтой, бодит хөрөнгө оруулалтын хэмжээ (үнийн дүн)-г хэлнэ.

Гурав. Тендерийн хуваарь

3.1. Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу зохион байгуулж явуулна.

Дөрөв. Тендерт оролцогч

4.1. Тендерт оролцогчийн эрх зүйн байдал

4.1.1. Урьдчилан шалгаруулалтад тэнцсэн компани, эсхүл тэдгээрийн оролцоотой консорциум зэрэг тодорхой хэмжээнд шаардлага хангасан бүх боломжит хөрөнгө оруулагчид тендерт оролцож болно.

4.1.2. Тендерт оролцогч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, төлөөлөх эрхийг зохих журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр баталгаажуулна.

4.1.3. Тендерт хэд хэдэн хуулийн этгээд хамтарч консорциумын хэлбэрээр оролцож байгаа тохиолдолд тэд эвлэн нэг /1/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

4.2. Тендерт оролцогчийн эрх

4.2.1. Тендерт оролцогч нь тендерт оролцох өргөдлөө ирүүлж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд Үйлдвэр, худалдааны яамнаас баталж, тэмдэг дарсан тендерийн баримт бичгийн иж бүрэн нэг багцыг авах эрхтэй байна.

4.2.2. Тендерт оролцогч нь дараахь эрх эдэлнэ:

1/Мэдээллийн танхимд тавигдсан мэдээллийг ашиглах;

2/Үйлдвэр, худалдааны яамнаас батлагдсан хуваарийн дагуу "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүстэй танилцах, дүн шинжилгээ болон уулзалт хийх, чөлөөт бүсийн удирдлагатай уулзах, барилга байгууламжийг үзэх;

3/Үйлдвэр, худалдааны яамнаас бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтантай уулзах;

4/Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар, тодруулга авах зорилгоор чөлөөт бүсийг хариуцсан Үйлдвэр, худалдааны яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах.

Тайлбар авах хүсэлтийг англи буюу монгол хэл дээр үйлдэж Үйлдвэр, худалдааны яаманд дараахь хаягаар бичгээр ирүүлнэ.

Үйлдвэр, худалдааны сайд
Ч.Ганзориг Танаа
Үйлдвэр, худалдааны яам
Засгийн газрын П байр, А корпус
210646 Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: 976-11-327912
Факс: 976-11-327914

Үйлдвэр, худалдааны яам ирсэн бүх хүсэлтэд бичгээр хариу өгөх бөгөөд асуулт, хариултын хувийг тендерт оролцогч бүрт тэдгээрийн өргөдөл дээр заасан хаягаар хүргүүлнэ. Иймхүү хүргүүлэхдээ буухиа шуудан, баталгаат захиа, факс, эсхүл электрон шууданыг ашиглаж болно.

Тендерийн саналыг авах хугацаа дуусахаас ажлын 5 /тав/-аас доош өдерт ирүүлсэн тайлбар, тодруулга авах хүсэлтийг Үйлдвэр, худалдааны яам хүлээж авахгүй байж болно.

5/Монгол Улсын хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

4.3. Тендерт оролцогчийн үүрэг

Тендерт оролцогч нь дараахь үүрэгтэй:

4.3.1. Өөрийн бизнес, эрх зүйн болон санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх.

4.3.2. Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүйн болон санхүүгийн байдалд гарсан, тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Үйлдвэр, худалдааны яаманд нэн даруй мэдээлэх.

4.3.3. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр нь байгуулж хөгжүүлэх үйл ажиллагаат менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх тендерийн бүсад оролцогчидтой ямар нэгэн харилцаа холбоо болон хэлэлцээрийн аливаа хэлбэрт орохгүй байх.

4.3.4. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд хөренге оруулах асуудлаар банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Үйлдвэр, худалдааны яаманд бичгээр мэдэгдэх.

4.3.5. Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах.

4.3.6. Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

Тав. Тендерийн баримт бичиг

5.1. Тендерт оролцогч тус бүрт тендерийн журам, өрөнхий мэдээлэл, менежментийн гэрээний төслөөс бүрдсэн тендерийн баримт бичгийн нэг ижил бүрдлийг олгоно.

5.2. Үйлдвэр, худалдааны яамнаас олгох тендерийн баримт бичигт Үйлдвэр, худалдааны яамны тэмдэг дарсан байна.

5.3. Үйлдвэр, худалдааны яам болон зөвлөхүүд тендертэй холбоотой мэдээллийг тендерийн баримт бичигт оруулна. Энэхүү мэдээллийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Үйлдвэр, худалдааны яам болон зөвлөхүүдийн аль аль нь хүлээхгүй.

Зургаа. Дүн шинжилгээ хийх

6.1. Тендерт оролцогчдыг тодгэзэрийн хүсэлтийн дагуу Засгийн газрын холбогдох албан тушаалтан болон чөлөөт бүсийн удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана.

6.2. Тендерт оролцогчдыг тендерийн саналаа ирүүлэхээс нь өмнө эдийн засгийн чөлөөт бүс дээр очиж дэд бүтэц, хөренге оруулалтын нөхцөлийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, Засгийн газраас дэвшүүлж байгаа зорилтын талаар Үйлдвэр, худалдааны яамны холбогдох албан тушаалтан болон зөвлөхүүдтэй санал солилцох бололцоогоор хангана. Үйлдвэр, худалдааны яам тендерт оролцогч тус бүрт эдийн засгийн чөлөөт бүс дээр очиж нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд зориулж ойролцоогоор 1 /нэг/ долоо хоногийн хугацаа олгоно. Оролцогч хүсэлт гаргасан тохиолдолд Үйлдвэр, худалдааны яам өөрийн үзэмжээр нэмэлт хугацаа олгож болно. Дүн шинжилгээ хийх хугацаанд тендерт оролцогчид чөлөөт бүсийн удирдлага, ажилтнуудтай уулзах өргөн боломжоор хангагдана.

6.3. Үйлдвэр, худалдааны яам нь чөлөөт бүс дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дараалалдаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4. Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр чөлөөт бүсийн нөхцөл байдлыг судлан зөвшөөрч, эдгээр нөхцөл байдал болон Үйлдвэр, худалдааны яамнаас гаргаж өгсөн бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдалтай танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал, менежментийн гэрээний төслийг боловсруулах үүргээс чөлөөлөгдөхгүй. Үйлдвэр, худалдааны яам, зөвлөх, чөлөөт бүсийн холбогдох ажилтнуудаас гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Үйлдвэр, худалдааны яам, зөвлөх, шинжээчдийн баг, чөлөөт бүсийн холбогдох ажилтнуудын аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5. Тендерт оролцогч дүн шинжилгээ хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн санал өгөх эрхтэй хэвээр үлдэнэ.

Долоо. Менежментийн гэрээний төслийг эцэслэн боловсруулах

7.1. Тендерт оролцогчдоос 2004 оны 4 дүгээр сарын 7-ны дотор Үйлдвэр, худалдааны яаманд ирүүлж санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Үйлдвэр, худалдааны яам менежментийн гэрээний төслөд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулна.

7.2. Үйлдвэр, худалдааны яам менежментийн гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2004 оны 4 дүгээр сарын 9-ний дотор хүргүүлнэ.

7.3. Менежментийн гэрээний шинэчилсэн төслөд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2004 оны 4 дүгээр сарын 12-ны дотор ирүүлэхийг тендерт оролцогчдод санал болгоно. Энэ өдрөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4. Менежментийн гэрээний шинэчилсэн төслөд оруулахаар тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Үйлдвэр, худалдааны яам менежментийн гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2004 оны 4 дүгээр сарын 14-ний дотор хүргүүлнэ.

Найм. Тендерийн санал бэлтгэх, санал ирүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

8.1. Бүх мөнгөн дүнг Америкийн Нэгдсэн Улсын доллараар илэрхийлнэ.

8.2. Тендерт оролцогчид тендерийн саналыг англи эсхүл монгол хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлнэ. Харин менежментийн гэрээний эцсийн хувилбарыг англи, монгол хэл дээр ирүүлнэ.

8.3. Тендерт оролцогчид тендерийн саналын нэг /1/ эх хувь болон таван /5/ хуулбарыг ирүүлнэ.

8.4. Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.5. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналд гарын үсэг зурж, хуудас бүрт хар буюу хөх өнгийн бэхээр нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг бичгээр гаргаж, тендерийн саналд хавсаргасан итгэмжлэлээр баталгаажуулна.

8.6. Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурах буюу эсхүл нэрийнхээ эхний үсгийг тавьж баталгаажуулна.

8.7. Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Үйлдвэр, худалдааны яаман дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8. Үйлдвэр, худалдааны яам тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогч тус бүрт илгээж хүлээн авснаа батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналд хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг ирүүлсэн саналын дугтуйн дээрх хаягаар юмуу тендерт оролцогчийн Үйлдвэр, худалдааны яамны бүртгэлд тусгагдсан хаягаар илгээнэ.

8.9. Тендерт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хүсэлтээ дуусахаас өмнө Үйлдвэр, худалдааны яаманд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсхүл татан авах эрхтэй.

Ес. Дэнчин

9.1. Тендерийн саналаа ирүүлэх хүсэлтэй тендерт оролцогчид Үйлдвэр, худалдааны яамны дор дурдсан валютын харилцах дансанд 500000 / таван зуун мянган/ америк долларын дэнчин төлнө.

Үүнд:

Банкны нэр :	Монгол Улсын "Монголбанк"
SWIFT код :	BOMUMNUB
Дансны нэр :	Үйлдвэр, худалдааны яам
Дансны дугаар :	3309001
Харилцагч банк :	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код :	FRNYUS33
Дансны нэр :	Монгол банк
Дансны дугаар :	021088506

Дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг тендерийн саналд хавсаргана.

9.2. Тендерт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендерт оролцох эрхгүй.

9.3. Тендерт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг үйл ажиллагаагаа эхэлсний дараа түүний хүсэлтийн дагуу ажлын 7 (долоо) өдөрт багтаан Монгол Улсын аль нэг арилжааны банкинд нээсэн валютын харилцах дансанд нь шилжүүлнэ.

9.4. Тендерийн саналыг үнэлсний дараа, тендерт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын 7 /долоо/ өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банкны дансны дугаарыг тодорхой заана.

9.5. Дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

1/ялагч нь тендерийн саналтайгаа хамт англи, монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан менежментийн гэрээний эцсийн хувилбарыг ирүүлээгүй буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэл /тэмдэглэл/-д гарын үсэг зурахаас татгалзсан;

2/ялагч нь менежментийн гэрээний нөхцөл, болзлыг болон гэрээнд заасан өөрийнхөө аливаа мэдэгдэл, баталгаа, тохиролцоогоо материаллаг байдлаар зөрчсөн.

9.6. Дэнчинд хүү төлөхгүй.

9.7. Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендерт оролцогч хариуцна.

Арав. Тендерийн санал бэлтгэн ирүүлэх

10.1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх сонирхолтой стратегийн хөрөнгө оруулагчид дараахь нөхцөлийг хангах шаардлагатай:

10.1.1. Засгийн газраас дэвшүүлсэн дор дурдсан зорилтыг тусгасан бизнесийн стратеги

болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх. Үүнд:

1/ "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орчин үеийн чөлөөт бүсийн жишигт хүргэж Монгол Улсын төвийн бүсийг хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүхий бүс болгоход хувь нэмэр оруулах замаар улс оны нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэхэд чиглэлээ;

2/ дэхийн өндөр хөгжилтэй үйлдвэрлэл, технологийг чиглэлээр тэргүүлэгч орнуудтай хуалдаа, ялал жуулчлалын болон үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлж, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг орос, хятадын хоёр том зах зээлийг холбосон хуалдааны томоохон гүүр болгох, улмаар Зүүн Өмнөд Азийн орнуудын зах зээлд нэвтрэх гол гарцын нэгдлгох;

3/ экспорт, импортын зохистой харьцааг хадгалах, тадаад хуалдаат үр ашигтай хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх замаар улс орны зах зээлийн хангамж нийүүлэлтийг сайжруулах.

10.12. Бизнесийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны стратегийн хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж ирүүлэх.

10.2 Тендерийн саналд бизнес төлөвлөгөөний үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалтын хэмжээ, хэзэгжүүлэх хугацаа маш тодорхой тусгасан байна.

10.3 Тендерийн саналын эх хувь болон хуулбаруудыг "ТЕНДЕРИЙН САНАЛ", "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР" гэж хаягласн тус тусад нь битүүмжлэн дутуйлна. Бүгээр дутуйг өөр дутуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднах дутуй дээр Үйлдвэр, хуалдааны яамны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"ЗАМЫН-ҮҮД" ЧӨЛӨӨТ БҮСИЙН УРАТАЛТ ШАЛГАРУУЛАЛТ/ТЕНДЕР/-Т ОРОЛЦОХ НУУЦ САНАЛ-ТЕНДЕРИЙН САНАЛ"

"ШИНЖЭЭЧДИЙН БАГИЙГ БАЙЛЦУУЛАХГҮЙГЭЭР НЭЭХИЙГ ХОРИГЛОНО"

гээх тэмдэглэл хийнэ.

Тендерийн саналыг Үйлдвэр, хуалдааны яамны дараах хаягаар 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 16.00 цаг (Улаанбаатарын цагаар)-аас өмнө ирүүлэх.

Үйлдвэр, хуалдааны сайд
Ч.Ганзориг Танаа

Үйлдвэр, хуалдааны яам
Засгийн газрын П байр, А корпус
210646 Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: 976-11-327912
Факс: 976-11-327914

10.4. Тендерийн санал

Тендерийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Тендерт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

(1) Тендерт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй банк болон компани тус бүрээр гаргаж өгнө);

(2) Сүүлийн гурван /3/ жилийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан сүүлийн 3 жилийн тайлан);

(3) Тендерт оролцогчийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж байгаа хувьцааны 5 /таваас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн жагсаалт (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч байгаа компани тус бүрийн нийт гаргасан буюу бусад хэлбэрээр өмчилж байгаа хувьцааны 5 /таваас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийг энэхүү жагсаалтад оруулна);

(4) Тендерт оролцогчоос санал болгож байгаа тендерт холбогдолтой байж болох бусад нэмэлт мэдээлэл.

Б. Бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө

Бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд эдийн засгийн чөлөөт бүсийг цаашид хөгжүүлэх бизнесийн стратегийг тодорхойлно. Таван (5)-аас доошгүй жилийг хамарсан энэхүү төлөвлөгөөнд дор дурдсан арга хэмжээг тусгасан байвал зохино. Үүнд:

(1) "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг олон улсын жишигт нийцсэн чөлөөт бүс болгон барьж байгуулахад хөрөнгө оруулалт хийх талаар санал болгож байгаа ерөнхий стратегийн зорилго;

(2)"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд бий болгож хөгжүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагааны хөгжил;

(3)Төлөвлөж байгаа санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, таван жилийн санхүүгийн прогноз;

(4)"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийн барилга байгууламж болон үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний хэсгийг барьж байгуулах, хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, өртөг зардлын бүтэц;

(5)"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон мастер төлөвлөгөө;

(6)"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн ажилтан, албан хаагчдыг сургах сургалтын хөтөлбөр, удирдлага зохион байгуулалтын хөгжил, гадаадын удирдлагын бүрэлдэхүүн, тоо, албан тушаал зэргийг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө;

(7)Байгаль орчинд харш нөлөө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын практикийг хэрэгжүүлэх амлалт.

В. Дэнчин төлснийг нотлох баримт

Г. Тендерийн энэхүү жүрмын суүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбар. Тендерт оролцогчнь Тендерийн жүрамд гарын үсэг зурснаар энэхүү жүрмын заалтыг сахин мөрдөж, түүнд тусгасан бүх нөхцөл болзлыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендерт оролцохыг зөвшөөрч тухайн хуулийн этгээдийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас тендерт оролцохыг зөвшөөрч гаргасан шийдвэр).

10.5. Менежментийн гэрээ

А. Тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зохих жүрмын дагуу гарын үсэг зурсан менежментийн гэрээний эцсийн төслийн англи болон монгол хэл дээрх тус бүр хоёр ижил эх хувь. Менежментийн гэрээний эцсийн хувилбарын гарын үсэг зурсан хоёр эх хувийг тендерийн саналын эх хувьд хавсаргасан бүх шаардлагатай. Тендерт оролцогчоор бөглүүлэхээр зориуд хоосон үлдээсэн хэсгийг бөглөхөөс өөрөөр менежментийн гэрээний эцсийн хувилбарт өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрнө.

Менежментийн гэрээний эцсийн хувилбарт дараахь зүйлийг хавсаргана:

(1) Менежментийн гэрээний эцсийн хувилбарт гарын үсэг зурахыг зөвшөөрсөн хуулийн этгээдийн удирдах байгууллагын шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч байгаа хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас гарсан шийдвэр);

(2) Итгэмжлэгдсэн төлөөлөгчид дараахь эрх олгосныг нотлох итгэмжлэл:

Гэрээнд гарын үсэг зурах,

Тендерийн саналыг нээх ажиллагаанд тендерт оролцогчийг төлөөлөх.

Тендерт оролцогчийн өргөдөлд хавсаргасан итгэмжлэлд эдгэр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид оногоо тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана.

Арван нэг. Сонгуулийн анал

11.1. Үйлдвэр, худалдааны ям тендерийн саналыг үнэлүүлэх зорилгоор шинжээдийн багийг томилно.

11.2. Шинжээчдийн баг нь тендерийн саналыг дор дурдсан шалгаруулах үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ Үүнд:

(1) Эдийн засгийн чөлөөт үсэд болон тухайн бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавх, эр хүнд, бизнесийн ур чадвар (0-30оноо);

(2) Санал болгож байгаа бизнесийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний чанар, түүнд Засгийн газраас дэвшүүлсэн зорилт хүлээн авч тусгасан байдал (0-20оноо);

(3) Байгаль орчинд харш нөлө үзүүлэхгүй бизнесийн үйл ажиллага явуулах, түүнийг дэмжихэд чиглэгдсэн олон улсын практикийг хэрэгжүүлэх амлалт (0-10 оноо);

(4) Хөрөнгө оруулалтын санал (0-35 оноо).

Нийлбэр дүнгээр хамгийн өндөр гаргасэн 85-аас доошгүй оноо авсан тендерийн санл ирүүлсэн оролцогчийг тендерийн ялагчаар шагаруулна.

11.3. Тендерийн саналыг тендерт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан нийтийн өмнө тендерин хүваарьт заасны дагуу 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр тендерийн комисс задална.

11.4. Тендерт оролцогчийнэр болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд оруулах хөрөнгө оруулалтын нийт хэмжээг чанаар унших, бүртгэнэ. Шинжээчдийн баг тендерийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагаанд тэмдэглэл хөтөлнө.

11.5. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагааг ажлын 3 (гурав) өдөрт дуусгасны дараа шинжээчдийн баг нь тендерийн саналын үнэлгээний тайлан гаргана.

11.6. Тендерийн саналын үнэлгээний тайлан гаргасан өдрөө шинжээчдийн баг нь тендерийн үр дүнгийн мэдэгдэл /тэмдэглэл/-ийн тэслийг бэлтгэж, Үйлдвэр, худалдааны яамны тендерийн комиссоор хянуулан батлуулна.

11.7. Хоёр буюу түүнээс дээш тендерт оролцогч ижил оноо авсан тохиолдолд тэдгээрийг энэхүү журмын нэгдүгээр үзүүлэлтийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлнэ. Хэрэв энэ саналын үнэлгээгээр авсан оноо нь мөн тэнцэж байвал хөрөнгө оруулалтын шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд энэ ажиллагааг аль нэг тендерт оролцогч бүсдаасаа илүү оновчтой хөрөнгө оруулалтын санал ирүүлэх хүртэл үргэлжлүүлэн явуулна.

11.8. Үйлдвэр, худалдааны яам тендерт ялагчаар шалгараагүй оролцогчдод энэ тухай болон дэнчинг буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

11.9. Шинжээчдийн баг болон Үйлдвэр, худалдааны яамны тендерийн комиссын гишүүд мөн өдөр нээлттэй хамтарсан хуралдаан хийж, Үйлдвэр, худалдааны сайд гарын үсэг зурсан тендерийн нэгдсэн мэдэгдэл /тэмдэглэл/-ийг уншиж тендерийн үр дүнг зарлана.

11.10. Ялагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тендерийн үр дүнгийн мэдэгдэл / тэмдэглэл/-д гарын үсэг зурахыг урих бөгөөд түүнд уг мэдэгдлийн гарын үсэг зурсан хувийг Үйлдвэр, худалдааны сайд хүүдас бүр дээр гарын үсэг зурсан менежментийн гэрээний эх хувьтай хамт олгоно.

Арван хоёр. Тендерийг явагдаагүйд болон хүчингүйд тооцох өргөдөл, саналируулэх хугацаа

12.1. Үйлдвэр, худалдааны яам өргөдөл, санал ирүүлэх хугацааг өөрийн саналчилгаар эсхүл тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу сунгах буюу тендерийн хугацааг хэдийд ч ямар ч байдлаар өөрчилж болно.

12.2. Монгол Улсын Засгийн газар нь аль ч үед урьдчилан мэдэгдэлгүйгээр үралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын аль ч заалтыг хасах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Тендерийн журамд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар Үйлдвэр, худалдааны яам бүх оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

Тендерт оролцогчийн гарын үсэг.....

он, сар, өдөр.....

Тендерийн журмын хавсралт

Агуулга	*Огнос/эцсийн хугацаа*
Тендерийн зар мэдээ	*2004.2.25*
Өргөдөөө ирүүлэх	*2004.3.1-2004.3.25*
Урьдчилсан шалгаруулалт /тендерийн баримт бичгийг хүргүүлэх	*2004.3.10-2004.4.1*
Оролцогчид газар дээр нь танилцах, судалгаа хийх санал, дүгнэлт гаргах хугацаа	*2004.3.10-2004.4.1*
Менежментийн гэрээний төсөлд санал авах	*2004.4.7*
Менежментийн гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, хүргүүлэх	*2004.4.9*
Менежментийн гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал авах	*2004.4.12*
Менежментийн гэрээний төслийг эцэслэн боловсруулж дуусган тендерт оролцогчдод хүргүүлэх	*2004.4.14*
Тендерийн санал хүлээн авах /эцсийн хугацаа/	*2004.4.26*
Тендерийн саналын үнэлгээ	*2004.4.26-2004.4.27*
Тендерийн үр дүн, ялагчийг зарлах	*2004.4.28*
Гэрээнд гарын үсэг зурах	*2004.4.28*

Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Дорноговь аймгийн зарим сумдын нутагт малын гоц халдварт шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Айраг сумын нутаг дэвсгэрт 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хорио цээрийн онцгой дэглэм тогтоон нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж, иргэдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Дорноговь аймгийн Сайншанд, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Эрдэнэ, Сайхандулаан, Улаанбадрах, Замын-Үүд; Говьсүмбэр аймгийн Шивээ-Овоо, Сүмбэр, Баянтал; Хэнтий аймгийн Галшар, Дархан, Дундговь аймгийн Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумдын нутаг дэвсгэрт 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

3. Дорноговь аймгийн Засаг дарга Ж.Батсуурьт даалгах нь:

а/гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн сумдад хорио цээрийн онцгой дэглэмийг чанд мөрдүүлэх замаар шүлхий өвчний тархалтыг таслан зогсоох, сэргийлэх, голомтыг устгахад чиглэгдсэн удирдлага, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй;

б/хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт иргэд, бүх төрлийн тээвэрийн хэрэгсэл, малын шилжилт, хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээ авсугай;

в/хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон нутагт орох, гарах гол зам дээр шалган нэвтрүүлэх пост, ариутгал, халдваргүйжүүлэлтийн цэгүүдийг зохих заавар, журмын дагуу байгуулан ажиллуулсугай;

г/шүлхий өвчний ил шинж тэмдэг илэрсэн мал, амьтан, бохирдсон бүтээгдэхүүн, түүхий эдийг устгах, халдварын голомтод ариутгал, халдваргүйжүүлэлт хийх арга хэмжээг зохих журмын дагуу шуурхай хэрэгжүүлсүгэй;

д/мал сүргийг байнгын хариулга маллагаатай болгон эмнэл зүйн үзлэгийг 2004 оны 2 дугаар сарын 18-ны дотор хийж өвчний сэжиг илэрсэн тохиолдолд шуурхай штабт мэдээлж халдвар тархахаас хамгаалах арга хэмжээг тухай бүр авсугай;

е/гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлсэн нутаг дэвсгэрт үе өвчнөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээний тухай мэдээллийг иргэдэд хүргэн таниулах ажлыг зохион байгуулсугай;

ж/хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон сум, багийн холбоог 24 цагийн ажиллагаанд оруулж, шуурхай штабтай байнгын холбоотой ажиллуулах арга хэмжээ авсугай.

4. Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Дундговь аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан хязгаарлалтын дэглэм тогтоосон сумдын нутаг дэвсгэрт хорио цээрийн зохих дэглэмийг мөрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажилласугай;

б/мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмжийг үндэслэн хязгаарлалтын дэглэм бүхий нутгийн заараг, уг бүсэд орох, түүнээс гарах, дамжин өнгөрөх цэг, зурвасыг нарийвчлан тогтоож, анхааруулсан тэмдэг, дохио, санамж тавиулах, харуул хамгаалалт гарган ажиллуулах, иргэд, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, журамлах арга хэмжээ авсугай;

в/гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 2004 оны 2 дугаар сарын 17-ны дотор тодотгол хийж, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах арга хэмжээ авсугай;

г/малын гоц халдварт өвчин гарсан үед шуурхай штаб дэлгэх, шаардагдах эм, ариутгалын бодисыг нөөцлөх, ажиллах хүч, хэрэгслийг томилгоожуулах ажлыг зохион байгуулсугай.

5. Нийслэл, аймгийн төв болон экспортод бүтээгдэхүүн нийлүүлдэг суурин газрын шүлхийгээр өвчлөмтгий мал, гэрийн тэжээвэр амьтныг вакцинжуулан, мал эмнэлэг, ариун цэвэр, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авах, хүн, мал, тэсвэрийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хязалтыг чангатгахыг Дорнод, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Төв аймаг болон нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүн аймгуудад шүлхий өвчинтэй тэмцэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, холбогдох арга хэмжээг иж бүрнээр авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ цагийн байдлын талаар Засгийн газарт тогтмол мэдээлж байхыг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид даалгасугай.

7. Шүлхий өвчинтэй тэмцэх мэргэжил, арга зүйн удирдлага, шаардагдах вакцин, зүү, тариураар хангаж ажиллах, оношилгоог баталгаажуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

8. Шүлхий өвчөөр өвчлөмтгий ан амьтны байршил, хөдөлгөөнд тандалт хийж, өвчний сэжиг илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Төв, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн болон нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

9. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлсэн аймаг, сумдад хорио цээрийн дэглэмийг чандлан сахиулж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн чанар, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатарт даалгасугай.

10. Шүлхий өвчний тархалтаас сэргийлэх арга хэмжээ болон вакцинжуулалтад шаардагдах хөрөнгийн эхний ээлжийн 1760.5 (нэг тэрбум долоон зуун жаран сая таван мянган) сая төгрөгийг 1300.0 (нэг тэрбум гурван зуун сая) сая төгрөгийг улсын төсвөөс, 460.5 (дөрвөн зуун жаран сая таван зуун мянган) сая төгрөгийг эрсдэлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

11. Халдварын голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй холбогдуулан шүлхийн вакцин, оношлуурыг шуурхай нийлүүлэх болон шуурхай штабын зардлын тооцоог хянан шийдвэрлүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт даалгасугай.

12. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгах нь:

а/хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа улсын чанартай авто болон төмөр замын тээвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналтад авч, шалган нэвтрүүлэх пост, халдварын голомт бүхий бүс нутгаас гарах зорчигч, авто тээврийн хэрэгслийг шуурхай штабын зөвшөөрөл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай баримтыг үндэслэн нэвтрүүлж байх арга хэмжээ авсугай;

б/ хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутагт нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсугай.

13. Хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт харуул хамгаалалт гаргах, өвчтэй мал, зээрийг устгах, үхсэн мал, амьтны сэг, зэмийг зааврын дагуу булшлах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор зэвсэгт хүчнээс шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг гарган ажиллуулах асуудлаар санал боловсруулж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.9-д заасны дагуу Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид тавьж шийдвэрлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаад даалгасугай.

14. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хүний эрүүл мэндийг хамгаалах эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, эм, бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх, хүн амыг мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангах арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваад даалгасугай.

15. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын хөдөлгөөнд зохицуулалт хийж Дорноговь аймгийн Айраг, Өргөн, Эрдэнэ сумын төмөр замын өртөө, Айраг-Сайншандын хоорондох зөрлөгүүдэд зорчигч буулгах, суулгахыг хориглох, Сайншанд өртөөнөөс зөвхөн ариутгал, халдваргүйжүүлэлтэд хамрагдсан зорчигчийг суулгах, Замын-Үүд-Улаанбаатар, Сайншанд-Улаанбаатарын чиглэлийн суудлын галт тэргээр зорчигчдыг ариутгах цэгийг нийслэлээс Замын-Үүд хүртэлх төмөр замын буудлуудад байгуулан ажиллуулах арга хэмжээ авахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

16. Малын гоц халдварт өвчний гарсан шалтгааныг тогтоох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Тагнуулын ерөнхий газрын дарга М.Батсайхан нарт даалгасугай.

17. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын явц, үр дүнгийн талаар иргэдийг бодит мэдээллээр цаг тухайд нь шуурхай хангаж ажиллахыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр | **Дугаар 38** | **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2004 оны 2 дугаар сарын 25-27-нд Астана хотноо зохион байгуулагдах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын Комиссын Ш хуралдаан, 2004 оны 3 дугаар сарын 1-3-нд Бишкек хотноо зохион байгуулагдах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын Комиссын анхдугаар хуралдаанд оролцох Монголын талын төлөөлөгчдийн зардалд зориулан 20.9 (хорин сая есөн зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр | **Дугаар 39** | **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Дүрэмт хувцас, хэрэглэлийн нормыг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, 1 дүгээр хавсралтын гарчигийн "Зэвсэгт хүчин" гэсний дараа "дотоодын цэрэг" гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын тайлбарын 1, 5-ын "хилийн цэргийнх ногоон" гэсний дараа "дотоодын цэргийнх хүрэн улаан" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр | **Дугаар 40** | **Улаанбаатар хот**

Мөнгөн төлбөрийн суурь хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2004 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 841300 (найман зуун дөчин нэгэн мянга гурван зуун) төгрөг байхаар тогтоосугай.

2. Мөнгөн төлбөрийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт, мөнгөн төлбөрийг холбогдох хугацаанд төлөөгүй иргэнээс албадлагаар гаргуулах ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярт тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр

Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан

Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 41 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35.2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, өвчний голомтыг устгах арга хэмжээ болон шуурхай штабуудын зардалд зориулан эхний ээлжинд 1145.0 (нэг зуун дөчин таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Гамшгаас хамгаалах ерөнхий газрын мэдэлд шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Дээрх хөрөнгийг хорио цээрийн дэглэм тогтоон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн аймаг, шуурхай штабуудаас гаргасан тооцоо, санхүүгийн баримтыг нягтлан үзсэний үндэсэн дээр зориулалтын дагуу зарцуулахыг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Дашид үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр

Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан

Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.6, 31.2, 31.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндэсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батална 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. "Төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох журам"-ыг 5 дугаар хавсралт ёсоор батална.

3. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажил үүрэг гүйцэтгэдэг төрийн албан хаагчийн хувьд энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар батална албан хаагчийн цалингийн сүлжээг "1.16" гэсэн итгэлцүүрээр өсгөн хэрэглэсүгэй.

4. Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээг тухайн онд батлагдсан цалингийн сандаа багтаан хэрэгжүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерүүдэд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 195 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр

Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(САРД ТӨГРӨГӨӨР)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13
1	45400	48600	52700	55900	59100	63000	65800	69400	73200	77000	81100	84600	88500
2	48600	52500	57100	60700	64300	68000	71100	74500	78800	82100	90700	94000	96300
3	51800	56300	61500	65600	69400	73200	76300	79500	84400	87200	100400	102200	104100
4	55100	60200	65900	70300	74600	78300	81500	84500	89900	92200			
5	58400	64100	70300	75000	79800	83300	86600	89500	95400	97300			

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ,СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(САРД ТӨГРӨГӨӨР)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1
1	56100	59100	63000	65700	69400	73200	76900	79800	84000	88100	92400
2	61100	64300	68000	70800	74500	78500	81800	84500	92300	96100	100200
3	66000	69400	73200	76100	79400	83700	86600	89300	100600	104100	108000
4	70800	74600	78400	81300	84400	89000	91600	94100			
5	75800	79800	83300	86500	89500	94300	96500	98800			

Засгийн газрын 2004 оны 42 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(САРД ТӨГРӨГӨӨР)

Цалингийн сулжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	42100	45400	48600	51800	53200	54000	57200	59100	63100	63500	64600	65700	69400	73200	75700	79700	84000	88500
2	45500	48600	52500	56200	57700	58900	62200	64300	67900	68600	69800	70900	74500	78800	81100	89500	93200	96300
3	48800	51800	56300	60600	62200	63900	67300	69400	72700	73600	74900	76100	79500	84400	86400	99500	102400	104100
4	52100	55000	60200	64900	66800	68800	72200	74600	77500	78600	80000	81400	84600	89900	91700			
5	55500	58400	64100	69200	71400	73700	77200	79800	82200	83600	85100	86500	89500	95400	97000			

Засгийн газрын 2004 оны 42 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(САРД ТӨГРӨГӨӨР)

Цалингийн доод жишгийн шатлал	Албан тушаалын зэрэглэл													
	ТУ-1	ТУ-2	ТУ-3	ТУ-4	ТУ-5	ТУ-6	ТУ-7	ТУ-8	ТУ-9	ТУ-10	ТУ-11	ТУ-12	ТУ-13	ТУ-14
1	40000	40400	41400	42600	43400	47000	50500	54100	57600	62100	66500	72800	79900	87000
2	40400	41400	42600	43200	46300	50100	53600	57200	60700	65300	73200	79000	85200	94000
3	41400	42600	44000	45700	49200	53200	56800	60300	63800	68400	79900	85100	90500	100900
4	44000	45500	46700	48200	52100	56300	59600	63400	67000	71500				
5	46900	48400	49200	50500	55000	59400	62300	66500	70100	74500				

Засгийн газрын 2004 оны 42 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР МӨНГӨН УРАМШИЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон бусад эрх зүйн актын хүрээнд төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил /цаашид "мөнгөн урамшил" гэх/ олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төсвийн ерөнхий менежерүүд нь энэхүү журмын дагуу төрийн албан хаагчид мөнгөн урамшил олгох арга хэмжээг тухайн онд батлагдсан цалингийн сандаа багтаан авч хэрэгжүүлнэ.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Мөнгөн урамшилыг бүх шатны төрийн улс төрийн албан тушаалтан, төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтан, бүх шатны шүүгч, прокурор болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдаас бусад бүх ангилал, зэрэглэлийн төрийн албан хаагчдад олгоно.

2.2. Мөнгөн урамшлыг "Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх журам", "Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу А, В, С үнэлгээ авсан төрийн албан хаагчдад олгоно.

Гурав. Мөнгөн урамшлын дээд хэмжээ

3.1. Төсвийн ерөнхий менежер нь төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгохдоо дор дурдсан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байна.

а/Төрийн жинхэнэ албан хаагчид:

№	Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэглэл	Ажлын үр дүнгийн үнэлгээ		
			С	В	А
			Урамшуулын дээд хэмжээ /мянган төгрөгөөр/		
1.	Туслах түшмэл	ТЗ-1 - ТЗ-3, ТТ-1 - ТТ-4	70.0	80.0	90.0
2.	Дэс түшмэл	ТЗ-4 - ТЗ-6, АА-9 - АА-11, ТТ-5 - ТТ-10	80.0	120.0	160.0
3.	Ахлах түшмэл	ТЗ-7 - ТЗ-9, АА-6 - АА-8, ТТ-11 - ТТ-14	120.0	160.0	190.0
4.	Эрхэлсэн түшмэл	ТЗ-10 - ТЗ-11, АА-4 - АА-5, ТТ-15 - ТТ-16	160.0	220.0	270.0
5.	Тэргүүн түшмэл	ТЗ-12 - ТЗ-13, АА-1 - АА-3, ТТ-17 - ТТ-18	220.0	290.0	360.0

б/Төрийн үйлчилгээний албан хаагчид:

№	Албан тушаалын ангилал	Албан тушаалын зэрэглэл	Урамшууллын жишиг хэмжээ /мянган төгрөг/		
			С	В	А
			Урамшууллын дээд хэмжээ /мянган төгрөгөөр/		
1.	Бага	ТҮ-1	40.0	50.0	60.0
2.	Техникийн гүйцэтгэх ажилтан	ТҮ-2 - ТҮ-4	50.0	70.0	90.0
3.	Мэргэжлийн албан хаагч	ТҮ-5 - ТҮ-7	70.0	100.0	120.0
4.	Удирдах албан хаагч	ТҮ-8 - ТҮ-14	100.0	150.0	200.0

Дөрөв. Мөнгөн урамшлыг олгох *Тав. Бусад зүйл*

4.1. Төсвийн ерөнхий менежер нь дараа оны 2 дугаар сарын 15-наас өмнө төрийн албан хаагчийн ажлын үр дүнг зохих журмын дагуу үнэлнэ.

4.2. Ерөнхий менежер төрийн албан хаагчийн жилийн ажлын үр дүнгийн үнэлгээ /А, В, С/-г үндэслэн энэхүү журмын 3.1-д заасан хэмжээнд багтаан мөнгөн урамшлын хэмжээг тогтоон тухайн төрийн албан хаагчид мэдэгдэнэ.

4.3. Төсвийн ерөнхий менежерт мөнгөн урамшил олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч гаргана.

5.1. Төсвийн ерөнхий менежерийн мөнгөн урамшил олгох шийдвэр, түүнийг төрийн албан хаагч хүлээн зөвшөөрсөн тухай мэдээллийг байгууллага нь албан хаагч бүрээр дараахь хүснэгтийн дагуу гаргаж тухайн оны 2 дугаар сарын 25-ны дотор багтаан төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан Төрийн албаны зөвлөлд ирүүлж байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн мэдээллийг үндэслэн мөнгөн урамшилд шаардагдах хөрөнгийг Санхүү, эдийн засгийн яам болон холбогдох төв, орон нутгийн санхүүгийн байгууллага санхүүжүүлнэ.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МӨНГӨН УРАМШУУЛЛЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Төрийн албанд ажилласан жил	Тухайн үеийн цалин хөлс /мян. төг/ Үүнээс		Үнэлгээ	Урамшууллын хэмжээ /мян.төг/	Тайлбар
			Үндсэн цалин	Нэмэгдэл, нэмэгдэл хөлс			
Дүн							

5.2. Энэхүү журмын 5.1-д дурдсан мэдээллэлд Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн засгийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээллэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (347)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай*

- *Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны дөрөвдүгээр сарын 15 №14 (347)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

167.	Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай	Дугаар 9	277
168.	Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай	Дугаар 10	278
169.	Зарим хүмүүсийг сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 11	278
170.	Сонгуулийн ерөнхий хорооны зарим гишүүнийг нөхөн томилох тухай	Дугаар 12	278

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

167.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 20	278
168.	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 35	285
169.	Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 43	286
170.	Тооны дээд хязгаар тогтоох тухай	Дугаар 44	286
171.	Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай	Дугаар 45	287
172.	Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлөх, томилох тухай	Дугаар 46	287
173.	Журам батлах тухай	Дугаар 48	287
174.	Гамшгаас хамгаалах тухай Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 51	292
175.	Дүрэм батлах тухай	Дугаар 52	295
176.	Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай	Дугаар 53	298

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр **Дугаар 9** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 2004 оны 4 дүгээр сарын 12-өдрөөс товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал хураалтыг 2004 оны 6 дугаар сарын 27-ны өдөр явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот

Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн Ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2004 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 696578660 төгрөгөөр тогтоосугай.

2. Энэхүү зардлыг 2004 оны батлагдсан төсвөөс гаргахыг Засгийн газар /Н. Энхбаяр-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ч. Амарболд, Ч. Даваасүрэн, Д. Намсрай, Н. Гүмэндэмбэрэл нарыг өөр ажилд шилжсэнтэй холбогдон Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолын 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

Сонгуулийн ерөнхий хорооны зарим гишүүнийг нөхөн томилох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Гандийн Бямбацэрэн, Бэгзийн Очирбат, Дансангийн Сандаг-Очир, Чимэдийн Хүрэлбаатар нарыг Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр нөхөн томилсугай.

2. Энэ тогтоолын 2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1, 12.5, 17.5 дахь хэсгээс заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх журмыг 1 дүгээр хавсралт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтаас лавлагаа өгөх үйлчилгээний хураамжийн хэмжээг 2 дугаар хавсралт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний загвар (тодорхойлолт)-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бүртгэлийн дэвтэр хэвлүүлэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг

Санхүү, эдийн засгийн сайд Ч. Улаанд даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 267 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЖАГСААЛТ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1-д заасан бүртгэх байгууллага хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөхөд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасан тухай болон хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан өөрчлөлт бусад мэдээллийг агуулсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтыг улсын хэмжээний нэгдсэн бүртгэлийн дэвтэрт хөтөлнө.

Хоёр. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх

2.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16, 20, 23 дугаар зүйлд заасан баримт бичиг нь улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх эх сурвалж болно.

2.2. Бүртгэх байгууллага нь энэхүү журмын 1.2-т заасан дэвтэрт бичилт хийж, хуулийн этгээдийг бүртгэнэ.

2.3. Энэхүү журмын хавсралтаар батлагдсан "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт"-д заасан бичвэрүүдийг дор дурдсан байдлаар хөтөлнө:

-01-хуулийн этгээдийг бүртгэх тухай бүртгэх байгууллагын шийдвэрийн он, сар, өдөр, дугаар;

-02-бүртгэх байгууллагаас хуулийн этгээдэд олгосон улсын бүртгэлийн дугаар;

-03-улсын бүртгэлийн регистрийн нэгдсэн сангаас олгосон регистрийн дугаар;

-04-Үндэсний татварын ерөнхий газраас баталгаажуулсан хуулийн этгээдийн нэр;

-05-хуулийн этгээдийн төрөл "ашгийн төлөө, эсхүл ашгийн төлөө бус", хэлбэр (ашгийн төлөө бол хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани; ашгийн төлөө бус бол холбоо, сан, хороо г.м)-ийг заааж өгнө. Төрийн бус байгууллагыг "нийгэмд үйлчилдэг", "гишүүддээ үйлчилдэг" гэж тус тус тэмдэглэх;

-06-10-хуулийн этгээдийн оршин байгаа газрын хууль ёсны хаяг, утасны дугаар;

-11-15-байгнын ажиллагаатай захиргаа байхгүй бол хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хаяг, утасны дугаар;

-16-хуулийн этгээд шинээр байгуулсан эсхүл өөрчлөн байгуулагдсаныг тэмдэглэх;

-17-23-үүсгэн байгуулагчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тэмдэглэх;

-24-үүсгэн байгуулсан нийт гишүүний тоо / төрийн бус байгууллагын нийтийг хамарсан хүрээ байгуулсан бол энэ тухай тэмдэглэх/;

-25-26-хуульд заасан эрх бүхий байгууллагаас гаргасан хуулийн этгээд байгуулах тухай шийдвэрийн нэр, дугаар, хуулийн этгээдийн дүрэм болон үүсгэн байгуулах гэрээ байгуулсан он, сар, өдрийг тэмдэглэх;

-27-30-Үндэсний статистикийн газраас хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг салбараар нь ангилсан кодын дугаар;

-31-32-Компанийн хэлбэрээр байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн хэмжээг мөнгөн болон биет хэлбэрээр илэрхийлэх;

-33-37-хуулийн этгээдийг итгэмжлэгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны овог, нэр, албан тушаал, иргэний үнэмлэх болон регистрийн дугаар, татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

-38-41-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа эрхэлдэг бол энэ талаархи мэдээлэл;

-42-45-өөрчлөн байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн нэгдсэн, нийлсэн, хуваасан, тусгаарласан, өөрчлөгдөний аль нь болох, эрх залгамжлагч этгээдийн нэр, регистрийн дугаар, эрх залгамжлалын хувь хэмжээ;

-46-49-өөрчлөн байгуулагдах явцад үйл ажиллагаа нь зогсоогдсон хуулийн этгээдийн талаархи мэдээлэл;

-50-салбар, төлөөлөгчийн газрын нэр, хууль ёсны хаяг;

-51-бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн он, сар, өдрийг тэмдэглэх;

-52- улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг;

-53-хуулийн этгээдийн харилцах банкны нэр, дансны төрөл, дугаар. Эдгээр мэдээллийг эрх бүхий байгууллагаас батална маягтын дагуу хуулийн этгээдийн харилцагч банкнаас ирүүлсэн тасалбарыг үндэслэж бүртгэсэн ажилтны гарын үсэг, бүртгэсэн он, сар, өдөр;

-54-хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичигт орсон өөрчлөлт, баримт бичгийн төрөл, өөрчлөлтийн агуулга, он, сар, өдөр, түүнийг бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг;

-55-хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татан буулгах эрх бүхий байгууллага болон татан буулгах комиссын шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, хуулийн этгээд татан буугдаж байгаа тухай тэмдэглэл хийсэн бүртгэх байгууллагын ажилтны нэр, гарын үсэг он, сар, өдөр, дугаар, улсын бүртгэлээс хассан он, сар, өдөр, түүнийг улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг.

2.4. Бүртгэх байгууллага хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэвтэрт бичигдсэн жагсаалтыг улсын бүртгэлийн цахим санд давхар хөтөлнө.

2.5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан болон регистрийн нэгдсэн сангийн тогтвортой хэвийн ажиллагааг Үндэсний татварын ерөнхий газар хариуцна.

2.6. Бүртгэх байгууллагууд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сангийн нэгдсэн сүлжээнд холбогдоно.

2.7. Үндэсний татварын ерөнхий газар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн нэгдсэн санг улсын хэмжээнд хамтад нь хөтөлж, хуулийн этгээдийн нэр давхардаж байгаа эсэхийг шалган, нэрийн баталгаажуулалт хийнэ.

2.8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт бүхий дэвтэр, улсын бүртгэлийн гэрчилгээг Үндэсний татварын ерөнхий газраас нэгдсэн журмаар хэвлүүлж, дугаарлан бүртгэх байгууллагуудад хүргүүлнэ.

2.8.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэвтрийг ББХХДД гэсэн дараалалаар дугаарлах бөгөөд энэ нь дараахь агуулгыг илэрхийлнэ:

-ББ-бүртгэх байгууллагын дугаар;

-ХХ-хуулийн этгээдийн төрөл, хэлбэр;

-ДД-тухайн улсын бүртгэлийн байгууллагад ашиглагдаж байгаа дэвтрийн дугаар.

2.9. Улсын бүртгэлийн жагсаалт дахь хуулиар хориглосноос бусад мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байх бөгөөд бүртгэх байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд лавлагаа мэдээлэл өгч болно.

2.10. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн нэгдсэн сан нь хуулийн этгээдийн тухай улсын хэмжээний мэдээлэл өгөх үндэсэн эх сурвалж болно.

2.11. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим сан дахь мэдээллийг нотлох баримт бичиг нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт бүхий дэвтэр болно. Улсын бүртгэлийн цахим сан дахь мэдээлэл, бүртгэлийн дэвтэр дэх мэдээллүүд зөрвөл бүртгэлийн дэвтэр дээрх мэдээллийг үндэслэл болгоно.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт хөтлөх журмын хавсралт

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮТГЭЛИЙН ЖАГСААЛТ

Бүртгэсэн байгууллагын шийдвэрийн огноо, дугаар			01						
Улсын бүртгэлийн дугаар			02						
Регистрийн дугаар			03						
Хуулийн этгээдийн нэр			04						
Хуулийн этгээдийн төрөл, хэлбэр			05						
Хуулийн этгээдийн хууль ёсны хаяг	Аймаг, нийслэл		06						
	Сум, дүүрэг		07						
	Баг, хороо		08						
	Байршил		09						
	Утасны дугаар		10						
Байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол түүхайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хаяг	Аймаг, нийслэл		11						
	Сум, дүүрэг		12						
	Баг, хороо		13						
	Байршил		14						
	Утасны дугаар		15						
Хуулийн этгээд байгуулсан арга /шинээр эсхүл өөрчлөн байгуулсан/			16						
Үүсгэн байгуулагчийн талаар	Овог		17						
	Эцэг (эх)-ийн нэр		18						
	Нэр		19						
	Иргэний үнэмлэх, регистрийн дугаар		20						
	Иргэний харьяалал		21						
	Өмчийн хэлбэр		22						
	Хаяг, утасны дугаар		23						
Үүсгэн байгуулсан гишүүний тоо			24						
Үүсгэн байгуулах бараат бичиг	Эрх бүхий байгууллагын шийдвэрийн нэр, дугаар		25						
	Дүрэм, үүсгэн байгуулах гэрээний огноо		26						
Үйл ажиллагааны чиглэл /Код/	Үндсэн		27						
	2 дэд		28						
	3 дэд		29						
	4 дэд		30						
Өөрийн хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Мөнгөн хөрөнгө		31						
	Бичиг		32						

Иттэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан	Овог	33	
	Нэр	34	
	Албан тушаал	35	
	Иргэний үнэмлэх, регистрийн дугаар	36	
	Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар	37	
Зээмшиж байгаа тусгай зөвшөөрлийн бүртгэл	Тусгай зөвшөөрлөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаа	38	
	Нийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр	39	
	Нийдвэрийн огноо	40	
	Дугаар	41	
Өөрчлөн байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн талаар	Өөрчлөн байгуулагдсан хэлбэр /нэгдсэн,нийлсэн, хуваасан, тусгаарласан, өөрчлөгдсөний аль нэгийг бичих/	42	
	Хуулийн этгээдүүдийн нэр	43	
	Регистрийн дугаар	44	
	Эрх залгамжлалын хувь	45	
Өөрчлөн байгуулагдсан хамрагдсан хуулийн этгээдийн талаар	Нэр	46	
	Регистрийн дугаар	47	
	Эрх залгамжлалын хувь	48	
	Үйл ажиллагаа зогсоосон огноо	49	
Салбар, төлөөлөгчийн газрын нэр, оршин байгаа газрын хаяг		50	
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо		51	
Улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг		52	

53. Харилцах банкны бүртгэл:

Д/д	Харилцах банкны нэр	Дансны дугаар		Бүртгэсэн: Огноо, Ажилтны нэр, гарын үсэг, тэмдэг
		Төгрөгийн	Валютын	
01				
02				
03				
04				
05				
06				
07				
08				
09				

54. Үүсгэн байгуулах баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Баримт бичгийн төрөл	Өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг, тэмдэг

55. Татан буулгаж байгаа тухай бичилт болон улсын бүртгэлээс хассан бүртгэл:

Татан буулгах шийдвэр гаргасан	Шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр	
	Шийдвэрийн огноо	
	Шийдвэрийн дугаар	
Татан буулгаж байгаа тухай тэмдэглэл хийсэн бүртгэлийн ажилтны нэр, гарын үсэг, огноо, тэмдэг		
Татан буулгах комиссын шийдвэр, огноо, дугаар		
Улсын бүртгэлээс хассан огноо		
Улсын бүртгэлд бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг		

Д/д	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	110
2	Баян-Өлгий	80
3	Баянхонгор	207
4	Булган	30
5	Говь-Алтай	52
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	44
8	Дорноговь	32
9	Дорнод	60
10	Дундговь	60
11	Завхан	150
12	Орхон	15
13	Өвөрхангай	50
14	Өмнөговь	50
15	Төв	60
16	Увс	10
17	Сүхбаатар	104
18	Сэлэнгэ	50
19	Ховд	50
20	Хөвсгөл	79
21	Хэнтий	90
22	Улаанбаатар	85
	Бүгд	1478

Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЖАГСААЛТААС ЛАВЛАГАА ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

1. Бүртгэх байгууллага нь хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр улсын бүртгэлийн жагсаалтаас энэ журмын 1.3-т заасан үйлчилгээний хураамж авч лавлагаа өгнө.

2. Бүртгэх байгууллага яаралтай лавлагааг ажлын 8 цагт багтаан өгөх бөгөөд энэ журмын 1.3-т заасан үйлчилгээний хураамжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж авна.

3. Бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийн талаар лавлагаа өгөхдөө дор дурдсан хэмжээний хураамж авна:

3.1. Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг шалгаж, баталгаажуулалт хийх–500 төгрөг;

Энэ заалт нь хуулийн этгээдийг анх бүртгүүлэхэд хамаарахгүй.

3.2. Улсын бүртгэлийн жагсаалтаас лавлагаа өгөх (Улсын бүртгэлийн жагсаалтын үзүүлэлт тус бүрээс)-200 төгрөг;

3.3. Холбогдох баримт бичгийн хуулбар өгөх(хуудас тутамд)-400 төгрөг.

Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ нь 297х210 мм-ийн хэмжээтэй, 200 гр/м–ын жинтэй, 80%2-иас дээш цайралт бүхий, бал, бахээр болон компьютер хэрэглэж бичихэд тохиромжтой сайн чанарын цаасан дээр хэвлэгдсэн байна.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ нь дэвсгэр хэсний цогцолбор, хүрээ хээ, нүдэнд үл үзэгдэх хэвлэлт, үндсэн бичвэр зэргээс бүрдэх бөгөөд дэвсгэр нь чанарын өндөр түвшинд үнэт цаасны хэвлэлийн нууцлалтайгаар хэвлэгдсэн байна.

3. Гэрчилгээний нийт гадаргууг дүүргэж байрлах дэвсгэр хээ нь гэрчилгээний нүүрэн талд хоёр захаасаа тэв рүүгээ цайвар ногоонооос цайвар хул шаргалруу уруссан өнгөөр хэвлэгдсэн байх ба суурь хээ, бичил бичвэр, соёмбоны суурь хээ, алхан хээ, бичвэр хээ, соёмбо зэргээс, гэрчилгээний ар талд суурь хээ, алхан хээ зэргээс тус тус бүрдсэн цогцолбор хээ юм.

3.1. Суурь хээг түмэн наст хээ болон алхан хээг хослуулсан хамар хээг 0,09 хэмхээтэй нарийн зураасаааар товойлгон урласан байх бөгөөд тодорхой хэсгүүдэд тогтмол бус хэмнэлтэйгээр нууцлалын түвшинд хэвлэгдсэн байна.

3.2. Гэрчилгээний гарчиг бичвэрийг дэвсэж 0,6 пунктын хэмжээтэй "Монгол Улс, Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн 37 мөр бүхий долгионтсон бичил бичвэр байрлана.

3.3. Гэрчилгээний зүүн дээд хэсэгт байрлах алтан соёмбыг суурилаж нарийн зураасуудаар нууцлалын тодорхой хэмнэлтэйгээр хэвлэгдэх соёмбоны суурь хээ байрлана.

3.4. Дэвсгэр хээний доод хэсэгт үндэсний алхан хээг тодорхой хэмнэл, өнцгүүдээр зурагдсан нарийн зураасуудаар дүүргэж хэвлэсэн байна.

3.5. Дэвсгэр хээний тэв хэсэгт тодорхой хэмнэлүүд бүхий өөр хоорондоо харилцан адилгүй өнцгүүдээр зурагдсан зургаан талт нарийн зураасаар хэвлэгдсэн соёмбо байрлана.

3.6. Соёмбоны дээд талд тодорхой хэмнэлүүд бүхий нарийн зураасаар дүүргэгдэж хэвлэгдэх "Монгол Улс", соёмбоны доод талд "Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн бичвэр хээнүүд тус тус байрлана.

3.7. Гэрчилгээний ар талд, нүүрэн талд байрлах суурь хээ болон алхан хээг тэдгээрээс хэмнэлийн зөрүүтэйгээр хэвлэсэн байна.

4. Дэвсгэр хээ болон гэрчилгээний үндсэн бичвэрүүдийг хашиж хүрээ хээ байрлах бөгөөд улаан туяа бүхий хар ногоон өнгөөр хэвлэгдсэн байна. Хүрээ хээ нь тодорхой хэмнэл бүхий үгалзсан нарийн зураасан хээ, бичил бичвэр, булангийн хээ, алхан хээ зэргээс бүрдэнэ.

5. Гэрчилгээний нүүрэн талын тэв хэсэгт соёмбо болон гэрчилгээний ар талын доод хэсэгт "Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн бичвэрүүдийг тус тус нүдэнд үл үзэгдэх будгаар хэвлэсэн байх ба эдгээрийг зөвхөн тусгай зориулалтын гэрлээр харахад зориулагдсан байна.

6. Гэрчилгээний нүүр болон ар талд батлагдсан загварын дагуу үндсэн бичвэрүүд байрлана:

6.1. Гэрчилгээний зүүн дээд буланд алтан соёмбоны дээр "УБ-2", баруун доод буланд "Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав" гэсэн бичилтүүд байрлана.

6.2. Гэрчилгээний дээд хэсэгт "Монгол Улс, Улсын Бүртгэлийн Гэрчилгээ" гэсэн гарчиг бичилтийг гэрчилгээний хүрээ хээний өнгөөр хэвлэсэн байна.

6.3. Гэрчилгээний үндсэн бичвэрүүд дээрээсээ дараахь дараалаар байрлана. Үүнд:

-1-2 дахь мөр: Зүүн дээд буланд бүртгэсэн "Он, сар, өдөр", баруун дээд буланд "Улсын бүртгэлийн дугаар", "Регистрийн дугаар" /2мөрөнд багтана/.

-3-5 дахь мөр: "Хуулийн этгээдийн нэр, хэлбэр", "Үүсгэн байгуулах баримт бичиг", үүсгэн байгуулсан "Шийдвэр", "Дугаар", "Огноо"(4 мөрөнд багтана).

-6 дахь мөр: "Код", "Үйл ажиллагааны чиглэл" (3 мөрөнд багтана).

-7 дахь мөр: "Хугацаа", "Гишүүдийн тоо", "Өөрийн хөрөнгийн хэмжээ (мян.төг)".

-8 дахь мөр: "Хуулийн этгээдийн хууль ёсны хаяг" (2 мөрөнд багтана).

-9 дэх мөр: "Бүртгэсэн байгууллагын нэр" (2 мөрөнд багтана). 9 дэх мөрийн зүүн доод талд тамга дарах зайнд "Тамга" гэсэн бичилт голлож байрлана.

Гэрчилгээний арын хэсэгт харилцагч банкны бүртгэл, хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл, "Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй." гэсэн бичвэрүүд байрлана.

7.Улсын бүртгэлийн гэрчилгээ нь загвар, хэвлэлтийн хувьд үнэт цаасны хэвлэлтийн нууцлалын дээд түвшинд хамаргдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 35** **Улаанбаатар хот**

Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзошгүй хүчтэй газар хөдлөлтийг судлах, инженер- сейсмологийн судалгаанд шаардагатай нүүдлийн станц авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Шинжлэх ухааны академийн саналыг үндэслэн хандивлагч орнуудын зээл, тусламжийн хүрээнд болон улсын төсөвт тусгах замаар шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт даалгасугай.

2. Инженер-сейсмологийн иж бүрэн судалгаа хийж, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох арга хэмжээнд жил бүр хоёроос доошгүй хот, суурин газрыг хамруулж, шаардагдах хөрөнгийг шинжлэх ухаан, технологийн сан болон улсын төсвөөс санхүүжүүлж сайжруулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын Газар хөдлөлт, техникийн магадлалын албанд барилга байгууламжийн хийц, бүтээцийн чанар байдлыг тогтоохоор хэрэглэх техееремж худалдан авахад шаардагдах 45.0 (дечин таван) сая төгрөгийг улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч тус албаны үйл ажиллагаанд 2004 оны урсгал зардалд шаардагдах 45.8 (дечин таван сая найман зуун мянган) сая төгрөгийг төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж цаашид үзэгдлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

4. Монгол Улсад ашиглагдаж байгаа мэдээлэл, холбооны техник хэрэгсэлд тулгуурлан гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог 2004 онд шинэчлэн байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт даалгасугай.

5. Баригдсан барилга байгууламжийн газар хөдлөлтэд тэсвэрлэх чадварыг үнэлж паспортжуулах ажлыг 2004-2005 онд багтаан дуусгаж газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн шаардлага хангагуй орон сууц болон бусад барилгын талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Газар хөдлөлтийн үед биеэ хамгаалах болон газар хөдлөлтийн хор уршгийн талаар сургалт сурталчилгаат радио, телевизээр 2004 оноос эхлэн явуулж байхыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга П.Даш нарт үүрэг болгосугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газар хөдлөлтөөс учрах хохирлыг багасгах, урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 206 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18- ны өдөр Дугаар 43 Улаанбаатар хот

Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй:

Дүүргийн Засаг дарга
88200-104000
Сумын Засаг дарга
82000-97600
Хорооны Засаг дарга
66400-78900
Багийн Засаг дарга
57700-69500

2. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалын цалинг тухайн шатны Засаг даргын албан тушаалын цалинтай адил байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 196 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 28 -ны өдөр Дугаар 44 Улаанбаатар хот

Тооны дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2004 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2004 оны 44 дүгээр тогтоолын хавсралт

2004 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаар

Д/д	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	110
2	Баян-Өлгий	80
3	Баянхонгор	207
4	Булган	30
5	Говь-Алтай	52
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	44
8	Дорноговь	32
9	Дорнод	60
10	Дундговь	60
11	Завхан	150
12	Орхон	15
13	Өвөрхангай	50
14	Өмнөговь	50
15	Төв	60
16	Увс	10
17	Сүхбаатар	104
18	Сэлэнгэ	50
19	Ховд	50
20	Хөвсгөл	79
21	Хэнтий	90
22	Улаанбаатар	85
	Бүгд	1478

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18- ны өдөр | **Дугаар 45** | **Улаанбаатар хот**

Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 болон 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны орон тоог 16-гаас, зардлыг 49900.0 (дөчин есөн сая есөн зуун мянга) мянган төгрөгөөс, чөлөөт бүсэд ажиллах мэргэжлийн хяналтын албаны орон тоог 15-аас дээшгүй байхаар тогтоосугай.

2. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд ажиллах гааль, татвар, хил хамгаалах байгууллагын бүтэц, орон тоо болон хэв журам сахиулах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албуудыг ажиллуулах зэрэг асуудлыг тухайн үед нь зохих журмын дагуу шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Чөлөөт бүсийн захирагчид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 18- ны өдөр | **Дугаар 46** | **Улаанбаатар хот**

Орон тоо, зардлын хязгаарыг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн дэд сайдаар ажиллаж байсан Л.Энхтайваныг Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Төрийн өмчийн хорооны гишүүнээр Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 25 - ны өдөр | **Дугаар 48** | **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн ажиллах журам"-ыг хавсралт ёсоор батлсугай.

2. Засгийн газрын 2003 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан "Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дүрэм"-д дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а/ 1 дүгээр заалт, 9 дүгээр заалтын 3, 14 дүгээр заалтын 2, 3-т "үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн" гэснийг, 7 дугаар заалтын "үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл" гэснийг 9 дүгээр заалтын "үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн" гэснийг тус тус "эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн" гэж өөрчилсүгэй;

б/ 9 дүгээр заалтын 2, 4, 6, 9, 10, 12-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2/ төрөөс хувьчилсан газар, орон сууц болон бусад эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн нотлох баримтыг үндэслэн эрхийн улсын бүртгэлд бүртгэх;

4/ шүүхийн шийдвэрийн үндсэн дээр эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, ашиглагч өөрчлөгдсөнийг бүртгэх, эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх;

6/ эд хөрөнгө өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох журмыг батлах, эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг нотолсны үндсэн дээр эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох, гэрчилгээний зарцуулалтын тайлан гаргах;

9/ эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн хувийн хэрэг нээх, бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, архив, мэдээллийн сангийн үйл ажиллагааг стандартын дагуу эрхлэн явуулах, хадгалалт, хамгаалалтын шаардлагыг хангаж ажиллах;

10/ эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаархи улсын нэгдсэн мэдээг сар, улирал, жилээр гаргах;

12/ улсын бүртгэгч болон эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгтэй харьцах эрх бүхий албан тушаалтнаар нууцын баталгаа гаргуулан ажиллуулах."

в/ 9 дүгээр заалтын 1, 8-ын "үл хөдлөх", 14 дүгээр заалтын 7-гийн "болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний" гэснийг тус тус хассугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм, журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2004 оны 48 дугаар тогтоолын хавсралт

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эд хөрөнгийн эрхийн улсын ерөнхий бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч (цаашид "ерөнхий бүртгэгч", "улсын бүртгэгч" гэх) нь эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг эрхийн улсын бүртгэл (цаашид "эрхийн улсын бүртгэл" гэх)-д бүртгэх баталгаажуулах үйл ажиллагаат хэрэгжүүлэхдээ энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгч нь үйл ажиллагаандаа Иргэний хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлага болгоно.

3. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгч нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахих, шийдвэр гаргахдаа бүсдын нөлөөнд үл автаж, шударга байх, чиргэдэлгүй, соёлтой үйлчлэх зарчмыг баримтална.

4. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгч нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12.2-т заасан шаардлагыг хангасан байна.

5. Ерөнхий бүртгэгч нь "эрхийн улсын ерөнхий бүртгэгч" гэсэн бичвэр, хувийн дугаар бүхий тэмдэгтэй байж, ерөнхий бүртгэгчийн албан бичгийн болон захирамжлалын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6. Улсын бүртгэгч нь эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрхийн улсын бүртгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэгтэй байна.

Хоёр. Ерөнхий бүртгэгч, улсын бүртгэгчийн эрхлэх үйл ажиллагаа

7. Ерөнхий бүртгэгч дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

1/эрхийн улсын бүртгэлийн албыг мэргэжлийн удирдлагаар хангаж, ёдөр тутмын үйл ажиллагаат нь зохион байгуулж, хяналт тавих;

2/Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.5, 18.3, 37.2-т заасан холбогдох заавар, журам, маягтыг баталж мөрдүүлэх;

3/эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн архив, мэдээллийн санг бүрдүүлж,

архив, мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын найдвартай бэлэн байдлыг хангах асуудлыг зохион байгуулж, тэдгээрийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих;

4/эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

5/эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ (цаашид "гэрчилгээ" гэх)-ний бичилт, зарцуулалт, олголтод хяналт тавих;

6/шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон болон үрэгдүүлсэн, гээгдүүлсэн гэрчилгээг хүчингүй болгож, нөхөн олгох талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргах;

7/Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.3, 7.5, 7.6, 12.6, 18.6 болон 20 дугаар зүйл, 23.1-д заасны дагуу улсын бүртгэгч бүртгэлийг алдаатай хийсэн эсэхийг тогтоож, алдаатай бол бүртгэлд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хаах шийдвэр гаргах;

8/тухайн эд хөрөнгийн анхны өмчлөгч болон барьцаалсан, түрээслэсэн, худалдаж, арилжсан, хамтран өмчлөгч нэмэгдсэн, хасагдсан, өв залгамжлал, гэрээслэл мөн шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөн, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдсэн талаархи нотлох баримт, нотолгоо, тайлбар, лавлагаат эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн архивын нотлох баримтад үндэслэн бүх шатны шүүх, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх зэрэг хуулийн байгууллагад гарган өгч, эд хөрөнгийн эрхийн талаархи маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримтуудаар ханган, хуульд заасны дагуу криминалистик шинжилгээний эх материал, хувийн хэргийг бэлтгэж өгөх;

9/шаардлагатай тохиолдолд эд хөрөнгийн маргаан болон эрхийн улсын бүртгэлтэй холбоотой шүүх хуралд орох;

10/эрхийн улсын бүртгэлийн талаархи улсын нэгдсэн дүн мэдээг гаргаж, холбогдох газрууд, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;

11/эрхийн улсын бүртгэлийн асуудлаар болон улсын бүртгэгчийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэх.

8. Улсын бүртгэгч дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

1/иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх үүсэх тухай нотлох баримтуудыг эрх зүйн үүднээс хянан дүгнэлт өгч, өмчлөх эрхийг төрөөс баталгаажуулан, тухайн эд хөрөнгийн хувийн хэрэг, архивыг үүсгэн бий болгох;

2/эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулахтай холбогдсон өмчлөгч өөрчлөгдөх, хамтран өмчлөгч нэмэгдэх, хасагдах, гэрээслэл, өв залгамжлал зэрэг тухайн өмчтэй холбоотой эрхийн улсын бүртгэлийг өмчийн талаархи архивын нотлох баримт бүхий хувийн хэрэгт бүртгэх бүртгэл явуулах;

3/эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх баталгаажуулсан эд хөрөнгө худалдах, бэлэглэх, арилжих, түрээслэх, барьцаалж зээл авах зэрэг үйлдлүүдийн эрхийн улсын бүртгэлийг тухайн эд хөрөнгийн архивын хувийн хэрэгт нь бүртгэж, байгуулагдсан гэрээг хуулийн дагуу хүчин төгөлдөр болгох;

4/эрхийн улсын бүртгэлийн мэдүүлэг (цаашид "мэдүүлэг" гэх)-ийг хүлээн авч, эрх зүйн дүгнэлт өгөн, мэдүүлэг болон түүнд хавсаргасан нотлох баримтын хуудас бүрт хүлээн авсан тэмдэг дарж, хуудсыг дугаарлан, хүлээж авсан огноо, цаг, минутыг бичсэний дараа цахим санд мэдээллийг оруулна. Цахим мэдээллийн сан байхгүй нөхцөлд эрхийн улсын бүртгэлийн холбогдох дэвтрүүдийг хөтөлнө;

5/эрхийн улсын бүртгэлийн талаархи аливаа бүртгэлийг хийхдээ ямар үйлчилгээ хийлгэх гэж байгаа тухай өмчлөгчийн тодорхойлолтыг нотлох баримтын бүрдэлд заавал авах;

6/эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг (цаашид "хувийн хэрэг" гэх)-ийг нээн хөтөлж, эрхийн улсын бүртгэлийн код, дугаар олгон, гэрчилгээнд бичилт хийх, нотлох баримтыг мэдүүлэг орж ирсэн огнооны дараалаар дугаарлаж, хуудасны дугаарыг баруун дээд өнцөгт нь бичиж үдэх;

7/эд хөрөнгө өмчлөх, эзэмших, барьцаалах, ашиглах эрхтэй холбоотой гэрээ хэлцэл, өөрчлөлт, хөдөлгөөнийг бүртгэх, хувийн хэрэгт баяжилт хийх бөгөөд гэрээ хэлцэлд "эрхийн улсын бүртгэлд бүртгэв" тэмдгийг дарж, мэдүүлэг гаргасан огноог тавин, гарын үсгээ зурж, гэрээг хуулийн дагуу хүчин төгөлдөр болгох;

8/анхны бүртгэлийг хийхдээ өмчлөгчийн өөрийнх нь гаргасан өргөдлэд эд хөрөнгийн байршил, хэмжээ, зориулалт зэргийг тодорхой тусгуулахаас гадна хамтран өмчлөгч бий эсэх, хэрэв байгаа бол хамтран өмчлөгчдийн овог, нэр, регистрийн дугаарыг, хамтран өмчлөгч байхгүй бол байхгүй гэдгийг нь өөрөөр нь нотлон бичүүлж, нотариатаар гарын үсгийг үнэн зөвийг, мөн бүх өмчлөгчдийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбарыг гэрчлүүлснээр авах, мөн Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17.1.6-д заасныг баримтлан ажиллах;

9/иргэн, хуулийн этгээдийн өөрийнх нь хөрөнгөөр баригдсан нийтийн орон сууцны барилгыг бүртгэхдээ өмчлөгчдийн нэрсийн жагсаалт, сууцны үнийг төлсөн тодорхойлолт, барилгыг улсын комисст хүлээлгэн өгсөн тухай акт, фото зураг, план зураг зэргийг үндэслэн бүртгэх, энэ үндсэн дээр тухайн орон сууцны барилгаас худалдагдсан байр, өрөөг мэдүүлгээр орж ирсэн гэрээний үндсэн дээр дараагийн өмчлөгчид шилжүүлэн бүртгэж, эхний өмчлөгчийн гэрчилгээнээс хасалт хийх замаар бүртгэх;

10/газар өмчлөх эрхийг баталгаажуулж, эрхийн улсын бүртгэлд бүртгэхдээ газрын нэгж, талбарын дугаар олгогдсон эсэхийг хянах;

11/нотлох баримтад эд хөрөнгийн 4 талаас нь бүрэн харуулсан фото зургийг заавал хавсаргах, 4 талаас нь авах боломжгүй тохиолдолд объектыг алсаас бүтэн харуулсан фото зургийг авч, уг фото зурган дээр тухайн объектыг улаанаар тойруулан зурж, тодотгож өгөх, хэрэв нийтийн орон сууц бол орон сууцны барилгын фото зургийг бүхэлд нь авч тухайн байрных нь цонхыг дугуйлан тэмдэглүүлэх, фото зургийг А4 хэмжээтэй цаасан дээр наалгаж, объектын аль тал нь болохыг өмчлөгчөөр нь бичүүлэн хүлээж авах;

12/нотлох баримтад эд хөрөнгийн план зургийг заавал хавсаргах бөгөөд план зураг эд хөрөнгийн талбайг өмчлөгчөөр нь тодорхойлуулж, бичүүлсэн байх;

13/эд хөрөнгө өмчлөх эрх нь нэг этгээдээс негөөд шилжэн тохиолдолд эхний өмчлөгчийн гэрчилгээг хүчингүй болгох бөгөөд гэрчилгээнд "хүчингүй" гэсэн тэмдэг дарж огноо тавин, хувийн хэрэгт хавсаргах;

14/эд хөрөнгийн өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл хийх бүрт шинэ өмчлөгчдийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлснээр хавсаргаж байх;

15/Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу мэдүүлэг гаргагчийн шаардлагын хэмжээнд лавлагаа, хуулбар гаргаж өгөх бөгөөд лавлагааны хуудсанд хувийн дугаар бүхий тэмдэг дарж, гарын үсгээ зурж баталгаажуулна;

16/эрхийн улсын бүртгэлтэй холбогдож ирүүлсэн болон явуулсан албан бичиг, өргөдөл, өргөдлийн хариу, шүүхийн шийдвэр, шүүхэд гаргасан тайлбар, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн актууд, эрхийн улсын өрөнхий бүртгэгчийн шийдвэр зэрэг холбогдох нотлох баримтуудыг тухайн хувийн хэрэгт хавсарган, холбогдох бичилтийг хувийн хэрэгт бүрэн гүйцэд хийж байх;

17/эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг боловсруулан цахим санд оруулах;

18/архиваас хувийн хэргийг хүлээн авч, тухайн ажлын өдөрт багтаан архивт буцаан хүлээлгэж өгч хувийн хэргийг хүлээлцсэн гарын үсэг зурах;

19/мэдүүлэг гаргагчийн мэдүүлгийг буцаахдаа бүртгэхээс татгалзсан үндэслэл, тайлбарыг тодорхой бичиж, гарын үсгээ зуран, хувийн дугаар бүхий тэмдгээ дарж, буцаасан огноог тавих;

20/эрхийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулсан гэрээ, хэлцэл, гэрчилгээ, лавлагаа, бүртгэхээс татгалзсан мэдүүлгийг түүнд хавсаргасан баримт бичгийн хамт мэдүүлэг

гаргагчийн биеийн байцаалтыг нь үндэслэн олгож, хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулах, хэрэв итгэмжлэлээр үйлчлүүлэх бол итгэмжлэлийн нотариатаар гэрчлэгдсэн хувийг авах;

21/эрхийн улсын бүртгэлийн мэдээ болон гэрчилгээний зарцуулалтын тайланг сар бүр гаргаж, дараа сарын 5-ны дотор өгөх;

22/өөрийн гүйцэтгэсэн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой шүүх хуралдаанд оролцох;

23/аливаа эрхийн улсын бүртгэлийн талаархи хувийн хэргийн бичилт, лавлагаа, гэрчилгээнд хувийн дугаар бүхий тэмдгийг тэгш, тод, гаргацтай, бүтэн дарах;

24/эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт холбогдох бичилтүүдийг тухай бүр нь хар бэхээр дэлгэрэнгүй гаргацтай бичиж, түүнтэй холбогдох нотлох баримтын хуудасны дугаарыг зааж, бичилт хийсэн огноо, эрхийн улсын бүртгэгчийн хувийн дугаар бүхий тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулах.

Гурав. Ерөнхий болон улсын бүртгэгчийн эрх, үүрэг

9. Ерөнхий бүртгэгч нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаас гадна дараахь эрхийг эдэлнэ:

1/улсын бүртгэгчид үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих;

2/архиваас хувийн хэргийг татан үзэж, шалгах, хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авах;

3/улсын бүртгэгчийн үйл ажиллагааг шалгах, дүгнэх болон холбогдох бусад арга хэмжээг авч ажиллах.

10. Ерөнхий бүртгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

1/нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн болон эрх бүхий этгээд албан тушаалаа ашиглаж хууль бус шийдвэр, тодорхойлолт гаргасан нь эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад илэрвэл энэ тухай холбогдох хуулийн байгууллагад мэдэгдэх;

2/өөрийн гаргасан шийдвэр болон эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар хянуулах;

3/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

11. Улсын бүртгэгч нь дараахь эрх эдэлнэ:

1/нотлох баримт бичиг дутуу гэж үзвэл мэдүүлэг гаргагчаас нэмэлт материал шаардах;

2/эд хөрөнгө өмчлөх, зээмших, ашиглах эрхийг нотлох баримт бичгийн талаар эргэлзээ төрвөл ерөнхий бүртгэгчээс туслалцаа дэмжлэг авах, холбогдох нотлох баримтыг хянуулж, дүгнэлт гаргуулах;

3/удирдлагын зүгээс нотлох баримт дутуу, хууль бус бүртгэл хийхийг үүрэг болгох, шаардах тохиолдолд түүнээс татгалзах;

4/биеийн байцаалт, эсхүл итгэмжлэлгүй хүнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаар үйлчлэхгүй байх;

5/хууль тогтоомжид заасан бусад эрх.

12. Улсын бүртгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

1/мэдүүлэг гаргагч мэдүүлгийг үнэн зөв, гүйцэд бөглөсөн эсэхийг шалгах;

2/нотлох баримтын бүрдэл гүйцэд, үнэн зөв эсэхэд дүгнэлт өгч, эрхийн улсын бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэх;

3/тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсийг зохих журмын дагуу бүрэн гүйцэд төлүүлэх;

4/мэдүүлэгт хавсаргасан баримт бичгийг хүлээн авсан огнооны дараалаар дугаарлаж, хувийн хэргийг эмх цэгцтэй байлган, нягт нямбай хөтлөх;

5/зөвхөн өөрийн хариуцах хувийн хэргийг архиваас авах;

6/өөрийн бүрүүтай үйлдлээс гэрчилгээ бүрэу бичигдэж хүчинтүй болбол түүний үнийг зохих журмын дагуу төлөх;

7/өөрийн хариуцан бүртгэсэн бүртгэлийн хувийн хэргийн нотлох баримтын бүрдэл болсн бүртгэлийн үнэн зөвийг хуулийн өмнө хариуцах;

8/эрхийн улсын бүртгэлтэй холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн нууцыг хадгалах;

9/хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

13. Эрхийн улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

1/хүлээж авсан мэдүүлэг, түүнд хавсргадах нотлох баримтыг дарагдуулах, алга болгох, хууль зүйн үндэслэлгүйгээр буцаах;

2/анхны бүртгэлийг хийхдээ зөвхөн анхны өмчлөгчийг бүртгэсний дараа дараагийн өмчлөгчид шилжүүлсэн бүртгэл хийх, өөрөөр хэлбэл анхны өмчлөгчөөс хэд хэдэн өмчлөгчид дамжсан байхад хамгийн сүүлийн өмчлөгчөөр анхны бүртгэл хийх;

3/үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэх, хүнд суртал гаргах, тэдэнд хууль бус шаардлага тавих, зүй бусаар харилцах;

4/өөрийн гүйцэтгэх бүртгэлийн үйл ажиллагаанд хамааралгүй хувийн хэргийг архивааc авч үзэх;

5/үүрэгт ажлаа гүйцэтгэсний төлөө шан харамж авах;

6/хувийн хэрэгт засвар хийх, хүлээж авсан мэдүүлгээс гадуур нотлох баримт нэмэх, хасах, нотлох баримтыг устгах, хувийн хэргийг алга болгох, хувийн хэргийн хуудсыг устгаж үгүй болгох;

7/нотлох баримтыг хуурамчаар үйлдэхэд оролцох, энэ талаар заавар зөвлөгөө өгөх;

лавлагаа, мэдээллийг нотлох баримтаас зөрүүтэйгээр хуурамчаар гаргаж өгөх, хувийн дугаар бүхий тэмдгээ ашиглах боломжийг бусдад олгох, хувийн дугаар бүхий тэмдгээ хууль бусаар ашиглах;

9/улсын бүртгэгчийн хувийн дугаар бүхий бусдын тэмдгийг ашиглах;

10/эрхийн улсын бүртгэлийн дугаарыг давхардуулан олгох, тухайлбал нэг эд хөрөнгөд нэгээс илүү дугаар олгох, эсхүл өөр өөр эд хөрөнгөд нэг дугаар олгон хувийн хэрэг нээж бүртгэл хийх, дугаарыг алгасаж олгох;

11/эрхийн улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эд хөрөнгийг хууль бусаар дахин бүртгэж, гэрчилгээ олгох;

12/эрхийн улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай өрөнхий бүртгэгч, эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга болон эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэрийг зөрчиж, бүртгэлд хөдөлгөөн хийх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 27 - ны өдөр | **Дугаар 51** | **Улаанбаатар хот**

Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гамшгаас хамгаалах өрөнхий газрын харьяа салбар, нэгжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Гамшгаас хамгаалах өрөнхий газрын харьяа салбар, нэгжийн зохион байгуулалт, орон тоог батлагдсан төсөвтөө багтаан тогтоож мөрдөхийг Гамшгаас хамгаалах өрөнхий газрын дарга П.Дашид үүрэг болгосугай.

3. Аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах штабыг тухайн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд агентлаг хэлбэрээр ажиллуулахаар тогтоосугай.

4. Татан буугдсан Гал түймэртэй тэмцэх газар, Иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газрын төсвийг тухайн төсвийн өрөнхийлөн захирагчийн төсвийн багцаас Өрөнхий сайдын төсвийн багцад шилжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

5. "Аймгийн Засаг даргын Тамгын газрын өрөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл болон "Нийслэлийн Засаг

дэргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 6 дугаар зүйлд "Цэрэг-иргэний хамгаалалтын штаб" гэснийг тус тус "Цэргийн штаб" гэж өөрчилсүгэй.

6. Цэрэг-иргэний хамгаалалтын штабыг Цэргийн штаб болгосонтой холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн Цэрэг-иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалтын чиг үүрэг бүхий орон тоог зохих төсөв, зардлын хамт Самгтаас хамгаалах штабт шилжүүлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын дор дурдсан тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

а/"Галын аюулаас хамгаалах газрын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоол;

б/"Иргэний хамгаалалтын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1994 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 185 дугаар тогтоол;

в/"Улсын нөөцийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 232 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс бусад зүйл, заалт;

г/"Зарим отряд, салбарыг өргөтгөх, байгуулах, санхүүжүүлэх тухай" 1999 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 169 дүгээр тогтоол;

д/"Аймгийн Засаг дарын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо удирдлагын бүдүүвчийг шинэчлэн тогтоох тухай" 2000 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн "Гал түймэртэй тэмцэх алба" гэсэн хэсэг;

е/"Нийслэлийн Засаг дарын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн "х" заалтыг.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЛБАР, НЭГЖ

1. Архангай аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 51 дүгээр анги, аврах отрядтай/.

2. Баянхонгор аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 16 дугаар ангитай/.

3. Булган аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 20 дугаар анги, аврах салбар, Хангал сумын Хялганат хороон дахь гал унтраах Ш зэрэглэлийн 55 дугаар ангитай/.

4. Баян-Өлгий аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 31 дүгээр ангитай/.

5. Говь-Алтай аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 59 дүгээр ангитай/.

6. Говьсүмбэр аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 37 дугаар ангитай/.

7. Дорнод аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 52 дугаар анги, аврах отрядтай/.

8. Дархан-Уул аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 22 дугаар анги, гал унтраах П зэрэглэлийн 54 дүгээр анги, Шарын гол суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 50 дугаар ангитай/.

9. Дорноговь аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 33 дугаар ангитай/.

10. Дундговь аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 25 дугаар ангитай/.

11. Завхан аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 43 дугаар анги, Тосонцэнгэл суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 39 дүгээр ангитай/.

12. Орхон аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 56 дугаар ангитай/.

13. Өмнөговь аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 21 дүгээр ангитай/.

14. Өвөрхангай аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 12 дугаар анги, Хархорин суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 45 дугаар ангитай/.

15. Сүхбаатар аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 15 дугаар ангитай/.

16. Сэлэнгэ аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 36 дугаар анги, аврах салбар, Хөтөл суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 61 дүгээр анги, Мандал суман дахь гал унтраах Ш зэрэглэлийн 19 дүгээр ангитай/.

17. Төв аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 24 дүгээр анги, аврах салбартай/.

18. Увс аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 41 дүгээр ангитай/.

19. Ховд аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах Ш зэрэглэлийн 48 дугаар анги, аврах отрядтай/.

20. Хөвсгөл аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 27 дугаар анги, аврах салбартай/.

21. Хэнтий аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах П зэрэглэлийн 32 дугаар анги, аврах салбартай/.

22. Нийслэл дэх Гамшгаас хамгаалах штаб /гал унтраах I зэрэглэлийн 10 дугаар анги, аврах отрядтай, дүүргийн Гамшгаас хамгаалах штабууд, гал унтраах П зэрэглэлийн 14 дүгээр анги, 18 дугаар анги, 26 дугаар анги, 28 дугаар анги, 30 дугаар анги, 34 дүгээр анги, 63 дугаар анги, 64 дүгээр анги, гал унтраах Ш зэрэглэлийн 11 дүгээр анги, 65 дугаар анги, 80 дугаар ангиудтай/.

23.Гамшгаас хамгаалах тусгай анги / шуурхай бүлэгтэй/.

24.Хангалт үйлчилгээний анги /тээврийн хэсэгтэй/.

Хоёр. Аж ахуйн тооцоотой

25. Улаанбаатар хот дахь хүнсний нөөцийн салбар.

26. Улаанбаатар хот дахь "объект №3" (бараа, өвс тэжээлийн нөөцийн салбартай).

27. Орхон аймаг дахь бараа, өвс тэжээлийн нөөцийн салбар.

28. Дорнод аймаг дахь бараа, өвс тэжээл, шатахуун, үр тарианы нөөцийн салбар.

29. Увс аймгийн Баруунтуруун сум дахь өвс тэжээл, үр тарианы нөөцийн салбар.

30. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум дахь өвс тэжээл, үр тарианы нөөцийн салбар.

31. Баян-Өлгий аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

32. Завхан аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

33. Дорноговь аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

34. Дундговь аймаг дахь өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

35. Ховд аймаг дахь бараа, өвс тэжээл, шатахууны нөөцийн салбар.

36. Архангай аймгийн Түвшрүүлэх сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

37. Баянхонгор аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

38. Булган аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

39. Говь-Алтай аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

40. Говьсүмбэр аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

41. Өмнөговь аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

42. Өвөрхангай аймгийн Сант сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

43. Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

44. Төв аймгийн Бүрэн сум дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

45. Увс аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

46. Хөвсгөл аймаг дахь өвс тэжээлийн нөөцийн салбар.

47. Булган аймгийн Сэлэнгэ сум дахь үр тарианы нөөцийн салбар.

48. Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь үр тарианы нөөцийн салбар.

49. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум дахь үр тарианы нөөцийн салбар.

50. Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь үр тарианы нөөцийн салбар.

51. Төв аймгийн Цээл сум дахь үр тарианы нөөцийн салбар.

52. Төв аймгийн Жаргалант сум дахь үр тарианы нөөцийн салбар.

53. Хөвсгөл аймгийн Тариалан сум дахь үр тарианы нөөцийн салбар.

54. Дархан-Уул аймаг дахь өвс тэжээл, шатахуун, үр тарианы нөөцийн салбар.

55. Сэлэнгэ аймгийн Баянгол сум дахь шатахууны нөөцийн салбар.

56. Улаанбаатар хот дахь шатахууны нөөцийн салбар.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 2 дугаар сарын 27- ны өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: баталсугай.

"Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэм"-ийг хавсралт ёсоор

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2004 оны 52 дугаар тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчдад тавигдах нийтлэг шаардлага, түүнийг биелүүлэхэд амжилт гаргагчдыг шагнах, урамшуулах, шаардлагыг зөрчигчдөд сахилгын шийтгэл ногдуулахад энэ дүрмийг дагаж мөрдөнө.

2. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагч /цаашид "албан хаагч" гэх/-ийн эрх зүйн болон ёс зүйн хэмжээг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга тогтооно.

3. Албан хаагч нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, дор дурдсан хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагын болон албан тушаалтны шийдвэрийн заалтыг ёсчлон биелүүлнэ:

а/Төрийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж;

б/энэ дүрэм, Засгийн газрын шийдвэр, Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын тушаал;

в/Гамшгаас хамгаалах ерөнхий газар, аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб, харьяалагдах салбар, нэгжийн зохих шатны удирдлагын шийдвэр;

г/аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын шийдвэр.

4. Албан хаагч дараахь үүргийг сахиж мөрдөнө:

а/үүргээ шударгаар биелүүлэх;

б/төр, засгийн бодлогыг хэрэгжүүлэх;

в/удирдлагаас шийдвэр гаргахад нөлөөлехгүй байх.

5. Албан хаагч дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хоригломо:

а/албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараах;

б/төр, засгийн бодлого, шийдвэрийг гуйвуулан шүүмжлэх;

в/аль нэг улс төрийн хүчин, намыг илт дэмжих буюу шүүмжлэх байдлаар ялгавартай хандах;

г/төрийн үйлчилгээг үзүүлэхдээ иргэд болон байгууллага, аж ахуйн нэгжийг ёмчийн хэлбэрээр ялгаварлах, танил тал харах, хүнд суртал гаргах, чирэгдүүлэх;

д/тухайн байгууллагын ёмч херөнгө, техник хэрэгсэл, мэдээ, мэдээллийн санг албаны бус зорилгоор ашиглах;

е/еөрийн албан тушаалын давуутай тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах;

ж/албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд соогтуруулах ундаа хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргах.

6. Албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр адил албан хаагчид хамтарч үүрэг гүйцэтгэх үед захирах даргаас тэдний хэн нь ахлахыг заавал тогтоож өгнө.

Хоёр. Шагнал, урамшуулал

7. Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаас гадна албан хаагчдыг дор дурдсанаар шагнаж урамшуулна:

а/баяр хүргэж бие бүрэлдэхүүнд мэдээлэх;

б/урьд оноогдуулсан сахилгын шийтгэлийг хугацааныг нь өмнө арилгах;

в/зургийг нь хүндэт самбарт тавьж алдаршуулах;

г/байгууллагын хүндэт дэвтэрт нэрийг нь бичих;

д/батлагдсан журамд нийцүүлэн хугацааны өмнө цол олгох.

8. Албан хаагч нь энэ дүрмийн 3, 4-т заасан хэм хэмжээ, үүргээ биелүүлэх талаар онцгой болон тогтвортой амжилт гаргасан нь шагнаж урамшуулах үндэслэл болно.

9. Албан хаагчдад шагнал, урамшуулал олгохдоо түүний гаргасан амжилт, ажилласан хугацаа, албаны төрөл, мэргэжлийг харгалзана.

10. Албан хаагчдад дор дурдсан удирдах албан тушаалтан дараахь шагнал урамшуулыг олгоно:

а/энэ дүрмийн 7 дахь заалтын "а"-д зааснаар харьяалагдах ажилтандаа баяр хүргэх урамшуулыг бүх шатны дарга;

б/Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2, 31.2-т заасан шагнал, энэ дүрмийн 7 дахь заалтын "б", "в", "г" -д заасан урамшуулыг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга;

в/энэ дүрмийн 7 дахь заалтын "д"-д заасан шагналыг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга;

г/Төрийн албаны тухай хуулийн 31.1.3-т заасан шагналд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга тодорхойлно.

11. Албан хаагчийг шагнаж, урамшуулах саналыг дор дурдсанаар уламжилна:

а/салбар, нэгжийн дарга нь энэ дүрмийн 7 дахь заалтын "б"-д зааснаар харьяалах ажилтнаа урамшуулах саналыг харьяа салбар, нэгжийн шийдвэр гаргах эрх бүхий даргад, тэр нь Гамшгаас хамгаалах штабын даргад, штаб нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад;

б/харьяа салбар, нэгжийн шийдвэр гаргах эрх бүхий дарга нь Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2-т болон энэ дүрмийн 7 дахь заалтын "в"; "г"-д зааснаар шагнаж урамшуулах саналыг Гамшгаас хамгаалах штабын даргад, штаб нь Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад;

в/газрын тэргүүн дэд, дэд дарга, газар, хэлтсийн дарга нь энэ дүрмийн 7 дахь заалтын "б", "в", "г", "д"-д болон Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2-т зааснаар шагнаж, урамшуулах тухай саналыг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад.

12. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, 31.1.2, 31.2-т болон энэ дүрэмд заасан бүх шагнал урамшуулыг олгох эрхтэй бөгөөд 31.1.3-т зааснаар Засгийн газар, төрийн дээд байгууллагад тодорхойлно.

13. Шагнал, урамшуулыг бие бүрэлдэхүүн, хамт олны өмнө, эсхүл хурал цуглаан дээр амаар буюу тушаал үншин мэдэгдэж, хүндэтгэлийн байдалтай олгох буюу мэдээлнэ.

Гурав. Сахилгын шийтгэл

14. Энэ дүрэм, дотоод албаны дүрэм, дотоод журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол албан хаагчид сахилгын шийтгэлногдуулна.

15. Албан хаагч энэ дүрмийн 3, 4-т заасан хэм хэмжээ, үүргээ зөрчсөн, эсхүл хангалтгүй биелүүлсэн нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

16. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг заавал шалгаж тогтоон, энэ тухай баримт, үндэслэлийг зөрчил гаргасан албан хаагчид урьдчилан танилцуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагч уг баримт материалтай танилцаад нэмэлт тайлбар хийх, дахин шалгахыг шаардах эрхтэй.

17. Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахдаа Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ыг мөрдөнө.

18. Албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 26.1-д зааснаас гадна дор дурдсан шийтгэл ногдуулна:

а/төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 сар хүртэл хугацаагаар хасах;

б/цолны цалинг 3 сар хүртэл хугацаагаар хасах;

в/цолыг нэг шатаар бууруулах, эсхүл цол олгохыг хойшлуулах;

19. Албан хаагчид ногдуулах сахилгын шийтгэл нь зөрчлийн шинж, учруулсан хохирол, гэм буруу тохирсон байна.

20. Сахилгын шийтгэлийг дор дурдсан албан тушаалтан ногдуулна:

а/Төрийн албаны тухай хуулийн 26.1.1-д заасан сахилгын шийтгэлийг бүх шатны дарга;

б/ энэ дүрмийн 18 дахь заалтын "а", "б"-д заасан сахилгын шийтгэлийг тухайн албан хаагчийг ажилд томилсон дарга;

в/Төрийн албаны тухай хуулийн 26.1.1-26.1.3-т болон энэ дүрэмд заасан сахилгын шийтгэлийг Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга.

21. Албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг дор дурдсанаар уламжилна:

а/тухайн албан хаагчийг харьяалах дарга нь Төрийн албаны тухай хуулийн 26.1.2-т болон энэ дүрмийн 18 дахь заалтын "б"-д заасан шийтгэл ногдуулах тухай саналыг салбар, нэгжийн даргад, салбар, нэгжийн дарга нь тухайн албан хаагчийг ажилд томилсон даргад;

б/салбар, нэгжийн дарга нь Төрийн албаны тухай хуулийн 26.1.3-т, энэ дүрмийн 18 дахь заалтын "в"-д заасан шийтгэл ногдуулах тухай саналаа Гамшгаас хамгаалах штабын болон Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргад.

22. Дүрэм, журмаар тогтоосон хэм хэмжээг анх удаа зөрчсөн албан хаагчид гэм буруу тайлбарлан ойлгуулсны үндсэн дээр амаар сануулж болно.

23. Гаргасан зөрчил нь жижүүрлэлтийн үед болон бүлэглэн үйлдэгдсэн, эсхүл согтуурсан, өмч хөрөнгө шамшигдуулсан бол шийтгэлийг хүндрүүлэх үндэслэл болно.

24. Гамшгаас хамгаалах штабын болон ерөнхий газрын даргын тушаалаар албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, өөрт нь мэдэгдэн бие бүрэлдэхүүнд танилцуулна.

25. Дүрэм, журмаар тогтоосон хэм хэмжээг сахиулах талаар арга хэмжээ авааГүй, зөрчил дутагдлыг нуун дарагдуулсан албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээргүй бол энэ дүрэмд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

26. Сахилгын шийтгэлийг давхардуулан болон албан хаагчийн нэр хүндийг гутаах, дарамтлах зорилгоор ногдуулахыг хориглоно.

27. Сахилгын шийтгэл арилгах эрхийг уг шийтгэлийг ногдуулсан дарга эдэлнэ. Шаардлагатай гэж үзвэл дээд шатны дарга шийтгэлийг арилгаж болно.

28. Сахилгын шийтгэлийг илрүүлснээс болон гаргаснаас хойшхи, түүнчлэн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаанд Төрийн албаны тухай хуулийн 26.4, 26.6-д заасныг баримтална.

29. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн гаргасан зөрчилд захиргааны шийтгэл ногдуулсан бол сахилгын шийтгэл давхардуулан ногдуулахгүй.

30. Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

Дөрөв. Бусад зүйл

31. Салбар, нэгж бүрт албан хаагчийн шагнал, урамшуулал болон сахилгын шийтэлийн бүртгэлийг энэхүү журмын хавсралтын дагуу хөтөлнө. Бүртгэлийг жилд нэг удаа тухайн албан хаагчид танилцуулж гарын үсэг зуруулж байна.

32. Шагнал, урамшуулал, сахилгын шийтэлийг зөв хэрэглэж байгаа эсэх болон бүртгэлийн хөтлөлтийн байдалтай Гамшгаас хамгаалах штабын болон ерөнхий газрын дарга жилд 1 удаа танилцаж илэрсэн зөрчлийг арилгуулж байна.

33. Албан хаагч өөр салбар, нэгжид шилжсэн тохиолдолд түүний шагнал, урамшуулал болон сахилгын шийтгэлийн бүртгэлийг тухайн томилогдсон салбар, нэгжид шилжүүлнэ.

Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн сахилгын дүрмийн хавсралт

АЛБА ХААХ БҮРТГЭЛ

(Нүүр тал)

АЛБА ХААХ БҮРТГЭЛ

1.Албан тушаал .....

2.Цол .....

3.Овог ....., нэр .....

4.Албанд ирсэн ... он ... сар ... өдөр

САЙШААЛ

Юуны учир, ямар сайшаал хүртсэн	*Сайшаагдсан огноо*	*Хэн сайшаасан*	*Баталгаажуулсан хүний цол, гарын үсэг*	*Албан хаагчийн гарын үсэг*

(Ар тал)

САХИЛГЫН ШИЙТГЭЛ

Хэзээ, ямар зөрчил гаргасан	*Шийтгэсэн он, сар, өдөр, тушаалын дугаар*	*Хэн шийтгэсэн*	*Баталгаажуулсан хүний цол, гарын үсэг*	*Албан хаагчийн гарын үсэг*

Танилцсан тухай тэмдэглэл

.....
.....
.....

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр **Дугаар 53** **Улаанбаатар хот**

Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэлийн саналыг үндэслэн 2004 онд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг хавсралт ёсоор тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ө.ЭНХТҮВШИН

ИРГЭДЭД 2004 ОНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

д/д	Аймаг, нийслэлийн нэрс	Өмчлүүлэх газрын байршил	Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-гаар/	Өмчлүүлэх газрын зориулалт /га-гаар/						
				Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар	Үүнээс		Аж ахуйн зориулалтаар	Үүнээс		
					Одоо эзэмшиж, ашиглаж байгаа газрын нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ		Үр тарианы	Төмс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад аж ахуйн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Архангай	Аймгийн болон сумын төвд	18145.21	7388.91	325.5	7063.41	10756.3	8070.9	2685.4	
2	Баян-Өлгий	Аймгийн болон сумын төвд	2185	1570.4	410.6	1159.8	614.6		316	298.6
3	Баянхонгор	Аймгийн болон сумын төвд	300.5	200.5	143.5	57	100		35	65
4	Булган	Аймгийн болон сумын төвд	64273.1	2310.46	1056.58	1253.88	61962.64	60005	1409.5	548.14
5	Говь-Алтай	Аймгийн болон сумын төвд	722.61	426.43	382.63	43.8	296.18	186	105	5.18
6	Говьсүмбэр	Аймгийн болон сумын төвд	507.04	496	50.6	445.4	11.04		6	5.04
7	Дархан-Уул	Аймгийн болон сумын төвд	2434.7	671.5	621.1	50.4	1763.2	1672	70	21.2
8	Дорноговь	Аймгийн болон сумын төвд	758.4	694.5	288.9	405.6	63.9		42	21.9
9	Дорнод	Аймгийн болон сумын төвд	5547	2808	1750.6	1057.4	2739	2605.5	113.5	20
10	Дундговь	Аймгийн болон сумын төвд	2322	2322	2195	127	0			
11	Завхан	Аймгийн болон сумын төвд	454.79	406.29	380.69	25.6	48.5		46	2.5
12	Орхон	Аймгийн болон сумын төвд	961.6	757.8	388.3	369.5	203.8	150	30	23.8

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
13	Өвөрхангай	Аймгийн болон сумын төвд	25.7	25.7		25.7	0			
14	Дөнговь	Аймгийн болон сумын төвд	1842.73	1585.35	304.65	1280.5	257.38		236.88	20.5
15	Сүхбаатар	Аймгийн болон сумын төвд	910	910	910		0			
16	Сэлэнгэ	Аймгийн болон сумын төвд	71043.42	4756.64	2908.13	1848.51	66286.78	63507	2637.7	142.08
17	Төв	Аймгийн болон сумын төвд	248732.9	2886.88	820.22	2066.66	245846.02	242973	2651	222.02
18	Увс	Аймгийн болон сумын төвд	3798.29	1092.69	966.29	126.4	2705.6	2642.1	58.9	4.6
19	Ховд	Аймгийн болон сумын төвд	1114.2	188.2	188.2		926		922	4
20	Хөвсгөл	Аймгийн болон сумын төвд	9777.1	41	29	12	9736.1	9452	187.5	96.6
21	Хэнтий	Аймгийн болон сумын төвд	21914.16	2543.16	984.68	1558.48	19371	18400	858	113
22	Нийслэл	Нийслэлд	5153.7	5153.7	28.7	5125	0			
Улсын хэмжээнд			462924.15	39236.11	15134.07	24102.04	423688.04	409663.5	12410.38	1614.16

Монгол Улсын Их Хурлын Тамын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (348)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Иргэний хамгаалалтын тусламжийн тухай конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны дөрөвдүгээр сарын 21 №15 (348)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

177. Иргэний хамгаалалтын тусламжийн тухай конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай 301

178. Хэлэлцээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай 302

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

179. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Дугаар 45 302

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

180. Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай Дугаар 55 302

181. Хэлэлцээр батлах тухай Дугаар 56 303

182. Үйл ажиллагааны чиглэл батлах тухай Дугаар 57 303

183. Хэлэлцээр батлах тухай Дугаар 58 313

184. Засгийн газрын үйл ажиллагааны мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай Дугаар 59 313

185. Хэлэлцээр батлах тухай Дугаар 60 314

186. Малын гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай Дугаар 65 314

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр — Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ТУСЛАМЖИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Швейцарь Улсын Женев хотноо 2000 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсугай.

Иргэний хамгаалалтын тусламжийн тухай Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 15–ны өдөр — Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлуулгай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 8–ны өдөр — Дугаар 45 — Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 41 дүгээр зарлигаар батлагдсан "Цэргийн цол олгох журам" -д дараахь нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1. Журмын 4 дэх хэсэгт "2[1] Дээд офицерыг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, цэргийн жинхэнэ албанд эргүүлэн авах, дээд офицерын цолны зэрэглэлгүй албан тушаалд томилон цэргийн цол бууруулах, дээд офицерын цэргийн цолыг хасах буюу сэргээн олгох бол энэ тухай саналаа дээд офицерын цол олгох саналыг өргөн мэдүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.", "2[11] . Энэхүү журмын "Дөрөв" дэх хэсгийн 2[1] -т заасны дагуу саналаа өргөн мэдүүлэлгүйгээр дээд офицерыг иргэний байгууллага эсхүл дээд офицерын цолны зэрэглэлгүй албан тушаалд томилсон байвал түүнийг уг албан тушаалд томилогдсон өдрөөс цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх эсхүл цэргийн цолыг нь бууруулах шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч гаргана." гэсэн заалт тус тус нэмэх,

2. Журмын хоёр дахь хэсгийн 2 дахь заалтыг "2. Зэвсэгт хүчний ахлагчийн "дэд ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч", дунд офицерын болон "хурандаа" -гаас бусад ахлах офицерын цолыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Хил Хамгаалах Ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн дарга нар тус тус олгоно." , мөн хэсгийн 4 дэх заалтыг "4. Ахлагчийн "ахлагч, ахлах ахлагч", түрүүч,байдагчийн цолыг цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нар олгоно." ; дөрөв дэх хэсгийн 2 дахь заалтыг "2. Монгол Улсын Ерөнхийлөгч дээд офицерын цол бүхий албан тушаалтныг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, цэргийн жинхэнэ албанд эргүүлэн авах, тэдний цолыг бууруулах, хасах буюу сэргээн олгох шийдвэр гаргана." гэж тус тус өөрчлөн найруулах,

3. Журмын хоёр дахь хэсгийн 5 дахь заалтын "Зэвсэгт хүчин, бусад цэргийн" гэснийг хасах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3–ны өдөр — Дугаар 55 — Улаанбаатар хот

Авто тээвэрийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай

Авто тээвэрийн тухай хуулийн 5.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Авто тээвэрийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишгийг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Шинэ авто тээвэрийн хэрэгслийг эхний 2 жилд техникийн хяналтын үзлэгт оруулахгүйгээр зөвхөн тооллогод хамруулж байсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2004 оны 55 дугаар тогтоолын хавсралт

АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ОРУУЛАХ ХУГАЦАА, ОНОШЛОГООНЫ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ

Тээврийн хэрэгслийн төрөл	Тухайн жилд үзлэгт орох хугацаа /давтамж/	Нэг удаагийн төлбөрийн жишиг /төгрөгөөр/
Суудлын автомашин	1 удаа	10000
Ачааны автомашин	1 удаа	15000
Автобус	1 удаа	15000
Нийтийн тээврийн автобус	2 удаа	15000
Нийтийн тээврийн такси	2 удаа	10000
Трактор, өөрөө явагч механизм	1 удаа	15000
Чиргүүл	1 удаа	5000
Мотоцикль	1 удаа	5000

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3–ны өдөр Дугаар 56 Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Хэлэлцээр"-ийг батлалсугай.

2003 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Сөүл хотноо гарын үсэг зурсан "Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3–ны өдөр Дугаар 57 Улаанбаатар хот

Үйл ажиллагааны чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлийг хавсралт ёсоор батлалсугай.

2. "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн урт, богино хугацааны төлөвлөгөө, төслүүдийг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт даалгасугай.

3. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ тогтоолоор батална уйл ажиллагааны чиглэлийн хүрээнд нутаг дэвсгэртээ хур тунадас, үерийн ус хуримтлуулах далан, цөөрөм, хиймэл нуур байгуулах ажлыг нутгийн иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлийн талаар үндэсний радио, телевиз болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр өрөн сурталчлах, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өрөн оролцуулах ажил зохион байгуулахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд нарт үүрэг болгосугай.

5. Ус ихээр хэрэглэдэг бүтээгдэхүүн боловсруулдаг уул уурхайн болон хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын экономенежертэй болох санал, санаачлагыг дэмжих, тэдгээрийг мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээ авч, зардлыг нь Байгаль орчны сайдын төсвийн багцаас санхүүжүүлж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2004 оны 57 дугаар тогтоолын хавсралт

"УСНЫ ШИНЭТГЭЛ-XXI" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

Усны нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, усны нөөцийн хайгуул, судалгааны ажлын өнөөгийн түвшинд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газраас ойрын 20 жилд усны талаар явуулах үйл ажиллагаа, усны нөөцийг зохистой ашиглах усны сав газрын менежментийн чиглэлийг тодорхойлохоор орших байна.

Үйл ажиллагааны чиглэлийн эрхэм зорилго нь усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл ахуйн чанарын шаардлагад нийцсэн усаар хангах, эрчимжсэн хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийг сайжруулж, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр усыг зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Энэхүү үйл ажиллагааны чиглэл нь дараахь зорилтуудаар хэрэгжинэ:

1. улсын хил дамжин урсдаг болон дотоодын урсгалтай гол, мөрний усыг хуримтлуулах цогцолборуудыг барьж байгуулах замаар гадаргын усны нөөц, усан хангамжийг нэмэгдүүлж эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах асуудлыг шийдвэрлэх;

2. услалтын системүүдийг барих, өргөтгөх болон сэргээн засварлах замаар усалгаатай газар тариаланг хөгжүүлэх;

3. ундны усны хангамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төв, суурин газрын стандартын шаардлага хангахгүй байгаа усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах;

4. Монгол орны газрын доорхи усны эрэл хайгуул, гадаргын болон газрын доорхи усны судалгаа шинжилгээний ажлыг шинэ шатанд гаргах замаар усны нөөцөд тулгуурласан ашиглалтын зүй зохистой менежмент бүхий усны бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх;

5. орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан хур тунадас, үерийн урсацыг хуримтлуулах замаар усан хангамж, газар тариалангийн үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хоёр.Хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэхүү үйл ажиллагааны чиглэлийг 2004-2015 он, 2015-2025 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд тухайн үе шатанд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлнэ.

1 дүгээр зорилтын хүрээнд дараахь цогцолборуудыг барьж байгуулна:

№	Усан сан байрлах газар, голын нэр	Олон жилийн дундаж урсац ($м^3$/сек)	Илүүдэл урсацаас хуримтлуулах усны хэмжээ ($м^3$/сек)	Хоногт хуримтлуулан ашиглаж болох урсацын нөөц (мян.$м^3$/хоног)	Усны эзэлхүүн /шоо км (жилээр)/
	Нэгдүгээр үе шат 2004-2015 он				
1	Идэр-Тосонцэнгэл	36,40	3,64	314,50	0,114791
2	Завхан-Тайшир	9,13	0,91	78,88	0,028792
3	Туул-Тэрэлж	23,70	3,32	286,68	0,104636
4	Сэлэнгэ-Алтанбулаг	198,00	29,70	2566,08	0,936619
5	Хэрлэн-Говь	28,70	4,31	371,95	0,135762
6	Орхон-Хархорин	7,65	1,15	99,14	0,036188
7	Онон-Дадал	38,20	5,73	495,07	0,180701
8	Ховд-Эрдэнэбурэн	52,10	3,65	315,10	0,115012
9	Булган-Говь	4,26	0,21	18,40	0,006717
10	Туул-Говь	28,00	1,40	120,96	0,044150
11	Халхгол-Мэнэн	5,72	0,29	24,71	0,009019
	Нийт				1,712389
	Хоёрдугаар үе шат 2015 - 2025 он				
1	Эг-Хантай	78,30	11,75	1014,77	0,370390
2	Орхон-Орхон	32,20	3,22	278,21	0,101546
3	Хархираа-Тариалан	3,00	0,45	38,88	0,014191
4	Түргэн-Түргэн	1,78	0,27	23,07	0,008420
5	Ховд-Өлгий	66,60	4,66	402,80	0,147021
6	Эг-Алаг-Эрдэнэ	43,00	3,01	260,06	0,094923
7	Шишхэд-Рэнчинлхүмбэ	7,20	1,08	93,31	0,034059
8	Ерөө-Ерөө	55,40	5,54	478,66	0,174709
9	Онон-Биндэр	17,20	2,58	222,91	0,081363
10	Хараа-Мандал	10,50	1,58	136,08	0,049669
11	Хараа-Түнхэл	10,40	1,56	134,78	0,049196
12	Урд Тамир-Цэцэрлэг	7,50	1,13	97,20	0,035478
13	Богд-Улиастай	4,80	0,72	62,21	0,022706
	Нийт			7934,41	1,183672

2 дугаар зориулалтын хүрээнд дэвшүүлэх үйлчилгээний системүүдийг бүрэн хэмжээгээр хангах, ергөтгөх болон сэргээн засварлах арга хэмжээ авна:

№	Аймаг	Сум	Үйлчилгээний системийн нэр	Хүчин чадал, га-гаар	Хайгуул, судалгаа хийж зураг төсөл боловсруулах		Барьж байгуулан ашиглалтад оруулах	
					Хугацаа	Зардал, сая.төг	Хугацаа	Зардал, сая.төг
А.Сэргээн засварлаж шинэчлэх үйлчилгээний системүүд								
1	Төв	Жаргалант	Дэлгэр-Уянга	60	–		2004	173,5
2	Сэлэнгэ	Сант	Цагаантолгой	1000	–		2004	322,0
3	Дархан-Уул	Орхон	Шарын гол	436	–		2004	
4	Өвөрхангай	Арвайхээр	Дайргын гол	70	–	–	2004	9,1
5	Сэлэнгэ	Алтанбулаг	Төхөм	50	–		2004	
6	Хэнтий	Дэлгэрхаан	Хэрлэнбаян-Улаан	1000	–	–	2004	156,0
7	Булган	Орхон	Шувуутын гол	80	–	–	2004	89,5
8	Говь-Алтай	Халиун	Ёлтон	200				
9	Улаанбаатар	Жаргалант	Акушийн ам	175	2003	–	2006	
10	Увс	Тариалан	Хархираа	1534	–	–	2004-2006	303,0
11	Төв	Борнуур	Борнуур	500	2003		2004	
12	Төв	Батсүмбэр	Батсүмбэр	436	2004		2006-2007	322,0
13	Өвөрхангай	Хархорин	Хархорин	3300	2004		2005-2006	
14	Төв	Батсүмбэр	Баянгол	34	2004		2005	
15	Төв	Батсүмбэр	Сөгнөгөр	60	2004		2005	50,0
16	Төв	Борнуур	Арангат	280	2003		2005	
17	Увс	Давст	Хилэнцэг	150	2004	15,0	2005	300,0
18	Дархан-Уул	Орхон	Бүрэнтолгой	250	–	–	2006	
19	Төв	Жаргалант	Жаргалант	500	2004		2004-2006	
20	Говь-Алтай	Цогт	Хана	400			2004	
21	Төв	Алтанбулаг	Бөхөгийн гол	40	2004		2005	
22	Төв	Баянцогт	Дунд-Урт	57	2004		2006	303,0
23	Увс	Баруунтуруун	Баруунтуруун	1909	2004	–	2006-2008	

24	Дархан-Уул	Хонгор	Хонгорын гол	201	2004		2006	156,0
25	Булган	Орхон	Шувуутын гол	80	-	-	2004	89,5
26	Говь-Алтай	Цогт	Цагүй	450				
27	Тов	Баянчандмань	Барйн ам	50	2004		2006	
28	Тов	Баяндэлгэр	Тогосын хоолой	50	2005		2007	
29	Сэлэнгэ	Хушаат	Хушаат	20	2005		2006	9,1
30	Сэлэнгэ	Баянгол	Загдын гол	80	2004		2005	
31	Сэлэнгэ	Мандал	Зүүнхараа-I	400	-		2004	50,0
			Б.Динээр барих усалгаан системүүд					
1	Сэлэнгэ	Баянгол	Эрхэт	100	-	-	2004	155,0
2	Сэлэнгэ	Баянгол	Загдал	20			2004	40,0
3	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Мангирт	300			2004	750,0
4	Тов	Жаргалант	Мөндийн үзүүр	20	-	-	2004	63,8
5	Сэлэнгэ	Хүдэр	Темертэй	500	2004	62,5	2005	1250,0
6	Увс	Баруунтуруун	Баруунтуруун	2000	2004	250,0	2005-2006	5000,0
7	Хэнтий	Баянмонх	Баянмонхийн тал	2000	2004	250,0	2005-2006	5000,0
8	Сэлэнгэ	Мандал	Төхмйн бүлаг	60	2004	7,5	2005	150,0
9	Булган	Сэлэнгэ	Ингэтийн хөндий	4000	2005	500,0	2007-2008	10000,0
10	Сэлэнгэ	Цагаannуур	Тийрэгийн хөндий	8000	2005	250,0	2007-2008	5000,0
11	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Бонгийн төхөй	3000	2005	375,0	2007-2008	7500,0
12	Дорнод	Баянтүмэн	Дээд Чойбалсан	2000	2006	250,0		
13	Булган	Хутаг	Хонгор-Өвөо	1500				
14	Сэлэнгэ	Ерөө	Эхэтал	1500				
15	Булган	Хутаг	Намнангийн өвөр	2500				
16	Хэнтий	Өндөрхаан	Ногоо бригад	1800				
17	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Орхон-Сэлэнгийн өлгийр	3000				
18	Хэнтий	Баян-Адарга	Мөсөриййн бүлан	1500				
19	Увс	Хяргас	Бөөргийн эх	1000				

3 дугаар зорилтын хүрээнд дараахь төв, хэмжээ авна:
суурин газрын усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлэх арга

№	Аймгийн нэр	Д/д	Сумын нэр	Нэгжийн дундаж зардал (1мян/га-гээс ихгүй)	Хатуулагг бууруулах шаардлагатай сумд (5.0 мг-экв/л-ээс их)	Эрдэсжилтийг бууруулах шаардлагатай сумд (1000 мг/л-ээс их)	Фторыг бууруулах шаардлагатай сумд (1,5мг/л-ээс их)
1	Архангай	1	Хашаат	33,6	4,92	557,4	
		2	Хотонт	37,0	5,0	545,1	
2	Булган	3	Дашинчилэн	34,9	5,4	707,8	
		4	Гурванбулаг	34,7	5,6	698,6	
3	Завхан	5	Цагаанчулуут	33,6	6,2	556,9	
		6	Тэлмэн	32,1	6,8	623,9	
		7	Тосонцэнгэл	34,2	3,6	423,9	
		8	Эрдэнэхайрхан	37,5	5,5	804,5	
		9	Завханмандал	42,2	6,8	926,0	
		10	Ургамал	51,2	7,0	881,0	
4	Сэлэнгэ	11	Орхонтуул	34,9	5,0	779,1	
		12	Сүхбаатар хот	38,8	5,5	553,3	
5	Өвөрхангай	13	Нарийнтээл	32,8	5,6	588,9	
		14	Баян-Өндөр	34,9	6,1	629,1	
		15	Богд	40	6,6	1157,6	
		16	Төгрөг	34,3	7,6	1097,0	
		17	Баруунбаян-Улаан	32,7	5,9	1383,4	
		18	Гучин-Ус	–	4,9	1334,4	
6	Хэнтий	19	Баян-Адарга	40,2	6,1	674,7	
		20	Галшар	40,5	5,9	641,5	
		21	Дархан	44,6	6,0	765,4	
7	Баянхонгор	22	Хүрээмарал	43,9	7,7	1009,3	
		23	Баянбулаг	36,2	6,97	757,2	
		24	Заг	101,2	12,84	1908,0	
		25	Галуут	34,7	6,3	481,6	
		26	Бөмбөгөр	46,9	7,81	968,7	
		27	Баян-Овоо	116,7	13,76	1231,7	
		28	Баянлиг	41,7	6,9	1165,1	

		31	Шинэжинст	72,8	8,97	1063,5	
		32	Баацагаан	48,2	6,98	1146,1	
		33	Гурванбулаг	-	5,0	1076,0	
		34	Байдраг	-	4,6	1664,7	
8	Увс	35	Наранбулаг	38,5	7,6	1890,6	
		36	Хяргас	33,5	4,7	674,9	
		37	Тариалан	75,3	4,8	774,6	
		38	Өндерхангай	-	7,0	1054,0	
9	Төв	39	Заамар	60,7	5,9	733,0	
		40	Өндөрширээт	36,3	4,8	514,0	
10	Баян-Өлгий	41	Дэлүүн	58,3	6,8	806,0	
		42	Толбо	39,7	5,5	609,9	
		43	Сагсай	45,0	5,2	432,4	
		44	Бугат	31,5	5,5	507,6	
		45	Ногооннуур	31,5	5,5	471,9	
		46	Улаанхус	70,0	9,8	872,0	
11	Говь-Алтай	47	Дарви	45,7	7,7	844,7	
		48	Төгрөг	62,8	8,24	828,6	
		49	Халиун	37,3	5,4	725,8	
		50	Чандмань	65,3	9,0	1368,7	
		51	Баян-Уул	43,8	6,2	900,0	
		52	Алтай хот	69,3	7,4	725,1	
		53	Дэлгэр	31,9	6,5	786,8	
		54	Жаргалан	42,5	6,4	790,4	
		55	Шарга	48,3	6,3	739,0	
		56	Хөхморьт	38,6	5,9	909,9	
		57	Эрдэнэ	118	16,9	2373,7	
		58	Цогт	38,5	7,3	747,2	
		59	Бигэр	-	8,7	790,8	
		60	Тонхил	-	7,3	528,3	
12	Дорнод	61	Дашбалбар	33,7	4,9	596,1	
		62	Эрээнцав	59,3	9,3	1270,9	
		63	Баян-Уул				2,66
		64	Чойбалсан				3,42

		65	Булган	35,6	5,3	777,9	
		66	Халхгол	57,1	7,6	1107,7	
		67	Сүмбэр	54,0	4,8	1418,8	
		68	Баянтүмэн	–	4,4	1076,7	2,33
		69	Хэрлэн	34,1	5,5	1521,6	
		70	Сэргэлэн	–	4,7	741,2	2,43
		71	Цагаан-Овоо	36,9	6,1	1179,9	3,04
13	Сүхбаатар	72	Баяндэлгэр	41,5	7,0	1392,7	3,54
		73	Түвшинширээ	35,9	5,6	1235,5	
		74	Бүрэнцогт	84,5	9,3	1444,9	
		75	Сүхбаатар	47,5	6,1	1290,1	3,72
		76	Халзан	43,0	6,6	1505,7	2,35
		77	Асгат	49,3	7,3	1198,9	2,35
		78	Эрдэнэцагаан	35,3	5,1	1044,4	5,45
		79	Дарьганга	76,9	7,2	1057,2	
		80	Наран	45,7	5,8	1750,9	2,05
		81	Онгон	34,3	5,2	1763,2	
		82	Баруун-Урт хот	45,6	5,2	1035,4	2,45
		83	Уулбаян	–	4,8	1191,1	1,9
		84	Түмэнцогт				
14	Дундговь	85	Дэлгэрцогт	48,2	7,6	1112,6	
		86	Дэрэн	43,7	5,8	1255,4	
		87	Цагаандэлгэр	116,4	14,5	1994,6	
		88	Эрдэнэдалай	31,5	4,7	1166,4	
		89	Луус	44,2	6,0	2922,3	
		90	Баянжаргалан	34,7	5,5	1191,7	
		91	Өлзийт	44,0	5,84	1441,5	
		92	Гурвансайхан	85,2	11,3	1459,5	
		93	Дэлгэрхангай	–	4,7	1177,0	
15	Дорноговь	94	Сүмбэр	63,2	9,6	1414,7	
		95	Даланжаргалан	95,0	11,47	2638,2	3,61
		96	Хажуу-Улаан	56,9	7,8	1148,1	
		97	Дэлгэрэх	38,7	6,2	1513,8	
		98	Хар-Айраг	45,1	6,2	1432,5	1,81
		99	Айраг	32,2	5,3	2189,6	

		100	Хатанбулаг	54,3	8,5	2035,0	1,94
		101	Сулинхээр	56,1	8,6	1760,9	
		102	Эрдэнэ	40,8	7,4	2236,3	
		103	Улаанбадрах	44,9	7,88	1573,5	2,25
		104	Алтанширээ	39,7	4,6	1344,6	
		105	Хөвсгөл	-	5,0	1122,8	
		106	Өргөн	-	4,8	1290,5	2,07
		107	Иххэт				2,5
		108	Зүүнбаян				1,52
		109	Сайншанд				2,15
		110	Сайхандулаан	-	5,6	1378,3	
16	Ховд	111	Дөргөн	63,4	14,8	1894,5	
		112	Дарви	35,2	6,77	703,6	
		113	Дуут	-			
17	Өмнөговь	114	Булган	34,6	5,1	541,5	1,65
		115	Сэврэй	30,4	5,2	3596,1	
		116	Доготцэций	-	3,9	1243,9	
		117	Догт-Овоо		4,4	1116,4	
		118	Хүрмэн	-	5,2	1216,9	
		119	Ноён	30,1	6,3	1269,0	

4 дүгээр зориптын хүрээнд газрын доорхи усны эрэл хайгуул, гадаргын ба газрын доорхи усны судалгааны ажлын чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

Д/д	Ажлын нэр	Үнэлэх нөөц, м.куб/хоног, хамруулах талбай	Санхүүжилт
1	Эдийн засгийн хөгжлийн бүс нуттуудад 1:100000, 1:200000-ын масштабын экологи, гидрогеологийн төрөлжсөн зураглал хийх	Монгол орны нутаг дэвсгэрийн 40 хүртэлх хувийг хамруулах	Улсын төсөв
2	Монгол орны 1:500000-ын масштабын гидрогеологийн зургийг хэвлүүлэх		Улсын төсөв
3	Усны нэгдсэн мэдээллийн санг монгол орны гадаргын, газрын доорхи усны болон ус ашиглалт, хамгаалалтын, усны барилга байгууламжийн, усны эрчим хүчний гэх зэргээр төрөлжүүлэн газар зүйн мэдээллийн систем /GIS/-д тулгуурлан хийж байнга баяжүүлж байх		Хандивлагч орнуудын дэмжлэгээр
4	Усны сав газрын нэгдсэн менежментийн загвар төслийг боловсруулан хэрэгжүүлэх		Хандивлагч орнуудын дэмжлэгээр
5	Ус хангамжийн эх үүсвэрийг илрүүлж үнэлэх газар доорхи усны эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэх:		Улсын төсөв

а/Хот суурин:			
	Улаанбаатар	100000	Улсын төсөв
	Эрдэнэт	10000	Улсын төсөв
	Алтанбулаг	6000	Улсын төсөв
	Замын-Үүд	10000	Улсын төсөв
	Хархорин	80000	Улсын төсөв
	Мандалговь	4000	Улсын төсөв
	Дорноговь	52000	Улсын төсөв
	Ховд	8000-12000	Улсын төсөв
	Улиастай	8000-12000	Улсын төсөв
	Зуунмод	8000-12000	Улсын төсөв
	Дархан	8000-12000	Улсын төсөв
	Өндөрхаан	8000-12000	Улсын төсөв
	Чойбалсан	8000-12000	Улсын төсөв
	Аймгийн төвүүдийн усны эх үүсвэрийн нөөц үнэлгээг 2010 оноос цааших хугацаанд үргэлжлүүлэн хийх	4000-8000	Улсын болон орон нутгийн төсөв
	Сумын төв, жижиг суурингийн ус хангамжийн судалгаа хийх	200-1200 /30 төв, суурин газар/	Орон нутгийн төсөв
б/Уулын үйлдвэр:			
	Оюутолгой	Захиалга тодорхойгүй	Хувийн хөрөнгө оруулалт
	Төмөртэй-Овоо		Хувийн хөрөнгө оруулалт
	Бүрэнхаан		Хувийн хөрөнгө оруулалт
	Цагаансуварга		Хувийн хөрөнгө оруулалт
	Тавт		Хувийн хөрөнгө оруулалт
	Цав		Хувийн хөрөнгө оруулалт
	Усалгаатай тариалан зэрэг ус хэрэглэгчдийн захиалгаар гүйцэтгэх ажил		Хувийн хөрөнгө оруулалт
6.	Рашаан, термаль усны судалгаа хийх		Улсын төсөв
7.	Мөстөл судлалын өртөөг Монгол Алтай, Цамбагаравт шинээр байгуулах		Улсын төсөв
8.	Гадаргын болон газрын доорхи усны горимын мониторингийн сүлжээг өргөтгөн зохион байгуулах		Улсын төсөв

5 дугаар зорилтын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн иргэд, малчид, тариаланчидтай тухайн газар орны онцлог, хур тунадас, үерийн усыг хуримтлуулж нөөцийг нэмэгдүүлэх асуудлаар санал солилцож, судалгаа хийх замаар газар тариалан, эрчимжсэн мал ахуй эрхлэдэг иргэд, аж ахуйн нэгжийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц гадаргын усны нөөц бүхий далан барих, хиймэл нуур, хөв, цөөрөм байгуулах арга хэмжээг орон нутгийн хөрөнгө, хүч, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Гурав.Үйл ажиллагааны чиглэлийн үр дүн

1. Гадаргын болон газрын доорхи үс ашиглалтыг тэнцвэржүүлнэ.

2. Гадаргын усны нөөцийг 1,7-2 дахин нэмэгдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3–ны өдөр **Дугаар 58** **Улаанбаатар хот**

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2003 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Стокгольм хотноо гарын үсэг зурсан Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Шведийн Вант Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН
САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3–ны өдөр **Дугаар 59** **Улаанбаатар хот**

Засгийн газрын үйл ажиллагааны мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын бодлого, шийдвэрийг мэдээлэх, сурталчлах ажлыг Монголын сонины холбоо, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу гүйцэтгүүлэх ажилд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 11-ний өдөр | **Дугаар 60** | **Улаанбаатар хот**

Хэлэлцээрийг батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Чили Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг батална.

Сантъяго хотноо 2003 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан Монгол Улсын дипломат болон албан паспорт эзэмшигчид, Бүгд Найрамдах Чили Улсын дипломат, албан болон тусгай паспорт эзэмшигчдийг визээс чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чили Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг батална.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 17-ны өдөр | **Дугаар 65** | **Улаанбаатар хот**

Малын гоц халдварт шүлхий өвчний талаар авах зарим арга хэмжээний тухай

Дундговь аймгийн Баянжаргалан, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран сумын нутагт малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран, Онгон сумын нутаг дэвсгэрт 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хорио цээрийн онцгой дэглэм тогтоон нутгийн захиргааны байгуллага, аж ахуйн нэгж, иргэдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Дундговь аймгийн Цагаандэлгэр, Гурвансайхан, Говь-Угтаал, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян, Халзан, Дарьганга, Асгат сумын нутаг дэвсгэрт 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоож нутгийн захиргааны байгуллага, аж ахуйн нэгж, иргэдийг гамшгаас хамгаалах өндержүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

3. "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 37 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллахыг Дундговь аймгийн Засаг даргаа Ж.Адьяа, Сүхбаатар аймгийн Засаг даргаа Т.Дашсүрэн нарт даалгасугай.

4. "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 37 дугаар тогтоолын 2 дугаар зүйлээс ".. Дундговь аймгийн Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр..." гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.
Улаанбаатар-12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 16 (349)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын Яамны Эрх зүйн байдлын тухай*
- *Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай*
- *Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны дөрөвдүгээр сарын 28 №16 (349)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

187. Монгол Улсын ямны эрх зүйн байдлын тухай 301
188. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай 302
189. Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 326
190. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 327
191. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 329
192. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай 329
193. Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай 330
194. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 330
195. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 330

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

196. Хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүд буцаах тухай Дугаар 13 330

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

197. Сулеймен Демирелийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 50 331
198. Мустафа Буминыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 51 331
199. Халил Акынжыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 52 331
200. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 54 331

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

201. Дүрэм батлах тухай Дугаар 66 332

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын яам /цаашид "яам" гэх /-ны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. дугаар зүйл. Ямны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1. Ямны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,[1] Засгийн газрын тухай [2], Төрийн албаны тухай [3], Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль[4], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Яам, түүний чиг үүрэг

3.1.Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.

3.2.Засгийн газрын бүтцэд ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яам ажиллана.

3.3.Яам нь Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.4.Ерөнхий чиг үүргийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны нийт салбарын нийтлэг, чиглэлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны тодорхой салбарын асуудлаар энэ хуулийн 3.3.-т заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

3.5.Яамыг гадаад, дотоодод Монгол Улсын сайд, хуульд өөрөөр заагаагүй бол түүний даалгасsnаар болон өөрийн эрх хэмжээний асуудлаар Төрийн нарийн бичгийн дарга төлөөлнө.

4 дүгээр зүйл. Яамны үйл ажиллагааны зарчим

4.1.Яамны үйл ажиллагааны үндсэн зарчим нь ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.

4.2.Яам нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, шуурхай, соёлч байдлыг хангах, мэргэшсэн байх, ил тод нээлттэй байх, үйл ажиллагаанаха төлөө хариуцлага хүлээх, яамд нь бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцон харилцан хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.

5 дугаар зүйл. Яамыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах

5.1.Засгийн газрын үйл ажиллагааны ерөнхий чиг үүрэг болон салбарын чиг үүргийг зохистой хуваарилах үндсэн дээр яамыг Үндсэн хуулийн Гүчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана.

6 дугаар зүйл. Яамны тамга, тэмдэг, бэлгэдэл

6.1.Яам тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

6.3.Яам эрхэлсэн ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болно.

6.4.Яамны бэлгэдлийн загвар, тодорхойлолт, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Яамны эрхлэх асуудал

7 дугаар зүйл. Яамны нийтлэг эрхлэх асуудал

7.1.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг ажил эрхэлнэ:

7.1.1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

7.1.2. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийн төсөл боловсруулах;

7.1.3.салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захиргачийн төсвийн теслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

7.1.4.төсвийн ерөнхийлөн захирагчаас яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх;

---

[1]Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

[2]Монгол Улсын Засгийн газрын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн

[3]Төрийн албаны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

[4]Төсвийн байгуулллагын удирдлага,санхүүжилтийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

7.1.5.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг суурьлчлах, хуулийг хэрэглэж байгаа практикийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

7.1.6.аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.1.7.Засгийн газрын агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын хоорондын болон эдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны холбогдох байгууллагын харилцан ажиллагаат уялдуулан зохицуулах;

7.1.8.төрийн албан хаагчдын хэрэгцээг тодорхойлох, тэднийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат нь хангахтай холбогдсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

7.1.9.хүний эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах;

7.1.10.Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, тэдгээрт хууль тогтоомжийг нийцүүлж, биелэлтийг хангуулах;

7.1.11.салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ материалыг бусад яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулж авах;

7.1.12.тухайн салбарын ажиллагсдыг урамшуулах, төрийн дээд шагналаар шагнуулах, цол олгуулах саналыг хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу холбогдох байгуулагад өргөн мэдүүлэх;

7.1.13.хууль тогтоомжид заасан бусад нийтлэг эрхлэх асуудал.

7.2.Яамны эрхлэх тодорхой асуудлыг хуулиар тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Яамны удирдлага, зохион байгуулалтын бүтэц

8 дугаар зүйл. Монгол Улсын сайд

8.1.Яамыг Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд /цаашид "сайд" гэх/ тэргүүлнэ.

8.2.Сайд Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн ажлын хэсэг, тэргүүлж буй яамныхаа аппаратад түшиглэж эрхлэх асуудлын хүрээнийхээ чиглэлээр зөвлөгөө, туслалцаа авч яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын үйл ажиллагаат нэгдсэн удирдлагаар ханагана.

8.3.Сайдын өөрийн ажлын хэсэг /зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан/ нь сайдад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлж, шуурхай ажлыг нь гүйцэтгэнэ.

8.4.Энэ хуулийн 8.3-т заасан ажилтан ажлаа сайдын өмнө хариуцаж, төрийн албан хаагчийн хувьд яамны аппаратад харъяалагдана.

9 дүгээр зүйл. Төрийн нарийн бичгийн дарга

9.1.Төрийн нарийн бичгийн даргыг Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу сайдын саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

9.2.Төрийн нарийн бичгийн даргыг Төрийн албаны тухай хуульд зааснаас өөр үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөх, чөлөөлөх, халах, захиргааны санаачлагаар албан тушаалаас нь буруулахыг хоригломо.

9.3.Төрийн нарийн бичгийн дарга яамны аппаратын ажлыг мэргэшлийн үндсэн дээр зохион байгуулж, удирдана.

9.4.Төрийн нарийн бичгийн дарга үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцсэн сайдын тушаал, үүрэг даалгаврыг удирдлага болгоно.

9.5.Төрийн нарийн бичгийн дарга нь яамны аппаратын ажлын үр дүнг сайдын өмнө хариуцна.

9.6.Төрийн нарийн бичгийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.6.1.яамны аппаратын ажлыг өдөр тутмын удирдлагаар хангах, яамны хэмжээнд мөрдөх дүрэм, заавар, журмыг хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, сайдын тушаалд нийцүүлэн батлаж, мөрдүүлэх;

9.6.2.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаал, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайд, сайдаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих;

9.6.3.яамны төсвийн ерөнхий менежерийн хувьд сайдтай үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлэх;

9.6.4.сайдаас эрхлэх асуудлынхаа хүрээний агентлаг, бусад этгээдтэй үр дүнгийн гэрээ байгуулахад нь болон салбарын бодлого зохицуулалт, хэрэгжилтийг хянах асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

9.6.5.сайдын даалгаснаар эрхлэх асуудлынх нь хүрээний агентлаг, бусад байгууллагын удирдлагатай харилцах;

9.6.6.бүрэн эрхийнхээ асуудлаар холбогдох байгууллагатай шууд харилцах;

9.6.7.яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд заасан хүрээнд хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх;

9.6.8.батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаартаа багтаан яамны төсвийн хөрөнгийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах;

9.6.9.хууль тогтоомжид заасны дагуу ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь буруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, төрийн албанаас түр чөлөөлөх, чөлөөлөх, халах;

9.6.10.ажилтныг ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах;

9.6.11.ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах;

9.6.12.зохих журмын дагуу яамны нэр дээр банкинд харилцах данс нээх;

9.6.13.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр олгосон болон сайдаас шилжүүлсэн бусад бүрэн эрх.

9.7.Сайдын түр эзгүйд түүний даалгаснаар байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн бичгэт хариу өгч, гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаварыг өөрөө хариуцна.

9.8.Төрийн нарийн бичгийн дарга энэ хуулийн 9.6-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх асуудлаар хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн яамны хэмжээнд мөрдөх тушаал гаргаж, биелэлтийг хангуулна.

9.9.Төрийн нарийн бичгийн даргын гаргасан тушаал нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, сайдын тушаалыг зөрчсөн нь тогтоогдсон бол түүнийг уг албан тушаалтан өөрөө, хэрэв уг албан тушаалтан хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлээгүй бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол сайд тус тус хүчингүй болгоно. Тухайн тушаалтай холбоотой маргаан гарсан тохиолдолд иргэн, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлэлээ гаргаж болно.

9.10.Төрийн нарийн бичгийн даргад зөвлөх үүрэг бүхий яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нараас бүрдсэн зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн ажиллах журмыг Төрийн нарийн бичгийн дарга батална.

9.11.Төрийн нарийн бичгийн даргыг түр эзгүйд албан үүргийг нь түр орлон гүйцэтгүүлэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн сайд гаргана.

10 дугаар зүйл. Яамны зохион байгуулалтын бүтэц

10.1.Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар батална.

10.2.Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн нарийн бичгийн дарга батална.

11 дүгээр зүйл. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага

11.1.Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргыг Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

11.2.Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

11.2.1.нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцах;

11.2.2.сайд, Төрийн нарийн бичгийн даргыг мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах;

11.2.3.Төрийн нарийн бичгийн даргын эрх олгосноор нэгжийнхээ ажилтантай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэх;

11.2.4.энэ хуулийн 9.6.1-д заасан дүрэм, заавар, журмыг нэгжийнхээ хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

11.2.5.нэгжийнхээ ажилтны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг тогтоосон журмын дагуу үнэлж дүгнэн, саналын хамт Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

11.2.6.ямны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.

12 дугаар зүйл. Ямны ажлын зохион байгуулалт

12.1.Ям нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй ажиллана.

12.2.Ямны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь сайдаас ямны төсвийн ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээний салшгүй хэсэг байна.

12.3.Ямны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, батлах, биелэлтийг нь дүгнэх журмыг хуулиар тогтооно.

12.4.Ямны хэмжээнд Төрийн нарийн бичгийн даргын хууль тогтоомжид нийцүүлж батлсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө.

12.5.Ямны хөдөлмөрийн дотоод журамд дараахь асуудлыг тусгана:

12.5.1. албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, халах;

12.5.2.захиргаа, ажилтны эрх, үүрэг;

12.5.3.ямны ажлыг төлөвлөх, тайлагнах;

12.5.4.ямны зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны үйл ажиллагааны үр дүнг тооцож дүгнэх, арга хэлбэр;

12.5.5.ажлын цагийн горим;

12.5.6.ажил хүлээлцэх;

12.5.7.дотоодын хяналт шалгалт хийх;

12.5.8.шагнал урамшуулал олгох;

12.5.9.сахилгын шийтгэл ногдуулах;

12.5.10.дотоод журамд тусгахаар хууль тогтоомжид заасан бусад зүйл.

12.6.Төрийн нарийн бичгийн дарга болон энэ хуулийн 11.2-т заасан албан тушаалтан ямны эрхлэх асуудлаар албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ Засгийн газар, сайдын бодлогыг баримтална.

13 дугаар зүйл. Ажлын нөхцөл

13.1.Ям нь ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат хангах хөтөлбөрийг боловсруулан батлуулж, түүнд тусгасан арга хэмжээг үйл ажиллагааныхаа хэтийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Ямны төсөв

14.1.Ям нь төсөвтэй байна.

14.2.Ямны төсвийн төслийг боловсруулах, батлах, захиран зарцуулах, тайлагнах журмыг хуулиар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ямнаас Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, бусад байгууллагатай харилцах

15 дугаар зүйл. Сайдаас Улсын Их Хуралтай харилцахад дэмжлэг үзүүлэх

15.1.Ям нь сайдаас Улсын Их Хуралтай харилцахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

15.1.1.Улсын Их Хурал, түүний Байнгын хороог сайдын эрхлэх асуудлын хүрээнийталаархи шаардлагатай мэдээллээр хангах;

15.1.2.Засгийн гаргаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх бүх шатанд тайлбар, зөвлөгөө, лавлагаа өгөх;

15.1.3.Улсын Их Хурлын удирдлага, Байнгын хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс шаардсан мэдээллийг гаргаж өгөх;

15.1.4.сайдаас Улсын Их Хурлын чуулганд хийх мэдээллийн болон Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулт, асуулгын хариултын төслийг бэлтгэх.

15.2.Хуульд өөрөөр заагаагүй бол ямнаас Улсын Их Хурлын гишүүнтэй сайдаараа

дамжуулан, Улсын Их Хурлын Тамгын газартай шуудхарилцана.

15.3.Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай[5] хуулийн 7 дугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд ямартай харилцана.

16 дугаар зүйл. Сайдаас Ерөнхийлөгчтэй харилцахад дэмжлэг үзүүлэх

16.1.Яам нь сайдаас Ерөнхийлөгчтэй харилцахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

16.1.1.Ерөнхийлөгчийг сайдын эрхлэх асуудлын хүрээний талаархи шаардлагатай мэдээллээр хангах;

16.1.2.Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн холбогдох шийдвэрийн биелэлтийг хангах;

16.1.3.сайдын эрхлэх асуудлын хүрээний чиглэлээр Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

16.1.4.хууль тогтоомжид заасны дагуу Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх зарлиг, бусад бичиг баримтын төсөл боловсруулах.

16.2.Хуульд өөрөөр заагаагүй бол ямнаас Ерөнхийлөгчтэй харилцахдаа сайдаараа дамжуулан, түүний ажлын албатай шууд харилцана. Ерөнхийлөгч ямтай сайдаар, түүний ажлын алба нь энэ хуулийн 3.5-д заасан албан тушаалтнаар дамжуулан харилцана.

17 дугаар зүйл. Сайдаас Засгийн газартай харилцахад дэмжлэг үзүүлэх

17.1.Ямнаас Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнтэй харилцахдаа сайдаараа дамжуулан харилцана. Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүн ямтай шууд харилцана.

17.2.Яам нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийн талаар ажлын албаар нь дамжуулан Засгийн газарт тогтоосон журмын дагуу мэдээлнэ.

18 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагатай харилцах

18.1.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагатай аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчидийн даргаар дамжуулан харилцана. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь ямтай сайдаар дамжуулан харилцана.

18.2.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагаас тавсан санал, хүсэлтийг хянан шийдвэрлэнэ.

19 дүгээр зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харилцах

19.1.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагатай аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана. Нутгийн захиргааны байгууллага нь ямтай сайдаар дамжуулан харилцана.

19.2.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа байдалтай орон нутагт танилцаж, биелэлтийг хангуулна.

19.3.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргаас сайдад хандаж тавсан санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

20 дугаар зүйл. Яам хоорондын хамтын ажиллагаа

20.1.Ямд нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ шаардлагатай асуудлаар хамтарч ажиллана. Хамтран ажиллах асуудлын хүрээ нь хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын үүрэг даалгавраар болон холбогдох ямдын удирдлагын түвшинд харилцан тохиролцсоноор тодорхойлогдоно.

20.2.Удирдлагын түвшинд тохиролцсон асуудлаар ямд хоорондоо шууд харилцаж ажиллана.

20.3.Ямд нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

21 дүгээр зүйл. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагтай харилцах

21.1.Яам сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагад хууль тогтоомж,

[5] Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 4 дүгээрт нийтлэгдсэн

Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын бодлого, шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа болон үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, биелэлтийг нь хангуулах арга хэмжээ авч, тэдгээрт туслалцаа үзүүлнэ.

21.2.Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлагтай харилцахдаа Ерөнхий сайд даалгасан бол энэ хуулийн 21.1-д заасан үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хэрэгжүүлнэ.

21.3.Агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого боловсруулах удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ өгөхөд шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ тайлан зэрэг мэдээллийг тогтоосон журмын дагуу гаргаж өгнө.

22 дугаар зүйл. Бусад байгууллага, иргэдтэй харилцах

22.1.Яам нь Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, прокурорын болон Улсын Их Хурлаас байгууллагатай сайдын өгсөн чиглэл, удирдамж, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар харилцана.

22.2.Яам нь сайдынхаа эрхлэх асуудлын хүрээний бус агентлагтай шууд харилцана.

22.3.Яам нь гадаад улсын болон олон улсын байгууллагатай сайдын өгсөн чиглэл, удирдамж, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар харилцана.

22.4.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагатай хуульд заасан журмаар харилцана.

22.5.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний тодорхой чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагад нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

22.6.Яам нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон нийтлэг асуудлаар тэдгээрийн улсын чанартай холбоо, нийгэмлэг зэрэг нэгдлээр нь дамжуулан тодорхой асуудлаар шууд харилцана.

22.7.Яам нь иргэдээс сайдын эрхлэх хүрээний асуудлаар гаргасан санал, өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд[6] заасан журмын дагуу хүлээж авч хянан шийдвэрлэнэ. Яам нь сайдаас иргэдийг хүлээн авч уулзах ажлыг сард 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл. Яамны хэвлэл

23.1.Яам нь сайдын тушаал, яамны бодлого, үйл ажиллагааны талаар нийтэд албан ёсоор мэдээлж байх зорилгоор эмхтгэл гаргаж болно.

24 дүгээр зүйл. Яамны гадаад харилцаа

24.1.Яам нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн яам, бусад байгууллага, олон улсын байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллана.

24.2. Төрийн нарийн бичгийн даргын гадаад улсын ижил төрлийн яам, бусад байгууллага, олон улсын байгууллагад туршлага судлах, мэргэжлийн сургалт, хурал, зөвлөлгөөнд оролцох /цаашид "албан томилолт" гэх/ асуудлыг сайд шийдвэрлэнэ.

24.3.Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга болон ажилтны албан томилолтын асуудлыг Төрийн нарийн бичгийн дарга шийдвэрлэнэ.

24.4.Гадаад улсын болон олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочин, төлөөлөгч үрих асуудлыг сайд шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл. Яаманд хориглох зүйл

25.1.Яаманд дараахь үйл ажиллагаа явуулахыг хоригломо:

25.1.1.жагсаал, цуглаан хийх, ажил хаялт, өлсгөлөн, суулт зарлах зэрэг улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулах;

25.1.2.хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр орлого олох;

25.1.3.Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд ямны байранд бусад байгууллагыг байрлуулах;

[6] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл,гомдлыг шийдвэрлэх тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн

25.1.4.хууль тогтоомжоор зориглосон бусад үйл ажиллагаа.

26 дугаар зүйл. Яамны шагнал

26.1.Яам нь дараахь шагналтай байж болно:

26.1.1.яамны хүндэт дэвтэрт бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

26.1.2.яамны жуух бичиг.

26.2.Яамнаас олгох шагналын нийтлэг загвар, дагалдах мөнгөн шагналын хэмжээг Засгийн газар тогтооно.

26.3.Яамны шагнал олгох, шагналын сан бүрдүүлэх, зарцуулах журмыг сайд тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын агентлаг /цаашид "агентлаг" гэх/-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Агентлагийн тухай хууль тогтоомж

2.1. Агентлагийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Засгийн газрын тухай[2], Төрийн албаны тухай[3], Яамны эрх зүйн байдлын тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай[4], Хөдөлмөрийн тухай[5] хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Агентлаг, түүний чиг үүрэг

3.1. Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

3.2.Засгийн газар нь тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлагтай байж болно.

4 дүгээр зүйл. Агентлагийн үйл ажиллагааны зарчим

4.1. Агентлаг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлан ажиллана.

5 дугаар зүйл. Агентлаг байгуулах

5.1.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, ерөнхий сайд, сайд /цаашид "сайд"гэх/-ын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.

5.2.Сайд агентлаг байгуулах тухай саналдаа дараахь үндэслэлийг тусгана:

5.2.1.тухайн агентлаг нь төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл;

5.2.2.тухайн агентлагийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжих;

5.2.3.агентлагийн үйл ажиллагаа төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэг, үйлчилгээтэй давхардахгүй байх.

5.3. Агентлаг байгуулах тухай саналд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

[2] Засгийн газрын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлтйн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн

[3] Төрийн албаны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

[4] Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

[5] Хөдөлмөрийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

5.3.1.үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, бүтцийн хөтөлберийн төсөл;

5.3.2. жилийн төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийн тухай танилцуулга, холбогдох тооцоо, судалгаа.

5.4.Засгийн газар нь агентлаг байгуулах зайлшгүй шаардлагатай эсэх талаар дүгнэлт гаргуулахаар ажлын хэсэг байгуулж болно.

5.5. Засгийн газар тухайн агентлагийг байгуулах шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны байгуулагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

6 дугаар зүйл. Агентлагийг өөрчлөн байгуулах, татан буулгах

6.1. Агентлагийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулна.

6.2. Агентлагийг дараахь үндэслэлээр татан буулгана:

6.2.1. тухайн агентлагаас хэрэгжүүлж байсан чиг үүрэг, үйлчилгээ нь төрийн чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээнд хамаарахгүй болсон;

6.2.2. хуульд заасан бусад үндэслэл.

6.3. Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу Засгийн газар шийдвэрлэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Агентлагийн эрхлэх асуудал, удирдлага, зохион байгуулалтын бүтэц

7 дугаар зүйл. Агентлагийн нийтлэг эрхлэх асуудал

7.1.Агентлаг нь дараахь нийтлэг асуудал эрхэлнэ:

7.1.1. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхэлсэн хүрээ, салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангах;

7.1.2. холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг сурталчлах, тэдгээрийг хэрэглэж байгаа практикийг судалж, боловсронгий болгох санал боловсруулж сайдад танилцуулах;

7.1.3. төсвийн хүрээний мэдэгдлийн төсөөд өгөх саналыг үндэслэл, тооцоотой боловсруулах;

7.1.4.агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан нөхцөл, үндэслэлээр хугацаанд нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид оруулах;

7.1.5. хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагад зөвлөж буй ажлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

7.1.6. салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

7.1.7. хүний эрх, эрх чөлөөг хангах зэрэг засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгаат бүрдүүлэх арга хэмжээ авах;

7.1.8. Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг тэдгээрт нийцүүлэх санал боловсруулж сайдад танилцуулах;

7.1.9. хуулиар эрх олгосон бол нийтээ дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журам, норм, нормативыг хууль тогтоомжид нийцүүлэ боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

7.1.10. хууль тогтоомжид заасан бусад нийтлэг эрхлэх асуудал.

7.2. Агентлагийн эрхлэх тодорхой асуудлыг хууль тогтоомж, хуулиар эрх олгосон бол Засгийн газрын шийдвэрээр тогтооно.

8 дугаар зүйл. Агентлагийн удирдлага

8.1. Агентлагийг Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилогдсон дарга тэргүүлнэ.

8.2. Агентлагийн дарга агентлагийн үйл ажиллагаат удирдан зохион байгуулж, түүний үр дүнг сайдын өмнө хариуцан тайлагнана.

8.3. Агентлагийн дарга нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1. энэ хуулийн 7.1.1-д заасан хууль тогтоомж, зарлиг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих;

8.3.2. агентлагийг өдөр тутмын удирдлагаар хангах, хуулиар эрх олгосон бол нийтээр дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, жүрмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлэж, Засгийн газраас батлагдсан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;

8.3.3. агентлагийн төсвийн ерөнхий менежерийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах;

8.3.4. батлагдсан төсөв, сайдын батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн сан тогтоох;

8.3.5. хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас буруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, тур чөлөөлөх, халах;

8.3.6. эрхэлсэн асуудлаараа сайдад мэргэшлийн зөвлөгөө өгч, холбогдох мэдээллээр хангах;

8.3.7.агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах;

8.3.8.тогтоосон журмын дагуу агентлагийн нэр дээр банкинд харилцах данс нээх;

8.3.9. агентлагийг төлөөлж бусад байгууллагатай харилцах;

8.3.10.салбарын мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх, төрийн болон боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ, материалыг хуульд харшлаагүй бол холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авах;

8.3.11. хуульд заасны дагуу олгосон болон сайдаас шилжүүлсэн бусад бүрэн эрх.

8.4. Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана.

8.5. Агентлагийн дарга нь Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдана.

8.6. Агентлагийг гадаад, дотоодод агентлагийн дарга төлөөлнө. Агентлагийн дарга даалгасаар болон хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга агентлагийг төлөөлж болно.

9 дүгээр зүйл. Агентлагийн зохион байгуулалтын бүтэц

9.1. Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хэтгэбэр болон зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын сайд батална.

9.2. Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг агентлагийн дарга батална.

9.3. Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагаат удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцана.

10 дугаар зүйл. Агентлагийн ажлын зохион байгуулалт

10.1. Агентлаг нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй ажиллана.

10.2.Агентлагийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний бүрэлдэхүүн хэсэг байна.

10.3. Агентлагийн хэмжээнд агентлагийн даргын хууль тогтоомжид нийцүүлэн батлагдан хөдөлмөрийн дотоод жүрмыг мөрдөнө.

10.4.Хөдөлмөрийн дотоод жүрамд дараахь үндсэн зүйлийг тусгана:

10.4.1. агентлагийн ажлыг төлөвлөх, тайлагнах журам;

10.4.2. албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, халах;

10.4.3. захирагаа, албан хаагчийн эрх, үүрэг;

10.4.4. зохион байгуулалтын нэгж, ажилтны үйл ажиллагааны үр дүнг тооцож, дүгнэх арга хэлбэр;

10.4.5. дотоодын хяналт, шалгалт хийх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

10.4.6. дотоод журамд тусгахаар хууль тогтоомжид заасан бусад зүйл.

10.5. Хөдөлмөрийн дотоод журмыг ажилтан бүрт танилцуулсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Агентлаг нь бусад байгууллага,албан тушаалтантай харилцах

11 дүгээр зүйл. Агентлаг нь бусад байгууллага, албан тушаалтантай харилцах

11.1. Агентлаг нь эрхэлсэн асуудлаараа Монгол Улсын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын нэгжийн дарга, ажилтантай шууд харилцана.

11.2. Агентлаг нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, шүүх, прокурор болон Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн ажлын алба, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнтэй сайдаар дамжуулан харилцах ба эдгээр байгууллага, албан тушаалтан нь агентлагтай мөн сайдаар дамжуулан харилцана.

11.3 Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Засгийн газартай Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар дамжуулан харилцана.

11.4. Агентлаг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бусад яам, агентлагтай хуульд өөрөөр заагаагүй бол шууд харилцана.

11.5.Агентлаг нь эрхлэх асуудлаараа нутгийн өөрөө удирдах байгууллагатай аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар дамжуулан харилцана.

11.6. Агентлаг нь эрхлэх асуудлаараа нутгийн захиргааны байгууллагатай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаар дамжуулан харилцана.

11.7.Агентлаг нь эрхлэх асуудлаараа энэ зүйлд зааснаас бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй шууд харилцана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Агентлагийн санхүүжилт, эд хөрөнгө

12 дугаар зүйл. Агентлагийн санхүүжилт

12.1.Агентлаг нь улсын төсвөөс буюу үйл ажиллагааныхаа орлогоос санхүүжиж болно.

12.2. Улсын төсвөөс санхүүждэг агентлагийн төсвийн төслийг боловсруулах, батлах, захиран зарцуулах, тайлагнах журмыг хуулиар тогтооно.

12.3.Үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг агентлагийн тухайн жилийн төсвийг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрхэлсэн асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн хамтран батална.

12.4. Үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг агентлагийн тухайн жилийн орлогоос батлагдсан зардлыг нөхөж, төсөвт төлөх төлбөрийн тооцоо хийсний дараа үлдэх орлогын зохих хэсгийг тухайн агентлагт хөрөнгө оруулалт хийх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар үлдээж, бусдыг нь улсын төсөвт оруулна.

12.5.Тухайн агентлагийн мэдэлд үлдээх орлогын хувь хэмжээг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрхэлсэн асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

13 дугаар зүйл. Агентлагийн эд хөрөнгө

13.1. Агентлаг нь төрөөс өөрт нь олгосон эд хөрөнгөтэй байна.

13.2. Агентлаг нь өөрт нь олгосон эд хөрөнгө болон хуульд заасны дагуу олсон орлогоороо бий болгосон эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

14 дүгээр зүйл. Агентлагийн хэвлэл

14.1. Агентлагийн даргын тушаал, үйл ажиллагааныхаа талаар албан ёсоор нийтэд мэдээлэх зорилгоор агентлаг нь эмхтгэл гаргаж болно.

14.2. Агентлагийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга эрхлэх асуудлаараа албан ёсны мэдээлэл хийхдээ Засгийн газар, Монгол Улсын сайдын бодлогыг баримтална.

15 дугаар зүйл. Агентлагийн гадаад харилцаа

15.1.Агентлаг нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагатай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын сайдын тогтоосон журмыг үндэслэн гэрээ, хэлэлцээр байгуулж хамтран ажиллана.

15.2.Агентлагийн даргыг гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагад туршлага судлах, мэргэжлийн сургалтад явах, хурал, зөвлөлгөөнд оролцох /цаашид албан томилолт" гэх/-ыг Монгол Улсын сайд шийдвэрлэнэ.

15.3.Бүтцийн нэгжийн дарга, ажилтны албан томилолтоор ажиллах асуудлыг агентлагийн дарга шийдвэрлэнэ.

15.4.Агентлагаас гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид төлөөлөгч урих асуудлыг Монгол Улсын сайд шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл.Агентлагийн тамга, тэмдэг, бэлгэдэл

16.1. Агентлаг тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

16.3. Агентлаг нь эрхэлсэн ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болно.

16.4. Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн бэлгэдлийн загвар, тодорхойлолт, хэрэглэх журмыг агентлагийн дарга тогтооно.

17 дугаар зүйл. Агентлагийн шагнал

17.1. Агентлаг нь дараахь шагналтай байж болно:

17.1.1.агентлагийн хүндэт дэвтэрт бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

17.1.2.агентлагийн хүндэт өргөмжлөл.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан шагнал олгох нийтлэг журмыг Засгийн газар тогтоож, шагналын тодорхойлолт, загварыг тухайн агентлагийн дарга батална.

18 дугаар зүйл. Агентлагийн үйл ажиллагаанд хориглох зүйл

18.1. Агентлагт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

18.1.1. жагсаал, цуглаан хийх, ажил хаялт, өлсгөлөн, суулт зарлах зэрэг улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулах;

18.1.2.хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр орлого олох үйл ажиллагаа явуулах;

18.1 3.Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд үндэсн үйл ажилла'аатай нь холбоо бухий үйлчилгээ үзүүлдэг байгуулага, аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг агентлагийн байранд байрлуулах;

18.1.4. хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр хориглосон бусад үйл ажиллагаа.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуульд дор дурдсан агуулгатай 18[1] дүгээр зүйл нэмсүгэй:

"18[1] дүгээр зүйл. Дэд сайдын бүрэн эрх

1.Дэд сайд сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/сайдад улс төрийн бодлогын асуудлаар зөвлөх, мэдээллээр хангах;

2/сайдын нэрийн өмнөөс холбогдох агентлаг, бусад байгууллагатай өдөр тутам харилцах, тэдгээрийн үйл ажиллагаанд нэгтгэн зохицуулах;

3/хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах;

4/сайдын даалгасназр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргатай харилцах;

5/Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий сайдаас байгуулах хороо, комисс, зөвлөл, ажлын хэсэгт сайдын түр эзгүйд түүний даалгасназр сайдыг төлөөлөх;

6/хуульд заасан бусад бүрэн эрх.

2.Сайдын түр эзгүйд түүнийг орлож байх хугацаанд гаргасан шийдвэрээ сайдад танилцуулах бөгөөд уг шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна.

3.Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байна.

4.Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь түүнийг Засгийн газар томилсноор эхэлж, тухайн дэд сайдыг шинээр томилсноор дуусгавар болно.

5.Дэд сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

6.Дэд сайдыг орон гарсан тохиолдолд Засгийн газар 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно. Нөхөн томилогдсон дэд сайдын бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

7.Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр огцорсон, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг уг албан тушаалд дахин томилоход саад болохгүй.

8.Сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ дэд сайд Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно.

10.Дэд сайд бодлогын асуудлаар сайдтай санал зөрсөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно. Харин энэ талаар эцсийн шийдвэр гартал үүрэгт ажлаа гүйцэтгэж, хариуцлагыг нь хүлээнэ."

2 дугаар зүйл. Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газрын гишүүд удирдлагын түвшинд тохироолцсон асуудлаар хамтарсан тушаал гаргаж болно." гэсэн агуулгатай 3 дахь өгүүлбэр нэмсүгэй.

3 дугаар зүйл. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажил эрхэлнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх үндсэн хүрээний ажлыг энэ хуулиар, тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна."

4 дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэрийн "мэргэшлийн үндсэн дээр" гэснийг, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалтын "шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээ" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Засгийн газрын тухай хуулийн зүйлийн дугаарыг "18[1]" гэснийг "18[2]", "18[2]" гэснийг "18[3]" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/22[1] дугаар зүйл:

"**22[1] дугаар зүйл.Соёлын өвийн хяналт**

22¹.1.Соёлын өвийн хяналтыг мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ.

22¹.2.Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм, журам, түүнтэй холбогдсон норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

22¹.3.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.8 -д дурдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад байгаль орчны байцаагч хяналт тавина."

2/8 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

"8.11. Сум, дүүргийн Засаг дарга 8.9-д заасан болон тухайн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй малтлага, хайгуул хийж байгаа мэдээллийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 хоногийн дотор мэдээлнэ."

3/ 17 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:

"17.15. Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно. "

4/23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"23.2.Энэ хуулийн 8.11, 20.1-ийг зөрчсөн зөрчлийг шүүгч, 11.4, 12.2, 12.3, 17.7, 17.10, 17.13-г зөрчсөн зөрчлийг байгаль орчны улсын байцаагч , 8.1, 8.9, 9.4, 9.6, 11.4, 12.3, 13.2, 13.4, 14.2, 15.2, 16.3, 17.7, 17.10, 17.13, 20.1, 21.1, 23.1.1, 23.1.3 -г зөрчсөн зөрчлийг сум, дүүргийн Засаг дарга, соёлын хяналтын улсын байцаагч, 23.1.7-д заасан зөрчлийг соёлын хяналтын улсын байцаагч тус тус харьяалан шийдвэрлэнэ."

5/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"23.1.7.энэ хуулийн 8.6, 9.7-г зөрчсөн албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох."

6/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"23.1.8. шүүгч энэ хуулийн 8.11, 20.1-ийг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгох; "

2 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.7 -гийн "дурсгалт" гэсний дараа "цогцолбор", 4.1-ийн "арга барил" гэсний дараа "дэг сургууль", 5.2-ын "холбогдох" гэсний дараа "музей,", 6.1.2-ын "аймаг, нийслэлийн" гэсний өмнө "сум," 15.2.2-ын "зүйлийг" гэсний дараа "даатгалд хамруулан", 17.1-ийн "нийслэл" гэсний дараа "баг," 17.6-гийн "барилга," гэсний дараа "археологи, палеонтологи болон", "хамгаалалтын" гэсний дараа "болон түүх, соёлын дурсгалт цогцолбор газрын", 23.1.1-ийн "17.13" гэсний дараа ", 21.1", 23.1.2-ын "9.6" гэсний дараа ", 10.3", 23.1.3-ийн "зөөж тээвэрлэх" гэсний дараа ", тоollого хийх", 23.1.5-ийн "мрэзгүй" гэсний дараа "мргэнийг 20000-50000, албан тушаалтныг 30000-60000," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"3.1.8.эртний хүн, амьтан, бичил биетэн, ургамлын чулуужсан олдвор, ул мөр, тэдгээрийг агуулсан олдворт газар;"

2/7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"7.1.Бүртгэл-мэдээллийн сан нь соёлын өвийн тодорхойлолт, судалгаа шинжилгээний ажлын товч тайлан, гэрэл зураг, слайд, дуу болон дүрс бичлэгтэй халъс ба цахим хэлбэрээр хадгалах ажлын товч тайлан зэргээс бүрдэнэ."

3/11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"11.3.Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажилгаа журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

4/11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"11.6.Түүх, соёлын дурсгалт зүйлийн судалгаа шинжилгээний ажлын дэлгэрэнгүй тайланг 2 хувь үйлдэж, шинжлэх ухаан, технологийн мэдээллийн сан болон малтлага явуулсан байгууллагад тус тус хадгална. Тайлан бүрэн эхээрээ хэвлэлд нийтлэгдээгүй тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрхийн тухай хууль[1]-ийн дагуу шийдвэрлэнэ."

5/13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"13.3.Түүх, соёлын олдворыг цаашид судлах шаардлагатай бол судалгааг дуусгах, олдворын зэрэглэлийг тогтоолгох, холбогдох байгууллагад шилжүүлэх талаар зөвшөөрөл олгосон байгууллагатай гэрээ хийж зохицуулна."

6/20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"20.1.Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлж болно. Шаардлагатай бол хугацааг сунгаж болно."

7/23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"23.1.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бол шүүгч, соёлын болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, сум, дүүргийн Засаг дарга гэм буруутай этгээдэд дараахь шийтгэл ногдуулна:"

4 дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1, 20.3-аас "аль нэг хэсгийг", 3.1.1-ээс "хөрсөн доорх шороон булш, нууцлагдсан", "хадны агуй, хөмөг дэх", "бүх төрөл, хэлбэрийн", 10.2-оос "бүртгэл-мэдээллийн сан", "зэрэг газарт", 13.4 -өөс "нарийвчилсан" гэсэн үгийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмсүгэй.

"12.1.4. улсын чанартай музей" гэсэн заалт

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 20 дахь хэсэг нэмсүгэй:

"20. Харагуй, дүлий болох тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан тахир дутуу хүн ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагсдад тахир дутуу хүний эзэлж байгаа хувиар хөнгөлнө.".

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — **Улаанбаатар хот**

ХӨН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 15 дахь заалт нэмсүгэй:

"15/хараагүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан тахир дутуу хүний орлого."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн /1907-МОН/ гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" -ийн хүрээнд зээлийн хөрөнгөөр гадаад, дотоодоос нийлүүлэгдэх машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материал, гүйцэтгэх барилгын ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — **Улаанбаатар хот**

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн /1907-МОН/ гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" -ийн хүрээнд зээлийн хөрөнгөөр гадаадаас нийлүүлэгдэх машин механизм, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, материалыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр — **Дугаар 13** — **Улаанбаатар хот**

Хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүд буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар агентлагийн тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзсэн тул Засгийн газраас өргөн мэдүүлсэн Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

Сулеймен Демирелийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч асан Сулеймен Демирелийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Мустафа Буминыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Турк Улсын Үндсэн хуулийн Шүүхийн дарга Мустафа Буминыг "Алтан гадас одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

Халил Акынжыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Турк Улсын Гадаад хэргийн яамны Төв Ази, Кавказ, Монголын асуудал эрхэлсэн Ерөнхий газрын захирал Халил Акынжыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр ажилд, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Бадарчийн Түмэнбаярыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дагвадоржийн Буянжаргалыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн, Сүхбаатарын Ганчимэгийг Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 17-ны өдөр | **Дугаар 66** | **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм"-ийг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цэрэг-иргэний хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 206 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолын хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЦЭРГИЙН ШТАБЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штаб (цаашид "штаб" гэнэ) нь батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт хангах ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед зохион байгуулах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэшил, арга зүйн удирдлага, туслалцаа үзүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Штаб нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Засаг даргын захирамжийг мөрдлөг болгон ажиллана.

3. Штабын үйл ажиллагаа нь дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд оршино:

3.1. батлан хамгаалах талаархи бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

3.2. хуульд заагдсан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3. цэрэг-техникийн тоо бүртгэл хөтлөх;

3.4. цэрэг халалт, татлага, дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах;

3.5. цэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгааны болон дайчилгаатай сургуулийн бэлтгэлийг хангах;

3.6. нутаг дэвсгэртээ байрлаж байгаа зэвсэгт хүчний цэргийн анги, байгууллагатай хамтран ажиллах;

3.7. үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгсэл, цэргийн зориулалттай химийн хорт бодисын хөнөөл, хордуулалт, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас сэргийлэх, иргэдийг хамгаалах, аврах, тэмцэх, хор уршгийг арилгах арга ажиллагаанд бүх нийтийг сургаж бэлтгэх, энэхүү арга ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.8. дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг орон нутагт зохион байгуулах.

4. Штаб нь зохих журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Штабын удирдлага, зохион байгуулалт

5. Штаб нь аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын шууд удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулна.

6. Штаб нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргаас захиргааны удирдлагаар, цэргийн мэргэжлийн удирдлагын дэвд байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангагдана.

7. Хоёроос доошгүй нэр дэвшигчийг оруулан аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр штабын даргыг Батлан хамгаалахын сайд, бусад ажилтныг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргатай зөвшилцсөний үндсэн дээр Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

Штабын дарга, ажилтныг томилж, чөлөөлөх асуудлыг ажлын 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8. Штабын дарга нь дотоод ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбогдсон асуудлаар шийдвэр гаргаж, штабын ажилтнуудыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангана.

Гурав. Штабын эрх, үүрэг

9. Штаб дор дурдсан эрхтэй байна:

9.1. хуульд заасан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийн дагуу хүн, техникийг сум, дүүргээр хуваарилан оногдуулан данслах, тухайн сум, дүүрэг (хороо)-ийн Засаг даргаар биелэлтийг гаргуулан авах;

9.2. сум, дүүргийн дайчилгааны төлөвлөгөө, үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөл, тэдгээрийг ашиглан үйлдэгдэх болзошгүй алан хядах ажиллагаанаас иргэдийг хамгаалах удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг хянах, дүгнэлт гаргах, баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;

9.3. холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас шаардлагатай тайлан мэдээ гаргуулан авах;

9.4. тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн харьяалал харгалзахгүйгээр батлан хамгаалах асуудалтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар үүрэг, чиглэл өгч, биелэлтийг хангуулах;

9.5. хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цэргийн жинхэнэ алба хаагчийн чөлөө, томилолтын хугацаг 7 хүртэл хоногоор сунгах;

9.6. орон нутагт батлан хамгаалах үйл ажиллагаг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэлтэй оролцсон аж ахуйн нэгж, байгууллага, цэргийн үүрэгтэн, иргэдийг шагнаж, урамшуулахаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад тодорхойлох;

9.7. хууль тогтоомжид заасан бусад эрх.

10. Штаб нь дор дурдсан үүрэгтэй байна:

10.1. салбарын талаархи бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах;

10.2. хууль тогтоомжид заасан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулан Засаг даргатайгаа зөвшилцсөний үндсэн дээр эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

10.3. эрх бүхий байгууллагын шийдвэр, Засаг даргын захирамжийн дагуу иргэдийг жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, халах, цэрэг-техникийн шинэчилсэн бүртгэл явуулах ажлыг зохион байгуулах, дайчилгааны даалгаврыг хангах бүх талын арга хэмжээ авах;

10.4. үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөл, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас иргэдийг хамгаалах арга хэмжээг орон нутагт төлөвлөн зохион байгуулж, хяналт тавих оперативын бэлтгэлийн явц, төлөвлөлт, биелэлтэд дүгнэлт хийж боловсронгуй болгох, тэдгээрээс сэргийлэх, тэмцэх, хамгаалах, аврах, хор уршгийг

арилгах үйл ажиллагааг удирдах, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх;

10.5. орон нутгийн хамгаалалтын удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

10.6. сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагаас цэргийн болон үй олноор хөнөөх зэвсэг, хөнөөх хэрэгслийн хөнөөл, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас иргэдийг хамгаалах сургалт, дадлагад оролцох хүн, техникийг тодорхойлох, үүнтэй холбогдсон төлөвлөгөө хийхэд туслах, зарлах, мэдээлэх;

10.7. улсын хил хамгаалалтад туслах хүчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

10.8. цэргийн сургуульд суралцах, анги, салбарт гэрээгээр алба хаах хүсэлтээ илэрхийлсэн иргэдийг судлах, үзлэг, шалгаруулалтад оруулах;

10.9. эрхэлсэн ажлын чиглэлээр батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн удирдлагын байгууллага, Засаг даргаас өгсөн үүргийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, Засаг даргад мэргэжлийн зөвлөлгөө өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;

10.10. Батлан хамгаалахын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

10.11. дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт сургаж бэлтгэх, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдыг сургах, алба хаалгах, тэдэнтэй холбогдсон асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

10.12. цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаагчдын бүртгэлийг хөтлөн төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулах;

10.13. цэргийн бэлтгэл үүрэгтэнг давтан сургах, цэргийн дүйцүүлэх албатай холбогдсон зардлын нэгдсэн тооцоог гаргаж, орон нутгийн төсөвт тусгуулахаар аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргад уламжлах;

10.14. амралт, чөлөөгөөр болон томилолтоор орон нутагт явааа цэргийн жинхэнэ албан хаагчийг бүртгэн, чөлөөний хуудас, томилолтод тэмдэглэл хийх;

10.15. тухайн аймаг болон нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа цэргийн үүрэгтний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг барагдуулах;

10.16. гамшгийн аюулын үед зэвсэгт хүчнээс туслamж үзүүлэхээр томилогдсон бүрэлдэхүүний орон нутгийн мэргэжлийн байгууллагатай харилцах ажиллагаанг зохион байгуулах;

10.17. аймаг,нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөтэй холбогдолтой баримт бичгийг боловсруулах, тэдгээрийн нууцлалт, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

10.18. цэргийн штабын ажлын мэдээ, тайланг тогтоосон журмаар гарган батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагад хүргүүлэх, илтгэх.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (350)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 4 №17 (350)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. Нэмэгдсэн ертгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай 336

203. Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай 336

204. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай 336

205. Хэлэлцээр соёрхон батлах тухай 336

206. Хэлэлцээр соёрхон батлах тухай 337

207. Хэлэлцээр соёрхон батлах тухай 337

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

208. Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 14 337

209. Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 15 338

210. Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 16 338

211. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай Дугаар 17 339

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

212. Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 55 340

213. Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай Дугаар 56 340

214. Уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг үйлдэх тухай Дугаар 57 340

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

215. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай Дугаар 67 342

216. Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулах тухай Дугаар 69 346

217. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 70 346

Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

218. Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 2/01 347

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 16 дахь заалт нэмсүгэй.

"9.2.16. хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэл, тоноглол. Энэ заалтад хамаарах барааны жагсаалтыг Засгийн газар батална."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурсан агуулгатай 14 дэх заалт нэмсүгэй.

"14/хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэл, тоноглол. Энэ заалтад хамаарах барааны жагсаалтыг Засгийн газар батална."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгуулагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 19 дэх хэсэг нэмсүгэй.

"19. Хийн түлшний салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгуулагын зөвхөн энэ үйл ажиллагаанаас олсон орлогын албан татвараг эхний 5 жилд бүрэн чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татвараг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — **Улаанбаатар хот**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 11- дүгээр сарын 19-ний өдөр Пхеньян хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — **Улаанбаатар хот**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Вена хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр — Дугаар 14 — **Улаанбаатар хот**

Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.5, 28.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар батлаж, 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 74 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолынхавсралт

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа	Түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл	Албан тушаалын цалингийн хэмжээ (сард төгрөгөөр)
ТӨ-I		254200
ТӨ-II		191600
ТӨ-III		147500
ТӨ-IY	ТӨ-IYA	141500
ТӨ-Y	ТӨ-YA	131100
ТӨ-YI	ТӨ-YI A	125000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 15** **Улаанбаатар хот**

Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүний туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 82000 төгрөгөөр, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 53700 төгрөгөөр тус тус баталж, 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 75 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 16** **Улаанбаатар хот**

Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28. 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ"-г 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ"-г 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 77 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын цалингийн хэмжээ (сард төгрөгөөр)
1	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	126100
2	Нийслэлийн шүүхийн шүүгч	115900
3	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	121000
4	Аймгийн шүүхийн шүүгч	112200
5	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	113600
6	Дүүргийн шүүхийн шүүгч	108400
7	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	113600
8	Сум, сум дундын шүүхийн шүүгч	108400

Монгол Улсын Их Хурлын 2004 оны
16 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын цалингийн хэмжээ /сард төгрөгөөр/
1	Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор	124600
2	Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	114600
3	Нийслэлийн прокурор	124000
4	Нийслэлийн прокурорын орлогч	115300
5	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	106900
6	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	105000
7	Аймаг, тээврийн прокурор	119000
8	Аймаг, тээврийн прокурорын орлогч	110400
9	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	106900
10	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	105000
11	Дүүргийн прокурор	109000
12	Дүүргийн прокурорын орлогч	106900
13	Дүүргийн прокурорын газрын туслах прокурор	105000
14	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	104000
15	Сум, сум дундын ахлах прокурор	109000
16	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	104000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 17** **Улаанбаатар хот**

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 5.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн нутагт Замын-Үүд боомтыг түшиглэн худалдаа, үйлдвэрлэл, аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс байгуулсугай.

2. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн газрын хэмжээг 900 га-аар тогтоож, хилийн заагийг хавсралтаар батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны
17 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн хилийн зааг

"ЗАМЫН-ҮҮД" ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГАЗРЫН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	Цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг		
		Град^0	Мин^0	Сек^0	Град^0	Мин^0	Сек^0
1	А	43	42	25.5	111	54	53.7
2	Б	43	41	51.7	111	55	41.5
3	В	43	41	32.0	111	54	41.0
4	Г	43	41	17.0	111	52	48.0
5	Д	43	41	59.9	111	51	51.3
6	Е	43	43	00.0	111	51	55.0
7	Ё	43	42	24.4	111	53	36.0
8	Ж	43	41	37.7	111	56	13.9
9	З	43	41	36.5	111	56	13.2
10	И	43	41	48.8	111	55	30.2

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Дугаар 55 Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сүхбаатарын Ганчимэгийг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Нэргүйн Батчимэгийг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

Бадарчийн Түмэнбаярыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Дагвадоржийн Буянжаргалыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Дугаар 56 Улаанбаатар хот

Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Буниагийн Оюунцэцэгийг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 57 Улаанбаатар хот

Уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг үйлдэх тухай

Монголын ард түмэн уул овооны төрийн тайлга тахилгын ёслолын өнө эртний түүх уламжлалтай билээ. Эрт цагаас Монголчууд уул овоог орон нутгийн хэмжээнд шүтэж тахиж байснаас гадна түүхийн сурвалжид тэмдэглэснээр XIII зууны үед Чингис хаан Бурхан Халдун уулыг үрийн үрд тахиж, үе тутам шүтэж байхыг зарлиг буулгаж байв. Үүнээс хойш Богд хан, Отгонтэнгэр, Бурхан Халдун уулыг тус тус төрийн ёслолын хэмжээнд зарлигаар тахиж байсны дээр Богд хааны зарлигаар Дарьгангын Дарь овоог тахисан байна.

Эх болсон байгаль дэлхийгээ хүмүүнлэн үзэж хайрлан хамгаалах, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг бататган бэхжүүлэх, ард иргэдийнхээ эх оронч, үндэсний үзлийг сэргээн бадраах утга санаа,үйлдлэг сэтгэлгээг агуулдагт энэхүү тайлга тахилгын ёслолын ач холбогдол гүнээ оршиж байдаг билээ.

Өвөг дээдсийнхээ өнө эртний энэ сайхан зан заншил, түүх соёл, төрт ёсны уламжлалыг баримтлан уул овоогны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг эдүгээ цагийн байдалд нийцүүлэн үйлдэж байх нь зүйтэй хэмээн үзэж Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

1. Бурхан Халдун уул, Богд хан хайрхан уул, Отгонтэнгэр уулын тэнгэрийг тайх, Дарьгангын Дарь овоог тахих төрийн тахилгын ёслолыг үйлдэх нь зүйтэй хэмээн үзэж дээрхи уул, овоог Төрийн тахилгатай уул, овоо хэмээн нэрлэсүгэй.

2. Төрийн тахилгатай овоо, уул бүрийн тэнгэрийг тайх тахилгын ёслолыг 4 жилд нэг удаа үйлдсүгэй.

3.Төрийн тахилгатай овоо, уулын тэнгэрийг тайх тахилгын ёслолд төрөөс албан ёсоор оролцох оролцоог уг зарлигийн хавсралт журмаар батална.

4. Тахилгын ёслолын дэг, жаяг төрийн бус болон шашны байгууллага, ард иргэдийн оролцоог уул, овоо тус бүрийн онцлогийг харгалзан үзэж журамлан, тахилга үйлдэх саналаа тахилгын ёслол болохоос 3 сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлж байхыг холбогдох аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

5. Энэхүү зарлиг бууж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 110 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2004 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн
57 тоот зарлигийн хавсралт

ТӨРИЙН ТАХИЛГАТАЙ УУЛ ОВООНЫ ТЭНГЭРИЙГ ТАЙХ ТАХИЛГЫН ЁСЛОЛЫН ЖУРАМ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1. Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх ёслолын журмын зорилго

1.1. Энэхүү журмаар Богдхан хайрхан уул, Бурхан Халдун уул, Отгонтэнгэр уулын тэнгэрийг тайх, Дарьгангын Дарь овоог тахих төрийн тайлга тахилгын /цаашид "ёслол" гэх / ёслолд төрийн оролцоо, ёслолыг үйлдэх газар, санхүүжилт болон бусад зүйлсийг журамлан тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

2. Ёслолд албан ёсоор оролцох бүрэлдэхүүн

2.1 Уг ёслолын ажиллагаанд төрөөс албан ёсоор дараахи бүрэлдэхүүнтэйгээр оролцоно:

-Монгол улсын төрийг төлөөлж элч төлөөлөгчийг /цаашид " төрийн элч төлөөлөгч"/ гэх Монгол Улсын Ерөнхийлөгч томилох бөгөөд төрийн элч төлөөлөгч нь сайдаас доошгүй албан тушаалтан байх буюу төрийн өндөр албанд ажиллаж байсан зүтгэлтэн байж болно.

-Ёслолд төрийн элч төлөөлөгчийг тухайн аймгийн ИТХ -ын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга болон бусад бараабологсод дагалдана.

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын аль нэг нь өөрийн тааллаар оролцох бол тухай ёслолд Монгол улсын төрийг төлөөлнө.

- Төрийн элч төлөөлөгч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн айлтгал бичиг, торго, хүж, сум болон төрөөс илгээдэг бусад эд зүйлсийг ёслолын ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс өргөн барих үүрэг гүйцэтгэнэ.

2.2 Ёслолын ажиллагааг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга удирдан явуулна.

3. Ёслол үйлдэх газар

3.1 Ёслолыг Богдхан хайрхан уул, Бурхан Халдун уул, Отгонтэнгэр уул, Дарьгангын Дарь овооны тахилгын овооны тус газарт/ эртнээс тахиж ирсэн уламжлалтай тэр / нь үйлдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

4. Бусад зүйл

4.1 Ёслолын үеийн дэг журмыг тухайн аймгийн Засаг даргын боловсруулсан тусгай хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд ёслолд оролцогсдын байр, орчин, хоол, унаа, зам, тэдгээрийн аюулгүй байдал бүгд багтана. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд ёслолд оролцох тохиолдолд тэдний аюулгүй байдал ба ёслолын асуудлыг төрийн тусгай хамгаалалтын болон ёслолын алба хариуцан, ёслолын ажиллагааг зохион байгуулах комисстой хамтран гүйцэтгэнэ. Чингэхдээ тухайн ёслолын батлагдсан дэг дараалыг баримтлана.

4.2 Ёслолын үеэр шашны хуврагуудын унших ном, үйлдэх үйлдлүүдийг уул, овоо тус бүрийн тайлгын нь онцлогийг харгалзан үзэж, тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /түүний тэргүүлэгчид, дарга/ зохицуулна.

4.3 Ёслолын үеэр төрөө дээдлэхийн билэгдлээр төрийн элч төлөөлөгчдийг эрхэмлэн хүндэтгэнэ. Энэ нь шашны эрхэм хуврагуудад хамаарна.

4.4 Ёслолын ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилна.

4.5 Ёслолын үйл ажиллагааг гэрэл зураг, баримтат кино, цахим хэлбэрээр баримтжуулан Монгол Улсын Үндэсний архивын сан хөмрөгт хадгалуулахыг төр хариуцна.

5. Уул, овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолын үеэр цээрлэх зүйл

5.1 Ёслолын үеэр амьтны амийг тавчиж, цус гаргах, архи уух, маргалдаж сөргөлдөх, цээртэй үг хэлэх, ёс бус авир гаргах болон ёслолын дэг, дараалыг зөрчихийг цээрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 67 | Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай

Монгол Улсын Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн хэлний зөвлөлийн дүрэм"-ийг 1 дүгээр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Төрийн хэлний зөвлөлийн шаардагдах зардлыг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Төрийн хэлний зөвлөлийн бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 15 дугаар хавсралт болгон батлуулсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт дахь хүснэгтийн 10-ыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХУХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

Засгийн газрын 2004 оны 67 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Төрийн хэлний зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) нь Төрийн хэлний тухай төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн албан ёсны хэлний тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Зөвлөл нь боловсрол, соёл, шинжлэх ухаан, хууль зүй, гадаад харилцаа, үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэлийн захиргаа болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байна.

1.4. Зөвлөл нь Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж төрийн албан ёсны үйл ажиллагаанд дагаж мөрдөх орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёо, зөв бичих дүрмийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, батлан мөрдүүлэх, хэвшүүлэх, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, нэр томъёотой холбогдох асуудлаар дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Зөвлөлийн бүрэн эрх

2.1. Зөвлөл нь Төрийн албан ёсны хэлний тухай хуульд заасны дагуу дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. орчин цагийн монгол хэлний үгийн сангийн болон хэл зүйн хэм хэмжээ, зөв бичих дүрэм, нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулан батлагаажуулж хэрэглэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

2.1.2. ажлын хэсэг, мэргэжлийн комиссыг зохион байгуулж, ирэгд, байгууллагын санал, хүсэлтийг судлах, зөвлөмж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх;

2.1.3. шинэ болон мөрдөгдөж байгаа нэр томъёо, үг хэллэгийг олон нийтэд мэдээлж, хэвлэн нийтлэх;

2.1.4. орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёо, зөв бичих дүрмийн онол, хэрэглээ, арга зүйн асуудлаар эрдэм шинжилгээний

хурал, зөвлөлгөөн, сургалт, ярилцлага зохион байгуулах;

2.1.5. нэр томъёог зохистой хэрэглэх, хэвшүүлэх сурталчилгаа зохион байгуулах;

2.1.6. шинээр тогтоосон нэр томъёо, зөв бичих дүрэм зэрэг тулгамдсан асуудлаар мэдээлэл, тайлбар, зөвлөмж нийтлэх;

2.1.7. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

2.1.8. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай холбоотой ном, хэвлэл, дуут, дүрст, цахим мэдээлэл бүхий мэдээллийн сан байгуулах;

2.1.9. хэвлэл мэдээлэл, радио, телевизийн хэлний соёлд хуулийн дагуу хяналт тавих;

2.1.10. Засгийн газарт жилд нэг удаа ажлаа тайлагнах.

2.2. Зөвлөл нь дараахь эрхийг эдэлнэ:

2.2.1. нэр томъёоны болон хэлний хэм хэмжээ, зөв бичих зүйн салбар зөвлөлийг байгуулан монгол бичгийн хэлний зөв бичих дүрмийг боловсронгуй болгох, шинжлэх ухааны олон салбарын нэр томъёог оноох, жигдлэх ажлыг эрхлүүлэх;

2.2.2. шинээр хэрэглэх, шинэчлэн тогтоох нэр томъёог батлах;

2.2.3. зайлшгүй шаардлагатай мэргэжлийн хүмүүсийг харьяа байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр ажлын хэсэг болон мэргэжлийн комисст түр хугацаанд гэрээгээр ажиллуулах;

2.2.4. төрийн албан ёсны хэлний хэм хэмжээ, нэр томъёог улс даяар мөрдүүлэх зорилгоор нэр томъёоны толь, ном, гарын авлагыг хэвлүүлж түгээх зэрэг үйл ажиллагаанд шаардагдах зардлыг шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусган шийдвэрлүүлэх;

2.2.5. мэдээллийн сан байгуулах, судалгаа хийх, дүгнэлт гаргахад хэрэглэгдэх шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулах;

2.2.6. төрийн албан ёсны хэлний хэм хэмжээ, нэр томъёог дагаж мөрдөх талаар холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргах;

2.2.7. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгах талаар зөвлөмж гаргах, түүнийг эс биелүүлбэл холбогдох саналыг боловсруулан хууль хяналтын байгууллагад хүргүүлэх.

2.3. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, ажлын албатай байна. Ажлын албаны үүргийг Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн гүйцэтгэнэ.

2.4. Зөвлөлийн дарга нь дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

2.4.1. Зөвлөлийн ажлыг удирдах;

2.4.2. Зөвлөлийг төлөөлөх;

2.4.3. Зөвлөлийн ажиллах журам, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах;

2.4.4. Зөвлөлийн ажлын төлөвлөгөө, гишүүдэд олгох урамшуулыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.4.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, товыг тогтоох;

2.4.6. Зөвлөлийн хуралдааныг даргалж, хэлэлцсэн асуудлаар гишүүдийн санал тэнцсэн нөхцөлд эцсийн шийдвэр гаргах;

2.4.7. Зөвлөлийн жил бүрийн төсвийн төслийг хянаж батлуулах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;

2.4.8. Зөвлөлийн ажлын гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг эрх бүхий байгууллагад тайлагнах;

2.4.9. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах.

2.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

2.5.1. эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хариуцан зохион байгуулах;

2.5.2. Зөвлөлийн ажлын жил, улирлын төлөвлөгөө, зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.3. Зөвлөлийн даргын зөвшөөрлийн дагуу зөвлөлийн төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг зурж, хариуцах;

2.5.4. Энэхүү дүрмийн 2.2.3-т заасан хүмүүстэй Зөвлөлийн нэрийн өмнөөс гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх;

2.5.5. Зөвлөлийн жилийн ажлын тайланг боловсруулан зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

2.6. Зөвлөлийн өдөр тутмын ажлыг ажлын алба гүйцэтгэнэ.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай үед зөвлөлийн дарга, эсхүл гишүүдийн олонхийн саналаар хурлыг зарлан хуралдуулж болно.

3.2. Зөвлөлийн хуралдааны дэгийг зөвлөлийн хурлаар батлуулж мөрдөнө.

3.3. Хуралдааныг гишүүдийн гуравны хоёр оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцож буй гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.4. Зөвлөл хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргана. Тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

3.5. Зөвлөл нь "Төрийн хэлний зөвлөлийн мэдээлэл" цуврал бэлтгэн гаргана.

3.6. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 15 дугаар хавсралт

ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга -Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

Гишүүд:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын боловсрол,соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан референт;

-Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

-Шинжлэх ухааны академийн нийгмийн ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч;

-Хуулийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хуулийн бодлогын асуудал хариуцсан газрын дарга;

-Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, судалчилгааны үндэсний төвийн хуулийн нэр томъёоны асуудал хариуцсан албан тушаалтан;

-Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бага, дунд боловсролын асуудал хариуцсан газрын дарга;

-Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын асуудал хариуцсан газрын дарга;

-Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын соёлын асуудал хариуцсан газрын дарга;

-Үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

-Оюуны өмчийн газрын дарга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

-Шинжлэх ухааны академийн нийгмийн ухааны бага чуулганы нарийн бичгийн дарга;

-МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн захирал;

-Монгол Улсын боловсролын их сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал;

-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга;

-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн шинжлэлийн салбарын эрхлэгч;

-Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга.

Нарийн бичгийн дарга

-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 69** **Улаанбаатар хот**

Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулах тухай

Дорноговь аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний голомтыг устгах, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үр дүн, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, Гамшигтай тэмцэх комиссын хурлын шийдвэрийг харгалзан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Айраг сумдын нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн онцгой дэглэм, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулж 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 37 дугаар тогтоолын 2 дугаар зүйлээс "... Сайншанд, ... Эрдэнэ, ... Улаанбадрах, Замын-Үүд ..." гэснийг хассугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 37 дугаар тогтоолын 1, 15 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД
БӨГӨӨД ХҮНС,ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭЧ Ч.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 70** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Конвенци хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 145 дугаар тогтоолын хавсралтад "11. Буянт-Ухаа дахь Гаалийн газар" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н. ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД Ч. УЛААН

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр **Дугаар 2/01** **Улаанбаатар хот**

Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүн Л.Рэнчин /илтгэгч/, Н.Чинбат, В.Удвал, Ч.Дашням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо, 25 дугаар байр, 31 тоотод оршин суух иргэн П.Баттогтох, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Б.Долгор нар оролцлоо.

Иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн цэцэд хандаж 2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр гаргасан өргөдөлдөө Иргэний хэргийг шүүхэд хянан хэлэлцэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд нь Үндсэн хуулийн хэд хэдэн зүйл, заалтыг зөрчсөн тухай бичсэнээр үүссэн маргааныг тус дунд суудлын хуралдаанаар авч хэлэлцлээ.

Иргэн П.Баттогтох өргөдөлдөө хоёр үндсэн асуудлыг көндөж тавьсан байна. Энэ нь:

1. 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт: *"Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай хоёр шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана"* гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэжээ.

Төрөөр үүнийгээ дараах <u>үндэслэлээр</u> тайлбарласан байна:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: **"Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ"** гэж заасан байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлд шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргааны тухай зохицуулсан байдаг бөгөөд тэдгээрээс бусад хэргийг шүүх, бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг.

Харин уг хуулийн дээр дурдсан 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалтад дүн шинжилгээ хийж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүнд буй 3 шүүгч 3 өөр санал гаргах боломжийг хуулиар олгосон ба, ингэхдээ шүүх хуралдаан даргалагчийн саналыг нөгөө хоёр шүүгчийн саналаас илүүд авч үзэж 3 өөр санал гарсан бол хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх тухай заалтын агуулгыг зөрчиж байна.

Учир нь тухайн шүүх хуралдаан даргалагч бол уг шүүх хурлыг удирдаж, түүний хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэх үүргийг хүлээсэн байдгаараа л шүүх бүрэлдэхүүнд байгаа нөгөө хоёр шүүгчээсээ ялгаатай бөгөөд бусад байдлаараа тухайн асуудал, хэрэгт нэг л санал өгөх эрхтэй шүүгч юм.

Гэтэл түүний саналыг өөр өөр санал гаргасан нөгөө хоёр шүүгчийн саналаас илүүд үзэж байгаа нь Үндсэн хууль зөрчсөн заалт юм. Үндсэн хуульд заагдсан "хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх" зарчим бол тухайн асуудлыг <u>олонхийн саналаар</u> шийдвэрлэх явдлыг ойлгодог билээ гэжээ.

Өргөдөл гаргагч энэ саналтай цааш үргэлжлүүлэн тайлбарлахдаа:

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "**Ардчилсан ёс ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн**" гэж заасан

байдаг бөгөөд "ардчилсан ёс" гэсэн ойлголт нь "аливаа асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх" гэсэн ухагдахууныг өөртөө агуулдаг билээ. Шүүх байгууллага бол төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс ард түмэнд үйлчилж байдаг байгууллагуудын нэг тул түүний үйл ажиллагаанд "ардчилсан ёсны зарчим буюу асуудлыг олонхиор шийдвэрлэх" зарчим үйлчлэх ёстой. Энэ нь шүүх хэрэг, маргааныг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үед тод илрэх учиртай.

Нөгөө талаар 1974 онд Монгол Улс нэгдэн орсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухайн олон улсын пакт"-ийн 14 дүгээр зүйлд: "Хүн бүр өөрт нь тулгасан ...иргэний байцаан шийтгэх ажиллагаанд ...шүүхээр хэргээ ...шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй" гэж заасан ба тэрхүү шударгаар шийдвэрлүүлэх явдал нь шүүх тухайн хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж буй үед шийдвэрийг олонхийн саналаар гаргах байдлаар тодорхойлогдох бөгөөд энэ нь шударга ёсонд нийцэх билээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн заалт болох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэсэн хүсэлт тавьжээ.

2. 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх хэсгүүдэд заасан заалтуудыг зөрчиж байна гэжээ.

Өргөдөл гаргагч үүнийгээ дараахь үндэслэлээр тайлбарлаж байна:

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэсэн заалтад дүн шинжилгээ хийж үзвэл эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн шүүхэд өөрийгөө төлөөлүүлэхдээ зөвхөн хоёрхон арга замыг ашиглах эрхийг нь олгожээ.

Өөрөөр хэлбэл, тухайн иргэн шүүхэд хэрэг, маргааныг шийдвэрлүүлэх үедээ нэгдүгээрт: өөрийнхөө гэр бүлийн гишүүн төрөл садангаараа, эсвэл хоёрдугаарт: өмгөөлөгчөөр тус тус өөрийгөө төлөөлүүлж эрх, ашгаа хамгаалуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах болж байгаа бөгөөд дээрхи хоёр арга замаас өөр боломжийг иргэнд олгоогүй байна.

Тодруулбал, эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл саданги н бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй байна. Уг төлөөлөх хүн нь тухайн иргэний итгэлийг хүлээсэн бөгөөд эрх, ашгийг хамгаалж чадах хэн ч байж болно.

Жишээ авч үзье: Иргэн Б бусдын компьютерийг түр ашиглаж байх үед цахилгаан тасарч, түүний улмаас тухайн компьютер нь эвдэрсэн байна. Уг компьютерийн өмчлөгч А нь Б-гээс хохирлоо буюу компьютерын үнийг нэхэмжилж шүүхэд хандсан. Иргэн Б өөрийгөө бууруулж гэж үзэсэн бөгөөд үндэслэлт нь тухайн үед цахилгаан хүчдэл гэнэт ихэсч тасарснаас шалтгаалж, компьютерт нөлөөлсний улмаас уг компьютер эвдэрсэн гэж үзэжээ.

Шүүх хурал болох өдөр иргэн Б хөдөө ажлаар явах зайлшгүй шаардлагатай болсон. Энэ тохиолдолд иргэн Б-д өөрийгөө бууруулж гэж батлах ямар боломжууд байна вэ гэвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу түүнд нэгдүгээрт: өөрийгөө гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, хоёрдугаарт: өмгөөлөгчөөр төлөөлүүлэх гэсэн хоёрхон л боломж байна.

Гэвч түүний гэр бүлийн гишүүн, төрөл саданд өөрийнх нь эрх ашгийг шүүхэд хамгаалчихаар хэмжээний компьютерийн мэдлэгтэй хүн байхгүй, мөн компьютерийн талаар сайн мэдлэгтэй бөгөөд санаанд нь нийцэн өмгөөлөгч олдохгүй, олдсон ч өмгөөлөгчийн ажлын хөлс нь маш өндөр учир тэрээр төлөх боломжгүй байв.

Одоо түүнд эрх ашгаа хамгаалах бас нэг арга бий. Тэр нь шинжээч томилуулах явдал болович шинжээч бол түүний эрх, ашгийн төлөө биш, харин хэргийн талаар ач холбогдол бүхий нотлох

баримтыг бий болгох үүднээс тодорхой нэг дүгнэлт гаргадаг билээ. Энэ тохиолдолд иргэн Б өөрөө компьютерийн мэдлэг муутай учир шинжээчийн дүгнэлтийг үнэн зөв эсэхийг үнэлж, дахин шинжээч томилуулах хүсэлт гаргах, эсвэл шүүх хуралдаанд шинжээчийг дуудаж, түүнд мэргэжлийн асуулт тавих зэргээр эрх, ашгаа хамгаалах шаардлага гарч ирж байна.

Харин түүнд компьютерийн программ, техник хангамжийн инженер мэргэжилтэй найз байдаг бөгөөд уг найзаараа шүүхэд өөрийгөө төлөөлүүлэхээр тохиролцож, түүнд итгэмжлэл олгох гэтэл иргэн Б-д хууль зүйн тийм боломж алга байна.

Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт түүнд тийм боломж олгоогүй байгаа бөгөөд энэ нь иргэн Б-гийн хууль ёсны эрх, ашгийг шууд зөрчиж байна.

Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт: "**...Монгол Улсын иргэн өөрийн байгуллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй**" гэж заасан байдаг. Иргэн хүн энэхүү эрхээ эдлэх эсэх нь түүний хүсэл зориг, үзэмжийн асуудал билээ. Хэрэв иргэн энэ эрхээ эдэлж, өөрийнхөө зөрчигдсөн болон зөрчигдөх гэж байгаа эрх ашгаа хамгаалуулахаар өргөдөл, гомдол гаргаж болох бэ энэ тохиолдолд хууль зүйн бүхий л бололцоог ашиглах боломжтой байдаг.

Тэрхүү боломжуудын нэг нь бусдаар өөрийгөө төлөөлүүлэх явдал бөгөөд төлөөллийн талаархи үндсэн харилцаат Иргэний хуулийн 62-70 дугаар зүйлүүдээр зохицуулдаг билээ.

Төлөөллийн талаархи уг зохицуулалт нь Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар: "Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ" гэж төлөөллийн харилцаа үүсэх үндэслэлийг заажээ.

Харин уг хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно" гэж заасан бөгөөд уг заалтын агуулгыг үзвэл аливаа хүн /төлөөлүүлэгч/ иргэний эрх зүйн зарим чадамжтай болон иргэний эрх зүйн чадамжгүй иргэнээс бусад хэнээр ч өөрийгөө төлөөлүүлж болохоор байна.

Мөн Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт бичээр олгосон итгэмжлэлд тавигдах шаардлагыг тодорхойлсон байна.

Ер нь аливаа төлөөллийн харилцаа нь Иргэний хуульд заагдсан дээрхи зохицуулалтын хүрээнд явагдах учиртай. Хэдийгээр салбар эрх зүйн онцлог гэж байх боловч шүүх иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх байгаа л юм бол Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд төлөөллийн харилцаг зохицуулахдаа Иргэний хуульд заасан төлөөллийн талаарх үндсэн зохицуулалтыг хэт явцуурүүлж тусгах ёсгүй билээ.

Ийнхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийг зөрчсөн болон Иргэний хуулийн төлөөллийн талаарх үндсэн зарчмыг гажуудуулж байна гэжээ. Өргөдөл гаргагч цааш нь тайлбарлахдаа:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт: "...Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, ...хууль зүйн туслалцаа авах, ...шүүхээр шүүлгэх, ...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхтэй" гэж заасан.

Энэ эрхүүдийг авч үзвэл:

"...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шүүхээр шүүлгэх..." эрхүүдийн агуулгад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн иргэн уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах болон шүүхээр шийдвэрлүүлэхдээ өөрийн эдэлж болох жам ёсны бүхий л эрхүүдийг эдэлж, өөрийнхөө эрх ашгийг хамгаалах явдал багтах учиртай. Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь иргэнийг гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн бус, түүнчлэн өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлж шүүхээр эрхээ хамгаалуулах боломжийг явцуурүүлж, хязгаарлаж байна.

"...өөрийгөө өмгөөлөх..." эрхийн хувьд иргэн өөрийнхөө эрх, ашгийг хамгаалахдаа өмгөөлөгч авч чөлөө, авахгүй ч байж болно. Энэ бол түүний үзэмжийн асуудал юм. Иргэний хэргийг шүүхээр шийдвэрлүүлж буй иргэн өмгөөлөгч авахгүй гэж үзэн, өөрийгөө өмгөөлж, өөрийнхөө эрх

ашгийг өөрөө хамгаалж болох бөгөөд энэ эрх нь тухайн хэрэг, маргаанд уг иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож чадахгүй болсон тохиолдолд өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсвэл өөрийн итгэл хүлээсэн, эрх ашгийг нь хамгаалж чадах хүнээр өөрийгөө төлөөлүүлж, шүүхээр хэрэг, маргааныг шийдвэрлүүлэх байдлаар илрэх ёстой гэж бодож байна. Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь тухайн иргэнийг өөрийгөө шүүхэд төлөөлүүлэхдээ нэг бол гэр бүлийн болон төрөл садангийн хүнээр төлөөлүүл, эсвэл заавал өмгөөлөгчөөр төлөөлүүл, өмгөөлөгч ав, өөр сонголт, боломж байхгүй гэсэн агуулгатай байгаа бөгөөд энэ нь иргэн хүний "өмгөөлөгч авах эсэх эрх"-ийг өмгөөлөгч зайлшгүй авах үүрэг болгосон шинжтэй заалт болжээ. Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуульд заасан "өөрийгөө өмгөөлөх" гэсэн эрхийг зөрчиж байна.

"...хууль зүйн туслалцаа авах..." эрхийн илрэх хэлбэрүүдийн нэг нь иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн иргэн итгэл хүлээсэн, мэргэжлийн хүнээр өөрийгөө төлөөлүүлэх хууль зүйн боломжтой байх явдал юм.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь тухайн иргэн мэргэжлийн хүнээс буюу бусдаас /өмгөөлөгчөөс биш/ "хууль зүйн туслалцаа авах эрх"-ийг боогдуулж байгаа нь Үндсэн хууль зөрчиж буй хэрэг мөн.

"...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох..." эрхийн хувьд авч үзвэл тухайн иргэн шүүх ажиллагаанд биеэрээ оролцох эрх эдлэхийн хувьд тийнхүү оролцох эсэх нь бас л түүний үзэмжийн асуудал билээ. Хэрэв тухайн иргэн иргэний хэргийн шүүх ажиллагаанд биеэрээ оролцох боломжгүй, шаардлагагүй гэж үзвэл оролцохгүй байх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд эрх ашгийг нь хамгаалж чадах хүнээр үүнийг өөрийгөө төлөөлүүлж, шүүх ажиллагаанд оролцуулж болох билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь хэрэг, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлж буй тухайн иргэнд хоёрхон сонголт олгосон бөгөөд тэдгээр нь өмнө дурдсанчлан: "гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсвэл өмгөөлөгчөөр төлөөлүүлэх" байдлаар тусгагдсан нь агуулгын хувьд хэрэв тухайн иргэн дээр дурдсан 2 сонголтыг хэрэглэхгүй гэж шийдвэл түүнд шүүх хуралдаанд өөрөө биеэрээ оролцох ёстой болох / нөгөө эрх нь бараг үүрэг болж хувирсан/, эсвэл шүүх ажиллагаанд болон хуралдаанд биеэрээ оролцохгүй гэвэл эрх ашгаа хамгаалж чадахгүй болж, нэхэмжлэл нь шүүхээс буцаагдах нөхцөл байдал бий болж байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хууль заасан **"хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох"** эрхийг гажуудуулж байгаа нь Үндсэн хууль зөрчиж байна гэжээ.

Өргөдөл гаргагч цааш нь өгүүлэхдээ:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: **"Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахийц... хууль зүйн ...баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"** гэж заасан байдаг. Энэ заалтын агуулгад иргэний хэргийн шүүх ажиллагаанд тухайн иргэн өөрийгөө иргэний эрх зүйн зарим чадамжтай болон иргэний эрх зүйн чадамжгүй иргэнээс бусад хэнээр ч төлөөлүүлэх, эрх ашгаа хамгаалуулж болох тийм хууль зүйн орчин, баталгааг бүрдүүлэх үүрэгтэй байх явдал хамаарагдана. Түүнчлэн "...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна..." гэсэн заалт нь тухайн иргэн өөрийн хэрэг, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх ажиллагаанд гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, өмгөөлөгчөөр болон өөрийнхөө эрх ашгийг хамгаалж чадах бусад этгээдээр тус тус өөрийгөө төлөөлүүлж болох боломжийг өөртөө агуулсан маш өргөн хүрээтэй ойлголт билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуулийн дээр дурдсан "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахийц...хууль зүйн...баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн үүрэг бүхий заалтыг хэрэгжүүлэхэд дөхөм болох биш харин эсрэгээр нь буюу "хүний төлөөлөх, төлөөлүүлэх эрх"-ийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэжээ.

Өргөдөл гаргагч ийм үндэслэл, тайлбаруудыг дурдаад хүсэлт болгоҳдоо:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн: "Ардчилсан ёс … нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг тус тус зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож өгнө үү.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэр бүхий заалт, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн холбогдох заалтууд, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Өргөдөл гаргагч өвөрийн 2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр гаргасан өргөдлөдөө 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр нэмэлт хүсэлт тайлбар гаргасан байна. Түүнд бичихдээ:

-Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хуульд, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн давах, хяналтын шатны хурлын хэргийг зохицуулсан заалтуудад хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж байгаа үед асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж заасан атлаа ганцхан иргэний хэсгийг анхан шатаар 3 шүүхийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж буй үед 3 өөр санал гарвал даргалагчийн саналаар шийдэнэ гэж заасан нь энэхүү заалт буруу бөгөөд Үндэсн хууль зөрчиж буйг давхар нотолж байна гэжээ.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийг мөн зөрчиж байна.

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: **"Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"**, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: **"Хүнийг …эрхэлсэн ажил, албан тушаал… аар нь ялгаварлан гадуурхаж үл болно"** гэсэн заалт юм.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: *"Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дурааргаа гэр бүлийн ашгүүн, төрөл садангараа, эсхүл эгрэзнийн үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно"* гэсэн нь эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн шүүхэд өөрийгөө төлөөлүүлэхдээ эвэхэн хоёрхон арга замыг ашиглах эрхийг нь олгосон тухай өмнөх өргөдлөөс дурдсан билээ.

Харин эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй байгаа юм.

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "Хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд өөрийн албан тушаал, эсхүл төлөөлөх эрх олгогдсоныг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлнэ" гэж заажээ.

Энэ заалт ёсоор бол хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд нь тухайн хуулийн этгээдэд ажилладаг албан тушаалтан байж болно, эсвэл уг хуулийн этгээдийг төлөөлөх эрх олж авсан хэн ч байж болохоор байна. Өөрөөр хэлбэл тухайн хуулийн этгээдийн удирдлагаас төлөөлөх эрхийг олж авсан аливаа хүн байж болно.

Гэтэл иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй хэрнээ хуулийн этгээдэд, албан тушаалтанд тийнхүү өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө / хуулийн этгээдийг/ төлөөлүүлэх боломжийг олгож байгаа нь иргэнийг албан тушаалтнаас доогуур тавьж, хууль, шүүхийн өмнө ялгаварлан гадуурхаж байна.

-Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: *"Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд…төрийн нэрийн өмнөөс оролцоно"*гэж төрийн байгууллага, албан тушаалтанд өмгөөлөгч бус хүнээр /прокуророор/ эрх ашгаа хамгаалуулж болохоор заасан хэрнээ иргэн хүнд өмгөөлөгч бус хүнээр эрх ашгаа хамгаалуулах боломжийг олгоогүй байгаа нь бас л иргэний албан тушаалтнаас доогуур тавьж, хууль, шүүхийн өмнө ялгаварлан

гадуурхаж байгаа хэрэг билээ гэвч, иймд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн заалтыг зөрчсөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Энэ өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн тухай УИХ-д мэдээлж өргөдлийн хувийг хүргүүлснээр УИХ-аас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр УИХ-ын гишүүн Б.Долгор томилогдож, тэрээр Цэцэд энэ асуудлаар тайлбараа ирүүлсэн байна. Энэ тайлбарт дурдахдаа:

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасанчлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох, мөн зүйлийн 4 дэх хэсэгт: эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлөх болох тухай заажээ. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх төлөөлөгчийг оролцуулж байгаа институт нь хоёр талтай.

Нэгдүгээрт, иргэн, хуулийн этгээдэд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалахад тусалж байна. Хоёрдугаарт, хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоох, түүнийг үнэн зөвөөр шийдвэрлэхэд шүүхэд тус дөхөм болж байгаа билээ. Төлөөлөл нь хуульд зааснаар, эсхүл сайн дураар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэй байх ерөнхий зарчим энэхүү хуульд тусгагдаж, төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлөгчөөс олгосон итгэмжлэл, бусад бичиг баримтаар тодорхойлно.

Мөн дээр дурдсан хуульд 18 насанд хүрээгүй этгээд, эсхүл эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, чадамжгүй этгээд төлөөлөгчөөр оролцож болохгүй талаар хуульчилсан юм. Иймхүү эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөхэд нэгдүгээрт, гэр бүлийн гишүүн, төрлийн эсхүл саданги хүн нь сайн дураараа оролцоно, хоёрдугаарт Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу гэрээний үндсэн дээр төлөөлж болно.

Үүнээс гадна эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо мэргэжлийн үндсэн дээр хамгаалуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Өмгөөллийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч-иргэнээр төлөөлүүлнэ.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.1-д заасанчлан иргэн өөрийн биеэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь тухайн хэрэгтэх төлөөлөгчийг давхар оролцуулах эрхийг нь хязгаарлаагүй болно. Энэ нь Иргэний хуулиар тогтоосон төлөөлөлтийн ерөнхий зарчим, агуулгад нийцэж байгаа юм. Иймд 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно гэж заасан заалтыг явцуу утгаар нь тайлбарлан ойлгож байгаа нь үндэслэлгүй гэж үзэж байна.

Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж заасан Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийн заалт нь гуйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн талаар заасан гэж үзэж байна.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн Монгол Улсын иргэн хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл, уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө емгөөлөх, ...хууль зүйн туслалцаа авах, ...шүүхээр шүүлгэх, ...шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхтэй тухай заажээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1-д иргэн өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно гэжээ. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэсэн үг билээ.

1994 оны 5 дугаар сарын 9-ны өдөр баталсан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн /одоо хүчингүй болсон/ 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад энэ асуудлыг хуульчлан тогтоож байсан болно.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин

хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

"Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн Үндсэн хуулийн энэ заалт нь шүүхээс аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ бүрэлдэхүүнээр буюу хэд хэдэн шүүгч хамтран хянан хэлэлцэж байх асуудлыг хуульчилсан гэж үзэж байна.

Харин ийнхүү хэрэг, маргааныг хамтран хянан хэлэлцсэн шүүх шийдвэрээ гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114.3-т заасны дагуу олонхийн саналаар шийдвэрээ гаргана. Харин 3 шүүгч гурван өөр саналтай байгаа тохиолдолд гарах нэг гарц болгон шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргахаар 114.4 дэх заалтыг хуульчилсан билээ. Иймд хуулийн дээр дурдсан заалт нь Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна гэжээ.

Өргөдөл гаргагч иргэн П.Баттогтох Цэцийн хуралдаанд оролцож үг хэлэхдээ өргөдөлд бичсэн хүсэлт, тайлбар, үндэслэлүүдээ дэмжиж байгаагаа илэрхийлээд өргөдлийн дагуу асуудлыг шийдэж өгөхийг хүсье гэв.

Хуралдаанд оролцсон УИХ-ын төлөөлөгч Б.Долгор өргөдлийг хүлээж аваад Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбараа тодруулан дэлгэрүүлж ярив. Инээхдээ өмнө гаргасан тайлбартаа нэмэлт болгон хэлэхдээ:

-Шүүх хамтын журмаар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэг нь хэргийг хэд хэдэн шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэх, хуралд ирэгдийн төлөөлөгчидийг оролцуулж хэлэлцэж буй асуудлаар тэдний санал бодлыг авч шийдвэрт тусгах агуулгыг гол нь илэрхийлж байгаа юм. Үүнийг шийдвэр гаргахдаа зөвхөн олонхийн саналаар гаргана гэсэн утгаар тайлбарлах нь өрөөсгөл зүйл болно гэв. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-д өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно гэсэн заалт нь Үндсэн хуульд заасан иргэн хүн хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлэхдээ аль болох мэргэшсэн, энэ асуудлыг эрхэлдэг хүнээс авах нь зохимжтой, ингэвэл ажил хэрэгч, эрхээ хамгаалж буй иргэнд ч илүү тустай, үр дүнтэй гэсэн агуулгаар бичигдсэн зүйл юм. Ингэж хуульд бичигдснээр иргэний эрх, эрх чөлөө хязгаарлагдаад, Үндсэн хууль зөрчигдөөд байна гэж үзэх үндэс байхгүй гэв.

Маргагч талуудын тайлбар, үндэслэл, бусад холбогдох баримт бичиг, материалыг хянан үзээд гаргасан дүгнэлтийн **ҮНДЭСЛЭЛ:**

Маргааны I хэсгийн талаар:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийднэ" гэж заасан нь 3 буюу түүнээс дээш бүрэлдэхүүнээр асуудлыг шүүх явч хэлэлцэж шийдвэрлэхдээ 1 хүний саналаар биш, оролцсон шүүгчдийн олонхийн саналаар шийдвэр гаргана гэсэн утгыг тодорхой илэрхийлсэн байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Ардчилсан ёс ….нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасан нь аль ч төрийн байгууллага асуудлыг хянаж шийдвэрлэхдээ ганцаар захирах, шийдэх ёсыг бус олонхийн саналыг харгалзаж, түүнд үндэслэж асуудлыг шийдэх зарчмыг баримтлах санааг илэрхийлсэн байна. Олонхийн саналаар асуудлыг шийдэх энэ зарчим маргаантай хэрэг, асуудлыг таслан шийдвэрлэдэг хараат бус, шударга шүүхийн үйл ажиллагаанд бүр ч тод томруунаар илэрч байх учиртай.

3.Олонхийн зарчмаар асуудлыг ийнхүү шийдэх энэхүү зарчим Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль зэрэг процессын бүх хуулиудад тодорхой тусгагджээ. Энд хэлэлцэж буй маргааны зүйл болсон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн тухайд гэхэд л энэ зүйлийн 3-т "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж байгаа бол олонхийн саналаар шийдвэр гаргана" гэж шууд, тодорхой хэлсэн атлаа мөн тэр дороо энэ зүйлийн 4-т: "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргана…" гэж заажаглуулгын илэрхий зөрчил гаргасан байна.

Мөн Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргана" гэсэн нь хууль тогтоогч Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлогдсон "хамтын зарчим" гэсэн ойлголтын гол агуулга нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн утга гэдгийг салбар хууль гаргахдаа тодруулан зааж өгчээ гэж ойлгогдож байна.

Эдгээрээс үзвэл хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэх үед 3 өөр санал гарсан бол хуралдаан дарталагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ гэсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх заалт нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсгийн агуулга, олонхийн саналаар шийдвэр гаргах зарчмыг зөрчсөн нь харагдаж байна.

Маргааны II хэсгийн талаар:

4.Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж Иргэний хэргийн байцаан шийтгэх ажиллагааны төлөөлөлтийн хэлбэрийг тоочиж тодорхойлходоо төлөөлөлтийн зарим боломж, хэлбэрийг орхигдуулж явцуурууллан тал харагдаж байгаа боловч үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх шууд үндэслэл тогтоогдохгүй байна.

5.Иргэн П.Баттогтох өргөдлөөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь заалт; Арван зургадугаар зүйлийн 12, 14 дахь хэсгийн заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь хүлээж авах боломжгүй байна.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж байхад 3 өөр санал гаргавал шүүх хуралдаан дарталагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх, хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-т "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА **Н.ЖАНЦАН**

ГИШҮҮД

Л.РЭНЧИН

Н.ЧИНБАТ

Ч.ДАШНЯМ

В.УДВАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (351)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Усны тухай*
- *Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд, хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 10 №18 (351)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

219. Усны тухай 355

220. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 368

221. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 368

222. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуульд нэмэлт оруулах тухай 368

223. Усны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай 369

224. Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 369

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

225. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай Дугаар 18 372

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

226. Төсвийн төлөвлөлтийн үе шатыг тогтоох тухай Дугаар 73 389

227. Дүрэм батлах тухай Дугаар 74 390

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

УСНЫ ТУХАЙ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь ус, түүний сав газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Усны тухай хууль тогтоомж

2.1.Усны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1] , Байгаль орчныг хамгаалах тухай хууль[2], Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль[3], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.
[2] Байгаль орчныг хамгаалах тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.
[3] Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 25 дугаарт нийтлэгдсэн

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."усны нөөц" гэж одоо ашиглаж байгаа, цаашид ашиглаж болох гадаргын болон газрын доорхи усыг;

3.1.2."усны сав газар" гэж гадаргын ус хурах талбай, газрын доорхи ус агуулсан чулуулаг бүхий орчинг;

3.1.3."усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газрыг;

3.1.4."онцгой болон энгийн хамгаалалтын бүс" гэдэгт усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг;

3.1.5."эрүүл ахуйн бүс" гэдэгт усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг;

3.1.6."хилийн ус" гэж Монгол Улсын хилийн шугамын дагуу буюу огглон оршиж буй гадаргын ба газрын доорхи усыг;

3.1.7."усан сан" гэж усыг хуримтлуулан ашиглах зориулалтаар баригдсан усны барилга, байгууламж , хиймэл нуур, цөөрмийг;

3.1.8."усны барилга байгууламж" гэж усны түрэлт болон урсацыг тохируулах, ус хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорхи ус олборлох, усны гамшигаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга, байгууламжийг;

3.1.9."услалтын систем" гэж бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорхи усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолборыг ;

3.1.10. "ашиглаж болох боломжит нөөц" гэж сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгээр тодорхой хугацаанд авч ашиглаж болох усны нөөцийн дээд хэмжээг;

3.1.11."усны аудит" гэж усны алдагдал болон ус хэмнэх нөхцөлийг тогтоож, түүнд шаардагдах хөрөнгийг тооцох, усны хэрэглээнд үнэлгээ хийх ажиллагааг;

3.1.12. "усны менежментийн төлөвлөгөө" гэж тухайн сав газрын усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон бодлогын баримт бичгийг;

3.1.13."усны экологи-эдийн засгийн үнэлгээ" гэж усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдлыг өртгөөр илэрхийлсэнийг;

3.1.14."ус ашиглагч" гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчинг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

3.1.15."ус хэрэглэгч" гэж ашиг олох зорилгүйгээр унд, ахуйн хэрэглээ болон мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг.

4 дүгээр зүйл. Усны нөөц

4.1.Монгол Улсын усны нөөцийн сан нь улсын хилийн доторхи гадаргын болон газрын доорхи усны нөөцөөс бүрдэнэ.

4.2.Усны нөөц нь экологи-эдийн засгийн үнэлгээтэй байна.

5 дугаар зүйл. Усны эрэл, хайгуул, судалгаа

5.1.Усны нөөц, түүнээс ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээг эрэл, хайгуул, судалгаагаар тогтооно.

5.2.Усны нөөц бүрэлдэн бий болох, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг үндэслэн усны нөөц, түүнээс ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээг тогтоох эрэл, хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр усны менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

5.3.Усны эрэл, хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг дараахь этгээд гаргана:

5.3.1.эдийн засгийн бүс, усны сав газрын гидрогеологийн болон гидрологийн судалгаа, улсын зэрэглэлтэй хот, бусад хот тосгон, суурин газрын усан хангамж, малын бэлчээр, хадлан, тариаланг усжуулах усны эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг Засгийн газар;

5.3.2.иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн байгаль хамгаалах албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга.

5.4.Усны эрэл, хайгуул, судалгааны ажлыг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.4.1.энэ хуулийн 5.3.1-д заасан үйл ажиллагаат улсын төсвийн хөрөнгөөр, 5.3.2-д заасан үйл ажиллагаат захиалагчийн хөрөнгөөр тус тус гүйцэтгэнэ.

5.5.Энэ хуулийн 5.3.1-д заасан хөрөнгөөр явуулах усны эрэл, хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд[1] заасны дагуу сонгон шалгаруулна.

5.6.Усны эрэл, хайгуул, судалгаа явуулсан байгууллага хайгуул, судалгааны ажлын дүнг баталгаажуулан, мэдээ, тайланг улсын усны мэдээллийн сан хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6 дугаар зүйл. Усны хяналт-шинжилгээний сүлжээ

6.1.Усны хяналт-шинжилгээний сүлжээ нь усны нөөц, чанарын өөрчлөлт, бохирдлын түвшинг тогтоох байнгын ажиллагаатай өртөө, ажиглалтын цооногоос бүрдэнэ.

6.2.Усны хяналт-шинжилгээний өртөө, харуулын тоо, байршил, шинжилгээний төрөл, арга зүйг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, мэргэжлийн удирдлагаар хангана.

6.3.Усны хяналт-шинжилгээний сүлжээг тоноглох, багаж хэрэгслээр хангах, сүлжээг ажиллуулах зардлыг улсын төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

7 дугаар зүйл. Усны мэдээллийн сан ба кадастр

7.1.Улсын усны мэдээллийн сан нь аймаг, нийслэлийн гадаргын ба газрын доорхи усны нийт ба ашиглалтын нөөц, чанар, өөрчлөлт, хяналт шинжилгээний мэдээлэл, ус ашиглалт болон бохир ус зайлуулахтай холбогдсон мэдээ, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламжийн үзүүлэлт зэрэг мэдээ, мэдээллээс бүрдэнэ.

7.2.Улсын усны кадастр нь усны нөөцийн байршил, хил хязгаар , эзлэх талбай, төлөв байдлын үзүүлэлтүүд, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, ашиглалтын горим, ашигласан усны хэмжээ,чанар болон усны улсын мэдээллийн сангаас бүрдэнэ.

7.3.Усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх үзүүлэлт, хэтлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8 дугаар зүйл. Усны тоо бүртгэл

8.1.Усны эх үүсвэрийн тоо, нөөц, чанар, ашигласан болон хаягдал усны хэмжээ, бүртгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг даргын шийдвэрээр жил бүр орон нутгийн төсвийн хөрөнгөөр, улсын хэмжээнд 4 жил тутам улсын төсвийн хөрөнгөөр холбогдох мэргэжлийн байгууллага явуулж, улсын усны мэдээллийн сан оруулна.

8.2.Усны тоо бүртгэл явуулах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3.Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны тоо бүртгэлтэй холбогдсон мэдээг эрх бүхий байгууллагад гарган өгөх үүрэгтэй.

[1] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 17 дугаарт нийтлэгдсэн

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Усны харилцааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

9 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

9.1.Улсын Их Хурал усны харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.усны талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

9.1.2.усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтоох;

9.1.3.томоохон гол, мөрний урсацын тохируулга хийх, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

9.1.4.хил дамжсан гол мөрөн, нуурын асуудлаар гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах, цуцлах.

10 дугаар зүйл . Засгийн газрын бүрэн эрх

10.1.Засгийн газар усны харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.усны талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;

10.1.2.улсын усны менежментийн төлөвлөгөөг батлах;

10.1.3.усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, усжуулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;

10.1.4.усны экологи, эдийн засгийн үнэлгээг батлах;

10.1.5.хүн амыг эрүүл, ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр батлах;

10.1.6.эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор гол, мөрний усыг ашиглах асуудлыг шийдвэрлэх;

10.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

11.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усны харилцааны асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. усны эрэл, хайгуул, судалгааны ажлын тайланг баталгаажуулж, ашиглаж болох боломжит нөөцийг батлах;

11.1.2.энэ хуулийн 10.1.2-т заасан төлөвлөгөөний төслийг Засгийн газарт оруулах;

11.1.3.хууль тогтоомжид нийцүүлэн ус ашиглалт, хамгаалалт, усны орчинг нөхөн сэргээх, уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших талаархи дүрэм, журам, аргачлал, заавар зэргийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлаж, мөрдүүлэх;

11.1.4.усны нөөцийн төлөв байдал, чанарыг тодорхойлох үнэлгээ өгөх, нөөцийн өөрчлөлт, хадгалалт, түгээлтийг хянан дүгнэх үүрэг бүхий хяналт-шинжилгээний сүлжээ ажиллуулах;

11.1.5.улсын усны мэдээллийн сан, кадастр бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих;

11.1.6.усны нөөц байгалийн жамаараа нөхөн сэргэх, цэвэрших чадвар буурсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчинг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар хориглох;

11.1.7.хүн амыг эрүүл, ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

11.1.8.усны эрэл, хайгуул хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах;

11.1.9.байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс усны нөөцийн менежментийн бодлого, зохицуулалтаар хангах;

11.1.10.хилийн усны хамтарсан ертөө, харуулын сүлжээ байгуулах, үер болон бусад нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаар хөрш орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулах;

11.1.11.усны нөөцийн судалгааны шинжлэх-ухаан, техникийн нэгдсэн бодлого боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;

11.1.12.энэ хуулийн 5.3.1-д заасан хайгуул, судалгааны ажилд шаардагдах улсын төсвийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, биелэлтийг дүгнэн, гүйцэтгэгчийг санхүүжүүлэх;

11.1.13.энэ хуулийн 5.3.1-д заасан хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

12 дугаар зүйл. Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын бүрэн эрх

12.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага ажиллана.

12.2.Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага усны харилцааны асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1.усны нөөцийг нэгдмэлээр ашиглах, хамгаалах, түүний орчныг нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөг боловсруулах;

12.2.2.усны эрэл, хайгуул, зураг төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны төлөвлөгөө боловсруулах;

12.2.3.усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар, хязгаалтын тоог ус ашиглагч болон гол, мөрний сав газраар тогтоон батлэх, мөрдүүлэх;

12.2.4.усны экологи-эдийн засгийн үнэлгээг боловсруулах;

12.2.5.химийн бодис хэрэглэдэг үйлдвэр, үйлчилгээний газрын хаягдал усыг цэвэршүүлэх техникийн нөхцөл, стандартыг дэвшилт технологи, шинжлэх ухааны олоттод тулгуурлан боловсруулж, батлуулах;

12.2.6.усны сав газрын зөвлөл, усны мэргэжлийн байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

12.2.7.усны сав газрын хэмжээнд усны экологийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах;

12.2.8.голын голдирлыг түр буюу хэсэгчлэн өөрчлөх, усны урсацын тохируулга хийх, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;

12.2.9. усны нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх, усны мэдээллийн сан ба улсын усны кадастрыг хөтлөх, усны төлөв байдалтай холбогдолтой мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах;

12.2.10.үйлдвэрлэлийн хаягдал усыг дахин ашиглах техникийн нөхцөл боловсруулж, мөрдүүлэх;

12.2.11.энэ хуулийн 5.3.1, 5.3.2-д заасан хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавьж, тайлан гүйцэтгэлийг баталгаажуулах;

12.2.12.бэлчээр, хадлан, тариаланг усжуулах инженерийн хийцтэй услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт хийж, байгаль орчин, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12.2.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

12.4.Аймаг, нийслэлийн байгаль орчны алба нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.4.1.усны тухай хууль тогтоомжийн биелэлтийн явцад хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг дарга, усны асуудал эрхэлсэн Засгийн газрын байгууллагад тайлагнах;

12.4.2.аймаг, нийслэлийн усны мэдээллийн санг бүрдүүлж, мэдээг усны асуудал эрхэлсэн Засгийн газрын байгууллагад өгөх;

12.4.3.усны нөөцийг ашиглах, усны орчинг нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих;

12.4.4.ус ашиглах зорилгоор цооног еремдөх зөвшөөрөл олгох эсэх талаар зохих шатны Засаг даргад санал оруулах;

12.4.5.усны тооллогыг нутаг, дэвсгэрийнхээ

хэмжээнд зохион байгуулах.

12.5.Сум, дүүргийн байгаль хамгаалагч усны харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.5.1.сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож, усны мэдээллийн санд бүртгүүлнэ;

12.5.2.усны нөөц ашигласны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж, гүйцэтгэлийг хангах.

13 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

13.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

13.1.2.усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, усны орчинг нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сав газрын зөвлөл, Засаг даргаас оруулсан дүгнэлт, хөтөлбөрийг хэлэлцэж, батлах;

13.1.3.Засаг даргын саналыг үндэслэн гадаргын усыг орон нутгийн хамгаалалтад авах, хамгаалалтын бүсийн заагийг тогтоох;

13.1.4.хуульд заасан бусад эрх.

14 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

14.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

14.1.2.аймгийн төв, нийслэлд хөрсний усны түвшин доошилж хомсдохоос сэргийлэх, үерийн аюулаас хамгаалах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх;

14.1.3.улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгааны захиалга гаргаж, байгаль орчны болон дэд бүтцийн асуудал зохицуулсан төрийн захиргааны төв байгууллагад оруулах;

14.1.4.ус, усны орчинг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, усны барилга, байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг удирдах;

14.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

15.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.нутаг, дэвсгэртээ усны тухай хууль тогтоомж, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаархи Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

15.1.2.энэ хуулийн 14.1.1-т заасан хөтөлбөрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсвийг баталж, түүний биелэлтэд хяналт тавих;

15.1.3.усны барилга, байгууламжийг өмчлөгч, эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр усны үйлчилгээний хөлсийг тогтоох;

15.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

16 дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

16.1.Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.нутаг, дэвсгэртээ ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжилтийг хангах;

16.1.2.усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашигласан, дур мэдэн цооног гаргасан үйл ажиллагаат таслан зогсоох;

16.1.3.мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн нутаг дэвсгэртээ бохир ус зайлуулах цэг тогтоох;

16.1.4.усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тухайн эх үүсвэрээс ус ашиглахыг зогсоох, тэдгээрийг нөхөн сэргээх, ойжуулах, ургамалжуулах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргах;

16.1.5.нутаг дэвсгэр дахь усны эх үүсвэр, усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтоож, тэмдэгжүүлэх;

16.1.6.усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг сурталчлах;

16.1.7.ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, ажлын 14 хоногт багтаан шийдвэрлэх;

16.1.8.усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, байгаль хамгаалагчийн дүгнэлтийг үндэслэн ус ашиглуулах шийдвэр гаргах.

16.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

17 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын бүрэн эрх

17.1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.нутаг, дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай баг, хорооны Засаг даргын мэдээллийг сонсох;

17.1.2.багийн нутаг, дэвсгэрт байгаа худаг, усан сан, услалтын системийн ашиглалт, эзэмшилийг зохицуулах, бэлчээр, хадлан, тариаланг усжуулах зорилгоор худаг гаргах, хөв, усан сан, услалтын систем байгуулах талаар Засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэх;

17.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

18 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

18.1.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, зохистой ашиглах, усны орчинг нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг, дэвсгэртээ зохион байгуулж, хангах;

18.1.2.гол, горхи, булаг, шандын эхийг тохижуулах, мод суулгац тарих, ургамалжуулах, үндаргыг нэмэгдүүлэх, бохирдоохоос хамгаалах арга хэмжээнд иргэдийг татан оролцуулах;

18.1.3.нутаг, дэвсгэртээ байгаа уст цэгийн ашиглалт, хамгаалалт, эзэмшилтэд хяналт тавих;

18.1.4.усны онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сахиулах;

18.1.5.хуульд заасан бусад эрх.

19 дүгээр зүйл. Сав газрын зөвлөл

19.1.Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаархи нутаг, дэвсгэрийн усны менежментэд нутгийн иргэдийг оролцуулах зорилгоор гол, мөрний сав газрын зөвлөл /цаашид "сав газрын зөвлөл" гэх/ байгуулан ажилуулна.

19.2.Сав газрын зөвлөлийн дарга, бүрэлдэхүүнийг дараахь эрх бүхий этгээдүүд томилж, чөлөөлнө:

19.2.1.хоёр буюу түүнээс дээш аймаг дамжин урсдаг гол, мөрний сав газрын зөвлөлийг тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

19.2.2.нэг аймгийн хоёр буюу түүнээс дээш сум дамжин урсдаг гол, мөрний сав газрын зөвлөлийг аймаг, нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид;

19.2.3.тухайн сум дотор байгаа гол, мөрний сав газрын эвдэлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид.

19.3.Сав газрын эвдэлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба ажлын үр дүнг харгалзан улируулан томилж болно.

19.4.Сав газрын эвдэлд нь дарга, нарийн бичгийн дарга, 5-15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба түүнд тухайн нутаг, дэвсгэрийн засаг захиргаа, байгаль орчны алба, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, төрийн бус байгууллага, иргэд, эрдэмтэн, судлаачид, байгаль хамгаалагч, мэргэжлийн хяналтын алба, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байна.

19.5.Сав газрын эвдэлийн шийдвэр нь дүгнэлт, тогтоолын хэлбэртэй байна.

19.6.Сав газрын эвдэлд нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.6.1.ус ашиглагч нь гэрээ болон энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан үүргээ бүрэн гүйцэд хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;

19.6.2.сав газрын усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, биелэлтэд хяналт тавих;

19.6.3.ус ашиглагч этгээд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр хүлээсэн нөхөн сэргээх үйл ажиллагаагаа бүрэн гүйцэд биелүүлж байгаа эсэхийг хянах;

19.6.4.усны нөөцийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм бүрэн гүйцэд хангагдаж байгаа эсэхийг хянах;

19.6.5.усны эх, ундаргыг ойжуулах, хамгаалалтын хашаа, хайс татаж, тохижуулах ажлыг нутгийн иргэдийн дэмжлэг, санаачлага, мэргэжлийн байгууллагын хүчээр зохион байгуулахад оролцох;

19.6.6.энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй этгээдийн ус ашиглах эрхийг 14 хүртэл хоногоор түдгэлзүүлэн зогсоох, буруутай үйл ажиллагааг арилгуулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих ;

19.6.7.усны барилга, байгууламжийн зураг, төсөл, усны нөөцөд сөрөг нөлөөтэй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан тохиолдолд түүнийг барьж байгуулах ажлыг түдгэлзүүлэх тухай санал гаргах;

19.6.8.усыг зориулалтын дагуу ашиглах, усны орчинг нөхөн сэргээх, хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

19.6.9.энэ хуулийн 19.6.6-д заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүргийг биелүүлээгүй этгээдийн ус ашиглах эрхийг бүрмөсөн цуцлах тухай дүгнэлт гарган эвдэлийн хурлаар хэлэлцүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх ба сав газрын эвдэлийн дүгнэлтийг хүлээн авсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын 7 хоногт багтаан хэлэлцэж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах үүргийг холбогдох Засаг даргад өгнө.

19.6.10.сав газрын эвдэлийн дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20 дугаар зүйл. Усны мэргэжлийн байгууллага

20.1.Усны эрэл, хайгуул, судалгаа явуулах, цооног өрөмдөх, усны барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах, түүнийг барих, тоноглох, ус хэмнэх технологи нэвтрүүлэх, усны шинжилгээ, аудит хийх ажлыг усны мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

20.2.Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.3.Усны мэргэжлийн байгууллагын эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5 жилийн хугацаагаар олгох бөгөөд үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн тохиолдолд эрхийг нь 5 жил тутам сунгана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ус хэрэглэх, ашиглах

21 дүгээр зүйл. Ус ашиглах зориулалт

21.1.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна.

21.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус ашиглах, хэрэглэх зориулалтаас хамааруулан дараахь байдлаар ангилна:

21.2.1.ус хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

21.2.2.ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

21.3.Рашаан, эрдэс усны нөөцийг эмчилгээний зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

21.4.Хилийн усны ашиглалт, хамгаалалтын асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулна.

22 дугаар зүйл. Ус хэрэглэгч

22.1.Ус хэрэглэгчид газрын доорхи ус ашиглалтын цооног өремдөх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

22.2.Ус хэрэглэгч нь чанарын шаардлага хангасан усаар хангагдах эрхтэй.

23 дугаар зүйл. Ус ашиглагч

23.1.Гэрээ байгуулж, зөвшөөрөл авснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

23.2.Ус ашиглах гэрээг 20 хүртэл жилээр байгуулж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан үүргээ бүрэн биелүүлж ирсэн ашиглагчийн ус ашиглах эрхийг тухай бүрд 5 хүртэл жилээр сунгана.

23.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрх нь өөрийн эзэмшилийн газар дахь ус ашиглах эрхийг төлөөлөхгүй.

23.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны эх үүсвэрийг гэрээний үндсэн дээр хамтран ашиглаж болно.

24 дүгээр зүйл. Ус ашиглуулахад тавигдах шаардлага

24.1.Ус ашиглахаар хүсэлт гаргагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

24.1.1.ус ашиглалтын явцад ялгарах бохир усаа стандартын түвшинд хүртэл цэвэршүүлэх барилга байгууламжтай байх;

24.1.2.хаягдал усыг дахин ашиглах, хэмнэлттэй зарцуулах технологитой байх;

24.1.3.усны нөөц ашигласны төлбөрийг бүрэн гүйцэд төлөх;

24.1.4.ус авах цэгт тоолуур байрлуулж, баталгаажуулах;

24.1.5.ус ашиглагч, хэрэглэгч нь ашигласан усны үйлчилгээний хөлсөө төлөх.

24.2.Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээнээс үйлдвэрлэлийн зориулалттай усны эх үүсвэр, шугам сүлжээг тусгаарлана.

24.3.Биологийн нөөц хамгаалах байгууламжгүй болон газрын хөрсийг намагжих, давсжих, эвдрэхэд хүргэхээр усны барилга байгууламж, усан сан, далан, суваг, нуур, цөөрөм байгуулж, ашиглахгүй байх.

24.4.Уул уурхайн олборлолтод ус ашиглах аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал баяжуулах усаа голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор дамжуулан авах.

25 дугаар зүйл. Ус ашиглах хүсэлт гаргах

25.1.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад гаргана.

25.2.Ус ашиглах хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

25.2.1.ашиглах усны эх үүсвэр, түүний байршлыг харуулсан зураг;

25.2.2 усны нөөц, чанарын үнэлгээ;

25.2.3.хоногт ашиглах усны хэмжээ;

25.2.4.барилга, байгууламжийн зураг, төсөл;

25.2.5.үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт;

25.2.6.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.

26 дугаар зүйл. Ус ашиглуулах дүгнэлт гаргах

26.1.Хоногт 100 шоо метрээс дээш ус ашиглуулах дүгнэлтийг усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага, 50-100 шоо метр хүртэл хэмжээний усыг ашиглуулах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба, 50 шоометр хүртэл хэмжээний усыг ашиглуулах болон гар аргаар худаг гаргах, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг байгаль хамгаалагч тус тус гаргана.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана.

26.3.Ус ашиглах гэрээ байгуулсан этгээдэд ус ашиглах эрхийн бичиг олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

26.4.Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглуулахыг хориглоно.

27 дугаар зүйл . Ус ашиглах гэрээ

27.1.Сум, дүүргийн байгаль хамгаалагч энэ хуулийн 16.1.8 дахь заалтыг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулна.

27.2.Ус ашиглах гэрээнд дараахь зүйлийг тусгана:

27.2.1.ус ашиглуулах тухай сум, дүүргийн Засаг даргын шийдвэр;

27.2.2.ус ашиглах зориулалт, хоногт ашиглах усны хэмжээ;

27.2.3.усны эх үүсвэрийн байршил, барилга байгууламжийн зураг, төсөл;

27.2.4.хаях бохир усны хэмжээ, цэвэршүүлэх болон ус хэмнэх технологи, цэвэршилтийн түвшин;

27.2.5.усны төлөв байдал, чанар, найрлага;

27.2.6.ашиглах усны 1 шоо метрт ногдох нөөц ашигласны төлбөр;

27.2.7.усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ;

27.2.8.гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг;

27.2.9.шаардлагатай бусад зүйл.

28 дугаар зүйл. Ус ашиглах гэрээг цуцлах

28.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан ус ашиглах гэрээг дараахь тохиолдолд зөвшөөрөл олгогчийн санаачлагаар хугацааныг нь өмнө цуцална.

28.1.1.гэрээнд заасан үүргээ бүрэн гүйцэд биелүүлээгүй;

28.1.2.Байгаль хамгаалах тухай болон Усны тухай хууль тогтоомж зөрчсөн;

28.1.3.ус ашигласны төлбөрөө тогтоосон хугацаанд нь төлөөгүй;

28.1.4.усны эх үүсвэрийг бохирдуулсан;

28.1.5.ус ашиглагч нь тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмжөө суурилуулагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

28.1.6.сав газрын зөвлөлийн дүгнэлтээр.

29 дүгээр зүйл. Ус ашиглах эрхийн бичиг

29.1.Гэрээ байгуулж, эрхийн бичиг авсанаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

29.2.Ус ашиглах зөвшөөрөл бүрийг усны мэдээллийн санд бүртгэнэ.

29.3.Ус ашиглах эрхийн бичгийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30 дугаар зүйл . Ус ашигласны болон бохирдуулсаны төлбөр

30.1.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус ашигласны төлбөр төлнө.

30.2.Ус ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх нөхцөлийг хуулиар тогтооно.

30.3.Ус бохирдуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсаны нөхөн төлбөр төлнө.

30.4.Ус бохирдуулсаны нөхөн төлбөрийн хэмжээг хуулиар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Усны нөөц, чанарыг хамгаалах, усны орчинг нөхөн сэргээх

31 дүгээр зүйл. Усны нөөц, чанарыг хамгаалах

31.1.Ус ашиглагч нь экологийн тэнцлийг хангахад шаардагдах хэмжээний нөөцийг байгальд заавал үлдээх үүрэг хүлээнэ.

31.2.Усны эх, ундаргад онцгой хамгаалалтын бүс тогтооно.

31.2.1.онцгой хамгаалатын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, эмийн болон хүнс, техникийн зориулалттай үргамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

31.3.Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно.

31.4.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

31.5.Мөрөн, гол, усны эх үүсвэр, усны сав газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

31.6.Улсын стандартад тохирохгүй технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулахыг хориглоно.

31.7.Гол, мөрний урсацын байгалийн үндсэн голдирлыг нийт уртын дагуу өөрчлөх, голдирол дотор ашигт малтмал угаах, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр олборлохыг хоригдоно.

31.8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн, сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө.

32 дугаар зүйл. Ган,цөлжилт,хуурайшилтын үед усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах

32.1.Ган, цөлжилт, хуурайшилтын үеийн тэнцвэр хангах зориулалтаар бороо, цас, үерийн усыг хуримтлуулах, далан, хаалт, хиймэл нуур, цөөрөм барьж, байгуулах ажлын талаархи тухайн нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжиж, бүх шатны Засаг дарга зохион байгуулан гүйцэтгэнэ.

32.2.Тухайн жилийн ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэлийг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.

32.3.Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн талаархи журмыг Засгийн газар тогтооно.

33 дугаар зүйл. Усны нөөцийг хэмнэх, хомсдохоос хамгаалах

33.1.Усыг хэмнэлттэй ашиглах зорилгоор ус ашиглагч бүр усны тоолууртай байх үүрэг хүлээнэ.

33.2.Усны нөөцийн байгалийн жамаар нөхөн сэргэх, цэвэрших чадвар буурсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглахыг зогсоож, усны орчинг нөхөн сэргээх арга хэмжээг сум, дүүргийн Засаг дарга ус ашиглагч байгууллагатай хамтран авч хэрэгжүүлнэ.

33.3.Хоногт 50 шоо метрээс их ус ашиглагч ус хэмнэлттэй ашиглах технологи нэвтрүүлэх, бохир ус цэвэрлэх технологийн горимыг мөрдүүлэх үүрэг бүхий усны хэрэглээ хариуцан менежертэй байна.

34 дүгээр зүйл. Усыг бохирдохоос хамгаалах

34.1.Усны нөөцийн сан бүхий газарт цацраг идэвхит, халдвар тараах болон химийн хорт бодисын хаягдал хадгалах, устгах, хог хаягдал, бохирдуулах бодис, үйлдвэрлэлийн бохир ус хаяхыг хориглоно.

34.2.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар доторлож, тохижуулсан байна.

35 дугаар зүйл. Усыг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг урамшуулах

35.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн ус ашиглагчдад дараахь хөнгөлөлт, урамшууллыг үзүүлж болно.

35.1.1.усыг хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг тохижуулах талаархи иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлага, үйл ажиллагааг урамшуулах;

35.1.2.өөрийн хүч, хөрөнгөөр цас, бороонд ус хуримтлуулж, нуур, цөөрөм байгуулсан, худаг гаргасан, хуучин услалтын систем, уст цэгийг засч, тохижуулан тоноглосон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн байгууламжийг давуу эрхээр эзэмшинэ;

35.1.3.усыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, технологийн процесст ялгарсан усаа шаардлагын хэмжээнд хүртэл цэвэршүүлсэн, дахин ашигласан, байгаль орчин, хүний эрүүл мэндэд ивээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид ус ашиглах давуу эрх олгоно;

35.1.4.усны нөөц, чанарыг хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн, байгаль орчинд ивээлтэй, хэмнэлттэй технологи хэрэглэж байгаа ус ашиглагчийг урамшуулна.

35.2. Энэ хуулийн 35.1.1, 35.1.2, 35.1.3-т заасан урамшууллыг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35.3.Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, байгаль хамгаалах сан, аж ахуйн, нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Усны барилга байгууламж

36 дугаар зүйл. Усны барилга байгууламж

36.1.Усны барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих ажлыг зөвхөн эрх бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

36.2.Энэ хуулийн 36.8-д зааснаас бусад улсын чанартай усны барилга байгууламж барих шийдвэрийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аймаг, нийслэлийн Засаг дарга, усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

36.3.Усны барилга, байгууламжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулж болно.

36.4.Усны барилга, байгууламж эзэмших, ашиглах эрхийг 20 хүртэл жилийн хугацаатайгаар олгох бөгөөд нэг удаад 5 жилээр сунгана.

36.5.Усны барилга, байгууламж эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бусдын усны хэрэгцээг гэрээний үндсэн дээр хангах үүрэгтэй бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга тухайн иргэн, аж ахуйн

нэгж, байгуулагатай байгуулсан гэрээг цуцалж болно.

36.6.Зохих зөвшөөрлийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, сэргээн засварласан усны барилга, байгууламж нь тэдгээрийн өмчлөлд байж болох бөгөөд харин усны нөөц нь нийтийн ашиглалтад байна.

36.7.Хүн амын төвлөрсөн ус хангамж, ариутгах татуурга, усны нөөцөд тохируулга хийх, хуваарилах зориулалт бухий толгойн барилга, байгууламж төрийн өмчид байна.

36.8.Услалтын систем барих, шинэчлэх, засварлах шийдвэрийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

36.9.Усны барилга, байгууламжийг өмчлөгч, эзэмшигч нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр усаар хангана.

36.10.Усны аливаа барилга, байгууламж нь паспорттай байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Хариуцлага хүлээлгэх

37 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

37.1.Усны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хохирлыг нөхөн төлүүлж, шүүх болон улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

37.1.1.усны тоо бүртгэлийн болон усны эрэл, хайгуулын судалгааны тайлан, мэдээг эрх бүхий байгуллага, албан тушаалтанд хугацаанд нь гаргаж өгөөгүй бол иргэнийг 10000, аж ахуйн нэгж, байгууллагыг 80000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.2.ус ашиглалтын болон бохир усны бүртгэлийг хугацаанд нь явуулаагүй, тайлан, мэдээг гаргаж өгөөгүй бол албан тушаалтныг 10000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.3.энэ хуулийн 22.1, 23.1, 24.1-ийг зөрчсөн иргэнийг 20000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.4.энэ хуулийн 31.3-ыг зөрчсөн албан тушаалтныг 20000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.5.усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр ашигласан буюу гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хураах, зөрчил гаргасан иргэнийг 30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.6.ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан иргэнийг 30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.7.ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан эсхүл бусдад шилжүүлсэн иргэнийг 30000, албан тушаалтныг 50000 хүртэл торгох;

37.1.8.усыг бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг 20000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 хүртэл төгрөгөөр торгох;

37.1.9.энэ хуулийн 31.2.1, 31.7-д заасныг зөрчсөн иргэнийг 30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 хүртэл төгрөгөөр торгож, онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн газрыг нөхөн сэргээхтэй холбогдсон зардлыг нөхөн төлүүлэх.

38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

38.1.Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 20 дугаар зүйлийн 5; 27 дугаар зүйлийн 11 дэх заалт тус тус нэмсүгэй.

1/ 20 дугаар зүйлийн 5 дугаар заалт

5. Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар.

2/ 27 дугаар зүйлийн 11 дүгээр заалт

11. Усны нөөц доройтон хомсдож, бохирдох бодит аюул учирч байгаа улсын хэмжээний ач холбогдол бүхий том гол, сав газрыг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг зохих шатанд тавьж шийдвэрлүүлэх.

2 дугаар зүйл. 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "өөрчлөх" гэсний дараа ",голын усыг бохирдуулах " гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 4.1.2-ын "аргачлал" гэсний дараа "Байгаль орчны асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.2-ын 13.5-д гэснийг 31.4-д гэж , 12.4.2-ын 13.4 гэснийг 31.3-д гэж, 12.4.4-ийн 13.5-д гэснийг 31.4-д гэж, 12.8-ийн 15.1-д гэснийг 34.1-д гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГООС БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "газрын төлбөрийн орлогын 20 ба түүнээс дээш" гэсний дараа ",ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын 35 ба түүнээс дээш", "үндсэн чиглэлд газар" гэсний дараа "ус," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын Их Хурлаас 1995 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр батлсан Усны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Усны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 4, 6, 12, 16, 18, 19, 22, 23 дугаар зүйлд дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 7 дахь заалт:

"7/ статистикийн мэдээллийг бага зардлаар, мэдээлэгчид ачаалал багатай арга, хэлбэрээр цуглуулах."

2/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "з":

"з/ бүтээмжийн үзүүлэлтүүд."

3/ 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2, 4, 21, 22 дахь заалт:

"2/ албан ёсны статистикийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах;

4/ захиргааны статистикийн мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэлтэй давхардуулахгүй байх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хянах, захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөх, мэдээллийн хамралт,үнэн зөв байдалд үнэлэлт өгөх;

21/ статистикийн мэдээллийн хэрэглэгч нь албан ёсны статистикийн мэдээллийн дунг өөрчлөн, олон нийтэд буруу ташаа мэдээлэх тохиолдолд албан ёсны тайлбар хийж, залруулах;

22/ албан ёсны статистикийн үзүүлэлтийн зэрэгцүүлэх суурь үнийг батлах."

4/16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 8 дахь заалт:

"8/ өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагаас егсен мэдээ, тайлан нь дутуу, алдаатай бол холбогдох этгээдээс тайлбар гаргуулан авах, анхан шатны бүртгэлтэй тулгаж, магадлах."

5/ 16 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:

"5. Статистикийн улсын байцаагч нь түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн шаардах хуудас, акт, торгуулийн хуудас хэрэглэнэ.

6. Статистикийн улсын байцаагч нь Төрийн албаны тухай[1] хуульд зааснаас гадна дараахь батлагаагаар хангагдана:

1/ статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахтай холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг тогтоосон журмын дагуу тухайн байгууллага нь нөхөн олгох;

2/ бүрэн эрхээ хэрэгжүүлж яваад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацааны туршид тус тус авах."

[1] Төрийн албаны тухай - " Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

6/ 18 дугаар зүйлийн 4 дэх заалт:

"4/ статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн газраас батлагдсан маягтаар мэдээлэгчээс гаргуулан авах."

7/ 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт:

"6/ хуулийн этгээдийг бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийн бүртгэлийн жагсаалт дахь шаардлагатай мэдээлэл, түүнд орсон өөрчлөлтийг Үндэсний статистикийн газарт тухай бүрт мэдээлэх."

8/ 22 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг:

"6. Статистикийн төв, орон нутгийн байгууллага нь хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн нууцыг чанд хадгалж, мэдээллийг улс, бүс нутаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, салбарын түвшинд нэгдсэн дүн гаргах, статистикийн үзүүлэлтийг тооцоход ашиглана.

7. Тооллого, түүвэр судалгаанд хамрагдсан хувь хүн, хуулийн этгээдийн анхдагч мэдээллэлд боловсруулалт хийний дараа хэрэглэгчид ашиглуулж болно.Анхдагч мэдээлэлд боловсруулалт хийж, хэрэглэгчид ашиглуулахтай холбогдсон жүрмыг нууцын тухай хууль тогтоомжид нийцүүлэн Үндэсний статистикийн газрын дарга батална."

9/ Төслийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Статистикийн мэдээг удаа дараа тасалж, хожимдуулсан, санаатайгаар бууруу мэдээлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх замаар бизнесийн нэр хүндэд нөлөөлж болно."

2 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "мэдээллээр төлбөртэй үйлчилгээ явуулах," гэсний өмнө " статистикийн мэдээллийн арга зүйг боловсронгуй болгож, шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох болон" гэж, 18 дугаар зүйлийн гарчгийн "Яам," гэсний дараа "Монголбанк," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ "7 дугаар зүйл. Тооллого, судалгаа явуулах

1. Үндэсний статистикийн газар дараахь тооллого, судалгааг явуулна:

а/ хүн ам, орон сууцны улсын тооллогыг 10-аас илүүгүй жил тутам;

б/ салбар хоорондын тэнцэл, нөөц ашиглалтын хүснэгтийг 5 жил тутам;

в/ мал, тэжээвэр амьтдын тооллогыг жил тутам;

г/ ерхийн аж ахуйн орлого, зарлагын судалгааг улирал тутам;

д/ хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгааг 3 жил тутам;

е/ хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн түүвэр судалгааг 5 жил тутам;

ё/ хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам;

ж/ хүүхэд хөгжил судалгааг 4 жил тутам;

з/ аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам;

и/ хашаа, худаг, тэжээлийн тооллогыг 3 жил тутам;

к/ цаг ашиглалтын түүвэр судалгааг 4 жил тутам улирлаар.

2. Зайлшгүй шаардлагаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг өөрчлөх, энэ хуульд зааснаас өөр тооллого, судалгаа явуулах асуудлыг Засгийн газар, эсхүл Үндэсний статистикийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

3. Тооллого, судалгааны зардлыг Үндэсний статистикийн газрын тухайн жилийн төсөвт тусгана.

4. Үндэсний статистикийн газар нь тухайн жилд хийгдэх тооллого, түүвэр судалгааг Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тооллого явуулах хугацааны товыг Засгийн газар, түүвэр болон иж бүрэн судалгааныхыг Үндэсний статистикийн газар тогтооно."

2/ "11 дүгээр зүйл. Статистикийн байгууллагын тогтолцоо

1. Статистикийн байгууллага нь улс , бүс нутаг, аймаг, нийслэлийн эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны талаарх статистикийн мэдээллээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад адил тэгш үйлчилдэг төрийн байгууллага мөн.

2. Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг Үндэсний статистикийн газар , аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ. Суманд

статистикийн үйл ажиллагаагаа сумын Засаг даргын Тамгын газрын үг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэнэ.

3. Үндэсний статистикийн газар, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар,хэлтсийн болон сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан нь төрийн захиргааны албан тушаалтан байна.

4. Үндэсний статистикийн газар, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагаагаа улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төсөв нь статистикийн үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. Статистикийн үйл ажиллагаагаа сум, баг, хороонд эрхлэн явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

5. Үндэсний статистикийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.

6.Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгуллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагаагаа эрхэлнэ."

3/ 3 дугаар зүйлийн 5,8 дахь заалт:

"5/ "албан ёсны статистикийн мэдээлэл" гэж Үндэсний статистикийн газраас батална аргачлал, үзүүлэлтээр энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны холбогдолтой үзүүлэлтээр гаргасан мэдээлэл, статистикийн үйл ажиллагааны хөтелберт тусгагдсан мэдээллийг;

8/ "захиргааны статистикийн мэдээлэл" гэж Үндэсний статистикийн газраас батална, эвшөөрсөн аргачлал, үзүүлэлтээр яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгуллага, нутгийн захиргааны байгууллагын хэрэгцээнд зориулж цуглуулсан мэдээллийг "

4/ 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 11 дэх заалт:

"11/ салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавхи , техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх;"

5/ 14 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг:

"1. Үндэсний статистикийн газарт албан ёсны статистикийн үйл ажиллагаагаа явуулахад туслах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүргэтэй Улсын Их Хурал, Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага болон хэрэглэгчийн төлөөлөлтэй зөвлөл ажиллана.

3. Зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн 3 гишүүнийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, 3 гишүүнийг Засгийн газар санал болгож, Улсын Их Хурал томилно. Үндэсний статистикийн газрын зөвлөлийн гишүүд нь орон тооны бус байна.

4 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "албан ёсны бус" гэснийг "захиргааны" гэж; 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 17 дахь заалтын " аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга, дүүргийн тасгийн дарга" гэснийг " аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн дарга"гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, дүүргийн статистикийн тасгийн даргыг" гэснийг " аймаг , нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн даргыг" гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "Улсын Их Хурлын чуулган, Байгын хороо, Засгийн газрын хуралдаанд өөрийн байр суурийг илэрхийлэх" гэснийг "Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцох " гэж , 19 дугээр зүйлийн 3 дахь заалтын " албан ёсны статистикийн төвлөрсөн бус мэдээлэл " гэснийг" захиргааны статистик мэдээлэл" гэж, мөн зүйлийн 4 дэх заалтын " статистикийн төвлөрсөн бус мэдээллийн " гэснийг " захиргааны статистик мэдээллийн " гэж, 20 дугаар зүйлийн 3 дахь заалтын " албан ёсны статистик мэдээллийг" гэснийг " захиргааны статистик мэдээллийг" гэж , 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "2" гэсэн заалтын дугаарыг "3" гэж, мөн хэсгийн " 3-18"хүртэлх заалтын дугаарыг "5-20" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "н" гэсэн дэд заалтын ", бүтээмж" гэснийг, 9 дүгээр зүйлийн 2 дахь заалтын " аргачлалаар" гэсний дараах " албан ёсны" гэснийг, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтын "зөвшөөрөх" гэснийг, 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтын "төвлөрсөн" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Статистикийн тухай хуулийн 8 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 6, 7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 18 | Улаанбаатар хот

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх, орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийн төрийн өмчид хүлээн авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор батлуулсугай.

2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн 2 дугаар хавсралтад заасан эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1.Архангай аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Эрдэнэбулган	Өрхийн эмнэлгийн барилга	22 242.80
2	Эрдэнэбулган	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, мотоцикл, компьютер, багаж	93 985.90
3	Тариат	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Эрдэнэмандал	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
5	Чулуут	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
6	Ихтамир	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
	ДҮН		**152 023.70**

2. Баян-Өлгий аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Өлгий	Өрхийн эмнэлгийн барилга	22 500.00
2	Өлгий	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн компьютер оношлогоо эмчилгээний, сургалтын багаж, тоног төхөөрөмж, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	27 385.50
3	Ногооннуур	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	16 307.50
4	Бугат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Булган	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Дэлүүн	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**70 963.00**

3. Баянхонгор аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баянхонгор	Өрхийн эмнэлгийн барилга	24 301.30
2	Баянхонгор	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж техөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	79 252.50
3	Баацагаан	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Бөмбөгөр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Жинст	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
6	Баянцагаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Галуут	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		126 221.30

4. Булган аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Булган	Өрхийн эмнэлгийн барилга	19 907.90
2	Булган	Өрхийн эмнэлгийн болон аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж, сургалтын тоног төхөөрөмж, мотоцикл, компьютер, эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	21 616.80
3	Хутаг-Өндөр	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	16 307.50
4	Тэшиг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Гурванбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		61 012.20

5. Говь-Алтай аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Цээл	Малын үржлийн албаны Цээл суман дахь тэжээлийн агуулахын чулуун барилга	1 200.00
2	Есөнбулаг	Өрхийн эмнэлгийн барилга	23 106.20
3	Есөнбулаг	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	25 296.10
4	Төгрөг	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
5	Алтай	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Хөхморьт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Бугат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		69 089.80

6. Говьсүмбэр аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сүмбэр	Өрхийн эмнэлгийн барилга	20 585.50
2	Сүмбэр	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	22 826.80
	ДҮН		43 412.30

7. Дархан-Уул аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Дархан	Өрхийн эмнэлгийн барилга	22 453.00
2	Дархан	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	156 713.00
3	Шарын гол	Өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, өрхийн эмчийн мотоцикл, компьютер	7 566.20
	ДҮН		186 732.20

8. Дундговь аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Мандалговь	Өрхийн эмнэлгийн барилга	21 435.00
2	Мандалговь	Өрхийн эмнэлгийн болон оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	71 893.80
3	Эрдэнэдалай	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, хувилагч машин, багийн эмчийн мотоцикл	16 307.50
4	Луус	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Өлзийт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**112 816.30**

9. Дорноговь аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сайншанд	Өрхийн эмнэлгийн барилга	21 811.20
2	Сайншанд	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин	227 563.70
3	Эрдэнэ	Сумын эмнэлгийн барилга	76 998.90
4	Эрдэнэ	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
5	Хөвсгөл	Сумын эмнэлгийн барилга	79 360.30
6	Хөвсгөл	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
7	Сайхандулаан	Сумын эмнэлгийн барилга	68 637.00
8	Сайхандулаан	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
9	Дэлгэрэх	Сумын эмнэлгийн барилга	73 717.40
10	Дэлгэрэх	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
11	Замын үүд	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	51 764.10
12	Айраг	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
13	Мандах	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
14	Хатанбулаг	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
15	Алтанширээ	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	10 101.50
16	Улаанбадрах	Багийн эмчийн мотоцикл	3 180.00

17	Их хэт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
18	Өргөн	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
19	Даланжаргалан	Багийн эмчийн мотоцикл	3 180.00
	ДҮН		**693 384.60**

10. Дорнод аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн барилга	23 800.00
2	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зурхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин, биохимийн болон иммунологийн анализатор	35 169.60
3	Дашбалбар	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Цагаан Овоо	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Чойбалсан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**76 867.10**

11. Завхан аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Асгат	Журамт компани	2 953.20
2	Улиастай	Өрхийн эмнэлгийн барилга	25 500.00
3	Улиастай	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зурхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	108 664.50
4	Тосонцэнгэл	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер, багийн эмийн мотоцикл	23 666.20
5	Яруу	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Идэр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Эрдэнэхайрхан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**165 553.90**

12. Орхон аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баян Өндөр	Өрхийн эмнэлгийн барилга	19 484.00
2	Баян Өндөр	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	176 699.90
	ДҮН		**196 183.90**

13. Өвөрхангай аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Арвайхээр	Өрхийн эмнэлгийн барилга	23 741.30
2	Арвайхээр	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин, биохимийн болон иммунологийн анализатор	23 924.10
3	Хархорин	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер, багийн эмчийн мотоцикл	23 666.20
4	Хужирт	Өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, компьютер, багийн эмчийн мотоцикл	5 269.40
5	Өлзийт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**78 191.00**

14. Өмнөговь аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Даланзадгад	Өрхийн эмнэлгийн барилга	27 881.80
2	Даланзадгад	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	71 893.80
3	Ноён	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
4	Сэврэй	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Мандал Овоо	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Цогтцэций	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**119 263.10**

15. Сэлэнгэ аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн барилга	21 215.80
2	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	287 712.50
3	Мандал	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер	29 434.90
4	Сайхан	Өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, компьютер	7 358.70
5	Алтанбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Шаамар	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
7	Хүдэр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
8	Жавхлант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**352 081.90**

16. Сүхбаатар аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баруун-Урт	Аймгийн шүүхийн хуучин барилга	483.40
2	Баруун Урт	Өрхийн эмнэлгийн барилга	23 420.00
3	Баруун Урт	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	71 893.80
4	Онгон	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
5	Асгат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Баяндэлгэр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**113 694.70**

17. Төв аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Зуунмод	Өрхийн эмнэлгийн барилга	19 800.00
2	Зуунмод	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	88 270.30

3	Алтанбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
4	Баянцагаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Дэлгэрхаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**112 840.30**

18. Увс аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Улаангом	Өрхийн эмнэлгийн барилга	24 518.70
2	Улаангом	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	119 243.00
3	Баруунтуруун	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.50
	ДҮН		**158 479.20**

19. Ховд аймаг
А. Цогцолбороор шилжүүлэх эд хөрөнгө

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Жаргалант	Тэжээлийн фондын төв ТӨҮГ	68 010.70
	ДҮН		**68 010.70**

Б. Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Жаргалант	Гаалийн газрын барилгын цогцолбор, дагалдах байгууламж, хөдлөх үндсэн хөрөнгө	156 800.00
2	Жаргалант	Өрхийн эмнэлгийн барилга	25 627.50
3	Жаргалант	Өрхийн эмнэлгийн мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин	46 359.00
4	Булган	Сумын эмнэлгийн барилга	165 428.80
5	Булган	Сум дундын болон өрхийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, компьютер, багийн эмчийн мотоцикл	57 033.50
6	Манхан	Сумын эмнэлгийн барилга	85 149.20
7	Манхан	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	53 354.10
8	Алтай	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50

9	Дарви	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
10	Дөргөн	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
11	Мөст	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	11 691.50
12	Мөнххайрхан	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
13	Цэцэг	Сумын эмнэлгийн тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 511.50
14	Үенч	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
15	Зэрэг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
16	Дуут	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
17	Ховд	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
18	Мянгад	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
19	Чандмань	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
20	Эрдэнэбүрэн	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
21	Буянт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
22	Бугат	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
23	Рашаант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	Дүн		**659 901.10**
	Ховд аймгийн дүн		**727 911.80**

20. Хөвсгөл аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Мөрөн	Стандартчилал хэмжил зүйн төвийн конторын барилга	39 855.00
2	Мөрөн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга	1 023 824.00
3	Мөрөн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин, аймгийн Эрүүл мэндийн газрын нөөцөд мотоцикл	440 416.70
4	Шинэ-Идэр	Сумын эмнэлгийн барилга	64 414.00
5	Шинэ-Идэр	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	52 863.60
6	Улаан-Уул	Сумын эмнэлгийн барилга	171 045.50

7	Улаан-Уул	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	52 863.60
8	Ринчинлхүмбэ	Сумын эмнэлгийн барилга	82 649.90
9	Ринчинлхүмбэ	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
10	Алаг-Эрдэнэ /Хатгал тосгон/	Сумын эмнэлгийн барилга	65 767.70
11	Алаг-Эрдэнэ /Хатгал тосгон/	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
12	Арбулаг	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
13	Тариалан	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
14	Цагаан-Уул	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
15	Цагаан-Үүр	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж, багийн эмчийн мотоцикл	8 348.00
16	Алаг-Эрдэнэ	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
17	Баянзүрх	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
18	Бүрэнтогтох	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
19	Галт	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
20	Жаргалант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
21	Их-Уул	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
22	Тосонцэнгэл	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
23	Төмөрбулаг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
24	Чандмань-Өндөр	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
25	Цагааннуур	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
26	Цэцэрлэг	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
27	Рашаант	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
28	Ханх	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
29	Эрдэнэбулган	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
30	Түнэл	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**2 067 638.00**

21. Хэнтий аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн барилга	23 000.00
2	Хэрлэн	Өрхийн эмнэлгийн болон аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний багаж төхөөрөмж, мотоцикл, компьютер, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, сургалтын тоног төхөөрөмж	73 483.80

3	Бэрх тосгон	Сум дундын эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмж	14 717.60
4	Дэлгэрхаан	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
5	Цэнхэрмандал	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
6	Баян-Овоо	Багийн эмчийн мотоцикл	1 590.00
	ДҮН		**115 971.40**
	АЙМГИЙН НИЙТ ДҮН		**5 868 342.40**

22 .Улаанбаатар хот
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Дүүргийн нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баянзүрх	II хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 577.90
2	Баянзүрх	V хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 529.00
3	Баянзүрх	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 257.30
4	Баянзүрх	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 759.00
5	Баянзүрх	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 579.00
6	Баянзүрх	XIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 347.30
7	Баянзүрх	XIV хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 879.00
8	Баянзүрх	XVII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 879.00
9	Баянзүрх	XIX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 759.00
10	Баянзүрх	XX хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 364.80
11	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж / 22 иж бүрдэл/	50 530.70
12	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн мотоцикл /4ш/	6 360.00
13	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн компьютер / 22 иж бүрдэл/	30 415.00
14	Баянзүрх	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /3 ш/	8 364.30
15	Баянзүрх	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
16	Баянзүрх	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
17	Сүхбаатар	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 000.00
18	Сүхбаатар	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	19 800.00
19	Сүхбаатар	XVI хорооны өрхийн эмнэлгийн барилга	8 300.00
20	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /18 иж бүрдэл/	41 343.30
21	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн мотоцикл /2ш/	3 180.00
22	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн компьютер / 17 иж бүрдэл/	23 502.50
23	Сүхбаатар	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /3 ш/	8 364.30
24	Сүхбаатар	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
25	Сүхбаатар	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00

26	Сүхбаатар	Нийслэлийн түргэн тусламжийн төвд автомашин /6ш/	102 163.20
27	Хан-Уул	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 383.80
28	Хан-Уул	V хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 424.50
29	Хан-Уул	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 943.40
30	Хан-Уул	VII хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 868.70
31	Хан-Уул	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 933.80
32	Хан-Уул	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 996.50
33	Хан-Уул	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
34	Хан-Уул	XI хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 996.50
35	Хан-Уул	XII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 899.00
36	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /12 иж бүрдэл/	27 562.20
37	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн мотоцикл /2ш/	3 180.00
38	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн компьютер /12 иж бүрдэл/	16 590.00
39	Хан-Уул	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /2ш/	5 576.20
40	Хан-Уул	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.00
41	Хан-Уул	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмж /1 иж бүрдэл/	30 249.60
42	Хан-Уул	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
43	Чингэлтэй	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 892.80
44	Чингэлтэй	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
45	Чингэлтэй	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 892.80
46	Чингэлтэй	XII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 825.60
47	Чингэлтэй	XIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 834.10
48	Чингэлтэй	XIV хорооны өрхийн эмнэлгийн барилга	21 895.50
49	Чингэлтэй	XVII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 367.30
50	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /17 иж бүрдэл/	39 046.50
51	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
52	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн компьютер/17 иж бүрдэл/	23 502.0
53	Чингэлтэй	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /3 ш/	8 364.30
54	Чингэлтэй	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
55	Чингэлтэй	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
56	Чингэлтэй	Нийслэлийн эрүүл мэндийн газарт сургалтын тоног төхөөрөмж, тавилга, техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	12 317.90
57	Чингэлтэй	Нийслэлийн эрүүл мэндийн газарт микроавтобус	10 675.10

58	Баянгол	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 378.30
59	Баянгол	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 558.50
60	Баянгол	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 558.50
61	Баянгол	XI хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 378.30
62	Баянгол	XVII хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 068.10
63	Баянгол	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /21 иж бүрдэл/	48 233.90
64	Баянгол	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
65	Баянгол	Өрхийн эмнэлгийн компьютер /21 иж бүрдэл/	29 032.50
66	Баянгол	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 2ш	5 576.20
67	Баянгол	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
68	Баянгол	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
69	Сонгинохайрхан	I хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
70	Сонгинохайрхан	II хорооны өрхийн эмнэлгийн барилга	19 519.80
71	Сонгинохайрхан	III хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 348.00
72	Сонгинохайрхан	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	23 276.00
73	Сонгинохайрхан	V хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 546.90
74	Сонгинохайрхан	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 990.30
75	Сонгинохайрхан	VI хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 990.30
76	Сонгинохайрхан	VII хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 433.60
77	Сонгинохайрхан	VIII хорооны өрхийн эмнэлгийн барилга	20 433.60
78	Сонгинохайрхан	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 991.60
79	Сонгинохайрхан	IX хорооны өрхийн эмнэлгийн барилга	22 991.60
80	Сонгинохайрхан	X хорооны өрхийн эмнэлгийн барилга	18 906.60
81	Сонгинохайрхан	XI хорооны өрхийн эмнэлгийн барилга	17 957.40
82	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /22 иж бүрдэл/	50 530.70
83	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
84	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн компьютер /22 иж бүрдэл/	30 415.00
85	Сонгинохайрхан	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /2ш/	5 576.20
86	Сонгинохайрхан	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин	17 027.20
87	Сонгинохайрхан	Дүүргийн нэгдсэн эмнэлэгт шүдний эмчилгээний машин	12 826.70
88	Сонгинохайрхан	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
89	Налайх	III хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 492.90
90	Налайх	IV хорооны өрхийн эмнэлгийн барилга	24 491.90
91	Налайх	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /4 иж бүрдэл/	9 187.40

92	Налайх	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
93	Налайх	Өрхийн эмнэлгийн компьютер /4 иж бүрдэл/	5 530.00
94	Налайх	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	2 788.10
95	Налайх	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
96	Багануур	Өрхийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний багаж төхөөрөмж /4 иж бүрдэл/	9 187.40
97	Багануур	Өрхийн эмнэлгийн мотоцикл	1 590.00
98	Багануур	Өрхийн эмнэлгийн компьютер /4 иж бүрдэл/	5 530.00
99	Багануур	Өрхийн эмнэлгийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	2 788.10
100	Багануур	Дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд сургалтын техник хэрэгсэл /1 иж бүрдэл/	1 372.00
	Нийслэлийн дүн		**1 877 717.50**
	НИЙТ ДҮН		**7 746 059.90**

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 18 дугаар тогтоолын 2-р хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ ҮНДЭСЛЭН ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭН АВАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1. Архангай аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Өндөр-Улаан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 3,9 км/	9 750.00
2	Тариат	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 5,3 км/	13 250.00
3	Жаргалант	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 3,2 км/	8 000.00
4	Цэцэрлэг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 3,2 км/	8 000.00
	Дүн		**39 000.00**

2. Булган аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Тэшиг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2,3 км/	5 750.00
2	Бугат	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 1,5 км/	3 750.00
3	Сэлэнгэ	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 8,5 км/	21 250.00
4	Сайхан /Сайхан-Овоо тосгон/	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 6,7 км/	16 750.00
	Дүн		**47 500.00**

3. Дорноговь

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Алтанширээ	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-4,1 км/	10 250.00
2	Айраг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3,5 км/, /10 кВ-1,5 км/ дэд станц-1	18 325.30
3	Замын-Үүд	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4 кВ-5,85 км/, дэд станц, тоног төхөөрөмж-1 ком	19 689.20
	Дүн		**48 264.50**

4. Дорнод аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Чойбалсан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4 кВ- 6 км/, /10кВ-2,3 км/, 35/10 дэд станц, подстанц-4	27 764.80
2	Баянтүмэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 1,9 км/, /10кВ-2,8 км/, дэд станц-1	25 105.60
3	Булган	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-5 км; 10кВ-1,2 км/, дэд станц 35/10 -1	20 849.40
	Дүн		**73 719.80**

5. Дундговь аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Говь-Угтаал	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-10 км/	25 000.00
2	Гурвансайхан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-16,2 км/	40 500.00
3	Хулд	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-6,8 км/	17 000.00
4	Луус	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8 км/	20 000.00
5	Цагаандэлгэр	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8,5 км/	21 250.00
6	Дэрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8 км/	20 000.00
7	Дэлгэрцогт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-10,3 км/	25 750.00
8	Сайхан-Овоо	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-7 км/	17 500.00
9	Сайнцагаан /Тэвшийн говь тосгон/	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3 км/	7 500.00

10	Дэлгэрхангай	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-8,5 км/	21 250.00
11	Эрдэнэдалай	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-10,8 км/	27 000.00
	Дүн		**242 750.00**

6. Өвөрхангай аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Сант	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-1,6 км/	4 000.00
	Дүн		**4 000.00**

7. Өмнөговь аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баяндалай	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3,7 км/ /110 ш мод/	9 250.00
2	Хүрмэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 9 км/ /138 ш мод/	22 500.00
3	Булган	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2,8 км/	7 000.00
4	Ханхонгор	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-20,9 км/ /113 ш мод/	52 250.00
	Дүн		**91 000.00**

8. Сүхбаатар аймаг
Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баруун-Урт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө	119 000.00
2	Халзан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө	10 500.00
3	Асгат	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө	6 250.00
4	Сүхбаатар	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө	8 000.00
5	Түмэнцогт	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө	14 500.00
6	Уулбаян	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө	11 250.00
	Дүн		**169 500.00**

9. Сэлэнгэ аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Баруунбүрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2,9 км/	7 250.00
	Дүн		**7 250.00**

10. Төв аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сум, дүүргийн нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Дэлгэрхаан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3,6 км/	9000.00
2	Бүрэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-7 км/	17 500.00
	Дүн		**26 500.00**

11. Увс аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Наранбулаг	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-2 км/, /10квт-63 км/, тоног төхөөрөмж	377000.00
2	Өмнөговь	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-61,5 км/, /10 квт-5 км/, тоног төхөөрөмж	43722.8
3	Өлгий	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-18 км/, /10квт-3 км/, тоног төхөөрөмж	20500.0
4	Түргэн	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-3 км/, /10 квт-22,6 км, тоног төхөөрөмж	95500.0
5	Сагил	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-12 км/	3000.0
6	Давст	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам/0.4кВ-15,5 км/, /10 квт-5,2 км/, тоног төхөөрөмж	128000.0
7	Тариалан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-2 км/, /10 квт-5,2 км/, тоног төхөөрөмж	4500.0
	Дүн		**672 222.80**

12. Хөвсгөл аймаг

Үл хөдлөх ба хөдлөх үндсэн хөрөнгө

№	Сумын нэр	Эд хөрөнгийн нэр	Нийт хөрөнгийн дүн /мян.төг/
1	Рашаант	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ-4,2км/	10 500.00
2	Тариалан	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /0.4кВ- 2,4 км/	11 430.00
3	Их-Уул	Нам хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам /04кВ- 1,6 км/	4 000.00
	Дүн		**25 930.00**
	НИЙТ ДҮН		**1 447 637.10**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

Төсвийн төлөвлөлтийн үе шатыг тогтоох тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төсвийн төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, хэлэлцэх, батлагдсан төсвийг төсвийн ерөнхийлэн захирагч нарт хуваарилан хүргүүлэхтэй холбогдсон төсвийн төлөвлөлтийн үе шат, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг хавсралт ёсоор батлсугай.

2. Энэхүү тогтоолд заасан төсвийн төлөвлөлтийн үе шатыг төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, төсвийн жил бүрийн болон дунд хугацааны төсөл, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд нь иж бүрэн, чанартай боловсруулан эрх бүхий холбогдох байгууллагуудад хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлэн захирагчид, төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2004 оны 73 дугаар тогтоолын хавсралт

ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

д/д	Үйл ажиллагааны үе шатууд	Хэрэгжүүлэх хугацаа
1	Дунд хугацаанд баримтлах төсөв, санхүүгийн үндсэн үзүүлэлтийн хязгаарыг төсвийн ерөнхийлэн захирагч нарт хүргүүлэх	Ш сарын 1-ний дотор
2	Төсвийн ерөнхийлэн захирагчдаас ирэх 3 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүнтэй уялдсан төсвийн төсөл, саналаа Санхүү, эдийн засгийн яаманд ирүүлэх	Ш сарын 20-ны дотор
3	Санхүү, эдийн засгийн яамнаас төсвийн ерөнхийлэн захирагч тус бүртэй үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, төсвийн талаар санал солилцох	IY сарын 10-ны дотор
4	Дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичгийн төсөл, холбогдох тооцоог эцэслэн боловсруулж Засгийн газарт хүргүүлэх	IY сарын 20-ны дотор
5	Дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичгийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах	IY сарын 30-ны дотор
6	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Y сарын 1-ний дотор
7	Улсын Их Хурлаас хэлэлцэн зөвшөөрсөн Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан үзүүлэлтийг холбогдох төсвийн ерөнхийлэн захирагчдад хүргүүлэх	YI сарын 10-ны дотор
8	Төсвийн байгууллагын менежерүүд дараа жилийн төсөв, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний саналаа төсвийн ерөнхийлэн захирагчдаа хүргүүлэх	YП сарын 1-ний дотор
9	Төсвийн ерөнхийлэн захирагчид дараагийн жилд зарцуулах төсвийн төсөл, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний саналыг Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэх	YШ сарын 15-ны дотор

10	Төсвийн ерөнхийлэн захирагчдаас ирүүлсэн төсвийн саналыг Санхүү, эдийн засгийн яамны холбогдох газар, хэлтсээс судлан үзэж төсвийн ерөнхийлэн захирагчтай зөвшилцөх	IX сарын 1-ний дотор
11	Төсвийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг эцэслэн боловсруулж Засгийн газарт хүргүүлэх	IX сарын 15-ны дотор
12	Ирэх оны төсвийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	IX сарын 30-ны дотор
13	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон улсын төсвийн төсөл, төсвийн ерөнхийлэн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	X сарын 1-ний дотор
14	Улсын Их Хурлаас батлагдсан төсвийг төсвийн ерөнхийлэн захирагч нарт дэлгэрэнгүй үзүүлэлтээр хүргүүлэх	XП сарын 10-ны дотор
15	Төсвийн ерөнхийлэн захирагчдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Ерөнхий менежерүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үр дүнгийн гэрээ байгуулах	XП сарын 25-ны дотор
16	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан аймаг, нийслэлийн төсвийг дэлгэрэнгүй үзүүлэлтээр Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэх	I сарын 15-ны дотор
17	Төсвийн ерөнхийлэн захирагчид тухайн жилийн төсвийн багцынхаа сар, улирлын санхүүжилтийн хуваарийг баталж Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлэх	I сарын 5-ны дотор
18	Санхүү, эдийн засгийн сайдын тушаалаар батлагдсан тухайн жилийн төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарийг төсвийн ерөнхийлэн захирагч нарт хүргүүлэх	I сарын 20-ны дотор

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр **Дугаар 74** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийг хавсралт ёсоор батлэсугай.

2. "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийг 2004 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 239 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2004 оны 74 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний нэгдсэн журам тогтоох, орших. Замын хөдөлгөөнтэй холбоотой бусад хэм хэмжээний актууд нь энэ дүрмийн заалт шаардлагууд дээр үндэслэгдсэн, түүнтэй зөрчилдөхгүй байвал зохино.

1.2. Механикжсан тээврийн хэрэгслийг дор дурдсанаар ангилна:

А - мотоцикль;

В - жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);

С - бүх жин нь 3500 кг-аас их ачааны автомашин (5000 кг-аас ихгүй даалтай чиргүүлтэй);

D - жолоочоос гадна 8-аас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй);

Е - "В", "D" ангиллын автомашин 750 кг-аас дээш бүх жинтэй чиргүүлтэй, "С" ангиллын автомашин 5000 кг-аас их даацтай чиргүүлтэй бүрэлдэхүүн;

Механизм - трактор, өөрөө явдаг машин механизм, тэдгээрийн чиргүүл буюу ажлын тоног төхөөрөмжтэй бүрэлдэхүүн.

1.3. "D" ангиллын тээврийн хэрэгслийг 21-ээс, бусад ангиллын тээврийн хэрэгслийг 18-аас дээш насны хүн жолоодно.

1.4. Энэ дүрэмд байгаа дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

"Аюултай ачаа" -тээвэрлэлтийн үед хүний амь бие, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл тарих, эд материалын хохирол учруулж болзошгүй элдэв бодис, түүгээр хийсэн эд зүйл, үйлдвэрийн хаягдал, аж ахуйн зориулалт бүхий бусад зүйл;

"Бодит жин" -тээврийн хэрэгслийн тухайн үеийн жин. Чирэгдэж явааа тээврийн хэрэгслийн жинг бодит жинд оролцуулан тооцно;

"Бүх жин"-тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон өөрийн болон ачаа, жолооч, зорчигчийн нийт эвсшөөрөгдөх дээд жин. Чиргүүл нь тухайн тээврийн хэрэгслийн бүтцэд хамаарагдах бол бүх жинг чирэгч, чиргүүл хоёрын бүх жингийн нийлбэрээр тооцно;

"Гарц" -ойролцоох зогсоол, шатахуун түгээгүүр, үйлдвэр, албан байгууллага, хашаа, хороолол зэрэг рүү орох, тэдгээрээс гарахад зориулагдсан зорчих хэсэг замтай огтлолцсон бэлчир;

"Гол зам" -чулзварт нийлсэн хучилттай болон шорооп замын хучилттай нь буюу энэ дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.1, 3.3.а,б,в, 5.1 тэмдэг (цаашид эвхэн тэмдэг, тэмдэглэлийн дугаарыг зааж бичнэ) бүхий зам;

"Гүйцэж түрүүлэх" -явж байгаа эгнээнээсээ гарч урдаа явааа нэг буюу хэд хэдэн тээврийн хэрэгслийг гүйцэх үйлдэл;

"Давуу эрх" -бусад замын хөдөлгөөнд оролцогчоос хеделгөөнөө урьтан хийх эрх;

"Ердийн хөсөг" -уналга, ачлагад ашиглаж байгаа мал, амьтан буюу түүнд хөлөсөн хэрэгсэл (хөсөг);

"Жолооч"-тээврийн хэрэгслийг жолоодож явааа хүн. Жолоодлогын дадлага хийлгэж явааа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж явааа хүнийг жолоочид хамааруулж ойлгоно;

"Зайлшгүй зогсолт" -жолооч, зорчигчийн биеийн байдал, тээж явааа ачаа, байгалийн үзэгдэл, зам дээр саад бий болсон зэргээс аюул учирч болзошгүй үед, түүнчлэн техникийн эвдрэлээс шалтгаалан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох үйлдэл;

"Зам" -тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газар. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, тариман зүлэг, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна;

"Зам тавьж өгөх" -замын хеделгөөнд оролцогчнь давуу эрх бүхий хеделгөөнд оролцогчийн хеделгөөний хурд болон чигийг өөрчлөхгүй нөлөөлөхгүйн тулд хеделгөөнөө эхлэхгүй буюу үргэлжлүүлэхгүй байх үйлдэл;

"Зам тээврийн осол" -зам дээр тээврийн хэрэгслийн хеделгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал;

"Замын хеделгөөн" -нийтийн хэрэгцээний зам дээрх явганаар болон тээврийн хэрэгслээр хүн ба ачаа шилжих үйл ажиллагаа;

"Замын хеделгөөнд оролцогч" -замаар явааа жолооч, явган зорчигч болон тээврийн хэрэгслээр зорчигч;

"Зорчих хэсэг" -тээврийн хэрэгслийн хеделгөөнд зориулсан замын хэсэг. Зам нь тусгаарлах зурвасаар заагласан хэд хэдэн зорчих хэсэгтэй байж болно;

"Зохицуулагч" -замын хеделгөөнийг зохицуулах, хяналт тавих эрх, үүрэг бүхий этгээд;

"Механикжсан тээврийн хэрэгсэл" -мопедоос бусад хеделгүүрээр тоноглогдсон бүх төрлийн тээврийн хэрэгсэл;

"Мопед" -50 см^3-ээс илүүгүй ажлын багтаамжтай хеделгүүр бүхий хоёр буюу гурван дугуйтай, техникийн хурд нь цагт 50 км-ээс ихгүй тээврийн хэрэгсэл;

"Мотоцикль" -шаахайтай буюу шаахайгүй хоёр дугуйтай механикжсан тээврийн хэрэгсэл. Энд өөрийн жин нь 400 кг-аас хэтрэхгүй гурав буюу дөрвөн дугуйтай механикжсан тээврийн хэрэгсэл мен хамаарна;

"Суурин газар" -5.3, 5.5 тэмдгээр тэмдэглэгдсэн, хүн ам төвлөрч суурьшсан нутаг дэвсгэр;

"Төмөр замын гарам" -төмөр замтай нэг түвшинд огтлолцсон замын бэлчир;

"Тусгаарлах зурвас" -зэргэлдээ зорчих хэсгүүдийг заагласан зориулагдаж хийгдсэн, зогсоол болон хеделгөөнд зориулагдаагүй замын хэсэг;

"Тууш зам" -5.1 тэмдгээр тэмдэглэгдсэн зам;

"Тээврийн хэрэгсэл" -хүн ба ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгсэл;

"Тээврийн хэрэгслээр зорчигч" -тээврийн хэрэгсэл дээр буюу түүний бүхээг дотор байгаа жолоочоос бусад хүн;

"Түр зогсолт" -тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 5 минутаас илүүгүй хугацаагаар зогсоох үйлдэл. Зорчигчдыг буулгах, суулгах буюу ачаа ачих, буулгахад үүнээс илүү хугацаагаар зогсоох үйлдэл нь түр зогсолтод хамаарна;

"Удаан зогсолт" -зорчигчдыг буулгах, суулгах буюу ачаа ачих, буулгахаас бусад тохиолдолд 5 минутаас дээш хугацаагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох үйлдэл;

"Унадаг дугуй" -унаж яваа хүний булчингийн хүчээр явдаг (тахир дутуу хүний тэргэнцрээс бусад) тээврийн хэрэгсэл;

"Уулзвар" -замууд нэг түвшинд огтлолцсон бэлчир (зорчих хэсгийн захын дугуйрч байгаа эхлэлийг түүний эсрэг тал руу шулуун холбож хязгаарлахад үүсэх талбай);

"Үзэгдэлт ханагалтгүй үе" -байгалийн үзэгдэл (манан, шуурга гэх мэт) болон замд тоос боссоноос буюу бүрэнхий үед 300 метрийн дотор зам харагдахгүй болсон үе;

"Харанхуй үе" -удшийн бүрийгээс үүрийн гэгээ орох хүртэлх хугацаа;

"Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх" -сургуулийн болон сургуулийн өмнөх насны хоёр буюу түүнээс олон хүүхдийг механикжсан тээврийн хэрэгслээр тусгайлан тээвэрлэх үйл ажиллагаа. Үүнд чиглэлийн тээврийн хэрэгслээр хүүхэд тээвэрлэхийг хамааруулахгүй;

"Цуваа" -ойрын гэрлээ асааж зохион байгуулагдсан цуварч явааг гурав буюу түүнээс олон механикжсан тээврийн хэрэгсэл. Цуваат тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглосон тээврийн хэрэгсэл хамгаалан явж болно;

"Чиглэлийн тээврийн хэрэгсэл" -тогтоосон буудал бүхий чиглэлийн дагуу хүн тээвэрлэх зориулалтаар нийтийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл (автобус, троллейбус, чиглэлийн такси);

"Чиргүүл" -механикжсан тээврийн хэрэгслээр чирэхэд зориулсан тээврийн хэрэгсэл;

"Эгнээ" -автомашины хөдөлгөөнийг нэг эгнээгээр явуулах боломж бүхий өргөнтэй, тэмдэглэлтэй буюу тэмдэглэлгүй зорчих хэсгийн дагуухь зурвас;

"Явган зорчигч" -замаар явган явааа (зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаагаас бусад) хүн. Жагсаалаар явах буюу тахир дутуу хүний тэргэнцэртэй, мөн тэрэг түрж, чарга чирч, мотоцикль, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар явааа хүмүүсийг явган зорчигчид хамаарулна;

"Явган хүний гарц" -явган зорчигч зам хөндлөн гарахад зориулсан, 5.16.а,б тэмдэг буюу 7.13.а,б тэмдэглэлтэй, зорчих хэсгийн хөндлөн зурвас. Тэмдэглэлгүй гарцын өргөнийг 5.16.а ба 5.16.б тэмдгүүдийн координдох зайгаар тодорхойлно;

"Явган хүний гарам" -зорчих хэсэгтэй нэг түвшинд огтлолцоогүй, 5.17.а,б,в,г тэмдэг тавигдсан, явган зорчигч зам хөндлөн гарахад зориулсан гарц;

"Явган хүний зам" -зорчих хэсэгтэй хиллэсэн буюу түүнээс таримал зүлэг, хөвөөгөөр зааглагдсан явган зорчигчийн хөдөлгөөнд зориулсан замын хэсэг.

1.5. Замын хөдөлгөөнд оролцогч нь бусдад аюул, хохирол учруулахгүй, хөдөлгөөнд саад, бэрхшээл, осолтой байдал бий болгохгүйгээр зорчино.

1.6. Замын тэмдэг, хөдөлгөөн зохицуулах зориулалт бүхий техник хэрэгслийг эвдэж гэмтээх, халхлах, байрлалыг дур мэдэн өөрчлөх, байрлуулах, авч хаях, хөдөлгөөнд саад болох зүйл зам дээр тавих, орхих, замын хучилтыг бохирдуулах, эвдэхийг хориглоно.

1.7. Замын хөдөлгөөнд оролцогч нь энэ дүрмийн өөрт хамаарах заалт, шаардлагыг мэддэг, сахин биелүүлдэг байвал зохино.

1.8. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2. Жолоочийн үүрэг

2.1. Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дараахь бичиг баримтыг биедээ авч явна:

а/ тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох Монгол Улсын үндэсний буюу олон улсын жолоодох эрхийн үнэмлэх;

б/ тээврийн хэрэгслийн гэрчилгээ;

в/ шаардлагатай тохиолдолд ачааны баримт бичиг.

2.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/ замын хөдөлгөөний тухай олон улсын Конвенцид нийцэх жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээтэй байх;

б/ тээврийн хэрэгсэл нь буртгэгдсэн улсынхаа ялгах тэмдэг, дугаартай байхаас гадна Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын алба (цаашид "Замын цагдаагийн алба" гэх)-нд тэмдэглүүлсэн байх.

2.3. Жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/хөдөлгөөнд оролцохын өмнө буюу замд явахдаа энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан зөрчилгүй байхаар тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангах;

Тээврийн хэрэгслийн ажлын тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос эвдэрсэн, харанхуй буюу үзэгдэлт ханагалтгүй үед зөв талын хол, ойрын болон ар талын өврын гэрлүүд асахгүй болсон, цас, бороо орж

байгаа үед жолоочийн талын шил арчуур ажиллахгүй бол хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно.

Хөдөлгөөнд оролцож явах үед тээврийн хэрэгсэлд дээр дурдсанаас бусад гэмтэл (энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан) тохиолдвол түүнийг засах, хэрэв бололцоогүй бол аюулгүй байдлыг хангаж аль ойр байгаа зогсоол (гараaш) буюу засварын газарт очно;

б/хамгаалах бүсээр тоноглогдсон автомашин жолоодохдоо хамгаалах бүс хэрэглэх, хамгаалах бүс хэрэглээгүй зорчигч тээвэрлэхгүй байх;

Тайлбар: Энэ заалт нь жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, үүргээ гүйцэтгэж явaа шуурхай албаны автомашины жолооч, зорчигчид хамаарахгүй.

в/мотоцикль жолоодохдоо хамгаалах малгай өмсөх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх;

г/соггууруулах үндаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн эсэхийг цагдаагийн ажилтны шаардлагаар зохих журмын дагуу шалгуулах;

д/зам тээврийн осолд нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, түүнийг эмнэлэгт яаралтай хүргэх;

е/зам тээврийн осол буюу техникийн саатлаар замд зогссон жолоочийн дохиогоор зогсож, бололцоотой тусламж үзүүлэх;

ж/замын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй элдэв саад гарсан тохиолдолд түүнийг арилгах, хэрэв бололцоогүй буюу зам тээврийн осол гарсан бол энэ тухай хөдөлгөөнд оролцогчдод урьдчилан анхааруулж аль ойр байгаа цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх;

з/гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих, гэмт этгээдийг мөрдөн хөөх, амь нас, эрүүл мэндэд ньноцтой хохирол учирч болох гэмтэлтэй хүмүүсийг эмнэлэгт, гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэхэд тээврийн хэрэгслээрээ үйлчлэх;

Тайлбар: Дээр дурдсан ажилд тээврийн хэрэгсэл хэрэглэсэн албан тушаалтан явсан зай, хугацаа, өөрийн овог нэр, албан тушаал, үнэмлэхний дугаарaа тэмдэглэж албан ёсны баримт бичиж өгнө. Үүнийг үндэслэн гарсан шууд зардлыг цаедаагийн байгууллага төлнө.

и/цагдаагийн алба хаагч, замын цагдаагийн туслах ажилтан, авто тээврийн буюу байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дохиогоор зогсож энэ дүрмийн 2.1-д заасан баримт бичгийг шалгуулах;

Тайлбар: Жолооч дээрх тохиолдолд шалгагчийн албаны үнэмлэхийг үзэж танилцах эрхтэй.

к/тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан (шар өнгийн дохио ажиллуулж яваагаас бусад) автомашин, мотоцикль буюу тэдгээрээр хамгаалуулж яваа тээврийн хэрэгсэл ойртон ирж яваа үед тухайн зорчих хэсэг (уулзвар, гарц) дээр зай тавьж өгөн зогсож өнгөрүүлэх.

2.4. Улаан, хөх, ногоон өнгийн тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулан хойшлуулшгүй албан үүрэг гүйцэтгэж яваа жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд бусад оролцогчоос давуу эрхтэй байх бөгөөд энэ дүрмийн 5 дугаар бүлэг (зохицуулагчийн дохионоос бусад), 6 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл, 7-14, 16, 17 дугаар бүлэг болон 1 дүгээр хавсралтын заалтыг мөрдөхгүй байж болно. Энэхүү эрх нь дээрх тээврийн хэрэгслээр хамгаалуулж яваа тээврийн хэрэгслийн жолоочид мөн адил хамаарна.

Харин шар өнгийн тусгай гэрэл дохио ажиллуулан зам, байгууламжийн засвар үйлчилгээний ажил гүйцэтгэж яваа жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд энэ дүрмийн 8.5-8.9, 17.1 болон 1 дүгээр хавсралтын тэмдэг (2.11-2.14, 2.20, 3.2, 3.4-3.6 тэмдгүүдээс бусад), тэмдэглэлийн заалтыг мөрдөхгүй байж болно. Шар өнгийн тусгай гэрэл дохио нь давуу эрх олгохгүй.

Тайлбар: Тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглосон автомашины жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг гуравaас дээш жил жолоодож дадлагажсан хүн байвал зохино.

2.5. Зам тээврийн осолд холбогдсон жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/тээврийн хэрэгслээ нэн даруй зогсоож, ослын дохионы гэрлээ асаах ба ослын зогсолтын тэмдгийг энэ дүрмийн 6.3-т заасан шаардлагын дагуу тавьж, тээврийн хэрэгсэл болон осолд холбогдол бүхий эд юмсыг байрнаас нь хөдөлгөхгүй байх;

б/зам тээврийн осолд нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, түргэн тусламж дуудах, хэрэв бололцоогүй бол үүнийг ойр байгаа эмнэлгийн байгууллагад аль тааралдсан тээврийн хэрэгслээр хүргүүлэх буюу зайлшгүй тохиолдолд өөрийн жолоодож яваа тээврийн хэрэгслээр хүргэж, эмнэлгийн ажилтанд өөрийн овог нэр, тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, гэрчилгээг үзүүлж тэмдэглүүлээд уг газартаа буцаж ирэх;

в/зам тээврийн ослын тухай цагдаагийн байгууллага (ажилтан)-д мэдэгдэж, түүнийг

үзсэн хүмүүсийн овог нэр, хаягийг мэдэж аваад осолд холбогдол бүхий эд мөрийн баримтын зүйлийг хамгаалан цагдаагийн байгууллагын ажилтанг иртэл хүлээх;

г/осолд холбогдсон тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаасны улмаас зорчих хэсгийг чөлөөлөх мөн осолд нэрвэгдсэн хүнийг эмнэлгийн байгууллагад уг тээврийн хэрэгслээр хүргэх зайлшгүй тохиолдолд хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан осолд холбогдол бүхий эд мөрийн баримт, тухайн тээврийн хэрэгслийн уг мөрийн байрлалыг тодорхой тэмдэглэсний дараа байрнаас нь хөдөлгөж болно;

д шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох ур чадвар, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгээ цагдаагийн албаны эрх бүхий албан тушаалтны шаардлагаар шалгуулах.

2.6. Хэрэв зам тээврийн ослын улмаас хүний амь бие, эрүүл мэнд хохироогүй бол осолд холбогдсон жолооч нар өөр хоорондоо зөвшилцөн, ослын бүдүүвч зургийг үйлдэж гарын үсэг зураад, аль ойр байгаа Замын цагдаагийн албаа (цагдаагийн байгууллага)-д бүртгүүлж болно.

2.7. Жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/соргууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох;

б/тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) буюу түүнчлэн соргууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан хүнд жолоогоо шилжүүлэх;

в/зам тээврийн ослын дараа шинжилгээ авах, эсвэл шаардлагагүй гэж эрх бүхий этгээд шийдвэр гаргах хүртэл соргууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх;

г/гарны оролцоогүйгээр ашиглах боломжгүй телефон утсыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед хэрэглэх;

д/тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио дур мэдэн тавих;

е/тээврийн хэрэгслээр зорчих хэсгийн хашлага давах, явган хүний зам буюу хөвөөгөөр явах, батлагдсан замаас гарч шинэ зам гаргах, байгаль орчин, газрын хөрс, хадлан, тариалангийн талбай, ой модыг гэмтээх, гол мөрөн, нуур, булаг, хиймэл усан байгууламжийг бохирдуулах;

ж/зам хөндлөн буюу гүүрээр тууварлан гаргаж байгаа мал, ердийн хөсгийг үргэлж;

з/цувраанд явах тээврийн хэрэгслүүдийн буюу жагсаалаар явах хүмүүсийн дундуур нэвтрэн гарах, тэдний хооронд байр эзлэх.

3. Явган зорчигчийн үүрэг

3.1. Явган зорчигч нь явган хүний замаар, иймэрхүү зам байхгүй бол зорчих хэсгийн хажуугийн хөвөөгөөр явна.

Явган хүний зам, хөвөө байхгүй буюу түүгээр явах боломжгүй тохиолдолд явган зорчигч нь унадаг дугуйн зам эсвэл зорчих хэсгийн захаар (тусгаарлах зурвастай) замд зорчих хэсгийн гадна талын захаар) явна. Түүнчлэн тэрэг түрсэн, чарга чирсэн, овор ихтэй ачаа барьсан буюу жагсаалаар явааг, мөн тахир дутуу хүний тэргэнцэртэй хүмүүс явган хүний зам, хөвөөгөөр явахад бусад явган зорчигчдод саад болохоор байвал зорчих хэсгийн захаар явж болно.

Суурин газрын гаднахь замд явган зорчигч зорчих хэсгээр явах тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чигийн эсрэг явна. Харин тээврийн хэрэгсэл (мотоцикль, мопед, унадаг дугуй гэх мэт) түрсэн хүн хөдөлгөөний чигийн дагуу гэрэлтүүлэх хэрэгсэл болон гэрэл ойлгуурыг халхлахгүйгээр явна.

3.2. Жагсаалаар явааг хүмүүс зорчих хэсгээр явах тохиолдолд дөрвөөс илүүгүйгээр зэрэгцэж хөдөлгөөний чигийн дагуу баруун гар талаар явна. Жагсаалын эүүн гар талын захын үед болон ард өдрийн цагт улаан дарцаг, харанхуй буюу үзэгдэлт ханган гэрэл ойлгуур) барьсан хүн хамгаалж явна.

3.3. Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглох бөгөөд харгалзаж яваа хүн хүүхдийг хөтөлж (тэвэрч) явна.

Хүүхдийн жагсаалыг эвхэн явган хүний замаар, явган хүний зам байхгүй бол зорчих хэсгийн хажуугийн хөвөөгөөр хоёроос илүүгүйгээр зэрэгцүүлж эвхэн өдрийн цагаар явуулахыг эвшөөрөх бөгөөд урд болон ард нь насанд хүрсэн хүн харгалзаж явна.

3.4. Явган зорчигч нь явган хүний гарц буюу гарамаар зам хөндлөн гарна. Хэрэв үзэгдэх хүрээнд явган хүний гарц ба гарам байхгүй бол замын дагуу хоёр тийш сайн харагдах саадгүй хэсгээр, ойртон ирж яваа тээврийн хэрэгслийг өнгөрүүлэн эгц хөндлөн гарна.

3.5. Хөдөлгөөн зохицуулж байгаа үед зам хөндлөн гарахдаа явган зорчигчид зориулсан гэрлэн дохио (иймэрхүү гэрлэн дохио байхгүй бол зэрэгцээ хөдөлгөөний тээврийн хэрэгсэлд зориулсан гэрлэн дохио) буюу зохицуулагчийн

зөвшөөрсөн дохиогоор зорчих хэсэгт орно. Хэрэв зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй байхад дохио өөрчлөгдвөл энэ дүрмийн 5.2-т заасныг баримтална.

3.6. Зам дээр үзэгдэлт халхалсан саад, тээврийн хэрэгсэл зогсож байх үед тэр хэсгээр зам хөндлөн гарахдаа тээврийн хэрэгсэл ойртон ирж байгаа эсэхийг магадлан мэдсэн байвал зохино.

3.7. Замын аль ч хэсэгт тусгай дуут болон гэрэл дохио (шар гэрэл дохионоос бусад) ажиллуулсан тээврийн хэрэгслийг урьдчилан енгөрүүлнэ.

3.8. Чиглэлийн тээврийн хэрэгслээр зорчих хүмүүс зориулсан талбай дээр, ийм талбай байхгүй бол зорчих хэсгийн хашлаганы гадна талд хүлээх бөгөөд тээврийн хэрэгслийг бүрэн гүйцэд зогссон үед зорчих хэсэг рүү орохыг зөвшөөрнө. Тээврийн хэрэгслээс буусны дараа зорчих хэсгийг нэн даруй чөлөөлнө.

3.9. Явган зорчигчид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/явган хүний гарцтай ба гарамтай (үзэгдэх хүрээнд) хэсгийн гарцгүй, гарамгүй хэсгээр зам хөндлөн гарах;

б/ашуглүй байдлыг хангахаас бусад шалтгаанаар зорчих хэсэг дээр зогсох, саатах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд санаатайгаар саад хийх;

в/ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур гэнэт гүйх;

г/ өөрийгөө хянаж, жолоодох чадваргүй үедээ зорчих хэсгээр явах.

4. Тээврийн хэрэгслээр зорчигчийн үүрэг

4.1. Тээврийн хэрэгслээр зорчигч дараахь үүргийг хүлээнэ:

а/хамгаалах бүсээр тоноглогдсон автомашинаар зорчихдоо хамгаалах бүс хэрэглэх, мотоциклоор зорчихдоо хамгаалах малгай өмсех;

б/тээврийн хэрэгслийг бүрэн гүйцэд зогссоны дараа явган хүний зам (эсвэл хөвөө) тал руу буюу ар тал руу бууж тэр талаас сууна. Хэрэв ийм боломжгүй бол ашуглүй байдлыг хангаж, бүсдын хөдөлгөөнд саад хийхгүйгээр зорчих хэсэг тал руу бууж, тэр талаас суухыг зөвшөөрнө.

4.2. Тээврийн хэрэгслээр зорчигчид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/хөдөлгөөний үед тээврийн хэрэгслийн хүн тээхэд зориулаагүй хэсэг дээр буюу ачааны автомашины тэвшний хашлаганаас дээш гарсан ачаан дээр байрлаж явах, тэвшин дээр зогсох;

б/ цонхоор биеэ болон бусад зүйл гаргах;

в/хөдөлгөөний үед жолоочийн анхаарлыг сарниулах, түүний үйлдэлд саад болох;

г/тээврийн хэрэгслийн явдал дунд хаалга нээх;

д/бусад хөдөлгөөнд оролцогчдод саад болохоор байвал зогсож байгаа тээврийн хэрэгслийн хаалгыг нээх.

5. Замын хөдөлгөөн зохицуулах дохио

5.1. Хориглосон дохиогоор жолооч "Зогс-шугам" тэмдэглэл буюу 5.29 тэмдгийн өмнө зогсох бөгөөд хэрэв тийм тэмдэг, тэмдэглэл байхгүй бол тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд саад болохгүйгээр уулзвар буюу явган хүний гарцын өмнө зогсоно.

5.2. Энэ дүрмийн 5.1-д заасан зогсох газрыг зөвшөөрсөн дохиогоор нэвтрэн орсон жолооч уг дохио өөрчлөгдвөл аюулгүй байдлыг хангаж, явж байгаа чигтээ хөдөлгөөнөө үргэлжүүлнэ. Харин уулзвар дээр жолоочийн явах чигийн өмнө "Зогс-шугам" тэмдэглэл буюу 5.29 тэмдэг бүхий гэрлэн дохио байвал түүнийг удирдлага болгоно.

Зөвшөөрсөн дохиогор явган хүний гарц руу орсон явган зорчигч дохио өөрчлөгдвөл аюулгүйн зурвас дээр зогсож дараагийн зөвшөөрөх дохиог хүлээх ба хэрэв аюулгүйн зурвасыг енгөрсөн, эсвэл тэр нь байхгүй бол зорчих хэсгийг нэвтрэн гарахыг зөвшөөрнө.

Тайлбар: Дээрх тохиолдолд явган зорчигч аюулгүй байдлыг хангах үүднээс хөдөлгөөний ээрэг урсгалын заагт дээр зогсож зөвшөөрөх дохиог хүлээж болно.

5.3. Зохицуулагчийн дохиогор хөдөлгөөн зохицуулж байгаа уулзварт гэрэл дохио болон дарааллын тэмдгийн заалтыг, гэрлэн дохиогоор зохицуулж байгаа бол дарааллын тэмдгийн заалтыг мөрдөхгүй.

Гэрлэн дохио

5.4. Замын хөдөлгөөн зохицуулахад улаан, шар, ногоон өнгийн гэрэл бүхий босоо буюу хэвтээ байрлалтай дохио хэрэглэнэ. Босоо байрлалтай дохионы гэрэл нь улаан, шар, ногоон өнгийн дараалаар дээрээс доош, хэвтээ байрлалтай дохионы гэрэл нь мөн дараалаар зүүн гар талаас баруун гар тийш байрлана.

Явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулахад явган хүний дүрс бүхий дээд талдаа улаан, доод талдаа ногоон өнгийн гэрэлтэй дохио хэрэглэнэ.

5.5. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио нь ногоон сум бүхий нэг буюу хоёр нэмэгдэл дохиотой, мөн ногоон гэрэл нь чиг заасан сумтай байж болно.

5.6. Гэрэл дохио нь дор дурдсан утгатай байна:

а/ногоон гэрэл дохио нь хөдөлгөөнийг зөвшөөрнө. Ногоон гэрэл анивчих нь түүний

зөвшөөрсөн утгыг өөрчлөхгүй бөгөөд хориглох гэрэл асах гэж байгаа анхааруулна;
б/шар гэрэл дохио нь гэрэл дохио солигдох гэж буйг анхааруулах бөгөөд энэ дүрмийн 5.2-т зааснаас бусад тохиолдолд хөдөлгөөнийг хориглоно;
в/анивчсан шар гэрэл дохио нь хөдөлгөөнийг зөвшөөрөх бөгөөд тухайн уулзвар буюу явган хүний гарц зохицуулагчгүй болсныг мэдээлж болгоомжтой явахыг анхааруулна;
г/улаан гэрэл дохио буюу түүний анивчих нь хөдөлгөөнийг хориглоно. Улаан гэрэл дохиотой хамт ассан шар гэрэл дохио нь хориглосон утгыг өөрчлөхгүй бөгөөд ногоон гэрэл дохио асах гэж байгааг анхааруулна.

5.7. Нэмэгдэл гэрэл дохио нь зөвхөн сум зассан чигийн хөдөлгөөнийг зохицуулна. Зүүн гар тийш чиг зассан сум бүхий гэрэл дохио нь зүүн гар тийш болон буцаж эргэх хөдөлгөөнийг зохицуулна.

Нэмэгдэл гэрэл дохио асаж байвал сум зассан чигт хөдөлгөөнийг зөвшөөрөх бөгөөд асаагүй (гэрлэн дохионы зохицуулгатай үед) бол үүнтэй хөдөлгөөнийг хориглоно. Энэ тохиолдолд үндсэн гэрэл дохио нь нэмэгдэл дохионы сум зассанаас бусад чигийн хөдөлгөөнийг зохицуулна.

Зохицуулагчийн дохио

5.8. Зохицуулагч биеийн байрлал, дохиурын заалтаар дохио өгнө.

5.9. Зохицуулагчийн хөдөлгөөн зохицуулах дохио нь дор дурдсан утгатай байна:

а/дохиурыг өргөсөн байвал энэ дүрмийн 5.2-т зааснаас бусад тохиолдолд хөдөлгөөнийг хориглоно;

б/дохиурыг цээжиндээ авсан буюу гараа алдалсан байвал зохицуулагчийн зүүн болон баруун гар талаас яваа тээврийн хэрэгсэл чигээрээ буюу баруун гар тийш нэвтрэх, явган зорчигч зам хөндлөн гарахыг зөвшөөрөх бөгөөд зохицуулагчийн ар, өвөр талаас яваа тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнийг хориглоно;

в/дохиурыг урагш зассан байвал зохицуулагчийн зүүн гар талаас яваа тээврийн хэрэгсэл бүх чигт, өвөр талаас яваа тээврийн хэрэгсэл зөвхөн баруун гар тийш эргэхийг зөвшөөрөх бөгөөд бусад талаас (баруун гар буюу ар талаас) яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно. Явган зорчигч зохицуулагчийн зөвхөн ар талаар зам хөндлөн гарахыг зөвшөөрнө.

5.10. Зохицуулагч нь жолооч, явган зорчигчдод хөдөлгөөний чигийг өөрчлөх, байр эзлэх, хөдөлгөөний хурдаа хасах буюу нэмэх, тойрон гарах, зогсох зэрэг үйлдэл хийхийг зассан ойлгогдохуйц дохио өгч болно.

5.11. Зохицуулагч дохиураа тээврийн хэрэгсэл рүү чиглүүлэн зааж дохих буюу чанга яригч хэрэгслээр шаардвал уг тээврийн хэрэгслийн жолооч зассан газарт зогсох үүрэгтэй.

5.12. Зохицуулагчийн шүглийн дохио буюу бусний анивчсан шар гэрэл нь хөдөлгөөнд оролцогчдын анхаарлыг өндөржүүлэх зорилготой.

5.13. Зохицуулагчийн ойлгодохуйц дохио нь гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэл түүнчлэн энэ дүрмийн бусад заалтуудаас давуу байна.

6. Дуут болон ослын дохио, ослын зогсолтын тэмдэг хэрэглэх

6.1. Дуут дохиог зөвхөн дараахь тохиолдолд хэрэглэж болно:

а/зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд;

б/суурин газрын гаднахь замд гүйцэж түрүүлэхийн тулд бусад жолоочид анхааруулах зорилгоор.

Дуут дохио нь давуу эрх олгохгүй бөгөөд урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээ авахаас чөлөөлөхгүй.

6.2. Ослын дохионы гэрлийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

а/ зам тээврийн ослын улмаас зогссон үед;

б/түр зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн үед;

в/харанхуй буюу үзэгдэлт хангалттүй үед замын гэрэлтүүлэгүй хэсэгт оврын гэрэл нь асахгүй (эсвэл байхгүй) тээврийн хэрэгслийг зогсоосон үед;

г/жолоочийн нүд гялбан зорчих баримжаа алдах үед;

д/чирэгдэж явааа (механикжсан тээврийн хэрэгсэл) үед;

е/тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлыг алдагдуулж болзошгүй бусад тохиолдолд.

6.3. Ослын зогсолтын тэмдгийг бусад жолооч нарт аюул саадыг урьдчилан анхааруулах зорилгоор тээврийн хэрэгслээс суурин газарт 15 метрээс багагүй, суурин газрын гаднахь замд 30 метрээс багагүй зайд байрлуулна.

Ослын зогсолтын тэмдгийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

а/зам тээврийн ослын улмаас зогссон үед;

б/түр зогсохыг хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн тээврийн хэрэгслийн ослын дохионы гэрэл нь ажиллахгүй (эсвэл байхгүй) буюу уг тээврийн хэрэгсэл нь ойртон ирж яваа бусад жолооч нарт харагдахааргүй тохиолдолд;

в/харанхуй буюу үзэгдэлт хангалттүй үед замын гэрэлтүүлэгтэй хэсэгт оврын болон ослын дохионы гэрлүүд нь асахгүй (эсвэл байхгүй) тээврийн хэрэгслийг зогсоосон үед;

г/чирэгдэж явааг механикжсан тээврийн хэрэгслийн ослын дохионы гэрэл нь ажиллахгүй (эсвэл байхгүй) бол.

Тайлбар: Энэ тохиолдолд ослын зогсолтын тэмдгийг үе тээврийн хэрэгслийн гадна талын арын хэсэгт байрлуулна.

7. Хөдөлгөөн эхлэх болон чиг өөрчлөх

7.1. Жолооч хөдөлгөөн эхлэх, чиг өөрчлөх (байр эзлэх, эргэх, зогсох)-ийн өмнө тэр чигт явахаа анхааруулсан дохиог эргэх чиг заадаг гэрлээр, хэрэв тэр нь ажиллахгүй буюу байхгүй бол гараар өгнө.

7.2. Эргэх чиг заадаг анхааруулах дохиог гараар өгсөн бол бусад хөдөлгөөнд оролцогчдод уг дохио сайтар харагдахуйц байдлаар гүйцэтгэнэ. Зүүн гар тийш дохио өгөхдөө зүүн гараа чигээр нь сунгах буюу эсвэл баруун гараа тохойгоор нь нугалж өргөнө. Баруун гар тийш дохио өгэхдээ баруун гараа чигээр нь сунгах буюу эсвэл зүүн гараа тохойгоор нь нугалж өргөнө.

7.3. Эргэх чиг заадаг анхааруулах дохиог тодорхой үйлдэл хийхийн өмнө өгөх бөгөөд үйлдлээ хийж дуусмагц зогсооно. Харин анхааруулах дохиог гараар өгсөн бол тодорхой үйлдэл хийж эхлэхийн өмнө дуусгаж болно.

7.4. Тоормосны гэрэл нь уг тээврийн хэрэгсэл хурдаа хасаж байгааг анхааруулах бөгөөд хэрэв тэр нь ажиллахгүй буюу байхгүй бол жолооч тоормослохын өмнө бусад хөдөлгөөнд оролцогчдод сайтар харагдахуйц байдлаар гараа сунган дээш доош хөдөлгөнө.

7.5. Анхааруулах дохио нь бусад хөдөлгөөнд оролцогчдыг төөрөгдүүлэхгүй, тэдэнд бууруу ойлголт төрүүлэхээргүй байвал зохино.

Анхааруулах дохио нь давуу эрх олгохгүй бөгөөд урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээ авахаас чөлөөлөхгүй.

7.6. Жолооч хөдөлгөөн эхлэхдээ зам, орчны байдлыг биеэр шалгаж, байр эзлэх, хөдөлгөөний чиг өөрчлөхөд бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй байх бүх нөхцөлийг хангана.

7.7. Жолооч гарцаар замд нийлэхдээ тэр замаар явааа тээврийн хэрэгсэл, явган зорчигчид, замаас гарахдаа явган зорчигч, унадаг дугуйнд зам тавьж өгнө.

7.8. Жолооч байр эзлэхийн өмнө зэрэгцээ эгнээнд чигээрээ явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Харин харилцан байраа солихоо баруун гар талд явааа нь эхэлж байраа эзэлнэ.

7.9. Уулзвар, гарцаар нэвтрэх хөдөлгөөн нь зөвхөн нэг чигт зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд жолооч баруун гар тийш эргэхийн өмнө хамгийн баруун, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн өмнө хөдөлгөөний тӭхайн чигийн хамгийн зүүн гар талын захад байр эзэлсэн байвал зохино.

Хэрэв тухайн эгнээнээс явах хөдөлгөөний чигийг тэмдэг, тэмдэглэлээр заасан байвал уг тэмдэг, тэмдэглэлийн заалтыг баримтална.

7.10. Жолооч баруун буюу зүүн гар тийш эргэхдээ тээврийн хэрэгслийн оврын хэмжээ болон бусад шалтгаан (ачааны онцлог, зам дээрх саад гэх мэт)-аар энэ дүрмийн 7.9-д заасан шаардлагыг биелүүлэх боломжгүй бол аюулгүй байдлыг хангаж, бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатуулахгүйгээр уг үйлдлийг өөр эгнээнээс гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Зорчих хэсэг дээр зүүн гар талын захаас буцаж эргэх боломжгүй бол баруун гар талын эгнээ (эсвэл хөвөө)-нээс гүйцэтгэхийг зөвшөөрнө. Ингэхдээ өөдөөс буюу эргэлдээ эгнээнд араас явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

7.11. Жолооч уулзвар, гарцаас гарахдаа эсрэг урсгалыг серехгүйгээр үйлдлийг гүйцэтгэнэ. Баруун гар тийш эргэхдээ зорчих хэсгийн баруун гар талын захад аль болох ойр байдлаар нэвтэрнэ.

7.12. Жолооч зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ (уулзвар нэвтрэх тохиолдлоос гадна) өөдөөс чигээрээ явааа болон баруун гар тийш эргэх тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

7.13. Хөдөлгөөний дараалал нь энэ дүрмийн бусад заалтуудад тусгагдаагүй газарт жолооч баруун гар талаас ойртон ирж явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

7.14. Зам нь хурд хасах эгнээтэй бол жолооч эргэх үйлдэл хийхийн өмнө тэр эгнээнэ орсны дараа тээврийн хэрэгслийн хурдыг хасна. Харин хурд авах эгнээгээр явж замд нийлэхдээ тухайн замаар явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

7.15. Саадыг тойрон гарахдаа өөдөөс явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

Бэрхшээлтэй (өгсүүр буюу ганга жалгатай) замын нарийссан хэсэгт тээврийн хэрэгслүүд зөрж өнгөрөх боломжгүй бол аль ганга жалгатай талд явааа тээврийн хэрэгсэлд, ганга жалгагүй бол өгсөж явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

7.16. Буцаж эргэхийг хориглох тохиолдол:

а/явган хүний гарц дээр;

б/төмөр замын гарам дээр;

в/гүүрэн дээр болон доор;

г/хонгил дотор;

д/үзэгдэлт замын дагуу аль нэг чигт 100 метрийн дотор хязгаарлагдмал газар;

е/чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал болон таксийн зогсоол дээр.

7.17. Бусдын хөдөлгөөнд саад учруулахгүйгаргүй газарт, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд ухрах үйлдэл хийхийг зөвшөөрнө. Шаардлагатай тохиолдолд ухрах үйлдлийг бусдын тусламжтайгаар гүйцэтгэх бөгөөд жолооч аюулгүй байдлыг хангах үүргээс чөлөөлөгдөхгүй.

7.18. Улэвэр, гарц дээр буюу энэ дүрмийн 7.16-д заасан буцаж эргэхийг хориглосон бүх газарт ухрах үйлдлийг хориглоно.

8. Тээврийн хэрэгсэл байрлан явах

8.1. Эгнээний тоог зорчих хэсэг дээрх тэмдэглэл буюу 5.10.а,б, 5.11.а,б тэмдгээр тодорхойлно. Хэрэв эдгээр тэмдэг, тэмдэглэл байхгүй бол зорчих хэсгийн өргөн, автомашины өргөний хэмжээ, тэдгээрийн хажуугийн зайг харгалзан эгнээний тоог тодорхойлох бөгөөд эсрэг хөдөлгөөнтэй бол тухайн зорчих хэсгийн өргөний зүүн гар тал дахь тэн хагасыг эсрэг хөдөлгөөнд зориулагдсанд тооцно.

8.2. Эсрэг хөдөлгөөнтэй хоёр эгнээгээр зорчдог замд гүйцэж түрүүлэх буюу тойрон гарахаас бусад тохиолдолд эсрэг урсгал сөрөхийг хориглоно.

8.3. Хөдөлгөөний эгнээ нь тэмдэглэлээр тодорхойлогдсон гурван эгнээгээр зорчдог замын дунд эгнээ сөрөг хөдөлгөөнтэй бол уг эгнээнд зөвхөн гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд орохыг зөвшөөрөх бөгөөд түүний зүүн гар талын эгнээнд урсгал сөрөхийг хориглоно.

8.4. Эсрэг хөдөлгөөнтэй дөрөв буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замд эсрэг урсгал сөрөхийг хориглоно.

8.5. Суурин газрын гаднахь зам буюу 5.1, 5.5 тэмдэг тавигдсан замд тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн баруун гар талын захад аль болох ойр явах бөгөөд баруун гар талын эгнээ чөлөөтэй байхад (зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд) түүний зүүн гар талын аль ч эгнээгээр явахыг хоригломо.

8.6. Суурин газарт жолооч энэ дүрмийн 8.7-8.10, 23.4-т заасан шаардлагуудыг зөрчихгүйгээр аль тохиромжтой эгнээг сонгож явна. Хөдөлгөөний эрчим ихтэй (эгнээ чөлөөгүй) замд эргэх үйлдэл хийх, саадыг тойрон гарах, зогсохооос бусад тохиолдолд эгнээ байр өөрчлөхийг хориглоно.

8.7. Нэг чиглэлийн гурав буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замын тухайн чигийн хамгийн зүүн гар талын эгнээнд зөвхөн гүйцэж түрүүлэх, зүүн гар тийш болон буцаж эргэхийн тулд, мөн хөдөлгөөний эрчим ихтэй (бусад эгнээнүүд чөлөөгүй) үед байр эзлэхийг зөвшөөрнө. Харин бүх жин нь 3.5 тонноос их ачаатай автомашин зөвхөн зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд уг эгнээнд орохыг хориглоно.

Дээрх зам нь нэг чигийн хөдөлгөөнтэй бол түр зогсохын тулд хамгийн зүүн гар талын эгнээнд орохыг зөвшөөрнө.

8.8. Трактор, өөрөө явдаг машин механизм болон цагт 40 км-ээс илүүгүй хурдтай явах тээврийн хэрэгсэл гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

8.9. Тууш замд бүх жин нь 3.5 тонноос их ачаатай автомашин зорчих хэсгийн баруун гар талын нэг буюу хоёр дахь эгнээгээр явна.

8.10. Троллейбусны жолооч өмнөх троллейбус шугаманаас салаагүй байхад зэрэгцээ эгнээнд орохыг хориглоно.

8.11. Жолооч нь урдаа явааа тээврийн хэрэгсэл зогсоход түүнийг мөргөхгүй, хажуу дахь тээврийн хэрэгслийг шүргэхгүй байх хэмжээний хоорондын болон хажуугийн зайг хөдөлгөөний хурднаас хамааруулан сонгож явна.

9. Тээврийн хэрэгслийн хурд

9.1. Жолооч хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж явааа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан тээврийн хэрэгслийн хурдыг энэ дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгож явна.

9.2. Жолооч хөдөлгөөнд ахуул, саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна.

9.3. Тээврийн хэрэгслийн хурдыг суурин газарт цагт 60 км, суурин газрын гаднахь замд цагт 80 км, тууш замд цагт 100 км-ээс хэтрүүлэхгүйгээр сонгож явна. Харин дараахь тохиолдолд тээврийн хэрэгслийн хурдыг дор дурдсанаас хэтрүүлэхгүйгээр сонгож явбал зохино:

а/механикжсан тээврийн хэрэгслийг чирэх үед цагт 40 км;

б/хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх үед цагт 50 км;

в/суурин газарт автобусаар буюу ачааны автомашины тэвшинд хүн тээвэрлэх үед цагт 50 км;

г/суурин газрын гаднахь зам болон тууш замд автобусаар буюу ачааны автомашины тэвшинд хүн тээвэрлэх үед цагт 70 км;

д/тууш замд мотоцикль, чиргүүлтэй суудлын автомашин, хүн тээвэрлээгүй автобус буюу бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин цагт 80 км;

е/ хорооллын дотор цагт 20 км.

9.4. Жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлтоор тогтоосон дээд хурдыг хэтрүүлэх;

б/"Хурдны хязгаар" таних тэмдэг бүхий тээврийн хэрэгслийн хурдыг уг тэмдэгт зааснаас хэтрүүлэх;

в/шалтгаангүйгээр хэт удаан явж бусдын хөдөлгөөнийг саатуулах;

г/зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд огцом тоормослох.

10. Гүйцэж түрүүлэх

10.1. Жолооч гүйцэж түрүүлэхийн өмнө дараахь нөхцөлүүдийг анхаарч мэдсэн байвал зохино:

а/уг үйлдлийг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хэмжээний зай байгаа эсэх;

б/өөдөөс болон араас яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулж болзошгүй эсэх;

в/урд яваа тээврийн хэрэгсэл чиг өөрчлөх дохио өгсөн эсэх.

10.2. Гүйцэж түрүүлэх үйлдлийг хийхдээ гүйцэгдэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхыг зохино.

10.3. Тээврийн хэрэгслийг зөвхөн зүүн гар талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрнө. Харин зүүн гар тийш дохио өгөөд эргэх үйлдлээ эхэлсэн тээврийн хэрэгслийг баруун гар талаар нь гүйцэж түрүүлж болно.

10.4. Гүйцэж түрүүлэх гэж байгаагаа бусад жолооч нарт гэрэл шилжүүлэх буюу дуут дохио өгөх байдлаар (энэ дүрмийн 6.1, 15.7-д заасныг зөрчихгүйгээр) анхааруулж болно.

10.5. Гүйцэгдэж байгаа жолооч хурдаа нэмэх, гүйцэж түрүүлэхэд ямар нэг байдлаар саад хийхийг хориглоно.

Гүйцэж түрүүлэх нь хөдөлгөөнд аюултай байвал гүйцэгдэж байгаа жолооч зүүн гар тийш эргэх дохио өгч анхааруулна.

10.6. Гүйцэж түрүүлэхийг хориглох тохиолдол:

а/зохицуулдаг уулзвар дээр эсрэг урсгалыг сөрөхөөр бол;

б/зохицуулдаггүй уулзвар буюу гарц дээр (баруун гар талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд);

в/явган хүний гарц дээр;

г/төмөр замын гарам дээр буюу түүнд хүртэл 100 метрээс ойр зайд;

д/гүйцэж түрүүлж байгаа буюу тойрон гарч байгаа, мөн зүүн гар тийш эргэх дохио өгсөн тээврийн хэрэгслийг (баруун гар талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд);

е/эсрэг урсгалыг сөрөхөөр бол замын өгсүүр хэсгийн төгсгөл буюу үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт;

ж/хөдөлгөөнд саад бэрхшээлтэй замд цуваа.

11. Түр буюу удаан зогсох

11.1. Жолооч тээврийн хэрэгслийг замын баруун гар талд зорчих хэсгийн хашлаганд шахаж, хашлагагүй замд зорчих хэсгийг чөлөөлж зогсооно. Хэрэв зорчих хэсгийг чөлөөлөх боломжгүй (хөвөөгүй) бол түүний зах руу аль болох шахаж зогсооно. Мөн энэ байдлаар нэг чигийн хөдөлгөөнтэй замын зүүн гар талд түр зогсохыг зөвшөөрнө.

11.2. Тээврийн хэрэгслийг зорчих хэсгийн зах (эсвэл хөвөө)-ыг дагуулан зөвхөн нэг эгнээгээр цувуулан зогсоохыг зөвшөөрнө. Харин зорчих хэсгийн өргөсгөсөн талбайд цувуулахаас өөр байдлаар (бусдын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр) зогсоож болно.

11.3. Жолооч гүйгээр тээврийн хэрэгсэл үл хөдлөх буюу өөрөөс нь бусад хүн хөдөлгөх боломжгүй болгох арга хэмжээ авсны дараа түүнийг орхиж явахыг зөвшөөрнө.

11.4. Суурин газрын гаднахь замд амрах, хонох зэрэгээр удаан зогсохдоо тээврийн хэрэгслийг тусгай зориулсан талбайд, эсвэл замаас зайдуу газарт зогсооно.

11.5. Түр зогсохыг хориглох тохиолдол:

а/уулзвар, гарц дээр буюу түүнд 20 метрээс ойр зайд (тусгаарлах зурвас буюу тэнхлэгийн үргэлжилсэн шугамтай Т-хэлбэрийн уулзвар, гарцын хөдөлгөөн оглолцохгүй хэсэг дээр зогсохоос бусад тохиолдолд);

б/явган хүний гарц дээр буюу түүний өмнө 5 метрээс ойр зайд;

в/чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал, таксийн зогсоол дээр буюу түүнд 15 метрээс ойр зайд (тэдгээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр хүн буулгах, суулгахын тулд түр зогсохоос бусад тохиолдолд);

г/төмөр замын гарам дээр буюу түүнд 20 метрээс ойр зайд;

д/гүүрэн дээр болон доор;

е/хонгил дотор;

ж/гэрэлзам дохио, замын тэмдэг халхлах, бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах газарт;

з/тээврийн хэрэгсэл зогсоход түүнээс үргэлжилсэн шугам (зорчих хэсгийн захыг тэмдэглэснээс бусад) буюу зорчих хэсгийн эсрэг талын зах хүртэл 3 метрээс бага зайтай газарт;

и/үзэгдэлт замын дагуу аль нэг чигт 100 метрийн дотор хязгаарлагдмал нөхцөлд зорчих хэсэг дээр.

11.6. Удаан зогсохыг хориглох тохиолдол:

а/түр зогсохыг хориглосон газарт;

б/төмөр замын гарамд 100 метрээс ойр зайд.

11.7. Хориглосон газарт зайлшгүй зогсолт хийсэн жолооч тээврийн хэрэгслээ замын тухайн хэсгээс аль болох нэн даруй зайлуулах арга хэмжээ авбал зохино.

11.8. Бусдын хөдөлгөөнд саад болохоор байвал зогсож байгаа тээврийн хэрэгслийн хаалгыг нээхийг хориглоно.

12. Уулзвар нэвтрэх

12.1. Жолооч уулзвараар баруун, зүүн гар тийш эргэх үед явган хүний гарцаар зам хөндлөн гарч яваа явган зорчигч, унадаг дугуйн замаар явах дугуйчинд зам тавьж өгнө.

12.2. Хөндлөн замаас яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулан тээврийн хэрэгслээ зогсоож болзошгүй тугжрэл, саатал бий болсон үед уулзвар руу орохыг хориглоно.

12.3. Гэрэл буюу зохицуулагчийн дохиогоор хөдөлгөөний дараалал тогтоож байгаа уулзварыг зохицуулдаг уулзвар гэнэ.

Зохицуулдаг уулзвар нэвтрэх

12.4. Жолооч ногоон гэрлээр зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ уулзварт ороод, өөдөөс чигээрээ яваа болон баруун гар тийш эргэх тээврийн хэрэгслэд зам тавьж өгнө.

12.5. Улаан буюу шар гэрэлтэй хамт ассан нэмэгдэл дохиогоор явж буй жолооч бусад чиглэлээс яваа тээврийн хэрэгслэд зам тавьж өгнө.

12.6. Зохицуулагчийн дохиогоор буцаж эргэхдээ зүүн гар талын замаас баруун гар тийш эргэж байгаа тээврийн хэрэгслэд зам тавьж өгнө.

12.7. Зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч нь уулзвар нэвтрэх үйлдлээ дуусгаж байгаа тээврийн хэрэгслээ, зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй яваа (ашуулгийн зурвастай тохиолдолд түүнийг өнгөрч яваа буюу түүнд хүрээгүй явваа) явган зорчигчид зам тавьж өгнө.

Зохицуулдаггүй уулзвар нэвтрэх

12.8. Адил замын уулзварт жолооч баруун гар талаас ойртон ирсэн тээврийн хэрэгслэд зам тавьж өгнө.

12.9. Гол ба туслах замын уулзварт туслах замаар яваа жолооч гол замаар яваа тээврийн хэрэгслэд зам тавьж өгнө.

12.10. Жолооч зүүн гар тийш буюу буцаж эргэхдээ уулзварт ороод, адил замаар өөдөөс чигээрээ яваа болон баруун гар тийш эргэх тээврийн хэрэгслэд зам тавьж өгнө.

12.11. Уулзвар дээр гол зам чигээ өөрчилсөн байвал түр замаар яваа жолооч нар өөр хоорондоо адил замын уулзвар нэвтрэх журам баримтална.

Туслах замаар яваа жолооч нар өөр хоорондоо мөн энэ заалтыг баримтална.

12.12. Хөдөлгөөний дараалал тогтоосон тэмдэг байхгүй үед жолооч зорчих хэсгийн гадаргуугийн байдлыг тодорхойлж чадахгүй (харанхуй, манантай, цас орсон, бохирдсон зэргээс шалтгаалан) бол өөрийгөө туслах замаар явааД тооцно.

13. Явган хүний гарц нэвтрэх

13.1. Явган хүний зохицуулдаггүй гарц руу ойртон ирсэн жолооч хурдаа хасаж, хэрэв явган зорчигч уг гарцаар явж байвал зам тавьж өгнө.

13.2. Зөвшөөрсөн гэрэл дохио асах үед жолооч явган хүний гарцыг нэвтрэхдээ зорчих хэсгийг хөндлөн гарч амжаагүй явваа (ашуулгийн зурвастай тохиолдолд түүнийг өнгөрч яваа буюу түүнд хүрээгүй явваа) явган зорчигчид зам тавьж өгнө.

13.3. Явган хүний гарцын өмнө тээврийн хэрэгсэл зогссон буюу хурдаа хасаж байвал араас нь ирсэн жолооч түүний урдуур зам хөндлөн гарч яваа явган зорчигч байхгүйг бүрэн мэдсэнийхээ дараа хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.

13.4. Жолооч замын аль ч хэсэгт хараагүй хүн (цагаан таяг барьсан)-ийг урьдчилан өнгөрүүлнэ.

13.5. "Хүүхэд тээвэрлэж явааа тээврийн хэрэгсэл" гэсэн таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл зогсож байвал ойртон ирсэн жолооч хурдаа хасаж анхаарал болгоомжтой явах. шаардлагатай бөгөөд зайлшгүй шаардлага гарвал зогсож хүүхдүүдийг урьдчилан өнгөрүүлнэ.

13.6. Жолооч явган хүний гарц дээр тээврийн хэрэгслээ зогсоож болзошгүй саад тохиолдсон үед гарц руу орохыг хориглоно.

14. Төмөр замын гарам нэвтрэх

14.1. Жолооч төмөр замыг зөвхөн гарамтай хэсгээр нэвтэрнэ. Ингэхдээ ойртон ирсэн галт тэрэг (зүтгүүр)-ийг урьдчилан өнгөрүүлбэл зохино.

14.2. Жолооч төмөр замын гарамд ойртон очихдоо ашуулгүй байдал хангагдсан эсэхийг магадлан, дуут буюу гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэлийн заалт, хаалтын байрлал, гармын жижүүрийн заалтыг удирдлага болгоно.

14.3. Төмөр замын гармын хаалт хаалттай буюу хаагдаж эхэлж байвал, мөн аниВсан улаан гэрэл ассан, эсвэл дуут дохио жижлаж байхад, түүнчлэн гармын жижүүр хориглосон дохио өгөх үед гарам руу орохыг хоригдоно.

14.4. Төмөр замын гармаар нэвтрэх хөдөлгөөнийг хориглосон үед жолооч "Зогс-шугам" тэмдэглэл буюу 3.5 тэмдэг эсвэл гэрлэн дохионы өмнө, хэрэв эдгээр нь байхгүй бол хаалтнаас 5 метрээс багагүй зайд, хаалтгүй тохиолдолд төмөр замаас 10 метрээс багагүй зайд зогсож галт тэргийг өнгөрүүлнэ.

14.5. Жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/гармын хаалтыг дур мэдэн нээх буюу өөрчлөх;

б/гармыг гэмтээж болзошгүй машин механизмыг тэвэрлэхээс бусад байдлаар гаргах;

в/цагт 8 км-ээс бага хурдтай явдаг машин механизмыг төмөр замын ангийн даргын зөвшөөрөлгүйгээр гаргах;

г/гарам дээр тээврийн хэрэгслээ зогсоож болзошгүй саад тохиолдсон үед гарам руу орох.

14.6. Төмөр замын гарам дээр жолооч зайлшгүй зогсолт хийвэл зорчигчдыг нэн даруй буулган, ослын дохионы гэрлээ асааж, гармыг чөлөөлөх арга хэмжээ авна.

Хэрэв гармыг нэн даруй чөлөөлөх боломжгүй бол:

а/бололцоотой бол хоёр хүнийг төмөр замын дагуу гармаас хоёр тийш (ганц хүнтэй бол түүнийг замын байдал муу үзэгдэх зүг рүү) 1000 метрийн зайд явуулж галт тэргэнд зогсох дохио өгүүлнэ. Ингэхдээ тэр хүмүүст дохио өгөх журмыг заавалчилна;

б/жолооч тээврийн хэрэгслийн дэргэд үлдэж дуут дохио өгнө;

в/галт тэрэг ойртон ирж байгаа эсэхийг анхааралтай ажиглан, хэрэв ирж байвал үгтан гүйж зогсох дохио өгнө.

Тайлбар: Дуут дохиог нэг урт, гурван богино хэмнэлээр, зогсох дохиог өдрийн цагт тод өнгийн сайн харагдах зүйлээр, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед гэрэл буюу галаар тойруулан даллаж өгнө.

15. Гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийг хэрэглэх

15.1. Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед тээврийн хэрэгслийн гадна талын гэрлийг дараахь байдлаар асаж явна:

а/замын гэрэлтүүлэгтүй хэсэгт холын буюу ойрын гэрлийг асаана. Өөдөөс ирж яваа тээврийн хэрэгсэл хүртэл 150 метрээс багагүй зайд буюу жолоочийг гялбуулж болзошгүй бусад тохиолдолд холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлнэ. Мөн өөдөөс яваа жолооч гэрлээ үе үе шилжүүлэн дохиол зайн хэмжээг үл харгалзан холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлнэ.

Хэрэв жолоочийн нүд гялбан зорчих баримжаа алдвал ослын дохионы гэрлээ асаж, эзэлж явсан эгнээгээ өөрчлөхгүйгээр хурдаа хасах буюу зогсоно;

б/замын гэрэлтүүлэгтэй хэсэгт ойрын гэрлийг асаана;

в/чиргүүл чирч явааг үед чиргүүлийн оврын гэрлийг асаана.

15.2. Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед замын гэрэлтүүлэгтүй хэсэгт тээврийн хэрэгслийг зогсоохдоо оврын гэрлийг асаана. Хэрэв тэр нь гэмтэлтэй буюу байхгүй бол тээврийн хэрэгслийг замаас гаргах бөгөөд иймбололцоогүй үед энэ дүрмийн 6.2-ын "в", 6.3-ын "в" заалтын дагуу анхааруулах дохио хэрэглэнэ.

15.3. Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед чиргүүл чирч явах бэлтгэсэхдээ бүхээг дээрх "Чиргүүлтэй тээврийн хэрэгсэл" таних тэмдгийг асаана.

15.4. Гэрэлтүүлүүрийг суурин газрын гаднахь замд хэрэглэхийг зөвшөөрөх бөгөөд өөдөөс тээврийн хэрэгсэл гарч ирсэн үед унтраажбайвал зохино. Түүнийг суурин газарт тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглогдсон автомашины жолооч албан үүргээ гүйцэтгэж явахдаа шаардлагатай үед хэрэглэж болно.

15.5. Манангийн гэрлийг цас, бороо орж байгаа буюу өтгөн манан будантай үед дангаар нь эсвэл хол, ойрын гэрлийн хамт хэрэглэнэ.

Тайлбар: Автомашинд хоёр, мотоциклд нэг манангийн гэрэл тавина. Манангийн гэрлийг автомашины урд талд, хоёр хажуугаас нь 400 мм-ээс дотогш, том гэрлээс өндөргүй зайд тэгш хэмтэй байрлуулна.

15.6. Бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах зорилгоор өдрийн цагт дараахь тохиолдолд ойрын гэрлийг асаана:

а/цуваагаар явааүед;

б/хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэж явааүед;

в/хүнд буюу овор ихтэй, мөн аюултай ачаа тээвэрлэж явааүед;

г/механикжсан тээврийн хэрэгслийг чирч явааүед;

д/тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан тээврийн хэрэгслээр хамгаалуулж явааүед.

15.7. Гэрэл шилжүүлэх дохиог өөрөөс харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед хол, ойрын гэрлийг ээлжлэн шилжүүлэх, өдрийн цагт асааж, унтраах байдлаар үйлдэнэ. Энэ дохио нь урд болон өөдөөс яваажолооч нар гялбуулахаар бол хэрэглэхийг хориглоно.

16. Хорооллын доторхи хөдөлгөөн

16.1. 5.30 тэмдгээр тэмдэглэгдсэн хорооллын доторхи хөдөлгөөнд явган зорчигч явган хүний зам буюу зорчих хэсгээр явж болно. Хорооллын дотор явган зорчигч давуу эрхтэй зорчих боловч тээврийн

хэрэгслийн хөдөлгөөнд санаатайгаар саад учруулахыг хориглоно.

16.2. Хорооллын доторхи хөдөлгөөнд тээврийн хэрэгслийн хурдыг цагт 20 км-ээс хэтрүүлэх, жолоодлогын дадлага явуулах, тээврийн хэрэгслиг удаан хугацаагаар асаалттай зогсоох, мөн нэмэлт тэмдгээр тусгайлан заасан зогсоолооос бусад хэсэгт бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашиныг удаан зогсоохыг хориглоно.

16.3. Жолооч хорооллын доторхи хөдөлгөөнөөс гарч зам руу ороход бусад хөдөлгөөнд оролцогчдод зам тавьж өгнө.

17. Тууш замын хөдөлгөөн

17.1. Тууш замд хориглох зүйл:

а/явган зорчигч, ердийн хөсөг, унадаг дугуй, мопед болон трактор, өөрөө явдаг машин механизм мөн түүнчлэн техникийн дээд хурд нь цагт 40 км-ээс ихгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн;

б/бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин зорчих хэсгийн баруун гар талын нэг буюу хоёр дахь эгнэхээс бусад аль ч эгнээгээр явах;

в/5.15, 5.44 тэмдгээр заасан зориулалтын зогсоолын талбайгаас бусад хэсэгт түр зогсох;

г/ухрах буюу буцаж эргэх;

д/жолоодлогын дадлага явуулах.

17.2. Тууш замд жолооч зайлшгүй зогсолт хийвэл энэ дүрмийн 6.2-ын "б", 6.3-ын "б" заалтын дагуу анхаарууллах дохио хэрэглэж, зорчих хэсгийг нэн даруй чөлөөлөх арга хэмжээ авна.

18. Цуваагаар явах

18.1. Цуваараг томилогдсон ахлагч зохион байгуулан удирдаж явна.

18.2. Цуваанд явааа тээврийн хэрэгслийн хурд болон хоорондын зайг замын байдал, цаг агаарын нөхцөлд тохируулан цувааны ахлагч тогтоох бөгөөд хөдөлгөөний хурд нь энэ дүрмийн 9.3-т заасан хязгаараас хэтрэхгүй байвал зохино.

Цуваа нь гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

18.3. Бусад жолооч нар замын нарийн хэсэгт (тэмдгээр дараалал тогтоогоогүй бол) цувааны зам тавьж өгнө.

18.4. Цуваараг тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан тээврийн хэрэгсэл хамгаалан явааа бол тэр нь цуваараг чиглүүлэн удирдаж явах бөгөөд энэ дүрмийн 2.4-т заасныг хэрэгжүүлж болно.

19. Жолоодлогын дадлага хийх

19.1. Жолоодлогын дадлагыг багшийн шууд удирдлагын дор хийнэ.

19.2. Жолоодлогын дадлагыг эхлээд тусгайлан бэлтгэсэн талбайд хийж, сурагчид замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, жолоодлогын зохих дадлагатай болсны дараа Замын цагдаагийн албанаас зөвшөөрсөн хугацаа, чиглэлийн дагуу замын хөдөлгөөнд хийнэ.

19.3. Жолоодлогын дадлага хийлгэх багш нь Замын цагдаагийн албанаас олгосон багшлах эрхийн үнэмлэх болон дадлага хийлгэж байгаа тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхтэй байна.

19.4. Жолоодлогын дадлагын тээврийн хэрэгсэл нь "Сургалтын тээврийн хэрэгсэл" таних тэмдэгтэй байна.

Жолоодлогын дадлагын автомашин, механизм нь багшид зориулсан тоормос болон авцуулах холбооны нэмэлт дөрөө, ар талыг харах нэмэлт толтой байхаас гадна дадлага хийх үед тэвшний зүүн урд болон баруун хойд өнцөгт 250 х 250 мм хэмжээтэй улаан дарцагтай байна.

19.5. Жолоодлогын дадлага хийх үед аюулгүй байдлыг хангах үүргийг дадлагын багш хариуцна.

20. Механикжсан тээврийн хэрэгслийг чирэх

20.1. Механикжсан тээврийн хэрэгслийг зөөлөн буюу хатуу холбоогоор, мөн цоройлгон ачих байдлаар найдвартай холбож чирэх бөгөөд хөдөлгөөнд оролцохдоо ойрын гэрлээ асаана.

Чирэгдэж яваа механикжсан тээврийн хэрэгсэл нь энэ дүрмийн 6.2-ын "д", 6.3-ын "г" заалтын дагуу анхааруулах дохио хэрэглэнэ.

20.2. Хатуу холбоогоор чирэгдэж яваа тээврийн хэрэгсэл нь шулуун чигт чирч яваа тээврийн хэрэгслийнхээ дугуйн мөрийг дагахаар холбогдоогүй, түүнчлэн зөөлөн холбоо хэрэглээсэн бол чирэгдэж яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэхтэй хүн жолоодно.

20.3. Хатуу холбоогоор чирэх үед тээврийн хэрэгслүүдийн хоорондын зай нь 4 метрээс илүүгүй байна. Хатуу холбоогоор чирэгдэх тээврийн хэрэгслийн жолоочы механизм бүрэн ажиллагаатай байвал зохино.

20.4. Зөөлөн холбоогоор чирэх үед тээврийн хэрэгслүүдийн хоорондын зай нь 4-6 метр байх бөгөөд зөөлөн холбооны нэг метр тутамд улаан дарцаг байна. Зөөлөн холбоогоор чирэгдэх тээврийн хэрэгслийн тоормосны систем, жолооны механизм, дуут дохио бүрэн ажиллагаатай байвал зохино.

20.5. Механикжсан тээврийн хэрэгслийг чирэх үед чирч явааг автобус, троллейбусанд буюу ачааны автомашины тэвшинд, мөн чиргэдэж явааг тээврийн хэрэгсэлд хүн тээвэрлэхийг хориглоно.

20.6. Механикжсан тээврийн хэрэгслийг чирэхийг хориглох тохиолдол:

а/чиргүүлтэй тээврийн хэрэгслээр;

б/хоёр буюу түүнээс олон механикжсан тээврийн хэрэгслийг;

в/хоёр дугуйтай мотоциклоор буюу хоёр дугуйтай мотоциклийг;

г/халтиргаатай зам буюу уулын замд зөөлөн холбоогоор;

д/чирэгдэж явааг тээврийн хэрэгслийнхээс илүү бол;

е/уулын замд зорчих хэсэг нь мөстсөн бол.

21. Хүн тээвэрлэх

21.1. Зорчигчдыг хүн тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Жолооч хөделгөөн эхлэхийн өмнө зорчигчдыг тээвэрлэхэд шаардагдах ачуулгий байдал хангагдсан эсэхийг шалгаж үзсэн байвал зохино.

21.2. Жолооч нь тээврийн хэрэгслээ гүйцэд зогсоосны дараа зорчигчийг буулгах буюу суулгах, хаалгаа гүйцэд хаасны дараа хөделгөөнөө эхлэх үүрэгтэй.

21.3. Хүн тээвэрлэхэд зориулан тоноглосон ачааны автомашины тэвшинд зорчигч тээвэрлэх тохиолдолд жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг гурваас дээш жил жолоодож дадлагажсан байвал зохих бөгөөд тээврийн хэрэгслийг доорхи шаардлагын дагуу тоноглосон байна:

а/тэвшин дотор суудал засаж бат бөх бэхэлсэн байх бөгөөд суудлын тавцан нь шалнаас 0.3-0.5 метр, хашлаганы дээд ирмэгээс 0.3 метрээс багагүй байх;

б/хүүхэд тээвэрлэх тохиолдолд хашлаганы өндөр 0.8 метрээс багагүй байх;

в/тэвшний хойд болон хажуу хашлаганы дагуу зассан суудал нь түшлэгтэй байх;

г/зорчигчдыг буулгах, суулгах шаттай байх.

21.4. Жолооч хөделгөөн эхлэхийн өмнө зорчигчдод буух, суух, зорчих журмын тухай зааварчилж, хөделгөөний үед тэвшин дээр зогсож явахыг хориглох тухай анхааруулбал зохино.

21.5. Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх үед, түүнчлэн хот хоорондын буюу аялал жуулчлалын автобусанд болон хүн тээвэрлэхэд зориулан тоноглосон ачааны автомашины тэвшинд тээвэрлэх зорчигчдын тоо нь үйлдвэрээс тавьсан буюу зориулан тоноглосон суудлын тооноос илүүгүй байна.

Тайлбар: Ачааны автомашины тэвшинд тоноглосон суудлын тоог тогтоохдоо тавцангийн 0.4-0.5 метрийн урттай хэсгийг 1 нэгжид тооцно.

21.6. Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэхдээ автобус буюу хүн тээвэрлэхэд зориулсан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Зайлшгүй тохиолдолд ачааны автомашин (хүн тээвэрлэхэд зориулан тоноглосон)-аар тээвэрлэхийг зөвшөөрөх бөгөөд ингэхдээ насанд хүрсэн хоёроос доошгүй хүнийг тэвшний урд болон арын хэсэгт суулгаж харгалзуулан явбал зохино.

21.7. Хүн тээвэрлэхэд зориулан тоноглоогүй ачааны автомашины тэвшинд зөвхөн тухайн ачааг дагалдан буюу хүлээж авахаар явааа хүмүүсийг (тэвшний дээд ирмэгээс нам зассан суудалд) суулгаж явахыг зөвшөөрнө.

21.8. Хүн тээвэрлэхийг хориглох тохиолдол:

а/тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон тооноос олон хүн;

Тайлбар: Энэ тоонд 12 нас хүрээгүй хүүхдийг тооцохгүй бөгөөд харин уг тээврийн хэрэгслийн бодит жин нь бүх жингээс хэтрэхгүй байвал зохино.

б/тээврийн хэрэгслийн хүн тээхэд зориулаагүй хэсэгт;

в/чиргүүлтэй тээврийн хэрэгслийн тэвшинд;

г/ачааны мотоциклийн тэвшинд;

д/12 нас хүрээгүй хүүхдийг мотоциклийн арын суудалд тусгай бэхэлгээ хийлгүйгээр;

е/3 хүртэлх насны хүүхдийг (харгалзах хүнгүй тохиолдолд) зориулалтын нэмэгдэл суудал, бэхэлгээ хийлгүйгээр;

ж/согтуу хүнийг мотоциклоор буюу тээврийн хэрэгслийн задгай тэвшинд.

22. Ачаа тээвэрлэх

22.1. Ачааны жин болон тэнхлэгт ногдох ачааллын хэмжээ нь тухайн тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

22.2. Ачааг дор дурдсан шаардлагыг хангахаар байрлуулж бэхэлсэн байна:

а/унаж чирэгдэхгүй, хөделгөөнд оролцогчдод саад, аюул учруулахгүй байх;

б/жолоочийн харах боломжийг хязгаарлахгүй байх;

в/тээврийн хэрэгслийн тогтворжилтыг алдагдуулахгүй, жолоодлогыг хүндрүүлэхгүй байх;

г/тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл, гэрэл ойлгуур, эргэх чиг заадаг гэрэл буюу гараар өгөх дохио, улсын дугаар, таних тэмдгийг халхлахгүй байх;

д/их хэмжээний дуу чимээ, эвгүй үнэр гаргахгүй, тоос шороо босгохгүй, зам ба орчныг бохирдуулахгүй байх.

22.3. Суурин газарт 22 цагаас 06 цагийн хооронд дуу чимээ гаргаж ачих, буулгахыг хориглоно.

22.4. Хүнд буюу овор ихтэй мөн аюултай ачаа тээвэрлэх автомашины жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг гурваас дээш жил жолоодож дадлагажсан хүн байх бөгөөд хөдөлгөөнд оролцохдоо ойрын гэрлээ асааж явна.

22.5. Хүнд ачаа тээвэрлэх, мөн тээврийн хэрэгслийн ачаатай буюу ачаагүй өндөр нь 4 метр, өргөн нь 2.5 метр, урт нь 20 метр, ачаа нь тээврийн хэрэгслийн овроос арагшаа 2 метрээс илүү түүнчлэн хөөр буюу түүнээс олон чиргүүлтэй бол хөдөлгөөнд оролцохдоо Замын цагдаагийн албанаас зөвшөөрөл авна.

22.6. Тээврийн хэрэгслийн овроос уртаашаа 1 метр, өргөөшөө 0.4 метрээс илүү гарсан ачааг тээвэрлэхдээ түүний илүү гарсан хэсэгт "Овор ихтэй ачаа" таних тэмдэг, харанхуй буюу үзэгдэлт хангалттүй үед урд нь цагаан, ард нь улаан өнгийн гэрэл буюу гэрэл ойлгуур байрлуулна.

22.7. Аюултай ачаа, тэдгээрийн ариутгаагүй сав, баглаа, боодлыг тусгай журам, стандартын дагуу тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн урд болон ард "Аюултай ачаа" таних тэмдгийг байрлуулна.

22.8. Суудлын автомашин, мотоциклоор түүний овроос урт буюу өргөнөөрөө 0.5 метрээс илүү гарсан ачаа тээвэрлэхийг хориглоно.

23. Унадаг дугуй, мопед, ердийн хөсгөөр зорчих, мал туухад тавих нэмэлт шаардлага

23.1. Унадаг дугуй буюу ердийн хөсгийг 14-өөс дээш, мопедыг 16-гаас дээш насны хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрнө.

23.2. Унадаг дугуйн тоормос, жолоо, хонх нь бүрэн ажиллагаатай байхын дээр харанхуй буюу үзэгдэлт хангалттүй үед хөдөлгөөнд оролцохдоо урд талдаа цагаан, ард талдаа улаан гэрэл буюу гэрэл ойлгуур, хоёр хажуу талдаа улаан буюу улбар шар өнгийн гэрэл ойлгууртай байвал зохино.

23.3. Ердийн хөсгийн тоног таталга нь бат бөх байхаас гадна харанхуй буюу үзэгдэлт хангалттүй үед хөдөлгөөнд оролцохдоо урд талдаа цагаан, ард талдаа улаан гэрэл ойлгуур (тус бүр хоёр ширхэг)-тай байвал зохино.

23.4. Унадаг дугуй, мопед нь (унадаг дугуйн зам байхгүй тохиолдолд) нэг эгнээнд хоёроос илүүгүйгээр зэрэгцэж, харин ердийн хөсөг зөвхөн нэг эгнээгээр гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн түлд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

23.5. Унадаг дугуй, мопедын жолооч нь уулзвараас өөр хэсэгт унадаг дугуйн замаар зорчих хэсэгт нийлэхдээ тухайн замаар явааа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

23.6. Унадаг дугуй, мопедын жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/жолооны гарыг сул тавих, дөрөөнд гишгэхгүй явах;

б/ачаа нь урт буюу өргөнөөрөө тээврийн хэрэгслийн овроос 0.5 метрээс илүү гарах, өндөр нь газраас 1.5 метрээс илүү байх;

в/зорчигчид зориулсан гишгүүр, суудалгүй тохиолдолд (түүнчлэн ачааны зориулалттай бол тэвшинд) хүн тээвэрлэх;

г/7 нас хүрээгүй хүүхдийг тусгай бэхэлгээ хийлгүйгээр тээвэрлэх;

д/соогуу хүн тээвэрлэх;

е/тээврийн хэрэгслийг чирэх, тээврийн хэрэгслээр чирүүлэх.

23.7. Суурин газрын гаднахь засмал замаар малыг зорчих хэсгийн дагуу тууж явахыг хориглоно. Засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал байлгахыг хориглоно. Малыг зам хөндлөн буюу гүүрээр аль болох түргэн, бөөнөөр нь гаргах бөгөөд энэ үед ойртон ирж яваа тээврийн хэрэгсэл зам тавьж өгнө.

23.8. Төмөр замын гармаар ердийн хөсгийг гурваас илүүгүйгээр цувуулж гаргана. Мал тууж гаргахдаа аюулгүй байдлыг хангаж, богино хугацаанд амжиж гарахуйц тоогоор хэсэг хэсгээр цувуулж гаргана.

23.9. Ердийн хөсгөөр зорчих, мал туухад хориглох зүйл:

а/ердийн хөсгийн овроос урт буюу өргөнөөрөө 0.5 метрээс илүү гарсан ачаа тээвэрлэх;

б/зам дээр ердийн хөсөг буюу малаа хараа хяналтгүй орхих;

в/соогуу байх.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралт

ЗАМЫН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭЛ

Нэг. Анхааруулах тэмдэг

1. Анхааруулах тэмдэг нь замын аюул бүхий хэсэгт ойртож байгааг болон түүнд зохицсон арга хэмжээ авахыг жолоочид урьдчилан анхааруулна:

1.1 "Төмөр замын хаалттай гарам";

1.2 "Төмөр замын хаалттүй гарам";

1.3.а,б "Төмөр замын гарам" -1.3.а тэмдэг нь нэг төмөр замтай, 1.3.б тэмдэг нь хоёр буюу түүнээс олон төмөр замтай хаалттүй гарам байгааг;

1.4.а,б,в,г,д,е "Төмөр замын гарамд ойртоно" -төмөр замын гарам ойртож байгааг (суурин газрын гаднахь замд);
1.5 "Адил замын уулзвар";
1.6 "Тойрох хөдөлгөөнтэй уулзвар";
1.7 "Гэрэл дохионы зохицуулга" -хөдөлгөөн нь гэрэл дохиогоор зохицуулагддаг уулзвар буюу явган хүний гарц ойртож байгааг;
1.8.а,б "Огцом эргэлт" -замын эргэх радиус багатай буюу үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт эргэх чиг ойртож байгааг;
1.9.а,б "Тахир зам" -замын огцом тахирласан хэсгүүд байгааг;
1.10 "Эгц уруу";
1.11 "Огцом өгсүүр";
1.12 "Халтиргаатай зам";
1.13 "Тэгш биш зам";
1.14 "Хайрга үсэрнэ" -тээврийн хэрэгсэл явахад дугуйн дооросс нь хайрга, чулуу үсэрч болзошгүй замын хэсэг байгааг;
1.15.а,б,в "Зам нарийсна" -1.15.а тэмдэг нь зам хоёр талаас, 1.15.б тэмдэг нь зам баруун гар талаас, 1.15.в тэмдэг нь зам зүүн гар талаас нарийсахыг;
1.16 "Эсрэг хөдөлгөөн" -эсрэг хөдөлгөөнтэй зам (зорчих хэсэг)-д шилжихийг;
1.17 "Явган хүний гарц";
1.18 "Хүүхэд" -зорчих хэсэг дээр хүүхэд гэнэт гарч ирж болзошгүй замын хэсэг (сургууль, цэцэрлэгийн орчим гэх мэт) байгааг;
1.19 "Унадаг дугуйн зам нийлнэ";
1.20 "Засварын ажил" -хүмүүс зам дээр ажил хийж байгааг;
1.21 "Мал тууж гарах газар";
1.22 "Ан амьтан" -мал, ан амьтан гарч ирж болзошгүй замын хэсэг байгааг;
1.23 "Чулуулаг нурангитай" -дээрээс шороо, чулуу нурж болзошгүй замын хэсэг байгааг;
1.24 "Хажуугийн салхитай";
1.25 "Онгоц доогуур ниснэ";
1.26 "Хонгил" -гэрэлтүүлэгтэй хонгил буюу замын үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт хонгил ойртож байгааг;
1.27 "Бусад аюултай газар" -энэ хавсралтад заасан тэмдгээр анхааруулаагүй бусад аюул бүхий замын хэсэг байгааг;
1.28.а,б,в "Эргэх чиг" -замын үзэгдэлт хязгаарлагдмал хэсэг дэх огцом эргэх чигийг.

2. 1.1, 1.2, 1.5-1.27 тэмдгийг хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй замын хэсэг эхлэх газраас суурин газрын доторкн замд 50-100 метр, суурин газрын гаднахь замд 150-300 метрийн өмнө байрлуулна. Шаардлагатай тохиолдолд 6.1.а тэмдгийн хамт өөр зайд байрлуулж, уг нэмэлт тэмдгээр аюул бүхий хэсгийн эхлэл хүртэлх зайг тодруулна.

Замын өсгүүр, уруу хэсгүүд залган үргэлжилж байгаа бол 1.10, 1.11 тэмдгийг аюул бүхий хэсгийн шууд өмнө байрлуулж болно.

Зорчих хэсэг дээр түр хугацааны ажил хийх тохиолдолд 1.20 тэмдгийг үг хэсгээс 10-15 метрийн өмнө байрлуулж болно.

3. 1.3.а,б тэмдгийг төмөр замын гармын шууд өмнө байрлуулна.

4. 1.4.а,б,в тэмдгийг зорчих хэсгийн баруун гар талд, 1.4.г,д,е тэмдгийг зүүн гар талд байрлуулах бөгөөд төмөр замын гармаас хамгийн их алслагдсан 1.1, 1.2 тэмдгийн доор 1.4.а, 1.4.г тэмдгийг, хамгийн ойр байрласан 1.1, 1.2 тэмдгийн доор 1.4.в, 1.4.е тэмдгийг, тэдгээрийн хооронд ижил зайд 1.4.б, 1.4.д тэмдгийг тус тус байрлуулна.

5. 1.28.а,б,в тэмдгийг аюул бүхий газар дээр байрлуулна.

Хоёр. Хориглох тэмдэг

6. Хориглох тэмдэг нь замын хөдөлгөөнд тодорхой хязгаарлалт тогтоохоос гадна хязгаарлалтыг өөрчилнө:

2.1 "Орох хориотой" - тээврийн хэрэгсэл тэмдгээс цааш орохыг хоригломо;
2.2 "Хөдлгөөн хориотой" - тээврийн хэрэгслийн хөдлгөөнийг хоригломо;
2.3 "Механикжсан тээврийн хэрэгслийн хөдлгөөн хориотой";
2.4 "Ачааны автомашины хөдлгөөн хориотой" - бүх жин нь 3.5 тонноос илүү (тэмдэгт бүх жинг заасан бол түүнээс илүү) ачааны автомашин, мөн трактор, өөрөө явдаг машин, механизмын хөдлгөөнийг хоригломо. Энэ тэмдэг нь хүн тээвэрлэхэд зориулан тоноглосон ачааны автомашинд хамаарахгүй;
2.5 "Мотоциклийн хөдлгөөн хориотой";
2.6 "Трактерын хөдлгөөн хориотой" - бүх төрлийн трактор, өөрөө явдаг машин, механизмын хөдлгөөнийг хоригломо;
2.7 "Чиргүүлтэй тээврийн хэрэгслийн хөдлгөөн хориотой" - чиргүүл чирч яваа ачааны автомашин буюу трактор, мөн мехникжсан тээврийн хэрэгсэл чирч яваа тээврийн хэрэгслийн хөдлгөөнийг хоригломо;
2.8 "Ердийн хөсгийн хөдлгөөн хориотой" - ердийн хөсгөөр явах, мал тууж буюу хөтлөж явахыг хоригломо;
2.9 "Унадаг дугуйн хөдлгөөн хориотой" - унадаг дугуй болон мопедын хөдлгөөнийг хоригломо;
2.10 "Явган зорчигчийн хөдлгөөн хориотой";

2.11 "Жингийн хязгаарлал" - бодит жин нь тэмдэгт зааснаас илүү тэсвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;

2.12 "Тэнхлэгийн ачааллын хязгаарлал" - аль нэг тэнхлэгт ногдож буй ачааллын хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тэсвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;

2.13 "Өндрийн хязгаарлал" - ачаатай буюу ачаагүй өндрийн хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тэсвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;

2.14 "Өргөний хязгаарлал" - ачаатай буюу ачаагүй өргөний хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тэсвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;

2.15 "Уртын хязгаарлал" - ачаатай буюу ачаагүй нийт бүрэлдэхүүний уртын хэмжээ нь тэмдэгт зааснаас илүү тэсвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно;

2.16 "Хоорондын зайн доод хязгаарлал" - тэсвэрийн хэрэгслүүдийн хоорондын зай нь тэмдэгт зааснаас бага явахыг хориглоно;

2.17 "Гааль" - гаалийн хяналтын бүсээр хяналт шалгалтад орохгүйгээр нэвтрэхийг хориглоно;

2.18.а "Баруун гар тийш эргэх хориотой";

2.18.б "Зүүн гар тийш эргэх хориотой";

2.19 "Буцаж эргэх хориотой";

2.20 "Гүйцэж түрүүлэх хориотой" - цагт 30 км-ээс бага хурдтай явааагас бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийг хориглоно;

2.21 "Гүйцэж түрүүлэх хорионы төгсгөл" - 2.20 тэмдгийн хүчинтэй хүрээ дуусснаыг заана;

2.22 "Ачааны автомашинаар гүйцэж түрүүлэх хориотой" - бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашинаар цагт 30 км-ээс бага хурдтай явааагас бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийг хориглоно. Мөн трактороор унадаг дугуй, ердийн хөсгөөс бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийг хориглоно;

2.23 "Ачааны автомашинаар гүйцэж түрүүлэх хорионы төгсгөл" - 2.22 тэмдгийн хүчинтэй хүрээ дуусснаыг заана;

2.24 "Хурдны дээд хязгаарлал" - хөдөлгөөний хурдыг (км/цаг) тэмдэгт зааснаас хэтрүүлэхийг хориглоно;

2.25 "Хурдны дээд хязгаарлалын төгсгөл" - 2.24 тэмдгийн хүчинтэй хүрээ дуусснаыг заана;

2.26 "Дуут дохио хориотой" - зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд дуут дохио өгөхийг хориглоно;

2.27 "Түр зогсох хориотой" - тээврийн хэрэгсэл түр буюу удаан зогсохыг хориглоно;

2.28 "Удаан зогсох хориотой" - тээврийн хэрэгсэл удаан зогсохыг хориглоно;

2.29 "Бүх хорионы төгсгөл" - 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26-2.28 тэмдгүүдийн хүчинтэй хүрээ дуусснаыг заана.

7. 2.2-2.9 тэмдгүүд нь уулзвар, гарцын өмнө байрласан бол тэдгээрийн хүчинтэй чигийг 6.3.а,б,в тэмдгээр тодорхойлно. Харин уулзвар, гарцын цаана байрласан бол тухайн зам (зорчих хэсэг)-д хамаарна.

8. 2.2, 2.3, 2.18.а,б, 2.19, 2.27 тэмдгүүд нь чиглэлийн тэсвэрийн хэрэгсэлд хамаарахгүй.

9. 2.18.а,б тэмдэг нь зорчих хэсгүүдийн эвхэн эхний огтлолцолд хамаарна.

10. 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26-2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээ нь байрласан газраасаа эхний уулзвар хүртэл, уулзваргүй замд суурин газраас гарах хүртэл хүчинтэй байна.

2.20, 2.22, 2.24 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 2.21, 2.23, 2.25 харгалзах тэмдгүүдээр, 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 6.2.а тэмдгийг хамт хэрэглэснээр, 2.24 тэмдгийн үйлчлэх хүрээг хурдны өөр хязгаарлал бүхий 2.24 тэмдгээр тус тус багасгаж болно. Мөн 2.27, 2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 6.2.б,д,е тэмдгийг хамт хэрэглэснээр буюу 6.2.в тэмдэгтэй хамт тавигдсан 2.27, 2.28 харгалзах тэмдгүүдээр, 2.27, 2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 7.4, 7.9 харгалзах тэмдэглэлүүдтэй хамт хэрэглэснээр (энэ тохиолдолд тэмдгийн үйлчлэх хүрээ нь тэмдэглэлийн уртаар тодорхойлогдоно), 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26-2.28 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг 2.29 тэмдгээр тус тус багасгаж болно.

11. 2.10, 2.27, 2.28 тэмдгүүд нь замын байрласан талдаа хүчинтэй.

Гурав. Дарааллын тэмдэг

12. Дарааллын тэмдэг нь уулзвар, зорчих хэсгийн огтлолцол буюу замын нарийссан хэсгээр нэвтрэх дараалыг тогтооно:

3.1 "Гол зам" - зохицуулдаггүй уулзвар нэвтрэхэд давуу эрх олгоно;

3.2 "Гол замын төгсгөл" - 3.1 тэмдгийн хүчинтэй хүрээ дуусснаыг заана;

3.3.а,б,в "Туслах зам нийлнэ":

3.3.а - туслах зам баруун болон зүүн гар талаас нийлнэ;

3.3.б - туслах зам баруун гар талаас нийлнэ;

3.3.в - туслах зам зүүн гар талаас нийлнэ;

3.4 "Зам тавьж өгнө" - хөдөлгөөний зохицуулгагүй үед жолоочийн хөндлөн замаар явах (хэрэв 6.12 тэмдэгтэй хамт тавигдсан бол гол замаар явах) тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө;

3.5 "Зогсохгүй явах хориотой" - хөдөлгөөний зохицуулгагүй үед "Зогс-шугам" тэмдэглэлийн

өмнө буюу тэмдэглэлгүй бол зорчих хэсгийн огтолцлын өмнө зогсолт хийхгүйгээр явахыг хориглоно. Жолооч хөндлөн замаар явааг (хэрэв 6.12 тэмдэгтэй хамт тавигдсан бол гол замаар явааг) тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

Энэ тэмдгийг төмөр замын хаалтгүй гарам буюу замын зарим шаардлагатай хэсгийн өмнө байрлуулж болох бөгөөд энэ тохиолдолд жолооч "Зогс-шугам" тэмдэглэлийн өмнө буюу тэмдэглэлгүй үед уг тэмдгийн өмнө зогсолт хийнэ;

3.6 "Серег хөделгөөнд зам тавьж өгно" - өдөөс явааг тээврийн хэрэгслийн хөделгөөнд саад болохоор байвал замын нарийссан хэсэгт орохыг хориглоно;

3.7 "Серег хөделгөөнд давуу эрхтэй" - замын нарийссан хэсэгт эрэг талаас явааг тээврийн хэрэгслээс түрүүлж нэвтрэх эрхтэй.

13. 3.1, 3.3.а,б,в тэмдэг бүхий замтай огтолцсон туслах чанарын замд 3.4 буюу 3.5 тэмдгийг, мөн 3.7 тэмдэг байрласан нарийссан хэсгийн эсрэг талд 3.6 тэмдгийг тус тус байрлуулна.

Дөрөв. Заах тэмдэг

14. Заах тэмдэг нь хөделгөөний зөвшөөрсөн чиг, хурдны зөвшөөрөгдөх доод хязгаар, мөн явган зорчигч болон тээврийн хэрэгслийн тодорхой төрлүүд явахыг зөвшөөрсөн замыг заана:

4.1.а,б,в,г,д,е - зөвхөн сум заасан чигт явахыг зөвшөөрнө. Зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн тэмдэг нь буцаж эргэхийг зөвшөөрнө;

4.2.а,б,в "Саадыг тойрч гарах чиг" - саадыг сум заасан талаар тойрч гарна. Энэ тэмдэг нь зөвхөн тухайн саадын орчинд хамаарна;

4.3 "Тойрох хөделгөөн" - сум заасан чигт хөделгөөнийг зөвшөөрнө;

4.4 "Суудлын автомашин явна" - суудлын автомашин, бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачааны автомашин, автобус, мотоцикль болон чиглэлийн тээврийн хэрэгслийн хөделгөөнийг зөвшөөрнө;

4.5 "Унадаг дугуйн зам" - зөвхөн унадаг дугуй болон мопедын хөделгөөнийг зөвшөөрнө. Явган хүний зам байхгүй бол явган зорчигч явахыг зөвшөөрнө;

4.6 "Явган хүний зам" - зөвхөн явган зорчигчийн хөделгөөнийг зөвшөөрнө;

4.7 "Хурдны доод хязгаарлал" - зөвхөн тэмдэгт заасан болон түүнээс илүү хурдтай (км/цаг) явахыг зөвшөөрнө;

4.8 "Хурдны доод хязгаарлалын төгсгөл" - 4.7 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг заана.

15. Уулзвар, гарц буюу замын хэсгийн шууд өмнө байрласан 4.1.а-4.1е тэмдэг нь зөвхөн тэр хэсэгтээ хамаарна.

4.1.а тэмдэг нь замын хэсгийн эхэнд (уулзварын цаана) байрласан бол эхний уулзвар хүртэл хүчинтэй байх бөгөөд гарцаар баруун гар тийш эргэхийг зөвшөөрнө.

16. 4.4 тэмдэг уулзвар, гарцын өмнө байрласан бол түүний хүчинтэй чигийг 6.3.а,б,в тэмдгээр тодорхойлно. Харин уулзвар, гарцын цаана байрласан бол тухайн зам (зорчих хэсэг)-д хамаарна.

Тав. Мэдээлэх тэмдэг

17. Мэдээлэх тэмдэг нь замын нөхцөл байдлын онцлог, суурин газар болон бусад объектын байрлалыг харуулна:

5.1 "Туш зам" - туш замын хөделгөөний журмыг баримтлан явах зам;

5.2 "Туш замын төгсгөл" - 5.1 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг мэдээлнэ;

5.3 "Суурин газрын эхлэл" - суурин газрын доторхи хөделгөөний журмыг баримтлах суурин газрын эхлэл болон нэрийг мэдээлнэ;

5.4 "Суурин газрын төгсгөл" - 5.3 тэмдгээр тэмдэглэгдсэн суурин газраас гарч байгааг мэдээлнэ;

5.5 "Суурин газрын эхлэл" - суурин газрын доторхи хөделгөөний журмыг тухайн замд баримтлах шаардлагагүй суурин газрын эхлэл болон нэрийг мэдээлнэ;

5.6 "Суурин газрын төгсгөл" - 5.5 тэмдгээр тэмдэглэгдсэн суурин газраас гарч байгааг мэдээлнэ;

5.7 "Нэг чигийн хөделгөөн" - хөделгөөн нь нэг чигт зохион байгуулагдсан зам буюу зорчих хэсэг;

5.8 "Нэг чигийн хөделгөөний төгсгөл" - 5.7 тэмдгийн хүчинтэй хүрээ дууссаныг мэдээлнэ;

5.9.а "Зүүнээс баруун гар тийш нэг чигийн хөделгөөнтэй" - хөндлөн нийлсэн зам буюу зорчих хэсэг баруун гар тийш нэг чигийн хөделгөөнтэй;

5.9.б "Баруунаас зүүн гар тийш нэг чигийн хөделгөөнтэй" - хөндлөн нийлсэн зам буюу зорчих хэсэг зүүн гар тийш нэг чигийн хөделгөөнтэй;

5.10.а,б "Эгнээнээс явах хөделгөөний чиг" - 5.10.а тэмдэг нь уулзварын өмнө зорчих хэсгийн дээр буюу замын баруун гар талд байрлаж хөделгөөний тухайн чиг дэх эгнээний

тоог мэдээлэх бөгөөд эгнэх тус бүрээс уг уулзвараар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заана.

5.10.б тэмдэг нь эгнээний харалдаа зорчих хэсгийн дээр байрлаж уг эгнээнээс тухайн уулзвараар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заана.

5.10.а,б тэмдгийн зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн сум бүхий захын (зүүн гар талын) эгнээнээс буцаж эргэхийг зөвшөөрнө.

Тэмдгийг уулзварын шууд өмнө болон байр эзлэх боломж бүхий зайд байрлуулна.

Тэмдэг дэх сумны чигийг тухайн уулзвар дээрх хөдөлгөөний шаардлагатай чигт нийцүүлсэн байна;

5.11.а,б "Эгнээгээр явах хөдөлгөөний чиг" - тухайн зорчих хэсгийн эгнээний тоог болон эгнээ тус бүрийн хөдөлгөөний урсгалын чигийг мэдээлнэ. 5.11.а тэмдэгт аль нэг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглосон тэмдэг дүрсэлсэн байвал тухайн эгнээгээр уг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглоно.

5.11.а,б тэмдгийг уулзварын цаана буюу замын тухайн онцлог хэсгийн эхлэлд байрлуулна.

Тэмдэгт гурваас олон эгнээтэй (эсрэг хөдөлгөөнтэй) зорчих хэсгийн хөдөлгөөний чигийг заасан байж болно;

5.12.а,б "Эгнээний эхлэл" - нэг чигт явааг эгнээний тоо нэмэгдэж байгааг мэдээлнэ:

5.12.а тэмдэгт 4.7 "Хурдны доод хязгаарлал" тэмдгийг дүрсэлсэн байвал уг тэмдэгт зааснаас илүү хурдтай явах боломжгүй тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөнөө зөвхөн нэмэгдэж буй эгнээгээр үргэлжлүүлнэ;

5.13.а,б "Эгнээний төгсгөл" - нэг чигт явааг эгнээний тоо хасагдаж байгааг мэдээлнэ;

5.14 "Буцаж эргэх газар" - зүүн гар тийш эргэхийг хориглоно;

5.15 "Зогсоол";

5.16.а,б "Явган хүний гарц" - зорчих хэсгээр явган зорчигч хөндлөн гарах газрыг мэдээлнэ. Явган хүний гарц нь тэмдэглэлгүй бол 5.16.б тэмдгийг замын баруун гар талд гарцын шууд өмнө, 5.16.а тэмдгийг замын зүүн гар талд гарцын цаана байрлуулна;

5.17.а,б,в,г "Явган хүний гарам" - явган зорчигч зорчих хэсгийн доогуур ба дээгүүр хөндлөн гарах газрыг мэдээлнэ;

5.18 "Тохиромжтой хурд" - замын тухайн хэсэг дэх хөдөлгөөний хурдны тохиромжтой хэмжээг мэдээлэх бөгөөд үйлчлэх хүрээ нь дараагийн уулзвар хүртэл байна. Харин анхааруулах тэмдгийн хамт байрлуулсан бол үйлчлэх хүрээ нь тухайн аюул бүхий хэсгийн үргэлжлэх зайгаар тодорхойлогдоно;

5.19.а,б,в "Мухар зам";

5.20.а,б,в "Ачааны автомашины хөдөлгөөний тохиромжтой чиг" - хөдөлгөөн нь аль нэг чигт хориглогдсон уулзвараар ачааны автомашин болон трактор, өөрөө явдаг машин, механизмын хөдөлгөөнөө үргэлжлүүлэхэд тохиромжтой чигийг мэдээлнэ;

5.21.а,б "Чигийн урьдчилсан заалт" - суурин газар буюу бусад объектод хүрэх чигийг урьдчилан мэдээлнэ. Тэмдэгт чиглэлийн дугаар (5.26.а тэмдгийн дүрс), тууш зам, нисэх буудлын болон тухайн объектын таних тэмдгийг дүрсэлсэн байж болно.

5.21.а тэмдгийн доод хэсэгт уг тэмдгээс тухайн уулзвар буюу хурд хасах эгнээний эхлэл хүртэлх зайг заана.

5.21.б тэмдэг нь хөдөлгөөний зөвхөн нэг чигийг мэдээлнэ;

5.22.а,б "Чигийн заалт" - суурин газар буюу бусад объектод хүрэх чигийг мэдээлнэ. Тэмдэгт тухайн суурин газар буюу объект хүртэлх зайг (километрээр) зааж болох бөгөөд тууш зам, нисэх буудлын болон тухайн объектын таних тэмдгийг дүрсэлсэн байж болно;

5.23 "Зайн заалт" - зам (чиглэл)-ын дагуухь суурин газар хүртэлх зайг (километрээр) мэдээлэх бөгөөд хамгийн ойр орших суурин газрын нэрийг дээд талд нь бичнэ;

5.24 "Объектын нэр" - гол мөрөн, нуур, түүхийн дурсгалт газар зэрэг (суурин газраас бусад) объектын нэр;

5.25 "Километрийн заалт" - тухайн замын эхнээс тэмдэг хүртэлх зайг километрээр мэдээлнэ. Уг тэмдгийг километр бүрийн төгсгөлд байрлуулна;

5.26.а,б "Чиглэлийн дугаар" - 5.26.а тэмдэг нь зам (чиглэл)-ын дугаарыг мэдээлэх бөгөөд уг замд байрлана. 5.26.б тэмдэг нь зам (чиглэл)-ын дугаар болон чигийг урьдчилан мэдээлэх бөгөөд уулзварын өмнө байрлана;

5.27.а,б,в "Тойрч гарах бүдүүвч" - 5.27.а тэмдэг нь хөдөлгөөнд түр хориглолт тогтоосон замын хэсгийг тойрч гарах чиглэлийг мэдээлнэ.

5.27.б,в тэмдгүүд нь тусгаарлах зурвастай замын түр хориглолт тогтоосон зорчих хэсгийг тойрч гарах чиглэлийн эхлэл ба төгсгөлийг мэдээлнэ;

5.28.а,б,в "Тойрох чиг" - хөдөлгөөнд түр хориглолт тогтоосон замын хэсгийг тойрч гарах чигийг мэдээлнэ;

5.29 "Зогс-шүгам" - гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохиогоор тээврийн хэрэгслийн зогсох газрыг мэдээлнэ;

5.30 "Хороолол" - хорооллын доторхи хөделгөөний журмыг баримтлах нутаг дэвсгэр;

5.31 "Хорооллын төгсгөл" - 5.30 тэмдгээр тэмдэглэгдсэн нутаг дэвсгэрээс гарч байгааг мэдээлнэ;

5.32 "Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал";

5.33 "Таксийн зогсоол" - суудлын болон ахуй үйлчилгээний таксийн зогсоолын байршлыг мэдээлнэ;

5.34 "Хүн эмнэлэг";

5.35 "Шатахуун түгээгүүр";

5.36 "Техникийн үйлчилгээний газар";

5.37 "Автомашины угаалга";

5.38 "Телефон";

5.39 "Хоолны газар";

5.40 "Худаг ус";

5.41 "Зочид буудал";

5.42 "Жуулчны байр";

5.43 "Хот айл";

5.44 "Амрах газар";

5.45 "Замын цагдаагийн харуул".

18. Суурин газрын гадна байрласан 5.21.а,б, 5.22.а,б тэмдэгт тууш замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг ногоон дэвсгэр дээр, бусад замаар явж хүрэх бол цэнхэр дэвсгэр дээр бичнэ. Суурин газрын дотор байрласан 5.21.а,б, 5.22.а,б тэмдэгт тууш замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг ногоон дэвсгэр дээр, уг суурин газраас гарч бусад замаар явж хүрэх бол цэнхэр дэвсгэр дээр, тухайн суурин газрын дотор орших объектын нэрийг цагаан дэвсгэр дээр тус тус бичнэ.

19. 5.5, 5.6, 5.23-5.26.б тэмдгүүд нь тууш замд байрласан бол ногоон, бусад замд байрласан бол цэнхэр өнгийн дэвсгэртэй байна.

20. 5.21.а, 5.27.а тэмдэгт хөделгөөний горим буюу чиглэлийн онцлогийг харуулах зорилгоор бусад тэмдгийн дурсийг байрлуулсан байж болно.

Зургаа. Нэмэлт тэмдэг

21. Нэмэлт тэмдгийг бусад тэмдэгтэй хамт тавьж тэдгээрийн утгыг тодруулна:

6.1.а,б,в,г "Объект хүртэлх зай":

6.1.а - тэмдгээс замын дагуухь ахуй бүхий хэсэг буюу хөделгөөнд хязгаарлалт тогтоосон хэсэг, эсвэл объект хүртэлх зайг заана.

6.1.б - суурин газрын гаднахь замд 3.5 тэмдгийг чуулзварын шууд өмнө байрлуулсан үед 3.4 тэмдгээс уг чуулзвар хүртэлх зайг заана.

6.1.в,г - замаас зайдуу байрласан объект хүртэлх зайг заана;

6.2.а,б,в,г,д,е "Үйлчлэх хүрээ" - 6.2.а тэмдэг нь 1.9-1.14, 1.18, 1.20-1.27 тэмдгээр анхааруулсан ахуун бүхий хэсгийн үргэлжлэх зайг, 2.16, 2.20, 2.22, 2.24, 2.26 буюу мөн 5.15, 5.18 тэмдгүүдийн үйлчлэх хүрээг заана.

6.2.б,в,г,д,е тэмдэг нь 2.27, 2.28 тэмдгийн үйлчлэх хүрээг заана;

6.3 а,б,в "Үйлчлэх чиг" - уулзвар, гарцын өмнө байрласан тэмдгийн үйлчлэх чигийг заана;

6.4.а,б,в,г,д,е,ж "Тээврийн хэрэгслийн төрөл" - тухайн тэмдэгт ямар төрлийн тээврийн хэрэгсэлд хамаарахыг заана:

6.4.а - бүх жин нь 3.5 тонноос их ачаатай автомашин;

6.4.б - чиргүүлтэй бүх төрлийн тээврийн хэрэгсэл;

6.4.в - суудлын автомашин буюу бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачаатай автомашин;

6.4.г - жолоочоос гадна 8-аас илүү хүний суудалтай хүн тээвэрлэхэд зориулсан автомашин;

6.4.д - трактор, өөрөө явдаг машин, механизм;

6.4.е – мотоцикль;

6.4.ж - унадаг дугуй, мопед;

6.5.а,б,в,г,д,е,ж "Үйлчлэх хугацаа" - тэмдгийн хүчинтэй байх хугацааг заана:

6.5.а - бямба, ням гариг буюу баяр, амралтын өдөр;

6.5.б - ажлын өдөр;

6.5.в – гариг;

6.5.г – цаг;

6.5.д,е,ж - өдөр (гариг) ба цаг;

6.6.а,б,в,г,д,е,ж,з,и "Тээврийн хэрэгслийг зогсоолд тавих хэлбэр" - 6.6.а тэмдэг нь 5.15 тэмдэг бүхий зогсоолд бүх төрлийн тээврийн хэрэгслийг явган хүний замын хашлаганд шахаж зорчих хэсэг дээр зогсоохыг, 6.6.б - 6.6.и тэмдэг нь 5.15 тэмдэг бүхий зогсоолд суудлын автомашин, мотоциклийг зорчих хэсэгтэй хилэгсэн явган хүний зам дээр буюу түүний хашлагыг нууулж (шахаж) зогсоохыг заана;

6.7 "Хөделгүүрийг унтрааж зогсоох" - 5.15, 5.44 тэмдэг бүхий зогсоолд тээврийн хэрэгслийн хөделгүүрийг унтрааж зогсоохыг заана;

6.8 "Төлбөртэй үйлчилгээ" - үйлчилгээ нь зөвхөн бэлэн мөнгөөр тооцоо хийдэг болохыг заана;

6.9 "Удаан зогсохыг зөвшөөрөх хугацаа" - 5.15 тэмдэг бүхий зогсоолд тээврийн хэрэгслийн удаан зогсохыг зөвшөөрөх хугацааны дээд хэмжээг заана;

6.10 "Автомашинд үзлэг хийх газар" - 5.15, 5.44 тэмдэг бүхий зогсоолын талбай нь мордмол тавцан буюу үзлэгийн суваттай болохыг заана;

6.11 "Тахир дутуу хүн" - 5.15 тэмдэг бүхий зогсоол нь зөвхөн "Тахир дутуу хүн" таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэлд хамаарахыг заана;

6.12 "Гол замын чиг" - уулзвар дээрх гол замын чигийг заана. 3.1, 3.4, 3.5 тэмдэгтэй хамт байрлуулна;

6.13 "Бүх жингийн хязгаарлал" - бүх жин нь тэмдэгт зааснаас илүү тээврийн хэрэгсэлд тухайн тэмдэг хамаарахыг заана;

6.14 "Эгнээ" - гэрлэн дохио, тэмдгийн үйлчлэх эгнээг заана;

6.15 "Хараагүй хүн" - хараагүй хүмүүс зам хөндлөн гарах гарцыг заах бөгөөд 1.17, 5.16. а,б тэмдэгтэй хамт байрлуулна;

6.16.а,б "Зорчих хэсгийн гадаргуугийн байдал" - 6.16.а тэмдэг нь зорчих хэсгийн гадаргуу нойтон үед, 6.16.б тэмдэг нь цастай буюу мөстсөн үед тухайн тэмдэг хүчинтэй байхыг заана.

22. Замын нөхцөл, байдлыг илүү мэдэхэд нь жолоочид туслах зорилгоор ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй бусад мэдээлэх болон нэмэлт тэмдэг хэрэглэж болно. Иймэрхүү тэмдгийг цэнхэр дэвсгэр дээр цагаан өнгөөр хийнэ.

23. Байнгын тэмдгээс зөрүү утга бүхий түр тэмдэг байрлуулсан байвал түр тэмдгийг бариматлна. Түр тэмдэг нь суурьтай (зөөврийн) байна.

Долоо. Хэвтээ тэмдэглэл

24. Замын хөдөлгөөнд тодорхой горим, журам тогтоох зорилгоор зорчих хэсэг буюу түүний хашлага дээр хийсэн шугам, сум, бичлэг зэрэг нь хэвтээ тэмдэглэлд хамаарна. Хэвтээ тэмдэглэлийг дангаар нь буюу тэмдэг, гэрлэн дохиотой хослуулан хэрэглэнэ.

Шар өнгийн 7.4, 7.9, 7.17 тэмдэглэлээс бусад хэвтээ тэмдэглэл нь цагаан өнгөтэй байна.

7.1 – хоёр буюу гурван эгнээгээр зорчдог замд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах, мөн замын аюул бүхий хэсэгт эгнээний хилийг заах, түүнчлэн зорчих хэсгийн орохыг хориглосон хэсгийг хязгаарлах буюу тээврийн хэрэгслийн зогсоолын хилийг тэмдэглэнэ;

7.2 (үргэлжилсэн өргөн шугам) - зорчих хэсгийн захыг тэмдэглэнэ;

7.3 - дөрөв буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлана;

7.4 - түр зогсохыг хориглосон газрыг тэмдэглэх бөгөөд дангаар нь буюу 2.27 тэмдэгттэй хамтруулан зорчих хэсгийн зах болон хашлага дээр хийнэ;

7.5 (тасархай шугамын нэг зураасын урт нь тэдгээрийн хоорондын зайнаас гурав дахин бага) - хоёр буюу гурван эгнээгээр зорчдог замд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах, нэг чигт хоёр буюу түүнээс олон эгнээгээр зорчдог замд эгнээний хилийг заана;

7.6 (тасархай шугамын нэг зураасын урт нь тэдгээрийн хоорондын зайнаас гурав дахин их) - хөдөлгөөний дагуу буюу эсрэг урсгалыг тусгаарласан 7.1, 7.10 тэмдэглэлд ойртож байгааг анхаарууулна;

7.7 (тасархай шугамын нэг зураасын урт нь тэдгээрийн хоорондын зайтай тэнцүү) - уулзвар дээрх хөдөлгөөний эгнээг тэмдэглэнэ;

7.8 (тасархай өргөн шугам) - хурд авах буюу хурд хасах эгнээний хилийг заана;

7.9 - удаан зогсохыг хориглосон газрыг тэмдэглэх бөгөөд дангаар нь буюу 2.28 тэмдэгттэй хамтруулан зорчих хэсгийн зах болон хашлага дээр хийнэ;

7.10 - хөдөлгөөний дагуу буюу эсрэг урсгалыг тусгаарлана. Зөвхөн аль нэгээс нь байр эзлэхийг зөвшөөрсөн зэрэгцээ эгнээнүүдийн хоорондох хил, зөвхөн аль нэг талын урсгалаас эсрэг тал руу ороход зориулсан газар, зөвхөн аль нэг талаас нь орох, гарахыг зөвшөөрсөн гарцыг тэмдэглэнэ;

7.11 "Зогс-шугам" - гэрэл буюу зохицуулагчийн хориглосон дохио эсвэл 3.5 тэмдгийн заалтыг биелүүлэхийн тулд тээврийн хэрэгсэл зогсох газрыг тэмдэглэнэ;

7.12 - хөндлөн замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөх (3.4 тэмдгийн заалтыг биелүүлэх)-ийн тулд зогсох газрыг тэмдэглэнэ;

7.13.а,б "Явган хүний гарц" - зорчих хэсгээр явган зорчигч хөндлөн гарах газрыг тэмдэглэнэ:

7.13.а - явган хүний зохицуулдаггүй гарцын тэмдэглэл (энэ тэмдэглэлд явган зорчигчийн хөдөлгөөний чигийг сумаар заасан байж болно)

7.13.б - явган хүний зохицуулдаг гарцын тэмдэглэл;

7.14 "Аюулгүйн зурвас" - гэрэл буюу зохицуулагчийн дохио өөрчлөгдөх үед зорчих

хэсгийг хөндлөн гарч амжаагүй явган зорчигч дараагийн зөвшөөрөх дохиог хүлээх газрыг тэмдэглэнэ. 7.13.б тэмдэглэлтэй хамт хэрэглэнэ;

7.15 - унадаг дугуйн зам зорчих хэсэгтэй огтлолцсон хэсгийг тэмдэглэнэ;

7.16.а,б,в - хөдөлгөөний урсгал нийлэх буюу салах газарт үлдэх зай, чигийг тэмдэглэнэ:

7.16.а - эсрэг урсгалыг тусгаарласан зай

7.16.б - нэг чигийн урсгал салж байгаа хэсгийг тусгаарласан зай

7.16.в - нэг чигийн урсгал нийлж байгаа хэсгийг тусгаарласан зай;

7.17 - чиглэлийн тэзврийн хэрэгслийн буудал, таксийн зогсоолыг тэмдэглэнэ. 5.32 буюу 5.33 тэмдэгтэй хамт хэрэглэнэ;

7.18 "Чиг заагч сум" - тухайн эгнээнээс уулзвар нэвтрэх зөвшөөрсөн чигийг заана. Дангаар нь буюу 5.10.а,б тэмдэгтэй хамт хэрэглэнэ. Зүүн гар тийш эргэхийг зөвшөөрсөн сум бүхий захын (зүүн гар талын) эгнээнээс буцаж эргэхийг зөвшөөрнө;

7.19 "Чиглүүлэгч сум" - зорчих хэсэг нарийсаж (тухайн чигт эгнээний тоо цөөрч) байгааг буюу эсрэг урсгалыг тусгаарласан 7.1, 7.10 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна. 1.15.а,б,в тэмдэгтэй хамт хэрэглэж болно;

7.20 - нь 7.12 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна. Гүрвалжны орой нь хөдөлгөөний урсгалын эсрэг чигласэн байна;

7.21 "Зогс-бичлэг" - 3.5 тэмдэгтэй хамт хэрэглэсэн 7.11 тэмдэглэлд ойртож байгааг анхааруулна;

7.22 - зам (чиглэл)-ын дугаарыг тэмдэглэх бөгөөд дангаар нь буюу 5,26.а,б тэмдэгтэй хамт хэрэглэнэ.

25. 7.2 тэмдэглэлийг жолооч зогсохын тулд давахаас бусад тохиолдолд 7.1-7.3, 7.14, 7.16.а,б,в тэмдэглэлүүдийг давахыг хориглоно.

7.5-7.8 тэмдэглэлийг аль ч талаас нь давахыг зөвшөөрөх бөгөөд харин дээгүүр нь унуулж явахыг хориглоно.

7.10 тэмдэглэлийг зөвхөн тасархай шугамтай талаас нь давахыг зөвшөөрнө. Харин гүйцэж түрүүлэх буюу тойрон гарах үйлдэл хийж дуусах үедээ үргэлжилсэн шугамтай талаас нь давахыг хориглохгүй.

26. 7.4, 7.9 болон зогсоолын хилийг тэмдэглэсэн 7.1 тэмдэглэлийн үзэгдэлтийг сайжруулах (хэмжээг тодотгох) зорилгоор шугамын эхлэл, төгсгөлд хөндлөн богино зураас татаж болно.

27. Зорчих хэсэгт хөдөлгөөний нөхцөл, байдлыг баримжаалахад нь жолоочид туслах зорилгоор ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй тэмдэглэл хийж болно.

28. Замын тухайн хэсэгт байрлуулсан тэмдэг ба тэмдэглэлийн утга хоорондоо зөрж байвал тэмдгийн эзэлтэй баримтална.

Найм. Босоо тэмдэглэл

29. Замын байгууламж болон элементүүдийн овор хэмжээг тодотгох, зорчих баримжаа олгох зорилгоор замын хашлага, шон, хашилт, бусад байгууламж дээр хийгдсэн хар ба цагаан хосолсон шугам, зураас зэрэг нь босоо тэмдэглэлд хамаарна.

8.1 - тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй замын байгууламжийн босоо хэсэг (гүүрийн тулгуур, усны хоолой, хонгилын нүүрэн тал гэх мэт)-ийг тэмдэглэнэ;

8.2 - гүүр, хонгил зэрэг замын байгууламжийн доогуур гарах үед уг байгууламжид шүргэж болзошгүй хэсгийг тэмдэглэнэ;

8.3 - тусгаарлах зурвас буюу аюулгүйн арал дээр байрласан тэмдгийн дугуй суурийг тэмдэглэнэ;

8.4 - замын дагуу байрласан чиглүүлэгч шон, хашилтын тулгуур зэргийг тэмдэглэнэ;

8.5 - эргэх радиус багатай, эгц уруу, нурж болзошгүй зэрэг аюул бүхий хэсэг дэх замын хашилтын хажуу гадаргууг тэмдэглэнэ;

8.6 - замын бусад хэсэг дэх хашилтын хажуу гадаргууг тэмдэглэнэ;

8.7 - замын аюул бүхий хэсгийн хашлагыг тэмдэглэнэ.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ЭВДРЭЛ, ГЭМТЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨРЧИЛ

Энэ хавсралтад заагдсан эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилтэй автомашин, чиргүүл, мотоцикль, мопед, трактор болон өөрөө явдаг машин, механизмыг ашиглахыг хориглоно:

1.Тоормосны систем

1.1. Ажлын тоормосны системийн идэвхжил нь туршилтын үед доорхи шаардлагыг хангаж чадахгүй байх:

Тээврийн хэрэгслийн төрөл	Тоормосны зам (метр), ихгүй байх		Удаашралт (м/сек²), багагүй байх	
	чиргүүлгүй	чиргүүлтэй	чиргүүлгүй	чиргүүлтэй
Суудлын автомашин буюу түүний ачаа тээвэрлэхэд зориулсан төрөл	12.2	13.6	6.8	5.9
Бүх жин нь 5 тонн хүртэлх автобус (5 тонн орно)	13.6	15.2	6.8	5.7
Бүх жин нь 5 тонноос их автобус	16.8	18.4	5.7	5.5
Бүх жин нь 3.5 тонн хүртэлх ачааны автомашин (3.5 тонн орно)	15.1	17.7	5.7	4.6
Бүх жин нь 3.5-12 тонн хүртэлх ачааны автомашин (12 тонн орно)	17.3	18.8	5.7	5.5
Бүх жин нь 12 тонноос их ачааны автомашин	16	18.4	6.2	5.5
Хоёр дугуйтай мотоцикль, мопед	7.5	-	5.5	-
Шаахайтай мотоцикль	8.2	-	5	-

Тайлбар: Туршилтыг тэгш, хуурай, хатуу хучилттай зам дээр автомашин, автобусыг цагт 40 км, мотоцикль, мопедыг цагт 30 км хурдтай явуа уед жолооч тоормосны дарвөн дээр нэг удаа гишгэх замаар гүйцэтгэнэ. Туршилтын уед тээврийн хэрэгслийн бодит жин нь түүний бүх жингээс хэтрэзгүй байвал зохино.

Тоормосны системийн идэвхжилийг тусгай зориулалтын тоног төхөөрөмж дээр шалгаж болно.

1.2. Шингэн дамжуулгатай тоормосны системийн битүүмж алдагдсан;

1.3. Хийн буюу хий-шингэн дамжуулгатай тоормосны системийн даралт хэмжүүр ажиллахгүй болсон;

1.4. Хийн буюу хий-шингэн дамжуулгатай тоормосны системийн битүүмж алдагдсанаас (хөдөлгүүрийг унтраасны дараа) хийн бүрэн даралтын хэмжээ 15 минутын хугацаанд 0.05 МПа (0.5 кг/см²)-аар буюу түүнээс илүү хэмжээгээр буурсан;

1.5. Зогсоолын тоормос дор дурдсан өгсүүр буюу уруу газарт тээврийн хэрэгслийг тогтоон барьж чадахгүй болсон:

- 16 %-д бүрэн ачаалагдсан тээврийн хэрэгслийг;
- 23 %-д ачаагүй суудлын автомашин, автобусыг;
- 31 %-д ачаагүй ачааны автомашиныг.

Тайлбар: Зогсоолын тоормосны идэвхжилийг шалгах уедээ хедөлгүүрийн ачааллыг хүч дамжуулах ангиас салгасан байвал зохино.

1.6. Тоормосны системийн эд ангиудын хийцийг өөрчилсөн.

2. Жолооны механизм

2.1. Жолооны механизмын бэхэлгээ эвдэрсэн, холбоосны суп хөдөлгөөн ихэссэн;

2.2. Үйлдвэрээс хийгдсэн хүчлүүр (мотоциклийн хувьд зөөллүүр) ажиллахгүй буюу байхгүй болсон;

2.3. Жолооны хүрдний сул эргэлтийн хэмжээ дор дурдсанаас илүү болсон;

Тээврийн хэрэгслийн төрөл	Жолооны хүрдний сул эргэлт (градус)
Суудлын автомашин буюу түүний явах ангид суурилуулсан төрөл	10
Автобус, троллейбус	20
Ачааны автомашин	25

2.4. Жолооны механизмын эд ангиудын хийцийг өөрчилсөн.

3. Дугуй

3.1. Дугуйн хээний гүн нь газарт тулах хэсгээрээ суудлын автомашинд 1.6 мм, ачааны автомашинд 1 мм, автобус, троллейбусанд 2 мм, мотоцикль, мопедонд 0.8 мм-ээс бага болсон;

Тайлбар: Чиргүүлийн дугуйн хээний гүн нь чиргэчийн дугуйн хээний тогтоосон хэмжээтэй адил байна.

3.2. Дугуй нэвт цоорсон, утаснууд нь тасарсан;

3.3. Дугуйн хэмжээ, даац нь тээврийн хэрэгслийн тухайн төрөлд тохироогүй;

3.4. Дугуйн булны бэхэлгээ сул, найдваргүй бэхлэгдсэн, дугуйн цоожлох цагираг гэмтсэн, буруу тавигдсан;

3.5. Нэг тэнхлэгт өөр марк, хэзтэй дугуй тавьсан.

4. Хөдөлгүүр, хүч дамжуулах анги

4.1. Хөдөлгүүрийн утаа, түүний найрлага дахь хорт хийн хэмжээ улсын стандартад заасан хязгаараас хэтэрсэн;

4.2. Тэжээлийн системийн битүүмж алдагдсан, шатах, тослох материал гоожсон;

4.3. Яндан, дуу намсгуур ажиллахгүй буюу байхгүй болсон;

4.4. Хурдны хайрцгийн араа хүндрэлтэй залгагддаг, өөрөө салдаг;

4.5. Кардан гол цавтай, савлагаатай.

5. Гэрэлтүүлэх хэрэгсэл

5.1. Гэрлийн тоо, хэлбэр, өнгө, байрлал, ажиллах горим нь тухайн тээврийн хэрэгслийн хийцэд тохироогүй;

5.2. Хол, ойрын гэрлийн тусгалын тохироо алдагдсан;

5.3. Гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл, эргэх дохио бохирдсон, асахгүй буюу бүдэг асдаг;

5.4. Үйлдвэрээс тавьсан гэрэл ойлгуур байхгүй буюу бохирдсон;

5.5. Гэрэлтүүлэг, дохиоллын системийн унтраалга, шилжүүлүүр гэмтсэн.

Тайлбар: Тээврийн хэрэгслийн урд талд улаан, ар талд цагаан өнгийн гэрэл (ухрах арааны болон улсын дугаарын гэрлээс бусад) буюу гэрэл ойлгуур тавихыг хориглоно.

6. Бусад төхөөрөмж

6.1. Хурд хэмжүүр ажиллахгүй болсон;

6.2. Дуут дохио ажиллахгүй болсон;

6.3. Шил арчуур, цан үлээгүүр ажиллахгүй болсон;

6.4. Хаалга, тэвшний цоож түгжээ эвдэрсэн, гүйцэд хаагдаж, нээгдэхгүй болсон;

6.5. Ар талаа харах толь, салхины шил, нарны хаалтгүй болсон;

6.6. Үйлдвэрээс тавьсан хамгаалах бүс, суудлын дэр байхгүй буюу шаардлага хангахгүй болсон;

6.7. Мотоцикль, мопедод зориулалтын гишгүүр, зорчигчийн барих бариул байхгүй болсон;

6.8. Чиргүүлийн холбоос эвдэрсэн, хамгаалалтын гинжин таталга байхгүй буюу гэмтсэн;

6.9. Тэвшний шал цөмөрсөн, бухээг, тэвшний гадна хэсэг их хэмжээгээр эвдэрсэн буюу өнгө үзэмж нь илт муудсан;

6.10. Автобус, троллейбус, суудлын буюу ачааны автомашин, дугуйт трактор эмийн сан, гал унтраагуур, ослын зогсолтын тэмдэг байхгүй;

6.11. Шаврын хаалтгүй;

6.12. Бухээгний шилэн дээр юм бичсэн, зураг наасан, хөшиг татсан, цацаг унжуулсан, салхины шил нь их хэмжээгээр цуурсан, бохирдсон зэргээс жолоочийн харах боломжийг хязгаарласан;

Тайлбар: Салхины шилний дээд хэсэгт өнгөт, тунгалаг хальс нааж болно. Мөн гэрэл бууруулагчтай (толины хэсгээс бусад хэсэгт) шил ашиглаж болох бөгөөд шилний гэрэл нэвтрүүлэх чадвар нь салхины шилэнд 75%, урд хаалганы шилэнд 70%, бусад шилэнд 60%-иас багагүй байвал зохино.

6.13. Автобус, троллейбусны хаалга нээх, хаах хэрэгсэл ажиллахгүй болсон, хаалгаа харах толигүй буюу толио буруу тавьсан;

6.14. Түлшний түвшин заагуур ажиллахгүй болсон;

6.15. Бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин буюу бүх жин нь 5 тонноос их автобусанд ивүүр байхгүй (хоёроос цөөнгүй).

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар хавсралт

ИРГЭН, АЛБАН ТУШААЛТНЫ ҮҮРЭГ

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа механикжсан тээврийн хэрэгсэл (троллейбусаас бусад) болон чиргүүл нь Замын цагдаагийн албанаас олгосон улсын дугаарын тэмдэгтэй байхаас гадна улсын дугаарын тоо, үсгийг ачааны автомашин, чиргүүл (суудлын автомашины чиргүүлээс бусад)-ийн хоёр хажуу болон ар талд, автобус (бага оврын автобусаас бусад)-ны ар талд үндсэн өнгөөс ялгарах өнгөөр бичсэн байна.

Үсгийн өндөр нь 200 мм, өргөн нь 80 мм, зураасны өргөн нь 20 мм, тооны өндөр нь 300 мм, өргөн нь 120 мм, зураасны өргөн нь 30 мм байна.

2. Тээврийн хэрэгслийн таних тэмдгийг хэрэглэх тохиолдол:

"Чиргүүлтэй тээврийн хэрэгсэл" - хоорондоо 150-300 мм-ийн зайтай байрлах улбар шар өнгийн гурван гэрэл. Энэ таних тэмдгийг чиргүүлтэй ачаалуу автомашин, дугуйт трактор, үгсраа автобус буюу троллейбусны бүхээг дээр хөндлөн байрлуулна;

"Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл" - улаан хүрээтэй, шар өнгийн дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 250 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь нэг талын хэмжээний 1/10-тэй тэнцүү) дотор хар өнгөөр 1.18 тэмдгийн дотрхи дүрсийг зурна. Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх автобус, ачаалуу автомашины урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна;

"Сургалтын тээврийн хэрэгсэл" - улаан хүрээтэй, цагаан өнгийн дэвсгэр бүхий тэнцүү талт гурвалжин (нэг талын урт нь 200 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь гурвалжны талын 1/10-тэй тэнцүү) дотор "С" үсгийг хараар бичнэ. Жолоодлогын дадлага хийх тээврийн хэрэгслийн урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна.

Жич: Ар, өвөр талдаа дүрслэгдсэн тэмдгийг суудлын автомашины бүхээг дээр байрлуулж болно;

"Хүрдны хязгаар" - улаан хүрээтэй, цагаан өнгийн дэвсгэр бүхий дугуй (голч нь 160 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь голчийн 1/10-тэй тэнцүү) дотор зөвшөөрөгдсөн хүрдны дээд хэмжээг хараар бичнэ. Хүүхдийг зохион байгуулалттайгаар тээвэрлэх, хүнд буюу овор ихтэй, мөн аюултай ачаа тээвэрлэх, түүнчлэн техникийн дээд хүрд нь замын хөдөлгөөний дүрмийн 9.3-т заасан хэмжээнд хүрэхгүй механикжсан тээврийн хэрэгслийн зүүн ард энэ таних тэмдгийг тавьж анхаарууллж болно;

"Аюултай ачаа" - 700х300 мм хэмжээтэй (15 мм өргөн хар хүрээтэй) тэгш өнцөгтийн баруун талын 400 мм урттай хэсгийг улбар шараар, үлдсэн зүүн талын хэсгийг цагаанаар будна. Тэмдэгт тээвэрлэж яваа ачааны онцлогийг тодорхойлсон тэмдэглэл хийнэ;

"Овор ихтэй ачаа" - улаан, цагаан ташуу зураас хосолсон (зураасын өргөн нь 50 мм) 400х400 мм хэмжээтэй байна;

"Урт тээврийн хэрэгсэл" - улаан хүрээтэй (өргөн нь 40 мм), шар өнгийн дэвсгэр бүхий 1200х300 мм хэмжээтэй тэгш өнцөгт дотор тухайн тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний нийт уртын хэмжээг хараар бичнэ. Ачаатай буюу ачаагүй нийт урт нь 20 метрээс илүү, мөн хоёр буюу түүнээс олон чиргүүлтэй тээврийн хэрэгслийн ард энэ таних тэмдгийг байрлуулна. Энэ хэмжээний тэмдгийг байрлуулах боломжгүй бол 600х300 мм хэмжээтэй хоёр тэмдгийг тээврийн хэрэгслийн ард тэгш хэмтэйгээр байрлуулж болно;

"Тахир дутуу хүн" - шар дэвсгэр бүхий дөрвөлжин (нэг талын урт нь 150 мм) дотор хар өнгөөр 6.11 тэмдгийн дотрхи дүрсийг зурна. Тахир дутуу хүн жолоодож явах буюу тахир дутуу хүн тээвэрлэж явах автомашины урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна;

"Дүлий жолооч" - Шар өнгийн дэвсгэр бүхий дугуй (голч нь 160 мм) дотор 45 мм-ийн голчтой хар өнгийн гурван дугуй дүрсийг адил талт гурвалжин (орой нь доош харсан)-гийн оройнуудад харгалзах байдлаар байрлуулна. Сонсгол муутай буюу дүлий хүн жолоодож явах механикжсан тээврийн хэрэгслийн урд болон ард энэ таних тэмдгийг байрлуулна;

"Хадаастай дугуй" – улаан хүрээтэй, цагаан өнгийн дэвсгэр бүхий тэнцүү талт гурвалжин (нэг талын урт нь 200 мм-ээс багагүй, хүрээний өргөн нь гурвалжны талын 1/10-тэй тэнцүү) дотор голч нь гурвалжны талын 1/3-тэй тэнцүү хар өнгийн дугуйг байрлуулж түүн дээр "Х" үсгийг цагаанаар бичнэ. Энэ тэмдгийг хадаастай дугуй бүхий механикжсан тээврийн хэрэгслийн ард байрлуулна.

3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, албан тушаалтан дараахь үүргийг хүлээнэ:

а/стандартын шаардлага хангаагүй буюу замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар хавсралтад заасан техникийн гэмтэлтэй, мөн тогтоосон журмын дагуу техникийн улсын үзлэг, тооллогод ороогүй, улсын дугааргүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх;

б/тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхгүй (жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд) буюу түүнчлэн согтуурууллах үндаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх;

в/гинж, ажлынхаа хэрэгслээр замын хэсэг, бусад элементийг эвдэж болзошгүй трактор, өөрөө явдаг машин, механизмыг хатуу хучилттай замаар явуулахгүй байх;

г/засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал, тэжээвэр амьтдыг сруулахгүй байх;

д/механикжсан тээврийн хэрэгслийг өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш 1 сарын дотор, тээврийн

хэрэгслийн марк, зориулалт, өнгө, хөдөлгүүр буюу арлын дугаар өөрчилсөн бол 7 хоногийн дотор Замын цагдаагийн албанд бүртгүүлэх.

4. Зам ашиглалт, хот тохижилтын асуудал эрхэлсэн байгууллагын ажилтан, албан тушаалтан нь зам, төмөр замын гарам буюу замын бусад байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагын дагуу бүрэн бүтэн байлгах, хэрэв эдгээр нь эвдэрсэн буюу замын гадаргуу мөстсөн зэргээс хөдөлгөөнд аюул учирч болзошгүй үед түүнийг нэн даруй засах, цэвэрлүүлэх арга хэмжээ авна.

5. Зам дээр засварын ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, иргэд дараахь үүргийг хүлээнэ:

а/засварын ажил, үйлчилгээ хийж байгаа үедээ хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, 1.20 тэмдэг тавьж анхааруулах, замын тухайн хэсгийг хашиж тусгаарлах, түүнийг тойрч гарах чиг заасан тэмдэг тавих;

б/барилгын материал, тоног төхөөрөмж, ажиллаагүй машин, механизмыг зорчих хэсгээс зайлуулах, хэрэв боломжгүй бол тойрч гарах чиг заасан тэмдэг, харанхуй буюу үзэгдэлт ханталтгүй үед нэмэгдэл улаан гэрэл тавьж анхааруулах;

в/засварын ажил, үйлчилгээг дуусгасны дараа тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын аюулгүй, хэвийн зорчих нөхцөлийг бүрдүүлэх.

6. Барилга, газар шорооны ажил эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан тушаалтан нь хатуу хучилттай зам, төмөр замын гармаар зорчих тээврийн хэрэгслийн дугуйн шавар шавхайг цэвэрлүүлэх, замын гадаргууг бохирдуулахгүй байх арга хэмжээ авна.

7. Дор дурдсан асуудлыг Замын цагдаагийн албатай тохиролцож зөвшөөрөл авна:

а/замын хөдөлгөөнийг зохион байгуулах, хөдөлгөөний чиг, урсгалыг өөрчлөх;

б/замын тэмдэг, тэмдэглэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн байрлалыг өөрчлөх, шинээр тавих, хураах авах;

в/зам, гүүр, талбай, барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах;

г/төмөр замын гарам байгуулах, өөрчлөх буюу хөдөлгөөн зогсоож түүнийг засварлах;

д/чиглэлийн тээврийн хэрэгслийн чиглэл, буудлыг шинээр тогтоох буюу өөрчлөх;

е/замын хөдөлгөөнд саад болох ажил хийх, гэрэл тавих, мод тарих, зүлэгжүүлэх;

ж/замын ойролцоо зурагт самбар, үзүүлэн чимэглэлийн зүйл байрлуулах;

з/зорчих хэсэг, явган хүний зам дээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, үзвэр, үзэсгэлэнгийн зүйл байрлуулах;

и/зам дээр биеийн тамирын бэлтгэл, уралдаан тэмцээн, жагсаал, тоглолт зэрэг үйл ажиллагаа явуулах;

к/жолоодлогын дадлага хийх чиглэл, хугацааг тогтоох;

л/тээврийн хэрэгслийг тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглох.

8. Замын цагдаагийн албаны байцаагч, зохицуулагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/замын хөдөлгөөн зохицуулах дохиог ойлгогдохуйц тодорхой өгч, шуурхай зохицуулан хөдөлгөөний аюулгүй нөхцөлийг ханган;

б/хөдөлгөөнд оролцогчдоос замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хангахтай холбогдсон хууль, дүрэм, журам, стандартыг хэрхэн биелүүлж байгааг хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хууль тогтоомжид заасны дагуу шуурхай шийдвэрлэх;

в/замын байгууламж, зорчих хэсгийн гадаргуу, замын гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, илэрсэн доголдлыг холбогдох байгууллагын ажилтан, албан тушаалтанд мэдэгдэж хэвийн байдалд нь нэн даруй оруулах арга хэмжээ авах;

г/онцгой байдал, нэгдсэн хяналт шалгалт, шуурхай зохицуулалтын ажлаас бусад тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсоох бол очиж шалгаж байх;

д/хөдөлгөөнд оролцогчидтой зөв боловсон харьцах.

9. Замын цагдаагийн албаны байцаагч, зохицуулагчид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/хөдөлгөөнд оролцогчдыг үндэслэлгүйгээр саатуулах;

б/хөдөлгөөнд оролцогчдод хууль бус шаардлага, элдэв болзол тавих, хувийн ажилд тээврийн хэрэгсэл ашиглах.

_____oOo_____

АНХААРУУЛАХ ТЭМДЭГ


1.1 Төмөр замын хаалттай гарам


1.2 Төмөр замын хаалттүй гарам


1.3.а


1.3.б

1.3 Төмөр замын гарам


1.4.а


1.4.б


1.4.в


1.4.г


1.4.д


1.4.е

1.4 Төмөр замын гарамд ойртоно.


1.5 Адил замын уулзвар


1.6 Тойрох хөдөлгөөнтэй уулзвар


1.7 Гэрэл дохионы зохицуулга


1.8.а


1.8.б

1.8 Оцом эргэлт


1.9.а


1.9.б

1.9.Тахир зам


1.10 Эрэг уруу


1.11 Оцом өгсүүр


1.12 Халтиргаатай зам


1.13 Тэгш бишзам


1.14 Хайрга усарсан


1.15.а


1.15.б

1.15 Зам нарийсна


1.15.в


1.16 Эсрэг хөдөлгөөн


1.17 Явган хүний гарц


1.18 Хүүхэд


1.19 Унадаг дугуйн зам ойрхон


1.20 Засварын ажил


1.21 Мал тууж гарах газар


1.22 Ан амьтан


1.23 Чулуунынурангитай


1.24 Хажуугийн салхитай


1.25 Онгоц доогуур нисно


1.26 Хонгил


1.27 Бусад аюултай газар


1.28.а


1.28.б


1.28.в

1.28 Эргэх чиг

ХОРИГЛОХ ТЭМДЭГ


2.1 Орох хориотой


2.2 Хөдөлгөөн хориотой


2.3 Механикжсан тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хориотой



2.4 Ачааны автомашины хөдөлгөөн хориотой


2.5 Мотоциклын хөдөлгөөн хориотой


2.6 Трактрын хөдөлгөөн хориотой


2.7 Чиргүүлтэй Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хориотой


2.8 Ердийн хөсгийн хөдөлгөөн хориотой


2.9 Унадаг дугуйн хөдөлгөөн хориотой


2.10 Явган зорчигчийн хөдөлгөөн хориотой



2.11 Жингийн хязгаарлал



2.12 Тэнхлэгийн ачаалалын хязгаарлал



2.13 Өндрийн хязгаарлал



2.14 Өргөний хязгаарлал



2.15 Уртын хязгаарлал



2.16 Хоорондын зайн доод хязгаарлал



2.17 Гааль


2.18.а Баруун гар тийш эргэх хориотой


2.18.б Зүүн гар тийш эргэх хориотой


2.19 Буцаж эргэх хориотой


2.20 Гүйцэж түрүүлэх Хориотой


2.21 Гүйцэж түрүүлэх хоригоны төгсгөл


2.22 Ачааны автомашинаар гүйцэж түрүүлэх Хориотой


2.23 Ачааны автомашинаар гүйцэж түрүүлэх хоригоны төгсгөл



2.24 Хурдны дээд хязгаарлал



2.25 Хурдны дээд хязгаарлалын төгсгөл



2.26 Дуут дохио хориотой


2.27 Түр зогсох хориотой


2.28 Удаан зогсох хориотой


2.29 Бүх хоригоны төгсгөл

БОСОО ТЭМДЭГЛЭЛ



МЭДЭЭЛЭХ ТЭМДЭГ


5.1 Туш зам


5.2 Туш замын төгсгөл



5.3 Суурин газрын эхлэл



5.5 Суурин газрын эхлэл



5.4 Суурин газрын төгсгөл



5.6 Суурин газрын төгсгөл



5.7 Нэг чигийн хөдөлгөөн


5.8 Нэг чигийн хөдөлгөөний төгсгөл


5.9.а Зүүнээс баруун гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй


5.9.б Баруунаас зүүн гар тийш нэг чигийн хөдөлгөөнтэй



5.10.а


5.10.б

5.10 Эгнээнээс явах хөдөлгөөний чиг


5.11.а


5.11 Эгнээгээр явах хөдөлгөөний чиг


5.11.б


5.12.а



5.12.б

5.12 Эгнээний эхлэл


5.13.а


5.13.б

5.13 Эгнээний төгсгөл


5.14 Буцаж эргэх газар



5.15 Зогсоол


5.16.а


5.16.б

5.16 Явган хүний гарц


5.17.а



5.17.б


5.17.в


5.17.г

5.17 Явган хүний гарам

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТАНИХ ТЭМДЭГ



Чиргүүлтэй тээврийн хэрэгсэл




Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл



Сургалтын тээврийн хэрэгсэл




Хурдны хязгаар



Дөхөлтэй ачаа



Овор ихтэй ачаа



Урт тээврийн хэрэгсэл



Тахир дутуу хүн




Дүлий жолооч



Хадаастай дугуй

НЭМЭЛТ ТЭМДЭГ





5.30 Хороопол



5.31 Хорооллын төгсгөл



5.32 Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал



5.33 Таксийн зогсоол



5.34 Хүн эмнэлэг



5.35 Шатахуун түгээгүүр



5.36 Техникийн уйтчилгээний газар



5.37 Автомашины угаалга



5.38 Телефон



5.39 Хоолны газар



5.40 Ходаг ус



5.41 Зочид буудал



5.42 Жуулчны бэйр



5.43 Хот айл



5.44 Амрах газар



5.45 Замын цэгдээгийн карруул

ХЭВТЭЭ ТЭМДЭГЛЭЛ



7.1 7.2 7.3 7.4 7.5 7.6 7.7 7.8 7.9 7.10




7.11
Зогс-шугам



7.12



7.13.а
Яаган хүний гарц



7.13.б
Яаган хүний гарц



7.14
Акупутүйн луужас



7.15



7.16.а



7.16.б




7.16.в



7.17



7.18
Чиг заагч сум



7.19
Чиглүүлэгч Сум



7.20



7.21
Зогс-бичлэг



7.22

ДАРААЛЛЫН ТЭМДЭГ



3.1 Гол зам



3.2 Гол замын төгсгөл



3.3.а



3.3.б



3.3.в

3.3 Туспах зам нийлэх



3.4 Зам тавьж өгнө



3.5 Зогсохгүй явах хориотой



3.6 Сереғ хөдлөөнд зам тавьж өгнө



3.7 Сереғ хөдлөөнд давуу эрхтэй



5.18 Тохиромжтой хурд


5.19.а


5.19.б


5.19.в

5.19 Мухар зам


5.20.а


5.20.б


5.20.в

5.20 Ачааны автомашины хөдөлгөөний тохиромжтой чиг






5.21.а




5.21.б

5.21 Чигийн урьдчилсан заалт



5.22.а



5.22.б

5.22 Чигийн заалт



5.23 Зайн заалт



5.24 Объектын нэр



5.25 Километрийн заалт



5.26.б



5.26.а

5.26. Чиглэлийн дугаар




5.27.б


5.27.в


5.27. Тойрч гарах будуурч



5.28.а




5.28.б



5.28.в

5.28.Тойрох чиг



5.29.Зогс-шугам

ЗААХ ТЭМДЭГ


4.1.а Чигээрээ явна


4.1.б Баруун гар тийш явна


4.1.в Зүүн гар тийш явна


4.1.г Чигээрээ буюу баруун гар тийш явна


4.1.д Чигээрээ буюу зүүн гар тийш явна


4.1.е Баруун буюу зүүн гар тийш явна


4.2.а


4.2.б


4.2.в

4.2 Сэвдэг тойрч гарах чиг


4.3 Тойрох хөдөлгөөн


4.4 Суудлын автомашин явна


4.5 Унадаг дугуйн зам


4.6 Явган хүний зам



4.7 Хурдны доод хязгаарлал



4.8 Хурдны доод хязгаарлалын төгсгөл

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487
Хэвлэлийн хуудас 8



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (352)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Тариалангийн тухай*
- *Терроризмтой тэмцэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг нэмэгдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 17 №19 (352)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

228. Тариалангийн тухай 428
229. Газрын тухай хуульд, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 433
230. Терроризмтой тэмцэх тухай 434
231. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 438
232. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 438
233. Төрийн нууцын тухай хуульд нэмэлт оруулах тухай 439
234. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай 439
235. Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 439
236. Хэлэлцээр соёрхон батлах тухай 439
237. Гэрээ соёрхон батлах тухай 439
238. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 440
239. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 440

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

240. "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д өөрчлөлт оруулах тухай Дугаар 19 440
241. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд өөрчлөлт оруулах тухай Дугаар 20 440

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

242. Шарапат Тешебаевна Сатымовыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 58 441
243. Н. Чулуунжавыг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 61 441

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

244. Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг нэмэгдүүлэх тухай Дугаар 77 441
245. Төмөр замын дагуухь шилэн кабелийн сүлжээний ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 80 441
246. "100 000 нарны гэр" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 81 442
247. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 82 442

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, үржил шимийг нь хамгаалахтай холбогдон иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тариалангийн тухай хууль тогтоомж

2.1. Тариалангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Газрын тухай хууль[2], Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль[3], Газрын төлбөрийн тухай хууль[4], Ургамал хамгаллын тухай хууль[5], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "тариалангийн газар" гэж тариалангийн үйлдвэрлэл эрхлэх зориулалттай иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан газрыг;

3.1.2. "хөрс" гэж ургамал ургахад тохиромжтой газрын гадаргын өнгөн хэсгийг;

3.1.3. "хөрсний шим тэжээлийн бодис" гэж ургамлын өсөлт, хөгжилтөд шаардагдах хөрсөн дэх химийн бодисыг;

3.1.4. "хөрсний үржил шим" гэж ургамал ургахад шаардагдах чийг, шим тэжээлийн бодис, агаар, дулаан, биологи, физик-химийн орчинг бүй болгогч хөрсний чадавхийг;

3.1.5. "атар газар" гэж судалгаа, шинжилгээний үр дүнд тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж болох нь тогтоогдсон хадлан, бэлчээрийн талбайг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тариалангийн салбарт төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрх

4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

4.1. Засгийн газар тариалангийн салбарт дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. тариалангийн салбарт төрөөс явуулах бодлого, тариалангийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

4.1.2. энэ хуулийн 5.1.4-т заасан тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх саналыг шийдвэрлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.1.3. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журмыг баталж, биелэлтэд нь хяналт тавих;

4.1.4. тариаланг хөгжүүлэх бодлого, хэтийн төлөвлөгөөг батлах;

4.1.5. усалгаатай тариаланг хөгжүүлэх төсөл, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг дэмжих.

5 дугаар зүйл. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

5.1. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. тариалангийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах;

5.1.2. тариалангийн салбарт хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг

[1] Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.
[2] Газрын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.
[3] Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.
[4] Газрын төлбөрийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 5 дугаарт нийтлэгдсэн.
[5] Ургамал хамгаллын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

боловсруулж, түүний хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн удирдлагаар хангах;

5.1.3. улсын хэмжээнд нийт тариалсан, уриншилсан, өнжөөсөн болон аташсан газрын хэмжээ, хураасан ургацын тайланг Засгийн газарт танилцуулах;

5.1.4. энэ хуулийн 7.1.3-т заасан тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндэсэн дээр Засгийн газарт оруулах;

5.1.5. тариаланг хөгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслүүдийг захиалах, үр дүнг ёмчлөх, суртачлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

5.1.6. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах;

5.1.7. тариалангийн салбарт төрөөс баримтлах бодлого, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан тариаланг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг боловсруулах;

5.1.8. газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид тариалангийн газар ашиглуулах хугацаа, хэмжээний талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах;

5.1.9. тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээхтэй холбогдсон журмыг тогтоож мөрдүүлэх.

6 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийнТөлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

6.1. Тариалангийн салбарт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. тариалангийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ тухай Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх;

6.1.2. Засаг даргын өргөн мэдүүлсэн тариаланг хөгжүүлэх аймаг, нийслэлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

6.1.3. энэ хуулийн 7.1.3-т заасан тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх саналыг хэлэлцэж дүгнэлт гаргах.

6.2. Тариалангийн салбарт сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1. Засаг даргын өргөн мэдүүлсэн сум, дүүрэгт тариаланг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг батлах;

6.2.2. тариаланг хөгжүүлэх аймаг, нийслэлийн дунд хугацааны төлөвлөгөөний төсөлд сум, дүүргийн Засаг даргын өгөх саналыг хэлэлцэх;

6.2.3. тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх сум, дүүргийн Засаг даргаас дээд шатны Засаг даргад тавих саналыг хэлэлцэх;

6.2.4. тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу усалгаатай тариалан эрхлэх зориулалтаар уст цэгийн орчимд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад 30 хүртэл га, үр тариа, тэжээлийн ургамал тариалахад 100 хүртэл га атар газрыг Монгол Улсын иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээнд нь зориулж эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх;

6.2.5. атаршсан газрыг услах, бордох зэргээр хөрсийг боловсруулан сайжруулж, хөрөнгө оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд уг газрыг давуу эрхээр эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх.

7.1. Тариалангийн салбарт аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1 тариалангийн тухай хууль тогтоомж болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих;

7.1.2. тариаланг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн тариаланг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг сум, дүүрэг бүрээр боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулж, үр дүнг мэдээлэх;

7.1.3. тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх сум, дүүргийн Засаг даргын саналыг хянаж

нэгтгэн, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

7.1.4. тухайн жилд тариалсан, уриншилсан, өнжөөсөн болон аташсан газар, хураасан үргацын мэдээг сум, дүүрэг бүрээр нэгтгэн дүгнэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх.

7.2. Тариалангийн салбарт сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1 тариалангийн тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

7.2.2. тариаланг хөгжүүлэх аймаг, нийслэлийн дунд хугацааны төлөвлөгөө болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө нийцүүлэн сум, дүүрэгт тариаланг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

7.2.3. тариаланг хөгжүүлэх аймаг, нийслэлийн дунд хугацааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх, энэ хуулийн 6.2.4-т зааснаас бусад тохиолдолд тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх, атар газрыг тариалангийн газар болгох талаарх саналаа аймаг, нийслэлийн Засаг даргад уламжлах;

7.2.4. тариалангийн газрын байршил, хэмжээ, тэдгээрт орсон өөрчлөлтийг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан ангилал тус бүрээр гаргаж сум, дүүргийн газрын нэгдмэл сангийн тайланд тусгах;

7.2.5. тухайн жилд тариалсан, уриншилсан, өнжөөсөн болон аташсан газар, хураасан үргацын мэдээг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан маягтын дагуу нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад мэдээлэх;

7.2.6. тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, услалтын байгуулламж барих зэрэг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжлэг үзүүлэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тариалангийн газрын ангилал

8 дугаар зүйл. Тариалангийн газар, түүний ангилал

8.1. Монгол Улсын тариалангийн нийт газрыг ашиглалтын хэлбэрээс нь хамааран дараахь ангилалд хуваана:

8.1.1. тариалсан газар;

8.1.2. уриншилсан газар;

8.1.3. өнжөөсөн газар;

8.1.4. атаршсан газар.

8.2. Монгол Улсын иргэний гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлсэн болон эзэмшүүлсэн газарт тариалан эрхэлж байгаа бол түүнийг энэ хуулийн 8.1-д заасан газарт хамааруулна.

8.3. Иргэн гэр бүлийн хэрэгцээндээ өмчилж авсан болон эзэмшиж байгаа газартаа тариалан эрхэлж байгаа бол энэ хуулийн 14 дүгээр зүйл болон 7.2.3 дахь заалт хамаарахгүй.

9 дүгээр зүйл. Тариалсан газар

9.1 Тариалсан газарт хүний үйл ажиллагаагаар тарьж ургуулсан үргамал бүхий тариалангийн талбайг хамааруулна.

9.2. Дор дурдсан таримал үргамал бүхий талбайг тариалсан газарт хамааруулахгүй:

9.2.1. байгалийн хадлан, бэлчээрийн үргацыг нэмэгдүүлэх зорилгоор нэг ба олон наст үргамлын үр цацах, услах, бордох зэргээр сайжруулж тордсон бэлчээр, хадлангийн талбай;

9.2.2. хот, суурингийн дотор тарьж ургуулсан мод болон зүлэгжүүлсэн талбай, хот орчмын ногоон бүс;

9.2.3. элсний нүүдэл зогсоох зорилгоор тарьсан мод, бут, сөөг.

10 дугаар зүйл. Уриншилсан газар

10.1. Уриншилсан газарт дараа жил нь үргамал тариалах зорилгоор боловсруулж өнжөөсөн тариалангийн талбайг хамааруулна.

11 дүгээр зүйл. Өнжөөсөн газар

11.1. Өнжөөсөн газарт хөрсний үржил шимийг нөхөн сэргээх буюу сайжруулах арга хэмжээ авах болон тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид тариалах үр дүтгэдэх, тухайн жилд ган болох магадлал ихтэй нь тогтоогдсон зэрэг хүндэтгэх шалтгааны улмаас 2 жил хүртэл хугацаанд тариалалт болон уринш хийгээгүй тариалангийн талбайг хамааруулна.

12 дугаар зүйл. Аташрсан газар

12.1. Аташрсан газарт тариалангийн газрын санд бүртгэлтэй боловч хоёроос дээш жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн талбайг хамааруулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тариалангийн салбар дахь төрийн зохицуулалт

13 дугаар зүйл. Тариаланг дэмжих сан

13.1. Тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ тогтвортой хангах зорилгоор тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий Засгийн газрын тусгай зориулалтын сан /цаашид "Тариаланг дэмжих сан" гэх / байна.

13.2. Тариаланг дэмжих сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

13.2.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

13.2.2. тариалангийн салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон зээл, буцалтгүй тусламж;

13.2.3. сангийн хөрөнгийг банкинд хадгалуулсны хүү;

13.2.4. иргэн, хуулийн этгээдээс олгосон хандив, тусламж;

13.2.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

13.3. Тариаланг дэмжих сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

13.3.1. усалгаатай тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах;

13.3.2. тариалангийн газрын хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх;

13.3.3. таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх:

13.3.4. хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх;

13.3.5. тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан үрийн болон хүнсний борлогдоогүй үлдсэн буудайг худалдан авах;

13.3.6. сангийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх.

13.4. Хандивлагч орон, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрт зориулалтыг нь тусгайлан заасан бол олгосон зээл, буцалтгүй тусламжийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна.

13.5. Энэ хуулийн 13.3-д зааснаас бусад зориулалтаар сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх

14.1. Дараахь тохиолдолд тариалангийн газрын зориулалтыг өөрчилж болно:

14.1.1. тариалангийн газрын хөрсний үржил шим алдагдсан, давжсан, намагшсны улмаас тариалангийн үйлдвэрлэлд тохиромжгүй болсон;

14.1.2. улсын тусгай хэрэгцээнд зориулан авсан;

14.1.3. өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь тухайн тариалангийн газрыг цаашид ашиглахаас татгалзан төрийн мэдэлд эгүүлэн өгснөөс хойш өмчлөх, эзэмших, ашиглах хүсэлт ирэлгүй хоёроос дээш жил өнжсөн.

14.2. Тариалангийн газрын зориулалтыг өөрчлөх талаарх сум, дүүргийн Засаг даргын саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга хянаж нэгтгэн, тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.3. Энэ хуулийн 14.2-т заасан саналд тухайн газрын байршил, хэмжээ болон хөрсний чанар байдлыг тодорхойлсон агрохимийн шинжилгээний үзүүлэлтийг харуулсан зураглал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүгнэлт зэрэг баримт бичгийг хавсаргасан байна.

14.4. Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.3-т заасан саналыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

15 дугаар зүйл. Тариалангийн газрыг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ашиглуулах

15.1. Тариалангийн зориулалтаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ашиглуулах газрын хэмжээг тарих ургамлын төрөл, газар зүйн байршлыг харгалзан Засгийн газар тогтооно.

15.2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тариалангийн зориулалтаар газар

ашиглах тухай хүсэлтийг хянаж шийдвэрлэх, түүнтэй газар ашиглах гэрээ байгуулахад Газрын тухай хуулийг дагаж мөрдөнө.

15.3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжтэй байгуулах газар ашиглах гэрээнд Газрын тухай хуулийн 34.6-д зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

15.3.1. тариалангийн газрыг ашиглах төсөл, хөтөлбөр;

15.3.2. тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх шинэ техник, технологи;

15.3.3. тариалангийн үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалтын доод хэмжээ;

15.3.4. хууль тогтоомжид нийцсэн бусад нөхцөл, болзол.

ТАВДУГААР БҮЛЭГ

Тариалангийн газрын хөрсний чанар байдалд тавих хяналт

16 дугаар зүйл. Тариалангийн газрын хөрсний чанар байдал, түүнд тавих хяналт

16.1. Тариалангийн газрын хөрсний чанар байдал гэж таримал ургамлын өсөлт, хөгжилтийг хангах үржил шим /элзмаг/, шим тэжээлийн бодис, хөрсний механик бүтцийн зохистой хослолын цогц дүнг хэлнэ.

16.2. Тариалангийн газрын хөрсний чанар байдлыг агрохимийн шинжилгээгээр тодорхойлно.

16.3. Агрохимийн шинжилгээг Газрын тухай хуулийн 58.4-д заасан мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

16.4. Агрохимийн шинжилгээг дараахь үзүүлэлтүүдээр гаргана:

16.4.1. хөрсний 0-40 см гүний элзмаг;

16.4.2. нитратын азот;

16.4.3. хөдөлгөөнт фосфор;

16.4.4. хөдөлгөөнт кали;

16.4.5. хөрсний бүхэлшил;

16.4.6. хөрсний эвдрэл, элэгдлийн зэрэг;

16.4.7. усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт.

16.5. Тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч хүсвэл энэ хуулийн 16.4-д заасан үзүүлэлтээс гадна бусад үзүүлэлтийг шинжилгээ хийгч мэргэжлийн байгууллагатай тохиролцон нэмж хийлгэж болно.

16.6. Агрохимийн шинжилгээг 5 жил тутамд нэг удаа заавал хийлгэх бөгөөд өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хүсэлт, холбогдох төрийн байгууллагын шаардлагаар агрохимийн шинжилгээг хугацаа хэргалзахгүйгээр хийлгэж болно.

16.7. Тариалангийн газрыг иргэн, хуулийн этгээдэд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар анх удаа олгох, нөхөн олговортойгоор эргүүлэн авах, хураан авах, тариалангийн газрын зориулалтыг өөрчлөхөд агрохимийн шинжилгээг заавал хийнэ.

16.8. Агрохимийн шинжилгээгээр гарсан үзүүлэлтийг үндэслэн хөрсний шим тэжээлийн бодисын хангамжийн зэргийг тогтоон, байршил зүйн кодын зураг буулгаж, зохих зөвлөмжийн хамт уг газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид актаар хүлээлгэн өгнө.

16.9. Агрохимийн шинжилгээ хийх зардлыг Газрын тухай хуулийн 58.7-д заасны дагуу санхүүжүүлнэ.

16.10. Агрохимийн шинжилгээ хийх арга члалыг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.

16.11. Агрохимийн шинжилгээ хийгдсэн тариалангийн газрыг газрын төлөв байдал, чанарын улсын хяналт батлагаанд хамрагдсанд тооцно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

17 дугаар зүйл. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг

17.1. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч дараахь эрх эдэлнэ:

17.1.1. өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа тариалангийн газрын хөрсний чанар байдал, түүний өөрчлөлтийн явцын талаар холбогдох байгууллагаас мэдээлэл авах;

17.1.2. Тариаланг дэмжих сангаас зохих дэмжлэг авах;

17.1.3. хууль тогтоомжид заасан бусад эрх.

17.2. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:

17.2.1. тариалангийн газраа бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг нь 2 хүртэл жил ашиглахгүй өнжээх бол сум, дүүргийн Засаг даргад албан ёсоор мэдэгдэх;

17.2.2. тариалангийн газрын хөрс, ургамалд хорио цээртэй өвчин, хортон, хор ургамал илэрсэн, хөрсний чанар байдал өөрчлөгдсөн, доройтсон, бохирдсон тохиолдолд энэ тухай холбогдох мэргэжлийн байгууллагад ажлын 5 хоногийн дотор мэдэгдэх, хорио цээртэй өвчин, хортон, хор ургамлыг бүсдын өмчлөл, эзэмшил газарт тараахгүйн тулд шаардлагатай арга хэмжээг авах;

17.2.3. тариалангийн газарт өвс, сүрэл шатаах зэргээр хөрсний үржил шим, бүтцийг алдагдуулахгүй байх;

17.2.4. тариалсан, уриншилсан, өнжөөсөн болон атаршсан газар, хураасан ургацын талаарх мэдээг сум, дүүргийн Засаг даргад жил бүр гаргаж өгөх;

17.2.5. хөрсийг шим бордоогоор бордох, ойн зурвас байгуулах, олон наст үет, бууцгаст ургамал тарих зэргээр хөрсний үржил шимийг салхи, усанд элэгдэж эвдрэх, давсжих, намагжихаас хамгаалсан арга, технологи хэрэглэх;

17.2.6. өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын халдлага болон малаас хамгаалах.

17.3. Энэ хуулийн 8.2-т заасан газарт тариалан эрхэлж буй Монгол Улсын иргэн мөн хуулийн 17.2.2, 17.2.4, 17.2.6-д заасан үүргийг нэгэн адил хүлээнэ.

18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1. Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

18.1.1. энэ хуулийн 17.2.1-д заасныг зөрчсөн иргэнийг 20000-25000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-120000 хүртэл төгрөгөөр торгох;

18.1.2. энэ хуулийн 17.2.2-т заасныг зөрчиж, бусдын газарт хохирол учруулсан нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол хохирлыг нөхөн төлүүлж, зөрчил гаргасан иргэнийг 30000-40000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 хүртэл төгрөгөөр торгох;

18.1.3. энэ хуулийн 17.2.3, 17.2.5-д заасныг зөрчсөн иргэнийг 10000-15000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-120000 хүртэл төгрөгөөр торгох.

18.2. Тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч энэ хуульд заасан нөхцөл, жүрмыг зөрчсөн нь агрохимийн шинжилгээний явцад илэрвэл энэ тухай мэргэжлийн байгууллага сумын газрын даамал, дүүргийн газрын алба болон мэргэжлийн хяналтын эрх бүхий байцаагчид мэдэгдэх үүрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Улаанбаатар хот**

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 58.9 дэх хэсэг нэмсүгэй:

"58.9. Тариалангийн газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа /агрохимийн шинжилгээ/ хийхэд баримтлах журам, хэрэглэх үзүүлэлтийг Тариалангийн тухай хуулиар зохицуулна."

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 54.3, 58.2-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ "54.3. Тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн газарт мал, амьтан оруулах, бэлчээхийг хоригломо.

2/ 58.2. Тариалангийн газраас бусад ангиллын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаат дараахь үзүүлэлтээр гаргана:"

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 54.1-ийн "газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэснийг "Засгийн газар" гэж; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаат хийлгүүлнэ" гэснийг "газарт агрохимийн шинжилгээ хийлгүүлнэ" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Тариалангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад терроризмтой тэмцэх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоож, энэ чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс хүлээх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомж

2.1.Терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."терроризм" гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэх бүй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагаа;

3.1.2."олон улсын терроризм" гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хэналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг;

3.1.3. "террорист ажиллагаа" гэж

3.1.3.1.террорист үйлдэл хийх, түүнд оролцох зорилгоор террорист бүлэг байгуулах;

3.1.3.2.террорист үйлдлийг бэлтгэх, зохион байгуулах;

3.1.3.3.террорист үйлдэлд бүрэн бүюу хэсэгчлэн ашиглуулах зорилгоор өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа эд хөрөнгө, мөнгийг террорист байгуулагад болон түүнийг дэмжигч хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар, эсхүл санаатайгаар өгөх, хуримтлуулах;

3.1.3.4.терроризмын зорилгоор мэдээллийн цахим сүлжээнд халдах;

3.1.3.5.терроризмын зорилгоор иргэнийг элсүүлэх, түүнийг зэвсэглэх, сургах;

3.1.3.6.террорист үйлдэлд байгууллага, иргэнийг өдөөн хатгах, албадах, эсхүл өдөөн хатгах, албадахыг оролдох;

3.1.3.7.терроризмын үзэл санааг дэлгэрүүлэхийг;

3.1.4."террорист үйлдэл" гэж терроризмын зорилгоор галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, химик, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг хэрэглэж иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учруулах, буюу аюул учруулахаар заналхийлэх, төр, нийгмийн зүтгэлтэн, үгсаатны болон шашны байгууллагын төлөөлөгчийн амь насанд халдах, хүн хулгайлах, хүн, объект барьцаалах, техникийн холбогдолтой гамшиг ослын нөхцөл бүрдүүлэхийг;

3.1.5."террорист этгээд" гэж террорист ажиллагаа, террорист үйлдэлд оролцож байгаа иргэнийг;

3.1.6."террорист бүлэг" гэж террорист ажиллагаа, террорист үйлдэл явуулах зорилгоор нэгдсэн бүлэг этгээдийг;

3.1.7."террорист байгууллага" гэж террорист ажиллагаа явуулах зорилгоор байгуулагдсан болон террорист үйлдлийг өөрийн ажиллагаанд ашиглах боломжийг хүлээн зөвшөөрдөг байгууллагыг;

3.1.8."терроризмоос сэргийлэх" гэж улс орондоо терроризм үүсэх шалтгаан, нөхцөл бүрдэхээс болон иргэдийн аюулгүй байдлыг террорист ажиллагаа, террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор төр, түүний байгууллага, иргэн, хуулийн этгээдээс авч хэрэгжүүлж буй үйл төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг;

3.1.9."террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа" гэж террорист ажиллагаа, террорист

[1] Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

үйлдлийг илрүүлэн таслан зогсоох, террорист этгээдийг аюулгүй болгох, баривчлах зорилгоор цагдаа, тагнуулын болон цэргийн салбар, байгууллагын хүч хэрэгслээр нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагаар гүйцэтгэх ажиллагаа;

3.1.10."терроризмтой тэмцэх" гэж терроризмоос сэргийлэх ажиллагаа, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгдлийг;

3.1.11."террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүс" гэж террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулахаар энэ хуулийн дагуу тогтоосон нутаг дэвсгэр, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, түүнтэй хиллэсэн дэвсгэр газрыг.

4 дүгээр зүйл. Терроризмтой тэмцэх үндсэн зарчмууд

4.1.Терроризмтой тэмцэхэд дараахь зарчмыг удирдлага болгоно:

4.1.1. хууль дээдлэх;

4.1.2. терроризмоос сэргийлэх арга хэмжээг урьтал болгох;

4.1.3. терроризмоос сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, ухуулга, сурталчилгааны арга хэмжээг цогцолбороор хэрэгжүүлэх;

4.1.4.терроризмын аюулд өртсөн иргэдийн амь нас, эрүүл мэндийг эрхэмлэн дээдлэх, аргагүй нөхцөлд учирч болох хор уршиг, хохирлыг аль болох багасгах;

4.1.5.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны удирдлага нэгдмэл байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Терроризмоос сэргийлэх ажлын зохион байгуулалтын үндэс

5 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл

5.1.Терроризмоос сэргийлэх арга хэмжээг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

5.1.1.улс орондоо террорист байгуулlaга, бүлэг үүсэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхээс сэргийлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулах;

5.1.2.иргэдэд терроризмыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх;

5.1.3.газар нутагтаа олон улсын терроризм, террорист этгээд үл нэвтрэх, үл орогнох, үл нутагших орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох цэрэг, тагнуул, цагдаагийн салбар, нэгжийг тусгайлан байгуулах, эсхүл томилох, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл, чадавхи, бэлэн байдлыг хангах;

5.1.5.иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг болзошгүй террорист үйлдлээс сэргийлэх, хамгаалах;

5.1.6.галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;

5.1.7.төрийн байгууллага, эдийн засгийн дэд бүтцийн барилга, байгууламж болон соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;

5.1.8.террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, үүдэн гарах хор уршиг, хохирлыг багасгахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авах;

5.1.9.бусад улс, тэдний хууль сахиулах байгууллага, тусгай албад, олон улсын холбогдох байгууллагатай терроризмоос сэргийлэх, террорист үйлдлээс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах.

6 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх үүрэг

6.1.Терроризмоос сэргийлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан терроризмоос сэргийлэх үндсэн арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах;

6.1.2.терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.3.террорист үйлдлийн улмаас онц байдал тогтоох нөхцөл байдал үүссэн тохиолдолд

онц байдал тогтоох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлүүлэх.

6.2.Төрийн захиргааны байгууллага хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөний дагуу терроризмоос сэргийлэх төлөвлөгөөг баталж, мөрдөж ажиллана.

6.3.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд[2] заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмоос сэргийлэх талаар мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл /цаашид "Зохицуулах зөвлөл" гэх/-ийг тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулж ажиллуулна.

6.4. Зохицуулах зөвлөл нь дор дурдсан чиг үүрэг хүлээнэ:

6.4.1.терроризмоос сэргийлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх;

6.4.2.терроризмын талаарх мэдээ, мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, Засгийн газрыг шуурхай мэдээллээр хангах, санал оруулах;

6.4.3. терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

6.4.4.террорист үйлдлээс сэргийлэх зорилгоор төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд үүрэг өгч, түүнийхээ хэрэгжилтийг хангуулах.

6.5.Зохицуулах зөвлөлийн дүрэм, ажиллах журмыг Засгийн газар тогтоож, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд томилно.

6.6. Терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд хэналт тавина.

7 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар хуулийн этгээдийн хүлээх үүрэг

7.1.Терроризмоос сэргийлэх талаар хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

7.1.1.терроризмоос сэргийлэх арга хэмжээг үйл ажиллагааныхаа онцлогт нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх;

7.1.2. Зохицуулах зөвлөлөөс терроризмоос сэрэмжлүүлж өгсөн үүргийг хугацаанд нь бүрэн биелүүлэх;

7.1.3.терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн серөг тусгай ажиллагаат явуулахад төрийн байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

7.1.4.терроризмоос сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад нэн даруй хүргэх;

7.1.5.террорист үйлдлийн эсрэг гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий төрийн байгууллагад мэдээлэл олзлох боломжийг бүрдүүлэх;

7.1.6. терроризмын сурталчилгаа явуулахгүй байх.

8 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар иргэний хүлээх үүрэг

8.1.Терроризмоос сэргийлэх талаар иргэн дараахь үүрэг хүлээнэ:

8.1.1.терроризмоос сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад нэн даруй өгөх;

8.1.2.террорист ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх;

8.1.3.терроризмоос сэргийлэх арга хэмжээ, террорист үйлдлийн серөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

8.1.4.терроризмын сурталчилгаа явуулахгүй байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Террорист үйлдлийн серөг тусгай ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын үндэс

9 дүгээр зүйл. Террорист үйлдлийн серөг тусгай ажиллагаа

9.1. Террорист үйлдлийн серөг тусгай ажиллагаанд үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын болон цэргийн хамтарсан хүч хэрэгслээр тусгайлан хэрэгжүүлэх дараахь ажиллагаа хамаарна:

[2] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

9.1.1.террорист ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэх, түүнээс иргэн, байгууллагыг сэрэмжлүүлэх, хамгаалах;

9.1.2.террорист үйлдэлд өртсөн иргэн, эд хөрөнгийг аврах, хамгаалах;

9.1.3.террорист ажиллагаа, террорист үйлдэлд хүргэж буй шалтгаан нөхцөлийг арилгах;

9.1.4.террорист үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

9.1.5. террорист этгээдийг баривчлах, аюулгүй болгох;

9.1.6. террорист ажиллагаа, террорист үйлдэлд ашиглаж байгаа буюу ашиглахад зориулсан эд хөрөнгө, мөнгө, террорист ажиллагаа, террорист үйлдлээс олсон орлогыг илрүүлэх, хураах;

9.1.7. тухайн нөхцөл байдлаас шалтгаалан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр бэлтгэж явуулах хууль тогтоомжид заасан бусад тусгай ажиллагаа.

10 дугаар зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох байгууллагын хүч хэрэгсэл

10.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дор дурдсан байгууллагын хүч хэрэгсэл оролцоно:

10.1.1.цагдаагийн төв, орон нутгийн байгууллага;

10.1.2.тагнуулын төв, орон нутгийн байгууллага;

10.1.3.улсын хил хамгаалах байгууллагын гүйцэтгэх ажил эрхлэх салбар, нэгж;

10.1.4.дотоодын цэргийн томилогдсон салбар, нэгж.

10.2.Шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрлөөр Зэвсэгт хүчний ерөнхий зориулалтын цэргийн томилогдсон анги, салбарыг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд татан оролцуулна.

10.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд гадаадын цэрэг, цагдаагийн тусгай хүчний салбар, нэгжийг Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуульд[3] заасны дагуу оролцуулж болно.

11 дүгээр зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах

11.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг шуурхай штаб удирдана.

11.2.Шуурхай штабыг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны зорилго, агуулга, далайцад нийцүүлэн Зохицуулах зөвлөл тухай бүр байгуулж ажиллуулна.

11.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцож байгаа салбар, нэгж, бие бүрэлдэхүүн тусгай ажиллагаа үргэлжлэх хугацаанд шуурхай штабын даргад шууд захирагдана.

11.4.Шуурхай штабын хүсэлт, шаардлагыг төрийн захирагааны төв, нутгийн захирагааны байгууллага, хуулийн этгээд нэн даруй биелүүлж, түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

12 дугаар зүйл. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах журам

12.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг энэ хууль болон холбогдох бусад хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн гаргасан дүрмийн дагуу явуулна.

12.2.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

12.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийн нууцын зэрэглэлийг Төрийн нууцын тухай хуульд[4] нийцүүлэн тогтооно.

12.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийг шуурхай штабын дарга тогтоож, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн[5] 24 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн[6] 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж болно.

13 дугаар зүйл. Террорист үйлдлийн хор уршиг,хохирлыг арилгах

13.1.Хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа

[3] Гадаадын цэргийн хүчнийг дамжин өнгөрүүлэх тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт нийтлэгдсэн.
[4] Төрийн нууцын тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[5] Цагдаагийн байгууллагын тухай хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 8 дугаарт нийтлэгдсэн.
[6] Эрүүгийн байцаан шийтгэх хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

орчинд террорист үйлдлээс үүсэх гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хуульд[7] зааснаар зохион байгуулна.

13.2.Террорист үйлдлийн хохирлыг арилгах арга хэмжээг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
Бусад зүйл

14 дүгээр зүйл.Террорист ажиллагаа, террорист үйлдэлд оролцсон этгээдэд хүлээлгэх хариуцлага

14.1.Террорист ажиллагаа, террорист үйлдэлд оролцсон этгээдэд Эрүүгийн хуульд[8] заасан хариуцлага хүлээлгэнэ.

15 дугаар зүйл. Терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1.Терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

15.1.1.энэ хуулийн 6.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгох;

15.1.2.энэ хуулийн 7.1.1-7.1.5-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг 50000-100000 төгрөгөөр торгох;

15.1.3.энэ хуулийн 7.1.6-г зөрчсөн хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр, 8.1.4-ийг зөрчсөн иргэнийг 30000-50000 төгрөгөөр торгох;

15.1.4.энэ хуулийн 8.1.1-8.1.3-т заасныг зөрчсөн иргэнийг 10000-20000 төгрөгөөр торгох;

15.1.5.энэ хуулийн 11.4-т заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг 40000-60000 төгрөгөөр торгох;

15.1.6.энэ хуулийн 6.5-д заасан Зохицуулах зөвлөлийн дүрэм, ажиллах журам, 12.2-т заасан сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг зөрчсөн албан тушаалтныг 40000-60000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд дор дурьдсан агуулгатай 7.1.9, 7.1.10 дахь заалт нэмсүгэй:

"7.1.9.гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;

7.1.10.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын алба,"

2 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг "Гамшгаас хамгаалах алба;" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх, " гэсний дараа "террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

---

[7] Гамшгаас хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

[8] Эрүүгийн хууль - "Төрийн мэдээлэл"эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1дүгээр зүйл. Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдсон мэдээ, баримт, материалын нууцлалбал зохих хэсэг" гэсэн 5 дахь заалт нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1дүгээр зүйл. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "Тав.Бусад" гэсэн хэсэгт:

2 дугаар зүйл. Энэ хуулийг Терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

59	Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичиг	нууцалсан зэрэглэлээр	байнга

гэсэн заалт нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1дүгээр зүйл. Улсын нисэхийн тухай хуульд "Улсын нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нисэх багийн бүрэлдэхүүнд хамгаалалтын ажилтныг ажиллуулж болно." гэсэн 14.5 дахь хэсэг нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл . 2002 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Сингапур улсад гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Сингапур улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газар өргөн мэдүүлснээр соёрхон батлагдуга.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл . Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын Зээлийн банк хооронд 2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан Эрчим хүчний салбарын нэгдүгээр хөтөлбөрийн нэмэлт зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Түлш, эрчим хүчний ерөнхий газар, БНХАУ-ын Гадаад эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны Шанхай (групп) корпорацийн хооронд байгуулсан гэрээний дагуу "Дөргөний усан цахилгаан станцыг барьж байгуулах төсөл"-ийн хүрээнд гадаадаас нийлүүлэгдэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр — Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Түлш, эрчим хүчний ерөнхий газар, БНХАУ-ын Гадаад эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны Шанхай /групп/ корпорацын хооронд байгуулсан гэрээний дагуу "Дөргөний усан цахилгаан станцыг барьж байгуулах төсөл" -ийн хүрээнд гадаадаас нийлүүлэгдэх бараа материал, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй .

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Дугаар 19 — Улаанбаатар хот

"Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 2.1.7-гийн 2 дахь хэсгийн "...чиглэлээр ажиллах" гэсний дараа "...дотоод..." гэж нэмсүгэй.

2. "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 2.2.4-ийн 2 дахь хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"-Багануур ХК, Шивээ Овоо ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг Дэлхийн банк болон Японы Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг графикийн дагуу төлөх нөхцөлтэйгээр хувьчлах;"

3. "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн "2.4. Ниймчийн салбарын өөрчлөн байгуулалт, хувьчлал" гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Дугаар 20 — Улаанбаатар хот

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл"-ийн тусгай албан тушаалын ТӨ-ҮУА-ийн "Төрийн хянан шалгах хорооны дарга" гэснийг "Монгол Улсын Ерөнхий аудитор", ТӨ-ҮІА -ийн "Төрийн хянан шалгах хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга" гэснийг "Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 58 | Улаанбаатар хот

Шарапат Тешебаевна Сатымовад "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсын боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж орос хэлийг зааж сургах, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Евро-Ази дээд сургуулийн орос хэлний тэнхмийн эрхлэгч Шарапат Тешебаевна Сатымовад "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот

Н. Чулуунжавыг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Наянбуугийн Чулуунжавыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Уул уурхайн салбарт шинэ техник, технологи эзэмшсэн мэргэжилтэй ажилчид дутагдаж байгаа харгалзан ОХУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай "Алтан дорнод-Монгол" компанийн 2004 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг 75 хүртэл нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 80 | Улаанбаатар хот

Төмөр замын дагуухь шилэн кабелийн сүлжээний ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төмөр замын дагуухь 1402 км шилэн кабелийн ашиглагдахгүй байгаа 4 шөрмөсийг Төмөр замын Хэрэг эрхлэх газраас Шуудан, цахилгаан холбооны газрын зээмшилд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Дээрх 4 шөрмөсөнд ногдох зардал болон түүнийг шилжүүлэхээс өмнө төлсөн хүүгийн хэмжээг тогтоож, Төмөр замын Хэрэг эрхлэх газарт төлөх болон уг 4 шөрмөсөнд ногдох зээл, зээлийн хүүгийн асуудлыг цаашид Шуудан, цахилгаан холбооны газарт хариуцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

3. Төмөр замын тээврийн аюулгүй байдал, технологийн холбоонд сергөөр нөлөөлөхгүй байхаар зохион байгуулж төмөр замын шилэн кабелийн суллжээний ашиглалтыг сайжруулах, хэвийн тасралтгүй ажиллагаат хангах, түүний ашиглалт, үйлчилгээний журмыг тогтоох, үнэ тарифыг бууруулах, шударга өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээ авч ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр **Дугаар 81** **Улаанбаатар хот**

"100 000 нарны гэр" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгах нь:

а)"100000 нарны гэр" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан Япон Улсын болон БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн нарны цахилгаан үүсгүүрийн үнийг 50 хувиар хөнгөлсүгэй;

б)"100000 нарны гэр" үндэсний хөтөлбөрийг 2005-2010 онд бүрэн хэрэгжүүлж, нийт малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор буцалтгүй тусламжаар нийлүүлсэн нарны цахилгаан үүсгүүрийн төлбөрөөс эргэлтийн сан байгуулж түүнийг хөдөөгийн иргэдийг нарны цахилгаан үүсгүүрээр хангахад зарцуулж байсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр **Дугаар 82** **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

2003-2012 оныг Ази, Номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийг дэмжих 10 жил болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтад дараахь нэмэлтийг оруулсугай:

48.	"Ази, Номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийг дэмжих 10 жилийн ажлыг Монгол Улсад эрхлэн зохион байгуулах Үндэсний хороо"	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (353)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Даатгалын тухай (шинэчилсэн найруулга)*
- *Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 24 №20 (353)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

248. Даатгалын тухай (Шинэчилсэн найруулга) 443
249. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай 464
250. Хууль хүчингүй болсонд тооцох тухай 477
251. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай 477
252. Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 477

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

253. Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай Дугаар 21 477
254. Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Дугаар 22 486
255. Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах тухай Дугаар 23 486

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ДААТГАЛЫН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагаат зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуультогтоомж

2.1.Даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Компанийн тухай хууль[3], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн даатгалын харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

[1] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №1
[2] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны № 7
[3] Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны № 34

3.3.Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн эрх зүйн байдлыг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулна.

3.4.Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-3.3-т зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."даатгалын үйл ажиллагаа" гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээх буй үйл ажиллагаа;

4.1.2."даатгагч" гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

4.1.3."даатгуулагч" гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

4.1.4."даатгалын тохиолдол" гэж даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;

4.1.5."даатгалын хураамж" гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;

4.1.6."даатгалын нөхөн төлбөр"гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.7."даатгалын багц дүрэм" гэж энэ хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагаа зохицуулах зорилгоор гаргаж буй дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлагыг;

4.1.8."актуарч" гэж даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийг;

4.1.9."давхар даатгалын үйл ажиллагаа" гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг;

4.1.10."гадаадын зохицуулах байгууллага" гэж даатгалын үйл ажиллагааг хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагыг;

4.1.11."эрх бүхий албан тушаалтан" гэж Компанийн тухай хуулийн 81.1-д заасан этгээдийг.

4.2.Давхар даатгалын үйл ажиллагааг энэ хуулийн 4.1.1 дэх заалт нэгэн адил хамаарна.

4.3.Бодит хохирлоос ул хамааран тодорхой итгэлцүүр буюу бусад аргачлалыг ашиглан даатгагчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг томъёогоор дундажлан тооцоолж гаргадаг үйл ажиллагаа энэ хуулийн 4.1.1-д нэгэн адил хамаарна.

5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал

5.1. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөө Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Даатгалын ангилал, төрөл, хэлбэр

6 дугаар зүйл. Даатгалын ангилал, төрөл, хэлбэр

6.1.Даатгалыг урт хугацааны даатгал, ердийн даатгал гэж ангилна.

6.2.Даатгал нь сайн дурын болон заавал гэсэн төрөлтэй байна.

6.3.Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд заавал даатгах даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.

6.4.Заавал даатгуулах даатгалын эрсдэл, нөхцөлийн талаархи нарийвчилсан зохицуулалтыг уг даатгалыг заавал даатгуулах даатгал гэж тодорхойлсон хуулиар зохицуулна.

6.5.Сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

6.6.Даатгагчийн үйл ажиллагаа нь энэ хуулийн дагуу тодорхойлсон ангилал, төрөл, хэлбэрээс өөр байна гэж үзвэл энэ хуульд нийцүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо даатгагчид даалгаж болно.

7 дугаар зүйл. Даатгалын хураамж

7.1.Заавал даатгалын хураамжийн хэмжээг Монгол Улсын хуулиар тогтооно.

7.2.Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 14.2.5-д заасан аргачлалын дагуу даатгагч тогтооно.

8 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөр

8.1.Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 8.4-т заасан баримтыг

үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

8.2.Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.

8.3.Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.

8.4.Даатгалын нөхөн төлбөрийг дараахь баримтыг үндэслэн олгоно:

8.4.1.даатгуулагчийн өргөдөл;

8.4.2.даатгалын баталгааны эх хувь;

8.4.3.учирсан хохирлын тухай хохирол үнэлэгчийн бичгээр гаргасан дүгнэлт, акт материал;

8.4.4.шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт.

8.5.Даатгагч дараахь үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно:

8.5.1.даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;

8.5.2.даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

8.5.3.даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;

8.5.4.гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;

8.5.5.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.6.Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

8.7.Даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

9 дүгээр зүйл. Даатгагчийн эрх, үүрэг

9.1.Даатгагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

9.1.1.энэ хуулийн 8.5-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;

9.1.2.даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;

9.1.3.даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

9.1.4.даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

9.1.5.даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;

9.1.6.даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;

9.1.7.Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;

9.1.8.даатгалын эрсдэлийн үлмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;

9.1.9.даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

9.1.10.гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

9.1.11.Санхүүгийн зохицуулах хороонооос тогтоосон журмын дагуу санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх.

10 дугаар зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг

10.1.Даатгуулагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

10.1.1.даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

10.1.2.даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

10.1.3.даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;

10.1.4.даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;

10.1.5.даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор болонцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;

10.1.6.даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах

11дүгээр зүйл.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

11.1.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

11.1.2.Засгийн газрыг даатгалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;

11.1.3.хууль тогтоомжид заасан бусад чиг үүргэг.

12 дугаар зүйл. Даатгалын зохицуулах байгууллага

12.1.Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ хэрэгжүүлнэ.

12.2.Зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын бүтцийг Улсын Их Хурал батална, үүнд зохицуулах санхүүжүүлнэ.

12.3.Зохицуулах хороо Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

13.1. Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн даатгалын үйл ажиллагааг хяналт тавих;

13.1.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

13.1.3.даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;

13.1.4.даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаархи албан ёсны мэдээлэл гаргах;

13.1.5.даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

13.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13.2.Зохицуулах хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсч болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Даатгалын багц дүрэм

14.1.Даатгалын үйл ажиллагаат Зохицуулах хорооноос батлсан даатгалын багц дүрмээр зохицуулна.

14.2.Даатгалын багц дүрэмд дараахь дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлага, хэмжээ багтана:

14.2.1.даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дэгаж мөрдөх үзүүлэлт;

14.2.2.даатгагчийн төлберийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам;

14.2.3.даатгалын нөөц сан болон бусад сан бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам;

14.2.4.даатгалын нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.5.даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал;

14.2.6.даатгалын үнэлгээ хийх аргачлал;

14.2.7.даатгагч болон бусад этгээдээс даатгалын мэргэжлийн оролцогчид шууд болон шууд бусаар төлөх төлбөр, хураамжийг тооцох аргачлал;

14.2.8.даатгагчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.9.актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам;

14.2.10.гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.11.Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

14.2.12.даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ;

14.2.13.даатгагчаас энэ хуульд заасны дагуу тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар;

14.2.14.даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгттэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам;

14.2.15.энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;

14.2.16.даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага;

14.2.17.Зохицуулах хороонд төлөх төлбөр, хураамж;

14.2.18.Дампуурлын тухай хууль[4], Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам;

14.2.19.даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл;

14.2.20.даатгалтай холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар;

14.2.21.энэ хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх журам.

15 дугаар зүйл. Даатгагчийн бизнесийн үйл ажиллагаа явуулах журам

15.1.Зохицуулах хорооноос даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно.

15.2.Даатгагч энэ хуулийн 15.1-д заасан журмыг заавал дагаж мөрдөх үүргийг хүлээхгүй боловч ийнхүү дагаж мөрдөөгүй нь даатгагчид хариуцлага ногдуулахад түүнийг даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмших тохиромжтой бус этгээд, эсхүл үйл ажиллагаагаа зохистой явуулаагүй гэж үзэх нөхцөл болж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

16 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

16.1.Энэ хуулийн 16.3, 17.2-т зааснаас бусад этгээд Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хоригломо.

16.2.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол энэ хуулийн 16.1-д заасны дагуу Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа явуулсанд тооцно.

16.3.Даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд энэ хуулийн 16.1 дэх хэсэг хамаарахгүй.

16.4.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон даатгагч энэ хуулийн 16.1-д заасанчлан даатгалын үйл ажиллагаа явуулах эрхгүй.

16.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар[5] зохицуулна.

17 дугаар зүйл. Даатгагчийн даатгах хөрөнгө

17.1.Монгол Улсад оршин суугч хувь хүн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй эд хөрөнгөө гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна.

17.2.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авааргүй гадаадын даатгагч тухайбал, Ллойдын андеррайтерын холбоонд багтдаг даатгагчтай даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээ байгуулах тохиолдол бүрт Зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан гэрээ байгуулах зөвшөөрлийг Зохицуулах хороо зөвхөн дараахь тохиолдолд олгоно:

17.3.1.энэ хуулийн 17.1-д заасан даатгагч тухайн даатгалын эрсдэлийг хариуцах чадваргүй;

17.3.2.энэ хуулийн 17.1-д заасан даатгагч эрсдлийг хариуцах боломжгүй гэж үзэх бусад хүндэтгэх шалтгаан байвал.

17.4.Гадаадын даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулах даатгагчид дараахь тохиолдолд энэ хуулийн 17.3 дахь хэсэг хамаарахгүй:

[4] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны №1

[5] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны №6

17.4.1.энэ хуулийн 47.1-д заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөг Зохицуулах хороогоор батлуулсан бол;

17.4.2.энэ хуулийн 47.2-т заасны дагуу тухайн гэрээнд давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага хамаарахгүй байхаар Зохицуулах хороонооc тогтоосон бол.

18 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах эрх бүхий этгээд

18.1.Дараахь этгээд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах эрхтэй:

18.1.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани;

18.1.2.гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан компани.

19 дүгээр зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

19.1.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан этгээд нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлээ Зохицуулах хороонд гаргана.

19.2.Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг зааж, Зохицуулах хороонооc тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ .

19.3.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

20.1.Зохицуулах хороо дараахь шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн даатгалын төрөл, хэлбэрээс хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

20.1.1.өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, өргөдөл гаргагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь тус тус даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

20.1.2.өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийг олгосны дараа энэ хууль болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

20.1.3.тухайн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд өргөдөл гаргагчийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр хангалттай гэж үзвэл;

20.1.4.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

20.2.Зохицуулах хороо даатгагчийн үйл ажиллагааны цар хүрээ, тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрээс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

20.3.Зохицуулах хороо урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй.

20.4.Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

20.4.1.тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

20.4.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

20.4.3.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр;

20.4.4.үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага;

20.4.5.тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

20.4.6.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга/тэмдэг/;

20.4.7.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй эсэх.

20.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 69, 70 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

20.6.Зохицуулах хороо өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн боловч даатгалын тодорхой төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөгүй бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

20.7.Зохицуулах хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

20.8.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

20.8.1.энэ хуулийн 20.1-д заасан шаардлагыг хангаагүй;

20.8.2.даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг бүрэн ирүүлээгүй;

20.8.3.хуульд заасан бусад үндэслэл.

20.9.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

20.10.Зохицуулах хороо энэ хуулийн 20.1.1-д заасан "тохиромжтой эгтээд"-ийг тодорхойлох зааврыг гаргаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт

21 дүгээр зүйл. Даатгагч хөрөнгөө шилжүүлэхэд тавих хяналт

21.1.Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

21.2.Аливаа этгээд Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран шууд буюу шууд бусаар эзэмших, өмчлөхийг хориглоно.

21.3.Даатгагч өөрийн эзэмшил, өмчлөлд буй энэ хуулийн 21.1-д заасан хөрөнгийн талаар Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

21.3.1.худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх;

21.3.2.өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эллэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.

21.4.Даатгагч энэ хуулийн 21.3-т заасан үйлдэл хийх зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зохицуулах хороонд гаргана.

21.5.Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмших, өмчлөхийг хүсэгч нь нийхүү эзэмших, өмчлөх тохиромжтой этгээд гэж үзсэн тохиолдолд Зохицуулах хороо даатгагчид зөвшөөрөл олгоно.

21.6.Зохицуулах хороо энэ хуулийн 21.5-д заасан зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл, шаардлага тавьж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төлбөрийн чадвар

22 дугаар зүйл. Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ

22.1.Даатгалын компанийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 500 сая төгрөг байна. Дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

22.2.Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан дүрмийн сангийн доод хэмжээнд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

22.4.Даатгагчийн дүрмийн сан энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Даатгалын компанийн хувьцаа

23.1.Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын компанийн гаргасан бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

23.2.Даатгалын компанид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй.

24 дүгээр зүйл. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

24.1.Даатгагч нь дараахь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

24.1.1.даатгалын багц дүрэмд заасан хэмжээнээс багагүй;

24.1.2.энэ хуулийн 24.2-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй.

24.2.Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлтийг энэ хуулийн 24.1.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

24.3.Энэ хуулийн 24.2-т заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

24.4.Даатгагчийн төлбөрийн чадвар нь энэ хуулийн 24.1-д заасан үзүүлэлтэд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

25 дугаар зүйл. Даатгалын нөөц сан

25.1.Даатгагч нь гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц сан бүрдүүлнэ.

25.2.Даатгалын нөөц сангийн хэмжээ, нөөц санг бүрдүүлэх болон хөрөнгө оруулалтад байршуулах нөхцөлийг даатгалын багц дүрмээр тогтооно.

25.3.Энэ хуулийн 25.1-д заасан даатгалын нөөц сангийн хөрөнгийг тусгайлсан дансанд байршуулна. Дансны бүрдүүлэлт, зарцуулалт Зохицуулах хорооны хяналтад байна.

25.4.Даатгагчийн нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ энэ хуулийн 25.2-т заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

26 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

26.1.Ногдол ашиг хуваарилсны дараа дараахь нөхцөлийн аль нэг нь үүсэхээр бол хувь нийлүүлэгчдэд ногдол ашиг хуваарилахгүй:

26.1.1.даатгагчийн дүрмийн сан нь энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнд хүрэхгүй;

26.1.2.даатгагчийн төлбөрийн чадвар энэ хуулийн 24.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй;

26.1.3.даатгалын нөөц сан нь энэ хуулийн 25.2-т заасан хэмжээнд хүрэхгүй.

27 дугаар зүйл. Урьдчилгаа болон зээлтэй холбоотой хязгаарлалт

27.1.Даатгагч нь энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

27.1.1.хувьцаа худалдаж авах, арилжих, менгэ зээлүүлэх, өөрийн үнэт цаасыг төлбөрийн баталгаа болгож урьдчилгаа авах;

27.1.2.холбогдох этгээдэд аливаа сангаас зээл олгох;

27.1.3.аливаа этгээдэд барьцаагүй зээл олгох;

27.1.4.холбогдох этгээдийн бусдаас авсан зээлд баталгаа, батлан даалт гаргах.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан "холбогдох этгээд"-ийг тодорхойлох зааврыг Зохицуулах хороо гаргаж болно.

27.3.Энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу ногдол ашиг хуваарилахад энэ хуулийн 27.1 дэх хэсэг хамаарахгүй.

28 дугаар зүйл. Даатгагчийн санхүүгийн чадавхид тавих хяналт

28.1.Зохицуулах хороо даатгагчийн санхүүгийн чадавхийг үнэлэх шалгуур тогтоон, шалгалт хийж болно.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасны дагуу тогтоосон шалгуурын тухай Зохицуулах хороо даатгагчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

29 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

29.1.Даатгагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль[6] болон даатгалын багц дүрэмд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргана.

29.2.Даатгагч нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөх бөгөөд даатгагчийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.2 дахь хэсэг хамаарахгүй.

29.3.Даатгалын багц дүрэмд өөрөөр заагаагүй бол Зохицуулах хороо даатгагчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг тогтоож болно.

29.4.Санхүүгийн тайлангийн баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.2-т болон даатгалын багц дүрэмд заасан, эсхүл энэ хуулийн 29.3-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон баримт бичгээс бүрдэнэ.

29.5.Даатгагч энэ хуулийн 29.4-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлнэ.

29.6.Даатгагчийн үйлээсэн үүрэг, эд хөрөнгийг даатгалын багц дүрэмд заасны дагуу үнэлнэ.

29.7.Даатгагч нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ 6 жилээс доошгүй хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

30 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх

30.1.Даатгагч нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө.

31 дүгээр зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

31.1.Даатгагч нь аудитаар баталгаажуулсан

[6] "Төрийн мэдээлэл" 2002 оны №2

санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд дараахь баримт бичгийн хамт Зохицуулах хороонд тушаана:

31.1.1.удирдлагын тайлан;
31.1.2.аудитын дүгнэлт;

31.1.3.урт хугацааны даатгал эрхэлж буй даатгагч (цаашид "урт хугацааны даатгагч" гэх)-ийн хувьд энэ хуулийн 40.1-д заасны дагуу томилсон актуарчийн тайлан;

31.1.4.тухайн санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйл явдлын тухай тодруулга, тайлбар;

31.1.5.даатгалын багц дүрэмд заасан бусад баримт бичиг.

31.2.Жил бүрийн санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

31.3.Энэ хуулийн 31.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлэхгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

32 дугаар зүйл. Улирал тутмын тайлан

32.1.Даатгагч нь улирал тутмын санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Зохицуулах хороонд тушаана.

32.2.Улирал тутмын санхүүгийн тайлан, холбогдох бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

32.3.Даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

33 дугаар зүйл. Аудит

33.1.Даатгагч нь санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор ауditорыг томилно.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан аудитор нь дараахь шаардлагыг хангасан байна:

33.2.1.Аудитын тухай хуулийн[7] 17 дугаар зүйлд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй;

33.2.2.даатгагчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрхийг Зохицуулах хорооноос авсан.

33.3.Зохицуулах хороо энэ хуулийн 33.2-т заасан эрх бүхий ауditорын нэрсийн жагсаалт болон түүнд өөрчлөлт орсон тухай бүр даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

33.4.Даатгагч нь ауditоруг аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

33.5.Даатгагч нь ауditоруг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл. Аудитор актуарчийн тооцоог үндэслэх

34.1.Урт хугацааны даатгагчийн аудитор нь аудитын үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий актуарчийн дараахь тооцоог үндэслэж болно:

34.1.1.тухайн санхүүгийн жилийн эцэст даатгалын гэрээнээс үүссэн үүрэг;

34.1.2.тухайн санхүүгийн жилийн туршид тодорхой сангуудтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт гарсан өөрчлөлт.

35 дугаар зүйл. Аудитын тайлан

35.1.Аудитор нь даатгагчийн санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу даатгагчид хүргүүлнэ.

35.2.Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийн чанар, эрсдлийн сангийн зохистой харьцаа, нягтлан бодох бүртгэл болон хяналтын тогтолцооны зохистой харьцааг тодорхойлох зорилгоор аудитын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас хэдийд ч шаардаж болно.

35.3.Энэ хуулийн 35.2-т заасан тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

36 дугаар зүйл. Ауditорын үүрэг

36.1.Даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар аудитор нь Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

36.1.1.даатгагч төлберийн чадваргүй болсон буюу төлберийн чадваргүй болж болзошгүй байгаа;

36.1.2.даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;

36.1.3.даатгагч энэ хуулийн 22-27 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзвэл;

36.1.4.даатгагч энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг ноцтойгоор зөрчсөн гэж үзвэл.

[7] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны №6

36.2.Даатгагч аудитортай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл аудитор өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд аудитор нь Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

36.2.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

36.2.2.энэ хуулийн 36.1-д заасан дүгнэлт гаргасан тохиолдолд энэ тухай.

36.3.Зохицуулах хороо аудитороос аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, нэмэлт материал шаардаж болно.

36.4.Аудитор болон аудитор байсан этгээд нь энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

37 дугаар зүйл. Зохицуулах хорооноос аудиторыг томилох

37.1.Даатгагч энэ хуулийн 33.1-д заасны дагуу аудиторыг томилоогүй бол Зохицуулах хороо аудиторыг томилж болно.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасны дагуу томилогдсон аудитор нь даатгагчийн аудиторын энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

38 дугаар зүйл. Компанийн нэгдлийн гишүүдийн нягтлан бодох бүртгэлийн тайланг шаардах

38.1.Даатгагч нь компанийн нэгдлийн гишүүн бол Зохицуулах хороо даатгагчаас тухайн нэгдлийн гишүүн аль ч этгээдийн санхүүгийн болон компанийн нэгдлийн нэгдсэн тайланг шаардаж болно.

38.2.Зохицуулах хороо энэхүү тайланг даатгагчийн аудитор, эсхүл өөрийн томилсон аудитороор баталгаажуулахыг шаардаж болно.

38.3.Энэ хуулийн 38.1-д заасан компанийн нэгдлийн тайлангийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Актуарч, актуарын хяналт шалгалт, тайлан

39 дүгээр зүйл. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

39.1.Зохицуулах хороо актуарчаар ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг сонгон шалгаруулж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.

39.2.Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох ажиллагааг даатгалын багц дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

39.3.Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасны дагуу эрх авсан актуарчийн нэрсийн жагсаалт, түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

40 дүгээр зүйл. Актуарчийг томилохтой холбоотой урт хугацааны даатгагчийн эрх хэмжээ

40.1.Урт хугацааны даатгагч нь заавал актуарчтай байх бөгөөд актуарч нь энэ хуулийн 39.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос эрх авсан этгээд байна.

40.2.Даатгагч нь өөрийн актуарчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрт Зохицуулах хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэнэ.

40.3.Актуарчаар томилогдсон этгээд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол ийнхүү боломжгүй болсноос хойш ажлын 30 хоногийн дотор даатгагч өөр актуарчийг томилно.

41 дүгээр зүйл. Актуарчийн дагаж мөрдөх стандарт

41.1.Актуарч нь өөрийн үйл ажиллагаандаа даатгалын багц дүрэмд заасан актуарын стандартыг дагаж мөрдөнө.

42 дугаар зүйл. Актуарын хяналт шалгалт, тайлан

42.1.Урт хугацааны даатгагч нь үйл ажиллагаандаа актуарын хяналт шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа өөрийн актуарчаар хийлгэх үүрэгтэй.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасан актуарын хяналт шалгалт нь даатгалын багц дүрэмд заасны дагуу явагдана.

42.3.Зохицуулах хороо даатгагчийн санхүүгийн байдлын талаархи шаардлагатай гэж үзсэн асуудлыг актуарчаар шалгуулах болон актуарын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас шаардаж болно.

42.4.Зохицуулах хороо актуарын хяналт шалгалтыг даатгагчийн томилсон, эсхүл өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлж болно.

42.5.Актуарч нь даатгалын багц дүрэмд заасан агуулга, хэлбэрийн дагуу хяналт шалгалтын тайлан бэлтгэнэ.

42.6.Энэ хуулийн 42.3-т заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх болон тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

43 дугаар зүйл. Актуарчийн эрх

43.1.Актуарч нь дараахь эрхтэй байна:

43.1.1.актуарын үйл ажиллагаар хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг шалгах;

43.1.2.даатгагчийн талаархи шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахыг даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, албан хаагчаас шаардах.

43.2.Актуарч нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож, дараахь асуудлаар үг хэлэх эрхтэй:

43.2.1.даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар болон даатгагчийн хөрөнгөд нөлөөлж болох бусад асуудлаар;

43.2.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд өгсөн актуарын зөвлөгөөний талаар;

43.2.3.актуарын ажиллагаатай холбоотой асуудлаар.

43.3.Актуарч нь компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, дараахь асуудлаар үг хэлэх эрхтэй:

43.3.1.даатгагчийн санхүүгийн болон няггүлан бодох бүртгэлийн тайлан;

43.3.2.актуарчийн эрх хэмжээ, чиг үүрэгтэй холбоотой аливаа асуудал.

43.4.Актуарч нь дараахь асуудлыг Зохицуулах хороонд мэдэгдэж болно:

43.4.1.энэ хуулийн 43.1.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг шалгахад даатгагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр актуарчид дэмжлэг үзүүлэхээс татгалзсан, бусад хэлбэрээр саад учруулсан тухай;

43.4.2.даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, албан хаагч шаардлагатай мэдээлэл баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахаас татгалзсан тухай.

44 дүгээр зүйл. Актуарчийн үүрэг

44.1.Актуарч нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

44.1.1.даатгагч нь энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй;

44.1.2.даатгагч хууль тогтоомж зөрчсөн нь даатгуулагчийн эрх ашигт ноцтой нөлөөлнө гэж үзсэн.

44.2.Актуарч нь даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар, даатгагч болон даатгуулагчийн ашиг сонирхолд нөлөөлж болох аливаа асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах талаар даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.

44.3.Актуарч энэ хуулийн 44.2-т заасны дагуу даатгагчид мэдэгдсэн бөгөөд тогтоосон хугацаанд даатгагч ямар нэг арга хэмжээ аваагүй бол энэ тухай Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ.

44.4.Даатгагч актуарчтай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд актуарч нь Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

44.4.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

44.4.2.энэ хуулийн 44.1, 44.3-т заасан мэдээллийн тухай.

44.5.Актуарч болон актуарч байсан этгээд тайлан болон энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

45 дугаар зүйл. Зохицуулах хороо актуарчийг томилох

45.1.Урт хугацааны даатгагч нь актуарчийг томилоогүй бол Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасан актуарын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг актуарчаар томилно.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу томилогдсон актуарч нь урт хугацааны даатгагчийн актуарчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Давхар даатгал

46 дугаар зүйл. Давхар даатгалд даатгуулах

46.1.Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараахь даатгагчид даатгуулж болно:

46.1.1.энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид;

46.1.2.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид.

47 дугаар зүйл. Даатгагчийн давхар даатгалын гэрээ

47.1.Даатгагч даатгалын эрсдлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороогоор батлуулна.

47.2.Зохицуулах хороо тухайн төрлийн давхар даатгалын гэрээнд энэ хуулийн 47.1-д заасан давхар даатгалын төлөвлөгөөг батлуулахад тавигдах шаардлага хамаарахгүй байхаар бичгээр тогтоож болно.

48 дугаар зүйл. Давхар даатгалын тайлан

48.1.Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг тогтоосон хугацаанд гаргаж Зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд тайланд давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ

Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлалт

49 дүгээр зүйл. Даатгагч зөвхөн даатгалын үйл ажиллагаа эрхлэх

49.1.Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ:

49.2.Даатгагчийн эрхлэх даатгалтай холбоотой үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

50 дугаар зүйл. Даатгагч бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх

50.1.Даатгагч үйл ажиллагаагаа Зохицуулах хорооноос хамгийн сүүлд батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

50.2.Даатгагч бизнес төлөвлөгөөндөө нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ хэзээ ч гаргаж болох бөгөөд энэ тухай хүсэлтээ шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөний төслийн хамт Зохицуулах хороонд хүргүүлнэ.

50.3.Зохицуулах хороо хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөг батлах эсэхийг шийдвэрлэнэ.

50.4.Зохицуулах хороо даатгагчийн шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөг батлах эсэх асуудлыг шийдвэрлэх явцдаа даатгагчаас нэмэлт материал шаардаж болно.

51 дүгээр зүйл. Урт хугацааны даатгагчийн сан байгуулах, түүнийг зарцуулах

51.1.Урт хугацааны даатгагч нь эрхэлж буй даатгалын төрөл тус бүрт тусгайлсан данс нээж, тусгайлсан сан байгуулна.

51.2.Урт хугацааны даатгагчийн хөтлөх нягтлан бодох бүртгэлийн болон бусад тайланд дараахь үзүүлэлтийг тус тусад нь гаргаж харуулна:

51.2.1.сан тус бүрд хамаарах хөрөнгө;

51.2.2.даатгалын төрөл тус бүрд хамаарах үүрэг.

51.3.Тухайн сангийн хөрөнгийг зөвхөн тухайн төрлийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах бөгөөд сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.

51.4.Дараахь тохиолдолд энэ хуулийн 51.3 дахь хэсэг хамаарахгүй:

51.4.1.тухайн сангийн хөрөнгийн үнэлгээ нь актуарын тооцоогоор тухайн төрлийн даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээс хэтэрч байвал ийнхүү хэтэрсэн хэсэгт;

51.4.2.урт хугацааны даатгагчийн сангийн хөрөнгийг зах зээлийн үнээр нь өөр хөрөнгөөр солиход.

51.5.Энэ хуулийн 51.4.1-д зааснаас бусад тохиолдолд урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд зориулж байгуулсан сангийн хөрөнгийг даатгагчийн өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

51.6.Урт хугацааны даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд урт хугацааны даатгагчийн сангийн хөрөнгийн хэмжээ хүрэхүүй болсон тохиолдолд даатгагч, түүний хараат болон охин компани нөгөөл ашиг төлөх болон төлөхөөр зарлахыг хориглоно.

51.7.Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон компанид энэ хуулийн 51 дүгээр зүйл нэгэн адил хамаарна.

52 дугаар зүйл. Тодорхойгүй хэлцлээс зайлсхийх

52.1.Энэ хуулийг дагаж мөрдсэн өдрөөс хойш даатгагчийн байгуулсан хариуцлагын хэмжээ, эсхүл дээд хэмжээ нь тодорхойгүй даатгалын гэрээ энэ хуулийн 52.2-т зааснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр бус байна.

52.2.Энэ хуулийн 52.1-д үл хамаарах даатгалын гэрээний төрөл, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

53 дугаар зүйл. Даатгагчийн ерөнхий захиргааны хяг

53.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан даатгалын компанийн ерөнхий захиргаа нь Монгол Улсад байрлах бөгөөд даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

53.2.Даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг өөрчилбөл ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

54 дүгээр зүйл. Салбар, төлөөлөгчийн газар нээх

54.1.Даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулахдаа Зохицуулах хороноос бичгээр зөвшөөрөл авна.

54.2.Гадаадын даатгагч Зохицуулах хороноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хоригломо.

54.3.Гадаадын даатгагч Зохицуулах хороноос бичгээр зөвшөөрөл авааг үй тохиолдолд аливаа этгээд гадаадын даатгагчийг төлөөлж дараахь үйл ажиллагаа явуулахыг хоригломо:

54.3.1.даатгалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан байр нээж ажиллуулах;

54.3.2.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

54.4.Зохицуулах хороо энэ хуулийн 54.1-д заасан зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээллэл, баримтыг даатгагчаас шаардаж болно.

54.5.Энэ хуулийн 54.2-т заасан зөвшөөрөл олгохоо Зохицуулах хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчилж болно.

55 дугаар зүйл. Эрх бүхий албан тушаалтныг томилох

55.1.Даатгагч нь Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн компанийн эрх бүхий албан тушаалтныг томилно.

55.2.Зохицуулах хороо нь тухайн этгээд компанийн үүсгэн албан тушаалд тохирно гэж үзвэл энэ хуулийн 55.1-д заасан зөвшөөрлийг олгоно.

55.3.Даатгагчийн эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх дуусгавар болсон, эсхүл хүсэлтэзрээ чөлөөлөгдсөн тохиолдолд даатгагч энэ тухай ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

56 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүй даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчид төлбөр төлөхийг хориглох

56.1.Даатгагч нь даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдэд аливаа төлбөр, хураамж төлөхийг хориглоно.

57 дугаар зүйл. Мэдээллийг өөрчлөх

57.1.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч байгаа этгээд, эсхүл даатгагч болон бусад этгээдээс энэ хууль, даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороонд гаргаж буй аливаа зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Зохицуулах хороонд ирүүлсэн мэдээллэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Зах зээлийн ёс зүй

58 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

58.1.Даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээллэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

58.2.Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

59 дүгээр зүйл. Зах зээлийн ёс зүй

59.1.Зохицуулах хороо даатгагчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журмыг гаргаж болох бөгөөд даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон даатгалын үйл ажиллагаанд оролцогч түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

Нэрэнд хяналт тавих

60 дугаар зүйл. "Даатгал" гэсэн нэр томъёог хэрэглэхийг хязгаарлах

60.1.Даатгагч нь онооосон нэртэй байх бөгөөд уг нэрийн ард "даатгал" гэсэн үгийг заавал хэрэглэнэ.

60.2.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд "даатгал", эсхүл

"даатгал" гэсэн үгний төрөл үг хэрэглэх, даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл уг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц нэр томъёо ашиглах болон тэдгээртэй адилтгах бусад үйлдэл хийхийг хориглоно.

60.3.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасны дагуу даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөлтэй компанид энэ хуулийн 60.1 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд тэдгээрийн нэр нь зөвхөн тухайн төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг болохыг илэрхийлсэн байвал зохино.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ

Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах

61 дүгээр зүйл. Үйл ажиллагааны шалгалтад хамаарах холбогдох этгээд

61.1.Энэ хуулийн арвангуравдугаар бүлэгт заасан "холбогдох этгээд" гэдэгт даатгагч болон даатгагч байсан этгээд, эсхүл түүний хараат болон охин компани хамаарна.

62 дугаар зүйл. Холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалт

62.1.Зохицуулах хороо холбогдох этгээдийн үйл ажиллагааг энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шалгах зорилгоор дараахь арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

62.1.1.холбогдох этгээдийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, баримт бичгийг шалгах;

62.1.2.холбогдох этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, бэлэн мөнгө зэргийг шалгах, тоолох;

62.1.3.холбогдох этгээдийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлан авч хянаж шалгах.

62.2.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдэд хяналт тавихтай холбоотой дараахь асуудлыг судлан үзэж болно:

62.2.1.нөөцийн сан, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон хөрөнгийг шалгах;

62.2.2 энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэм болон Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа эсэх.

62.3.Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалтын удирдамжийг холбогдох этгээдэд урьдчилан танилцуулна.

62.4.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

62.5.Үйл ажиллагааны шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа холбогдох этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

63 дугаар зүйл. Үйл ажиллагааны шалгалттай холбоотой холбогдох этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

63.1.Холбогдох этгээд үйл ажиллагааны шалгалтын үед дараахь үүрэг хүлээнэ:

63.1.1.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

63.1.2.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

63.1.3.шаардлагатай мэдээлэл, тайлбараар хангах;

63.1.4.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс олж авч Зохицуулах хороонд өгөх.

63.2.Зохицуулах хороо шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгөхийг холбогдох этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас бичгээр шаардаж болно.

64 дүгээр зүйл. Шалгалтын тайлан

64.1.Зохицуулах хороо нь үйл ажиллагааны шалгалт дуусснаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

64.2.Шалгалтын тайланд дараахь зүйлийг тусгана:

64.2.1.холбогдох этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаархи зөвлөмж;

64.2.2.тайлантай холбогдуулан холбогдох этгээдээс хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзэж буй асуудлын талаар.

64.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол холбогдох этгээд тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Зохицуулах хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

65 дугаар зүйл. Зохицуулах хорооны мэдээлэл цуглуулах эрх

65.1.Зохицуулах хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн

эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 65.2-т заасан эгтээдээс дараахь зүйлийг биечээр шаардаж болно:

65.1.1.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

65.1.2.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

65.2.Энэ хуулийн 65.1-д заасан мэдэгдлийг холбогдох эгтээд болон түүнтэй холбоотой эгтээд, даатгагч, эсхүл мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн эгтээдэд өгөх бөгөөд мэдэгдэлд мэдээлэл, баримт бичигийг гаргаж өгөх буюу үйлдэх хугацаа, газрыг заана.

65.3.Энэ хуулийн 65.2-т заасан "холбоотой эгтээд"-ийг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

65.4.Зохицуулах хороо энэ хуулийн 65.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь шаардлагыг тавьж болно:

65.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

65.4.2.уг мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

65.4.3.уг мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

65.5.Зохицуулах хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

65.6.Зохицуулах хорооноос энэ хуулийн 65.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан эгтээд заавал биелүүлэх үүрэгтэй.

66 дугаар зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

66.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг биечээр хүссэн тохиолдолд Зохицуулах хороо энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу холбогдох, мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

66.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, биечи баримтаар хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараахь асуудлыг анхаарна:

66.2.1.Гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

66.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

66.2.3.асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;

66.2.4.мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

66.2.5.энэ хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

66.3.Зохицуулах хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

66.4.Гадаадын зохицуулах байгууллага энэ хуулийн 66.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Зохицуулах хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлага

67 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

67.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр даатгагчид албадлагын арга хэмжээ авч болно:

67.1.1.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн;

67.1.2.даатгуулагчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

67.1.3.даатгагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

67.1.4.Зохицуулах хорооноос энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

67.1.5.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

67.1.6.тусгай зөвшөөрөл үзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангараа буюу бусад этгээдтэй хамтран үзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

67.1.7.даатгагч татан буугдсан;

67.1.8.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих өсөөр хөтлөөгүй;

67.1.9.даатгалын үйл ажиллагааг зохистой явуулаагүй;

67.1.10.холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Зохицуулах хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

67.1.11.даатгалын эрсдлээ

хязгаарлах зорилгоор давхар даатгалын төлөвлөгөө хийгээгүй, эсхүл давхар даатгалын төлөвлөгөө нь даатгалын багц дүрэмд заасан шаардлага хангахгүй;

67.1.12.бизнес төлөвлөгөөг дагаж мөрдөөгүй буюу хамгийн сүүлд батлсан бизнес төлөвлөгөөг нөцтойгоор зөрчсөн;

67.1.13.Зохицуулах хороонооос ногдуулсан торгуулийг хугацаанд нь төлөөгүй;

67.1.14.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

68 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

68.1.Зохицуулах хороо энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлээр дараахь төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

68.1.1.түгээл зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

68.1.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

68.1.3.энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу шалгагч томилох;

68.1.4.энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

68.1.5.даатгалын үйл ажиллагаог зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох;

68.1.6.торгох.

69 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

69.1.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

69.1.1.энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

69.1.2.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

69.1.3.тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

69.2.Тусгай зөвшөөрлийг дараахь хугацаагаар түдгэлзүүлнэ:

69.2.1.Зохицуулах хороонооос тогтоосон хугацаагаар;

69.2.2.Зохицуулах хороонооос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

69.3.Энэ хуулийн 69.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

69.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш энэ хуулийн 69.2.2-т заасан шаардлагыг 6 сарын дотор биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

69.5.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

69.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 69.5-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

69.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

69.7.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

69.7.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

69.7.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

70 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

70.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

70.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

70.1.2.даатгалын компани татан буугдсан;

70.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

70.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

70.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

70.2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

70.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

70.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

70.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

70.4.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл; огноо.

71 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

71.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгагч Зохицуулах хороонооc бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

71.1.1.шинээр даатгалын гэрээ байгуулах;

71.1.2.тухайн өдрөөс өмнө байгуулсан даатгалын гэрээг шинэчлэх, өөрчлөх.

71.2.Шаардлагатай гэж үзвэл даатгагч нь даатгалын гэрээгээр хүлээсэн үүрэг, давхар даатгалын хураамжийн төлбөр болон гэрээнээс үүссэн бусад зардлыг төлөх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

71.3.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаархи мэдээллийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

72 дугаар зүйл. Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

72.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 69.1, 70.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон зээлдүүлэгч, даатгуулагчийн ашиг сонирхол, даатгагчийн өмч хөрөнгө, үйл ажиллагаат хамгаалах зорилгоор Зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

72.2.Зохицуулах хороо энэ хуулийн 72.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгагчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

72.3.Даатгагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 69.5, 70.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгагчид өгөхөөс өмнө гаргаж болно.

72.4.Энэ хуулийн 72.1-д заасан нэхэмжлэлийн дагуу шүүх дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

72.4.1.даатгагч болон бусад этгээдийн зээмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

72.4.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө даатгагчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

72.4.3,компанийг татан буулгах;

72.4.4.даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

72.5.Шүүх энэ хуулийн 72.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Зохицуулах хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

72.6.Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараахь арга хэмжээг хэдийд ч авч болно:

72.6.1.эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

72.6.2.эрх хэмжээг нь өөрчлөх;

72.6.3.бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

73 дугаар зүйл. Даалгавар

73.1.Зохицуулах хороо даатгагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараахь агуулга бүхий даалгаврыг өгч болно:

73.1.1.даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

73.1.2.даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэртэй холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

73.1.3.байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;

73.1.4.даатгалын нийт хураамжийн хэмжээг даалгаварт заасан хэмжээгээр тогтоох;

73.1.5.тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахыг хориглох;

73.1.6.тодорхой хугацааны дотор өөрийн эзэмшилд буй хөрөнгө оруулалтыг чөлөөлөх;

73.1.7.хуульд заасан хугацаанаас өмнө санхүүгийн хяналт шалгалт хийх, шалгалттай холбогдуулан актуарч болон бусад этгээдийг томилох;

73.1.8.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэмд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

73.1.9.бизнес төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

73.1.10.даатгуулагч болон хувь нийлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор

шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

73.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон бол шаардлагатай гэж үзсэн бусад даалгаврыг өгч болно.

73.3.Энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгагч биелүүлэх үүрэгтэй.

73.4.Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон этгээдэд энэ хуулийн 73 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

74 дүгээр зүйл. Шалгагчийг томилох

74.1.Зохицуулах хороо энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагаат хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

74.2.Энэ хуулийн 74.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараахь асуудлыг хянан шалгаж болно:

74.2.1.даатгагчийн үйл ажиллагаа, түүний шинж чанар;

74.2.2.даатгагчийн үйл ажиллагааны тодорхой асуудлууд;

74.2.3.даатгагчийн болон хувь нийлүүлэгчдийн хяналт.

74.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагаат хэдийд ч шалгаж болно.

74.4.Шалгачийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Зохицуулах хороо өөрийн үзэмжээр тогтооно.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагаат шилжүүлэх, нэгтгэх

75 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаат шилжүүлэх болон нэгтгэх

75.1.Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлтээ Зохицуулах хороонд гаргаж бичгээр зөвшөөрөл авна.

75.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд даатгагчид дараахь зүйлийг хориглоно:

75.2.1.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх;

75.2.2.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх.

75.3.Энэ хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх болон нэгтгэх тухай өргедэл гаргах, өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаат даатгалын багц дүрмээр зохицуулна.

75.4.Шилжүүлэх болон нэгтгэх тухай зөвшөөрлийг олгохоос өмнө Зохицуулах хороо дараахь арга хэмжээг авч болно:

75.4.1.шилжүүлэх болон нэгтгэх нь зохимжтой эсэх талаар судлах;

75.4.2.даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, мэдээллийг шаардаж авах.

75.5.Энэ хуулийн 75.4.1-д заасныг Зохицуулах хороо буюу түүний эрх олгосон этгээд хэрэгжүүлэх бөгөөд зардлыг даатгагч хариуцна.

75.6.Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх, эсхүл бусдын үйл ажиллагаатай нэгтгэх үр дагавар бүхий даатгагчийн байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

75.7.Зохицуулах хороо нь даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх тухай гаргасан өргөдлийг нээлттэй хурлаар хэлэлцэж болох бөгөөд даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай нотлох баримт шаардаж болно.

АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ

Даатгагчийг татан буулгах

76 дугаар зүйл. Даатгагчийн дампуурал

76.1.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

76.2.Шүүх дараахь асуудлын талаар Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо уг асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй:

76.2.1.Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгүүлэх тухай шүүхэд гаргасан нэхэмжлэл болон хүсэлт;

76.2.2.Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгэсэнтэй холбоотой гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргаж буй аливаа гомдол;

76.2.3.даатгагчийн дампууралтай холбоотой Дампуурлын тухай хуулийн дагуу шүүхээс шийдвэрлэж буй бусад асуудал.

76.3.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан тохиолдолд Зохицуулах хороо Дампуурлын тухай хуулийн 5.7-д заасан хэрэг гүйцэтгэгчийг тур томилуулахаар хүсэлт гаргаж болох бөгөөд түүнд тохирох мэргэжил, даалгага туршлага бүхий хүнийг санал болгож болно.

76.4.Даатгагч дампуурсан тухайгаа зарласан тохиолдолд Зохицуулах хороо тохирох мэргэжил, даалгага туршлага бүхий хүнийг хэрэг гүйцэтгэгчээр томилуулахаар шүүхэд санал тавих бөгөөд энэ тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 8.2 дахь хэсэг үйлчлэхгүй.

76.5.Шүүх Зохицуулах хорооноос санал болгосон этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр томилж болно.

76.6.Хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчээр тур томилогдсон этгээд нь Дампуурлын тухай хуулийн 11.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна даатгалын компанийн үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй байна.

76.7.Зохицуулах хороо нь Дампуурлын тухай хуулийн 8.3.3, 8.3.4, 8.3.6-д заасан асуудлаар шийдвэр гаргах эрхтэй.

76.8.Хэрэг гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны тухай Зохицуулах хорооны шаардлагатай гэж үзсэн мэдээлэл, тайланг гаргаж өгөх үүрэгтэй.

76.9.Зохицуулах хороо хариуцагч болон хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар шүүхэд хэдийд ч гомдол гаргах эрхтэй.

76.10.Хариуцагч нь даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Дампуурлын тухай хуульд заасан аливаа хугацааг шүүх өөрийн үзэмжээр сунгах эрхтэй.

77 дугаар зүйл. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх

77.1.Дампуурлын тухай хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж байгаа, мөн хуулийн 24.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд гаргаж буй этгээд нь уг хүсэлт, төлөвлөгөөний хуулбарыг Зохицуулах хороонд хүргүүлнэ.

77.2.Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж буй нэхэмжлэгчдийн хуралд Зохицуулах хороо оролцож саналаа илэрхийлэх эрхтэй.

77.3.Шүүх даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр батлахгүй.

77.4.Шүүхээс даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах үйл ажиллагаанд Дампуурлын тухай хуулийн 28 дугаар зүйл үйлчлэхгүй.

78 дугаар зүйл. Даатгагчийг татан буулгах

78.1.Даатгагчийг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулагүй харилцаг Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

78.2.Даатгагчийг дараахь тохиолдолд татан буулгана:

78.2.1.шүүхийн шийдвэрээр;

78.2.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр.

78.3.Даатгагчийг татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр нь Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хүчин төгөлдөр бус байна.

78.4.Энэ хуулийн 78.2-т зааснаас бусад тохиолдолд даатгагчийг татан буулгасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

78.5.Дараахь тохиолдолд Зохицуулах хороо даатгалын компанийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

78.5.1.даатгалын компани төлберийн чадваргүй болсон;

78.5.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

78.6.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хуулийн этгээдийг татан буулгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

78.7.Даатгагчийг татан буулгахаар нэхэмжлэл гаргасан тухай шүүх Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо нэхэмжлэлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

78.8.Дампуурлын тухай хуулийн дагуу даатгагчийг татан буулгахад шүүх хяналт тавих бөгөөд Дампуурлын тухай хуулийн 38.1 дэх хэсэг үйлчлэхгүй.

79дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах

79.1.Энэ хуулийн 78.2.2-т заасны дагуу гаргасан хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах тухай өргөдлөл татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалтыг хавсаргана.

79.2.Зохицуулах хороо хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах зөвшөөрлийг дараахь тохиолдолд олгохгүй:

79.2.1.даатгагчийн хөрөнгийн нийт үнэлгээнээс түүний хүлээсэн үүргийг хасаж үлдсэн хэсэг нь энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан төлберийн чадварын шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг хангахгүй;

79.2.2.татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй.

79.3.Хувь нийлүүлэгчдийн хурлаас даатгагчийг татан буулгах тухай тогтоолыг батлахдаа татан буулгах комиссыг томилно.

79.4.Татан буулгах комисс томилогдсон тухайгаа тогоолд заасан хугацаанд Зохицуулах хороонд мэдэгдэх үүрэгтэй.

79.5.Татан буулгах комиссын эрх хэмжээг Зохицуулах хорооноос холбогдох хуульд нийцүүлэн тогтооно.

80 дугаар зүйл. Даатгагчийн урт хугацааны сан

80.1.Урт хугацааны даатгагч нь удаан хугацаагаар тогвортой үйл ажиллагаа эрхлэх үүднээс урт хугацааны сан бүрдүүлнэ.

80.2.Урт хугацааны даатгагч Дампуурлын тухай хууль болон бусад хуулийн дагуу татан буугдахад даатгагчийн урт хугацааны санг эвэхэн энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу зарцуулна.

80.3.Даатгагчийн урт хугацааны сан нь тус санд хамаарах даатгагчийн урт хугацаат үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулагдах бөгөөд энэ хэмжээгээрээ даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцогдохгүй.

80.4.Энэ хуулийн 80.3-т заасны дагуу зарцуулсны дараа үлдсэн хөрөнгийг Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцож болно.

АРВАНДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад

81 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

81.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

81.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

81.1.2.даатгагч, эсхүл даатгагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

81.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

81.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 81.1 дэх хэсэг хамаарахгүй:

81.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

81.2.2.Зохицуулах хороо шаардсан;

81.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

81.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

81.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

81.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 81.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

81.2.7.энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

82 дугаар зүйл.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдах

82.1.Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.

82.2.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдсан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд даатгагчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг шийдвэрлэхэд Захиргааны хариуцлагын тухай[8] хуулийн 19.2, 19.3 дахь хэсэг хамаарахгүй.

83 дугаар зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

83.1.Даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь хариуцлага ногдуулна:

83.1.1.тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хураах 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.2.энэ хуулийн 17.2-т заасны дагуу Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй гадаад улсын даатгагчтай даатгалын гэрээ байгуулсан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.3.энэ хуулийн 21.1, 21.2-т заасны дагуу Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй өөрийн эзэмшиж буй хөрөнгийг бусдад шилжүүлсэн

[8] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №4,5

буюу өөртөө шилжүүлэн авсан, эсхүл энэ хуулийн 21.3-ыг зөрчсөн бол 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.4.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.5.энэ хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчаас гаргаж буй хувьцааны төлбөрийг менгөн бус хэлбэрээр гүйцэтгэсэн бол 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.6.энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөөгүй бол даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.7.энэ хуулийн 25.2-т заасны дагуу нөөц санг бүрдүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.8.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчиж нөгөдөл ашиг хуваарилсан, эсхүл хуваарилахаар зарласан даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.9.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.10.энэ хуулийн 29.2, 29.6, 67.1.8-д заасныг зөрчиж нягтлан бодох болон санхүүгийн бүртгэлээ зохих ёсоор хөтлөөгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.11.энэ хуулийн 33.2-т заасны зөрчиж аудиторыг томилсон бол албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.12.энэ хуулийн 36.1, 36.2-т заасан үүргээ биелүүлээгүй аудиторыг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.13.энэ хуулийн 38.1, 42.3-т заасны дагуу Зохицуулах хорооноос тавьсан шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-100000 төгрөгөөр торгох;

83.1.14.энэ хуулийн 39.1-д заасныг зөрчиж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд актуарчаар ажилласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.15.энэ хуулийн 40 дугаар зүйлд заасны дагуу өөрийн актуарчийг томилоогүй, эсхүл энэ хуулийн 42.1-д заасны дагуу актуарын хязгалт шалгалт хийлгээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.16.энэ хуулийн 41, 44 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй актуарчийг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.17.энэ хуулийн 47.1, 50 дугаар зүйлд заасны дагуу давхар даатгалын болон бизнес төлөвлөгөөг батлуулаагүй, эсхүл эдгээр төлөвлөгөөг дагаж мөрдөх үүргээ биелүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.18.энэ хуулийн 48.1-д заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайлбар гаргаж өгөөгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.19.энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасныг зөрчиж даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоогүй үйл ажиллагаа эрхэлсэн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.20.энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасныг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.21.энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу даатгагчийн оршин байгаа газрын хаяг болон түүний өөрчлөлтийг мэдэгдээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.22.энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан салбар, төлөөлөгчийн газар нээхтэй холбогдсон журмыг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.23.энэ хуулийн 55.1-д заасныг зөрчиж Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр эрх бүхий албан тушаалтныг томилсон бол албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.24.энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан нэр ашиглах журмыг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.25.энэ хуулийн 63 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.26.энэ хуулийн 64.3-т заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.27.энэ хуулийн 65.6-т заасан мэдэгдлийг биелүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.28.энэ хуулийн 71.1-д заасныг зөрчиж шинээр даатгалын гэрээ байгуулсан, даатгалын гэрээнд өөрчлөлт оруулсан даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.29.энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгсөн

даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.30.энэ хуулийн 75.1-д заасныг зөрчиж Зохицуулах хорооноос зөвшөөрөл авалгүйгээр даатгалын үйл ажиллагаа шилжүүлсэн, нэгтгэсэн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.31.энэ хуулийн 22.4, 24.4, 25.4, 40.2, 55.3, 57 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хороонд мэдэгдээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.32.даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооны гаргасан шийдвэрийг биелүүлээгүй эсвэл, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.33.хуулиар тогтоосон заавал даатгалд даатгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр, иргэнийг 5000-20000 төгрөгөөр торгох.

84 дүгээр зүйл. Зохицуулах хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

84.1.Зохицуулах хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын багц дүрэмд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

85 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

85.1.Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

85.2.Энэ хуулийн даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг заасан 22.1 дэх хэсгийг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр **Улаанбаатар хот**

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж

2.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Компанийн тухай хууль[3], Даатгалын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулагдуй харилцаг Даатгалын тухай хуулийн дагуу зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн энэ хуулийн 3.2-т зааснаас бусад нэр томъёог Даатгалын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

3.2.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

[1] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №1
[2] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны №7
[3] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны № 34

3.2.1."даатгалын мэргэжлийн оролцогч" гэж даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийг;

3.2.2."даатгалын төлөөлөгч" гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг;

3.2.3."даатгалын зуучлагч" гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээдийг;

3.2.4."даатгалын хохирол үнэлэгч" гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг;

3.2.5."Зохицуулах хороо" гэж Даатгалын тухай хуулийн 12.1-д заасан байгууллагыг;

3.2.6."гадаадын мэргэжлийн оролцогч" гэж гадаад улсад үүсгэн байгуулагдаж, үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийг.

3.3.Даатгагчаас цалинжин ажиллаж буй ажилтан энэ хуулийн 3.2.2-т заасан даатгалын төлөөлөгчид хамаарахгүй.

3.4.Дараахь этгээдийг энэ хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч гэж тооцохгүй:

3.4.1.даатгагчийн буюу даатгалын төлөөлөгчийн ажилтан;

3.4.2.даатгалын төлөөлөгч.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг төрөөс зохицуулах

4 дүгээр зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага

4.1.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага нь даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

4.1.2.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

5 дугаар зүйл. Зохицуулах хороо

5.1.Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг хяналт тавих;

5.1.2.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

5.1.3.даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан этгээдэд арга хэмжээ авах;

5.1.4.даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах багц дүрэм

6.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг Зохицуулах хорооноос батлагдсан даатгалын багц дүрмээр зохицуулна.

6.2.Даатгалын багц дүрэмд Даатгалын тухай хуулийн 14.2-т заасснаас гадна дараахь дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлага, хэмжээ багтана:

6.2.1.даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага;

6.2.2.даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах шаардлага;

6.2.3.даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам;

6.2.4.энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;

6.2.5.Зохицуулах хороонд төлөх төлбөр, хураамжийн хэмжээ;

6.2.6.гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага;

6.2.7.Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах гадаадын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага;

6.2.8.даатгалын мэргэжлийн оролцогчоос энэ хуульд заасны дагуу тайлан, мэдээ гаргах заавар.

7 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны журам

7.1.Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаагаа зохистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно.

7.2.Даатгалын мэргэжлийн оролцогч энэ хуулийн 7.1-д заасан журмыг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй боловч ийнхүү дагаж мөрдөөгүй нь түүнд хариуцлага ногдуулахад түүнийг даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрлийг зэрэмших тохиромжтой бус этгээд, эсхүл үйл ажиллагаагаа зохистой явуулаагүй гэж үзэх нөхцөл болж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

8 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл

8.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь дараахь төрөлтэй байна:

8.1.1 даатгалын төлөөлөгчийн;

8.1.2.даатгалын зуучлагчийн;

8.1.3.даатгалын хохирол үнэлэгчийн.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

9.1.Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа этгээд Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

9.2.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол энэ хуулийн 9.1-д заасны дагуу Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулсанд тооцно.

9.3.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон даатгалын мэргэжлийн оролцогч энэ хуулийн 9.1-д заасанчлан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах эрхгүй.

9.4.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[4] хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

10.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэн этгээд Зохицуулах хороонд өргөдөл гаргана.

10.2.Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд эрхлэх үйл ажиллагааны төрлийг зааж, Зохицуулах хороонооос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

10.3.Даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь эрхлэх үйл ажиллагаандаа хамаарах даатгалын төрөл, хэлбэрийг өргөдөлд заана.

10.4.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд даатгагчийн зөвшөөрлийг өргөдөлд хавсаргана.

10.5.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

11.1.Зохицуулах хороо дараахь шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн төрөл, хэлбэрээс хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

[4] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны №6

11.1.1.тусгай зөвшөөрөл олгосон нь энэ хуулийн 12 дугаар зүйлийг зөрчихөөргүй бол;

11.1.2.өргөдөл гаргагч нь даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

11.1.3.өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол түүний эрх бүхий албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд тус тус тохиромжтой этгээд бол;

11.1.4.өргөдөл гаргагч энэ хууль болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

11.1.5.тухайн төрлийн даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхэд өргөдөл гаргагчийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр хангалттай гэж үзвэл;

11.1.6.өргөдөл гаргагчийн нэр нь өргөдөл гаргагч даатгалын үйл ажиллагаа эрхлэх, эсхүл даатгалын зуучлагчийн тухайн үйл ажиллагааг эрхэлнэ гэдгийг илэрхийлэхгүй бол;

11.1.7.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

11.2.Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны цар хүрээ, тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрээс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

11.3.Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

11.3.1.тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

11.3.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

11.3.3.эрхлэх үйл ажиллагааны төрөл;

11.3.4.даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн хувьд эрхлэх даатгалын үйл ажиллагааны төрөл, хэлбэр;

11.3.5.даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийн зөвшөөрөл;

11.3.6.эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;

11.3.7.тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

11.3.8.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга/тэмдэг/.

11.4.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

11.5.Зохицуулах хороо өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн боловч даатгалын мэргэжлийн оролцогчийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөгүй бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

11.6.Зохицуулах хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

11.7.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

11.8.Зохицуулах хороо энэ хуулийн 11.1-д заасан "тохиромжтой этгээд"-ийг тодорхойлох заавриг гаргаж болно.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хязгаарлалт

12.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн компанид олгоно.

12.2.Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээдэд даатгалын төлөөлөгч болон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй.

12.3.Даатгагчид даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг олгохгүй.

12.4.Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээдэд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.

12.5.Даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг давхардуулан олгохгүй.

12.6.Даатгалын хохирол үнэлэгчид даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

13 дугаар зүйл. Гадаадын мэргэжлийн оролцогч

13.1.Гадаадын мэргэжлийн оролцогч нь гагцхүү Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

13.2.Гадаадын мэргэжлийн оролцогч нь энэ хуулийн 13.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл авааруй тохиолдолд аливаа эттээд гадаадын мэргэжлийн оролцогчийг төлөөлж дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

13.2.1.мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах зорилгоор суурьлчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;

13.2.2.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

13.3.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй этгээд нь Зохицуулах хороонд өргөдөл гаргана.

13.4.Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд холбогдох журамд заасан баримт бичгийг хавсаргана.

13.5.Зохицуулах хороо энэ хуулийн 13.1-д заасан зөвшөөрлийг хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

13.6.Энэ хуулийн 13.1-д заасан зөвшөөрөл олгохдоо Зохицуулах хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

[3] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны №4

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хөрөнгө, хувьцаа

14 дүгээр зүйл. Дүрмийн сангийн доод хэмжээ

14.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд дараахь хэмжээтэй байна:

14.1.1.даатгалын багц дүрэмд заасан хэмжээнээс багагүй;

14.1.2.энэ хуулийн 14.2-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй.

14.2.Зохицуулах хороо тухайн даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 14.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан дүрмийн сангийн доод хэмжээнд хүрэх боломжит хугацааг даатгалын мэргэжлийн оролцогчид олгоно.

14.4.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан энэ хуулийн 14.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд энэ тухай Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

15 дугаар зүйл. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хувьцаа

15.1.Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн гаргаж буй бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

15.2.Даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгчид Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл хамаарахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

16 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

16.1.Даатгалын мэргэжлийн оролцогч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль[5] болон даатгалын багц дүрэмд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

16.2.Даатгалын мэргэжлийн оролцогч нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөх

бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.2 дахь хэсэг хамаарахгүй.

16.3.Даатгалын багц дүрэмд өөрөөр заагаагүй бол Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг тогтоож болно.

16.4.Даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.2 болон даатгалын багц дүрэмд заасан, эсхүл энэ хуулийн 16.3-т заасан Зохицуулах хорооноос тогтоосон бусад баримт бичгээс бүрдэнэ.

16.5.Даатгалын мэргэжлийн оролцогч нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ 6 жилээс доошгүй хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

17 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт хэрэглэх

17.1.Даатгалын мэргэжлийн оролцогч нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө.

18 дугаар зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

18.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд дараахь баримт бичгийн хамт Зохицуулах хороонд тушаана:

18.1.1.удирдлагын тайлан;

18.1.2.аудитын дүгнэлт;

18.1.3.тухайн санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйл явдлын тухай тодруулга, тайлбар;

18.1.4.багц дүрэмд заасан бусад баримт бичиг.

18.2.Жил бүрийн санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлэхдээ тохиолдолд санхүүгийн тайланг өөрөүйд тооцно.

[6] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны №6

19 дүгээр зүйл. Улирал тутмын санхүүгийн тайлан

19.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь улирал тутмын санхүүгийн тайлангаа даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Зохицуулах хороонд тушаана.

19.2.Улирал тутмын санхүүгийн тайлан, холбогдох бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлэхдээ тохиолдолд тайланг өөрөүйд тооцно.

20 дугаар зүйл. Аудит

20.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор аудиторыг томилно.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан аудитор нь дараахь шаардлагыг хангасан байна:

20.2.1.Аудитын тухай[6] хуулийн 17 дугаар зүйлд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй;

20.2.2.даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрхийг Зохицуулах хорооноос авсан.

20.3.Зохицуулах хороо энэ хуулийн 20.2-т заасан аудиторын нэрсийн жагсаалт болон түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

20.4.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь аудиторыг аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

20.5.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч аудиторыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

21 дүгээр зүйл. Аудитын тайлан

21.1.Аудитор нь санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчид хүргүүлнэ.

21.2.Зохицуулах хороо эд хөрөнгийн чанар, эрсдлийн сангийн зохистой харьцаа, нягтлан бодох бүртгэл болон хяналтын тогтолцооны зохистой

харьцааг тодорхойлох зорилгоор аудитын тайлан гаргаж өгөхийг даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчээс хэдийд ч шаардаж болно.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч хариуцна.

22 дугаар зүйл. Аудиторын үүрэг

22.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар аудитор нь Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

22.1.1.даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч төлбөрийнчадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа;

22.1.2.эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэсэн байж болзошгүй;

22.1.3.энэ хуулийн 14, 15 дугаар зүйлийг зөрчсөн;

22.1.4.энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг ноцтойгоор зөрчсөн гэж үзсэн.

22.2.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь аудитортай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд аудитор Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

22.2.1.гэрээг цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

22.2.2.энэ хуулийн 21, 22.1-д заасан тайлан болон мэдээллийн талаар.

22.3.Зохицуулах хороо аудитороос аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, нэмэлт материал шаардаж болно.

22.4.Аудитор болон аудитор байсан этгээд энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

23 дугаар зүйл. Зохицуулах хорооноос аудиторыг томилох

23.1.Хэрэв даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч энэ хуулийн 20.1-д заасны дагуу аудиторыг томилоогүй бол Зохицуулах хороо аудиторыг томилж болно.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан аудитор нь даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн аудиторын энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Даатгалын мэргэжлийн оролцогчид тавих хязгаарлалт

24 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогч, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтанд тавих хязгаарлалт

24.1.Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтныг даатгагчийн захирлаар томилж болохгүй.

24.2.Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийг даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнаар томилж болохгүй.

25 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүй даатгагч

25.1.Даатгалын мэргэжлийн оролцогч Даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авааг үй даатгагчтай хамтран үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

25.2.Энэ хуулийн 25.1 дэх хэсэг даатгалын мэргэжлийн оролцогч гадаадын даатгагчтай хамтран ажиллахад хамаарахгүй.

26 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн төлбөр, хөлс, хураамж

26.1.Даатгалын мэргэжлийн оролцогч дор дурдсанаас бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж буй

хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг хориглоно:

26.1.1.даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг даатгагч эвслөөрсөн;

26.1.2.Зохицуулах хорооноос эрх олгосон.

27 дугаар зүйл. Мэдээллийг өөрчлөх

27.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж байгаа этгээд, эсхүл даатгалын мэргэжлийн оролцогч болон бусад этгээдээс энэ хууль, даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороонд гаргаж буй зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Зохицуулах хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Зах зээлийн ёс зүй

28 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

28.1.Даатгалын мэргэжлийн оролцогч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

28.2.Даатгалын мэргэжлийн оролцогч болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

29 дүгээр зүйл. Зах зээлийн ёс зүй

29.1.Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журам гаргаж болох бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогч, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох бусад этгээд түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах

30 дугаар зүйл. Үйл ажиллагааны шалгалтад хамаарах холбогдох этгээд

30.1.Энэ хуулийн наймдугаар бүлэгт заасан "холбогдох этгээд" гэдэгт даатгалын мэргэжлийн оролцогч, даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компани хамаарна.

31 дүгээр зүйл. Холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалт

31.1.Зохицуулах хороо холбогдох этгээдийн үйл ажиллагааг энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шалгах зорилгоор дараахь арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

31.1.1.холбогдох этгээдийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, баримт бичгийг шалгах;

31.1.2.холбогдох этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, бэлэн мөнгө зэргийг шалгах, тоолох;

31.1.3.холбогдох этгээдийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлаж авах, хянан шалгах.

31.2.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдэд хяналт тавихтай холбоотой дараахь асуудлыг судлан үзэж болно:

31.2.1.холбогдох этгээдийн эд хөрөнгийг шалгах;

31.2.2.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэм болон Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа эсэх.

31.3.Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалтын удирдамжийг холбогдох этгээдэд урьдчилан танилцуулна.

31.4.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

31.5.Үйл ажиллагааны шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа холбогдох этгээдийн едөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

32 дугаар зүйл. Үйл ажиллагааны шалгалттай холбоотой холбогдох этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

32.1.Холбогдох этгээд үйл ажиллагааны шалгалтын үед дараахь үүрэг хүлээнэ:

32.1.1.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

32.1.2.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

32.1.3.шаардлагатай мэдээлэл, тайлбараар хангах;

32.1.4.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс олж авч Зохицуулах хороонд өгөх.

32.2.Зохицуулах хороо шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгөхийг холбогдох этгээдийн эрх бухий албан тушаалтан болон ажилтнаас шаардаж болно.

33 дугаар зүйл. Шалгалтын тайлан

33.1.Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалт дуусснаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

33.2.Шалгалтын тайланд дараахь зүйлийг тусгана:

33.2.1.холбогдох этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаархи зөвлөмж;

33.2.2.тайлантай холбогдуулан хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзсэн асуудлын талаар.

33.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол холбогдох этгээд тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Зохицуулах хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

34 дүгээр зүйл. Зохицуулах хорооны мэдээлэл цуглуулах эрх

34.1.Зохицуулах хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 34.2-т заасан этгээдээс дараахь зүйлийг бичгээр шаардаж болно:

34.1.1.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

34.1.2.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд, даатгалын мэргэжлийн оролцогч эсхүл, мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд уг мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх болон үйлдэх хугацаа, газрыг заана.

34.3.Энэ хуулийн 34.2-т заасан "холбоотой этгээд"-ийг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

34.4.Зохицуулах хороо энэ хуулийн 34.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь шаардлагыг тавьж болно:

34.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

34.4.2.мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

34.4.3.мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

34.5.Зохицуулах хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

34.6.Зохицуулах хорооноос энэ хуулийн 34.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд уг мэдэгдлийг заавал биелүүлэх үүрэгтэй.

35 дугаар зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

35.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Зохицуулах хороо энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу холбогдох мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

35.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, баримт бичгээр хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараахь асуудлыг анхаарна:

35.2.1.гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

35.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн аших сонирхолд нийцэх байгаа эсэх;

35.2.3.асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;

35.2.4.мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлөсөн эсэх;

35.2.5.энэ хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

35.3.Зохицуулах хороо гадаадын зохицуулах байгууллагын хүсэсэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

35.4.Гадаадын зохицуулах байгууллага нь энэ хуулийн 35.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлэгүй бол Зохицуулах хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлага

36 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

36.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр даатгалын мэргэжлийн оролцогчид албадлагын арга хэмжээ авч болно:

36.1.1.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн;

36.1.2.үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд, даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

36.1.3.даатгалын мэргэжлийн оролцогч төлберийн чадваргүй болсон буюу төлберийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

36.1.4.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

36.1.5.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

36.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

36.1.7.Зохицуулах хороонд бодитой бус, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн нь тогтоогдсон;

36.1.8.даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч татан буугдсан;

36.1.9.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүй;

36.1.10.холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Зохицуулах хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

36.1.11.Зохицуулах хорооноос ногдуулсан торгуулийг хугацаанд нь төлөөгүй;

36.1.12.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

37 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

37.1.Зохицуулах хороо энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан үндэслэлээр дараахь төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

37.1.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

37.1.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

37.1.3.энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу шалгагч томилох;

37.1.4.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

37.1.5.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий, дадлага туршлагатай мэргэжилтэн томилох;

37.1.6.торгох.

38 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

38.1.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

38.1.1.энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

38.1.2.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

38.1.3.тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлберийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

38.2.Тусгай зөвшөөрлийг дараахь хугацаагаар түдгэлзүүлнэ:

38.2.1.Зохицуулах хорооноос тогтоосон хугацаагаар;

38.2.2.Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

38.3.Энэ хуулийн 38.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

38.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш энэ хуулийн 39.2.2-т заасан шаардлагыг 6 сарын дотор биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

38.5.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

38.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

38.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

38.7.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

38.7.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

38.7.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

38.8.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

39 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

39.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

39.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

39.1.2.даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч татан буугдсан;

39.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

39.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

39.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

39.2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

39.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

39.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

39.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

39.4.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл, огноо.

39.5.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

40 дүгээр зүйл. Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

40.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 38.1, 39.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон үйлчлүүлэгч, даатгуулагчийн ашиг сонирхол, даатгалын мэргэжлийн оролцогчийн өмч хөрөнгө, үйл ажиллагаат хамгаалах зорилгоор Зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

40.2.Зохицуулах хороо энэ хуулийн 40.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгалын мэргэжлийн оролцогчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

40.3.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 38,5, 39.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгалын мэргэжлийн оролцогчид өгөхөөс өмнө гаргаж болно.

40.4.Энэ хуулийн 40.1-д заасан нэхэмжлэлийн дагуу дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

40.4.1.холбогдох этгээдийн эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

40.4.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө

даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

40.4.3.компанийг татан буулгахаар шүүхэд хандах;

40.4.4.даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

40.5.Шүүх энэ хуулийн 40.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Зохицуулах хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

40.6.Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараахь арга хэмжээг хэдийд ч авч болно:

40.6.1.эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

40.6.2.эрх хэмжээг нь өөрчлөх;

40.6.3.бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

41 дүгээр зүйл. Даалгавар

41.1.Зохицуулах хороо даатгалын мэргэжлийн оролцогчид албадлагын арга хэмжээ авахдаа дараахь агуулга бүхий даалгаврыг өгч болно:

41.1.1.даатгалын мэргэжлийн оролцогчийн тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

41.1.2.тодорхой төрлийн үйл ажиллагаатай холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

41.1.3.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэмд зааснаас бөгино хугацаанд гаргаж өгөх;

41.1.4.үйлчлүүлэгч болон даатгалын төлөөлөгчийн хувьд төлөөлж буй даатгагчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

41.2.Энэ хуулийн 41.1-д заасны дагуу Зохицуулах хороноос өгч буй аливаа даалгаврыг даатгалын мэргэжлийн оролцогч биелүүлэх үүрэгтэй.

41.3.Энэ хуулийн 41 дүгээр зүйл тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон этгээдэд нэгэн адил хамаарна.

42 дугаар зүйл. Шалгагчийг томилох

42.1.Зохицуулах хороо энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагаат хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараахь асуудлыг хянан шалгаж болно:

42.2.1.тухайн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, шинж байдал;

42.2.2.тухайн этгээдийн үйл ажиллагааны тодорхой асуудал;

42.2.3.тухайн этгээдийн болон хувь нийлүүлэгчдийн хяналт

42.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагаат хэдийд ч шалгаж болно.

42.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Зохицуулах хороо өөрийн үзэмжээр тогтооно.

АРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

43 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

43.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

43.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

43.1.2.даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

43.1.3.үйлчлүүлэгч, эсхүл үйлчлүүлэгч байсан этгээд.

43.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 43.1 дэх хэсэг хамаарахгүй:

43.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

43.2.2.Зохицуулах хороо шаардсан;

43.2.3.шүүх болон прокурор, цагдаа, татнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

43.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

43.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

43.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 43.1-д заасан этгээдийг

таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

43.2.7.энэ хуулийн 35.1-д заасны дагуу гадаадын зохицуулах байгуллага бичгээр хүсэлт гаргасан.

44 дүгээр зүйл. Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдах

44.1.Аливаа этгээд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг зс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.

44.2.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдсан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааНд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19.2, 19.3 дахь хэсэг хамаарахгүй.

45 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага

45.1.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь захиргааны хариуцлага ногдуулна:

45.1.1.тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хураж, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр, даатгалын төлөөлөгчийг 200000-500000 төгрөгөөр торгох;

45.1.2.энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлэхгүй даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.3.энэ хуулийн 15.1-д заасны дагуу гаргаж буй хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэсэн даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.4.энэ хуулийн 16.2-т заасныг зөрчиж нягтлан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтлөөгүй даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.5.энэ хуулийн 20.2-т заасныг зөрчиж аудиторыг томилсон албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

45.1.6.энэ хуулийн 22.1, 22.2-т заасан үүргээ биелүүлээгүй аудиторыг 50000-100000 төгрөгөөр торгох;

45.1.7.энэ хуулийн 25.1-д заасныг зөрчиж тусгай зөвшөөрөлгүй даатгагчтай хамтран үйл ажиллагаа явуулсан даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.8.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчсөн даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.9.энэ хуулийн 32.1-д заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.10.энэ хуулийн 33.3-т заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.11.энэ хуулийн 34.6-д заасан мэдэгдлийг биелүүлээгүй даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.12.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

45.1.13.энэ хуулийн 14.4, 27 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хороонд мэдэгдээгүй даатгалын мэргэжлийн оролцогчийг 100000-150000 төгрөгөөр торгох;

45.1.14.даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооны гаргасан шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгалын мэргэжлийн оролцогчийг 500000-1000000 төгрөгөөр торгох.

46 дугаар зүйл. Зохицуулах хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

46.1.Зохицуулах хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын багц дүрэмд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

47дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

47.1.Энэ хуулийг Даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр — Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр — Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Банкны тухай" гэсний дараа "Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай" гэх нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр — Улаанбаатар хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хоршооны тухай хуулийн 8.4-ийн "тогтооно" гэснийг "тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавина" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Дугаар 21 — Улаанбаатар хот

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хавсралтаар батлсугай.

2.Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл боловсруулан ажиллах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

3.Бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо (Т.Ганди)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын 1996 оны 22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

А. Нийтлэг үндэслэл

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, эх орондоо иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг зорин буй цөөн хүн амтай, өргөн

уудам нутагтай, хүн амын нягтрал багатай, нүүдлийн бодлон суурин соёл иргэншилд хосолсон хөгжиж буй орон билээ.

Даяарчлагдаж буй дэлхий нийтийн хөгжлийн үйл явцад хүн амын идэвхтэй оролцоо чухал бөгөөд тэдний зүгээс хувь нэмрээ оруулахад нь тохиолдож буй бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх шаардлагатайг олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрч, Мянганы хөгжлийн зорилтоо тодорхойлон хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт 1986-2002 оны хооронд 2,8-аас 1,4 хувь болтлоо буурсан бөгөөд энэ бууралт цаашид хэвээр үргэлжилбэл 2025 он гэхэд 0,9 хувь болох төлөвтэй. Суүлийн 10-аад жилд хот суурин руу чиглэсэн хүн амын дотоод шилжих хөдөлгөөн эрчимжиж, суурьшлын хэв шинжид томоохон өөрчлөлт орох боллоо.

Хүн амын өсөлтийн сааралт, насны бүтцийн өөрчлөлт, байршил, суурьшилтай холбогдон гарч буй асуудал нь энэхүү бодлогын өвөрмөц, онцлог байдлыг илтгэнэ.

Хүний эрхийг хангах, хөгжлийн үйл явцыг түргэтгэх, хүн амын амьдралын чанарын тэгш бус байдлыг арилгах нь хүн ам, хөгжлийн талаар тавигдаж буй тулгамдсан асуудал болж байна.

Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг Улсын Их Хурлаас 1996 онд батлан хэрэгжүүлж ирсэн ба дэлхий нийтийн болон үндэсний хэмжээнд дэвшүүлж буй шинэ зорилт, хөгжлийн хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлага урган гарсан юм.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь хүн ам, хөгжлийн уялдаа холбоог хангахад тохиолдож буй бэрхшээлийг арилгах, үүн төвтэй хөгжилд хүрэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хүн амын бүлгүүдийн асуудлыг гэр бүлийн хүрээнд шийдвэрлэх, нийгмийн бүхий л харилцаанд жендэрийн тэгш байдлыг эрхэмлэхийг эн тэргүүнд чухалчилж байгаа болно.

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь Хүний эрхийн тугээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Нийгмийн дэвшил, хөгжлийн, Хөгжих эрхийн, Мянганы хөгжлийн, Бүх нийтийн боловсролын тухай Даккарын тунхаглал, Эмэгтэйчүүдийн тэгш байдал, хөгжил, энх тайвны асуудлаарх Найробийн (1985), Хүний эрхийн талаарх Венийн (1993), Хүн ам, хөгжлийн асуудлаарх Каирын (1994), Нийгмийн хөгжлийн асуудлаарх Копенгагений (1995), Эмэгтэйчүүдийн байдлын талаарх Бээжингийн (1995) бага хурлуудын шийдвэр, Үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын Үндсэн хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан үндэсний хууль тогтоомж, бодлого, стратеги, бусад олон улсын болон үндэсний хэмжээний хүний эрх, хөгжлийн талаар тавьж буй зорилтыг хангахад чиглэгдсэн болно.

Энэхүү бодлогыг Монгол Улсын хөгжлийн болон Мянганы хөгжлийн зорилтыг дүгнэх үе шаттай уялдуулан 2015 он хүртэл дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2004-2007 он;
Хоёрдугаар үе шат: 2008-2011 он;
Гуравдугаар үе шат: 2012-2015 он.

Б. Зорилго

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

В. Хүн амын хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

- *Хүний хөгжлийг улс орны хөгжил, дэвшлийн төвд тавина:* Хүн байгальтайгаа зохицож, өөрийн чадавхи, нөөцөд түшиглэн эрүүл энх, үр бүтээлтэй ажиллаж, хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- *Хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагыг баримтална:* Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрхийг дээдлэх, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд ажиллах зарчмыг бүрдүүлнэ.
- Хүн ам, хөгжлийн асуудлаарх нийгмийн зөвшилцөл, оролцоог хангана: Хүн амын хөгжилд иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлж, нийгмийн зөвшилцлийг хангана.
- *Жендэрийн тэгш байдлыг хангана:* Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш оролцох, хяналт тавих, шийдвэр гаргах үйл ажиллагаанд шударга ёсыг бэхжүүлнэ.

Г. Бүрэлдэхүүн хэсэг

Энэхүү бодлого нь дараахь бүрэлдэхүүн хэсгэтэй байна:

1. Хүн ам зүйн талаар:
   1.1. Хүн амын төрөлт;
   1.2. Хүн амын нас баралт;
   1.3. Хүн амын байршил;
   1.4. Дотоод шилжих хөдөлгөөн;
   1.5. Гадаад шилжих хөдөлгөөн.

2. Хүн амын хөгжлийг хангах талаар:
   2.1. Гэр бүл;
   2.2. Жендэрийн тэгш байдлыг хангах;
   2.3. Өсвөр үе, залуучууд;
   2.4. Хүүхэд;
   2.5. Ахмад настан, насжилт;
   2.6. Тахир дутуу иргэд.

3. Хүний амьдралын чанарыг сайжруулах талаар:
   3.1. Эрүүл мэнд;
   3.2. Боловсрол;
   3.3. Нийгмийн хамгаалал;
   3.4. Орлого ба ядуурал;
   3.5. Орон байр;
   3.6. Хоол хүнс;
   3.7. Байгаль орчин.

4. Бодлогыг хэрэгжүүлэх арга замын талаар:
   4.1 Хүн амын бүртгэл, мэдээлэл, судалгаа;
   4.2 Мэдээлэл, сурталчилгаа;
   4.3 Чадавхийг бэхжүүлэх;
   4.4 Туншлэл, хамтын ажиллагаа ба хөрөнгө нөөцийг дайчлах;
   4.5 Хүн амын хөгжлийн талаарх үндэсний тогтолцоо;
   4.6 Хяналт, шинжилгээ, үнэлгээ.

1. Хүн ам зүйн талаар

- Хүн амын бодлогын цөм - хүн ам зүйн талаар баримтлах чиглэлийн хүрээнд хүн амын тооны өөрчлөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйл болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний асуудлыг цогцоор авч үзнэ.

- Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана.

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцсэн хүн амын байршлыг дэмжиж дотоод шилжих хөдөлгөөний серег үр дагаврыг арилган, гадаад шилжих хөдөлгөөний үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.1.Хүн амын төрөлт

1.1.1. Хүүхдийг оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эсэн мэнд, эрүүл чийрэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлж 20-39 насны эхчүүдийн 2-3 жилийн зайтай төрөлтийг түлхүү дэмжинэ.

1.1.2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж эхийн эндэгдэлд өртөмтгий бүлэг болон өсвөр, ахимаг насны эмэгтэйчүүдэд тэдний сонголтын дагуу жирэмслэлт, төрөлтөө зохицуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.3. Хүсэгүй жирэмслэлт, үр хөндөлт, түүний хүндрэлийг бууруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

1.1.4. Төрөхийн өмнөх, төрсний дараахь болон хүүхдээ өсгөхөд шаардлагатай эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

1.1.5. Гэр бүлийн хос 3 ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөхийг урамшуулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх чиглэл баримтална.

1.1.6. Хүн амын алангуяа, эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг, үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хүний эрх болон нөхөн үржихүйн эрхийг хангах орчныг бүрдүүлнэ.

1.1.7. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийг бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх нийгэм, хамт олонд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлнэ.

1.1.8. Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн ажлын байрыг хадгалж, хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, улмаар түүний сарын цалингийн хэмжээнд хүргэнэ.

1.2.Хүн амын нас баралт

1.2.1. Эхийн эндэгдлийг 2015 он гэхэд 2000 оны түвшнээс 1/2-аар, нялхасын эндэгдлийг 1/3-аар тус тус бууруулна.

1.2.2. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, буруу зуршлаас урьдчилан сэргийлэх, зан үйлийг өөрчлөх замаар хүн амын өвчлөл, нас баралт ялангуяа, нялхасын эндэгдэл, хүүхэд, залуучуудын цаг зуурын нас баралтыг бууруулан дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.2.3. Вакцины хамралтыг нэмэгдүүлэх замаар хүн амын дархлаажуулалтыг сайжруулан, халдварт өвчнийг бууруулна.

1.3. Хүн амын байршил

1.3.1. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаг багасган байгаль орчны даац, түүний нөөцтэй уялдуулан хүн амын зохисгүй бөөгнөрлийг сааруулж, дагуул хот, бүсийн тулгуур төвүүд болон бүлэг сууринг түшиглэсэн орон нутагтаа суурин амьдрах хүн амын байршлыг дэмжинэ.

1.3.2. Байгаль орчиндоо зохицсон бэлчээрийн болон фермерийн аж ахуй эрхэлж, нүүдлийн, хагас суурин хэвшлээр амьдарч буй хүн амд хүргэх орчин үеийн техникийн дэвшилд суурилсан зам, холбоо, эрчим хүч, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанарыг тогтвортой сайжруулах бодлого баримтална.

1.4. Дотоод шилжих хөдөлгөөн

1.4.1. Бүсийн тулгуур төв, нийслэлийн дагуул хотыг хөгжүүлэх замаар хүн амын нүүдлийн болон суурин амьдралын зохистой харьцаог тогтоон, хүн ам хэт төвлөрсөн төв, суурин газарт чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимжилтийг зохицуулна.

1.4.2. Хүн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй шилжин суурьших эрхийг хүндэтгэж, ажиллах амьдрах газраа сонгох нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.3. Хүн амын орон нутагтаа тав тухтай амьдран суурьших нөхцөлийг сангаж, байгаль орчны зохисгүй өөрчлөлт, зах зээлийн болзошгүй эрсдлээс хамгаална.

1.4.4. Шилжин суурьшигчдын нийгмийн үйлчилгээнд ногдох зардлыг оршин суух байсан аймаг, сумын төсвөөс шинээр шилжин суурьшсан газарт шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

1.5. Гадаад шилжих хөдөлгөөн

1.5.1. Үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн монгол иргэд хилийн чанадад амьдарч ажиллах, мэдлэг боловсрол эзэмших, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлэх санаачилгыг урамшуулж, иргэд харилцан сурч хөдөлмөр эрхлэх талаар хоёр ба олон талт идэвхтэй хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

1.5.2. Гадаадад ажиллаж байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар мөнгө, санхүү, татварын оновчтой бодлого хэрэгжүүлж, мөнгөн гүйвүүлэгч найдвартай үйлчилгээг хөгжүүлнэ.

1.5.3. Монголоос гадаадад гарч буй өндөр мэргэжлийн боловсон хүчин, өндөр мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаан ирүүлэх сонирхлыг бий болгож, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.5.4. Иргэдийг гадаадад хүүх бусаар гарган хохироох, орлого олох аливаа үйлдлээс хамгаална.

1.5.5. Албан ёсоор гадаадад ажиллах хүч гаргаж байгаа субъект нь зуучилсан иргэнийг тухайн улсад хэвийн нөхцөлд амьдарч ажиллах боломжийг бүрдүүлэх, түүний ар гэрт туслах талаар гаргасан санаачилгыг дэмжинэ.

1.5.6. Гадаад шилжих хөдөлгөөний үйл явцыг олон улсын харилцаанд ач холбогдол бүхий стратегитэй уялдуулан боловсронгуй болгоно.

1.5.7. Гадаадад сурч ажиллах сонирхолтой монгол иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.

2. Гэр бүл, хүн амын бүлгийн хөгжлийг хангах талаар

- Хүн амын насны бүтцийн өөрчлөлтөөс үүдэн гарах тулгамдсан асуудлыг хүн амын бүлгийн нас, бие, сэтгэхүй, чадамжийн онцлогт тохирсон, гэр бүл төвтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар хүний хөгжлийг хангах чиглэл баримтална.

- Хүн амын бүлэгт хүүхэд, өсвөр үе, залуучууд, эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд, ахмад настныг хамруулж, тэдний хөгжлийн асуудлыг хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах төрийн бодлоготой уялдуулан цогцоор авч үзнэ.

- Хүнд нөхцөлд байгаа хүүхэд, ахмад настан, ядуу, нэн ядуу иргэд, тахир дутуугийн хоёр болон түүнээс дээш төрөлд хамрагддаг эмээх хэсгийн хүмүүс, шилжин суурьшигчид болон үндэстэн ястны онцлог асуудалд онцгой анхаарна.

2.1. Гэр бүл

2.1.1. Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгана.

2.1.2. Гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангана.

2.1.3. Үндэсний өв соёл, удам угсаагаа хүндэтгэн ирсэн ёс заншлыг хүүхэд, залуучуудад уламжлуулан хөгжүүлэхийг дэмжин урамшуулна.

2.1.4. Өмчийн харилцаанд гэр бүлийн гишүүн бүрийг тэгш эрхтэйгээр оролцуулах, эдийн

засгийн талаар бие даан хөгжих, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.5. Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн ачааллыг багасгах, тусгай асаргаа шаардлагатай бага насны хүүхэд, өндөр настан, тахир дутуу иргэдэд зориулсан нийгмийн үйлчилгээг бий болгон хөгжүүлнэ.

2.1.6. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах эрх зүй, зан үйл, хандлагын эерэг орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.1.7. Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалалд эцэг, эхийн тэгш оролцоог хангахад чиглэсэн гэр бүлд үзүүлэх дэмжлэгийн хүрээг өргөжүүлнэ.

2.2. Жендэрийн тэгш байдлыг хангах

2.2.1. Жендэрийн тэгш байдлыг эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, гэр бүлийн болон хүний эрхийн хүрээнд хангах, аливаа тэгш бус байдал, ялгаварлал, хавчин гадуурхлын бүх шалтгааныг багасган, улмаар арилгах чиглэл бариманлна.

2.2.2. Эдийн засгийн өсөлтийг хангах, үр дүнг шударга хуваарилах, нийгмийн хөгжлийг дэмжсэн нийгмийн хамгааллын бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлнэ.

2.2.3. Улс төр, өмчийн харилцаа, удирдах болон шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн уламжлалт үүргийг өөрчлөх сэтгэлгээг хүн амын үхамсарт төлөвшүүлнэ.

2.2.4. Хөдөлмөрийн чадвар бүхий гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ядуурлаас хамгаалах, эрүүл мэндийн доройтлыг арилгах, гэрийн хөдөлмөрийн ачаалллыг хөнгөвчлөхөд онцгой анхаарч, эмэгтэйчүүд өөрсдийн чадавхи, бололцоогоо бүрэн ашиглах явдлыг хөхиүлэн дэмжинэ.

2.2.5. Эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хувьд бие даах, хөдлөх, үл хөдлөх өмч эзэмших эрхийг бүрэн эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.

2.2.6. Эмэгтэйчүүд, хүүхдийг хэрцгийлэх, дороомжлох, тарчилган зовоох зэрэг хүчирхийллийн бүх хэлбэр болон тэднийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хөлслөх (янхан болгох) зэрэг гаж бууруу замд татан оруулахаас сэргийлнэ.

2.2.7. Ерөнхий боловсролын болон бүх шатны мэргэжлийн сургуульд эрэгтэйчүүдийн суралцах, боловсрол эзэмших таатай орчинг бүрдүүлж, 2005 он гэхэд бага, 2010 он гэхэд дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсрол дахь жендэрийн тэгш бус байдлыг арилгана.

2.3. Өсвөр үе, залуучууд

2.3.1. Өсвөр үе, залуучуудыг оюун ухаан, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, нийгмийн хөгжлийг бүтээх, хяналт тавих, боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулах, шийдвэр гаргахад санаа бодлоо илэрхийлж оролцох чадвартай, идэвхтэй иргэд болгон төлөвшүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ.

2.3.2. Залуу гэр бүлийг орон сууцаар хангах, орлогыг нь нэмэгдүүлэх, зээл, хөгжлийн тусламжид хамруулах боломжийг өргөжүүлнэ.

2.3.3. Өсвөр үе, залуучуудын албан ба албан бус боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан байдлыг нь хангаж, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

2.3.4. Залуучуудад байгаль орчин, эх хэл, бичиг үсэг, ёс заншил, соёл ирэгшилл, удам угсаагаа дээдлэх үзлийг төлөвшүүлэхэд анхаарна.

2.3.5. Өсвөр үе, залуучуудын амралт, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлж, хөгжих таатай орчинг бий болгоно.

2.3.6. Залуучуудын хэрэгцээ, сонирхол, насанд нь тохирсон, эрхийг нь хангасан нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.

2.3.7. Залуу гэр бүлийн хэрэгцээ, бололцоонд нь тохирсон хүүхэд асрах, халамжлах, хөгжүүлэх үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.

2.3.8. Шинээр гэр бүл болсон залуучуудад бие даан амьдрахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

2.4. Хүүхэд

2.4.1. Хүүхдийг дээдлэх зарчимд нийцүүлэн тэдний эрхийг хамгаалах, хөгжүүлэх, хүсээн боловсрол, мэргэжлээ эзэмших орчныг бүрдүүлэх, гэр бүлдээ эрүүл энх, сайн сайхан амьдрах таатай нөхцөлийг хангана.

2.4.2. Хүүхэд бүр халамж, анхаарал хүртэх, эсэн мэнд бойжих, хөхөөр хооллох нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

2.4.3. Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролыг хүүхэд бүрт эзэмшүүлэх таатай орчныг бүрдүүлж боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарын ялгаг арилгана.

2.4.4. Хүүхдийн сэтгэц, өсөлт, хөгжлийн онцлогт нийцсэн хоол хүнсээр хангаж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлнэ.

2.4.5. Тахир дутуу, эмгэг согоотой, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг нийгэм, хамт олны дунд төлөвших таатай орчинг бүрдүүлнэ.

2.4.6. Хүүхдийг үл хайхрах, хаях, доромжлох, хүчирхийлэх, хэрцгийлэх, гэмт хэрэг, садар самууны зорилгоор ашиглах, татан оруулах, дамжуулан худалдах зэрэг болзошгүй аюулаас хамгаална.

2.4.7. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгана.

2.4.8. Хүнд нөхцөлд байгаа хүүхдэд зориулсан нийгмийн цогц үйлчилгээг бий болгоно. Гэр бүлд түшиглэсэн, хүүхдийн оролцоонд тулгуурласан халамж, асрамжийн үйлчилгээг төрөөс урамшуулан дэмжинэ.

2.4.9. Өнчин хүүхдийг гэр бүлийн нөхцөлд өсч хөгжих бололцоогоор хангасан үрчлэгч, асрамжлагч, халамжлагч гэр бүлийг урамшуулан дэмжинэ.

2.5. Ахмад настан, насжилт

2.5.1. Ахмад настан нийгмийн идэвхтэй гишүүн байж, хүсэл сонирхлынхоо дагуу утга төгөлдөр амьдрах орчныг бүрдүүлж, амьдралын чанарыг нь дэзшлүүлнэ.

2.5.2. Ахмад настныг насны доройтлоос хамгаалахад чиглэсэн нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлж, эрүүл насжилтыг дэмжих боджого бариатлана.

2.5.3. Ахмад настанд үзүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, тогтмолжуулна.

2.5.4. Ахмад настанд насан туршийн боловсрол олгох, дахин сургах хөтөлбөрт хамруулж, тэдний бололцоо, сонирхол, хэрэгцээнд тохирсон хөдөлмөр эрхлэхийг дэмжин, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлнэ.

2.5.5. Ахмад настны мэдлэг, ажлын дадлага туршлагыг хүүхэд залуучуудад өвлүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.

2.5.6. Ахмад настанд туслах, тэднийг идэвхтэй амьдрахад чиглэсэн нийгмийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг цогцоор нь сайжруулахын хамт энэ чиглэлээр иргэний нийгэм, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын бүхий л санаачилгыг урамшуулан дэмжинэ.

2.6. Тахир дутуу иргэд

2.6.1. Тахир дутуу хүмүүсийн нөөц бололцооны талаарх шинэ хандлага, ойлголтыг бэхжүүлж, нийгмийн идэвхтэй гишүүд байлгах чиглэл баримтална.

2.6.2. Тахир дутуу хүмүүст зориулсан эмнэлгийн болон нийгмийн үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.3. Тахир дутуу хүний хязгаарлагдмал боломжид тохирсон амьдрах орчны дэд бүтцийг сайжруулж, нийгмийн зүгээс тэдэнд хандах таатай хандлагыг төлөвшүүлнэ.

2.6.4. Тахир дутуу хүмүүс нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралд оролцох, нөхөн үржихүйн эрхээ эдлэх, гэр бүл болоход тулгарч болох гадуурхлын аливаа хэлбэрийг арилгах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.5. Тахир дутуу хүмүүст зориулсан нийгэм, хамт олонд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлнэ.

3. Хүний амьдралын чанарыг сайжруулах талаар

- Хүн ам эрүүл орчинд амьдрах, хөдөлмөрлөх, амьдрал ахуйгаа сайжруулах, мэдлэг боловсрол эзэмшин нийгмийн амьдралд үр бүтээлтэй оролцох, хөгжих орчныг нь бүрдүүлэх замаар хүний амьдралын чанарыг сайжруулах чиглэл баримтална.

3.1. Эрүүл мэнд

3.1.1. Хүн эрүүл байх эрхээ эдлэхэд шаардлагатай, хүрэлцээтэй, хүртээмжтэй, сэтгэлд нийцсэн, чанартай эрүүл мэндийн үйлчилгээг хүн амд хүргэж, олон улсын жишигт ойртуулна.

3.1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний байр, тоног төхөөрөмжийн хүртээмж, үйлчилгээний үнэ нь иргэдийн төлбөрийн чадвартай уялдсан, иргэдэд тэгш үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1.3. Иргэд өөрийн эрүүл мэндийг хамгаалах асуудалтай холбоотой мэдээллийг хайх, олж авах тогтолцоог бүрдүүлнэ.

3.1.4. Эрүүл хоол хүнс, орон байр, ундны ус, шаардлага хангасан аюулгүй ажлын байр, хүрээлэн байгаа орчныг бүрдүүлж, хүн амыг эрүүл, эсэн мэнд амьдрах нөхцөлөөр хангана.

3.1.5. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хорт зуршил, өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлд сургах замаар өвчлөл эндэгдлийг бууруулна.

3.1.6. Хүний амьдралын чанарт сөргөөр нөлөөлж өвчин эмгэг, осол гэмтэлд хүргэж буй хүчин зүйлээс сэргийлэх, улмаар шалтгаан, үр дагаврыг арилгана.

3.1.7. Хүн амын эрүүл мэндийг байгалийн хүчин зүйлээр нөхөн сэргээх, рашаан усыг эмчилгээ сувилгаанд хэрэглэхийг хөхиүлэн дэмжинэ.

3.1.8. Гэр бүлд үгийн бичгийг хөтлүүлж, цус ойртох, удамшлын өвчнөөс хүн амыг сэргийлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2. Боловсрол

3.2.1. Хүн өөрөө хөгжлийн үйл явцын идэвхтэй гишүүн байж амьдралын дадал, чадвар эзэмших, эрх мэдэл, амьжиргааны түвшингээ дээшлүүлэх гол хэрэгсэл нь боловсрол гэж үзэж, боловсролын чанар, хүртээмж, үр ашиг, түүнээс авах сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Хүн бүрт боловсрол эзэмших тэгш сонголт, адил боломжийг олгож, хүүхдэд суурь боловсролыг заавал, насанд хүрэгчдэд хэрэгцээтэй боловсролоо өөртөө тохиромжтой хэлбэрээр, бололцоотой хугацаандаа тасралтгүй эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.3. Мэрэгжлийн боловсрол олгох сургалтын агуулга, арга технологийг үян хатан болгож хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөрвөх чадвартай мэрэгжилтэй боловсон хүчнийг бэлтгэнэ.

3.2.4. Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгана.

3.2.5. Хүн амын оюуны бүтээлийн үнэлэмжийг эрс дээшлүүлэх эрх зүйн орчинг бий болгож, хэрэгжүүлнэ.

3.3. Нийгмийн хамгаалал

3.3.1. Нийгмийн хамгааллын үйлчилгээнд иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.3.2. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж, нийгэм, хамт олонд түшиглэсэн хэлбэрийг гэр бүлд чиглэсэн цогц үйлчилгээ болгон өргөжүүлж, нийгмийн ажлыг хөгжүүлнэ.

3.3.3. Эдийн засгийн идэвхтэй нийт хүн амыг тэтгэврийн даатгалд хамруулах, тэтгэврийн санг бүрдүүлэх олон хэлбэрийг бий болгож, нэг хүнд ногдох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.3.4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулж, үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулж, хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийн асуудалд анхаарна.

3.3.5. Хэрэглэгчдийг чанарын баталгаатай бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээр ханган, энэ талын мэдээллэл авах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.4. Орлого ба ядуурал

3.4.1. Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгахад иргэдийг идэвхтэй оролцуулж, тэдэнд хөгжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн эмзэг хэсгийн амьжиргааны баталгаажих түвшинд амьдрах эрхийг ханган.

3.4.2. Хүн амыг орлогын болон оюуны ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.

3.4.3. Хүн амын амьжиргааны чадавхийг дэмжин хөгжүүлэх эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зайлшгүй үйлчилгээ, технологи, мэдээллийн хүртээмжийг өргөжүүлнэ.

3.4.4. Эмзэг, ядуу, дунд хэсгийн хүн амд насан туршдаа сурах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүртэх, хөдөлмөр эрхлэх, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлэх замаар орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, удам дамжсан ядууралд өртөхөөс хамгалана.

3.4.5. Ядуу, нэн ядуу өрхийг орлогыг нь нэмэгдүүлэх хөгжлийн зээл, туслamжид хамруулах замаар ядуурлаас гаргана.

3.4.6. Сургууль завсардалтыг багасгах, суралцах таатай орчныг бий болгох, мэрэгжилтэй багшлах боловсон хүчний хангамжийг сайжруулах замаар хөдөө дэх оюуны ядуурлыг бууруулна.

3.4.7. Хүн амын амьжиргааны түвшинг тухайн үеийн инфляцийн түвшинтэй уялдуулан хүний амьдралын наад захын хэрэгцээг хангахуйц хүрэлцээтэй хэмжээгээр тогтооно.

3.5. Орон байр

3.5.1. Хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг нь сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэл баримтална.

3.5.2. Хот сууринд амьдардаг хүн амын орон сууцны фондыг нэмэгдүүлж, нөхцөлийг нь сайжруулах, хөдөө орон нутагт нүүдэллэн амьдардаг хүн амыг уламжлалт гэр сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

3.5.3. Иргэдийн хөдөлмөр, хөрөнгө хоршин орон сууц барих хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжинэ.

3.5.4. Залуу гэр бүл, оюутнуудад зориулсан орон сууцны цогцолбор, нийтийн байр барих, аж ахуйн нэгж, байгууллагаас ажиллагчдаа орон байраар хангах талаар гаргасан санал санаачилга, хөдөлгөөнийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.

3.6. Хоол хүнс

3.6.1. Хүн амын хоол хүнсний хангамжийг сайжруулж, калори, амин дэмээр баялаг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах

чиглэл баримтална.

3.6.2. Монгол хүний хоол хүнсний физиологийн нормыг нас, хүйс, ажил мэргэжлийн онцлог, нутаг дэвсгэр, уур амьсгалын онцлогтой уялдуулан тогтооно.

3.6.3. Хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих эрүүл ахуй, халдвар судалын хяналтыг тогтмолжуулна.

3.6.4. Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настан болон тусгай хоол хүнс хэрэглэдэг хүн амын хоол хүнсийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг хөгжүүлнэ.

3.6.5. Хоолыг орлого, дутагдалтай эрдэс бодисыг нөхөх нэмэгдэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэдалдаанг дэмжинэ.

3.6.6. Хүн амыг зохистой зөв хооллох, эрүүл хүнс хэрэглэх хэвшил, хорт зуршлаас өөрийгөө хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

3.7. Байгаль орчин

3.7.1. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль экологид халгүй технологи, үйлдвэрлэл хөгжүүлэх замаар хүн байгальтайгаа зохицож өөрийн чадавхи, нөөцөд түшиглэн, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.7.2. Ган, зуд, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт зэрэг байгалийн гамшгийн улмаас хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад сөрөгөө нөлөөлж болох хүчин зүйлийн нөлөөг багасгах талаар гаргасан санал санаачилгыг урамшуулан дэмжинэ.

3.7.3. Хүн амыг олноор хөнөөх аюултай өвчин тахал гарах, ой мод, бэлчээр, үргамлыг устгах хортон шавьж олшрох, агаар, ус, хөрсөөр дамжин цацраг идэвхт бодис, химийн бохирдол ихсэхээс сэргийлнэ.

3.7.4. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж хот суурин газрын ногоон бүсийг бохирдлоос хамгаална.

3.7.5. Хүн амын хэт төвлөрөөс үүдэн байгаль орчны тэнцвэр алдагдахаас урьдчилан сэргийлнэ.

3.7.6. Усны нөөцийг ашиглах, хамгаалах менежментийг сайжруулж нэг хүнд ноогдох эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны хэрэглээг 2015 он гэхэд хоногт дунджаар 20 литрт хүргэнэ.

4. Бодлогыг хэрэгжүүлэх арга замын талаар

- Олон нийт, шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдад мэдээлэл хүргэх, ухуулга сурталчилгаа явуулах, сургалт судалгаа хийх үндэсний чадавхийг бэхжүүлэх замаар хүн амын хөгжлийн асуудлаарх дэмжлэгийн таатай орчныг бүрдүүлнэ.

- Хүн ам, хөгжлийн асуудалд улс төр, нийгэм, эдийн засгийн дэмжлэгийг бүх шатанд бүрдүүлэх, хөрөнгө нөөцийг дайчлах, харицан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, туршлага солилцох, ололт амжилтаа бататгах чиглэлээр түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлнэ

- Хүн амын асуудлыг үндэсний стратеги, бодлогыг тодорхойлох, хөтөлбөр, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

4.1. Хүн амын бүртгэл, мэдээлэл, судалгаа

4.1.1. Иргэний болон хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сүлжээ бий болгож мэдээллийн бусад сантай холбон, хүн ам, хөгжлийн асуудлаарх мэдээллийн цогц сан байгуулна.

4.1.2. Бүртгэлийн нэгдсэн сүлжээг найдвартай ажиллуулахад шаардлагатай орчин үеийн техник хэрэгслээр хангана.

4.1.3. Хүн амын талаарх мэдээлэл, судалгааны чанарыг олон улсын түвшинд хүргэж бүртгэлд хамралтын түвшинг байнга нэмэгдүүлнэ.

4.1.4. Хүн амын хүчин зүйлийг хөгжлийн төлөвлөлтөд тусгахад шаардлагатай статистик мэдээлэл цуглуулж боловсруулах, хэрэгцээ, тулгамдсан асуудлын талаарх хэтийн тооцоо, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд шуурхай хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.5. Хүйсээр ангилсан мэдээлэл, судалгааг өргөжүүлнэ.

4.1.6. Орчин үеийн судалгаа шинжилгээний арга зүй, ололтод үндэслэн монгол хүн судлалыг хөгжүүлнэ.

4.2. Мэдээлэл, сурталчилгаа

4.2.1. Хүн ам, хөгжлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлахад мэдээллийн хэрэгслийн үр нөлөөг дээшлүүлнэ.

4.2.2. Тогвортой хөгжлийн талаарх хүн амын ойлголтыг сайжруулах, өрхийг хангах, хөгжлийн үйл явцад тэдний гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн мэдээллэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

4.2.3. Хэрэглагчдийг мэдээ мэдээллээр цаг алдалгүй хангах, хүн амд хүргэх үйлчилгээг шуурхай болгоход чиглэсэн мэдээллийн шинэ технологийн хэрэглээ, хангамжийг нэмэгдүүлнэ.

4.2.4. Хүн ам, хөгжлийн асуудлаарх дэмжлэгийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгааг эрчимжүүлнэ.

4.2.5. Хүн амын мэдээлэл хүлээн авах орчныг сайжруулах, орон нутгийн хэвлэл мэдээллийн сүлжээг өргөтгөж үйлчилгээг нь хүртээмжтэй болгох, ялангуяа, алслагдсан нутгийн хүн амд мэдээллэл хүргэх, хүлээн авах, дамжуулах боломжийг сайжруулна.

4.3. Чадавхийг бэхжүүлэх

4.3.1. Хүн ам, хөгжлийн асуудлыг улс орны нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд цогцоор авч үзэх, стратегийн төлөвлөлт, бодлого, хөтөлбөрт уялдуулан үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

4.3.2. Хүн ам судлал, хүн ам, хөгжлийн асуудлаар үндэсний түвшинд мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэхийг дэмжинэ.

4.3.3. Хүн ам, хөгжлийн сургалтын баазыг бэхжүүлэх, сургалтын бүтэц, агуулга, технологийг олон улсын жишигт хүргэж боловсронгуй болгоно.

4.4. Түншлэл, хамтын ажиллагаа ба хөрөнгө нөөцийг дайчлах

4.4.1. Хүн амын хүчин зүйлсийг хөгжлийн бодлого, төлөвлөлтэд тусган үндэсний бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжүүлэхэд тэр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

4.4.2. НҮБ, түүний төрөлжсөн байгууллага болон гадаад орнуудын дэмжлэгийг хүн ам, тогтвортой хөгжлийн талаарх үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, олон улс, бүс, дэд бүсийн хэмжээнд хамтран ажиллах, хөрөнгө нөөцийг дайчлах таатай орчинг бүрдүүлэхэд чиглүүлнэ.

4.4.3. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засагталыг бүрдүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд өмчийн бүх хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн гаргасан санал санаачилга, хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжиж хамтран ажиллана.

4.4.4. Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс хүн ам, хөгжлийн хүрээний асуудлыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог өргөжүүлэх чиглэлээр гаргаж буй санал, санаачилгыг дэмжинэ.

4.5. Хүн амын хөгжлийн талаарх үндэсний тогтолцоо

4.5.1. Монгол Улсын Их Хурал (Парламент) нь хүн амын хөгжлийн талаарх бодлогыг тодорхойлон зүрх зүйн орчинг боловсронгуй болгож, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилт, энэ чиглэлээр Засгийн гаргаас явуулж буй үйл ажиллагаанд хяналт тавина.

4.5.2. Засгийн газар нь хүн ам ба хөгжлийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, энэхүү бодлогын биелэлтийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсн чиглэл, улсын нэгдсэн төсөвт тусган зохион байгуулах, хөрөнгө нөөцийг хуваарилах, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаа арга зүйн удирдлагаар хангах, санал санаачилгыг урамшуулан дэмжих, уялдуулан зохицуулах ажлыг УИХ-ын өмнө шууд хариуцна. Үүн амын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хүн амын хөгжлийн асуудлыг хэрэгжүүлэх үндэсний тогтвортой чадавхи бүхий бүтцийг бүрдүүлнэ.

4.5.3. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хүн амын хөгжлийн асуудлыг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, энэ үйл ажиллагааг орон нутгаас зарцуулах хөрөнгө нөөцийг нэмэгдүүлэх, иргэдийн ашиг сонирхлыг хамгаалан шийдвэр гаргах үйл явцад тэдний идэвхтэй оролцоог хангана.

4.5.4. Хүн ам, хөгжлийн асуудлаарх зөвшилцлийн байгууллага нь энэхүү бодлогын хэрэгжилтийн байдалд хяналт тавих, зөвлөмж гаргах, цаг үеийн шинжтэй арга хэмжээг үялдуулан зохицуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

4.5.5. Иргэний нийгэм хүний эрх, эрх чөлөө, хөгжил зэрэг аливаа асуудлаар гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ялгаварлал, шударга бус үйлдлийг таслан зогсооход идэвхтэй хамтран ажиллана.

4.6. Хяналт, шинжилгээ, үнэлгээ

4.6.1. Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас түншлэгч талуудтай хамтран Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд үе шат бүрийн эцэст хяналт, шинжилгээ, үнэлгээг хийнэ.

4.6.2. Хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүн, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан энэхүү бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүн ам, хөгжлийн талаарх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 22** **Улаанбаатар хот**

Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгаль орчны тэнцэл, унаган төрхийг хадгалах шаардлага, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ач холбогдолтойг харгалзан Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дахь Шилийн богд уул, Хөргийн хөндий орчмын газар нутгийг дурсгалт газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтад авахаар тогтоосугай.

2.Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг дахь Ганга нуурын байгалийн дурсгалт газрыг мөн сумын нутаг дахь Алтан (дарь) овоо, Наран сумын нутаг дахь Молцог элс орчмын газар нутгаар өргөтгөн Дарьгангын байгалийн цогцолборт газар болгон өөрчилж, хилийн заагийг хавсралтаар батлсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай" Улсын Их Хурлын 1993 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 83 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн "Ганга нуур орчмын хэсэг газрыг Ганга нуурын дурсгалт газар" гэсэн 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 22 дугаар тогтоолын хавсралт

ДАРЬГАНГЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

Баруун хойт захын цэг нь Сүхбаатар аймгийн Наран, Онгон сумын хилийн заагт дахь Тостын нуурын зүүн хойт эрэгт 45°17'29''-113°25'10'' солбицолд орших 1 дүгээр цэг, түүнээс зүүн хойш 45°19'57''-113°29'53'' солбицолд орших худаг, түүнээс зүүн урагш орших Хүнт (1152.6), Хүйтэн уул (1200.2), 45°16'15''-113°43'40'' солбицолд орших Салаа булаг, түүнээс зүүн хойш 45°17'55''-113°47'45'' солбицолд орших Шармөнх, түүнээс баруун хойш эргэж 45°19'18''-113°45'40''.солбицолд орших Хамар булаг, түүнээс зүүн тийш 45°19'00''-113°50'25'' солбицолд орших 2 дугаар цэг, түүнээс урагш 45°18'30''-113°50'20'' солбицолд орших 3 дугаар цэг, түүнээс баруун урагш 45°18'10''-113°49'40'' солбицолд орших 4 дүгээр цэг, түүнээс зүүн урагш 45°17'42''-113°50'20'' солбицолд орших 5 дугаар цэг, түүнээс зүүн хойш Ганга нуурын дурсгалт газрын хилийн заагт дахь 45°17'54''-113°52'07'' солбицолд орших 6 дугаар цэг, түүнээс зүүн урагш 1286.6 тоот өндөрлөг, түүнээс зүүн зүгт 1335.4 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш Гангын цагаан овоо (1530.2), түүнээс зүүн урагш Бадрах уул (1423.7), түүнээс зүүн урагш 1395.5 тоот цэг, түүнээс баруун хойш 1358.4 тоот цэг, түүнээс баруун хойш орших Их бургасны худаг (1328.0), түүнээс баруун урагш 1370.4 тоот цэг, түүнээс баруун урагш Сүмтийн хар толгой, түүнээс баруун урагш 1290.7 тоот цэг, түүнээс баруун хойш 1189.0 тоот цэг, Наран, Онгон сумын хилийн заагт дахь Тостын нуурын зүүн хойт эрэгт 45°17'29''-113°25'10'' солбицолд орших 1 дүгээр цэг.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 30-ний өдөр **Дугаар 23** **Улаанбаатар хот**

Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг ханган тухай

Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн теслийг боловсруулж 2004 оны 8 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд ирүүлэхийг Засгийн газар (Н. Энхбаяр)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 5.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 21 (354)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *"Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги"-ийн баримт бичгийг батлах тухай*
- *Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд тавих тухай хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 31 №21 (354)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

256. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай 487

257. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 492

258. Протокол соёрхон батлах тухай 492

259. "Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим жүрмыг нэг мөр болгох тухай конвенци"-д нэгдэн орох тухай 492

260. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай 492

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

261. "Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги"-ийн баримт бичгийг батлах тухай Дугаар 24 493

262. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Дугаар 25 514

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр **Улаанбаатар хот**

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж

2.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."тэсэрч дэлбэрэх бодис" гэж тэсрэлтийн хүчийг ашиглах, зориулалттай гадны хүчний үйлчлэлээр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулах аюултай химийн нэгдэл буюу механик хольцийг;

3.1.2."тэсэлгээний хэрэгсэл" гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх зориулалттай эд зүйлийг;

3.1.3."пиротехникийн хэрэгсэл" гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр, ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг";

3.1.4."тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт" гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагаа.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хууль нь цэргийнхээс бусад зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих хүрээнд үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй ажиллагаат хангах

5 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хадгалалтын аюулгүйн бүс

5.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, хадгалах байр, агуулах нь тооцоогоор тогтоосон аюулгүйн бүстэй байна.

5.2.Аюулгүйн бүс, түүний дэглэмийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага хамтран тогтооно.

6 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх

6.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэгцээг үндэслэн тэдгээрийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 10 өдрийн дотор аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

6.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав, баглаа, боодлын гадна талд үйлдвэрийн нэр, үйлдвэрлэсэн болон ашиглах баталгаат хугацаа, тэсэрч дэлбэрэх аюултайг анхааруулсан таних тэмдэгтэй байна.

6.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлоход улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэх, нэвтрүүлэхийг хориглох хилийн боомтыг Засгийн газар тогтооно.

7 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэхэд тавигдах шаардлага

7.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн[1] 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь шаардлага тавигдана:

7.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны стандартын шаардлага хангасан зориулалтын барилга байгууламж, туршилтын талбайтай байх;

7.1.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, хадгалах болон ачих буулгах тусгай зориулалтын тоног төхөөрөмж, дотоодын тээврийн хэрэгсэлтэй байх;

7.1.3.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн чанарын үзүүлэлт нь үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангасан байх;

7.1.4.шинэ төрлийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэхэд тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу туршилт хийлгэн мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, стандартаа батлуулсан байх;

7.1.5.мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх;

7.1.6.цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын санал авсан байх;

7.1.7.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэхэд байгаль орчны нөлөөллийн болон эрсдлийн үнэлгээ хийлгэсэн байх.

7.2.Энэ хуулийн 7.1.4-т заасан тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг Засгийн газар батална.

8 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экпортлоход тавигдах шаардлага

8.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох аж ахуйн нэгж, байгууллагад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь шаардлага тавигдана:

[1] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн

8.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, мэргэжлийн боловсон хүчний талаархи мэргэжлийн байгууллагын тодорхойлолт;

8.1.2.цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын санал.

8.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийг импортлоход энэ хуулийн 8.1-д заасан шаардлага нэгэн адил тавигдана.

8.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл экспортлох аж ахуйн нэгж, байгууллагад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь шаардлага тавигдана:

8.3.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

8.3.2.экспортлох бүтээгдэхүүнийн стандарт, техникийн шаардлага хангасан байдлын талаархи мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, экспортлох тоо хэмжээ;

8.3.3.худалдан авагчтай урьдчилан байгуулсан гэрээ, тээвэрлэлтийн нөхцөлийг тусгасан баримт бичиг;

8.3.4.цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын санал.

9 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл худалдахад тавигдах шаардлага

9.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөлтэй этгээд тэдгээрийг зөвхөн энэ хуулийн 12.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагад худалдана.

9.2.Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хураагдсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг мэргэжлийн байгууллагын хяналтын дор тэсэлгээний ажил явуулах эрх бүхий байгууллагад худалдах буюу шинэчлэн сэлгэн сольж байршуулж болох ба энэ тухайгаа энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан улсын нэгдсэн мэдээллийн санд тухай бүр мэдэгдэнэ.

9.3.Энэ хуулийн 9.1-д заасан этгээд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн борлуулалт, зарцуулалтын тайланг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүрээр гарган хүргүүлж байна.

9.4.Аж ахуйн нэгж, байгууллага нь хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдан авах эрх бүхий байгууллагад мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр худалдаж болно.

10 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтэд тавигдах шаардлага

10.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн стандартыг баримтлан тусгай тоноглосон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэнэ. Тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг цагдаагийн байгууллага олгоно.

10.2.Тэсэрч дэлбэрэх бодисыг тэсэлгээний хэрэгслийн хамт тээвэрлэж болохгүй. Энэ нь үйлдвэрлэлийн технологийн дагуу явагдах дотоодын тээвэрлэлтэд хамаарахгүй.

10.3.Тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх зааварчилгааг тээврийн хэрэгслийн жолооч болон дагалдан яваа хүн бүрт танилцуулж, аюулгүй байдлыг хангасан байна.

10.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хот тосгон, бусад суурин газраар тээвэрлэхдээ онц аюултай ачаа тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны техникийн шаардлагыг хангасан байна.

10.5.Хот суурин газарт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх чиглэл, хугацааг тухайн орон нутгийн цагдаагийн байгууллага баталж, аюулгүй байдалд хяналт тавина.

10.6.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг аюулгүй ажиллагааны шаардлага хангасан нөхцөлд зориулалтын талбайд ачиж, буулгана.

11 дүгээр зүйл.Тэсэлгээний ажил явуулахад тавигдах шаардлага

11.1.Тэсэлгээний ажил явуулах аж ахуйн нэгж, байгууллагад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь шаардлага тавигдана:

11.1.1.мэргэжлийн боловсон хүчинтэй байх;

11.1.2.тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн харуул хамгаалалт бүхий агуулахтай байх.

12 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах

12.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашигт малтмалын хайгуул, уул уурхай, зам, барилгын үйлдвэрлэлийн зориулалтаар Аж ахуйн үйл ажилагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.4-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага ашиглана.

12.2.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага нь тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагын туслалцааг авч болно.

12.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглахдаа тэсэлгээний ажлын ахуулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг мөрдөж ажиллана.

13 дугаар зүйл. Пиротехникийн хэрэгсэл

13.1.Пиротехникийн хэрэгслийг, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах асуудлыг тусгай дүрмээр зохицуулна.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан дүрмийг Засгийн газар батална.

14 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалахад тавигдах шаардлага

14.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тус тусад нь стандартын шаардлага хангасан зориулалтын агуулахад хадгална.

14.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийг тэсэлгээний ажлын ахуулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу хөтөлж, улирал тутам тооллого явуулна.

14.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл алдагдсан тохиолдолд цагдаагийн болон тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэж, эрэн сурвалжлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд түүнийг зээмшигч аж ахуйн нэгж, байгууллага бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

14.4 Аймаг, нийслэлийн Засаг дарга тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, хадгалах газрын байнгын байршлыг тогтооно.

15 дугаар зүйл.Хориглох зүйл

15.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараахь зүйлийг хориглоно:

15.1.1.өөрийн эзэмшлийн газар, зориулалтын байр, тээврийн хэрэгсэл, мэргэжлийн боловсон хүчин, галт зэвсэг бүхий харуул хамгаалалтгүй аж ахуйн нэгж, байгууллагад тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгох;

15.1.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хувь хүн олж авах, импортлох, экспортлох, худалдах, хадгалах, ашиглах, устгах;

15.1.3.зориулалтын бус газарт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах;

15.1.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг, нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

15.1.5.энэ хуулийн 5.1-д заасан хамгаалагдсан аюулгүйн бүсэд хүн, тээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй нэвтрэх, түр буюу байнга суурьших, бүсийн дэглэм зөрчих;

15.1.6.худалдан авагч нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, хадгалах, бусдад дамжуулан худалдах, шилжүүлэх;

15.1.7.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх буй тээврийн хэрэгслийг тэсэлгээний ажлын удирдагч болон хамгаалалтын ажилтнаас бусад хүн дагалдан явах.

16 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгах

16.1.Чанарын шаардлага хангахгүй болсон, ашиглах хугацаа нь дууссан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь тэсэлгээний ажлын ахуулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасан төлөвлөгөөний дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын дор устгана.

16.2.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг устгасан тухай үйлдсэн нотломжийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 хоногийн дотор хүргүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн сан

17 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн сан

17.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагад хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхгийг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сантай байна.

17.2.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, мэдээллийн сантай холбогдсон зааврыг батлан мөрдүүлнэ.

17.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлагын мэдээ, тайланг гаргаж, улирал тутам энэ хуулийн 17.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

17.4.Гаалийн байгууллага нь улсын хилээр нэвтрүүлсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээг тухай бүр нь цагдаагийн болон тагнуулын байгууллагад мэдэгдэж, мэдээ, тайланг сар бүр геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байна.

18 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй ажиллагааны мөрдөх стандарт

18.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэлийн байр, хадгалах агуулахын болон тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны шаардлага хангасан стандартыг геологи, уул уурхайн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага хамтран боловсруулж, стандартын мэргэжлийн байгууллагаар батлуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хяналт, хариуцлагын тогтолцоо

19 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалтад тавих хяналт

19.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

19.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалт болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль тогтоомж, журам, технологийн горимын биелэлтэд дотоодын хяналт тавина.

20 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хяналтын лаборатори

20.1.Мэргэжлийн хяналтын байгууллага нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн марк, ангилал, хүчин чадал, ашиглах хугацаа, стандартын чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох хяналтын лабораторитай байна.

21 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэж буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол геологи, уул уурхайн улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

21.1.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай мэдээ, тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлээгүй буюу зориуд буруу мэдээлсэн аж ахуйн нэгж , байгууллагыг 30000-50000 төгрөгөөр торгох;

21.1.2.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгахад тавих шаардлагыг зөрчсөн иргэнийг 20000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

21.1.3.энэ хуулийн 15.1.1-15.1.5, 15.1.7-г зөрчсөн бол хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураажж, иргэнийг 20000-50000 төгрөгөөр,

албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

21.1.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хууль бусаар ашиглаган, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, нөөцөлж хадгалсан бол хууль бусаар олсон орлого, эд зүйлийг хураах, зөрчил гаргасан иргэнийг 30000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

21.2.Хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар хураагдсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

22 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

22.1.Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.4-ийг "тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тэсэлгээний ажил явуулах;" гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр **Улаанбаатар хот**

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан "Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенци"-ийн нэмэлт, өөрчлөлтөд хамаарах Монреаль хотноо 1989 оны 10 дугаар сарын 6-ны өдөр гарын үсэг зурсан Протоколыг соёрхон батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр **Улаанбаатар хот**

"ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВЭРТ ХАМААРАХ ЗАРИМ ЖУРМЫГ НЭГ МӨР БОЛГОХ ТУХАЙ КОНВЕНЦИ"-Д НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монреаль хотноо 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан "Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэг мөр болгох тухай Конвенци"-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

"Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги"-ийн баримт бичгийн батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги"-ийн баримт бичгийг хавсралтаар батлуулсугай.

2. Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/, Төрийн албаны зөвлөл /Ж.Норовсамбуу/-д тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 24-р тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

1. ОРШИЛ

1.1.Үндэслэл

Монгол Улс макро эдийн засгийг тогтворжуулах, үнийг чөлөөлөх, гадаад худалдааны саад хоригийг арилгах болон эдийн засаг дахь улсын салбарын хэмжээг багасгах зэрэг арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж зах зээлийн эдийн засагт шилжих томоохон алхмууд хийгээд байна.

Шилжилтийн эдийн засаг бүхий орнууд дотроос богино хугацаанд шинэтгэл хийсэн гэж үзлээн эввшөөрөгдсөн орны хувьд дотоодын нийт бүтээгдэхүүнд улсын салбарын эзлэх хувийн жин 1993 онд 51.8 хувь байсан бол одоо 25 хувь болж буурав. Гэвч 1990-ээд оны сүүлийн хагаст тохиолдсон экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ буурсан зэрэг гол төлөв гадаад хүчин зүйлээс үүдэлтэй эдийн засгийн хямрал нь гүйцэтгэлд чиглэсэн улсын салбарын хөгжлийг түргэсгэн дэмжихүйц бүтцийн болон институцийн шинэтгэл хийх шаардлагатайг тодорхой харуулсан юм.

Монгол Улсын Засгийн газар иргэдэд төрийн суурь үйлчилгээг үзүүлэх чадавхыа хадгалан бэхжүүлж, үр нөлөө бүхий хувийн хэвшлийн хөгжлийг дэмжихүйц эрх зүйн болон зохицуулалтын орчинг бий болгохыг зорьж байна.

Монгол Улсын Засгийн газрын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги нь эввхэн ажилгүйдлийг бууруулаад зогсохгүй, улсын салбарын менежментийн шинэтгэл, төрийн суурь үйлчилгээг иргэдэд үр нөлөөтэй хүргэх, нийлүүлэлтийг нь сайжруулахад чиглэж байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж зэрэг нэн чухал чиглэлээр үзүүлдэг үйлчилгээг дорвитой сайжруулах шаардлага байгааг энэхүү стратегийн баримт бичигт онцлон тэмдэглэсэн болно.

2003 онооос хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхэлсэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль нь төрийн албаны шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлэхэд нэг чухал алхам болсон. Энэхүү хууль нь төсвийн сахилгыг хангах шинэ механизм, түүнчлэн хариуцлага хүлээх, санхүү, төсвийн удирдлагыг сайжруулахад чиглэсэн, гарц (бүтээгдэхүүн)-д суурилсан гэрээний шинэ готтолцоог бий болгож байна. Үүний зэрэгцээ мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлэх чиглэлээр Төрийн албаны тухай хууль болон Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ.

Өөрчлөгдөн хөгжиж байгаа төрийн үүрэг, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, төрийн үйлчилгээг хүргэх хэрэгцээ, санхүү, төсвийн бодит байдалд төрийн албаны хэмжээ, өртөг зардал болон олон талт үр чадварыг тасралтгүй нийцүүлж байх шаардлагатай байна. Иймд төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичигт төрийн албаны өнөөгийн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, төрийн албаны үр нөлөөтэй үйл ажиллагаа, хариуцлага хүлээх чадавхийг нь бэхжүүлэх талаар тодорхой санал, зөвлөмжийг тусгасан болно.

1.2.Төрийн албаны шинэтгэлийн хүчин зүйлс

Монгол Улсад төрийн албаны шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлэхэд дор дурдсан гадаад хүчин зүйлс нөлөөлж байна:

- 1990-ээд оны эхнээс дэлхийн социалист систем задран унаж, урьд өмнө хэдэн арван жилийн туршид хамтран ажиллаж байсан орнуудын төрийн захиргаанд гүн гүнзгий өөрчлөлт гарсан;

- Зөвхөн шилжилтийн үед байгаа тэдийгүй ихэнх хөгжингүй орон төрийн захиргааны шинэ загварыг боловсруулан хэрэгжүүлж байгаа;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагын хөтөлбөр, тэр дундаа техникийн туслалцаа, зээлийн нөхцөл нь төрийн захиргааны шинэтгэлийг чухалчлах болсон.

Монгол Улсад төрийн албаны шинэтгэлийг цаашид гүнзийрүүлэхэд дор дурдсан дотоод хүчин зүйлс нөлөөлж байна:

- Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт нь төрийн байгууллага болон төрийн албан хаагчийн үүргийг олон чиглэлээр өөрчлөхөд хүргэж байгаа;
- Байгаа нөөцийг туйлын хэрэгцээтэй бөгөөд үр нөлөөтэй чиглэлээр ашиглах, тухайлбал, эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үндсэн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн гаръын Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги хэрэгжиж эхэлсэн;
- Өргөн утгаар нь авч үзвэл төрийн эдгээр үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд төрийн албаны гүйцэтгэлийг сайжруулах хүсэл эрмэлзэл, тэр дундаа нэн ядуу болон эмзэг бүлгийнхэнд үзүүлэх төрийн нэн чухал үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байгаа;
- 2000 оноос хойш төрийн албан хаагчийн тоо нэмэгдсэн, түүнчлэн нийт төрийн албаны хэмжээнд цалин хөлсийг удаа дараа нэмэгдүүлсэн зэрэг нь төсөвт ихээхэн дарамт үзүүлж, улмаар төсвийн хөрөнгийг төрүүлэх чиглэлийн үйлчилгээ (ялангуяа эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахтай холбоотой) үзүүлэх болон хүмүүсийг шаардлагатай албан тушаалд томилох, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэхэд хүндрэл учруулж байгааг хүлээн зөвшөөрсөн явдал;
- Төрийн албаны бүтцийг цаашид боловсронгуй болгох хэрэгцээ;
- Монгол Улс зах зээлийн эдийн засагт бүрэн шилжихтэй холбоотойгоор төрийн албаны олон талт үр чадварыг өнөөгийн шаардлагад нийцүүлэх хэрэгцээ.

Дээр дурдсан хүчин зүйлсийг үндэслэн төрийн албаны шинэтгэлийн зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна:

1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бий болгохын тулд төрийн албаны хэмжээ, бүтэц, цалин хөлс, урамшуулал, бусад орлогын тогтолцоог Монгол Улсын санхүү, төсвийн бодит байдалд бүрэн нийцүүлэх;

2. Боловсон хүчний нөөцийг ядуурлыг бууруулах зэрэг Засгийн гаръын стратегийн тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулан хуваарилах;

3.Засгийн гаръаас тодорхойлсон бодлогын хүрээнд төрийн чанартай үйлчилгээг үр ашиг, үр нөлөөтэй хүргэхэд шаардлагатай ур чадвар, урам зориг болон институцийн бүтэц, зохион байгуулалтыг төрийн албанд бий болгох.

2. ТӨРИЙН АЛБАНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 Төрийн албаны шинэтгэлийн үе шат

Шилжилтийн орны төрийн албаны шинэтгэл нь улс төрийн болон эдийн засаг, нийгмийн асар их өөрчлөн байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн туслал юм. Тэдгээр шинэтгэлийн амжилт нь үндсэндээ засаглалын чадавхиас шалтгаалж байгаа учир төрийн захиргаа өөрөө улс төрийн болон эдийн засаг, нийгмийн шинэтгэлийн гол хөтөч нь болж байна.

Орон тоог цөөрүүлэх, өмч хувьчлах, төвлөрлийг сааруулах, татвар, боловсрол, эрүүл мэндийн салбар болон нийгмийн хамгаалал, тэтгэврийн тогтолцоонд шинэтгэлийг хэрэгжүүлэх зэргээр төрийн албаны шинэтгэлийн нэг бүс удаагийн арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ үйл явц одоо хүртэл үргэлжилсээр байна. Санхүү, төсвийн хүндрэлтэй байдал, түүнчлэн хямд өртөг бүхий чанартай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх шаардлага нь төрийн албаны шинэтгэлийг дүнд болон урт хугацаанд улам гүнзийрүүлэн эрчимжүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Төрийн албаны шинэтгэл сүүлийн арав гаруй жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн гаръын анхаарлын төвд байсаар ирсэн. Энэ хугацаанд дор дурдсан үндэсэн гурван үе шатыг дамжин хэрэгжиж байна:

Нэгдүгээр үе шат (1990-1993 он) нь Монгол Улсын төрийн байгуулллын шинэ бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, үүнтэй холбогдсон эрх зүйн болон бодлогын хүрээ заагийг бий болгоход төвлөрч байв. Энэ үе шатны гол алхмуудыг дурдвал:

- нам төвтэй улс төрийн тогтолцоог халж, төр төвтэй улс төрийн тогтолцоог бүрдүүлсэн;
- шинэ Үндэсэн хууль (1992 он) батлагдаж, түүнд нийцүүлэн гол гол хуулиудыг батлан гаргасан;
- хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн төрийн байгуулллын шинэ тогтолцоо бүрэлдэн тогтож, үйл ажиллагаагаа эхэлсэн;
- олон намын тогтолцоо бий болсон.

Хоёрдугаар үе шат /1993-2000 он/ нь төрийн бодлого, зорилгуудыг хэрэгжүүлэх чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Энэ үе шатны гол алхмуудыг дурдвал:

1.Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон бусад хандивлагч орон, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөр нь удирдлагын чадавхийг бий болгохыг чухалчилж байсан хэдий ч Монгол Улсын төрийн захиргаат шинэтгэх анхны иж бүрэн оролдлого байсан. Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гурван чухал үр дүнд хүрсэн. Үүнд: 1) Төрийн хянан шалгах хороо болон Төрийн захиргааны албаны зөвлөлийг шинээр байгуулж шинэ институцийг бий болгосон; 2) Төрийн албаны тухай хуулийг баталж төрийн албаны эрх зүйн орчинг бүрдүүлсэн; 3) удирдлагын чадавхийг бий болгосон.

2.Төрийн албаны тухай хууль нь Монгол Улсын түүхэнд анх удаа төрийн албаны боловсон хүчний бодлого, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлж, төрийн албаны шинэтгэл хийх эрх зүйн таатай орчинг бүрдүүлсэн.

3."Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулан Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор батлан мөрдүүлсэн.

Гуравдугаар үе шат нь 2000 оноос эхэлсэн бөгөөд засаглалын институцийн чадавхи, үйл ажиллагааных нь үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэж байна. Энэхүү үе шатны тэргүүлэх чиглэл нь:

- Засаглалын болон институцийн чадавхийг бэхжүүлэх;
- Улсын салбарын үр ашиг болон бүтээмжийг дээшлүүлэх;
- Төрийн үйлчилгээний үр нөлөө болон чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх явдал юм.

Дээр дурдсан тэргүүлэх чиглэлийг Засгийн газрын "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр"-ийн "Зохистой засаглал" бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажлын гүйцэтгэлийг сайжруулах зэрэг арга хэмжээ авч байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг батлан мөрдүүлж байгаа нь энэ үе шатны шинэтгэлийг хэрэгжүүлэх эрх зүйн нэн таатай орчинг бүрдүүлж байна. Уг хуулиар төсвийн байгууллагын ерөнхий менежерт боловсон хүчний асуудлаар шийдвэр гаргах эрхийг шилжүүлэх, иж бүрэн стратеги төлөвлөлт хийх болон Засгийн газрын "худалдан авах" бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хэрхэн гүйцэтгэсэн талаар хариуцлага хүлээх зэрэг харилцааг зохицуулж байна. Энэхүү хуулийн үзэл баримталж нийцүүлэн шинэчлэн найруулсан Төрийн албаны тухай хууль нь төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох, тэдний ажлын үр дүнгийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн.


Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны энэхүү стратеги нь 1990-ээд оноос хэрэгжүүлж ирсэн төрийн албаны шинэтгэлийн нэн чухал гуравдугаар үе шатанд хамаарч байгаа юм.

2.2. Төрийн албаны өнөөгийн байдал

Төрийн албаны зөвлөлөөс 2003 оны 2 дугаар улиралд төрийн албан хаагчтай холбогдолтой мэдээллийг цуглуулах төсөл хэрэгжүүлсэн бөгөөд уг төслийн дүнгээс үзэхэд 5200 гаруй төсвийн байгууллагад төрийн 124630 албан хаагч, сул орон тоон дээр төрийн албан хаагч биш боловч улирлын гэрээгээр буюу түр хугацаагаар 2684 хүн тус тус ажиллаж байсан байна. Ийнхүү төрийн албанд нийт 127314 хүн ажиллаж байсан нь 2003 оны улсын төсвөт тусгагдсан төрийн 136866 албан хаагчийн орон тоотой харьцуулахад нэлээд доогуур байв.

Эдгээр төсвийн байгууллагаас гадна өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг 15 агентлагт 4085 албан хаагч ажиллаж байсан ба хуульд заасны дагуу агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн албан хаагчийн ангилалд хамаардаг тул тэдгээрийг Монгол Улсын төрийн албан хаагчийн нийт тоонд оруулсан тохиолдолд 2003 оны 4 дүгээр сарын байдлаар төрийн албаны нийт ажиллагчийн тоо 128846 хүрч, энэ нь нийт хүн амын 5.2 хувьтай тэнцэж байв. 1996 оноос хойш төрийн албан хаагчийн тоонд гарсан өөрчлөлт (1990-ээд оны сүүлээр буурсны дараа 20 хувиар нэмэгдсэн)-ийн хандлагыг 1 дүгээр хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 1: Нийт төрийн албан хаагчдын тоо, 1996-2003



Дээр дурдсан тоо баримт нь төрийн албаны бүрэлдэхүүнд дор дурдсан хандлага бүхий өөрчлөлт гарсныг харуулж байна:

- Боловсрол, эрүүл мэндийн_салбарт ажиллагчдыг оролцуулан төрийн нийт албан хаагчийн дийлэнх буюу 73 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд, 7 хувь нь төрийн захиргааны албан тушаалд, 18 хувь нь төрийн тусгай албан тушаалд, 2 хувь нь төрийн улс төрийн албан тушаалд тус тус ажиллаж байна;
- Төрийн албан хаагчийн 73 хувь нь нутгийн захиргааны байгууллагад, 27 хувь нь төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажиллаж байна (1997-2002 онд эдгээр байгууллагад ажиллагчдын хувь байнга нэмэгдсэн);
- Төрийн албан хаагчийн ихэнх нь /59 хувь/ эмэгтэйчүүд байгаа бөгөөд тэдний эзлэх хувь өссөөр байна;
- Удирдах болон төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоо харьцангуй цөөн буюу 47 хувь байгаа боловч 1998 оноос /34 хувь байсан/ харьцуулбал энэ харьцаа тасралттүй өсч байна;
- Төрийн алба залуужиж байна. 2003 онд төрийн албан хаагчийн 75.9 хувь нь 45 хүртэлх, 5 хувь нь 55-аас дээш насных /0.5 хүрэхгүй хувь нь тэтгэврийн насных бөгөөд тэд гол төлөв хөдөө орон нутагт боловсон хүчин дутагдсаны улмаас ажиллаж байгаа/ байна;
- Сүүлийн жилүүдэд, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажилладаг төрийн албан хаагчийн тоо буурсан байна.

Хүснэгт 2: Төрийн албаны цалингийн сангийн ДНБ-д эзлэх хувь, 1995-2006 он



2.3 Төрийн албаны зардал, түүний төсөвт үзүүлэх нөлөө

1990-ээд оны эхэнд шилжилтийн үйл явцын нэг хэсэг болж төрийн албаны ажил эрхлэлт нэлээд буурсан ч 1995 оноос гол төлөв цалинг нэмэгдүүлсний улмаас төрийн албаны цалингийн сан ихээхэн хэмжээгээр өссөн.

Зах зээлийн эдийн засагт шилжих эхний үед Монгол Улсын эдийн засагт төрийн албаны зардал 1993 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 51.8 хувийг зээлж байсан бол 1995 онд 31.5 хувь болж буурсан байна. 1997 оноос өмнө төрийн албаны цалингийн сангийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь шилжилтийн үед байгаа орон болон бус нутгийн бусад орнотой харьцуулбал ойролцоо байсан.


1997 оноос хойш төрийн албаны цалингийн сангийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь ихээхэн өссөн. Гэхдээ 2 дугаар хүснэгтээс үзэхэд 2004 оны улсын төсөв болон дунд хугацааны төсвийн хүрээнд тусгасанаар 2003-2006 онд цалингийн сангийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь бага зэрэг буурах төлөвтэй байна (төсвийн өрөнхийлөн захирагчаар төсвийг хуваарилах болсны улмаас төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын цалингийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2002 оноос цааш хүснэгтэд харуулагдуй болно).

1997-2003 оны цалингийн сангийн өсөлт нь өмнөх хэсэгт авч үзсэн төрийн албан хаагчийн орон тооны өсөлттэй зарим талаар холбоотой ч гол төлөв төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ нэмэгдсэнийг харуулж байна. Албан тушаалын цалинг 2000 онд 25 хувиар, 2001 онд 9.2 хувиар, 2002 оны 10 дугаар сард 20 хувиар тус тус нэмсэн. Энэ хугацаанд цалингийн зардал төсөвт туссан хэмжээнээс ихээхэн хэтэрсэн байна.


Цалингийн энэхүү өсөлтийн улмаас 2000–2001 онд цалингийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 5 хувиас хэтрэн оцом өсөж, улмаар 2002 онд урсгал зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьтай тэнцэх хэмжээгээр өссөн байна. 2002 оны 10 дугаар сарын цалингийн өсөлт нь 2003 оны улсын төсөвт тусгагдсанаар нийт цалингийн сангийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлэх байсан ч төрийн албан хаагчийн тоог 2003 онд цөөрүүлснээр энэхүү өсөлтийг зогсоосон. Энэхүү чиг хандлагыг 3 дугаар хүснэгтэд үзүүлэв.

Төрийн албаны цалингийн зардал 2003 оны төсвийн зардал (цэвэр зээлийн бууаан төлөлтийг

Хүснэгт 3: Төсвийн зардал ба цалингийн сангийн ДНБ-д эзлэх хувь, 2001-2006 он



Хүснэгт 4. Төсвийн зардлын зүйл анги 2002 ба 2003 он



оролцуулан)-ын 20 хувь байгаа нь Засгийн газрын төсвийн зардлын ихээхэн хэсгийг эзэлж байв. /4 дүгээр хүснэгтэд үзүүлэв/ 2003 оны эхний 10 сарын байдлаар цалингийн сан урсгал төсвийн зардал (зээлийн хүүг оролцуулан)-ын 27.8 хувьтай тэнцэж байсан. Энэ нь 2001 онд 25.1 хувь болтлоо буураад, дараа нь өссөн ч ойролцоогоор 2000 оны түвшинд байна. Цалингийн сан зээлийн хүүг оролцуулалгүйгээр урсгал зардлын 29 хувьтай тэнцэж байгаа ба 2000 оноос хойш ижил төстэй хандлагатайгаар өөрчлөгдөж ирсэн байна.

Цалинг хугацаанд нь олгохгүй байх явдал 1999 онд ихээхэн гарч байсан бол одоо энэ асуудал шийдэгдсэн.

Төсвийн ихэнх хэсгийг цалиндзарцуулсны улмаас 1995-2000 онд дотоодын нийт бүтээгдэхүүнд түүний эзлэх хувь эрс өссөн нь улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хязгаарлах, Засгийн газрын зээлдэх хязгаарлагдмал чадавхи, ядуурлыг бууруулахад чиглэсэн санаачилга-алхмуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж эхэлж байна.

Олон улсын түвшингээс доогуур байгаа өнөөгийн цалингийн нягтрал нь (улс төрийн албан тушаалаас бусад төрийн албаны дээд болон доод цалингийн харьцаа) санхүү, төсвийн хувьд нэн чухал бөгөөд сүүлийн жилүүдэд тодийлэн нэмэгдээгүй байна. Тухайлбал 1997 онд цалингийн нягтрал 3.01 байсан бол 2003 онд 2.96 болсон байна. Цалингийн сүлжээний доод түвшингийн цалин илүү хурдан нэмэгдсэнээр хувийн хэвшлийнхтэй ижил түвшинд хүрээд байна. Одоогийн байдлаар төрийн албан хаагчийн цалин хөлсний доод түвшин /цалингийн сүлжээний/ зарим тохиолдолд хувийн хэвшлийнхээс дээгүүр байна.

Харин төрийн албаны удирдах албан тушаалын цалин хувийн хэвшлийн ижил төстэй албан тушаалын цалингаас улам хоцорсоор байна. Энэ нь төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэгч дунд түвшний нарийн мэргэжлийн болон мэргэшсэн албан хаагчийн сэтгэл санааг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зах зээлийн зохицуулалт, татвар зэрэг чухал салбарын сайн бэлтгэгдсэн мэргэжлийн хүмүүсийн цалин хөлс доогуур байх нь төрийн албанд шинэхүн авах, тогтвор суурьшилтай ажиллуулахад хүндрэл учруулах талтай юм. Улсын болон хувийн хэвшлийн цалинг харьцуулахад төрийн албан хаагчийн баталгаа, албан тушаалын цалингийн нэмэгдлийг харгалзан үзэх хэрэгтэй ч зарим чухал албан тушаалын цалингийн зөрүү улам нэмэгдсээр байгаа нь анхаарвал зохих асуудал болж байна.

3. ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙН ЗАРЧИМ, БОДЛОГО

3.1. Төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго ба эрхэмлэн дээдлэх зүйлс

Төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго:

Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхитэй, санаачлагатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Төрийн албаны шинэтгэлийн эрхэмлэн дээдлэх зүйлс:

- **Төрийн үйлчилгээг үр нөлөөтэй хүргэх.** Энэхүү эрхэмлэн дээдлэх зүйлс нь төрийн үйлчилгээг хүргэх явдлыг сайжруулах, улмаар ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болно.

- **Ажлын гүйцэтгэл, үр дүнг эрхэмлэн дээдлэх**. Шинэтгэлийн стратеги нь орцод биш, гарц, үр дагаварт тулгуурласан болно. Төрийн үйлчилгээг иргэдэд, нэн ялангуяа ядуу буюу эмэгт бүлгийнхэнд адил тэгш хүргэх нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэг байх болно.
- **Ур ашигтай бөгөөд хүртэхэд хялбар байх**. Монгол Улсын төрийн албан нь хамгийн бага өртөгөөр, төвийг сахиусалтын хатуу хязгаарлалтын дор аль болох олон үйлчилгээг хүртээж байх ёстой.

3.2. Төрийн албаны шинэтгэлийн зарчим

Төрийн албаны шинэтгэлийг дараахь зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Үүнд:

- **Олон нийтэд үйлчлэх** – төрийн албан хаагч нь Монгол Улсын төр, ард түмэнд үйлчлэх явдлыг өөрийн эрхэм үүргэз гэж үзэж, түүнийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавина.
- **Төрийн албаа мэргэшсэн, тогтвортой байх** – аливаа албан тушаалд томилох, албан тушаал дэвшүүлэхэд эвхэн мэргэшсэн байдал, ажлын гүйцэтгэлийг нь харгалзана.
- **Хүнийг тохирсон ажилд томилох** – аливаа албан тушаалд томилохын гол зорилго нь албан тушаал бүрт хамгийн сайн тохирсон мэргэжилтэнг байгуулагын харьяаллыг үл харгалзан сонгон ажилуулахад оршино. Энэ нь төрийн албаа мэргэшсэн, тогтвортой байх зарчмаар мөн баталгаажина.
- **Адил тэгш боломжтой байх** – Засгийн газар нь сайн ажил олгогч болохоо өөрийн жишээгээр харуулна. Улсын салбарт ажил эрхлэх нь эмэгт бүлгийнхний ямар нэгэн хэлбэрээр үл ялгаварлан гадуурхах сонголтын шалгуур бүхий нээлттэй үйл явц юм.
- **Менежерт удирдах бололцоог нь олгох** - менежер удирдаж буй байгуулагынхаа гарц (бүтээгдэхүүн), үр дагавар, хянаж буй үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх үүрэгтэй. Ийнхүү үр дүнгийн төлөө хүлээсэн үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь хэрэгтэй эрх мэдэл, уян хатан байх боломжийг тэдэнд олгоно.
- **"Сэлүүрдэх бус, залж чиглүүлэх"** – бодлогыг үйл ажиллагаанаас ялган салгаж, тэдгээрийн хоорондын зохистой тэнцвэрийг хангана. Үүнд төр нь нийтийн бараа, үйлчилгээг хүргэх бодлого боловсруулах, бодлогынхоо хүрээнд улсын /хувийн/ нийгмийн салбарын хөрөнгө нөөцийг зохистойгоор хуваарилан бараа, үйлчилгээ үйлдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.
- **Стратегиас урган гарсан бүтэцтэй байх** – байгууллагын бүтцийг түүний үйл ажиллагааны зорилго, зорилтод хүргэх хамгийн оновчтой аргаар тодорхойлно.
- **Орцыг бус, гарц, үр дагаврыг чухалчлах** – орцод хяналт тавих бус, харин гарц (бүтээгдэхүүн), үр дагаварт хүрэхийг хөхиүлэн дэмжих замаар улсын нөөцийг зохистой удирдана. Энэ зарчмыг улсын нийт салбарын санхүүгийн менежментийн болон төсвийн шинэтгэлд баримтална.
- **Төрийн алба байнга суралцагч хамт олон байх**- төрийн бүх байгууллага, хувь хүн шинэ санааг хүлээж авах, өмнөх туршлагаасаа суралцах чадвар, хүсэл эрмэлзэлтэй байх ёстой.
- **Эрх мэдлийг хүлээх хариуцлагатай нь хамт олгох** –эцсийн үр дүнгийн төлөө хариуцлага хүлээлгэхэд орцыг хянах хангалттай эрх мэдлийг менежерт олгох шаардлагатай. Юуны төлөө хариуцлага хүлээх нь тодорхой байсан нөхцөлд хариуцлага хүлээх чадвар бий болно.
- **Гүйцэтгэлд суурилсан урамшуулал олгох**- улсын салбарт ажиллагчдыг ажлын гүйцэтгэлээр нь урамшуулна.
- **Хэмнэлттэй хэмжээтэй байх**- Монгол Улсын хөгжилд үр нөлөөтэй, цомхон, чадварлаг төрийн албыг бүрдүүлнэ.

Дээр дурдсан эрхэмлэн дээдлэх зүйлс, зарчим нь Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны бодлогыг тодорхойлох боломж олгож байна.

3.3.Төрийн албаны шинэтгэлийн бодлого

Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх бодлого нь Төрийн албаны тухай хууль, Төвийг байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгалаа олсон.

Төрийн албаны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт нь дараахь бодлогыг тодорхойлсон:

- Төрийн албаа улс төрөөс ангид байх;
- Боловсон хүчний талаархи шийдвэр ил тод байх;

- Монгол Улсын иргэн төрийн албанд орох адил тэгш эрх эдлэх;
- Төрийн албан хаагчийн үүрэг, эрх, ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтоох;
- Хувийн орлого болон өмчийн талаар мэдээлэх;
- Албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих ажил, албан тушаалд гэр бүл, төрөл, садангийн хүмүүс хамт ажиллахыг хориглох;
- Үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнадаг, хараат бус бие даасан Төрийн албаны зөвлөлийг бий болгох.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хүрээнд дор дурдсан менежментийн үзэл баримтлал, арга хэрэгслийг нэвтрүүлсэн:

- Бүтээгдэхүүнд суурилсан төсөв зохиох (гэрээг үндэслэн төсвийн санхүүжилт авах);
- Үр дүнгийн гэрээ байгуулах;
- Бизнесийн стратеги төлөвлөгөө боловсруулах;
- Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан гаргах;
- олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийг мөрдөх;
- Байгууллагын (яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн) үүрэг, хариуцлагыг оновчтой тогтоох.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар төсвийн байгууллагын ерөнхий менежерийг төрийн албаны болон санхүүгийн менежментийн шинэтгэлийн цөм нь мөн гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлсэн.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу ерөнхий менежер боловсон хүчний талаар үндсэн шийдвэрийг гаргах, байгууллагаа удирдаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих эрх мэдэлтэй байна. Орц бус гарц (бүтээгдэхүүн)-д суурилах зарчмыг санхүү, бусад эд хөрөнгийн нөөцийг захиран зарцуулах, төрийн албан хаагчийг удирдахад нэгэн адил баримтална. Ерөнхий менежер төрийн албаны шинэтгэлийн стратегийн шаардлагыг мэддэг, түүнийг хэрэгжүүлэхэд хангалттай ур чадвар, эрх мэдэл эдлэх, ур ашиг, ур нөлөөтэй үр дүнд хүрэхэд хангалттай уян хатан байх нь амжилтын чухал үндэс буюу хүчин зүйл байх болно.

Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль нь Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлж байгаа төдийгүй төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны бодлогыг тодорхойлох боломж олгож байгаа юм.

Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны бодлого:

- Төсвийн байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх;
- Төрийн албаны хүний нөөцийн менежментийг сайжруулах;
- Төрийн албаны зохистой хэмжээг хангах, төрийн албан хаагчийн цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох.

Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны дээр дурдсан бодлого нь уг бодлогыг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлох боломж олгож байна.

4. ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙН СТРАТЕГИ

4.1 Стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын стратеги

Стратеги зорилт: Төрийн албаны, ялангуяа ерөнхий менежерийн стратеги төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль нь яам, агентлаг, төсвийн байгууллагаас үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөөгөө боловсруулж, улмаар бүтээгдэхүүнд суурилсан хариуцлагын тогтолцоонд шилжихийг шаардаж байна. Төсвийн нийт байгууллага холбогдох заавар, журмын дагуу энэхүү төлөвлөгөөгөө боловсруулж байна. 2004 оны төсөвт зарлагын ангиллыг бүтээгдэхүүний ерөнхий анги (эсхүл хөтөлбөр)-аар тусгасан болно.

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөө боловсруулах эхний жилийн туршлагаас үзэхэд энэ нь тэргүүлэх чиглэлээр бодлого боловсруулж стратеги зорилтод хүрэх арга замаа тодорхойлох бус, зөвхөн өнөөгийн үйл ажиллагаагаа бэлэн загварт оруулах байдлаар хязгаарлагдаж байна. Стратеги төлөвлөлтийг цаашид хөгжүүлэхэд (а) бүтээгдэхүүн нийлүүлэхэд гарах боловсон хүчний зардлыг хянах, (б) стратеги төлөвлөлтийн хүрээнд хүний нөөцийг төлөвлөх чадавхи нэн шаардлагатай байх болно.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн засгийн яам хамтран дагаж мөрдөж буй заавар, жүрмыг боловсронгуй болгох, сургалтын хөтөлбөр боловсруулах зорилгоор стратеги төлөвлөлтийн тодорхой туршлага хуримтлуулсан 7 байгууллагын ерөнхий менежерийг оролцуулан туршлага солилцох сургалт зохион байгуулна.
- Эхний жилийн туршлага дээр үндэслэн ерөнхий менежер, холбогдох албан тушаалтанд зориулан стратеги төлөвлөлтийн аргачлалаар сургалт зохион байгуулна.
- Төсвийн байгууллагын стратеги төлөвлөлтийн үйл явцыг төлөвшүүлэхийн тулд шаардлагатай төрийн албаны салбар зөвлөлд агентыг томилон ажиллуулна. Эдгээр агент нь тухайн байгууллагын төлөвлөгөөг гардан боловсруулах бус (учир нь үүнийг тухайн байгууллагын удирдлага хийх ёстой), харин тэдгээрийн ерөнхий менежерт туслалцаа, дэмжлэг үзүүлэх, төлөвлөлтийг зохицуулах, мөн үүний зэрэгцээ бусад үүрэг гүйцэтгэх болно.

Стратеги зорилт: Төрийн албаны орцод тавих зарим хяналтыг аажмаар сулруулахын хэрээр үр дүнг хэмжээсжүүлэх, түүнд мониторинг үнэлгээ хийх зэргээр гүйцэтгэлд үндэслэсэн удирдах чадавхийг бэхжүүлэх.

Гүйцэтгэлийн бодит, найдвартай шалгуур үзүүлэлтийг боловсруулах явдал нь бүтээгдэхүүнд суурилсан удирдлага, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэхэд хамгийн төвөтэй асуудал байдаг. Төрийн албаны хувьд төсвийн байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь төрийн албан хаагчтай байгуулах үр дүнгийн гэрээ, түүнийг үнэлж дүгнэх гол үндэс суурь байх болно.

Ялангуяа, хөгжиж байгаа болон шилжилтийн эдийн засагтай бусад орны туршлагаас үзэхэд, бүтээгдэхүүн тодорхойлох, түүний өртгийг тооцох, гүйцэтгэлийн оновчтой, найдвартай шалгуур үзүүлэлтийг боловсруулах, тийм механизм бий болгох үйл явц нь бүрэн хэмжээгээр төлөвшин хөгжихөд нэлээд хэдэн жил шаардагддаг байна.

Төсвийн зарим байгууллагын үйл ажиллагаог бүтээгдэхүүн хэлбэрээр тодорхойлох болон гүйцэтгэлийг дүгнэхэд хялбар байдаг учир гүйцэтгэлд суурилсан шинэтгэлийг бүрэн агуулгаар нь хэрэгжүүлэх үйл явц зөв гольдрилдоо харьцангуй түргэн ордог байна. Иймээс шинэтгэлийг хэрэгжүүлэх явцад байгууллагын дотоод хяналтын систем бий болгох зэрэг ажлыг гүйцэтгэх чадвартай, манлайлах үр чадвартай ерөнхий менежерийг урамшуулах үүднээс тухайн байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцох явдлыг арилгаж, дээрх төсвийн байгууллагад ялгавартай хандах шаардлагатай юм. Энэ хандлага нь (төрийн албаны хэмжээнд шинэтгэлийг хэрэгжүүлэхийг хүлээх бус) шинэтгэлийн зарим наалтыг үр дагаврыг аль болох эрт бий болгох, санхүүгийн болон менежментийн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд ерөнхий менежерт тус дэм үзүүлэх, "менежерт удирдах боломжийг нь олгосноос" гарах үр ашиг, үр нөлөөг аль болох ихэсгэх зэрэг давуу талтай.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар өмнө нь хэрэгжүүлсэн удирдлагын чадавхийг бэхжүүлэх туршлага дээр үндэслэн ерөнхий менежер, холбогдох албан тушаалтанд зориулсан сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах. Сургалт нь гүйцэтгэлийн үр нөлөөтэй шалгуур үзүүлэлтийг боловсруулах, үр дүнгийн гэрээ, хувь хүний гүйцэтгэлийг үнэлэх зэрэг асуудлыг хамрах болно.
- Төрийн албаны гүйцэтгэлийн талаар хэрэглэгчийн дунд санал асуулга явуулах, түүний дүнг нийтэлж байх зэрэг тогтмол эргэх холбооны механизмыг бий болгох.
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шат дараалалтай хандлагыг баримтлах. Тухайн төсвийн байгууллага нь стратеги төлөвлөлт болон гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үр чадвар, үйл явцыг бий болгон хөгжүүлэхийн хэрээр орон тоонд хязгаар тогтоох, орон тооны талаар төвөөс дүрэм, журам гаргаж мөрдүүлэх зэрэг орцод тавих зарим тодорхой хяналтыг аажмаар сулруулах. Төсвийн тухайн байгууллага нь шинэтгэлийн шалгуур үзүүлэлт (эдгээрийг 2004 онд боловсруулна)-ийг бүрэн хангасан гэсэн баталгаагаар Төрийн албаны зөвлөл болон Санхүү, эдийн засгийн яаманд гаргасан нөхцөлд тэдгээрийг бүтээгдэхүүнд суурилсан шинэтгэлийг хэрэгжүүлэх "дунд зэргийн туршлагатай" эсхүл "шилдэг туршлага"-тай байгууллага гэж ангилах болно.

4.2. Манлайлал болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтын стратеги

Стратеги зорилт: Төрийн албаны удирдах албан тушаалтан, ялангуяа ерөнхий менежерийг

нээлттэй, өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа төрийн албаны болон санхүүгийн менежментийн шинэтгэл нь ерөнхий менежерийг өргөн хүрээтэй төрийн албаны шинэтгэлийн үйл явцын төвд нь дэвшүүлэн тавьж байна. Төрийн албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, суурь үйлчилгээг хүргэхэд ерөнхий менежер чухал үүрэгтэй. Ерөнхий менежер Засгийн газарт сайн чанарын бодлого боловсруулахад зөвлөгөө өгч, Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэн, ирэгдэд үйлчилгээг хүргэнэ. Засгийн газраас тодорхойлсон үр дагаварт хүрэхэд дэмжлэг болохуйц бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ)-ийг нийлүүлэхийн төлөө ерөнхий менежер онцгой хариуцлага хүлээхээс гадна эргэж тайлагнах үүрэгтэй. Тэд тухайн байгууллагын нийлүүлэх бүтээгдэхүүн (гарц)-д анхаарлаа төвлөрүүлэхээс гадна нийлүүлэх бүтээгдэхүүнээ Засгийн газрын илүү өргөн хүрээтэй зорилготой уялдуулах ёстой. Үүний тулд тэд тухайн байгууллагын зорилго болон алсын харааны тухай нэгэн жигд ойлголт, мэдлэгтэй байх шаардлагатай бөгөөд ингэснээр ажиллагчдад ажлын өндөр гүйцэтгэлд хүрэх боломж олгох, урам хайрлах болно.

Ерөнхий менежерийг сонгон шалгаруулах нь төрийн албаны шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болно.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн актын дагуу төрийн жинхэнэ албаны 3000 гаруй удирдах албан тушаалтан-ерөнхий менежерийг нээлттэй, өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах юм. Хуулийн дагуу эдгээр орон тоог нийтэд зарлан Төрийн албаны зөвлөлөөс санал болгосон 3-5 хүний дотроос сонгон шалгаруулах болно. Уг нэрсийн жагсаалт болон түүнээс ямар шалтгаанаар хэнийг сонгосон тухай нийтэд мэдээлнэ. Улсын Их Хурлын 2003 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журмыг батална.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Улсын болон хувийн хэвшлийн байгууллагын удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах, томилох шилдэг туршлагад тулгуурлан илүү тодоор сонгон шалгаруулах шалгалтын тест боловсруулах, дүгнэх журмыг олон улсын экспертийн туслалцаатайгаар боловсруулж хэрэгжүүлнэ.
- Төрийн жинхэнэ албаны бусад удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журмыг нээлттэй, өрсөлдөөний зарчимд үндэслэсэн ерөнхий менежерийг сонгон шалгаруулах журамтай нийцүүлэн хэнах болно.

Стратеги зорилт: Ерөнхий менежер болон төрийн жинхэнэ албаны бусад удирдах албан тушаалд томилогдсон хүмүүсийн манлайлах ур чадварыг хөгжүүлэх.

Хамгийн сайн хүмүүсийг сонгох нь төрийн албаны үр нөлөөтэй манлайллыг хангахад хангалттай бус юм. Манлайлал болон бат бүрдүүлэх ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай. Ерөнхий менежерээс (а) байгууллагынхаа хэмжээнд стратегийн түвшинд бодож сэтгэх, (б) байгууллагын дотоод болон гадаад орчны хүрээнд үр бүтээлтэй ажлын харилцааг бүй болгох, (в) бусадтай нөлөө бүхий ажлын харилцаа тогтоох, (г) өөрийн биеэр үлгэрлэн өөрийгөө дайчлан, шударгаар ажиллах, (д) үр дүнд хүрэх явдлыг шаардаж байна.

Удирдах албан тушаалтныг илүү нээлттэй бөгөөд өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж томилсноор, мөн зарим албан тушаалд бусад байгууллагын төрийн албан хаагчийг сэлгэн ажиллуулснаар байгууллага хоорондын өдөр тутмын хамтын ажиллагаат сайжруулахад тус дэм болно. Швейцийн Төрийн Захиргааны Олон Улсын Институтын дэмжлэгтэйгээр хэрэгжих буй төсөлд туршиглэн удирдах боловсон хүчний манлайлах ур чадварыг нийт төрийн албаны хэмжээнд дээшлүүлнэ.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Ерөнхий менежер болон тэдэнтэй шууд хамтран ажилагчдад зориулан стратегийн хэмжээнд бодож сэтгэх, ажлын харилцаа холбоо тогтоох, биеэ дайчлан шударгаар ажиллах, ажлын үр дүнд хүрэх зэргийг багтаасан иж бүрэн бөгөөд төрийн албаны манлайлах үр чадварыг эрчимтэй дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулна. Энэхүү хөтөлбөр (хоёр долоо хоногоос доошгүй хугацаанд хийх сургалт) нь суралцагч байгууллагын зарчимд суралцах, тийм байгууллагын сүлжээ бий болгоход үндсэндээ чиглэгдэнэ. Уг хөтөлбөрт одоо ажиллаж байгаа бух ерөнхий менежер болон 2005 оны дунд гэхэд шинээр томилогдсон, ялангуяа ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагын менежер хамгийн түрүүнд хамрагдсан байх шаардлагатай. 2006 оны эцэс гэхэд ерөнхий менежерийн албан тушаалд шинээр томилогдох хүмүүст наад зах нь хөтөлбөрийн эхний шатанд хамрагдсан байх шаардлагыг урьдчилсан болзол нөхцөлийн нэг болгоно.
- Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг дүгнэх журмыг

удирдах ажилтныг сонгон шалгаруулах журамд тусгагдсан ижил тестэй шалгуурыг үндэслэн тэдний манлайлан удирдах ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгөх чиглэлээр өөрчилнө.

4.3 Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн стратеги

Стратеги зорилт: Төсвийн байгууллагын дотоод шийдвэр нь ил тод, байх, ажлын гүйцэтгэлд чиглэсэн байх явдлыг хангасан дүрэм, журам, зааврыг боловсруулах, хүний нөөцийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх.

Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн амжилт нь ерөнхий менежерээс тухайн байгууллагынхаа ажлын гүйцэтгэлд анхаарлаа төвлөрүүлж, ил тод, шударга байх наад захын стандартыг хангасан дүрэм, журам, хүний нөөцийн удирдлагын тогтолцоо бий болгосон байдлаас шалтгаална.

Төрийн албан тушаалтныг сонгон шалгаруулах журам нь төрийн алба мэргэшсэн тогтвортой байх, хүнийг тохирсон ажилд томилох, адил тэгш боломжоор хангах зэрэгт тулгуурласан байна.

Шинэтгэлийн дунд хугацаанд сонгон шалгаруулах үйл ажиллагааг ирээдүйд шаардагдах ажилтны орон тоо, үр чадвар, мэдлэг чадвар ба зардлыг тусгасан байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх болно. Хүний нөөцийн төлөвлөлт нь байгууллагын бизнесийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт болон стратегид үндэслэсэн байх болно. Байгууллагын бүтэц болон хөгжлийн стратеги нь хүний нөөцийн төлөвлөлтийн нэг хэсэг байх болно.

Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно. Ерөнхий менежерийн болон бусад удирдах албан тушаалд уг албан тушаалыг хаших шаардлага хангасан иргэн, төрийн албан хаагчийг нээлттэй, өрсөлдөөний зарчмаар томилох зарчмыг мөрдөх болно.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Төрийн албаны зөвлөлөөс төрийн нийт албанд хамаарах хүний нөөцийн удирдлагын загварыг боловсруулна. Уг загвар нь холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актын шаардлага, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ /Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын болон Төрийн албаны зөвлөлийн тогтоолууд) болон ерөнхий менежерт сонголт хийх боломж олгохуйц шилдэг практикийг тусгасан байна.
- Төрийн албаны тухай хуулийн 39.3-т заасан маргаан хянан шийдвэрлэх журмыг хянан үзнэ. Ингэхдээ (а) төрийн албан хаагч нь (ноцтой асуудлаас бусад) маргаантай асуудлаа ажил олгогч байгууллагаараа иоуны түрүүнд хянан шийдвэрлүүлсэн байх шаардлага, (б) энэхүү заалтын хүрээнд төрийн үйлчилгээний албан хаагчийг хамруулан өргөжүүлэх асуудлыг мөн авч үзэх болно.
- Төрийн захиргааны дунд түвшний удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулахад удирдах үр чадварын түвшин тогтоох мэргэшлийн шалгалтын тестийг боловсруулан нэвтрүүлнэ.
- Дунд хугацаанд төрийн захиргааны бүх албан тушаалын сул орон тоо болон үр орон тоог хэрхэн нөхсөн тухай нийтэд зарлан мэдээлдэг болно.
- Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлэх удирдлагыг удирдах албан тушаалтанд төвлөрүүлэх, мөн "дунд зэргийн туршлагатай" болон "шилдэг туршлага"-тай байгууллагын ерөнхий менежерийг илүү уян хатан ажиллах боломжоор хангахад чиглүүлнэ.
- Төрийн албаны бүх албан тушаалд томилох асуудлын талаар гарсан хууль тогтоомж, дүрэм, журам (Төрийн албаны тухай хууль болон тодорхой салбарын хууль тогтоомжийг оролцуулан)-ыг хянан үзнэ.

Стратеги зорилт: Төрийн албан хаагч бүрт хамгийн чухал шаардлагатай ур чадвар, тухайлбал төрийн албанд бүхэлд нь хамаарах бодлогын дүн шинжилгээ хийх, эрсдлийн менежмент, мэдээллийн технологи ашиглах ба хүний нөөцийн удирдлага, түүнчлэн гүйцэтгэлийн удирдлагын ур чадвар үзэмшүүлэх.

Энэхүү стратеги зорилтын нэн тэргүүний шаардлага нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа өрөн хүрээтэй шинэтгэл, төсвийн байгууллагын хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн төрийн дээд болон дунд шатны албан тушаалтны суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх явдал юм. Энэ шаардлагыг хангах үүднээс манлайллын болон гүйцэтгэлийн удирдлагын чадавхийг хөгжүүлэхээс гадна сургалтын хэрэгцээны шаардлагыг тодорхой яам, улмаар төрийн нийт албаны хэмжээнд хянан үзэх, сургалтын хэрэгцээнд иж бүрэн үнэлгээ хийх шаардлагатай байна.

Сургалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийж дуусгахыг хүлээхгүйгээр төрийн нийт албаны хэмжээнд дөрвөн тэргүүлэх чиглэлийн сургалт явуулах хэрэгтэй. Нэгдүгээрт, салбарын яаманд стратеги төлөвлөлтийн үр чадвараас гадна бодлогын дүн шилжилгээ хийх үр чадвар нэн шаардлагатай байна. Тєсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хүрээнд хийгдэх менежментийн шинэтгэл нь түүний суурь болох Засгийн газрын бодлого болон бодлогын чанартай эвлүүлэг, дүн шинжилгээг Засгийн газарт гаргаж ѐгдэг яамны шийдвэрлэх үүргээс үндсэндээ хамаарна. Салбарын онцлогтой бодлогын тодорхой асуудал байхын зэрэгцээ нийт яамны хэмжээнд бодлогын дүн шинжилгээ хийх үндсэн багц үр чадвар гэж байх бѐгөөд түүнийг цаашид хөгжүүлэх болно.

Хоѐрдугаарт, Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн стратегид эрсдлийн менежментийн хандлагыг тусгасан. Үчир нь, манлайлал нь "завийг сэлүүрдэхээсээ" илүү "залж чиглүүлэх" үүрэгтэй байдаг тул үг завины чиглэлийг хэдийд өөрчлөх, хэр ойроос хянах ба хэдийд хөндлөнгөөс оролцох вэ гэдгийг мэдэж байх нь туйлын чухал. Төвлөрсөн шийдвэр гаргах, бүхнийг хянан шалгахын оронд стратегийн түвшинд шийдвэр гарган хариуцлага хүлээдэг болно. Үүний зэрэгцээ эрсдлийн зохих үнэлгээ, менежмент заавал байх шаардлагатай. Төрийн албаны бүх түвшинд, тухайлбал ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яам, агентлаг хоорондын харилцаа, ерөнхий менежер болон бусад шатны менежер хоорондын харилцаа, мөн төрийн аудит хийх, тєсвийн орлого бүрдүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдүүлэхэд эрсдлийн менежмент хэрэгтэй байдаг. Иймээс төрийн албан тушаалтныг эрсдлийн үнэлгээ, эрсдлийн менежментийн зарчмын талаар өргөн хүрээтэй ойлголттой болгох нь тодорхой арга техник хэзээшихээс илүү онцгой ач холбогдолтой юм.

Гуравдугаарт, хүний нөөцийн удирдлагын загварын хүрээнд яам, агентлагийн хүний нөөцийн удирдлагын ур чадварыг бэхжүүлэх, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтны үндсэн мэдлэг чадварыг хөгжүүлэх, албан тушаалд сонгон томилох үйл явцыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дөрөвдүгээрт, мэдээллийн технологи ашиглах ур чадварыг дээшлүүлэх өргөн хэрэгцээг гагцхүү мэдээллийн технологийн мэргэжилтэй хүмүүс авч ажиллуулах бус, харин дунд болон дээд шатны удирдах ажилтны мэдээллийн технологи ашиглах ур чадварыг хөгжүүлэх замаар хангана.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Төрийн албаны сургалтын хэрэгцээнд иж бүрэн дүн шинжилгээ хийх бѐгөөд ингэхдээ нийт төрийн албанд хамаарах үндсэн мэдлэг, чадвар, тодорхой салбарын дүн шинжилгээг хамрах болно.
- Дээр дурдсан дүн шинжилгээнд тулгуурлан мэдлэг, чадварт суурилсан төрийн албаны сургалтын стратегийг боловсруулах бѐгөөд салбарын онцлог бүхий сургалтын болон чадавхийг хөгжүүлэх стратегитэй уялдуулна.
- Урт хугацаанд төрийн албаны сургалтыг "худалдан авагч-нийүүлэгч" гэсэн загварыг үндэслэн явуулах бѐгөөд ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яам, түүнчлэн Төрийн албаны зөвлөл нь сургалтын үйлчилгээг нийүүлэгчээс нь худалдан авч, нийүүлэгчийн дунд өрсөлдөөн ѐрнүүлэхийг идэвхитэй дэмжих болно. Цаашид, байгууллагын хэрэгцээт тусгай сургалтыг тэднээс ирүүлсэн санал, хандивлагчдын дэмжлэгийн бололцоог судлан, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яамнаас ѐгсөн үнэлгээнд үндэслэн улсын тєсвеєс санхүүжүүлэх болно. Алслагдсан бүс нутагт ажиллаж буй төрийн албан хаагчийн сургалтанд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх үүднээс зайны сургалтын арга чилэлыг сургалтанд нэвтрүүлэн ашиглана.
- Дээр дурдсан сургалтыг эхлэх хүртэлх хугацаанд төрийн албаны хэмжээнд богино хугацааны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, холбогдох төрийн албан тушаалтныг бодлогын дүн шинжилгээ хийх, эрсдлийн менежмент, хүний нөөцийн удирдлага болон мэдээллийн технологи ашиглах чиглэлээр сургах болно. Эдгээр сургалтад тодорхой чиглэлийн удирдах болон төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалтныг хамруулах бѐгөөд сургалтыг хандивлагчдын дэмжлэгээр (ялангуяа 2004 онд) болон улсын тєсвеєс (2005 оноос эхлэн) хэсэгчлэн санхүүжүүлэх гэсэн хосолсон хэлбэрээр санхүүжүүлнэ.

4.4 Бодлогын шинжилгээ болон тоо баримтын стратеги

Стратеги зорилт: Төрийн албаны мэдээллийн сан бий болгох, мониторинг хийх чадавхийг хөгжүүлэх замаар боловсон хүчний удирдлага, хяналтыг бэхжүүлэх.

Төрийн албан хаагчийн ажил эрхлэлттэй холбогдсон аливаа шийдвэр нь орон тооны цомхотгол хийх, тэтгэвэр олгох, ажлаас чѐлөѐлсний тэтгэмж олгохтой холбоотой их хэмжээний зардал, мөн нэгэнт ажиллаж байгаа боловсон хүчнийг

ажлаас халахтай холбоотой улс төрийн шинжтэй бэрхшээлтэй тулгарах нь олонтаа байдаг.

Төрийн албаны эвдрэлээс 2003 оны 4 дүгээр сард төрийн албаны талаархи тоо баримтыг нарийвчлан шалгасан боловч шаардлагатай бүх мэдээллэл түүнд ороогүй бөгөөд түүнийг тогтмол шинэчлэн баяжуулаагүй байна. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны мэдээллийн сан төрийн бүх албан хаагчийн овог, нэр, иргэний үнэмлэхийн регистрийн дугаар, боловсрол, мэргэшил, мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшил болон мөнгөн бус хангамж (унаа, гар утас г.м.) зэргийг багтаасан бүхий л мэдээллийг оруулна. Энэхүү мэдээллийн тогтолцоог бий болгосноор төрийн албаны ажил эрхлэлтийн байдалд тогтмол хяналт тавих боломж бүрдэнэ.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны загвар боловсруулахад (а) холбогдох бүх мэдээллийг хамруулахын тулд төрийн захиргааны төв байгууллагын мониторингийн хэрэгцээ; (б) ерөнхий менежерийн удирдлага дор ажилладаг боловсон хүчний талаарх (хүний нөөцийн төлөвлөлтийг оролцуулан) удирдлагын мэдээллийн хэрэгцээ; (в) мэдээллийн санг бүрдүүлж, тогтмол баяжуулах журам болон урамшуулал (үүнд өгөгдсөн мэдээлэл оруулах хариуцлага, цуглуулсан мэдээллийн хэмжээ, хувь, хүний албан тушаал болон цалингийн өөрчлөлттэй холбогдсон мэдээллийг автоматаар шууд оруулах г.м.); (г) төрийн албан хаагч хувийн хэрэгтэйгээ танилцах, бууруу ташаа зүйл байвал залруулах хүсэлт гаргах эрх; (д) хувийн нууцтай холбоотой мэдээллийн нууцыг (тодорхой түвшний мэдээллийг хүртэх журмыг оролцуулан) хамгаалах зэргийг онцгойлон анхаарах болно.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны загварыг иж бүрэн боловсруулан нэвтрүүлэхдээ мэдээллийн санг бүрдүүлэх, нууцыг хамгаалах зэрэг дээр дурдсан асуудлыг анхааран авч үзэх бөгөөд үүнийг хэрэгжүүлэхээр тохиролцсон стратегийг үндэслэн компьютер, хэрэглээний программ хангамжийг худалдаж авна.
- Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд_шаардагдах суурь мэдээллээр хангахын тулд төрийн албаны бүрэн хэмжээний тооллогыг 2004 онд явуулна.
- Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх буюу ашиглах яам, агентлагийн ажилтанд зориулсан тусгай сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

Стратеги зорилт: Төрийн захиргааны төв байгууллагын дүн шинжилгээ хийх чадавхийг хөгжүүлэх.

Одоогийн байдлаар Төрийн албаны эвдрэл болон Санхүү, эдийн засгийн яамны дүн шинжилгээ хийх чадавхи хязгаарлагдмал байна. Иймээс энэ хоёр байгууллагын чадавхийг бэхжүүлэн төлөвшүүлснээр гүйцэтгэлийн мэдээллэл болон хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх болно. Тухайлбал, эдгээр байгууллага нь а) гүйцэтгэлийн болон төрийн албаны холбогдолтой мэдээлэлд дүн шинжилгээ хийх, б) гүйцэтгэл, санхүүгтэй холбогдсон шинээр гарч буй асуудлыг шийдэх, в) төрийн албаны шинэтгэлийн зохистой бодлогыг боловсруулах шаардлагатай тулгарч байна.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Төрийн албаны шинэтгэлийн талаар гол шийдвэр гаргагч байгууллага хоорондын ажлын харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны эвдлэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Санхүү, эдийн засгийн яамны дүн шинжилгээ хийх үр чадварыг сайжруулахад зориулсан чадавхи бүй болгох тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

5.ТӨСӨВ САНХҮҮ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТРАТЕГИ

5.1 Төрийн албаны оновчтой хэмжээний стратеги

Стратеги зорилт: Төрийн албаны чиг үүрэг болон чухам ямар үйлчилгээг зохистой арга механизмаар үзүүлэхийг Засгийн газраас хүсч байгаат судлан үзэх замаар төрийн албаны хэмжээг зохистой хэмжээнд үе шаттайгаар хүргэх.

2002, 2003 онд Засгийн газраас төрийн албан хаагчийн орон тоог бууруулах талаар удаа дараа шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэрт нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл болон хувьчлалын талаархи Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоол, түүнчлэн улсын төсвийн удирдлагын шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоол тус тус хамаарч байна.

2003 онд орон тоог дунджаар 10 хувиар бууруулахаар шийдвэрлэсэн хэдий ч ямны чадавхи, байгууллагын орон тоогоо хэмнэх боломжоос шалтгаалан чөлөөлөгдсөн орон тоо байгууллага тус бүрт харьцангуй өөр байна.

Өмнөх жилүүдийн төсвийн алдагдлыг бууруулах үүднээс ийнхүү орон тоог цөөрүүлсэн нь богино хугацаанд авсан арга хэмжээ байсан гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй. Гэвч дунд болон урт хугацаанд, ялангуяа Засгийн газраас төрийн үндсэн үйлчилгээг иргэдэд хүргэх механизмыг сайжруулах, бүтээгдэхүүнд суурилсан төсвийн удирдлагыг нэвтрүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч байгаа нь-юнд зардлыг барих буюу бууруулах нь тэдийлэн үр нөлөөтэй стратеги биш юм. Төсвийн зардлын тухай Дэлхийн банкны илтгэлд цохон тэмдэглэснээр орон тоог эрс бууруулах, орон тооны дээд хязгаар тогтоох, төрийн албаназ сайн дураараа халагдсан хүмүүст нөхөх олговор олгох зэрэг төрийн нийт албыг камарсан стратеги нь тэргүүлэх ач холбогдол багатай салбарт чиглэгдээгүйн зэрэгцүэ мэдлэгтэй, зохицон ажиллах чадвартай ажилтныг улам олноор алдахад хүргэх зэргээр ядуурлыг бууруулах урт хугацааны зорилтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх талтай юм.

Төрийн албан хаагч нийт хүн амын 5 хувийг эзэлж байгаа нь бусад орнотой харьцуулахад ойролцоо хэмжээнд байна. Гэвч 2004 оны улсын төсөвт тусгагдсанаар улсын салбарын ажил эрхлэлт (төрийн емчит үйлдвэрийн газрыг оролцуулан) нийт ажил эрхлэлтийн 17 хувьтай тэнцэж байгаа нь улсын салбарын эдийн засагт эзлэх хувь өндөр байгааг харуулж байгаа бөгөөд түүний хэмжээ, бүтэц байвал зохих түвшиндээ хүрээгүй байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж буй өнөө үед төрийн албаны зохистой хэмжээ нь юуны өмнө төрийн албанаас юуг хүсэн хүлээж байгаагаас шалтгаална. Улсын болон хувийн хэвшлийн зохистой харьцаат тогтоох, өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжихийн тулд олон байгууллагын эрх зүйн байдлыг хянан үзэх хэрэгтэй.

Түүнчлэн төрийн ямар чиг үүргийг төрийн байгууллагаар, ямар чиг үүргийг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх вэ гэдгийг шийдэж, сонголт хийх хэрэгтэй. Хэрэв төрийн үйлчилгээг төрийн албан хаагчаар шууд үзүүлэхгүй, төрийн албаны үүргийг гагцхүү бодлогын зөвлөгөө өгөх, гэрээний удирдлага, эсүүл бүцалтгүй тусламжийг захиран зарцуулахаар хязгаарлавал түүний хэмжээ тедийлэн том байх шаардлагагүй юм.

Дээрх сонголтыг хийхэд төрийн албан хаагчийн тоонд өөрчлөлт оруулах нь тедийлэн нөлөөлөхүй, харин зайлшгүй шаардлагатай суурь үйлчилгээг хамгийн үр ашиг, үр нөлөөтэй арга механизмаар хэрхэн хүргэхээс шалтгаална.

Төсөв хязгаарлагдмал байгаа болон өнөөгийн зах зээлийн нөхцөлд ач холбогдол багатай буюу эрэгтүй болсон зарим үйл ажиллагааг тодорхойлон тогтоож, цар хүрээг нь хумих буюу зогсоох нь чухал юм. Энэ нь зарим төрийн захиргааны төв байгууллага, агентлагийг хамарч, ач холбогдол багатай буюу хэрэгүй болсон чиг үүргийн талаар Засгийн газрын танхимд стратеги санал зөвлөмж өгөх, стратеги чиг үүргийг хянан үзэхэд гол асуудал байх болно.

Стратегийн эдгээр асуудлыг урт хугацаанд шийдсэний дараа бүтээгдэхүүнд суурилсан нийт төсвийнхөө үр дүнд багтаан өөрийн байгуулагын хэмжээг тогтооход өренхий менежер гол үүрэг гүйцэтгэнэ.

Монгол Улсын төрийн алба гол төлөө өргөн уудам нутаг дэвсгэрт тархай бутархай, хүнд нөхцөлд нүүдлийн аж ахуй эрхлэн амьдарч буй иргэдэд төрийн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээн хүргэж байна. Иймэ байдал нь үндэсний онцлогтой хүндрэл бэрхшээл, хэрэгцээг буй болгон тэдгээрийн шийдлийг шаардаж байна. Энэ нь төсвийн байгууллага тогтсон тооны ажиллагчдыг цалинжүүлахыг хүсэх бус, харин бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээндээ зориулан санхүүжилт хүсдэг бүтээгдэхүүнд суурилсан төсвийн загварыг Засгийн газраас үе шаттайгаар хэрэгжүүлэх болсон шалтгааны нэг юм.

Төрийн захиргааны төв байгууллага буюу өренхий менежер төрийн албаны орон тоог бууруулахад хэрэглэж болох арга механизмыг ашиглана. Эдгээрт орон тооны дээд хязгаар тогтоох, төрийн албаназ сайн дурын үндэсэн дээр гаргах зэрэг төрийн нийт албыг хамарсан арга хэмжээнээс эхлээд бүтцийг өөрчлөх буюу үйл ажиллагаар дахин инженерчлэхэд чиглэсэн чиг үүргийг хянан үзэх, өмч хувьчлалын стратегийг хэрэгжүүлэх зэрэгт чиглэсэн зорилготой стратеги хүртэл багтана. Төрийн нийт албыг хамарсан шинэтгэлийн зарим стратеги нь төрийн чухал суурь үйлчилгээний чанарыг бууруулж, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүртэх эдгээр үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг. Нэн тэргүүний ач холбогдолтой төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг бодитой сайжруулахын тулд төрийн албаны орон тоог туушгай бууруулах багц арга хэмжээ авах шаардлагатай байна.

Ялангуяа алслагдсан бүс нутагт "үйлдвэрлэлийг оновчтой хэмжээнд тогтоох" буюу ашигтай үйлдвэрлэл явуулахын тулд Засгийн газраас үйлчилгээ хүргэх арга хэрэгслээ өөрчлөх, тухайлбал, үйлчилгээ хүргэх цэгүүдийг нэгтгэн "нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэх зэргээр өөр өөр альтернатив арга хэрэгсэлтэй хослуулах боломжийг судалж үзнэ. Үүнд төрийн үйлчилгээний

төвлөрлийг сааруулах стратегийн нэг хэсэг болгон нутгийн захиргааны нэгж болон үүрэг хариуцлагыг нэгтгэх асуудлыг ч хамруулж болох юм.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Стратеги чиг үүргийг хянан үзэхдээ тодорхой зарим салбарын чиг үүрэг, бүтцийг өөрчлөх болон Засгийн газарт (а) шаардлагагүй болсон чиг үүрэг; (б) Засгийн газрын стратегийн тэргүүлэх чиглэл болон орчин үеийн зах зээлийн эдийн засгийн хэрэгцээг үндэслэн бодитойгоор шинэчлэн өөрчлөх шаардлагатай чиг үүрэг буюу үйлчилгээг хүргэх хэрэгслийг өөр өөр хувилбар; (в) стратеги шийдвэрээс үүдэлтэй бүтцийн чанартай үр дагавар; (г) ялангуяа алслагдсан бүс нутагт байгуулагын уламжлалт хил хязгаараас давсан үйлчилгээг хүргэх шинэлэг арга хэрэгслийг тодорхойлон тогтоох зэрэг асуудлаар зөвлөмж гаргана.
- Төрийн захиргааны төв байгууллага, агентлагийн боловсон хүчний нөөцөө үр нөлөөтэй зохицуулах (үүнд шаардлагатай үед орон тоог бууруулах механизм, зохистой орон тооны талаар шийдвэр гаргаж хэрэгжүүлэх асуудал мөн хамаарна) чадавхитай болгох зорилгоор сургалт зохион байгуулна.
- Чиг үүргийг хянаж үзэх арга хэмжээний хэрэгжилтэд төсвийн тайлан, хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо болон Засгийн газрын танхимд тогтмол тайлагнах механизмаар дамжуулан хяналт тавина.

Эдгээр арга хэмжээг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар тодорхойлсон бизнесийн стратеги төлөвлөлтийн үйл явцын хүрээнд авч хэрэгжүүлнэ.

5.2Цалин хөлс болон хангамжийн стратеги

Стратеги зорилт: Төрийн албаны цалингийн санг төсөвт хэт их хүндрэл учруулахгүй байхаар, үр нөлөө бүхий төрийн үйлчилгээнд, ялангуяа ядуурлыг бууруулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх Засгийн газрын чадавхид сөргөөр нөлөөлохгүй байхаар төлөвлөж байх.

Төрийн албаны дунд хугацааны шинэтгэлийн амжилтын үндэс нь нэг талаас үр нөлөө, үр ашигтай төрийн үйлчилгээг хүргэхийн тулд чадварлаг төрийн албан хаагчийг шинээр авч, тогтвортой ажиллуулахын зэрэгцээ, нөгөө талаас үр бүтээл муутай ажилтан бүй зарим ажилтныг ажлаас чөлөөлөх, төсвийн сахилга батыг чанд сахиулах явдал юм. Энэ хоёр асуудлыг Засгийн газар үндэслэл болгоно. Төрийн үйлчилгээг дунд болон урт хугацаанд үр нөлөөтэй болгохын тулд төрийн албаны дадлага туршлагатай, мэдлэг, чадвартай чадварлаг хүмүүсийг хослуулан ажиллуулж, ажлын гүйцэтгэл, авъяасыг нь үнэлэн цалин хөлс олгодог (албан тушаал ахиулдаг) урамшууллын тогтолцоотой чадварлаг төрийн албатай байх шаардлагатай.

Төрийн албаны цалингийн санг нэмэгдүүлэх нь улсын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, Засгийн газрын зээлдэх, ядуурлыг бууруулах зэрэг тулгамдсан асуудлыг шийдэх хязгаарлагдмал чадавхийг нь доройтуулах болно. 2003 онд цалингийн сангийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 8.6 хувьд хүрч байв. Улсын Их Хурлаас 2003 оны 6 дугаар сард батлагдсан Засгийн газрын дунд хугацааны төсвийн хүрээ нь төрийн албаны цалингийн санг дунд хугацааны зорилтыг тодорхойлсон бөгөөд төрийн албаны цалингийн санг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2004 онд 8.5, 2005 онд 8.4, 2006 онд 8.3 хувиас хэтрэхгүй байхаар тус тус тогтоосон. Засгийн газар 2004 онд цалингийн санг нийт улсын төсвийн 19.2 хувь, урсгал төсвийн 25.2 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоосон бөгөөд энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүнд туссан 2004 оны төлөвлөгөөт зорилтоос доогуур байна.

Төрийн нийт албаны, эсхүл тодорхой байгууллагын буюу төрийн албаны ангиллын хүрээнд ирээдүйд цалин нэмэх санал нь төсвийн нийт зардалд ямар нөлөө үзүүлэх талаар үнэлгээ өгөх Засгийн газрын чадварыг дээшлүүлэх зорилгоор Цалингийн зардлыг судлан шинжлэх загварыг Дэлхийн банкны туслалцаатайгаар боловсруулаад байна. Энэ загвар нь төрийн албаны орон тоо, албан тушаалын үндэсэн цалингийн хэмжээ, нэмэгдэл, нөхөх төлбөр зэргээ гол өгөгдөхүүний болзошгүй өөрчлөлтөд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээнийг хугацаанд нийт цалингийн санг зардлын хувилбарыг тооцох боломж олгож байна. Энэхүү загварын тусламжтайгаар цалингийн нэмэгдэл ирээдүйн тэтгэврийн хэмжээнд хэрхэн нөлөөлөхийг мөн тооцоолон гаргах боломжтой болно.

Стратегийн 5.1-д дурдсан арга хэмжээнээс гадна дор дурдсан тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр нийт цалингийн санг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг дунд хугацааны төсвийн хүрээнд заасан хэмжээгээр багасгана:

- Төрийн албан хаагчийн бодит цалингийн өсөлт нь дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт, төрийн албаны шинэтгэлийн стратегийн хэрэгжилт, стратеги чиг үүргийн шинжилгээнээс үүдэн гарах орон тооны зохицуулалтаас хамаарна.

Төрийн нийт албаны хэмжээн дэх цалингийн ирээдүйн өсөлтийг Цалингийн зардлыг судлан шинжлэх загварыг ашиглан бүрэн хэмжээгээр тооцож гаргана.

Стратеги зорилт: Төрийн албан хаагчийн цалин хөлсний тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн нөхцөлд тохируулах, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэх, улам ил тод болгох, гүйцэтгэлтэй холбох замаар боловсронгуй болгох.

Төрийн албан хаагчийн цалингийн нягтрал, улсын болон хувийн хэвшилд ажиллагчдын цалингийн зөрүү нь төрийн албан хаагчийг тогтвортой ажиллуулах, шинээр ажилд авахад сөрөгөөр нөлөөлж эхэлж байна.

Тогтвортой төрийн алба нь тодорхой ур чадварыг шаарддаг бөгөөд зарим ур чадвар нь Монголд хомс байна. Төрийн албан хаагчид зохих хэмжээний цалин хөлс өгөхгүйгээр үйлчилгээг иргэдэд хүргэх, боловсон хүчнийг ажилд авах, тогтвортой ажиллуулах, урамшуулахад хүндрэлтэй байх болно.

Засгийн газраас төрийн захиргааны, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчийн цалинг цаашид нэмэгдүүлэх шаардлага байгаа эсэхийг хянахдаа ур чадварын хувьд зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн шаардлага ямар байгааг онцгойлон анхаарах бөгөөд төсвийн байдал, төрийн нэн шаардлагатай суурь үйлчилгээний хүргэлтийг сайжруулахад чиглэсэн төсвийн бодлогыг харгалзан үзнэ. Үүнд:

- Төрийн албан хаагчийн цалин хөлсний талаархи хууль тогтоомжийн зохицуулалтыг анхааран үзэх;
- Төрийн албанд дутагдаж байгаа ур чадвар болон төрийн албанаас бусад салбарт ажиллаж байгаа ур чадвар, эсхүл өндөр ур чадвартай төрийн албан хаагчид илүү өндөр цалин хангамжтай бусад салбарт ажил эрхлэх боломж хайж байгаа зэргийг голлон судлах;
- Тэргүүлэх чиглэлээр ажилд авах, ажлаас халж байгаа байдалд (дараа дараагийн албан тушаалд авах цалин урамшуулыг оролцуулан) дүн шинжилгээ хийх;
- Төрийн өмчит үйлдвэрийн газар, хандивлагчдаас санхүүжүүлж буй төсөл болон хувийн хэвшлээс төрийн албатай өрсөлдөж буй байдлыг судлах;
- Ойрын болон дунд хугацааны төлөв байдлыг анхаарах;
- Төрийн албан хаагчийн цалингаас гадуур эдэлдэг хангамж (ялангуяа олон жил ажилласан төрийн албан хаагчийн цалингийн нягтралыг хэсэгчлэн орлох төтгөвэр)-ийг анхааралдаа авах;
- Цалингийн дээд хэмжээг нэмэгдүүлэх боломжийг авч үзэх. Ингэснээр өрөнхий менежер цалин нэмэгдүүлэхэд уян хатан хандах болно.
- Ур чадварын өнөөгийн болон ирээдүйн хомсдолын асуудлыг шийдэх стратегийн өөр өөр хувилбарыг тодорхойлох. Үүнд давтан сургах болон ур чадварыг дээшлүүлэх асуудал мэн хамаарна (өөрөөр хэлбэл, өндөр цалин урамшуулал олгосноор төрийн албанд орох хүсэлтэй хүмүүсийн тоог нэмэгдүүлэн улмаар ямар ч ур чадварын хомсдолыг арилгана гэж ойлгож болохгүй).

Санхүүгийн менежмент, аудит, санхүүгийн зах зээлийн зохицуулалт, татвар, удирдлагын дэд түвшний удирдах ажилтны болон үндэсний тэргүүлэх чиглэлийн (гэхдээ үүгээр хязгаарлахгүй) нарийн мэргэжил бүхий ажилтны ур чадварт үнэлгээ хийнэ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж, туршлага хуримтлагдахын хэрээр төсвийн байгуулагын ажилтнынхаа цалин хөлсийг ур нөлөөтэй, ил тод байдлаар тогтоох чадавхийг нь хөгжүүлэх хэрэгтэй болно. Шилжилтийн нэг алхам болгож зарим менежерийг (эсхүл хүний нөөцийн ахлах менежерийг) цалингийн сангийн илүүдэл (жишээ нь, 3-5 хувийн илүүдэл)-ийг цалин нэмэгдүүлэхэд хэрхэн зарцуулах төлөвлөгөө боловсруулах үйл явцад татан оролцуулна. Энэхүү үйл явц нь бүтээгдэхүүнд суурилсан төсвийн нөхцөлд эдгээр байгууллагын цалин, урамшууллын менежментийн болон дунд хугацаанд тесөвт үзүүлэх нөлөөг тооцоолох ур чадварыг нь хөгжүүлэхэд тустай байх болно.

Цалин хөлсний тогтолцоонд гүн гүнзгий шинэтгэл хийх шаардлага тавигдаж байна. Цалин нэмэгдүүлэх шахалтын нэг хэсэг болон төрийн албан хаагчийн цалин хувийн хэвшлийнхээс хэт доогуур байна гэсэн ойлголт нь цалингаас гадуурхи хангамжийг тэр бүр бүрэн гүйцэд авч үздэггүйтэй холбоотой юм. Монгол Улсад цалингаас гадуурхи хангамж нь бусад олон орны нэгэн адил төрийн албаны нийт цалин, урамшууллын үлэмж хэсгийг бүрдүүлж байна.

Тухайлбал, төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл / жишээ нь төрийн албан хаагч 16-20 жил төрийн алба хаасан бол үндсэн цалингийн 15 хувьтай тэнцэх нэмэгдэл/, докторын зэргийн нэмэгдэл /үндсэн цалингийн 15-20 хувьтай тэнцэх/, зэрэг дэвийн нэмэгдэл /үндсэн цалингийн 35 хүртэл хувьтай тэнцэх/ тус тус авдаг. Тэдэнд өндөр насны тэтгэвэр

олгохоос гадна цалин хөлсний бүх шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн 80-аас доошгүй хувийг болон бусад даатгалын зохих хэсгийг, түүнчлэн тэдний их, дээд сургууль сурч буй нэг хүүхдийн сургалтын төлбөрийг тус тус төр хариуцах, мөн орон сууц олгох зэрэг бусад цалингаас гадуурх хангамж үзүүлдэг. Зарим удирдах ажилтанд албан тушаалын болон албан ажлын унаа хэрэглүүлэх, түүнчлэн хэвлэлийн захиалга, утасны зардлыг төр хариуцдаг. Түүнээс гадна Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар цалингийн тодорхой хувьтай тэнцэх гүйцэтгэлийн бонус болон ажлын үр дүнтэй холбосон бусад төрлийн шагнал урамшуулал олгохыг зөвшөөрсөн байдаг. Төрийн албаны тухай хуулийн дагуу олгох нэмэгдэл болон цалингаас гадуурх бусад хангамжийн нийт хэмжээ нь тухайн төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн 100 хувиас хэтрэх ч тохиолдол гардаг.

Цаашид менежерийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхийн тулд өнөөгийн олон нэмэгдлийг үндсэн цалинд шингээх болно. Харин тэр болтол төрийн албан тушаалтны нэмэгдэл ба цалингаас гадуурх хангамжийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоогоор дамжуулан ил тод болгоно. Энэ нь төрийн албан хаагчийн цалин хөлсийг хувийн хэвшлийн цалин хөлстэй илүү бодитой харьцуулах боломжийг олгох бөгөөд төрийн албан хаагчийг хөдөлмөрийн зах зээлээс элсүүлэн авах, улмаар төрийн албаны чадавхийг сайжруулах боломжийг бүрдүүлж, хариуцлага хүлээх явдлыг сайжруулна.

Гүйцэтгэлийн бонус олгох шинэ бодлого нь ил тод байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ гүйцэтгэлийн удирдлага болон стратеги төлөвлөлтийн уялдаа холбоог улам сайжруулна. Ажлын гүйцэтгэлийг хөхиүлэн дэмжих, нийт цалин хөлсний тогтолцооны шударга байдлыг хангах зорилгод хүрэхийн тулд гүйцэтгэлийн бонус болон бусад шагнал урамшуулал ил тод байх шаардлагатай.

Цалин, урамшууллын шинэ бодлогод эхний үед жилийн эцсийн гүйцэтгэлийн бонусыг онцлон үзэхийн зэрэгцээ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 49-р зүйлийг хэрэгжүүлэхэд ерөнхий менежерт чиг баримжаа болгох үүднээс олон улсын урамшууллын тогтолцооны дараахь зарчмыг баримтална:

- Стратеги зорилттой уялдсан байх;
- Гүйцэтгэлийн бонус нь хэмжиж болохуйц гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд үндэслэсэн байх;
- Зөв зохистой гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хүсээгүй үр дагаварт хүргэхгүй байхаар сонгож авах;
- Гүйцэтгэлийг дүгнэхээс өмнө урамшууллын талаар хэлэлцэж тохирсон байх;
- Урамшууллын төрлийг тогтоохдоо урам оруулах хүчин зүйлс болон уламжлалыг анхааралдаа авах;
- Энгийн хялбар, ил тод байх, итгэлийг нь хүлээх замаар ажилтныхаа дэмжлэг авах;
- Байгууллагын урамшууллын тогтолцоог эдгээр зарчмын дагуу боловсруулахыг ерөнхий менежерт зөвшөөрөх;
- Өөрийн байгууллагын урамшууллын тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэхэд ерөнхий менежерт чиг баримжаа өгөх.

Дээр дурдсан стратеги зорилтын хүрээнд дор дурдсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Төрийн албаны зөвлөлд цалин хөлсний асуудлаар судалгаа хийх, мэдээлэл өгөх, шаардлагатай бол холбогдох санал боловсруулах нэгж бий болгоно.
- Ойрын хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс одоогийн цалингийн сүлжээ болон дээр дурдсаныг оролцуулан хамгийн чухал буюу хомсдолтой байгаа ур чадварын цалин, урамшуулын тогтолцоны талаар санал боловсруулна.
- Цаашид нэмэгдэл болон цалингаас гадуурх хангамжийг аажмаар албан тушаалын суурь цалинд нэгтгэн оруулна. Тэр болтол төрийн албан хаагчид олгож буй бүх нэмэгдэл, хангамжийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоонд оруулна.
- Төрийн албан хаагчийн ажлын үр дүнг урамшуулахад чиглэсэн гүйцэтгэлийн бонусын шинэ бодлого боловсруулна.

Дээр дурдсан арга хэмжээ нь цалингийн дарамтыг ямар нэг хэмжээгээр зөөлрүүлэх, үр дүнд чиглэсэн хандлага юм. Одоогоор хомсдолтой байгаа болон цаашид ч хомсдолтой байх ур чадвар бүхий ажилтны цалинг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэлээр урамшуулах явдлыг дэмжих, цалингаас гадуурх хангамжийг оновчтой болгох зорилтыг хэрэгжүүлснээр санхүү, төсвийн дарамт үүсгэлгүйгээр төрийн үйлчилгээг үр нөлөөтэй хүргэх төрийн албаны чадавхийг бэхжүүлэх болно.

Стратеги чиг үүргийн шинжилгээ болон бусад стратегийг хэрэгжүүлснээр илүүдэл чиг үүрэг, орон тоог амжилттай зохицуулан, цалингийн өсөлтийн хурдыг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хурдаас доош оруулж чадвал төрийн

нийт албан хаагчийн цалинг бодит байдлаар нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ

6.1. Төрийн албаны зөвлөлийн үүрэг

Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхойлсоноор: 1) улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явцад хяналт тавих; 2) төсвийн байгууллагын удирдах албан тушаалтныг хуульд заасан зарчмыг баримтлан сонгон шалгаруулах; 3) төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах; 4) төрийн албан хаагчийн талаар нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх; 5) мэргэшлийн шалгалтаар иргэдийг төрийн жинхэнэ албанд авах болон төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах; 6)төрийн жинхэнэ албан хаагчийн сургалт болон төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохицуулах; 7) төрийн байгууллагын бүтцийн өөрчлөй бүдүүвч, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишиг тогтооход санал өгөх; 8) төрийн албаны үйл ажиллагааг шинжилгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал боловсруулах; 9) төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төрийн албаны зөвлөл нь шийдвэр гаргах болон хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах талаар хуулиар хүлээсэн чиг үүргээ цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд өөрчлөлтийн менежмент болон чадавхийг бүй болгох чиглэлээр түүний хүлээх үүрэг нь улам бүр өргөжинө. Тухайлбал, төрийн албаны бодлого, чиглэлийг боловсруулах, хүний нөөцийн болон төрийн захиргааны менежментийн бусад асуудлаар өрөнхий менежерт зөвлөгөө өгөх болон төрийн албаны сургалтыг зохицуулах зэрэг чиг үүрэг нэмэгдэнэ. Гүйцэтгэх засаглалаас хараат бус, Улсын Их Хуралд шууд тайлагнадаг Төрийн албаны зөвлөл эдгээр үүргийг гүйцэтгэснээр төрийн албаны улс төрөөс ангид байх байдлыг бэхжүүлнэ.

Төрийн албаны зөвлөлийн ихээхэн өргөжих чиг үүрэгт 1)Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу өрөнхий менежерийн өсөн нэмэгдэж бүй үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 2) одоогоор дутагдаж байгаа төрийн албаны шинэтгэлийг хийх мэдлэг, туршлагатай хүмүүсийн хэрэгцээний нэгдсэн судалгаа гаргах; 3), олон улсын зөвлөхийн зөвлөмжийн өнөөгийн давхардал, үр ашиг багатай ажиллаж буй байдлыг засч залруулах; 4) техникийн туслалцаа, зөвлөхийн хийсэн судалгааны үр дүнг харилцан хуваалцах, алдагдсан боломжийг ашиглах; 5) төрийн албаны чиглэлийн хэд хэдэн байгууллага хамарсан техникийн туслалцааны төсөлд ажлын байр олох болон бусад дэмжлэг үзүүлэх; 6) Удирдлагын академизс гадна сургалтын үйлчилгээ авах хязгаарлагдмал боломлоог өргөтгөх зэрэг асуудал хамаарна.

Төрийн албаны зөвлөл нь төрийн захиргааны менежментийн шинэтгэлд дэмжлэг үзүүлэх, сайн засаглалын зарчмыг баримтлах талаар хошуучлан өөрчлөгч болох ёстой бөгөөд төрийн албаны шинэтгэл, сайн засаглалын мэдлэгийн төв байх болно.

Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны шинэтгэл, сайн засаглалыг дэмжих зорилгоор бодлого, чиглэл, удирдамж боловсруулах өнөөгийн чиг үүргээсээ гадна дор дурдсан үйлчилгээг үзүүлэх болно:

1. Улсын салбарын аль ч байгууллагад үйлчилгээ үзүүлж чадах улсын салбарын менежментийн шинэтгэл болон менежментийн бүх асуудлаар мэргэшсэн дотоодын зөвлөхийн баг бий болгон хөгжүүлэх. Үүний зэрэгцээ дотоодын зөвлөх болон бусад хэрэглэгчид нарийн мэдлэг олгох олон улсын зөвлөхийг санхүүжүүлэгч байгууллагаар дамжуулан урьж ажиллуулна.
2. Улсын салбарын менежментийн шинэтгэл болон засаглалын талаархи бүх судалгааны баримт бичиг, тайлан зэргийг агуулсан төвлөрсөн ном, мэдээллийн сан байгуулахын зэрэгцээ гадаад, дотоодын холбогдох интернетийн веб хуудастай холбоо бүхий интернетийн веб хуудас байгуулж ажиллуулах.
3. Олон улсын зөвлөхийн үйл ажиллагаат зохицуулах төв бүй болгох– гадаадын зөвлөхийг (шаардлагатай бол) ажиллах нөхцөл, үйлчилгээг зохицуулах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээг удирдах арга хэмжээ авах.
4. Төрийн албаны менежментийн сургалтыг зохицуулах, үүнд сургалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, сургалтын хөтөлбөрийг санал болгох, мэдлэг чадварыг хөгжүүлэх, сургалтын үйлчилгээ нийлүүлэгчийг төрийн албаны сургалтын зах зээлд нэвтрэн орохыг хөхиүлэн дэмжих.
5. Төрийн албаны шинэтгэл болон засаглалын асуудлаар Засгийн газарт зөвлөгөө өгөх.

Албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн албаны цалин хөлс, урамшууллын талаар судалгаа хийж санал боловсруулах, мэдээлэл өгөхөд Төрийн албаны зөвлөл голлох үүрэг гүйцэтгэнэ. Уг үүргийг гүйцэтгэхэд Төрийн албаны зөвлөлд бий болох нэгж дэмжлэг үзүүлэх болно.

Нэг талаас Төрийн албаны зөвлөл, негөө талаас Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны чиг үүргийг ялган зааглана. Хуульд өөрөөр заагаагүй бол эдгээр бодлого нь төрийн албаны ажил эрхлэлтэд нэгэн адил хамаарна. Давхардлыг арилгах, Засгийн газарт чанартай зөвлөгөө өгөхийн тулд Төрийн албаны зөвлөл, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хоёр нь хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх, тухайлбал, шинээр гарч буй үр чадварын дутагдал буюу цалин хөлсний чиг хандлагыг судлах талаар хамтран ажиллана. Гэвч төрийн албаны ажил олгогч болох Засгийн газрын үүргийг хөдөлмөрийн зах зээлийн өрөн хүрээтэй бодлого боловсруулах, зохицуулах үүргээс нь ялган зааглах нь нэн чухал юм.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төрийн албан хаагчийн орон тоонд тавих едер тутмын хэналтыг төсвийн байгууллагад шилжүүлснээр дүрэм журам мөрдүүлэхэд Төрийн албаны зөвлөлийн мониторинг хийх үүрэг нэмэгдэж, улмаар ерөнхий менежер засагчалын шаардлагыг ханагаж, төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг баттай сахих болно.

Эдгээр стратеги нь дор дурдсан зүйлийг хангана:

- Шинэчлэн боловсруулж мөрдүүлэхээр бэлтгэж байгаа төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг төрийн албан хаагчаар чанд сахиулах;
- Байгууллагын хэмжээнд дүрэм, журмыг ажиллагдаараа мөрдүүлэх эн тэргүүний хариуцлага хүлээж ажиллахыг ерөнхий менежерийн хувьд хэвшил болгох, дүрэм, журмыг мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээг боловсруулах;
- Байгууллагын хэмжээнд дүрэм журмыг хэрхэн мөрдүүлж байгаа, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд авч буй арга хэмжээнд Төрийн албаны зөвлөлийн мониторингийг шууд чиглүүлэх, өндер эрсдэлтэй зарим чиглэлээр шууд мониторинг хийх.

6.2 Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үүрэг

Төрийн албаны зөвлөл 2003 онд бие даасан байгууллага болж байгуулагдсанаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хүний нөөцийн асуудалд гүнзгий оролцох нь багассан ч ялангуяа Засгийн газрын хуралдааны шийдвэрүүлэхээр оруулж байгаа асуудал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой болон бусад чиглэлийн асуудлыг зохицуулах чухал үүргээ гүйцэтгэсээр байна.

Ерөнхий Сайд, Засгийн газрын танхимаас манлайлан удирдах чиг үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үндсэн үүрэг оршдог. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь бодлогын удирдлага, стратеги төлөвлөлттэй холбогдсон нэн тэргүүний чиг үүргээ гүйцэтгэхдээ чиглэлийн ямдад улсын хөгжил, стратеги төлөвлөлт, макро-эдийн засгийн судалгаа шинжилгээ, санхүү, хүний нөөцийн болон гүйцэтгэх удирдлагын менежментийн асуудлаар зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн төрийн захиргааны шинэтгэлийг зохицуулах талаар ч онцгой хариуцлага хүлээнэ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын танхимын стратегийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд едер тутмын дэмжлэг үзүүлэх үүргэтэйн хувьд төрийн албаны төлөвлөлтийг Засгийн газрын үйл ажиллагааны зорилт, гаргасан шийдвэртэй нь нийцүүлэхийн тулд чиглэлийн ямны стратеги төлөвлөлтийн явцад хэналт тавихад гүнзгий татагдан оролцох болно. Төрийн албаны шинэтгэлийн стратегийн дагуу стратеги чиг үүрийн шинжилгээ хийх үйл ажиллагааг зохицуулах чухал хариуцлага хүлээнэ. Гэхдээ энэ үйл ажиллагааг өөрөө гардан явуулах бус харин Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн засгийн яам болон тодорхой чиглэлийн ямтай хамтран нэн тэргүүнд хянан үзэх хэрэгтэй салбар, чиг үүргийг тодорхойлон тогтоох, үүнтэй холбогдсон хөтөлбөр, ажлын удирдамжийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх, уг ажлын явцыг хянах, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх болно.

6.3 Санхүү, эдийн засгийн ямны үүрэг

Санхүү, эдийн засгийн ямны гол үүрэг нь Засгийн газрын эдийн засаг, санхүү болон санхүү, төсвийн удирдлагын үндсэн чиг үүргийг гүйцэтгэхэд оршино. Санхүү, эдийн засгийн яам улсын эдийн засгийн үр нөлөө бүхий санхүү, төсвийн удирдлагын талаар бодлого боловсруулна. Санхүү, эдийн засгийн яам нь үндэсний эдийн засгийг чиглүүлэх өрөн хүрээтэй эдийн засгийн хариуцлага, улсын салбарын санхүүгийн менежмент хоёрыг хооронд нь нарийн зааглан салгаснаар Монгол Улсын санхүүгийн байдлыг бүхэлд нь нэлээд сайжруулж чадсан. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд улсын салбарын нийт бэлэн мөнгөний зарцуулалтад хатуу хяналт тогтоосон нь хамгийн шийдвэрлэх арга хэмжээ болсон. Тус яамны Төрийн сангийн газар Олон улсын валютын сангийн туслалцаа, хамтын ажиллагааны үр дүнд энэ амжилтанд хүрсэн. Засгийн газрын санхүүгийн статистикийн загварын

дагуу Засгийн газрын эхний аккруэл санхүүгийн тайланг 2002 оны 12-р сарын 31-ний байдлаар гаргасан бөгөөд энэ нь санхүүгийн тайлангаар дамжуулан хяналт сайжирсныг харуулав.

Санхүү, эдийн засгийн яам нь бүтээгдэхүүнд суурилсан санхүү, төсвийн удирдлагыг нэвтрүүлж, түүнтэй холбоотой шинэтгэлийг эрчимтэй урагшлуулан, төсвийн байгууллага аккруэл нягтлан бодох бүртгэлд шилжих Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд улсын салбарын бүх байгууллага нягтлан бодох, бүртгэлийнхээ тогтолцоог улам боловсронгуй болгож, төсөв боловсруулахад шаардлагатай бүтээгдэхүүний өртгийг зөв тооцож, улмаар байгууллагын менежмент сайжирна. Нягтлан бодох бүртгэлийг ийнхүү сайжруулснаар Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргах боломжтой болно.

Санхүү, эдийн засгийн яамыг хөгжүүлэх дараагийн шатанд Засгийн газарт тулгараад байгаа эдийн засаг, санхүүгийн асуудлын талаар цогц бодлого боловсруулах явдал юм. Энэхүү бодлого нь төсвийн бүтцийн алдагдлыг бууруулах, гадаадын тусламжаас хараат байдлыг арилгах, улсын хязгаарлагдмал нөөцийг хамгийн чухал чиглэл болох дэд бүтцийг хөгжүүлэх, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх, иргэдэд илүү чанартай төрийн үйлчилгээ хүргэхэд чиглүүлэх боломжийг Засгийн газарт олгох болно.

6.4 Зохицуулалт болон чадавхи буй болгох нь

Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам нь холбогдох ямдын оролцоотойгоор төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй бөгөөд энэ нь тэдний ажлын уялдаа холбоог үр нөлөөтэй болгож, чадавхийг нь бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэхэд Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Санхүү, эдийн засгийн яам дор дурдсан үүргийг тус тус гүйцэтгэнэ:

- Төрийн албаны зөвлөл нь төрийн нийт албыг хамарсан сургалт, төрийн албан хаагчийн чадавхийг бэхжүүлэх асуудлыг зохицуулж, өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлэгч байгууллагын үүргийг гүйцэтгэнэ.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь төрийн захиргааны төв байгууллагын оролцоотойгоор Засгийн газрын бодлогын төрүүлэх чиглэлийн болон төрийн албаны шинэтгэлийн зохицуулалтыг бүхэлд нь хариуцна. Үүнээс гадна чиг үүргийг өндөр түвшинд хянан үзэх тодорхой хариуцлага хүлээнэ. Санхүү, эдийн засгийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран эрхлэлт болон санхүү, төсөвтэй холбогдолтой асуудлыг Төрийн албаны зөвлөлийн саналыг авсны үндэсэн дээр Засгийн газарт оруулна.
- Санхүү, эдийн засгийн яам нь санхүү, төсвийн бодлогын асуудлаар Засгийн газарт зөвлөгөө өгсөн хэвээр байх бөгөөд төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнахтай холбогдолтой бүх үйл явцыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу удирдана.

Төрийн албаны зөвлөл болон Санхүү, эдийн засгийн яамны хувьд өөрсдийн үйл ажиллагаагаа зохицуулан сайжруулах нь нэн чухал байна.

Чадавхи буй болгох стратеги боловсруулан батлуулахад дээрх байгууллагын хамтын ажиллагаа нэн чухал болно. Төрийн албаны зөвлөл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Санхүү, эдийн засгийн яам болон Эрүүл мэндийн яам зэрэг холбогдох яам, агентлагтай зөвлөлдөн, олон улсын зөвлөхийн туслалцаатайгаар сургалтын хэрэгцээнд дүн шинжилгээ хийх асуудлыг хариуцна. Улмаар уг стратеги төслийн зардлын тооцоог Санхүү, эдийн засгийн яамтай зөвлөлдөн гаргаж, улсын төсвийн бодлогын хүрээнд Засгийн газарт оруулна. Тус сургалтын стратеги нь Засгийн газрын өргөн хүрээтэй шинэтгэлийн зорилттой нийцэж байх, түүнийг Засгийн газрын хуралдаанаар хугацаа алдалгүй оруулж хэлэлцүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцна.

Түүнчлэн цалин хөлсний шинэтгэлийн загвар гаргахад эдгээр байгууллага хамтран ажиллана. Ялангуяа энэ ажилд Төрийн албаны зөвлөлд шинээр бий болох албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн албаны цалин хөлс, урамшууллын талаар судалгаа хийж, санал боловсруулах, мэдээлэл өгөх үүрэг бүхий нэгж тодорхой үүрэгтэй оролцоно. Санхүү, эдийн засгийн яаманд боловсруулан хэрэглэх Цалингийн зардлыг судлан шинжлэх загварыг шинэчлэн баяжуулах суурь болох улсын хэмжээний хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх асуудлыг Төрийн албаны зөвлөл мөн хариуцна. Энэхүү дүн шинжилгээний хэрэгслийн үнэ цэнийг алдагдуулахгүй байхад Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн засгийн яам хоёрын хамтын ажиллагаа чухал байна.

Стратеги чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг зөвшөөрч эхлүүлэхэд дээрх байгуллага хамтран ажиллана. Ялангуяа салбарын түвшинд хийх чиг үүргийн шинжилгээг Засгийн газрын дээд түвшинд зөвшөөрч хийлгүүлснээр тэдгээрийг Засгийн газрын стратегийн төрүүлэх чиглэлд нийцүүлэх боломж бүрдэнэ. Энэ нь Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны чадавхи, боловсон хүчний болон санхүү, төсвийн нөөцийг нэмэгдүүлэх хэрэгцээг бий болгож байна.

Төрийн албаны шинэтгэлийн энэхүү стратегийн дагуу Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банк зэрэг хандивлагчдын дэмжлэгтэйгээр дараагийн гурван жилийн хугацаанд Төрийн албаны зөвлөл, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүү, эдийн засгийн яам, Эрүүл мэндийн яамны ажилтны ур чадварыг дээшлүүлнэ.

Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн засгийн яам хоёр үр нөлөөтэй түншлэлийг бий болгох эхний алхмыг хийгээд байна. Энэ хоёр байгууллагын үйл ажиллагаа хооронд нь зохицуулахыг санхүү, төсвийн бодит байдал шаардаж байна. Иймэ зохицуулалт байсан нөхцөлд л хүний нөөцийн бодлого, төсвийн төлөвлөлт, түүний зарцуулалт бодитой бөгөөд тогтвортой байж чадна. Үүний зэрэгцээ Төрийн албаны зөвлөл, Санхүү, эдийн засгийн яамны чадавхийг зохих түвшинд хүртэл бэхжүүлэх нь хүний нөөцийн бодлого, төсвийн төлөвлөлт, түүний зарцуулалтад тэдгээр байгууллагын ур нөлөөтэй хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулахад туйлын чухал байх болно.

Төрийн албаны чадавхийг бэхжүүлэхэд хандивлагчийн үзүүлж буй туслалцаат илүү сайн ур ашигтай зохицуулах шаардлага байгаа бөгөөд Санхүү, эдийн засгийн яам зөөл тусламжийг оролцуулан хандивлагчийн хөтөлбөрийн санхүүгийн асуудлыг зохицуулж байдагтай нэгэн адилаар төрийн захиргаат бэхжүүлэхээр төрийн албанд олгож буй техникийн туслалцаат улам сайн зохицуулах шаардлагатай байна.

Төсөл хэрэгжүүлэх олон нэгж (нэг байгууллагад олон нэгж байх нь олонтаа байна) байх нь зохицуулалтыг улам хүндрүүлдэг. Төсөл хэрэгжүүлэх тусгай нэгжийг байгууллж ажиллуулснаар төрийн албаны гол байгууллагын төслийн удирдлагын үр чадварыг хөгжүүлэхэд сергөөр нөлөөлөх ч магадлалтай. Төсөл хэрэгжүүлэх инэнх нэгжид ажилладаг мэргэжилтэн тухайн төсөл хэрэгжүүлэгч яам, агентлагийн өдөр тутмын үйл ажиллагаанд болон тэдгээрийн стратегийн шийдвэр гаргах үйл явцад төдийлөн оролцдоггүй /яам, агентлагийн үндсэн бус ажиллагчид/ хүмүүс байдаг. Төсөлд ажилжж буй үндэсний ажилтанд олгож байгаа цалин хөлс нь яам, агентлагийн ажиллагчдын тогтвор суурьшилтай ажиллахад нь сөрөг нөлөөтэй юм.

Иймээс Засгийн газар гол хандивлагчтай хамтран төсөл дэмжих өнөөгийн ажиллагаат хянан судалж, 6.1 дэх хэсэгт тодорхойлсоны дагуу Төрийн албаны зөвлөл өргөтгөсөн үүргийнхээ хүрээнд төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хандивлагчийн олгож буй тусламж, төрийн албаны сургалтыг зохицуулах үүргийг хүлээнэ.

7. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

7.1 Үйл ажиллагааны төлөвлөгөө

Стратеги зорилтын хүрээнд авах тодорхой арга хэмжээ болон хүлээх хариуцлага, стратеги зорилт нэг бүрийн үр дүнгийн гарцын шалгуур үзүүлэлт, түүнчлэн урт хугацааны гүйцэтгэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар батлан хэрэгжүүлэх болно.

7.2 Хэрэгжүүлэх хугацааны тэргүүлэх ач холбогдол

Стратегид туссан арга хэмжээг хэрэгжүүлэх дарааллыг зөв тогтоох нь чухал юм. Зарим арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байхад заримыг нь амжилттай хэрэгжүүлэхийн тулд бэлтгэл алхмыг хийх, ялангуяа сургалтын журам, нөхцөлийг боловсруулах шаардлага гарна. Зарим тохиолдолд тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг гаргахын тулд уг арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаог төсвийн үе шаттай уялдуулах хэрэгтэй болно.

Стратегид тусгагдсан арга хэмжээний дарааллыг тогтооходоо цаг хугацааны дараахь тэргүүлэх ач холбогдлыг харгалзан үзнэ:

1.Нийт цалингийн санг ур нөлөөтэй хуваарилан зохицуулахад шаардагдах санхүүгийн сахилга батыг анхаарах. Засгийн газраас дотоодын нийт бүтээгдэхүүнд цалингийн сангийн эзлэх хувийг аажмаар бууруулах шийдвэр гаргасан. Төрийн албаны ажил эрхлэлтийн чиг хандлагыг хянах, хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүй болгох, үүнтэй холбоотой дүн шинжилгээ хийх ур чадварыг хөгжүүлэх зэрэг асуудлаар Засгийн газарт зөвлөгөө өгөх, төрийн захиргааны төв байгууллагын чадавхийг цаг алдалгүй бэхжүүлэх

болно. Цалингийн зардлыг хянах загварыг цалингийн саналд үнэлгээ өгсөд ашиглана.

2.Зах зээлийн эдийн засагт нийцэхгүй буюу ач холбогдол багатай чиг үүргийн цар хүрээг хумих буюу зогсоох, төрийн үйлчилгээг хүргэхэд үр ашиг, үр нөлөөтэй болох нь тогтоогдсон механизмын хувилбарыг хөгжүүлэх зорилгоор чиг үүргийг хянан үзэх. Энэ суурь алхмыг хийхэд цаг хугацаа хэрэгтэй бөгөөд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж эхлэхээс өмнө үүнийг хийх хэрэгтэй. Монгол Улсын орчин үеийн зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, санхүү, төсвийн нөхцөлд төрийн болон төсвийн байгууллагад бүтцийн туушгай өөрчлөлт хийх буюу заримыг нь татан буулгах учраас чиг үүрэг нь тэргүүлэх ач холбогдолгүй байгууллага бизнесийн нарийвчилсан стратеги төлөвлөгөө хийх, тэдгээрт гүйцэтгэлийн менежментийн үр чадварыг бүй болгон хөгжүүлэх нь ямар ч ач холбогдолгүй юм. Үүнийг хийснээр тэргүүлэх чиглэлээр цалин хөлс, орон тооны асуудлыг шийдэхэд шаардлагатай төсвийн хэмнэлт гарах учир хянаж үзэх арга хэмжээг ань болох ойрын хугацаанд хэрэгжүүлэх хэрэгтэй.

3.Орцод тавих төвлөрсөн хяналтыг гүйцэтгэлийн менежмент болон байгууллагын нөөцийн менежментийн чадавхийг хөгжүүлэхтэй уялдуулан шилжүүлэх. Гүйцэтгэлийн үр нөлөөтэй шалгуур үзүүлэлт, үр дүнгийн гэрээ боловсруулах болон нөөцийн удирдлагын үр чадварыг хөгжүүлж буй өнөөгийн хурдац байгууллага тус бүрт өөр өөр байна. Шинэтгэл хийх санаачлагыг бууруулахгүй, эхний амжилтын давуу талыг ашиглахад эдгээр шаардлагыг үр нөлөөтэй, шуурхай биелүүлж байгаа байгууллагыг (хүлээн зөвшөөрч, менежментийн уян хатан эрх олох зэргээр) шагнаж урамшуулах нь чухал. Түүнчлэн гүйцэтгэлийн үр нөлөөтэй удирдах чадавхитай болж амжаагүй байгууллагад эрх мэдлийг шилжүүлэх үйл явцыг үе шаттай хэрэгжүүлэх болно. Иймээс Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шат дараалсан хандлагыг нэвтрүүлж, улмаар үр дүнгийн гэрээний хүрээнд удирдлагын шийдвэр гаргах илүү уян хатан эрх мэдэл эдлэх "шилдэг туршлагатай" болон "дунд зэргийн туршлагатай" байгууллага хэмээн ангилан авч үздэг болно.

4.Төсвийн бүх байгууллагын ерөнхий менежер төрийн албаны болон санхүүгийн менежментийн шинэтгэлийг ойлгодог, түүнийг хэрэгжүүлэх ур чадварыг аль болох ойрын хугацаанд хэзмихс. Ерөнхий менежерийг сонгон шалгаруулах шинэ жүрмыг мөрдөх, ерөнхий менежерт зориулсан Төрийн албаны манлайллын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.Ерөнхий менежерийг дэмжин ажиллах ажилтанд нэн тэргүүний шаардлагатай, ялангуяа бодлого болон эрсдэлд дүн шинжилгээ хийх, хүний нөөцийн удирдлага болон мэдээллийн технологийг ашиглах ур чадвар ээзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх. Эхний ээлжинд дунд шатны менежер болон шинжээч нарын сургалтын хэрэгцээг хангаж байх явцад Төрийн албаны зөвлөлөөс төрийн бүх байгууллагын сургалтын нийт хэрэгцээнд үнэлгээ өгөх болно.

6.Удирдах албан тушаалтныг томилох буюу тогтвортой ажиллуулахад шаардлагатай ур чадварыг бүрдүүлэх. Цалингийн нягтралын зөв харьцаат бий болгох, цалинг гүйцэтгэлийн үр дүнтэй нягт уялдуулахад гол анхаарлаа хандуулна. Ажлын гүйцэтгэлийн хангалттай үзүүлэлттэй буюу нээлттэй, өрсөлдөөний зарчмаар сонгогдон томилогдсон албан тушаалтны цалинг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.

7.Төрийн албаны цалин, нэмэгдэл, түүнтэй адилтгах бусад орлогыг улам ил тод болгож, гүйцэтгэлтэй үр нөлөөтэйгээр холбох. Энэ нь Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлэх цалин хөлсний өргөн хүрээтэй шинэтгэлийн эхний алхам болно. Хоёр дахь үе шатанд ангилал, зэрэглэл тус бүрийн цалингийн боломжит хязгаарыг нэмэгдүүлэх, ихэнх нэмэгдэл (ажлын гүйцэтгэлийн нэмэгдлээс бусад)-ийг инфляцийн түвшинтэй дүйцүүлэн нэмэхгүй байх, тэдгээрийг шинээр томилогдсон хүмүүст (албан тушаал дэвшигчийг оролцуулан) олгохыг зогсоох, өөрөөр хэлбэл нэмэгдлийг үндсэн цалинд оруулах, гүйцэтгэлийн бонусыг нэмэгдүүлэх болно.

8. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Баримт бичигт тусгагдсан стратегийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрнэ:

- Төрийн албаны ажил эрхлэлтэд тавих хяналт сайжрах ба төсвийн байгууллагын нөөцийн менежментийн үр чадвар бэхжих, санхүүгийн сахилга батыг чанд сахидаг болно. Ингэснээр төсвийн байгууллагын төсвийн хэтрэлт арилж, жилийн төсөв болон дунд хугацааны төсвийн хүрээнд тусгагдсан цалингийн бодлого хоорондоо бүрэн нийцэж, гагцхүү тодорхой нөхцөлийн улмаас гарах зарим зөрүү зэргээр илрэлээ олдог болно.
- Салбарууды бүхэлд нь хамруулсан болон тухайн чиг үүргийг стратегийн хэмжээнд хянан үзсэнээр төрийн албаны үйл ажиллагаа улам илүү тодорхой үйлчилгээнд чиглэдэх болно. Үүний гол зорилго бол төрийн албаны хэмжээг

бууруулахад бус, харин төрийн гүйцэтгэх үүргийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцүүлэн зохистой болгоход төвлөрч, төрийн үйлчилгээг хүргэх хамгийн үр ашиг бүхий механизмыг сонгон ашиглахад оршино. Гэхдээ төрийн албаны ажил эрхлэлт буурч, тесвийн цэвэр хэмнэлт гарах нь үр дүнгийн чухал шалгуур үзүүлэлт байх болно.

Үр нөлөөтэй стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ болон бодлогын дүн шинжилгээ зэрэг менежментийн практик арга барилыг төрийн нийт албаны хэмжээнд сайжруулснаар төрийн болон төсвийн байгууллагаас хүргэх үйлчилгээний үр ашиг, үр нөлөө улам дээшилнэ. Үүний үр дүнд нөөцийн хуваарилалт улам уян хатан болж, Засгийн газар хомс нөөцөө ядуурлыг бууруулах зэрэг тэргүүлэх чиглэлд зориулан зарцуулах боломжтой болно. Шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх үйл явцын хүрээнд төрийн болон төсвийн олон байгууллага "шилдэг туршлагатай" байгууллагын ангилалд хамаарах болно.

Ажлын гүйцэтгэлтэй уялдсан урамшуллын илүү ил тод журам, дүрэм зэрэг хүний нөөцийн удирдлагын дэвшилтэт арга техник нэвтрүүлснээр төрийн албаны ажил эрхлэлтийн практик арга барил сайжирч, улмаар бэлтгэгдсэн гол боловсон хүчин төрийн албанаас гарах нь багасч, Засгийн газраас ур чадвартай хүмүүсийг бэлтгэхэд оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах болно. Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн харьцаа /нягтрал/-г дараагийн гурван жилийн хугацаанд ажлын хариуцлага, ачаалалтай уялдуулж зөв зохистой болгоно.

Төрийн албаны ерөнхий менежерт тусгайлан зориулсан сургалт нь төрийн байгууллагад ажиллагчдын мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлж, төрийн албаны мэргэшсэн байдлыг сайжруулж, гүйцэтгэлийн өндөр түвшинг хангах болно.

Төрийн албаны менежментийг засаглал болон эрсдлийн менежментийн зарчимд төвлөрүүлснээр дотоодын хяналт хангалттүйгээс үүдэлтэй нөөц бууруу зарцуулах эрсдэл буурна.

Төрийн албаны зөвлөл нь гол төлөв зохицуулах үүрэг бүхий байгууллагаас бодлогод суурилсан, үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн, төрийн албанд менежментийн арга техникийг сайжруулах, Төрийн албаны тухай хууль болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг үүрэг бүхий байгууллага болж өөрчлөгдөнө. Үр дүнгийн нэг гол шалгуур үзүүлэлт нь төсвийн байгууллагын ерөнхий менежерийн эргэх холбоо байх болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр | **Дугаар 25** | **Улаанбаатар хот**

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль батлагдсантай холбогдуулан 2004 оны 12 дугаар сарын 1-ний дотор дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль заасан "Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм", "Пиротехникийн хэрэгслийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж, батлах;

2/Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасан холбогдох стандартыг гаргаж мөрдүүлэх;

3/тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн улсын хэмжээний тооллогыг явуулж, дүнг тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн санд оруулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Д.Лүндээжанцан/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (355)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Үндэсний Их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны зургаадугаар сарын 7 №22 (355)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

263. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 516

264. Үндэсний Их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 517

265. Үндэсний Их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 518

266. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай 518

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

267. Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэх тухай Дугаар 26 518

268. Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 27 518

269. Монгол Улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай Дугаар 28 519

270. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 29 519

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

271. Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай Дугаар 83 524

272. Удо Хаазег "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 86 525

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

273. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлах тухай Дугаар 84 525

274. Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай Дугаар 85 530

275. Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан байгуулах тухай Дугаар 86 532

276. Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 87 534

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэр:

"Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлэх, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд саналаа оруулж, үг хэлж болно."

2/ 14^1 дүгээр зүйл.

"14^1 дүгээр зүйл. Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл, түүний чиг үүрэг

14^1.1. Улсын Их Хурлын даргын дэргэд дор дурдсан бүрэлдэхүүнтэй Зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана:

14^1.1.1. Улсын Их Хурлын дэд дарга;

14^1.1.2. Байгын хорооны дарга;

14^1.1.3. нам, эвслийн бүлгийн ахлагч.

14^1.2. Зөвлөл дараахь чиг үүрэгтэй:

14^1.2.1. Улсын Их Хурлын чуулганаар долоо хоногийн хэлэлцэх асуудлыг зөвшилцөх;

14^1.2.2. шаардлагатай тохиолдолд нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад ажлын өдөр хуралдах Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны хуваарийг тогтоох;

14^1.2.3.Байгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдааны хуваарь тогтоох;

14^1.2.4. Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудал.

14^1.3. Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно."

3/ 16 дугаар зүйлийн 3,4,5 дахь хэсэг:

"16.3. Байгын болон дэд хороо дүрэмтэй байна. Байгын хорооны үлгэрчилсэн дүрмийг Улсын Их Хурал батална.

16.4. Улсын Их Хурлын Тамгын газрын төсөвт Байгын хорооны ажлын албаны үйл ажиллагааны зардлыг тусгайлан тусгана.

16.5. Байгын хороо тогтоосон журмаар үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ."

4/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"15.1.4. хуралдааны явцад ёс зүйн зөрчил гаргасан гэж үзвэл тухайн гишүүний талаар Ёс зүйн дэд хороонд санал тавих."

5/ 15^1 дүгээр зүйл. Хуралдааны дэг сахиулагч

"15^1.1. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байгын хорооны хуралдааны танхимд хуралдааныг тасралтгүй явуулах, хэвийн ажиллагаг хангах үүднээс хуралдааны дэг сахиулагч ажиллана.

15^1.2. Хуралдааны дэг сахиулагч нь албаны хувцас, тусгай таних тэмдэгтэй байна. Албаны хувцас, тусгай таних тэмдгийн загварыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

15^1.3.Хуралдааны дэг сахиулагч нь дараахь эрх, үүрэгтэй байна:

15^1.3.1.хуралдааны танхимд журам сахиулах;

15^1.3.2.хуралдаан даргалагчийн зүгээс дэг сахиулах талаар өгсөн үүргийг хэрэгжүүлэх;

15^1.3.3. гишүүнд энэ хуулийн 15.1.3-т заасан арга хэмжээ авах тохиолдолд шаардлагатай бол биед нь гэмтэл учруулахгүйгээр хуралдааны танхимаас гаргах."

6/ 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"34.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурлын ерөнхий менежерийн хувьд холбогдох Байгын хорооны даргын саналыг харгалзан Байгын хорооны ажлын албаны ажилтанг томилж, чөлөөлнө."

7/ 36 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"36.2. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно."

36.3. Тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр, бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно."

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14.6-ын "Улсын Их Хурлын даргад" гэсний дараа "урьдчилан"; мөн хуулийн 16.1, 17.1.1-17.1.3, 17.1.6, 17.1.7, 17.1.9, 18.3, 19.3, 19.5, 22.1.1, 32.1.15-ын "дүгнэлт" гэсний өмнө "санал"; 26.2.2-ын "чуулганаар" гэсний өмнө "нам, эвслийн бүлэг, Байгаын хорооднын саналыг харгалзан" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараахь зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"8.5. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн Пүрэв гариг, Баасан гаригийн үдээс хойш хуралдуулахаар зохион байгуулна. Шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад ажлын өдөр зохион байгуулж болно."

2/ 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

"14.7. Улсын төсөв, дараа жилийн төсвийн хүрээниймэдэгдэл болон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой чухал асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх явцад Байгаын хороод санал, дүгнэлтээ бэлтгэхэд тодорхой хугацаа шаардагдах, соңсогчдоос санал авах, түүнчлэн тухайн үеийн нөхцөл байдлын улмаас зайлшгүй шаардлага гарвал Байгаын хорооны болон нам, эвслийн бүлгийн саналыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 7-14 хоногийн хугацаагаар түр завсарлуулж болно."

3/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"15.1.3. хуралдааны дэгийг удаа дараа зөрчсөн, хуралдааныг хэвийн явуулахад саад болж байгаа тохиолдолд урьдчилан сануулахгүйгээр чуулганы хуралдаанаас гаргана."

4/ 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"28.3. Байгаын хорооны дарга хорооныхоо өдөр тутмын ажлыг удирдаж, хуралдааныг даргална. Байгаын хорооны дарга 7-гоос дээш хоногийн хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх, дотоод, гадаадад томилолтоор ажиллах зэргээр эзгүй байх хугацаанд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон нэг гишүүн үүргийг нь түр орлон гүйцэтгэнэ."

5/ 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэр:

"Улсын Их Хурлын Тамгын газрын ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө."

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26.2.1-ийн "ээлжит болон ээлжит бус" гэснийг "ээлжит, ээлжит бус болон хүндэтгэлийн" гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.1.8-ыг хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 16.3-ыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын баяр наадамд 6 давсан бөхөд улсын харцага, 8 давсан бөхөд улсын гарьд цолыг тус тус олгоно.

2 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улс, аймаг, сумын цолыг нэхэн олгохгүй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараахь агуулгатай 5 дахь заалт нэмсүгэй.

"5/ Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 11.3-т заасан үндэслэл бий болсон бол."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийг дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 26** **Улаанбаатар хот**

Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэх тухай

Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Алтай сумын төвийг "Боомын ам"-нд нүүлгэн шилжүүлсүгэй.

2. Ховд аймгийн Алтай сумын төвийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 27** **Улаанбаатар хот**

Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 15.1.5, 15.1.6-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана." гэсэн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээнийүндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 2/01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

Монгол Улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийг дор дурдсан үзүүлэлт, хувь хэмжээгээр зөвшөөрсүгэй:

1. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн доод хэмжээ, хувь 6.0

2. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлтийн дээд хэмжээ, хувь 5.0

/ДНБ-д эзлэх хувиар/

3. Төсвийн нийт орлогын доод хэмжээ 41.4

4. Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 46.0

5. Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ 7.1

6. Төсвийн алдагдлын дээд хэмжээ -4.6

7. Хөрөнгө оруулалтын зардлын дээд хэмжээ 5.9

8. Төсөвт байгууллагад ажиллагчдын цалингийн нийт сангийн дээд хэмжээ 8.2

Хоёр. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын 2005 оны төсвийн төслийг боловсруулахдаа эдгээр үзүүлэлтүүдийг баримтлахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Н.Баярцайхан/, Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/ -нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр | Дугаар 29 | Улаанбаатар хот

"Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг."Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-д дараахь заалт нэмсүгэй:

1/ 1.3.5 дахь заалт:

"1.3.5.үг хэлэх, тайлбар хийхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг үг хэлж байхад яриаг таслах, өмнөөс нь үг хэлэх, санал өгөх, дороомжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, хувийн шинж чанартай үндэслэл гаргах, өөрийн саналыг дэмжүүлэх, эсхүл бусдын саналыг няцаах зорилгоор тэднийг албадах, шахалт үзүүлэхийг хоригломо."

2/ 1.12 дахь заалтын 3 дахь өгүүлбэр:

"Тайлбар өгөөгүй бол хуралдаан тасалсанд тооцно."

3/ Арван нэг[1]:

"**Арван нэг[1]. Зөвсэгт хүчний жанжин штабын даргыг Ерөнхийлөгч томилохдоо Улсын Их Хуралтай зөвшилцөх**

11[1].1. Зөвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна.

11[1].2. Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн санал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцаад Зөвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох асуудлаар ил санал хураалт явуулж, дүнг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ."

4/ Арван нэг[2]:

"**Арван нэг[2]. Улсын Их Хурлаас байгууллагдсан байгууллагын албан тушаалтныг томилох, чөлөөлөх**

11[2].1. Улсын Их Хурлаас байгууллагдсан байгууллагын бүрэлдэхүүн, удирдах албан тушаалтныг эрх бүхий эгтээдээс санал болгосны дагуу Улсын Их Хурлаас томилох, чөлөөлөх асуудлыг холбогдох Байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна. Улсын Их Хурлын гишүүд тухайн албан тушаалд нэр дэвшигчид асуулт тавьж, хариулт авч болно.

11[2].2. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, санал дүгнэлт гаргасны дараа тухайн албан тушаалд нэр дэвшигчийг томилох, албан

тушаалтныг чөлөөлөх тухай асуудлаар тус бүрт нь ил санал хураалт явуулна. Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын бүрэлдэхүүнийг томилохдоо хүн тус бүрээр ил санал хураалт явуулна.

Дээрх асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална."

5/ Арван хоёр[1]:

"Арван хоёр[1]. Засгийн газрын тайланг хэлэлцэх

12[1].1.Засгийн газар нь үйл ажиллагааныхаа тайланг хаврын чуулганы эхэнд Улсын Их Хуралд иргүүлнэ.

12[1].2.Засгийн газрын үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд танилцуулах бөгөөд Засгийн газрын гишүүд байлцана. Тайлантай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч болно.

12[1].3.Байгаль орчны төлөв байдлын тайланг хэлэлцэхдээ энэ дэгийн 12[2].2, 12[2].3 дахь заалтыг баримтална."

6/ Арван хоёр[2]:

"Арван хоёр[2]. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын тайланг хэлэлцэх

12[2].1.Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагууд нь үйл ажиллагааныхаа тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан гишүүдийн тоогоор Улсын Их Хуралд иргүүлнэ.

12[2].2.Зохих Байнгын хороо хуралдаанаараа холбогдох тайланг урьдчилан хэлэлцэх бөгөөд хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуулт, хариулт явуулж, гишүүд санал, дүгнэлт гаргаж болно. Шаардлагатай гэж үзвэл тухайн Байнгын хороо уг асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна.

12[2].3.Тайланг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдийн саналаар уг байгууллага, холбогдох албан тушаалтанд ажил сайжруулах, тодорхой асуудалд анхаарах талаар үүрэг даалгавар өгч Байнгын хорооноос эсхүл Улсын Их Хурлаас тогтоол гаргаж болно.

7/ Арван хоёр[3]:

"Арван хоёр[3]. Улсын ерөнхий прокурорын мэдээлэл сонсох

12[3].1.Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно.

12[3].2.Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно.

8/ Арван хоёр[4]

"Арван хоёр[4]. Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл сонсох

12[4].1.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд илтгэнэ.

12[4].2.Илтгэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно."

9/ Арван хоёр[5]

"Арван хоёр[5]. Улсын Их Хурлын Тамгын газрын тайланг хэлэлцэх

12[5].1.Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулна.

12[5].2.Тайлантай холбогдуулан Байнгын хорооны гишүүд асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно.

10/ Арван хоёр[6]

"Арван хоёр[6]. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаар Улсын Их Хурал олон нийтэд мэдээлэх

12[6].1.Засгийн газар Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээллийг Улсын Их Хуралд иргүүлнэ.

12[6].2.Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээллийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд танилцуулна. Уг мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч болно.

12[6].3.Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаархи мэдээлэлтэй танилцсаны дараа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан улсын эдийн засгийн гол үзүүлэлт, Улсын Их Хурлын сонгуульд болох оны жилийн эцсийн санхүүгийн төлөв, санхүүгийн төлөвт тусгагдаагүй боловч Засгийн газрын урьд гаргасан шийдвэрийн улмаас гарч болзошгүй ер төлбөр, нэмэлт зардал, орлогын дутагдлын талаархи төсвийн эрсдэл, төсвийн болон эдийн засгийн төлөвт нөлөөлөх болох бусад хүчин зүйлийн талаар Улсын Их Хурлын дарга мэдээлнэ."

11/ Арван гурав[1]

"Арван гурав[1]. Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын талаар мэдээлэх

13[1].1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32.1.11-д заасны дагуу Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын талаар холбогдох Байнгын хороонд, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга мэдээлнэ.

13[1].2.Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч болно."

12/ 14.2-ын 5 дахь өгүүлбэр:

"Хэрэв Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт нь тухайн асуудлыг хариуцаж байсан Байнгын хорооны санал, дүгнэлттэй санал нэгдээгүй тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд зохих Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна."

13/ 15.1.4 дэх заалтын 2 дахь өгүүлбэр:

"Хэрэв Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт нь тухайн асуудлыг хариуцаж байсан зохих Байнгын хорооны санал, дүгнэлттэй нэгдээгүй тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны саналаар эхэлж санал хураана. Энэ санал нь олонхийн санал авч чадаагүй бол зохих Байнгын хорооны санал дэмжигдсэнд тооцно."

14/ 15.2 дахь заалт:

"15.2.Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь хэсэгт заасан асуудлаар Үндсэн хуульд нийцэж байна гэж Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл цэцийн ажлын нэг гишүүн танилцуулж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно. Уг асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахгүй."

15/ 15.3-ын 4 дэх өгүүлбэр:

"Тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байхгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний эзгүйд цэцийн аль нэг гишүүн танилцуулж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсоно. Уг асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахгүй."

16/ 20.5 дахь заалт:

"20.5.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн дараа жилийн улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тогтоосон төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхэд доорхи жүрмыг баримтална:

1/төсвийн хүрээний мэдэгдлийг нам, эвслийн бүлэг, Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газрын дунд хугацааны зорилтууд, тухайн жилд Монгол Улсын төсвийн урсгал зардал, орлогын хэмжээ, хөрөнгө оруулалт, нийт болон урсгал тэнцэл, төлөвлөсөн баланс, мөнгөн гүйлгээ зэрэг макро эдийн засгийн үндэсэн үзүүлэлтээр тооцоо, танилцуулгыг төсвийн ерөнхийлөн захирагч нэг бүрээр гаргуулан авч хэлэлцэнэ. Шаардлагатай бол ажлын хэсэг байгуулан ажиллуулж Байнгын хорооны санал, дүгнэлт бэлтгэнэ.

Нэг дэх хэлэлцүүлгээр: төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагчдыг байцүүлан асуулт хариулт явуулж, санал дүгнэлт гаргана. Төсвийн хүрээний мэдэгдлийн талаар Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, санал, дүгнэлт гаргасны дараа Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

Хоёр дахь хэлэлцүүлгээр: төсвийн хүрээний мэдэгдлийн талаар Улсын Их Хурлын Байнгын хороод, нам, эвслийн бүлэг олонхийн дэмжлэг авсан саналаа нэгтгэн, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд ирүүлнэ. Төсвийн байнгын хороо эдгээр саналыг нэгтгэн, нягтлан үзэж хороонхоо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг нэгтгэн дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна.

Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлт болон Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг тус тус Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсгоно. Төсвийн байнгын хорооны олонхийн дэмжлэг авсан саналаар санал хураалт явуулж гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

Гурав дахь хэлэлцүүлгээр: Төсвийн байнгын хороо олонхийн дэмжлэг авсан саналыг төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусган танилцуулгын хамт Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оруулна. Төсвийн хүрээний мэдэгдлийг санал хураалт явуулж шийдвэрлэнэ."

17/ Хорин хоёр[1]:

"Хорин хоёр[1]. Нээлттэй сонсох

22[1].1.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх тодорхой төслийн талаар эрдэмтэд, шинжээчид, мэргэжлийн байгууллагын болон сонирхлын бүлгийн хүмүүсээс санал сонсох, мэдээлэл авах зорилгоор нээлттэй сонсож болно.

22[1].2.Тухайн Байнгын хорооны дарга нээлттэй сонсох төслийн сэдэв, өдөр, цагийг 1 сарын өмнө Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн товлож, нийтэд зарлана.

22[1].3.Нээлтгэй сонсох үйл ажиллагаанд оролцох хүмүүсээс санал, мэдээллийг урьдчилан авч Байгүйн хорооны гишүүдэд 3-аас доошгүй хоногийн өмнө тараасан байна.

22[1].4.Байгүйн хорооны хуралдаанд асуудлыг нээлттэй сонсох үйл ажиллагаанд оролцогчдод санал, мэдээлэлтэй нь холбогдуулж Байгүйн хорооны гишүүд асуулт тавьж, хариулт авч болно.

22[1].5.Нээлттэй сонсох үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг Байгүйн хороо, Тамгын газар хариуцна."

18/ 23.3.2-ын 2 дахь өгүүлбэр:

"Санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч болно."

19/ 23.4-ийн 3 дахь өгүүлбэр:

"Чуулганаар хэлэлцэхээр тогтсон төсөл гэдгийг тухайн эзлэхит чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгасан асуудлыг ойлгоно."

20/ 23.7-ийн "а" заалтын 2 дахь өгүүлбэр:

"Энэ тохиолдолд санал хураалт явуулахгүй бөгөөд зохих Байгүйн хороонд шилжүүлж байгааг зарлана;"

21/ 23.12.3-ын "г" заалт:

"г/ энэ дэгийн 22.11-д заасан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг зохих Байгүйн хорооны саналаар санал хураалт явуулж, анхны хэлэлцүүлгээр батална. Зохих Байгүйн хорооны санал дэмжигдээгүй бол уг асуудлаарх анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн Байгүйн хорооны зарчмын зөрүүтэй саналаар энэ дэгийн 23.12.3-ын "в"-д заасан үндэслэлээр дахин санал хураж шийдвэрлэнэ. "

Хоёр."Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 1.1-ийн "хуралдааны" гэсний өмнө "чуулганы"; 15.5-ын "дүгнэлтийг" гэсний дараа "Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний эзгүйд орлож байгаа цэцийн аль нэг гишүүн танилцуулж,"; 20.2-ын "Хоёр дахь хэлэлцүүлгээр" гэсэн хэсгийн 3 дахь өгүүлбэрийн "Төсвийн зарлагын" гэсний дараа "хяналтын" гэж тус тус нэмсүгэй.

Гурав."Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1.6 дахь заалт:

"1.6.Улсын Их Хурлын өглөөний нэгдсэн хуралдаан 9.00 цагаас, үдээс хойшхи нэгдсэн хуралдаан 15.00 цагаас эхэлнэ."

2/ 1.8 дахь заалт:

"1.8.Улсын Их Хурал долоо хоног бүрийн Баасан гаригийг 15.00 цагаас Засгийн газрын мэдээлэл, Засгийн газарт тавьсан асуулгын хариуг сонсоно."

3/ 7.2 дахь заалтын 2 дахь өгүүлбэр:

"Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдохоор нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал санал хураахгүй бөгөөд асуулт тавьж, хариулт авч болно.

4/ 12.2 дахь заалт:

"12.2.Ерөнхийлөгч ажлын тайлангаа жил бүр Улсын Их Хуралд ируулж, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсгоно. Тайлантай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж болно."

5/ 14.3 дахь заалт:

"14.3.Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг 14 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж, энэ талаар тогтоол батална.

6/ 15.1 дэх заалт:

"15.1.Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлаар Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:"

7/ 19.3 дахь заалт:

"19.3.Улсын Их Хурлын гишүүн асуултын хариуг бичгээр авсны дараагаар уг хариуг Байгүйн хорооны хуралдаанд сонсох эсэх, хэзээ сонсох тухай саналаа Байгүйн хорооны даргад бичгээр ирүүлнэ. Асуултын хариуг Байгүйн хорооны хуралдаанд сонсох өдөр, цагийг Байгүйн хорооны дарга шийдвэрлэнэ."

8/ 19.5 дахь заалт:

"19.5.Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүнээс бусад гишүүн хуралдаан даргалагчийн зөвшөөрснийг дагуу асуултын хариутай холбогдуулж тухайн асуултын сэдвээр Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын холбогдох албан тушаалтанд тодруулан асуулт тавьж болно."

9/ 19.7 дахь заалт:

"19.7.Асуулга тавсан Улсын Их Хурлын гишүүн, Байгүйн хороо, нам, эвслийн бүлэг асуулгынхаа хариуг бичгээр авсны дараа уг хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд сонсох эсэх, хэзээ сонсох тухай саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлнэ. Асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар сонсох өдөр, цагийг Улсын Их Хурлын дарга шийдвэрлэнэ."

10/ 19.8-ын 3 дахь өгүүлбэр:

"Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гадна Улсын Их Хурлын бусад гишүүн хуралдаан даргалагчийн эзвшээрсний дагуу асуулгын хариутай холбогдуулж тухайн асуулгын сэдвээр Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнагдаг байгууллагын холбогдох албан тушаалтанд тодруулан асуулт тавьж болно."

11/ 20.2-ын "Хоёр дахь хэлэлцүүлгээр" гэсэн хэсгийн 5 дахь өгүүлбэр:

"Гаргасан саналаар энэ дэгийн 23.5-д заасан журмын дагуу санал хураалт явуулж, улсын төсвийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр зохих Байнгын хорооныд шилжүүлнэ."

12/ 21.2 дахь заалт:

"21.2.Төслийн цар хүрээ, боловсруулах ажлын хэмжээ, шаардлагыг харгалзан Байнгын хорооноор хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэх, эсхүл анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Ажлын хэсгийн гишүүдийн зонхилох хувь нь Улсын Их Хурлын гишүүд байна.

Ажлын хэсэг нь дараахь чиг үүрэгтэйгээр ажиллана:

1/хуралдаанаараа тухайн төслийг хэлэлцэн, үзэл баримтлалын чанартай асуудлыг нарийвчлан тодруулах үүднээс холбогдох байгууллагаас мэдээлэл, судалгаа гаргуулан авах, дүн шинжилгээ хийх;

3/тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулж зохих Байнгын хорооны хуралдаанд оруулах."

Улсын Их Хурлын чуулганаар тухайн асуудлыг хэлэлцэхэд түүнийг хариуцаж байгаа Байнгын хороо, Тамгын газрын ажилтнууд оролцоно. Мэдээлэл авах үүднээс Монгол Улсын сайд, дэд сайд, газар, хэлтсийн дарга, холбогдох бусад хүмүүсийг байлцуулж болно.

13/ 21.3 дахь заалт:

"21.3.Хууль санаачлагч нь хэлэлцүүлгийн аль ч шатанд төслөө татан авч болно. Энэ тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлнэ. Уг хүсэлтийг хуралдаан даргалагч Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд албан ёсоор танилцуулснаар төслөө татан авсанд тооцно."

14/ 22.7-ийн 3 дахь өгүүлбэр:

"Байнгын хороо зарчмын зөрүүтэй санал гаргаагүй, гишүүд санал нэгдсэн тохиолдолд төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн дүгнэлтээ анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн дүгнэлттэй хамтатган гаргаж болно."

15/ 22.11 дэх заалт:

"22.11.Төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдвөл Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуулыд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол холбогдох Байнгын хорооогоор заавал хэлэлцүүлнэ. Төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлтээ зохих Байнгын хорооны танилцуулгад тусгуулах буюу, эсхүл Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулна."

16/ 23.12.5-ын 3 дахь өгүүлбэр:

"Хэрэв төслийг бүхэлд нь батлах саналыг гишүүдийн олонхи дэмжээгүй бол уг төслийг хууль санаачлагчид нь бүцаах тогтоол батална."

Дерев. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 1.9-ийн "гишүүдийн олонхийн" гэснийг "Улсын Их Хурлын дарга, Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн"; "Хорь"-ийн гарчигийн, 20.1-20.3 дахь заалтын "төвлөрсөн төсөв" гэснийг "төсөв"; 20.2-ын "ерөнхийлөн захирагчид" гэснийг "ерөнхийлөн захирагчдыг"; 15.3-ын "15.2-т" гэснийг "15.3-т"; "14.6" гэсэн дугаарыг "14.5"; "15.2, 15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7" гэсэн дугаарыг "15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.8"; 23.5.4-ийн "Тамгын газар" гэснийг "Байнгын хороо"; 23.7-ийн эхний өгүүлбэрийн "санал хураах шийдвэрлэнэ." гэснийг "гаргана." гэж тус тус өөрчилсүгэй.

Тав. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 1.11.8-ын "шийдвэрлэх", 19.2-ын "амаар болон" гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Зургаа. "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг"-ийн 14.5 дахь заалт, 20.2-ын "нэг дэх хэлэлцүүлгээр" гэсэн хэсгийн "төвлөрүүлэн захирагчдыг" гэснийг, мөн 26.6 дахь заалтыг тус тус хассугай.

Долоо. Энэ тогтоолыг 2004 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 83** **Улаанбаатар хот**

Цэргийн дүрэмт хувцасны зарим загварыг батлах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Зэвсэгт хүчний офицер, ахлагч, Нэгдсэн Үндэсний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн бие бүрэлдэхүүний дугуй малгай болон нарнаас хамгаалах бүрх малгайн загварыг хавсралтаар батлалсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 180 дугаар зарлигаар батлагдсан "Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварын нэр, код" -ын төгсгөлд "26. Дугуй малгай /загварын код/ 1-16" , "27. Нарнаас хамгаалах, өнгөлөн далдлалтын бүрх малгай / загварын код / 1-17" гэсэн нэмэлт оруулсугай.

3. "Цэргийн хувцасны загварыг батлах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан 27, 36, 43, 47, 53, 56, 61, 66, 71, 77, 82, 91, 95, 103, 112, 117, 123, 127, 133, 136, 146, 150, 154, 190б, 199, 200, 204а, 225, 230, 235, 260, 261, 267, 279, 329, 334, 346 дугаар загварыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 05 дугаар сарын 20-ныөдрийн 83 дугаар зарлигийн хавсралт

Дугуй малгай



Загварын код 1-16

НАРНААС ХАМГААЛАХ, ӨНГӨЛӨН ДАЛДЛАЛТЫН БҮРХ МАЛГАЙ



Загварын код 1-17

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 21-ний өдөр | **Дугаар 86** | **Улаанбаатар хот**

Удо Хаазег "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, монгол орныг өөрийн оронд сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын Дааме Шпревальд мужийн Шөнефельд дүүргийн Засаг захиргааны дарга Удо Хаазег "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр | **Дугаар 84** | **Улаанбаатар хот**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2004 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр 1 дүгээр хавсралт, улсын төсвийн болон замын сангийн хөрөнгөөр 2004 онд хэрэгжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлалсугай.

2. Шинээр эхлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь батлагдсаны дараа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, барилга байгууламж, төсөл, арга хэмжээний эхлэх гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дүнд нь багтаан шаардлагатай бол зохицуулалт хийж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2004 оны 84 дүгээр тогтоолын 1-р хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2004 оны жагсаалт (Төсвийн эрх захирагчаар)

(сая төг)

д.д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт ертөг	Үүнээс 2004 онд санхүүжих
А	Б	1	2	3
I	**Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга**		**350.0**	**350.0**
1	УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад орон сууц худалдан авах, Улаанбаатар.	2002-2004	250.0	250.0
2	Тоног төхөөрөмж	2004-2004	100.0	100.0
II	**Монгол Улсын Ерөнхий сайд**		**635.5**	**635.5**
II.1	Тагнуулын ерөнхий газар		191.8	191.8
1	Конторын барилга, 12 хүн, 2 машины гараацуй, Говь-Алтай	2004-2004	65.0	65.0
2	Их засвар	2004-2004	26.8	26.8
3	Тоног төхөөрөмж	2004-2004	100.0	100.0
II.2	Төрийн тусгай хамгаалалтын газар		88.2	88.2
1	Тоног төхөөрөмж	2004-2004	88.2	88.2
II.3	Улсын мэргэжлийн хяналтын газар		100.0	100.0
1	Тоног төхөөрөмж	2004-2004	100.0	100.0
II.4	"МОНЦАМЭ" агентлаг		30.0	30.0
1	Тоног төхөөрөмж	2004-2004	30.0	30.0
II.5	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар		182.5	182.5
1	Бүсийн төвд GPS станц суурилуулах	2004-2004	117.5	117.5
2	Тоног төхөөрөмж	2004-2004	65.0	65.0
II.6.4	Гамшгаас хамгаалах ерөнхий газар		43.0	43.0
1	Тоног төхөөрөмж	2004-2004	18.0	18.0

II.6.4	Гамшгаас хамгаалах ачаалгатай газар		43.0	43.0
1	Тоног төхөөрөмж	2003-2004	18.0	18.0
2	Их засвар	2004-2004	25.0	25.0
III	**Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга**		**2,698.5**	**1,227.0**
1	Төрийн мэдээллийн сүлжээний компьютер, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн шинэчлэлт	2004-2005	287.8	100.0
2	Соносгүдын дотуур байр, 112 хүн. Улаанбаатар	2004-2004	250.0	250.0
3	Их засвар	2003-2004	1,025.0	525.0
4	Тоног төхөөрөмж	2003-2004	320.0	150.0
5	Аймгийн ЗДТГазрын контор. Улиастай	2004-2005	783.7	170.0
6	Сумдаар сумын ЗДТГ-ын байгаль верчлэлт, засвар	2004-2004	32.0	32.0
IY	**Гадаад хэргийн сайд**		**296.0**	**296.0**
1	Астана хотод ЭСЯ-нд байр худалдан авах	2004-2004	40.0	40.0
2	Их засвар	2004-2004	143.0	143.0
3	Тоног төхөөрөмж	2004-2004	113.0	113.0
Y	**Санхүү, эдийн засгийн сайд**		**3,943.0**	**2,127.0**
1	Тоног төхөөрөмж	2004-2004	25.0	25.0
2	Их засвар	2004-2004	95.0	95.0
Y.1	Цагааннуурын боомтын АТҲШНЦорцогтбор, Баянөлгий	2003-2004	2,550.0	1,434.0
Y.2	УТЕГазрын конторын ерөнтлөл, Улаанбаатар	2004-2006	800.0	100.0
Y.3	Төсөл, арга хэмжээний багтаган хангах		473.0	473.0
YI	**Хууль зүй, дотоод хэргийн сайд**		**3,600.0**	**2,157.2**
YI.1	Явганы дүн		**710**	**710**
2	ХЗДХЯамны их засвар	2004-2004	21.3	21.3
3	ТТАХНЭмналтийн тоног төхөөрөмж	2004-2004	27.0	27.0
4	ХЗДХЯамны тоног төхөөрөмж	2004-2004	22.7	22.7
YI.2	Цагдаагийн ачаалгатай газар		**748.0**	**648.0**
1	Эрүүл хамгаалалтын 801-р хорооны штаб сумангудын байр	2003-2004	400.0	300.0
2	Цагдаагийн хэсгийн байр, 30 ш	2004-2004	150.0	150.0
3	Их засвар	2004-2004	118.0	118.0
4	Тоног төхөөрөмж	2004-2004	80.0	80.0
YI.3	Шүүхийн шийдвар гүйцэтгэх ачаалгатай газар		**458.0**	**258.0**
1	Аймгуудад барьцаалах байр, гадна хамгаалалтын хашаа барих	2003-2004	223.0	113.0
2	Хорс хуулбалын ажил	2002-2004	130.0	40.0
3	Барьцаалах байр, эмэгтэйчүүдийн хорих	2004-2004	20.0	20.0
4	Барьцаалах байр, 467-р анги, Ховд	2004-2004	20.0	20.0
5	Тоосгонц уйлдвэр, 4 сав.ш. тооого, 413-р анги, Хэнтий	2004-2004	15.0	15.0
6	Их засвар	2004-2004	30.0	30.0
7	Тоног төхөөрөмж	2004-2004	20.0	20.0
YI.4	Хил хамгаалах ачаалгатай газар		**2,246.0**	**1,103.2**
1	Хилийн 27-р отряд Дорнод, Монон	1999-2004	676.7	137.4
2	Хилийн 0129-р анги,ин штаб, цэргийн байр, Дорноговь, Эрдэнэ сум	2002-2005	735.0	250.0
3	0277, 0257-р ангиудын хилийн хэсэгт инженерийн байгууламж барих, Завхан, Хөвсгөл аймгийн хилийн хэсэгт	2003-2004	156.0	100.0
4	Хилийн 0186-р ангийн Замбилгэхийн застав, Говь-Алтай, Эрдэнэ сум	2004-2004	158.8	158.8
5	Хилийн модон шонг төмөр-бетон шонгоор солих. Дорнод	2004-2004	58.0	58.0
6	0186-р ангийн Чандганы хилийн харуулд ерөмдлэт худаг /Өмнөговь/	2004-2004	12.0	12.0
7	Хилийн отрядын сөөнын тев, спорт заал. /Хөвдын Үянх сум /	2004-2004	138.0	76.0
8	0214-р ангийн Өрөстэйн хилийн харуулд ерөмдлэт худаг Говь-Алтайн Алтай сум	2004-2004	13.5	13.0
9	Их засвар	2004-2004	150.0	150.0
10	Тоног төхөөрөмж	2004-2004	150.0	150.0
YI.5	Үндэсний архивын газар		**77.0**	**77.0**
1	Үндэсний тев архивын барилгын их засвар	2004-2004	30.0	30.0
2	Гагын болон хамгаалалтын дохиоллын систем, архивын баримт хадгалах нягтруулган шүүгээ, тоног төхөөрөмж	2004-2004	47.0	47.0
YII	**Байгаль орчны сайд**		**100.0**	**100.0**
1	Цаг уурын станцын барилга барих, Тев	2004-2004	5.0	5.0
2	Цаг уурын станцын барилга барих, Дундговь	2004-2004	5.0	5.0
3	Цаг уурын станцын барилга барих, Завхан	2004-2004	5.0	5.0
4	Цаг уурын станцын барилга барих, Хэнтий	2004-2004	5.0	5.0
5	Байгаль орчны албанд байр худалдан авах, Ховд	2004-2004	5.0	5.0
6	Их засвар	2004-2004	45.0	45.0
7	Тоног төхөөрөмж	2004-2004	30.0	30.0
YIII	**Батлан хамгаалахын сайд**		**606.0**	**482.0**
1	Зэвсгийн агуулах, 12хбм, 12ш, Дорнод, 327-р анги	2004-2005	128.0	64.0
2	Гэрээт цэргийн байр, Дорнод, 327-р анги	2004-2005	110.0	50.0
3	Цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэл, Улаанбаатар	2004-2004	100.0	100.0
4	Их засвар	2004-2004	188.0	188.0
5	Тоног төхөөрөмж	2004-2004	80.0	80.0

IX	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сан		16,008.7	7,368.8
1	Сургуулийн барилга, 928 суудал, Дорноговь, Сайншанд	2002-2005	966.9	300.0
2	Сургуулийн барилга, 960 суудал, Ховд, Жаргалант	2003-2005	1,280.0	400.0
3	Сургуулийн барилга, 320 суудал, Увс, Өмнөговь	2003-2004	288.2	288.2
4	Сургуулийн барилга, 240 суудал, Өмнөговь, Манлай	2003-2004	206.0	175.0
5	Сургуулийн барилга, 240 суудал, Хэнтий, Баянхан	2003-2004	240.0	190.0
6	Сургуулийн биеийн тамирын заал, 15х30 м, Говь-Алтай, Тонхил	2004-2005	160.0	45.0
7	Сургуулийн барилга, 320 суудал, Архангай Хайрхан	2003-2004	349.0	296.0
8	Сургуулийн барилга, 640 суудал, Дорнод, Хэрлэн	2004-2005	510.0	40.0
9	Сургуулийн барилга, 640 суудал, Баянхонгор	2004-2006	766.0	50.0
10	Сургуулийн барилга, 640 суудал, Өвөрхангай, Арвайхээр	2004-2005	380.0	80.0
11	Сургуулийн барилга, 640 суудал, Хэнтий, Мөрөн	2004-2005	400.0	100.0
12	СУИС-ууд-ын хичээлийн байрны дугуйлан, 704 суудал, УБ	2004-2005	510.0	120.0
13	Сургууль, 640 суудал, Улаанбаатар, СХД	2004-2005	620.0	40.0
14	Дотуур байрны дугуйлан, Хөвсгөл, Улаан-Уул	2004-2004	20.0	20.0
15	Сургуулийн барилга, 240 суудал, Булган, Рашаант	2003-2004	277.5	177.5
16	Сургуулийн дотуур байр, 65 ор, Төв, Баян-Өнөрүүл	2003-2004	189.7	129.7
17	Цэцэрлэг, 50 ор, Архангай, Цэнхэр	2004-2004	58.0	58.0
18	Цэцэрлэгийн дугуйлан, Дундговь, Дэлгэрхангай	2004-2004	108.0	28.0
19	Цэцэрлэг, 240 ор, Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	2004-2005	245.0	45.0
20	Цэцэрлэг, 100 ор, Өвөрхангай, Уянга	2004-2005	173.0	73.0
21	Сургуулийн спорт заал, Булган, Баян-Агт	2004-2005	128.0	20.0
22	10 жилийн 2-р сургууль, 240 суудал, Улаастай	2004-2005	230.0	40.0
23	Сургуулийн өргөтгөл, 240 суудал, Сүхбаатар, Эрдэнэцагаан	2004-2005	220.0	40.0
24	Соёлын төвийн дугуйлан, Ховд, Манхан	2003-2004	180.0	110.0
25	Цэцэрлэг, Соёлын төвийн дугуйлан, Дундговь, Даран	2003-2004	83.6	18.6
26	Соёлын төвийн барилга, 150 суудал, Дорнод, Баян-Уул	2003-2004	127.9	78.0
27	Соёлын төвийн дугуйлан, Булган, Сайхан	2004-2005	95.0	30.0
28	Соёлын төвийн барилга, Увс, Завхан сум	2004-2005	140.0	30.0
29	Соёлын төв. 150 суудал, Дундговь, Сайхан-Овоо	2004-2005	140.0	30.0
30	Соёлын төв. 200 суудал, Ховд, Дарви	2004-2005	225.0	40.0
31	Соёлын төвийн дугуйлан, Сүхбаатар, Баруун-Урт сум	2004-2004	150.0	150.0
32	Соёлын төв. 150 суудал, Увс, Давст	2004-2005	130.0	30.0
33	Мэдээлэл технологийн үндэсний паркийн барилын шинэчлэлт	2003-2004	30.0	30.0
34	АХБ-ны "БСХХ-2" төслийн Монголын талын хэрэгцээ	2003-2006	2,080.0	600.0
35	Жайа-газар харгачих төслийн дотоод эх үүсвэр	2003-2007	216.0	38.0
36	Япон улсын ЗГ-ын туслэмжээр "Сургуулийн барилын өргөтгөл-2" төслийн дотоод эх үүсвэр, Дархан, Орхон	2004-2005	350.0	204.0
37	Сургуулийн биеийн тамирын заалны дугуйлан, Говь-Алтай, Хөхморьт	2004-2004	90.0	50.0
38	Сургуулийн барилга, 320 суудал, Сэлэнгэ, Мандал	2004-2005	440.0	43.9
39	Их засвар	2004-2004	427.5	427.5
40	Соёлын төвийн барилын их засварт нэмэх олгох хэрэгцээ	2004-2004	336.4	336.4
41	Тоног төхөөрөмж	2004-2004	500.0	500.0
42	Сургууль, соёлын байгууллагын их засвар	2004-2004	1900	1900
X	**Дэд бүтцийн сан**		**159,455.4**	**31,885.2**
I.1	**Эрчим хүч**		**86,610.1**	**12,186.8**
X.1.1	**Дугуйлан цэцэлгээн станц, дугуйланы шугам**		**19,664.2**	**1,203.0**
1	Улаанбаатар хотын дугуйлан ур ашигийн төслийн зээлийн дотоод эх үүсвэр	1998-2006	6,606.0	110.2
2	Дугуйлан гадна шугам, ф-1000 мм, 6.1 км, (ТЭЦ 3- ТЭЦ 4 стандүүдын хоорондх), Улаанбаатар	2002-2004	3,344.9	300.0
3	Дугуйлан 4-р цэцэлгээн станцын 2-р шатны шинэчлэлтийн Монголын талын хэрэгцээ	2004-2006	8,917.0	400.0
4	Дугуйлан шугамын шинэчлэлт. Увс, Улаангом	2003-2004	218.3	172.8
5	Дугуйлан станцын КБ 25-14 С зууханы шинэчлэлт, Баян-Өлгий	2004-2005	196.0	70
6	Дугуйлан станцын шинэчлэлт, Сэлэнгэ	2004-2005	380.0	150
X.1.2	**6, 10, 15, 35, 110 кВ-ын цэцэлгээн дамжуулах шугам, дэд өртөө:**		**29,742.4**	**6,518.8**
1	Дарвийн УЦС-Мянгад шилжих 110 кВ-ын ЦДАШ, 76 км, дэд өртөө, 2х10 мВа. Ховд	2002-2006	2,320.0	50.0
2	Тайширын УЦС-Улиастай 110 кВ-ын ЦДАШ, 135 км, дэд өртөө 1х1; 1х10 мВа, Завхан	2004-2006	4,300.0	100.0
3	Тайширын УЦС-Алтайн 35 кВ-ын ЦДАШ, 47 км, дэд өртөө, 1х1 мВа, Говь-Алтай	2003-2004	972.8	594.3
4	Тариат-Жаргалтын сумын 35 кВ-ын ЦДАШ, 86.6 км, дэд өртөө, 1х1 мВт. Хэвсгэл.	2003-2004	650.0	550.0
5	Зүүлэгтэй-Галшар сумын 35 кВ-ын ЦДАШ, 61 км, дэд өртөө , 1х1 мВа. Хэнтий	2003-2004	915.0	715.0
6	Батноров-Баян-Адрага сумын 35 кВ-ын ЦДАШ, 80 км, дэд өртөө, 1х1 мВа. Хэнтий	2003-2005	1,057.0	400.0
7	Тегрег-Гучин-Ус сумын 10 кВ-ын ЦДАШ, 50 км, дэд өртөө, 1х0.4 мВа. Өвөрхангай	2004-2005	400.0	200.0
8	Баян-Адрага-Биндэр сумын 15 кВ-ын ЦДАШ, 47 км, дэд өртөө, 1х0.1; 1х 0.16 мВа , Хэнтий	2004-2005	423.0	141.0
9	Тариат - Хайрхандулаан сумын 10 кВ-ын ЦДАШ, 54 км, дэд өртөө, 1х0.4 мВа. Өвөрхангай	2003-2004	250.7	81.6
10	Улгөвөн-Түвшинширээ сумын 10 кВ-ын ЦДАШ, 56 км, дэд өртөө, 1х0.1; 1х0.16 мВа. Сүхбаатар	2004-2005	448.0	100.0
11	Төвшийн говь-Адвацаг сумын 15 кВ-ын ЦДАШ, 64 км, дэд өртөө, 1х0.1; 1х0.16 мВа Дундговь	2003-2004	492.5	317.0
12	Галшар-Дэлгэрэх сумын 10 кВ-ын ЦДАШ, 58.3 км, дэд өртөө, 1х0.1; 1х0.16 мВа. Хэнтий	2004-2005	467.0	100.0
13	Сайншанд-Сайхандулаан сумын 35 кВ-ын ЦДАШ, 91 км, дэд өртөө, 1х0.4 мВа. Дорноговь	2004-2005	1,092.0	100.0

14	Зүүнбаян-Улаанбадрах сумын 15 кВ-ын ЦДАШ, 75 В км, дад.өртөө 1х0.4; 1х0.25 мВа. Дорноговь	2003-2004	600.0	350.0
15	Хүрэлбаян-Мөнххаан сумын 10 кВ-ын ЦДАШ, 60 км, дад.өртөө 1х0.1; 1х0.16 мВа. Сүхбаатар аймаг	2004-2005	560.0	50.0
16	Өлиндэвч-Баянчуулт сумын 10 кВ-ын ЦДАШ, 55.1 км, дад.станц 1х0.1; 1х0.16 мВа. Баян-Өлгий	2004-2005	441.0	200.0
17	Баян-Овоо- Түмэнцогт сумын 10 кВ-ын ЦДАШ, 35 км, дад.өртөө, 1х0.1; 1х0.16 мВа. Сүхбаатар	2004-2004	157.5	157.5
18	Мөрөн-Түнэл, 6 кВ-ын ЦДАШ, 46 км, дад.өртөө, 1х0.16 мВа. Хөвсгөл	2004-2006	300.0	113.6
19	Үеэнчийн УЦС-Булган сум, 35 кВ-ын ЦДАШ, 43 км, дад.өртөө, 1х0.63 мВа, Ховд	2004-2005	1,200.0	100.0
20	Үеэнчийн УЦС-Алтай сум, 10 кВ-ын ЦДАШ, 39 км, дад.өртөө, 1х0.16, 1х0.16 мВа, Ховд	2004-2005	204.0	50.0
21	Цахилгаан шугам сүлжээний олдлагдлыг багасгах тестийн зааглийн дотоод эх үүсвэр	2001-2006	6,664.4	656.0
22	Диспетчерийн тавийн хяналт мэдээллийн систем ба дамжуулах сүлжээний шинэчлэлтийн тестийн зааглийн дотоод эх үүсвэр.	2002-2006	1,420.0	450.0
23	Таврит-Хэнэгт сум, 10 кВ-ын ЦДАШ 45 км, дад.станц , 1х0.16, 1х0.1 мВа, Архангай	2004-2005	400.0	126.0
24	Жаргалант-Их-Уул сумын 15 кВ-ын ЦДАШ, 45 км, дад.станц 1х0.16; 1х0.1, мВа, Өмнөговь	2004-2005	280.0	160
25	Жаргалант-Их-Уул сумын 15 кВ-ын ЦДАШ, 45 км, дад.станц 1х0.16; 1х 0.1,мВа, Завхан	2004-2005	385.0	100
26	Жаргалант- Шинэ-Идэр сумын 10 кВ-ын ЦДАШ, 54 км, дад.станц, 1х0.16, 1х0.1, мВа, Хөвсгөл	2004-2005	478.0	50
27	Шивээговь-Баянжаргалан сумын 35 кв-ын ЦДАШ, 65 км, 1х1 мВа, Дундговь	2003-2005	969.8	100
28	Ховд-Дуут сумын 35 кв-ын ЦДАШ, 61.1 км, 1х0.4 мВа, Ховд	2001-2004	887.7	178.8
29	Улаанбаатар хотын захын гар хорооллын цахилгаан дамжуулах шугам**	2003-2004	1,000.0	211.0
30	Эрчим хүчний тесел, арга хэмжээний зураг төсөл, судалгаа	2004-2004	17.0	17
X.13	**1.3. Сэргээгдэх эрчим хүч**		**37,203.5**	**4,465.0**
1	100 мянган нүүрс гаргах хэмжээний харанжуулах	2001-2007	520.0	100.0
2	Үеэнчийн усан цахилгаан станц 1.2 мВт Ховд	2003-2005	1,595.0	770.0
3	Тайширын усан цахилгаан станц 8 мВт Хувьлийн сангийн зээлийн дотоод эх үүсвэр/ Говь-Алтай	2001-2005	513.5	20.0
4	ХБНГУын Бүдэгтүй гүрлэмж, зээлийн хөрөнгөөр харанжуулах буй сэргээдэх эрчим хүчний тестийн Монголын талын хөрөнгө	2003-2005	575.0	125.0
5	Дарлигийн усан цахилгаан станц 12 мВт (Буцаан төлөх төлбөр)	2003-2006	34,200.0	3,450.0
X.2	**Тулш**		**10.0**	**10.0**
1	Улсын хэрэгх эрчим хүчний техникэрэмж	2004-2004	10.0	10.0
X.3	**Бэрилгэ, хот байгуулалт, орон сууц, нийтийн эх хэрэг**		**5,589.0**	**1,640.9**
1	Цэвэр усны хос шугам/ 9 км Ф150мм/ Говь-Алтай, Есөнбулаг	2003-2004	270.0	138.2
2	Айлчлэгч тив, сүмдын нийтийн зориулалтын шинэчлэл, шинэчлэлт,хийх	2001-2004	1,875.0	500.0
3	Хатуун усны бэрилгэ, Улаанбаатар**	2004-2004	344.0	344.0
4	Цэвэр усны эх үүсвэр, гүний худаг-1ш, шугамын шинэчлэлт, хамгаалалтын далан-150м Сайнэзэ аймаг Сүхбаатар	2003-2005	550.0	250.0
5	Цэвэр усны шугамын шинэчлэлт 9 км Төв, Зуунмод	2003-2004	120.0	38.7
6	Цэвэр усны шугамын шинэчлэл, темергүйжуулах байгуулалж Говьсүмбэр	2004-2005	125.0	60.0
7	Халиалтын тогоо солих Хөвсгөл , Мөрөн	2004-2004	30.0	30.0
8	Цэвэр усны шугамын шинэчлэлт-22км, Орхон- Хөтөл, Сайхэнгэ	2004-2007	1,240.0	150.0
9	Цэвэрлэх байгуулалж, Орхон, Жаргалант	2004-2005	100.0	30.0
10	Цэвэрлэх байгуулалж, Налайх дүүрэг	2004-2006	930.0	100.0
X.4	**Авто замын хэрэгцэ оруулалт**	2002-2007	**67,246.3**	**17,547.5**
X.5	**Орон сууцны хороололын дотоорхи замын засвар ****	2004-2004	**500.0**	**500.0**
XI	**Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд**		**2,110.0**	**380.8**
1	Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөрийн дотоод эх үүсвэр	2002-2006	1,800.0	70.8
2	Улсын нийгмийн халамжийн үйлчилгээний төв	2004-2004	150.0	150.0
3	Их засвар	2004-2004	120.0	120.0
4	Тоног төхөөрөмж	2004-2004	40.0	40.0
XII	**Үйлдвэр, худалдааны сайд**		**786.9**	**717.0**
1	Үйлдвэр, худалдааны чанарт бүсийн хашаа, харуулын байр. Сайхэнгэ, Алтанбулаг	2004-2004	390.0	390.0
2	Алтанбулагийн чанарт бүсийн мастер төлөвлөлтөө, Сайхэнгэ	2004-2004	270.0	270.0
3	Тоног төхөөрөмж	2002-2004	70.0	20.0
4	Экологийн төв лаборатори	2004-2004	10.0	10.0
5	Геологийн судалгааны тес	2002-2004	46.9	27.0
XIII	**Хүнс, хөдөө эх ахуйн сайд**		**880.0**	**880.0**
1	Инженерийн хийгдэй худаг шинээр гаргах	2004-2004	250	250
2	Их засвар	2004-2004	581.1	581.1
3	Тоног төхөөрөмж	2004-2004	48.9	48.9
XIY	**Эрүүл мэндийн сайд**		**6,301.0**	**3,697.0**
1	Сумын хүн эмнэлийн барилга, 10 ор, Дундговь, Эрдэнэдалай	2004-2004	130.0	130.0
2	Сумын хүн эмнэлийн барилга, 15 ор, Ховд, Үеэнч	2004-2004	130.0	130.0
3	Сумын хүн эмнэлийн барилга, 10 ор, Булган, Баян-Агт	2004-2004	110.0	110.0
4	Сумын хүн эмнэлийн барилга, 15 ор, Увс, Сагил	2004-2004	120.0	120.0
5	Сумын хүн эмнэлийн барилга, 10 ор, Говь-Алтайн, Жаргалан	2004-2004	110.0	110.0
6	Сумын хүн эмнэлийн барилга, 10 ор, Дархан-Уул, Орхон	2004-2004	100.0	100.0
7	Сумын хүн эмнэлийн барилга, 15 ор, Увс, Цагаанхайрхан	2004-2005	140.0	50.0
8	Сумын хүн эмнэлийн барилга, 15 ор, Хөвсгөл, Галт	2004-2004	110.0	110.0
9	Сумын хүн эмнэлийн барилга, 10 ор, Хэнтий Батноров	2004-2004	110.0	110.0
10	Сумын хүн эмнэлийн барилга, 15 ор, Өвөрхангай Зүүл	2004-2005	140.0	40.0
11	Сумын хүн эмнэлийн барилга, 10 ор, Завхан Завханмандал	2004-2005	130.0	60.0

12	Сумын хүн эмнэлгийн барилга, 10 ор., Сэлэнгэ, Хушаат	2004-2004	110.0	110.0
13	Эмнэлгийн засвар шинэчлэлт, Багахангай	2004-2004	80.0	80.0
14	Хүүхдийн эмнэлэг, Завхан аймаг	2004-2006	300.0	100.0
15	"Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-2"-ийн Монголын талын хөрөнгө	2003-2008	2,431.0	287.0
16	Өрхийн эмнэлгийн барилга, Улаанбаатар **	2004-2004	150.0	150.0
17	Их засвар	2004-2004	400.0	400.0
18	Тоног төхөөрөмж	2004-2004	400.0	400.0
19	Хот, хөдөөгийн хүн эмнэлгийн барилгын их засвар	2004-2004	1100	1100
XY	**Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч**		**20.0**	**20.0**
1	Их засвар	2004-2004	6.0	6.0
2	Тоног төхөөрөмж	2004-2004	14.0	14.0
XYI	**Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга**		**55.0**	**55.0**
1	Их засвар	2004-2004	30.0	30.0
2	Тоног төхөөрөмж	2004-2004	25.0	25.0
XYII	**Улсын Ерөнхий прокурор**		**26.5**	**26.5**
1	Их засвар	2004-2004	26.5	26.5
XYIII	**Үндэсний статистикийн газар**		**40.0**	**40.0**
1	Интернетийн сүлжээнд холбох		20.0	20.0
2	Тоног төхөөрөмж	2004-2004	20.0	20.0
XIX	**ЦАУЗБУКомиссын дарга**		**110.0**	**110.0**
1	Хэлмэгдсэн иргэдэд олгох орон сууц	2004-2004	100.0	100.0
2	Тоног төхөөрөмж	2004-2004	10.0	10.0
XX	**Үндсэн хуулийн цэцийн дарга**		**5.0**	**5.0**
1	Тоног төхөөрөмж	2004-2004	5.0	5.0
	Нийт хөрөнгө оруулалтын дүн		**198,027.5**	**52,560.0**

Тайлбар ** Нийслэлийн засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчидтай гэрээ байгуулан хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

Засгийн газрын 2004 оны 84 дүгээр тогтоолын 2-р хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2004 оны жагсаалт

д.д	Төсөл арга хэмжээний нэр, байршил	Хүчин чадал	Барих хугацаа	Төсөвт өртөг	2004 оны төсөл			Ашиглалтад оруулах хугацаа	
					Бүгд	Үүнээс		Хүчин чадал	Хугацаа (улирал)
						Төсөв	Замын сан		
А	Б	1	2	3	4	5	6	7	8
	Нэг. Гадаадын зээлээр хэрэгжих буй төслүүдийн дотоод эх үүсвэр			21,499.4	5,887.3	4,722.3	1,165.0		
	а. ТЭЗҮ, хайчуул, зураг төсөв			1,346.9	607.1	607.1	0		
1	Чойр - Замын -Үүдийн хатуу хучилттай зам		2003-2004	1,000.0	300	300			
2	Эрдэнэсант-Улаанбаатарын хатуу хучилттай замын засвар, шинэчлэлт		2004-2004	346.9	307.1	307.1			
	Зам			18,822.5	5,148.3	4,115.2	1,033.1		
	в. шинээр эхлэх			5,310.1	978.5	531.2	447.3		
1	Эрдэнэт-Булган-Үнэтын хатуу хучилттай зам	146.2 км	2002-2007	5,310.1	978.5	531.2	447.3		
	б.шилжих			13,512.4	4,169.8	3,584.0	585.8		
1	Налайх-Чойрын хатуу хучилттай зам	200 км	2000-2005	9,316.0	3,584.0	3,584.0		200 км	IY
2	Арвайхээр-Эрдэнэсантийн замын засвар, шинэчлэлт	215 км	2001-2004	2,148.90	154.4		154.4		
3	Арвайхээр -Ховдын сайжруулсан хайрган зам	93 км	2003-2005	953.4	414.1		414.1	93 км	IY
4	Хархорин-Тосонцэнгэлийн сайжруулсан хайрган зам	92.7 км	2001-2004	1,094.10	17.3		17.3		
	в.бүгд			1,330.00	131.9	0	131.9		
5	Тээвэрийг хөгжүүлэх төслийн барилгын хяналт., сургалт, тоног төхөөрөмж		2001-2005	1,330.00	131.9-		131.9		
	Хөөр. Замын сүлжээний засвар , арчлалт, замын хуулийг хэрэгжүүлэх		2004-2004	5,000.00	5,000.00		5,000.00		
	Гүүрэв. ЭГҮАМХ-т тусгагдсан зам, гүүр			18,620.3	2,664.2	1,633.2	1,031.0		
	Зам			16,898.5	1,633.2	1,633.2	0.0		
1	Улаангом-Хандгайтийн хатуу хучилттай зам	58 км	2003-2007	5,000.00	500	500			
2	Ховдын Булган-Ярантын хатуу хучилттай зам	65 км	2002-2005	2,928.50	633.2	633.2			
3	Өлгий-Цагаанчуурайн хатуу хучилттай зам	69 км	2004-2006	8,970.00	500	500			
	Гүүр			1,721.8	1,031.0	0.0	1,031.0		
1	Хөмүүлтийн модон гүүр, Хэнтий	200 у/м	2003-2004	350	115		115	200 у/м	IY
2	Харчулуутын төмөр бетон гүүр, Баян-Өлгий	72 у/м	2003-2004	256	156		156	72 у/м	III
3	Эүүн бүрэнгийн төмөр бетон гүүр, Сэлэнгэ	168 у/м	2001-2004	435.8	400		400	168 у/м	II
4	Буянтын төмөр бетон гүүр, Завхан	170 у/м	2002-2004	680	360		360	170 у/м	IY
	Дэрэв . Мянгины замын төсөл			22,126.6	3,996.0	3,996.0	0		
	Зам			19,500.0	2,900.0	2,900.0	0		
1	Багануур -Өндөрхаан хатуу хучилттай зам	200 км	2004-2008	19,500.0	2,900.0	2,900.0			
	Гүүр			2,626.6	1,096.0	1,096.0	0		
1	Сархайрханы төмөр бетон гүүр, Завхан	126.9 у/м	2001-2004	1,658.00	800	800		126.9 у/м	II
2	Шургийн голын төмөр бетон гүүр, Ховд	145.1 у/м	2002-2004	968.6	296	296		145.1 у/м	II
	НИЙТ ДҮН			67,246.3	17,547.5	10,351.5	7,196.0		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13[2] дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийг 1 дүгээр хавсралт, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, аймаг хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 16 дугаар хавсралт болгон тус тус батална.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2004 оны 85 дугаар тогтоолын 1-р хавсралт

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Архидан согтуурахтай тэмцэх сан (цаашид "Сан" гэх)-гийн зорилго нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, архидан согтуурсны улмаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учирч байгаа хор уршгийг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд оршино.

1.2. Сангийн үйл ажиллагаа Сангийн зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) удирдана.

1.3. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

1.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

1.5. Зөвлөл хэлэлцсэн асуудлаа олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Тогтоолд Зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө.

1.6. Сангийн зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.7. Сангийн зөвлөлийн ажлын алба нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба байна.

1.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

1.9. Сангийн зөвлөл нь үйл ажиллагаагаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд жил бүр тайлагнана.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

2.1. Сангийн хөрөнгө Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13[2].2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13[2].4-т заасныг үндэслэн дараахь үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар санхүүжүүлнэ болно:

2.2.1. архинд донтох өвчтэй хүнийг эрт илрүүлж оношлох, наркологийн тусламж үзүүлэх, хүн амыг эрүүлжүүлэх, эмчилгээний үр дүнг судлах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.2.2. архидан согтуурахаас сэргийлэх, архины хор уршгийг бууруулах талаар улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ;

2.2.3. архидан согтуурснаас нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тогтоох судалгаа, шинжилгээний ажил.

2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба энэ дүрмийн 2.2-т заасан үйл ажиллагаа, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг төлөвлөж Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоосон журмын дагуу Засгийн газарт оруулна.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

3.1. Сангийн хөрөнгийг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13[2].6-д заасан зориулалтаар зарцуулна.

3.2. Сангийн хөрөнгийг энэ дүрмийн 3.1-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Сангийн зөвлөлийн бүрэн эрх

4.1. Сангийн зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

4.1.2. Сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргах;

4.1.3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг шалгаруулах;

4.1.4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, үр дүнг шалгах, холбогдох мэдээ, тайланг хэлэлцэн үнэлэлт өгөх.

Тав. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах

5.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг дараахь байдлаар зохицуулна:

5.1.1. Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

5.1.2. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбоотой бусад ажлыг зохицуулах;

5.1.3. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах болон бусад үйл ажиллагаатай холбогдсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

Засгийн газрын 2004 оны 138 дугаар тогтоолын 16-р хавсралт

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	-Хууль зүй, дотоод хэргийн сайд;
Гишүүд:	-Санхүү, эдийн засгийн дэд сайд;
	-Эрүүл мэндийн дэд сайд;
	-Үйлдвэр, худалдааны дэд сайд;
	-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
	-Сэлэнгэ аймгийн Засаг дарга;
	-Цагдаагийн ерөнхий газрын дарга;
	-Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (тохиролцоноор);
	-Улсын мэргэжлийн хяналтын газрын тэргүүн дэд дарга;
	-Нийслэлийн Засаг даргын орлогч;
	-Монголын үндэсний худалдаа,аж үйлдвэрийн танхимын тэргүүн (тохиролцоноор);
	-Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцоноор);
	-"Улаанбаатар ротари клуб"-ийн ерөнхийлөгч (тохиролцоноор);
	-Хүнс үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн (тохиролцоноор);
	-Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцоноор);
Нарийн бичгийн дарга	-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын Хөрдүгаар хэсгийн 4-ийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламжаар олгосон бүтээгдэхүүний борлуулалтын сан, түүний хүүгийн орлогоос "Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан" байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журмыг хавсралт ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2004 оны 86 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЖИЖИГ ҮЙЛДВЭРЛЭЛ-ШИНЭ ТЕХНОЛОГИ САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан (цаашид "сан" гэх)-г бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сан нь Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын бүрэлдэхүүн хэсэг болно.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хүнс, хөдөө аж ахуйн болон Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан тушаалаар батална.

2.2. Сангийн зөвлөл дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжих боломж, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хүрэлцээ, удирдлагын болон мэргэжлийн боловсон хүчний чадавхи, зээлийг хугацаанд нь төлөх магадлал, барьцаалах эд хөрөнгө зэргийг хянан үзэж, төслийг сангийн зөвлөлийн хуралдаанаар нэгбүрчлэн хэлэлцэн шийдвэрлэх;

2.2.2. Төсөлд олгох зээлийн хэмжээ, эргэж төлөх хугацаа тогтоох;

2.2.3. Сангаас эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, зээлийг хугацаанд нь төлүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.4. Сантай холбоотой, энэхүү журамд нийцсэн бүхий л асуудлыг сангийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх;

2.2.5. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээнд анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, үйл ажиллагааны тайланг улирал, жилээр гаргаж Санхүү, эдийн засгийн яаманд тушаах үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны сангийн асуудал хариуцсан нэгж (цаашид "Сангийн асуудал хариуцсан нэгж" гэх) хариуцан гүйцэтгэх бөгөөд түүний дүнтэй сангийн зөвлөл улирал бүр танилцаж байна.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанаар хэлэлцэн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэл гаргана.

2.4. Сангийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн сайд тушаал гаргах бөгөөд энэ нь хөрөнгө зарцуулах эцсийн шийдвэр болно.

2.5. Сангийн зөвлөлийн хуралдааныг гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

2.6. Сангийн өдөр тутмын үйл ажиллагаг Хүнс, хөдөө аж ахуйн яамны сангийн асуудал хариуцсан нэгж эрхэлнэ.

Гурав. Сангийн санхүүгийн эх үүсвэр, зориулалт

3.1. Сангийн эх үүсвэр нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарт гадаад орон, олон улсын байгууллагаас буцалтгүй тусламжаар олгосон бүтээгдэхүүний борлуулалтын орлогын зарим хэсэг, түүний хүүгийн орлого, сангийн үйл ажиллагааны болон бусдад үйлчилгээ үзүүлснээс олсон орлого, тус санд оруулсан хөрөнгө болон зөвлөлийн хураамж зэргээс бүрдэнэ.

3.2. Сангийн хөрөнгийн зориулалт нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилготой хөтөлбөр, төсөлд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Дөрөв. Сангаас зөвлөх олгоход баримтлах журам

4.1. Зөвлөх хүсэгч нь дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1. Төсөл;

4.1.2. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ, эсхүл төсөл хэрэгжүүлэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар, оршин суугаа хаяг;

4.1.3. Газар эзэмших гэрчилгээ;

4.1.4. Барьцаалах эд хөрөнгө /хувьцаа, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө/;

4.1.5. Банкны ёр барагдуулах албаны тодорхойлолт;

4.1.6. Тухайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, санхүүгийн талаархи харилцагч банкны тодорхойлолт;

4.1.7. Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцэл.

4.2. Төсөл нь дараахь шаардлагыг хангасан байна:

4.2.1. Төсөл нь сангийн зориулалтад нийцсөн, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлтэй жижиг үйлдвэрлэлийг эрчимжсэн технологиор явуулж, эдийн засгийн хувьд тогтвортой үр ашигтай ажиллах нөхцөлийг хангасан байх;

4.2.2. Төслийн цар хүрээ, давуу тал тодорхой байх;

4.2.3. Төслийн ямар арга хэмжээнд нь зориулж жижиг зээл авах, өөрийн хөрөнгө болон арилжааны банкны зээлээр ямар арга хэмжээг нь санхүүжүүлэхийг тодорхой зааж, арилжааны банкнаас зээл авах талаар урьдчилан санал авсан байх;

4.2.4. Төслийг хэрэгжүүлэх явц, гарч болох эрсдэл, түүнийг шийдвэрлэх арга замын тухай үнэлгээ гаргасан байх;

4.2.5. Төсөл хэрэгжүүлэгчийн мэргэжил, ажил үүргийн хуваарийг заасан байх;

4.2.6. Зөвлийг эргүүлэн төлөх санхүүгийн төлөвлөгөө хийгдсэн байхын дээр төсөл хэрэгжүүлэх газар, объектын талаар шаардлагатай материал, фото зураг хавсаргасан байна.

4.3. Зөвл хүссэн аж ахуйн нэгж, иргэний өргөдөл, холбогдох баримт бичгийг Хүнс, хөдөө аж ахуйн яам хүлээн авна.

4.4. Хүнс, хөдөө аж ахуйн яамны холбогдох газар, хэлтсүүд төслийг бодлогын болон технологийн хувьд дэмжих боломжтой эсэх талаар дүгнэлт гаргаж, дэмжсэн төслөө Сангийн асуудал хариуцсан нэгжид үндэслэлийн хамт шилжүүлж, дэмжих боломжгүй төслийг зөвлөх хүн зохих тайлбарын хамт буцаана.

4.5. Бодлого болон технологийн хувьд дэмжигдсэн төсөл бүрийг Сангийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж зөвл олгох эсэх талаар дүгнэлт гарган сайдад уламжилна.

Тав. Хөрөнгийг зарцуулах зарчим

5.1. Нэг төслийг зөвлөхүүлэх хөрөнгийн дээд хэмжээ нь 5.0 (таван) сая хүртэл төгрөг, зөвлийг эргүүлэн төлөх хугацаа нь 2 хүртэл жил байна.

5.2. Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи төсөлд олгох зөвл нь үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор жилийн 10.0 хувийн хураамжтай байна. Хугацаа хэтэрсэн зөвлийн алдангийг арилжааны банкны жишгийг харгалзан тусгасан зөвлдэгч, зөвлдүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

5.3. Сангийн асуудал хариуцсан нэгж нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдын шийдвэрийг үндэслэн төслийн зээл олгох аж ахуйн нэгж, иргэнтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийг төслийн үе шат бүрт олгох, эргүүлэн төлүүлэх, зээлийн гэрээг дүгнэж Сангийн зөвлөлд танилцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулна. Зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээг Сангийн асуудал хариуцсан нэгж аж ахуйн нэгж болон иргэн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Сангийн зөвлөлийн дүгнэлт, сайдын шийдвэргүйгээр аж ахуйн нэгж, иргэнд зээл олгохыг хориглоно.

6.2. Сангийн асуудал хариуцсан нэгж нь зээлдэгч аж ахуйн нэгж, иргэний гэрээгээр хүлээсэн үүргээноцтой зөрчсөн, төлбөрийн чадваргүй болсон, эд хөрөнгө зээмших найдваргүй болсон тохиолдолд түүнтэй холбогдсон маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ. Маргаан шийдвэрлэхтэй холбогдон сангаас гаргасан зардлыг зээлдэгч аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр **Дугаар 87** **Улаанбаатар хот**

Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Говийн бага дархан цаазат газрын "Б" хэсэгт хууль бусаар алт олборлосон үйл ажиллагаанд дүгнэлт хийж улсын тусгай хамгаалалттай газар нутагт дахин зөрчил гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн тохиолдолд цаг алдалгүй тасламж зогсоох, хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулах арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатар нарт үүрэг болгосугай.

2. Тусгай хамгаалалттайгаас бусад алтны орд бүхий газарт хууль бусаар алт олборлож буй зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Батбаатар, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Уул уурхайн үйлдвэрлэлд хэрэглэж буй тэсэрч, дэлбэрэх бодис, холбогдох хэрэгслийн ашиглалт, хадгалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

4. Хууль бусаар алт олборлосноос учирсан хохирлын хэмжээг тогтоож, холбогдох этгээдээр нөхөн төлүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд нарт үүрэг болгосугай.

5. Уул уурхайн орд, ашигт малтмалын нөөц бүхий бүс нутагт оршин суух байгаа ард иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу ашигт малтмалын олборлолт явуулах талаар төр, засгийн бодлого, шийдвэрийг сурталчлах ажлыг эрчимжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (356)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай*
- *Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны зургаадугаар сарын 14 №23 (356)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

277. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 536

278. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 540

279. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт,өөрчлөлт оруулах тухай 542

280. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай 543

281. Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай 546

282. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай 546

283. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 549

284. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай 549

285. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 549

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

286. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 30 550

287. Хуулиудын төслийг буцаах тухай Дугаар 31 550

288. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 32 550

289. "Энхийн төлөө" медаль бий болгох тухай Дугаар 33 550

290. Үнэт цаасны хорооны гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Дугаар 34 552

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

291. Паавангийн Дамдинд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 87 552

292. Нямын Ширнэндугарт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай Дугаар 88 552

293. Зарим багш нарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай Дугаар 89 553

294. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 90 553

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

295. Засвар, заавар батлах тухай Дугаар 88 557

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийллэтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлохтой холбогдсон харилцаат зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж

2.1.Гэр бүлийн хүчирхийллэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Эрүүгийн хууль[3], Гэр бүлийн тухай[4], Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль[5] энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

3.1.Энэ хуулийн зохицуулалтад Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн хамаарна.

3.2.Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс, түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд түүнтэй иргэний асрамжид байгаа этгээд нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим

4.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зарчимд үндэслэнэ.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1."гэр бүлийн хүчирхийлэл" гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.2."болзошгүй хүчирхийлэл" гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг;

5.1.3."хамгаалах байр" гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг;

5.1.4."хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт" гэж хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанаас үүссэн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохих хөтөлбөрийн дагуу явуулах сургалтыг;

5.1.5."хохирогчид үзүүлэх үйлчилгээ" гэж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь тур хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх ажиллагааг;

5.1.6."эрх хязгаарлах арга хэмжээ" гэж хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлагыг.

6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхиллийн хэлбэр

6.1. Энэ хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүрэг

[1] Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

[2] Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн

[3] Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

[4] Гэр бүлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 8 дугаарт

[5] Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 6 дугаарт нийтлэгдсэн

7 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

7.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи бодлого, хөтөлбөрийг батална, хэрэгжүүлэх;

7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгаж, Улсын Их Хуралд оруулах.

7.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах;

7.2.2.хамгаалах байранд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох.

7.3.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.3.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх тухай[6] хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах;

7.3.2.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлэж, мөрдүүлэх.

8 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

8.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.2.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;

8.1.3.хууль хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих;

8.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи цагдаагийн байгууллагын үүрэг

9.1.Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар дараахь үүрэг хүлээнэ:

9.1.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, буртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асуух,тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

9.1.2.энэ хуульд заасны дагуу хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлан өгөх;

9.1.3.хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах;

9.1.4.шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх;

9.1.5.шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах;

9.1.6.согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх;

9.1.7.хохирогчийг энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх;

9.1.8.хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;

9.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

[6] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

10 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нийгмийн ажилтны үүрэг

10.1.Нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

10.1.1.тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох;

10.1.2.хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж, энэ хуулийн 7.3.2-т заасан хөтөлбөрийн дагуу явуулах;

10.1.3.хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын туслалцаатайгаар явуулах;

10.1.4.хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи тайлан мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн холбоотой мэдээллийн сүлжээ бий болгоход оролцох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо

11 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо

11.1.Хохирогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах, хохирогчид үзүүлэх үйлчилгээ болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

11.2.Төрийн бус байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг дүрмийнхээ зорилгод нийцүүлэн явуулж болно.

12 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн төлөөлөгч

12.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

12.2.Итгэмжлэгдсэн төлөөлөгч дараахь эрх эдэлнэ:

12.2.1.хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах;

12.2.2.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл олж авах, судалгаа явуулах;

12.2.3.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаархи саналаа эрх бүхий байгууллагад оруулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ

13 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл

13.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

13.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа тухай цагдаагийн буюу нутгийн захиргааны байгууллагад мэдээлж болно.

13.3.Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд мэдээллээ цахилгаан холбоо, шуудан, мэдээллийн хэрэгслийг ашиглан өгч болно.

13.4.Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн байнга буюу түр оршин суугч байгаа, эсхүл хүчирхийлэл үйлдэгдсэн газрын, хэрэв хохирогч нь эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд болон хүчирхийлэл үйлдэгч нь энэ хуулийн 5.1.4-т заасан албадан сургалт явуулдаг байгууллагад байгаа бол уг байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хүлээн авч, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авна.

14 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаархи сум, багийн Засаг даргын үүрэг

14.1.Тухайн харьяалах нутаг дэвсгэртээ сум, багийн Засаг дарга гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

14.1.1.хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих;

14.1.2.шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл боломжтой

бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь төр хамгаалалтад өгөх;

14.1.3.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асуух, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах.

15 дугаар зүйл.Хохирогчийг хамгаалах арга, түүний нууцыг задруулахгүй байх талаар бусад этгээдийн хүлээх үүрэг

15.1.Хохирогчийг хамгаалах зорилгоор дараахь аргыг хэрэглэж болно:

15.1.1.хамгаалах байранд хүргэх;

15.1.2.эцэг, эх, төрөл, садны хүн, эсхүл хамт олны нь түр хамгаалалтад өгөх;

15.1.3.шаардлагатай гэж үзвэл хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх;

15.1.4.энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах.

15.2. Хохирогч нь эрх зүйн асуудлаар хууль зүйн туслалцаа авах, хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тэжээн тэтгүүлэх, эсхүл хууль тогтоомжийн дагуу эдийн болон эдийн бус гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

15.3.Нийгмийн ажилтан болон энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан этгээд зөвлөгөө өгөх явцдаа итгэмжлэлээр олж мэдсэн зүйлээ бусдад задруулахыг хориглоно.

15.4.Ажил үүргээ гүйцэтгэж байсантай холбоотой эсэхээс үл хамааран хамгаалах байрны байршлын талаар мэдсэн этгээд энэ тухай бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

16 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ

16.1.Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах зорилгоор дараахь арга хэмжээ авч болно:

16.1.1.тусдаа амьдрахыг даалгах;

16.1.2 хамгаалах байранд, эсхүл энэ хуулийн 15.1.3-т заасны дагуу өөр газарт байгаа хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох;

16.1.3.хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох;

16.1.4.асрамжиндаа байгаа насанд хүрээгүй хүнтэй харилцахыг түр хориглох;

16.1.5.зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах;

16.1.6.шаардлагатай гэж үзвэл согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан эмчилгээ хийлгэх, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан арга хэмжээ авагдсан этгээд хохирогчийг хуулийн дагуу асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

17 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр

17.1.Хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтны, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримтыг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай[7] хуулийн 82.1.8-д заасны дагуу гаргана.

17.2. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шүүх нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай гомдол хүлээн авсанаас хойш 24 цагийн дотор энэ хуулийн 16.1.1-16.1.5-д заасан арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж болно.

17.3.Энэ хуулийн 16.1-д заасан хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нь тохируулж нэг жил хүртэл хугацаагаар авч болно.

17.4.Талууд энэ хуулийн 17.1-д заасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй. Ийнхүү гомдол гаргасан явдал тухайн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаог зогсоох үндэслэл болохгүй.

17.5.Энэ хуулийн 17.1-д заасан шийдвэр нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар захиргааны эрчлийг хянан шалгах ажиллагаа явуулах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болон иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

17.6.Шүүх энэ хуулийн 17.1-д заасны дагуу шийдвэрээ гаргахдаа дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

17.6.1.хохирогчтой удаа дараа хэрцгий хандсан, заналхийлсэн, хүч хэрэглэсэн;

17.6.2.хүчээр бэлгийн харьцаанд оруулсан буюу оруулахыг завдсан;

17.6.3.хохирогчийг төрөл садан,

[7] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

хамт олноос нь тусгаарлаж, сэтгэл санааны хүнд даramтад оруулсан;

17.6.4.тэжээн тэтгэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн буюу хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан;

17.6.5.согтууруулах ундаа мансууруулах бодис байнга буюу удаа дараа хэрэглэж хохирогчийг айдас, түгшүүрт байдалд оруулсан;

17.1.6.гэр бүлийн хүчирхийллийн улмаас энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан эгтэгдийн хэн нэгний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй байгаа.

18 дугаар зүйл.Хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам

18.1.Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд үг шийдвэр хүчинтэй байх хугацаанд хохирогч өөрөө буюу насанд хүрээгүй болон иргэний эрх зүйн чадамжгүй хохирогчийн хувьд асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулж болно.

18.2.Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдсан бөгөөд зайлшгүй шаардлагаар насанд хүрээгүй эгтээдийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан уулзуулж болно.

18.3.Энэ хуулийн 18.1,18.2-т заасан уулзалтыг цагдаагийн эрх бүхий ажилтан зохион байгуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуульд дор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2^1 дугаар зүйл:

"2^1 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/"даатгуулагч" гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг;

2/"нийгмийн даатгалын байгуллага" гэж ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагаат эрхэлж байгаа хуулийн этгээдийг;

3/"нийгмийн даатгалын сан" гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг;

4/"нийгмийн даатгалын шимтгэл" гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг;

5/"нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа" гэж ажил олгогч болон даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг даатгалын санд шилжүүлсэн өдрийг;

6/"тэтгэвэрийн төрлийг сонгох эрх" гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзлын дагуу хоёр буюу түүнээс дээш төрлийн тэтгэврийн эрх нэгэн зэрэг үүсч байгаа даатгуулагч тэтгэврийн төрлийг сонгож, тэтгэвэр тогтоолгон авах эрхийг;

7/"шимтгэл төлөгч" гэж хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг хүлээсэн хуулийн этгээдийг;

8/"тэтгэвэр" гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл/-ийн нийгмийн баталгаат хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;

9/"тэтгэмж" гэж хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг;

10/"төлбөр" гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 буюу түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нөхөн олгох хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний үнэ, рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын газрын үйлчилгээний хувьсах зардлыг;

11/"рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллын газрын үйлчилгээний хувьсах зардал" гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагч сувиллын газар эмчлүүлэхэд гарсан зардлыг нөхөх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох төлбөрийг.".

2/ 26[1] дугаар зүйл:

"26[1] дугаар зүйл. Нийгмийн даатгалын байцаагчийн нийгмийн баталгаа, мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл

1.Нийгмийн даатгалын байцаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон, бусдын нөлөөгөөр амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дараахь буцалтгүй тусламжийг олгоно:

1/хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

2/тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

3/амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж.

2.Энэ хуулийн 26[1].1.3-т заасан буцалтгүй тусламжийг ажиллаж байсан байгууллага олгож, жуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

3.Нийгмийн даатгалын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байна. Мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар тогтооно.

4.Нийгмийн даатгалын байцаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгож болно. Нийгмийн даатгалын байцаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар тогтооно.

5.Нийгмийн даатгалын байцаагч нь үйлчилгээний онцлогт тохирсон ажлын тусгай хувцыг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Нийгмийн даатгалын байцаагчийн ажлын тусгай хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглээ журам, эдэлгээний хугацаа нийгмийн даатгалын төв байгууллага батална."

3/ 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5, 6 дахь заалт:

"4/энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн, даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэр нээж баталгаажуулаагүй, уг зөрчлийг улмаас даатгуулагчийн эрх ашгийг хохироосон албан тушаалтныг 10000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

5/нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, ашигласан бол хууль бус олсон орлого, зүйлсийг хурааж, албан тушаалтныг 5000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

6/даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацаа болон хөдөлмөрийн нөхцөлийг буруу тогтоосон албан тушаалтныг 10000-50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

4/26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7, 8, 9 дэх заалт:

"7/байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын байр, ажиллагчдын тоог цалингийн сан, төлсөн шимтгэлийн тооцоотой тулган шалгах;

8/ажиллагчдын тоог дарагдуулсан, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллуулсан, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин олгож байсан болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүйгээс өр үүсгэсэн, ажиллагчдын төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын санд хугацаанд нь оруулаагүй зэрэг зөрчил гаргасан албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, шаардлагатай бол хуулийн байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх;

9/нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ шалтгааны улмаас даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч хариуцна." гэсэн хоёр дахь өгүүлбэр, 4

дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "иргэн" гэсний дараа "хувиараа хөдөлмөр эрхлэх замаар" гэж, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хэзээ хахууль авах," гэсний дараа "ёс зүйн хэм хэмжээ зөрчих, мэдээллийн нууц задруулах," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйл, 7 дугаар зүйлийн хоёр дахь өгүүлбэр, 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ "31 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх

1.Нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг нийгмийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлнэ.

2.Нийгмийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлэх нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг санхүү, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр батална."

2/ 7 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр:

"Хэрэв давхардахаар байвал даатгуулагч илүү таатай нөхцөлтэй тэтгэвэр буюу тэтгэмжийг зөвхөн нэг удаа сонгон авах эрхтэй"

3/ 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/тогтоосон хугацаанд төлөөгүй шимтгэл болон нөхөн ногдуулсан шимтгэл, алданги, хүү, торгуулийг шимтгэл төлөгчөөс үл маргах журмаар гаргуулах;"

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "25000-50000 төгрөгөөр" гэснийг "иргэнийг 5000-30000, албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр" гэж, 26 дугаар зүйлийн 1дэх хэсгийн "3-аас доошгүй" гэснийг "2-оос доошгүй" гэж, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "4" дэх заалтын дугаарыг "7" гэж, хуулд "рашаан сувилал" гэснийг "рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилал" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг нийгмийн хамгаалал, болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно"

2/ 4 дүгээр зүйлийн 5, 6 дахь заалт:

"5/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл;

6/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын даатгуулагчийг сувилахад ногдох тусламж үйлчилгээний хувьсах зардал"

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага батална" гэсэн агуулга бүхий 2 дахь өгүүлбэр, мөн хэсгийн "үнийг" гэсний дараа "Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан" гэж, 16 дугаар зүйлд "хийлгэх" гэсний дараа "тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх" гэж, 17 дугаар зүйлийн 3 дах хэсгийн "сувилуулбал" гэсний дараа "рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих үнааны зардлыг" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир, дутуу болж Монгол Улсад хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопеди/ хийлгэсэн бол үнийг эхний удаад 100 хувь, цаашид нийгмийн даатгалын шимтгэл үргэлжлүүлэн төлж байгаа бол протез, ортопедийн эдэлгээний хугацаа дуусан тохиолдол бүрт үнийг бүрэн, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй бол хоёр дахь удаад үнийн 50

хувийг нийгмийн даатгалын байгууллага тус тус нөхөн төлнө."

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "олгоно" гэснийг "болон хуульд заасан бусад зардлыг санхүүжүүлнэ" гэж, мөн хуулийн "рашаан сувилал" гэснийг "рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилал" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУСЫН ХАЛДВАР, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтний үүрэг, иргэд, уг вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эрх, үүргийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомж

2.1. Хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмолын хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хүний дархлал хомсдолын вирус" гэж эвэхэн хүний биеийн дархлалын эсүүдийг гэмтээдэг вирус /ретровирус/-ыг;

3.1.2. "дархлалын олдмол хомсдол" гэж хүний биеийн дархлалын эсүүд гэмтэж, дархлалын тогтолцоо алдагдсанаар эмгэг, хам шинжүүд илрэхийг;

3.1.3. "хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх" гэж хүн амд хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол тархахад нөлөөлж буй нөхцөл, шалтгааныг арилгах, тархалтыг бууруулах, халдвар дамжих замыг таслан зогсоохоо чиглэсэн цогц арга хэмжээг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

4.1. Засгийн газар хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, хяналт тавих;

4.1.2. хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4.1.3. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүмүүс эрхэлж болохгүй ажил, үйлчилгээг тогтоох.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

5.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх асуудлыг боловсруулах, энэ талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. хүний дархлал хомсдолын

вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолтой холбогдсон албан ёсны мэдээ, мэдээллийг хариуцах;

5.1.3. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг бусдад халдаахгүй байх талаар уг вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүн болон түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, зааварчилгаа өгөх журмыг батлах.

6 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

6.1. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх, энэ талаархи сургалт, сурталчилгааны ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг оролцуулах, уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

6.2. Бүх шатны Засаг дарга хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг өөрийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

7 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

7.1. Эрүүл мэндийн байгууллага хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь үүргэтэй:

7.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх, магадлах, уг вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийг эмчлэх арга хэмжээ авах;

7.1.2. хариуцсан нутаг дэвсгэртээ оршин суугаа бөгөөд хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүн уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг бусдад халдаахгүй байх талаар түүнд болон түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, зааварчилгаа өгөх ажлыг зохион байгуулах;

7.1.3. зүү, тариур болон эмнэлгийн бусад багаж хэрэгслээр хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

7.1.4. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх шинжилгээ хийж баталгаажаагүй цус, цусан бүтээгдэхүүн, донорын эд эрхтэнийг эмчилгээний зориулалтаар хэрэглэхгүй байх.

7.2. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүн өөртөө хяналт тавих чадваргүйгээс энэ хуульд заасан үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд түүнийг тусгаарлаж эмчилнэ.

7.3. Энэ зүйлийн заалт өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад нэгэн адил үйлчилнэ.

8 дугаар зүйл. Эмч, эмнэлгийн мэргэжилт--ний үүрэг

8.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь үүргэтэй:

8.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлсэн, оношилсон тухайгаа харьяалах эрүүл мэндийн байгууллагад зохих журмын дагуу заавал мэдээлэх;

8.1.2. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүн биеэ хэрхэн авч явах, уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг бусдад халдаахгүй байх талаар түүнд болон түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, зааварчилгаа өгөх;

8.1.3. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүнд эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэхээс татгалзахгүй байх.

8.2. Энэ хуулийн 7.1.3-д заасан үүрэг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд нэгэн адил хамаарна.

9 дүгээр зүйл. Иргэний эрх, үүрэг

9.1. Монгол Улсын иргэн дараахь эрхтэй:

9.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх үзлэг, шинжилгээ, халдвар судлалын хяналт хийж байгаа эттэздээс уг үзлэг, шинжилгээ, хяналтыг хийх эрхтэй болохыг нь нотлох албан ёсны баримт бичгийг шаардах;

9.1.2. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх, магадлах эмнэлгийн үзлэг, шинжилгээнд сайн дураар хамрагдах;

9.1.3. хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын талаар үнэн зөв, бодит мэдээлэл олж авах, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос урьдчилан сэргийлэх аргад суралцах.

9.2. Монгол Улсын иргэн дараахь үүрэгтэй:

9.2.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос

сэргийлэх, тэмцэх талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд оролцох;

9.2.2. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсодолтой хүмүүсийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байх.

9.3. Энэ зүйлийн заалт тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон дамжин өнгөрөгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

10 дугаар зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалах

10.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хүний дархлалын олдмол хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эрх, эрх чөлөөг хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглоно.

10.2. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүнийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглоно.

10.3. Албан тушаалтан, иргэн хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийн талаарх мэдээллийг задруулахыг хориглоно.

11 дүгээр зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний үүрэг

11.1. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүн дараахь үүрэгтэй:

11.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой болсон нөхцөл, шалтгааны талаар эрүүл мэндийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгөх;

11.1.2. эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу заасан хугацаанд эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийлгэх;

11.1.3. эмнэлгийн тусламж авах бүртээ хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой тухайгаа эрүүл мэндийн байгууллагад заавал мэдэгдэх;

11.1.4. цус, бусад эд, эрхтэний донор байхаас татгалзах;

11.1.5. халдварыг бусдад тараахгүй байх, тараж болох аливаа үйлдлээс татгалзах, өөрийгөө болон бусдыг хамгаалах;

11.1.6. эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтнээс өгсөн зөвлөгөө, зааварчилгаог чанд сахин биелүүлэх;

11.1.7. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон бол энэ тухайгаа өөрийн эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчид нэн даруй мэдэгдэх.

11.2. Гадаадад оршин сууж байсан Монгол Улсын иргэн хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой болсон бол Монгол Улсад орж ирэхдээ улсын хилийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагад энэ тухайгаа мэдэгдэх үүрэгтэй.

11.3. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон гадаадын иргэн Монгол Улсын эрүүл мэндийн байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс зайлсхийвэл түүнийг хууль тогтоомжид заасны дагуу тус улсаас албадан гаргана.

12 дугаар зүйл. Хэвлэл, мэдээллийн болон шашны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо

12.1. Хэвлэл, мэдээллийн болон шашны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар хүн амын дунд зохиох сургалт, сурталчилгааны ажилд оролцоно.

13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

13.1. Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрүй бол сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

13.1.1. энэ хуулийн 7.1.3-ыг зөрчсөн бол аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 20000-50000 төгрөгөөр торгох;

13.1.2. энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 20000-50000 төгрөгөөр торгох;

13.1.3. энэ хуулийн 10 дугаар зүйлийг зөрчсөн бол иргэнийг 20000-50000, албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

13.1.4. энэ хуулийн 11 дүгээр зүйлийг зөрчсөн бол иргэнийг 20000-50000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр **Улаанбаатар хот**

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар тер, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж

2.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль[1], Эрүүгийн хууль[2], Эрүүгийн байцаан шийтгэх хууль[3], Иргэний хууль[4], Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль[5], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим

3.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь хууль дээдлэх, өмчлөгчийн эрхийг хамгаалах, олон нийтийн хүчинд түшиглэх, мал бухий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр малаа гэмт халдлагаас хамгаалах үүрэг хүлээх, төрийн байгууллага мал хулгайлах гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг зохион байгуулах зарчимд тулгуурлана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг

4 дүгээр зүйл.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт

4.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний салбар зөвлөл зохицуулна.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, мал бухий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ ажлыг зохион байгуулж болно.

5 дугаар зүйл.Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үүрэг

5.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1.харъяа нутаг дэвсгэртээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2.мал хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлан, арилгах арга хэмжээг зохион байгуулах;

5.1.3.мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийг

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.
[2] Эрүүгийн хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.
[3] Эрүүгийн байцаан шийтгэх хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.
[4] Иргэний хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
[5] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

татан оролцуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг туслалцаа үзүүлэх;

5.1.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа мал сүргээ хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

5.1.5.төв суурин газар, хүнсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож, мал, махны гарал үүсэлд хяналт тавих;

5.1.6.малыг им. тамга, зүсийн бүртгэл, өдрийн хариулга, шөнийн манаатай болгох, эргүүл, харуул ажиллуулах ажлыг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах, энэ хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжих;

5.1.7.шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагатай хамтран энэ хуулийн 7.1.1-д заасан им тамга, бүртгэлтэй тулгаж, хэсэгчилсэн бүюу ганцаарчилсан хяналтын тооллого явуулах;

5.1.8.бод малыг улсын хэмжээнд индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах ажлыг зохион байгуулах.

5.2.Энэ хуулийн 5.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

6 дугаарзүйл.Хууль хяналтын байгууллагын үүрэг

6.1.Хууль хамгаалах болон мэргэжлийн хяналтын байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг бүрэн илрүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.

7 дугаар зүйл.Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

7.1.Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

7.1.1.өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа малаа им тамга, бусад таних тэмдэгтэй болгох, бод малд зүсийн бүртгэл хөтлөх;

7.1.2.уламжлалт им тамгын зэрэгцээ бод малаа энэ хуулийн 5.1.8-д заасан индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах;

7.1.3.малаа байнгын хариулга, манаатай байлгаж хулгайд алдахгүй байх бусад арга хэмжээг орон нутгийн болон улирлын онцлог, боломжид тохируулан авах;

7.1.4.малыг бусдын өмчлөлд шилжүүлэх тохиолдолд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ авч, нэг бүрчилсэн бүртгэлийг гэрээнд хавсаргах.

8 дугаар зүйл.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

8.1.Мал, махны үйлвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

8.1.1. мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

8.1.2.мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх;

8.1.3.амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх;

8.1.4.мал, мах бэлтгэх ажлыг энэ хуулийн 5.1.5-д заасан цэгт хийх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр

9 дүгээр зүйл.Малыг бусдын өмчлөлд шилжүүлэхэд тавигдах шаардлага

9.1.Малыг зөвхөн Иргэний хуульд заасан холбогдох гэрээний үндсэн дээр бусдын өмчлөлд шилжүүлнэ.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан гэрээнд бусдын өмчлөлд шилжүүлж байгаа малын нэг бүрчилсэн бүртгэлийг хавсаргасан байна.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан бүртгэлд малын төрөл, нас, хүйс, им тамганы талаар тодорхой зассан байна.

10 дугаар зүйл.Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ

10.1.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргамал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, маханд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгоно.

10.2.Мал, мах бэлтгэх гарал үүслийн

гэрчилгээний загвар, олгох журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

11 дүгээр зүйл.Алдуул малыг бүртгэх, мэдээлэх

11.1.Нутгийн захиргааны байгууллага алдуул малыг бүртгэж, алдуул малын талаар цагдаагийн байгууллага болон олон нийтэд тогтмол мэдээлж байна.

11.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага алдуул малын талаар нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

11.3.Алдуул малыг өөрийн эзэмшилд байлган маллаж байсан этгээдэд Иргэний хуулийн 116, 117 дугаар зүйлд заасан урамшуулал олгоно.

12 дугаар зүйл.Отрын болон тууврын малд бүртгэл хөтлөх

12.1.Мал бүхий иргэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс өөр нэгжид түр хугацаагаар оторлох болон тууварлах, шилжин суурьших тохиолдолд тухайн малчин малдаа бүртгэл хөтөлнө.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлд малын төрөл, тоо толгой, нас, хүйс, зүс, им тамга, оторлох нутаг, хугацаа, оторлох, тууварлах буюу шилжин суурьших засаг захиргааны нэгжийг заах бөгөөд үг бүртгэлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга батламжилна.

13 дугаар зүйл.Мал тууврын зам тогтоох

13.1.Сум, дүүргийн нутаг дэвсгэрээр мал туувар дайран өнгөрөх орон нутгийн тууврын замын маршрутыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүсийн маршрутыг Бүсийн захирагч, бүс хоорондын маршрутыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Бүсүүдийн захирагч нартай хамтран тус тус тогтооно.

14 дүгээр зүйл.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах

14.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу урамшуулна.

15 дугаар зүйл.Мал хулгайлах гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах

15.1.Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд цагдаагийн байгууллага Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу мэдээлэл худалдаж авсны төлбөр олгоно.

15.2.Мэдээлэл үндэслэлтэй болох нь шүүхийн шийтгэх тогтоолоор нотлогдсон тохиолдолд хулгайд алдагдсан малын өмчлөгч нь буцаан олж авсан малын тоо толгойн бүюу хохирлоо нөхөн төлүүлсэн үнийн дүнгийн 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг мэдээлэгчид олгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт

16 дугаар зүйл.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сан

16.1.Энэ хуулийн 4.1-д заасан салбар зөвлөлийн дэргэд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тусгай сан байгуулж болно.

16.2.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батална.

16.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн дүрмийг орон нутгийн онцлогт тохируулан батална.

16.4.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх санд гадаад, дотоодын иргэд, байгууллагын тусламж, хандив болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлж болно.

16.5.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

16.5.1.мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд тогтоомжийг сурталчлах, энэ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах;

16.5.2.мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэж байгаа эргүүл, жижүүр, харуулыг урамшуулах;

16.5.3.мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

17 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрэгүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

17.1.1.гарал үүслийн гэрчилгээгүй мал, мах тээвэрлэсэн, тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн бол хууль бусаар бэлтгэсэн, тээвэрлэсэн мал, махыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох;

17.1.2.энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлгүйгээр мал тууварласан, оторлосон, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон мал туурын замаас өөр замаар мал тууварласан иргэнийг 30000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000 хүртэл төгрөгөөр торгох;

17.1.3.энэ хуулийн 8.1.3-т заасныг зөрчсөн иргэнийг 40000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000 хүртэл төгрөгөөр торгох.

18 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

18.1.Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 49.2-ын "хэрэгслийг" гэсний өмнө "тээвэрийн болон бусад ", 145.2-ын "үчирсан" гэсний дараа ",олон тооны мал хулгайлсан" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 71.1-ийг "Энэ хуулийн тусгай ангийн 145.1/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/-д зааснаас бусад хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно." гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25.1-ийг "Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145.1/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/-д зааснаас бусад хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн бөгөөд гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27.3-ын "145.2/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/ " гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зарим барааны ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсгийн Гаалийн татварын хэмжээ /төгрөгөөр/ "140" гэснийг "350" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 30** **Улаанбаатар хот**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н. Энхбаяр/-т даалгасугай:

1/гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор шүүгч, прокурор, цагдаагийн болон нийгмийн ажилтныг давтан сургах, ирэгний нийгмийн оролцоог өргөжүүлэх зорилгоор гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх;

2/хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Т.Ганди/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 31** **Улаанбаатар хот**

Хуулиудын төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхтэй холбогдсон харилцааг бие даасан хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзсэн тул Улсын Их Хурлын гишүүн Б. Долгор, Т.Ганди, Н.Гэрэлсүрэн нарын өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай,Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 32** **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Норматив тогтоох тухай" Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр **Дугаар 33** **Улаанбаатар хот**

"Энхийн төлөө" медаль бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:


1. НҮБ-ын энхийг сахиулах хүчин, олон улсын бусад ажиллагаанд оролцсон цэрэг, цагдаагийн албан хаагчид, энхийг сахиулах, хүмүүнлэгийн асуудлаар идэвхтэй ажиллаж, амжилт гаргасан гадаадын болон Монгол Улсын иргэнийг шагнах "Энхийн төлөө" медаль бий болгосугай.

2. "Энхийн төлөө" медалийн загварыг 1 дүгээр хавсралтаар , "Энхийн төлөө" медалийн тодорхойлолт, шагнах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИЙН ЗАГВАР



Монгол Улсын Их Хурлын 2004 оны 33 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ЭНХИЙН ТӨЛӨӨ " МЕДАЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ШАГНАХ ЖУРАМ

Нэг. "Энхийн төлөө" медалийн тодорхойлолт

1."Энхийн төлөө" медалийн үндсэн хэсэг нь алтан шар өнгийн 1 мм хүрээ бүхий 4 см-ийн голчтой бор шаргал өнгөтэй, дугуй хэлбэртэй байна. Медалийн тев хэсэг нь 2 см-ийн голч бүхий дэлхийн бөмбөрцгийг Евро-Азийн талаас нь товойлгон дүрсэлсэн, түүнийг тойрсон 3 см-ийн голч бүхий 1 мм-ийн өргөн алтан шар хүрээ байна.

2.Дэлхийн бөмбөрцгийн дээд хэсэгт алтан шар өнгөөр товойлгон дүрсэлсэн соёмботой байна.

3.Бамбайн доод хэсэгт хоёр хүрээний хооронд "Энхийн төлөө" гэсэн үгийг шар өнгөөр кирилл монгол үсгээр товойлгож бичсэн байна.

4.Медалийн зүүлтийн хэсэг нь 30х25 мм-ийн хэмжээтэй, 2.5 мм-ийн өргөн алтан шар өнгийн хүрээтэй, хөх цэнхэр өнгийн суурьтай, гурвалжин хэлбэртэй байх бөгөөд дундаа 2.5 мм-ийн өргөн хоёр эгнээ шар зураастай байна.

5.Медалийг зүүлттэй нь алтан шар өнгийн гархиар холбоно, зүүлтийн ар талд хувцсанд тогтоох зүүтэй байна.

Хоёр: "Энхийн төлөө" медалийн бэлгэдлийн тайлбар

1."Энхийн төлөө" медалийн үндсэн суурь нь Монгол цэргийн уламжлалт эртний бамбайн хэлбэрийг дүрсэлсэн, уг бамбай нь халдах дайсан, хар санаат халхлан хамгаалах гэсэн утгыг илэрхийлнэ.

2.Бамбайн тев хэсэгт дэлхийн бөмбөрцгийг байрлуулсан нь дэлхий ертөнцийг энхийн үйлсээр хамгаална гэсэн утгыг тодорхойлно.

3.Бамбайн дээд хэсэгт төрийн алтан соёмбо тэмдгийг байрлуулсан нь Монгол төрийн цэрэг гэсэн утгыг агуулна.

4.Бамбайн доод хэсэгт "Энхийн төлөө" гэж алтан шар өнгөөр кирилл монгол үсгээр товойлгон бичсэн нь дэлхий ертөнцийн энх амгалан сайн сайхны төлөө тэмцэгч гэсэн утгатай үг болно.

5.Медалийн зүүлтийн гурвалжин хэлбэр нь өнө мөнхөд тогтвортой байх гэсэн утгыг илэрхийлнэ.

6.Зүүлтийн гурвалжны өнгө нь цэлмэг хөх тэнгэрийг, хоёр хос шар зураас нь одоо ба ирээдүйг бэлгэдсэн байна.

Гурав: "Энхийн төлөө" медалиар шагнах журам.

1."Энхийн төлөө" медалийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ыг үндэслэн НҮБ-ын энхийг сахиулах хүчин, олон улсын бусад ажиллагаанд оролцсон цэрэг, цагдаагийн албан хаагчид, энхийг сахиулах, хүмүүнлэгийн асуудлаар идэвхтэй ажиллаж, амжилт гаргасан гадаадын болон Монгол Улсын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгоно.

2."Энхийн төлөө" медалиар шагнуулах тухай тодорхойлолтыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.Шагнагдах хүмүүсийн материалыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр | **Дугаар 34** | **Улаанбаатар хот**

Үнэт цаасны хорооны гишүүнийг чөлөөлөх, томилох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Энхбаярыг Үнэт цаасны хорооны гишүүнээр томилсугай.

Гадаадад удаан хугацаагаар ажиллах болсон тул Содномын Ганболдыг Үнэт цаасны хорооны гишүүнээс чөлөөлж, Намжилдоржийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 87** | **Улаанбаатар хот**

Паавангийн Дамдинд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Төрийн болон төрийн бус байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын аж үйлдвэржүүлэх бодлогыг боловсруулж амьдралд хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах үйлст оруулсан дорвитой хувь нэмрийг нь үнэлж үйлдвэр худалдааны "Говь" ХК-ийн зөвлөх Паавангийн Дамдинд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 88** | **Улаанбаатар хот**

Нямын Ширнэндугарт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай

Төмөр замын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохицуулах хариуцлагатай үүргийг амжилттай гүйцэтгэж, тээврийн төлөвлөгөөт зорилт, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар төмөр замын Улаанбаатар өртөөний сэлгээний зохицуулагч Нямын Ширнэндугарт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 89** **Улаанбаатар хот**

Зарим багш нарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд багшаар олон жил үр бүтээлтэй ажиллаж заах аргын ур чадвар, сургалтын чанарыг дээшлүүлэн, өсвөр үеийнхэнд боловсрол эзэмшүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан багш нарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

1. Жамцын Баасанжав - Орхон аймгийн Баян-Өндөр сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн биологийн багш

2. Дагвахүүгийн Нямсүрэн -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн бага ангийн багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 90** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, банк, радио, соёл урлаг болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Голиминсээгийн Шилагарди
МУИС-ийн Физик, электроникийн сургуулийн физикийн салбарын эвлэлөх профессор

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР :

1.Сономын Адъяа
Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын Тамгын газрын дарга

2.Бэгзжавын Алтангэрэл
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр дунд сургуулийн математикийн багш

3.Чимэдийн Баатар
Дамжуулах байгууламж, радио, телевизийн техникийн төвийн харъяа УКВ станцын ерөнхий инженер

4.Баатарын Бадамханд
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сүрьеэгийн тандалт судалгааны албаны гэрлийн их эмч

5.Дэнсмаагийн Баяр
Монгол шуудан банкны дэд захирал

6.Лхамсүрэнгийн Бордух
Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ерхийн эмч

7.Жагваралын Буд
Өмнөговь аймгийн Даланзадгад сумын “Говийн оргил” хоршооны эзэн

8.Абзодын Буйдахмет
Монголын үндэсний радиогийн “Хурд” ажентлагийн хариуцлагатай редактор

9.Товуучийн Бямбадорж
Монголын үндэсний радиогийн нийгэм, эдийн засаг, бизнесийн албаны тоймч

10.Пүрэвдагвын Бямбасүрэн
“Капитрон” банкны Зээлийн эдийн засгийн газрын захирал

11.Пүрэвсүрэнгийн Гочоо
Булган аймгийн Орхон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

12. Нятжавын Даваажав
Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын захиргаа, аж ахуйн албаны дарга

13.Дэжидийн Дамдин
Хөвсгөл аймгийн Их-Уул сумын 10 жилийн дунд сургуулийн математикийн багш

14.Лувсандоржийн Дамдинсүрэн
Төв аймгийн Аргалант сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

15.Цэрэнгийн Дамдинсүрэн
Улаанбаатар төмөр замын Улаанбаатар өртөөний ачааны зохицуулагч

16.Гочоогийн Дармаа
Завхан аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан, ахмад шүүгч

17.Түнтүүгийн Дарьсүрэн
Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар багт малчин

18.Шаарийбуугийн Дирваа
"Монгол шуудан" ХХК-ийн Улаанбаатар хот дахь холбооны 21 дүгээр салбарын эрхлэгч

19.Төмөрдөөгийн Дуламжав
Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн газар зүйн багш

20.Дондогжанцангийн Дуламхүү
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сурьеэгийн клиникийн хүүхдийн тасгийн эрхлэгч

21.Лочингийн Дэнсмаа
Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн хүүхдийн их эмч

22. Намхайдоржийн Ёндон
МУИС-ийн Математик компьютерийн сургуулийн алгебрын тэнхмийн багш

23.Дамбажамцын Жамъянсүрэн
Клиникийн 3 дугаар нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч

24.Равдангийн Лутаа
Нийслэлийн "Тахько" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

25.Маслов Валерий Иванович
Улсын клиникийн төв эмнэлгийн дүрс оношлогооны тасгийн дурангийн багийн ахлагч,их эмч

26.Хөхийн Монхоо
Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 13 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш

27.Сүрэнгийн Мөөмөө
Улаанбаатарын их сургуулийн хэл утга зохиолын факультетийн багш

28.Дэмчигдоржийн Мягмарсүрэн
Монголын үндэсний радиогийн редактор

29.Лувсандоржийн Насанбат
Улаанбаатар төмөр замын Улаанбаатар суудлын вагон депогийн орлогч дарга

30.Жанцансамбуугийн Нацагдорж
Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёлын газрын орлогч дарга

31.Дамбаравжаагийн Олзод
Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор дунд сургуулийн газар зүйн багш

32. Далхсүрэнгийн Оюун
Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

33.Цэдэн-Очирын Пагмажав
Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолборын 1 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

34.Чүлтэмийн Пэрэнлэй
Хүнс, хөдөө аж ахуйн ямны хөдөө аж ахуйн сангийн хэлтсийн дарга

35.Сүрэнгийн Сандагдорж
Монголын үндэсний радиогийн гадаад мэдээний хариуцлагатай редактор

36.Ёндонгийн Санжмаа
Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн механикч

37.Баттогтохын Содномбалжир
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 44 дүгээр дунд сургуулийн сургалтын менежер

38.Ядамжавын Сумъяа
МОНЦАМЭ агентлагийн дотоод мэдээллийн газрын дарга, "МОНЦАМЭ" сэтгүүлийн эрхлэгч

39.Кызылын Төлөөгөн
Улаанбаатар төмөр замын материал техникээр хангах баазын дарга

40.Лантуугийн Хандсүрэн
Техник-технологийн коллежийн боловсон хүчин, бичиг хэргийн эрхлэгч

41.Аюушийн Хашбаатар
МУИС-ийн Математик, компьютерийн сургуулийн математикийн дидатик,геометрийн тэнхмийн багш

42.Түвдэнгийн Хишигжаргал
Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн математикийн багш

43.Лодоншаравын Цэвэлмаа
Улсын клиникийн төв эмнэлгийн радио химийн их эмч

44.Цэвэгжавын Цэвээн
МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн менежментийн тэнхмийн багш

45.Өлөгчөөгийн Цэдэндамба
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын хэлтсийн дарга

46.Чимэдцэрэнгийн Цэдэн-Иш
Нийслэлийн "Цэ энд Пү" эрэгтэйчүүдийн хувийн эмнэлгийн захирал

47.Үржингийн Цэрэндэжид
Улаанбаатар төмөр замын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

48.Ханагатын Цэрэг
Ховд аймгийн Ховд сумын 10 жилийн дунд сургуулийн захирал

49.Бираагийн Цэрэннадмид
Увс аймгийн Өндөрхангай сумын хүний эмнэлгийн хүүхдийн их эмч

50. Дэмидийн Цэрэнханд
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолборын 2 дугаар дунд сургуулийн түүх, эрх зүйн багш

51.Батаагийн Чанцалдулам
Улаанбаатар төмөр замын Дуу, бүжгийн чуулгын гоцлол хөгжимчин

52.Агваанхандын Чойдорж
Улаанбаатар төмөр замын боловсон хүчин,үйлчилгээний албаны тэргүүлэх инженер

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

Хавтгайн Дамжин
- Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн гал унтраах 28 дугаар ангийн захирагч, дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Самбуугийн Алтангэрэл
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 87 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

2.Сандагдоржийн Алтанцэцэг
Дамжуулах байгууламж, радио телевизийн техникийн төвийн радио нэвтрүүлэх төв станцын ээлжийн ахлагч

3.Дамдинпүрэвийн Амаржаргал
Монголын үндэсний радиогийн "Хурд" агентлагийн хариуцлагатай редактор

4. Цэрэвийн Амраа
Увс аймгийн Хөгжимт драмын театрын хөгжмийн багш

5.Дэлгэгийн Баасгай
Улаанбаатар төмөр замын барилга үйлдвэрлэлийн нэгдлийн дарга

6.Дашдэлгэгийн Баатарчулуун
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолборын 2 дугаар дунд сургуулийн орос хэлний багш

7.Осорын Баасанжав
Хөвсгөл аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн инженер багш

8.Осорын Бадарч
Дамжуулах байгууламж, радио телевизийн техникийн төвийн цахилгааны инженер

9.Батын Балдир
Архангай аймгийн Эрдэнэмандал сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

10.Далхаагийн Бариваан
Дамжуулах байгууламж, радио телевизийн техникийн төвийн харъяа УКВ станцын инженер

11.Сэрээнэндоржийн Батбаяр
ХААН банкны "Баруун хүрээ" салбарын захирал

12. Элбэгийн Батдорж
Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн зөвлөх эмч

53. Довдондоржийн Чойжилсүрэн
Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын зөвлөх, их эмч

54. Чагдагийн Энхтунгалаг
Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 10 жилийн дунд сургуулийн захирал

13.Бямбын Баттулга
Дундговь аймгийн Луус сумын мал эмнэлэг,үржлийн албаны "Салхит" ХК-ийн захирал

14. Тонгошийн Баярмагнай
Дамжуулах байгууламж, радио телевизийн техникийн төвийн харъяа Говь-Алтай аймаг дахь радио өргөн нэвтрүүлэх станцын техникч

15. Цэрэнпунцагийн Болдбаатар
Үндэсний архивын газрын ерөнхий нягтлан бодогч

16. Батсүхийн Боролзой
Дамжуулах байгууламж, радио телевизийн техникийн төвийн харъяа Өмнөговь аймаг дахь радио өргөн нэвтрүүлэх станцын ээлжийн ахлагч

17.Гомпилын Буд
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын төвийн үйлдвэрийн "Цацрал" чуулгын хөгжимчин

18.Дондоын Бумцэнд
Улаанбаатар төмөр замын Дархан татах хэсгийн машинч

19.Шүнхэйн Галсандорж
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 3 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

20. Жамъянгийн Ганбат
"Голомт" банкны дотоод хяналтын хэлтсийн захирал

21. Ёнзонгийн Ганчимэг
"Капитрон" банкны 1 дүгээр салбарын эдийн засагч

22.Лхамжавын Гэрэлмаа
Дамжуулах байгууламж, радио телевизийн техникийн төвийн аймаг дахь радио өргөн нэвтрүүлэх станцын дарга

23.Сийсаагийн Даваа
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 44 дүгээр дунд сургуулийн физик, математикийн багш

24.Чойжамцын Дашцэрэн
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн ажилчин

25. Хасын Доржмаа
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

26. Цэрэндоржийн Дуламсүрэн
Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

27.Дамдингийн Дүгэр
Капитал банкны зээлийн хэлтсийн захирал

28. Самбуугийн Дүгэрсүрэн
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 33 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

29. Санжмятавын Дэлгэр
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 119 дүгээр цэцэрлэгийн багш

30. Төлеубайн Ерен
Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цагаан Арал багийн бага эмч

31.Лүнбэнгийн Жанцандорж
Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны улсын байцаагч

32. Гозгорын Лхагвасүрэн
Улсын клиникийн төв эмнэлэгийн мэс заслын клиникийн ахлах сувилагч

33.Чойжилын Лхамсүрэн
Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

34.Цэрэндоржийн Минжүүр
Улсын клиникийн төв эмнэлгийн дотрын их эмч

35.Самбуугийн Мөнхдэлгэр
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

36.Цэвэлийн Мягмарсүрэн
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 105 дугаар дунд сургуулийн монгол хэлний багш

37.Чимэддоржийн Нарантуяа
Улаанбаатар төмөр замын Зүүнхараа нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч

38.Чогсомжавын Намжин
Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөлийн 10 жилийн дунд сургуулийн бага ангийн багш

39.Магвандоржийн Нансалмаа
Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн орос хэлний багш

40.Шаравдоржийн Норжмаа
Кредит банкны Дархан-Уул аймаг дахь салбарын 13 дугаар тооцооны төвийн эрхлэгч

41.Чимэддоржийн Нэргүй
Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч

42.Дамдингийн Нядаанороов
Улаанбаатар төмөр замын зам засварын машинт станцын сантехникийн механикч

43.Дамдинсүрэнгийн Нямаа
Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан

44.Дамдинсүрэнгийн Ордос
Улаанбаатар төмөр замын Барилга орон сууцны 1 дүгээр ангийн Орхонтуул хэсгийн уурын зуухны мастер

45. Цэрэннадмидын Оюунбаатар
Түлш, эрчим хүчний ерөнхий газрын түлшний албаны инженер

46.Ванганы Оюунгэрэл
Худалдаа, хөгжлийн банкны тооцооны 3 дугаар төвийн эрхлэгч

47. Норовын Оюундэлгэр
Улсын клиникийн төв эмнэлгийн цус, булчирхайн клиникийн тасгийн эрхлэгч, их эмч

48.Шаравын Оюунсүрэн
Монголбанкны мөнгөн тэмдэгтийн хэлтсийн хянагч

49.Лхасүрэнгийн Пагма
Худалдаа хөгжлийн банкны Сэлэнгэ аймаг дахь салбарын ахлах нярав

50.Мятавын Пүрэвдорж
Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөлийн 10 жилийн дунд сургуулийн математикийн багш

51. Өлзийбатын Пүрэвхүү
Улсын клиникийн төв эмнэлгийн цус, булчирхайн клиникийн ахлах сувилагч

52.Банзарын Сарангэрэл
Үндэсний статистикийн газрын макро эдийн засаг, бизнес статистикийн газрын ахлах мэргэжилтэн

53.Пүрэвийн Соёлдэлгэр
Монголын үндэсний радиогийн уран зохиол, урлаг соёлын албаны редактор

54.Дамдингийн Тавхар
Булган аймгийн Хиших-Өндөр сумын 10 жилийн дунд сургуулийн хими, биологийн багш

55.Дугараагийн Туяа
Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг дарга

56.Цэрэнтулгын Түмэнбаяр
Утга зохиол, нийгмийн ажилтны дээд сургуулийн багш, зохиолч

57.Чулууны Хоролсүрэн
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн ажилчин

58.Жанцангийн Цогзолмаа
Улаанбаатар төмөр замын Улаанбаатар суудлын вагон депогийн вагоны үйлчлэгч

59.Сэнгээрэйн Цэвэгжав
Монголын үндэсний радиогийн инженер

60.Лаганы Цэгмид
Хөвсгөлд аймгийн Мөрөн сумын 5 дугаар багийн Засаг дарга

61.Батмөнхийн Цэрэндорж
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 67 дугаар дунд сургуулийн математикийн багш

62.Лувсангийн Цэцгээ
Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн мэс заслын ахлах сувилагч

63.Батсуурийн Цэцэгмаа
"Анод" банкны дотоод хяналтын газрын захирал

64.Шаравын Цэдэвдолгор
- Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын авто тээврийн хяналтын улсын байцаагч

65.Чүлтэмийн Чулуунцэцэг
ХААН банкны Дархан-Уул аймаг дахь салбарын захирал

66.Лувсангийн Шархүү
Улаанбаатар төмөр замын Сайншанд татах хэсгийн илчит тэрэгний машинч

67.Галсансамбуугийн Шархүүхэн
Нийслэлийн Хан-Уул дүүргийн 72 дугаар цэцэрлэгийн багш

68. Мажиграгчаагийн Шашмаа
ХААН банкны Сүхбаатар аймгийн Онгон сум дахь тооцооны төвийн эрхлэгч

69.Хиланбайн Шилдебай
Ховд аймгийн Ховд сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

70.Бадарчийн Янжин
"Капитал" банкны ахлах нягтлан бодогч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 88** **Улаанбаатар хот**

Загвар, заавар батлах тухай

Улсын Их Хурлын 2004 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам"-ын 3.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах нийтлэг загварыг 1 дүгээр хавсралт, загварыг ашиглахад баримтлах зааврыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Загвар, зааврыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Нийтлэг загвар, зааврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2004 оны 88 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗАГВАР

.....

(БАЙГУУЛЛАГЫН НЭР)

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 20... ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ, 20...-20... ОНЫ ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

.....

(аймаг, хотын нэр)

20... оны ... сар

1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

.....

.....

.....

.....

.....

.....-ИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

(БАЙГУУЛЛАГЫН НЭР)

.....	.....	.....
(албан тушаал)	(гарын үсэг)	(овог, нэр)

200... оны... сарын ...-ны өдөр

2. ТАНИЛЦУУЛГА

2.1..... ийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал
(Салбарын нэр)
(..... аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал)
(Аймгийн нэр)

. . . . . .
. . . . . .
. . . . . .
. . . . . .
. . . . . .

2.2. 20... оны үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээ,
20...-20... оны хөгжлийн хандлагын талаархи танилцуулга

2.2.1. 20... оны үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний тухай

. . . . . .
. . . . . .
. . . . . .
. . . . . .
. . . . . .

2.2.2. 20...-20... оны хөгжлийн хандлага, бодлогын зорилт

. . . . . .
. . . . . .
. . . . . .
. . . . . .
. . . . . .

3. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 20... ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАХ БОДЛОГЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МАТРИЦ

БОДЛОГЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР	ХУГАЦАА (улирлаар)	ЗАРДАЛ: -Эх үүсвэр - Хэмжээ, сая төгрөг	БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭЭД ХУРЭХ УР ДҮН
1.Бодлогын зорилт				
1.1-Арга хэмжээ				
1.2-Арга хэмжээ				
1.3-Арга хэмжээ				
1.4-Арга хэмжээ				
...				
2.Бодлогын зорилт				
2.1-Арга хэмжээ				
2.2-Арга хэмжээ				
2.3-Арга хэмжээ				
...				

4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨТӨЛБӨР, ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХӨРӨНГӨ САНХҮҮГИЙН ХУВЬД ХҮНДРЭЛТЭЙ БАЙГААГААС ТАСАРЧ БОЛЗОШГҮЙ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

д/д	Арга хэмжээ	Хөтөлбөр, төсөлд туссан байдал	Шаардагдах хөрөнгө, (сая төгрөг)	Хэрэгжүүлсэн байх эцсийн хугацаа	Гарах үр дүн
1.					
2.					
3.					
...					

5. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжилтийн хуваарь, сая төгрөгөөр						Төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт
		200... оны гүйцэтгэл	*200... оны ХБГ*	*20...оны төсөл*	*20... оны төсөөлөл*	*20... оны төсөөлөл*	*20... оны төсөөлөл*	
1.								
2.								
...								
	Дүн							

Засгийн газрын 2004 оны 88 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗАГВАРЫГ АШИГЛАХАД БАРИМТЛАХ ЗААВАР

1. ЗААВРЫН ЗОРИЛГО

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл боловсруулах нийтлэг загварын дагуу Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад энэхүү зааврыг баримтлах бөгөөд энэхүү заавар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас боловсруулж ирүүлсэн Үндсэн чиглэлийн төслийг хянан, хүлээж авах үндэслэл болно.

2. ЗАГВАРЫН НИЙТЛЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ

Загварт нийтлэг ашиглагдсан тэмдэглэгээнүүдийг дараахь байдлаар ойлгоно: Үүнд:

-"20... оны гүйцэтгэл" гэдэгт Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа тухайн оны өмнөх оныг ойлгоно. Тухайлбал Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг 2004 онд боловсруулах ба боловсруулж байгаа жил нь 2004 он, түүний өмнөх жил нь 2003 он болно. Тиймээс "2003 оны гүйцэтгэл" гэж ойлгоно.

-"20... оны ХБГ" гэдэгт үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг ойлгоно. Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа бол "2004 оны ХБГ" гэж ойлгоно.

-20...оны Үндсэн чиглэл эсвэл 20... оны төсөл гэдэгт Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа оны дараахь он буюу Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх оныг ойлгоно.

-"20...-20...оны төсөөлөл" эсвэл "20...-20... оны хөгжлийн хандлага" гэдэгт дунд хугацааны буюу ойрын ирээдүйг ойлгоно. Энэ нь 3 жил байх ба Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх оны дараагийн 3 жил юм.

Тухайлбал Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа бол тэмдэглэгээг "2006-2008 оны төсөөлөл" эсвэл "2006-2008 оны хөгжлийн хандлага" гэж үзнэ.

-"байгууллагын нэр" гэдэгт төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын нэрийг бичнэ. "Эрүүл мэндийн яам", "Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар" гэх мэт

-"салбарын нэр" гэдэгт тухайн төрийн захиргааны төв байгууллагад харьяалагдах салбарын нэрийг бичнэ. Тухайлбал Эрүүл мэндийн яамны хувьд "Эрүүл мэндийн салбарын" гэх мэт.

3. ЗАГВАРЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдэгдэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдэгдэл нь салбар болон орон нутгийн хэмжээнд боловсруулсан Үндсэн чиглэлийн төслийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан тухай мэдэгдэл юм. Энэхүү мэдэгдэлд төсвийн ерөнхийлөн захирагчийн дараа жилийн үр дүнгийн гэрээнд үндсэн чиглэлд тусгагдах бодлогын зорилт, арга хэмжээний матрицад оруулсан зорилтуудыг хэрхэн тусгагдахыг бичнэ. Мөн бодлогын хувьд тухайн салбар болон орон нутагт (үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх жилд) авч хэрэгжүүлэх гол зорилтыг тодорхойлж тусгана.

2. Танилцуулга

Энэ хэсэг нь аймаг, нийслэлийн эсвэл салбарын хөгжлийн байдал болон боловсруулсан

үндсэн чиглэл, дунд хугацааны хөгжлийн хандлагын талаархи мэдээллийг багтаасан байна.

2.1 дүгээр хэсэг Танилцуулгын 2.1 буюу нэгдүгээр хэсгийг бичихдээ аймаг, нийслэлийн хувьд тухайн орон нутгийн хөгжлийн байдлыг, бүс нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийн талаар бичнэ. Харин төрийн захиргааны төв байгууллагууд буюу яамдын хувьд өөрсдийн харьяалах салбарынхаа хөгжлийн байдлыг гаргаж бичнэ. Өнөөгийн байдлыг бичихдээ салбарын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийн өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан бичнэ.

Мөн энэ хэсэгт тухайн салбарт болон орон нутагт өмнөх онуудад авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, түүний үр дүн, мөн улсын хэмжээнд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ нь тухайн салбарт, орон нутагт хэр үр дүнгээ өгсөн, эсвэл үр дүнгүй болсон тухай түүний шалтгааныг авч үзэж дэлгэрэнгүй дүгнэлт өгч бичнэ.

2.2 дүгаар хэсэгт үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний матрицыг танилцуулан бичих ба ингэхдээ үндсэн чиглэлийн бодлого, арга хэмжээний матрицад тусгагдсан зорилт тус бүрийн тухайн аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжил эсвэл салбарын хөгжилд хэрхэн нөлөөлөхийг зорилтот үзүүлэлтүүдийн хүрээнд тодорхойлон бичнэ.

Мөн энэ хэсэгт дунд хугацааны зорилтыг товч тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэх арга замыг томъёолж өгнө. Дунд хугацааны бодлогын зорилтууд нь Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын ядуурлыг бууруулах стратеги, дунд хугацааны бодлогын бусад баримт бичгүүдэд суурилсан байх шаардлагатай.

Тухайн салбарын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн тайлбарыг бичихдээ зураг, диаграмм, харьцуулалт, хүснэгтээр илэрхийлэхийг эрмэлзэх хэрэгтэй.

3. Эдийн засаг, нийгмийг 20... онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний матриц

3.1. Бодлогын зорилт, арга хэмжээ

а/ Бодлогын зорилт гэдэг нь тухайн салбарын эсвэл бүс нутаг, орон нутгийн хүрээнд чухал ач холбогдолтойд тооцогдон, тухайн жилд хүрэхээр төлөвлөж байгаа ерөнхий үр дүн юм. Тухайн жилийн бодлогын зорилт нь Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын ядуурлыг бууруулах стратеги, бусад батлагдсан хөтөлбөр, төсөлд байгаа бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц болохоор байх бөгөөд хяналт хийдэхүйц үр дүнгийн үзүүлэлтүүдийг агуулсан байх шаардлагатай. Бодлогын зорилт нь төрийн захиргааны төв болон нутгийн захирганы байгууллагын тухайн жилийн үр дүнгийн гүрээнд тусгагдах бүтээгдэхүүнээр илэрхийлэгдэж байх чиглэлийг түлхүү барьж тодорхойлогдоно.

б/ Арга хэмжээ гэдэг нь бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд тухайн жилд хийгдэх гол ажлууд юм. Арга хэмжээ нь эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл боловсруулж батлуулах, УИХ, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, бодлогын зорилгод нийцсэн зохион байгуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн зорилтот хэмжээг хангах хэлбэртэй байна.

Арга хэмжээнүүдийг ач холбогдлын түвшин, хэрэгжүүлэх хугацааны дараалаар нь эрэмбэлэн төсөв, хөрөнгө бусад эх үүсвэр, зохион байгуулалттай уялдуулан сонгож үндэсэн чиглэлийн төсөлд тусгана. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээнээс Засгийн газрын хөтөлбөрт туссан онцгой ач холбогдолтойг нь салган багцалж Үндэсн чиглэлийн бодлого, арга хэмжээний матрицад тусгаж болно.

Үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний матрицыг боловсруулахдаа Үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмын 6 дугаарт заасан бүтэц, агуулгыг баримтална.

Бодлогын зорилт арга хэмжээний жишээ:

Бодлогын зорилт: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтын хэрэгжүүлэх хүрээнд хөдөөгийн малчин өрхийг сэргээдэх эрчим хүчээр хангана.

Арга хэмжээ 1: Хямд, удаан эдэлгээтэй, найдвартай ажиллагаа бүхий нарны зайн импортыг нэмэгдүүлж, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар малчин өрхийг нарны зайн эрчим хүчээр хангана.

Арга хэмжээ 2: Малчдад нарны зай, салхин сэнс нийлүүлэх, худалдах, гэрээгээр олгох тогтолцоог бүрдүүлнэ.

Арга хэмжээ 3: Сэргээгдэх эрчим хүчний сүүлийн үеийн бусад эх үүсвэрүүдийг судлан, гадаад орнуудаас хямд нийлүүлэх боломжийг судалж шийдвэрлэнэ.

3.2. Үндэслэл тайлбар

Энэ хэсэгт тухайн арга хэмжээ тус бүрийг ямагт бодлогын матрицад оруулах болсон шалтгааныг бичнэ. Ер нь бодлогын арга хэмжээ бүр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад батлагдсан төсөл хөтөлбөрт тусгагдсан байх шаардлагатай. Үндэслэл тайлбар хэсэгт яг ямар төсөл, хөтөлбөрт туссаныг тодорхой бичих ба хэрэв батлагдсан төсөл, хөтөлбөрт тусгагдаагүй зорилт арга хэмжээг оруулж байгаа бол зайлшгүй оруулах болсон шалтгааныг бичнэ.

3.3. Зардал

а/ Эх үүсвэр. Арга хэмжээнүүдийн хөрөнгийн эх үүсвэр төсвийн хүрээний мэдэгдэл, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр батлагаажсан байх шаардлагатай ба арга хэмжээний эх үүсвэр гэсэн баганад эдгээрийн алинаар нь санхүүжигдэхийг доорхи ангиллын дагуу тодорхой бичиж өгнө:

-төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан санхүүжигдэх

-гадаадын хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэх

-гадаадын буцалтгүй тусламжаар санхүүжих

-тусгайлан зардал шаардагдахгүй үйл ажилагааны зардлаар санхүүжигдэх

б/ Зардлын хэмжээ. Төлөвлөсөн зардлын мөнгөн дүнг тавьж өгнө.

3.4. Арга хэмжээг хэрэгжүүлээд хүрэх үр дүн

Арга хэмжээг хэрэгжүүлээд гарах үр дүн хэсэгт тухайн арга хэмжээний эцсийн үр дүнг тодорхой үр дүнгийн үзүүлэлтээр тайлбарлах эсвэл батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үзүүлэх ач холбогдлыг нь гаргаж харуулна.

4. Хөрөнгө, санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаагаас татаруу болзошгүй арга хэмжээний жагсаалт

Энэ хүснэгтэд шийдвэрлэх шаардлагатай боловч зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн боломжгүй байдлаас болоод хугацаа хоцорч байгаа, цаашид шийдвэрлэгдэхгүй байх магадлал бүхий арга хэмжээг хамруулна. Ач холбогдол, хэрэгжүүлэх хугацааны хувьд эрэмбэлэвэл төсөв, хөрөнгийн боломжид тохирсон эн тэргүүний арга хэмжээнүүдийг үндсэн чиглэлд оруулах бодлогын матрицад тусгах ба хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаагаас татарч болзошгүй арга хэмжээний хүснэгтэд тусгагдах арга хэмжээнүүд нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлага байгаа чөтөөв, хөрөнгө оруулалтын боломжгүйгээс үлдэж байгаа арга хэмжээнүүд байна. Өөрөөр хэлбэл бодлогын матрицад туссанаас ач холбогдлын хувьд илүү биш ч тухайн жилд хэрэгжүүлэх шаардлага байгаа арга хэмжээнүүд болно. Эдгээр арга хэмжээнүүд нь гадаад эх үүсвэр шийдвэрлэгдэхгүй байгаагаас хойшлох магадлал өндөр арга хэмжээнүүд байна.

Татарч болзошгүй арга хэмжээнүүдийг ач холбогдол, хугацааны хувьд эрэмбэлэн, төсөл, хөтөлбөрт туссан байдал, шаардагдах хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлсэн байх хугацааг нь тодорхой бичнэ.

5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих арга хэмжээний хүснэгтийг бөглөхдөө санхүүжилтийг сая төгрөгөөр тавих ба хөрөнгө оруулалтын 20...төсөл, дүнд хугацааны төсөөллүүдийн төсөвт өртгийн дүн, төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд тухайн өрөнхийлөн захирагчид өгсөн хөрөнгө оруулалтын хязгаарааас ихгүй байна.

Хөрөнгө оруулалтын өгөгдсөн хязгаарт өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг хуваарийн дагуу оруулж тооцон, хөрөнгө оруулалтын арга хэмжээ нэмж хэрэгжүүлэх боломж үлдэж байвал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад батлагдсан төсөл, хөтөлбөрт суусан арга хэмжээг нэмж оруулна.

Төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт хэсэгт тухайн объектын хүчин чадлыг харуулах үзүүлэлтийг тавина. Тухайлбал, эмнэлгийн барилга бол орны тоо, сургуулийн барилга бол сурагчийн суудлын тоо гэх мэт.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 24 (357)

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН 2004 ОНЫ ИЛТГЭЛ

- *Тодорхой эрхүүдийн хэрэгжилтийн төлөв байдал*
- *Эмзэг бүлгийн эрхийн асуудал*
- *Хүний эрхийн анхаарал татаж буй зарим асуудал*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны зургаадугаар сарын 21 № 24 (357)

Гарчиг

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ 2004 ОНЫ ИЛТГЭЛ

ӨМНӨХ ҮГ 564

НЭГ. ТОДОРХОЙ ЭРХҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ 565

1.1 Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний төлөв байдал
1.2 Газар эзэмших, өмчлөх эрхийн төлөв байдал
1.3 Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн төлөв байдал
1.4 Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн талаар
1.5 Уул уурхайн салбарт ажиллагсдын эрхийн төлөв байдал

ХОЁР. ЭМЗЭГ БҮЛГИЙН ЭРХИЙН АСУУДАЛ 591

2.1 Үндэсний цөөнхийн эрхийн төлөв байдал
2.2 Эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгаалал, хууль зүйн заасан тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхийн төлөв байдал

ГУРАВ. ХҮНИЙ ЭРХИЙН АНХААРАЛ ТАТАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ 601

3.1 Хуулийн байгууллагын үйл ажиллагаа ба хүний эрх
3.2 Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийн төлөв байдал

Санамж, зөвлөмж 607

Товчилсон үгийн тайлал 609

Өмнөх үг

Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (20.1)-д заасны дагуу тус Комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай ээлжит гурав дахь илтгэлээ гаргаж байна.

УИХ-ын Хууль зүйн Байнгын хороо Комиссын хоёр дахь илтгэлийг авч хэлэлцээд, илтгэлд хийсэн дүгнэлт, зөвлөмжийг сайшааж, цаашид хууль тогтоомж нь хүний эрхийн үндсэн зарчимд хэрхэн нийцэж байгаа талаар зөвлөмж, санал гаргах, хуулийн заалтыг бодитой хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй хяналт тавьж ажиллахыг ХЭҮК-т даалгасан юм. Энэ удаагийн илтгэлийг бэлтгэхдээ УИХ-ын Байнгын хорооны энэ заалт чиглэлийг анхааран үзсэн болно.

Илтгэлийн нэгдүгээр бүлэгт хүний тодорхой эрхүүдийн хэрэгжилтийг, тухайлбал, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, газар эзэмших, өмчлөх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой, анхаарал татаж буй асуудлуудыг авч үзсэн болно.

Илтгэлийн хоёрдугаар бүлэгт нийгмийн эмзэг бүлгийн эрхийн асуудлыг тусгайлан тусгасан. Өмнөх хоёрдугаар илтгэлд (2003 он) эмзэг бүлгийн эрхийн талаар бичиж байсан боловч энэ асуудалд дахин анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэв. Энэ удаад эмзэг бүлгийн талаархи хууль тогтоомж, халамж үйлчилгээний төрөл, нөөц боломж, хүртээмжийг түлхүү анхаарав. Түүнчлэн үндэсний цөөнхийн эрх (цаатан иргэд)-ийн хэрэгжилтэд анхаарал хандуулав.

Илтгэлийн гуравдугаар бүлэгт хуулийн байгууллагын үйл ажиллагаа ба хүний эрх, хөдөлмөрийн хүрээн дэх ялгаварлан гадуурхалттай холбогдолтой анхаарал татаж буй асуудлуудыг авч үзсэн болно.

Илтгэлийг боловсруулахдаа өмнөх хоёр илтгэлтэй холбогдуулан хийсэн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг болон УИХ-ын ХЗБХ-ны хуралдаан дээр гарсан санал, шүүмжлэл, дотоод, гадаадын хүний эрхийн судлаач, шинжээчид, идэвхитнүүдийн бодол, саналыг харгалзан үзэв.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

НЭГ. ТОДОРХОЙ ЭРХҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1. Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний төлөв байдал

Монгол Улсад тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний эрх зүйн орчны талаар дагнан хийсэн дүгнэлт судалгаа, дүгнэлт бараг байхгүй юм. Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд 2001 онд анх удаагаа хийгдсэн "Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал" судалгааны явцад хууль тогтоомжийн талаар зарим нэг харьцуулалт, үнэлэлтийг өгсөн болно (Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, Улаанбаатар хот, 2001 он, 33 дугаар тал).

Сүүлийн жилүүдэд энэ эрх чөлөөний хэрэгжилтийн талаар олон нийтийн дунд ихэд маргаан гарч, зарим жагсаал, цуглаан зохих зөвшөөрөлгүйгээр зохион байгуулагдаж, албадан тараах үйл ажиллагаа ч явагдсан.

Анхаарал татаж буй өөр нэг асуудал бол нийслэлийн Сүхбаатарын талбайд иргэд, улс төрийн хүчнээс жагсаал, цуглаан зохион байгуулах гэж нэг бус удаа оролдож бай явдал юм.

Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийн хэрэгжилт нь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй салшгүй холбоотой, эдгээр эрхүүд нь нэг нь нөгөөгүйгээр байх боломжгүй, хоорондоо салшгүй нягт уялдаатай байдагараа онцлог юм.

ХЭҮК-оос манай улсад сүүлийн арав гаруй жилд (1989-2003 он) зохион байгуулагдсан тайван жагсаал, цуглааны талаар дүн шинжилгээ хийх, энэ эрхийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор судалгаа явуулав. Судалгаанд ихэнх аймгуудад (18) сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны талаарх мэдээлэл авагдсан ба хууль зүйн орчны холбогдолтой хууль тогтоомжид онцгой анхаарал хандуулсан болно.

Нийслэлийн болон зарим дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрүүд, Засаг дарга нарын холбогдох захирамжууд, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн шүүхийн шийдвэрүүд, төвийн едер тутмын сонин хэвлэлүүдийн жагсаал, цуглаан, елселөн, суулттай холбоотой мэдээ баримтуудыг нэгтгэн судалж үзсэн болно.

1.1.1. УИХ 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр "Жагсаал, цуглаан хийх жүрмын тухай хууль"-ийг батална ба үг хууль нь 15 зүйлтэй бөгөөд 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр зарим нэг нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэхүү хууль нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндэсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал, цуглаан хийх жүрмыг тогтоох, уул арга хэмжээний уед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг ханган гэсэн гурван зорилтын хүрээнд түүнтэй холбоотой харилцаг зохицуулдаг.

Хуулийн үйлчлэх хүрээний гадна:

а) Төрийн ёслолын болон төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа жагсаал, цуглаан;

б) Иргэд, байгууллага улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдолгүй сэдвээр зохион байгуулж байгаа спорт, урлаг, уран сайхан,баяр наадмын болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ;

в) Төрийн болон улс төрийн нам, олон нийтийн байгууллагаас ирсэн,

сонгогчид, гишүүд, дэмжигчидтэй хийх хурал, уулзалт;

г) Аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажиллагсдаас тухайн байгууллагын үндэсэн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар зохион байгуулж байгаа хурал, цуглаан, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээнүүд үлддэг.

Дээрх дервен төрлийн арга хэмжээ нь Жагсаал, цуглаан хийх жүрмын тухай хуульд хамрагдаагүй гол үндэслэл нь тухайн арга хэмжээнүүдийн зорилго нь улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэхтэй холбогдолгүй байхтай холбоотой юм.

Энэ хуулиас үзэхэд аливаа тайван жагсаал, цуглаан хийхэд заавал зөвшөөрөл авахаар тогтоосон боловч төрийн байгууллагаас зохион байгуулж буй жагсаал, цуглааныд зөвшөөрөл шаарддаггүй (5.1) нь анхаарал татаж байна. Энэ нь үнэн хэрэгтээ Үндэсэн хуулийн "тэгш байдал" нь төрийн үйл ажиллагааны үндэсэн зарчим (Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг)- гэснийг зөрчихсэд хүргэж байна.

Хуулиар жагсаал, цуглаан хийх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгох (хуулийн 9 дүгээр зүйлийн 1) ба зөвшөөрсөн эсэхээ ажлын 6 өдрийн дотор (хуулийн 9 дүгээр зүйлийн 3) мэдэгдэнэ. Харин хуульд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг үг арга хэмжээг зохион байгуулахаас хэд хоногийн емнө гаргахыг заалгүй нээлттэй орхисон байна.

Эдгээрээс үзэхэд иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх нь үнэн хэрэгтээ зөвхөн тухайн сум, дүүргийн (нийслэлийн) Засаг даргын үзэмж, шийдвэрээс шууд хамаардаг. Гэтэл энэ эрх нь ихэнх тохиолдолд улс төр, эдийн засаг, хүний эрхтэй холбоотой асуудлаар олон нийтэд тедийгүй, засаг төрд тэр тусмаа эрх баригч нарт санал, шаардлага тавих, явуулж буй бодлого, үйл ажиллагаас нь шүүмжилж, эсэргүүцэхтэй салшгүй холбоотой байдаг учраас тухайн цаг үеийн засагчалын тоглолцооны гол төлөөлөгч болсон улс төрийн албан тушаалтан - Засаг дарга (сум, дүүрэг, нийслэлийн) зөвшөөрөл олгож байхаар хуульчлагдсаныг эргэж авч үзэх шаардлагатай байна.

Зайлшгүй зөвшөөрлийн систем байх шаардлагатай бол энэхүү зөвшөөрлийг улс төрийн биш албан тушаалтан, тухайлбал, тусгай албан тушаалтан, эсхүл шүүх өгдөг байх болох юм. Түүнчлэн бүртээ, мэдэгдлийн журам, тогтолцоог тайван жагсаал, цуглаан хийх эрхийг эдлэхэд хэрэглэх боломжтой гэж үзнэ. Өнөөг хүртэл нийслэлийн хэмжээнд зохиогдож ирсэн жагсаал, цуглаанд өгч байсан зөвшөөрөл, гаргаж байсан татгалзлыг судалж үзэхэд дараах зүйлүүд анхаарал татаж байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор "Нийслэлийн

гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, бяяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журам"-ыг батлсан. Энэхүү журам нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн (1994 он) 5 дугаар зүйлд заасан тухайн хуулийн үйлчлэлд хамрагдахгүй гурван тохиолдлыг (хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг) зохицуулжээ.

Дүүргийн Засаг дарга хоёр өөр янзын зөвшөөрөл тухайлбал, нэг зөвшөөрөл нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар (9 дүгээр зүйл), негөө зөвшөөрөл нь нийслэлийн ИТХТ-ийн 31 дүгээр тогтоолыг үндэслэн жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл олгодог аж.

Судалгааныаас үзэхэд нийслэлийн болон Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Засаг даргаас 1998-2003 онд ирсэдийн жагсаал, цуглаан хийх тухай 21 хүсэлтэд татгалзсан хариу өгсөн байх бөгөөд татгалзсан үндэслэлийг тэр бүр зөв гэж үзэх боломжгүй байна. Зөвхөн хоёр жишээг дурдвал: Ардчилсан Залуучуудын Холбооноос 2001 оны 5 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд их, дээд сургуулиудын багш, оюутны "Явган аялал"-ын нээлтийн ажиллагааг Д.Сүхбаатарын талбай дээр зохион байгуулах зөвшөөрөл хүсэхэд НЗДТГ-аас "Еренхийлөгчийн сонгуульд өнгөртөл Д.Сүхбаатарын талбайд ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулахгүй гэж шийдвэрлэсэн" хэмээн зөвшөөрөл олгохоос татгалзсан байв. "Оюутан-төсөл үндэсний төв" хэмээх ТББ-аас Монголын оюутны холбооны удирдлагын явуулж буй үйл ажиллагаа, бодлого, шийдвэрийг хүлээн зөвшөөрехгүй байгаагаа илэрхийлж, МЗХ-ны төв байрны өмнөх талбайд 2003 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 14 цагт 400-500 оюутны цуглаан хийх зөвшөөрөл хүссэн хүсэлтийг 2003 оны 3 дугаар сарын 22-ны өдөр ирүүлснийг "хуульд заасан хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй" гэсэн үндэслэлээр зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгч байжээ. Гэтэл Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд: жагсаал, цуглаан зохион байгуулагч зөвшөөрөл хүсэх хүсэлтээ уг арга хэмжээ эхлэхээс өмнө хэдийд ч гаргах эрхтэй бөгөөд энэ талаар ямар нэг хугацаат хууль тогтоогч заагаагүй юм.

1.1.2. ХЭҮК-оос хийсэн судалгаагаар 1998-2003 оны хооронд нийслэл болон Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирсэн, байгууллагаас жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл хүссэн 165 хүсэлт ирүүлжээ. Үүний 141 хүсэлтэд жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл олгож, 21 хүсэлтэд зөвшөөрөл олгохоос татгалзсан байна. Харин үлдсэн гурван хүсэлтийн нэгнийх нь хувьд зөвшөөрөл олгосон эсэх нь тодорхойгүй, хоёр хүсэлтийн тухайд зөвшөөрөл хүсэгч эргэж холбогдон хариу аваагүй бол энэ хугацаанд гурван удаа зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан зохион байгуулагдсан байна. Үүний хоёрыг нь албадан тараажээ. Үүнд, СБД-ийн Засаг даргын 2002 оны 11 сарын 12-ны өдрийн №327 тоот захирамжаар албадан тарасан жагсаал, цуглаан орно. Захирамжаар "МоАХ-ноос хөдөө аж ахуйн машин механизм ашиглан хийж байгаа жагсаал, цуглааныг зохион байгуулагчдад "Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль"-ийн заалтыг байнга зөрчсөнийг сануулан удаа дараа мэдэгдэл өгсөн боловч 2002 оны 11 сарын 5, 12-ны өдөр хуулиар хориглосон газар болох Д.Сүхбаатарын талбайд зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулж, тараахыг шаардсан албан мэдэгдлийг эс биелүүлсэн тул мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн жагсаал, цуглаанд оролцож буй хүн, түэврийн хэрэгсэл, хөдөө аж ахуйн машин механизмыг албадан тараахаар шийдвэрлэх, албадан тараах ажлыг 2002 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 19 цаг 16 минутаас эхлэн хууль заасны дагуу зохион байгуулах тухай" заасан бол удаах нь 2003 оны 11 сарын 30-ны өдөр болсон ХААИС-ийн 800-900 орчим оюутан оролцон, Нийслэлийн Засаг Дарга болон Нийслэлийн зам түэврийн газарт хандан ХААИС-ийн 1500-аад оюутан автобусны билетүүй хоцорснооос үүдэлтэйгээр оюутны хөнгөлөлтийн билетийг хангалттай тоогоор хэвлүүлэх шаардлага тавьж зөвшөөрөл авалгүй зохион байгуулсан жагсаал, цуглааныг албадан тараажээ.

Хуулийн 14 дүгээр зүйлийн 3-д "... жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараана" гэж заасан боловч чухам ямар арга хэрэгслээр хэрэхэн яаж тараах болохыг аль ч хуульд заагаагүй байна. Цагдаагийн байгууллагын тухай хуульд (1993 он) тусгай хэрэгсэл, мэхийг хэрэглэх нөхцөл байдлуудыг нэрлэсэн байх боловч одгээр жагсаалтад жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагаа хамрагдаагүй болно.

Нийслэл, дүүрэг дэх тайван жагсаал, цуглаан /1998-2003 он/

№	Нэрс	Зөвшөөрөл хүссэн хүсэлтийн тоо	Үүнээс:			Зөвшөөрөлгүй хийсэн
			Олгосон	Татгалз сан	Бусад	
1.	НЗДТГ	58	50	8		
2.	СБД-ийн ЗДТГ	53	47	6		1
3.	ЧД-ийн ЗДТГ	51	41	7	3	
4.	БГД-ийн ЗДТГ	1	1			
5.	ХУД-ийн ЗДТГ	2	2			1
6.	БЗД-ийн ЗДТГ					1
	Бүгд	165	141	21	3	3

Аймгуудад зохион байгуулагдсан тайван жагсаал, цуглаан /1989-2003 он/

№	Аймгуудын нэрс	Нийт зохион байгуулагдсан жагсаал, цуглааны тоо	Үүнээс			Эвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийн тоо	Албадан тараасан жагсаал, цуглааны тоо	Талбайн нэр
			Зөвшөөрөлтэй хийсэн	Зөвшөөрөлгүй хийсэн	1989-1991 онд хийгдсэн			
1.	Төв	16	13	2	1	2	2	"Мөнх алдар"-ын талбай
2.	Сүхбаатар	7	3	-	4			Сүхбаатарын хөшөөтэй талбай
3.	Булган	5	3	-	2			-Төв талбай /Улсын баатар Лхагвадорж/ -Чин ван Ханддоржийн талбай
4.	Өмнөговь	51	50	-	1			-Т.Борын нэрэмжит талбай -Улсын Арслан Дэмүүлийн нэрэмжит талбай
5.	Дархан-Уул	3	1	1	1			Найрамдлын талбай
6.	Дорноговь	1	1					Төв талбай
7.	Баянхонгор	6	5	-	1			"Баганат" талбай
8.	Баян-Өлгий	17	15	2	-	2	2	Төв талбай /Партизануудын дурсгалд зориулсан/
9.	Завхан	6	5	-	1			Аймгийн ЗДТГ, МАХН-ын хооронд байрлах талбай
10.	Архангай	20	20	-	-			"Дэмид жанжин"-ны талбай
11.	Дорнод	2	-	1	1			Хүүхдийн төвийн урд байрлах талбай
12.	Өвөрхангай	2	2	-	-	2		"Аюуш Баатар"-ын талбай
13.	Дундговь	3	-	-	3			Сүхбаатарын талбай
14.	Ховд	2	1	-	1			"Ард Аюуш"-ийн талбай
15.	Сэлэнгэ	12	10	2	-			Партизаны талбай
16.	Хөвсгөл	2	1	-	1			С.Даваадоржийн талбай
17.	Говь-Алтай	4	-	-	4			-
18.	Увс	1	1	-	-			Ю.Цэдэнбалын талбай
	Бүгд	160	131	8	21	6	4	

1.1.2. Судалгаанаас үзэхэд жагсаал, цуглаан зохион байгуулах хүсэлтэд (хуульд зааснаар мэдэгдэл юм) эвшөөрсөн буюу татгалзсан хариуг нийслэлийн хэмжээнд НЗДТГ-ын дарга гаргадаг (Нийслэлийн Засаг дарга эвөхөн нэг удаа 2002-04-24-ний өдрийн 1/2539 тоотоор татгалзсан хариу өгчээ) байхад дүүргүүдийн хэмжээнд зохион байгуулагддаг жагсаал, цуглааны хувьд ихэвчлэн дүүргийн Засаг дарга нар хариу өгчээ. Хуулиас үзэхэд (9 дүгээр зүйлийн 1, 3) эвшөөрлийг эвөхөн дүүрэг, нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргаж (хуулийн 10 дугаар зүйлийн 1), энэ тухайгаа бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй байна. Гэтэл жагсаал, цуглааныг зохион байгуулах тухай хүсэлтэд татгалзсан хариуг Засаг даргын Тамгын газрын даргын гарын үсэгтэй тоот бичгээр өгсөөр, зохион байгуулагчид ч тэдгээрийг байх ёстой зүйл мэтээр хүлээн авч иржээ. Зүй нь Засаг даргын захирамжийг л шийдвэрт тооцдог.

Жагсаал, цуглааныг зохион байгуулахыг татгалзсан хариунд чухам юуг үндэслэж, хууль, журмын ямар заалтыг иш үндэс болгож татгалзаж байгааг ort дурддаггүй байна.

1.1.4. Хуулийн 6 дугаар зүйлд хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхах, жагсаал, цуглаан хийхэд зориуд саад учруулах, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тараахыг хориглосон. Мөн 15 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт "жагсаал, цуглааныг хууль бусаар тараасан болон хууль бусаар

зөвшөөрөл олгоогүйгээс зохион байгуулагч, оролцогч, байгууллага, иргэдэд учирсан хохирлыг төр хариуцна" гэж заасан.

Хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар "Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцоных нь төлөө иргэнийг мөрдөн мөшгөсөн, эрх чөлөөг нь хязгаарласан, аливаа хэлбэрээр гадуурхсан иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэлгүйгээр мөнгөн торгууль оногдуулахаар заасан. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн 1994-2003 оны, Сүхбаатар дүүргийн шүүхийн 1992-2003 оны захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тухай шийтгэврийг судалж үзэхэд дараах гурван тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгээсэн байна.

- v 1994 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхээс "Тэмүүжин Менч" компанид оёдолчин, эмэгтэй, Чөлөөт ҮЭ-ийн гишүүн Г, С нарыг 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаас хууль бусаар зогсоохоор нөлөөлж ажилчдыг цуглуулж яриа хийхэд оролцож, танхайрсан гэж үзэн, тус бүр 2000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.
- v Мөн дүүргийн шүүхээс 1998 оны 6 дугаар сарын 12-ны өдөр иргэн А нь 1998 оны 6 дугаар сарын 11-ний өдөр сотгуугаар Сүхбаатарын талбай дээр суулт хийж байсан хүмүүс дээр очиж асган тавьж, айлган сүрдүүлж иргэн Б-г цохиж танхайрсан байх тул Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасанаар 7 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулжээ.
- v 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүх Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн "Газрыг шударгаар хувьчлахыг төлөв" хөдөлгөөний тэргүүн иргэн Б-д холбогдох материалыг хянан захиргааны шийтгэл оногдуулах тухай 1059 тоот шийтгэвэр гаргажээ.

Шүүх "Газрыг шударгаар хувьчлахын төлөө" хөдөлгөөний тэргүүн Б-ийн 2002 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Газрыг шударгаар хувьчлахын төлөө" жагсаал, цуглаан нь Монгол Улсын Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн болох нь тогтоогдож байна гэж үзэн, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 3-д заасанаар 25.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуульд "Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих" гэсэн 132 дугаар зүйлийг оруулсан. Үг 132 дугаар зүйлд:

- хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан;
- жагсаал, цуглаанд оролцоных нь төлөө иргэнийг ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заажээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д "гудамж, талбайд өлгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно", 15 дугаар зүйлийн 4-д "гудамж, талбайд хөндлөнгөөс зориуд өлгөлөн зарлахыг уриалсан буюу зохион байгуулсан гэм буруутай байгууллага, иргэн, албан тушаалтан"-д хариуцлага хүлээлгэх тухай тус тус заажээ.

Иргэд өөрийн сонгосон олон арга үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй, түүний нэг нь өлгөлөн зарлах явдал юм. Өлгөлөн зарлаж буй иргэд өөрсдийн тавьж буй санал, шаардлагыг дэмжиж буй иргэдийг үзэл бодлоо илэрхийлэн тэмцэхийг уриалах, тэдний дэмжсэн үйл ажиллагаат зохион байгуулах, хамтран тэмцэх явдлыг хориглох ёсгүй юм.

Харин өлгөлөнд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татах, айлган сүрдүүлэх, шахалт дарамт үзүүлэх болон бусад хэлбэрээр албадах явдлыг хориглох нь зүйтэй. Иймд асуудлыг ялгавартай тогтоох хэрэгтэй байна.

Иргэд, олон нийт жагсаал, цуглааныг зохион байгуулагчийн үүргийн талаархи хуулийн 11 дүгээр зүйлд их шүүмжлэлтэй ханддаг. Энэ зүйлээр төрийн өөрийнх нь хэнтэй ч хуваалцахгүй үүргүүдийг тухайлбал, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, оролцогчдод сотгууруулах ундаа хэрэглүүлэхгүй байх үүргийг жагсаал, цуглааныг зохион байгуулагч иргэдэд тохоон үүрүүлсэн нь иргэд энэхүү эрхээ чөлөөтэй эдлэх, хэрэгжүүлэхэд том дарамт болж байна гэж хэлэх үндэслэлтэй. Зүй нь нийгмийн хэв журам сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах нь төрийн өөрийнх нь тусгай алба, байгууллагын үүрэг юм.

1.2. Газар эзэмших, өмчлөх эрхийн төлөв байдал

2002 онд Газрын тухай хууль (шинэчилсэн найруулга), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тус тус батлагдсан билээ.

Үндсэн хуульд газар өмчлөх эрхийг баталгаажуулан зааснаас хойш 10 гаруй жил иргэд өнгөрсний эцэст Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсан.

v Өнөөдөр манай улсад газрын харилцаатай холбоотой асуудлуудыг дараах хуулиудаар зохицуулж байна.

- Иргэний хуулийн 102 дугаар зүйл, 10 дугаар бүлэг (2002 он)
- Газрын тухай хууль (шинэчилсэн найруулга) (2002 он)
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002 он)
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2002 он)

- Газрын төлбөрийн тухай хууль (1997 он)
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) (2003 он)

Үндэсн хуульд **“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж болно”** гэж заасан байхад Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4.-т **“иргэн, түүний гэр бүлийн гишүүн - Монгол Улсын иргэнд дундаа хатгамж өмчлөх хэлбэрээр энэ хуулийн 4.1.1-д заасан зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлнэ”** гэж зөвхөн гэр бүл болж бүртгүүлсэн иргэдээр хязгаарласан нь иргэдийн газар өмчлөх эрхийг зөрчсөн явдал болсон гэж үздэг хүмүүс цөөнгүй байна. Энэ заалт болон хуулийн бусад заалт Үндэсн хууль зөрчсөн талаар зарим иргэд Үндэсн хуулийн Цэцэд хандаж байжээ.

2002 оны 7 сарын 19-ний өдөр нэр бүхий дөрвөн иргэн 2002 оны 6 сарын 28-ны өдөр батлагдсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4, 20.1.1, 20.3.2 дахь заалт Үндэсн хуулийн 6.3-ыг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1.2.3 дахь заалт Үндэсн хуулийн 1.2, 6.3, 14.1, 14.2 дахь заалтыг зөрчсөн эсэхийг тогтоолгохоор Үндэсн хуулийн Цэцэд хандан өргөдөл гаргасан байна. Үндэсн хуулийн Цэцийн гишүүн 2002 оны 10 сарын 4-нд №25 тоот тогтоолоор өргөдөл гаргагчид өөрийн нэхэмжлэл, байр суурь, үзэл бодлын үндэслэл, нөхцөл байдал, нотолгоог тодорхой заагаагүй гэдэг үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажилдагаа үүсгэхээс татгалзжээ.

Үүний дараа хэсэг иргэдийн хоёр дахь удаа гаргасан өргөдлөөр хэрэг үүсгэх эсэх асуудлыг Цэцийн бага суудлын хуралдаанаар авч хэлэлцэн “өөрийн шаардлагын үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоо, маргаж байгаа асуудлын талаархи өөрийн бүрэн суурь, Цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлага тодорхой биш” гэж үндэслэлээр хэрэг үүсгэхээс татгалзсан №2 тоот тогтоолыг 2003 оны 4 сарын 11-ний өдөр батлажээ.

1.2.1. Иргэн гэдэг нь юуны өмнө тухайн хүний харьяаллыг илтгэдэг, өөрөөр хэлбэл уг хүн аль улсын харьяат мөн болохыг, түүнчлэн “Иргэн” гэх энэ үг насны байдлыг ямагт илтгэдэг. Учир нь тус улсын иргэн мөн болохыг батлан гэрчлэх баримт бичиг бол Монгол Улсын иргэний үнэмлэх байдаг (Иргэний бүртгэлийн тухай хуулийн 22-р зүйл) бөгөөд иргэний үнэмлэхийг 16 нас хүрээд авдаг. Тэгэхлээр Үндэсн хуулийн 6 дугаар зүйлд орсон “**иргэн**” хэмээх энэ үг тодорхой насанд хүрсэн бодгалийг илэрхийлж байна. Мөн зүйлд “Монгол Улсын иргэн” хэмээн тусгахдаа ямар нэгэн онцгойлон авч үзсэн хэсэг бүлэг иргэний талаар биш (гэр бүлтэй, гэр бүлгүй гэх мэтчилэн) нийт иргэн, өөрөөр хэлбэл иргэн бүр гэсэн утгыг бэлхнээ илэрхийлжээ. Газар өмчлөх эрх Үндэсн хуульд тусгагдсан утгаараа Монгол Улсын иргэний үндэсн эрхийн нэг болох юм.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4-т газар өмчлөх субъектийг **иргэн, түүний гэр бүлийн гишүүн** хэмээн тодорхойлсон нь Үндэсн хуульд заасан **иргэн** гэсэн субъектийн зөвхөн тодорхой хэсгийг хамарсан гэх үндэстэй.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн **“иргэн, түүний гэр бүлийн гишүүд”** гэсэн заалт нь зөвхөн өмчлөлийн хэлбэрийг тусгасан зохицуулалт. Иргэд гэр бүлийнхээ хэрэгцээнд өмчилж байгаа учир “дундаа” өмчлөх ашаардлага тавьсан гэж үзэх үндэстэй байна. Харин Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд (2002 он) “Гэр бүлийнхээ хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилж авах Монгол Улсын иргэдийн гэр бүлийн бүртгэлийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг батална гэдэрээр тооцно” (Хуулийн 1 дүгээр зүйл) гэсэн нь **“иргэн, түүний гэр бүлийн гишүүд”** гэсэн өмчлөлийн хэлбэрийг заасан утгаар бус харин газрыг үнэ төлбөргүй өмчлөх эрхтэй субъект нь заавал гэр бүлийн бүртгэлтэй байхыг шаардсан нь Үндэсн хуулийн иргэн газар өмчлөх эрхтэй гэсэн заалттай нийцэж буй зөсөхэд Үндэсн хуулийн Цэцэд өргөдөл гаргасан хүмүүс анхаарлаа хандуулсан байв.

Газар өмчлөх хэлбэрийг хуульд тухайлан заан тусгаж болохыг үгүйсгэхгүй боловч түүнтэй зохицуулалт нь гагцхүү иргэн бүрийн “газар өмчлөх эрх”-ийг ямар нэгэн байдлаар хязгаарлаж, хөндөөгүй байх ёстой.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд “гэр бүлийн гишүүн” гэсэн нэр томъёо орсон байгаа бөгөөд түүнийг Гэр бүлийн тухай хуулиас үзвэл:

- v **“гэр бүл”** гэж гэрлэлтийн үр дүнд бүй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг (Хуулийн 3.1.2 дахь заалт);
- v **“гэрлэлт”** гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг (Хуулийн 3.1.1 дэх заалт);
- v **“гэр бүлийн гишүүн”** гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг (3.1.4 дэх заалт);
- v **“гэрлэгчид”** гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг (Хуулийн 3.1.3 дахь заалт) хэлнэ гэжээ.

Гэр бүлийн тухай хуульд заасан эдгээр тодорхойлолтыг иш үндэс болговол гэр бүл гэдэг нь ямагт эрэгтэй, эмэгтэй хоёр хүний харилцаанд үндэслэсэн, түүнтэй холбогдон гарах бусад харилцаат агуулж байна. Гэрлэлтийн харилцаанд үндэслэн иргэдийг:

- Гэрлэсэн
- Ганц бие хэмээн хоёр ангилж болно.

Үндсэн хуульд заасан "иргэн" хэмээх нэр томъёо нь иргэний энэ хоёр статусыг хоёуланг нь хамарсан.

1.2.2 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсын иргэнд нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүлэх газрын байршлыг тогтоох асуудлыг дараахь байдлаар шийдвэрлэнэ.


1/ нийслэлд бүртгэлтэй иргэн нийслэлд буюу аль ч аймаг, сумын газарт (Хуулийн 3.1 дэх заалт);

2/ Дархан, Эрдэнэт хотод бүртгэлтэй иргэн тухайн хотдоо буюу нийслэлээс бусад аль ч аймаг, сумын газарт (Хуулийн 3.2 дахь заалт);

3/ энэ зүйлийн 1, 2 дахь заалтад зааснаас бусад иргэд нийслэл, Дархан, Эрдэнэтээс бусад аль ч аймаг, сумын газарт" (Хуулийн 3.3 дахь заалт) гэсэн байна.


1.2.3. Комиссоос иргэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл, шат дамжлагын (тухайлбал, иргэн хашаагаа хэдийд хаттах, газрын талаарх мэдээллийг хаанаас олж авах гэх мэт жижиг мөртлөө, хэн хүн тодийлөн шууд хариуцахгүй асуудлууд олон байдаг) талаар тусгайлан судалсан юм.

Газрын тухай хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд газар өмчлөх, эзэмшиж, ашиглахдаа дараахь үе шатыг туулах ёстой. Үүнд:



Энэ дараалаар тооцвол 7 шат дамжлага байгаа боловч үнэн хэрэгтээ иргэн, аж ахуйн нэгж байгууллага үүнээс их шат дамжлагаар явах болдог байна.

Иргэний хувьд



Аж ахуйн нэгж, байгууллагын хувьд

- Газар эзэмшиж, ашиглахыг хүссэн өргөдөл
- Газрын мэргэжилтэн өргөдлийг бүртгэнэ.
- Газрын даамал, газрын албаны мэргэжилтэн тухайн газар дээр дараахь зорилгоор очно:
  - Байршилыг тодорхойлж, эзэмших, ашиглах эрх үүссэн эсэхийг тодорхойлно;
  - Сум, дүүргийн хувьд хотын суурьшлын бүсийн инженерийн шугам, сүлжээ бүхий газар эсэхийг тогтоох;
  - Газар зохион байгуулалтын 2020 он хүртэлх төлөвлөгөөтэй харьцуулж шалгах.
- Эзэмшиж, ашиглахыг хүссэн газрыг үзсэн талаар буюу дээр дурдсан шаардлага хангагдсан эсэх тухай газрын албаа цохолт хийж өгнө.
- Газрын алба газар дээр очиж зураглал, хэмжилт хийнэ. (Улаан шугам татна)
- Засаг дарга өргөдлийг хүлээн авна.
- Засаг даргын захирамж
- Техникийн нөхцөл бүрдүүлж, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч гарын үсэг зуруулна. (нийслэлд) Үүнд:
  - Хотын Ерөнхий архитекторч;
  - УМХГ-ын Дэд бүтцийн Хяналтын хэлтэс;
  - УМХГ-ын Байгаль орчны Хяналтын хэлтэс;
  - УМХГ-ын Эрүүл мэндийн Хяналтын хэлтэс;
  - Дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч;
  - Дүүргийн архитекторч;
  - Ус сувгийн удирдах газар;
  - УМХГ-ын Галын аюулаас хамгаалах хяналтын алба;
  - Цахилгаан шугам сүлжээний газар;
  - Дулааны шугам сүлжээний газар зэрэг байгууллагын албан тушаалтан зөвшөөрөл олгоно.
- Газрын төлбөрийг орон нутгийн төсөвт оруулна.
- Газрын алба гэрээ байгуулна.
- Газар эзэмшиж, ашиглах гэрчилгээ олгоно.
- Гэрчилгээг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

1.2.4. Газрын тухай хуульд иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдлийг ямар хугацаанд шийдвэрлэхийг заагаагүй нь тэднийг ихээхэн чирэгдүүлэх, хүнд суртал үүсэх нөхцөл болж байна. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын (Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын тушаал, Журам батлах тухай, 2003.5.5, №165) 2.9-д газрын алба, газрын даамал нь өргөдлийг 30 хоногийн дотор няггүй шалгаж, шийдвэр гаргуулахаар эрх бүхий Засаг даргад уламжилна гэжээ. Харин тухайн дүгнэлтийг хүлээн авсан Засаг дарга чухам хэд хоногт багтаан шийдвэр гаргах үүрэгтэй вэ? гэсэн чухал асуулт өнөөдөр хууль зүйн хувьд хариултгүй буюу тухайн албан тушаалтны үзэмжийн асуудал болжээ. Дээрх журмын 3.5-д газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэрийг үндэслэж, ажлын 15 хүртэлх хоногт багтаан тухайн иргэн, хуулийн этгээдтэй аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэхээр заажээ. Эндээс техникийн нөхцөлөө бүрдүүлж, эвшээрэл авах ажил ердөө 15 хоногт хийгдэх ёстой ажээ. Гэвч бодит байдал үүнээс эсрэг бөгөөд энэ хугацаа маш их сунжирч удааширдаг байна. Тухайлбал, бидний хийсэн ярилцлагын судалгааны явцад барилга угсралтын "Барилга" корпорации техникийн нөхцөлөө бүрдүүлэх гээд 5 сар гаруй хугацаа зарцуулсан тухайгаа ярьж байлаа.

Дээрх хугацаанаас гадна Газрын тухай хуулийн 34.2-т "Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх"-ийг үүрэг болгосон байдаг.

Иймхүү газар эзэмшүүлэх, ашиглуулахад зарцуулж буй нийт хугацаог тоймловол:

№	Үйл ажиллагаа	Эрхлэх субъект	Хугацаа
1.	Өргөдлийн бүрдүүлбэрийг шалгах	Газрын алба, газрын даамал	30 хоног
2.	Газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах	Засаг дарга	Хугацаа тодорхойгүй
3.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага	90 хоног
4.	Техникийн нөхцөл бүрдүүлж, эвшээрэл авах	Эрх бүхий хяналтын байгууллагууд	Тодорхойгүй
5.	Гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх	Газрын алба, газрын даамал	Ажлын 15 өдөр
6.			125 хоног+зарим тодорхойгүй хугацаа

Иргэн, хуулийн этгээд газар эзэмшиж, ашиглаж нийт 125 хоног мөн энэ харилцааны үндсэн гол хэсэг болох Засаг дарга шийдвэр гаргах, техникийн нөхцөл бүрдүүлэх ажлын хугацаа тодорхойгүй байгааг харгалзан үзвэл газар эзэмшиж, ашиглах эрх олж авахад дунджаар 4-5 сар зарцуулахаар байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ердийн хугацаа 30 хоног байдагтай харьцуулан үзвэл газар эзэмшиж, ашиглах эрх олж авахад 4-5 сар зарцуулж байгаа нь иргэдийг чирэгдүүлж, улмаар үл хөдлөх эд хөрөнгө эзэмшиж, ашиглах эрхийг шударгаар олж авах боломжийг хүндрүүлж байна.

1.2.5. Газрын тухай хууль 1994 онд батлагдсанаас хойш нийслэлийн төвийн дүүргийн шүүхүүдээс газартай холбогдох нийт 65 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Хэргийг маргааны төрлөөр нь авч үзвэл:

№	Маргааны төрөл	Шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
1.	Газар чөлөөлүүлэх	13	21.3%
2.	Албадан нүүлгэх	32	52.4%
3.	Газрын төлбөр барагдуулах	5	8.1%
4.	Захиргааны акт буюу захирамж хүчингүй болгуулах	4	6.5%
5.	Захиргааны акт гаргуулах	1	1%
6.	Газар эзэмших эрх тогтоолгох	4	6.5%
7.	Хохирол арилгуулах	2	3.2%
	Нийт	**61**	

Газар ашиглах харилцаанд гарч буй сөрөг үзэгдэл нь ашиглах эрхийн гэрээг богино хугацаатай байгуулдаг тул энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд техникийн нөхцөлөө бүрдүүлж, зөвшөөрөл авч амжихгүй гэрээний хугацаа нь дуусдаг байна. Тухайн гэрээний хугацаанд иргэн, хуулийн этгээдийн зүгээс гэрээг дахин сунгах хүсэлт тавихад Газрын албаа татгалзсан хариу өгөх явдал олонтаа гарч байсан бөгөөд энэ тохиолдолд иргэн, хуулийн этгээд эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах явдал харьцангуй нэмэгдэж байгаа нь ажиглагдсан.

1.2.6. Нийслэлийн Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нийт 250 оршин суугчдын дунд газрын харилцаа, газар өмчлөх, эзэмшихтэй холбоотой асуудлаар санал асуулга явуулсан.

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (57.6%) газрын асуудлаар ямар нэгэн байдлаар захиргааны байгууллагад хандаж байжээ.

Иргэд газартай холбоотой мэдээллийг олж авах, улмаар өөрийнхөө эрхийг эдлэхийн тулд лавлагаа, зөвлөгөө авахад их анхаардаг болсон.

Зохих байгууллагад хандаад хүссэн мэдээллээ авч чадааруй бол шалтгаан нь юу вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 4.8% нь тухайн мэдээлэл төлбөртэй байсан, 23.6% нь дараа ир хэмээн хойшлуулсан, 28.4% нь дутуу дулимаг хариулт өгсөн гэж хариулсан байв.

Иргэн, аж ахуйн нэгж байгуулагад газрын архивын лавлагаа, зураг мэдээллээр үйлчлэхэд авах хураамжийн хэмжээг тогтоосон байна (Засгийн газрын 2003 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн тогтоол №205, "Хураамжийн хэмжээг тогтоох тухай"). Уг тогтоолд захирамжийн хуулбар авахад хуудас тус бүр 200 төгрөг, баталгаажилтын схем хуудас тус бүр 1000 төгрөг, харин зураг мэдээллээр үйлчлэхэд нэгж талбар бүр 2500 төгрөг байхаар тогтоосон. Газрын талаар мэдээлэл авах хураамжийн хэмжээ өндөр байгаа нь иргэдэд нэлээд бэрхшээлтэй байна.

Судалгааны явцад Та газраа өмчилж авааруй бол шалтгаан нь юу вэ? гэсэн асуултанд:

- 14.4% нь зав хомс байна
- 21.2% нь газрын татварын зохицуулалт хийгдэхийг хүлээж байна
- 13.2% нь газар эзэмших эрхийн гэрчилгээ маань зөрчилтэй байгаа
- 21.6% нь энэ асуудал зүгширч тогтворжихийг хүлээж байна
- 2.4% нь өмчилж авахыг хүсэхгүй байна гэж хариулсан.

1.2.7. Иргэдэд газар өмчлүүлэх ажил Нийслэл, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт дараахь байдалтай байна.

№	Аймаг, нийслэл	Гэр бүлийн тоо	2003 онд өмчлүүлэх газрын хэмжээ	2003.12.31.-ний байдлаар өмчлүүлсэн газар	Газар өмчлөх боломжтой нийт гэр бүлийн дотор эзлэх хувь
1.	Улаанбаатар хот	129252	4586.05 га	16160 өрхөд 768.48 га	16.7%
2.	Булган	13252	3933.78 га	127 өрхөд 63.5 га	1.6%
3.	Сэлэнгэ	21431	72082.38 га	670 өрхөд 266.3 га	0.3%
4.	Дархан-Уул	14961	1962.95 га	300 өрхөд 41.36 га	2.1%

1.3. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол,байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн төлөв байдал

Сүүлийн гучаад жилд Монгол Улсад хотжилт улам бүр идэвхитэй болж, хот суурингийн тоо нэмэгдсээр байна. Хүн амын суурьшилтыг авч үзвэл нийт хүн амын бараг гуравны нэг нь Улаанбаатар хотод, 60-аас илүү хувь нь төвийн бүс нутагт (Улаанбаатарыг оролцуулан) амьдарч байна.

Байгальтайгаа зүй зохистой харьцдаг уламжлалт зан заншил алдагдаж буйн сацуу хот суурин газруудын хүн амын төвлөрөл, орчиндоо халтай үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хот төлөвлөлтийн хоцрогдсон менежментийн улмаас төв суурин газруудад агаар, хөрс болон усны бохирдлын түн хэмжээ үндэсний болон олон улсын стандартын хүлцэх хэмжээнээс хэт их болж эрүүл аюулгүй орчинд амьдрах хүний эрх зөрчигдөх явдал сүүлийн жилүүдэд их боллоо.

Байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах зарчим алдагдаж буйгаас гадаргын болон газрын гүний усны нөөц, ой мод, хөрс, бэлчээр зэрэг байгалийн нөөцийн зарцуулалт, хэрэглээний хувь хэмжээ мөн зохистой хэмжээнээсээ хэтрээд байна.

Энэ байдалд Хүний Эрхийн Үндэсний Комисс дүгнэлт хийж эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн төлөв байдлын талаар энэ удаагийн илтгэлд тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзсэн юм. Энэ сэдэвтэй холбоотой

судалгаа шинжилгээ нь нарийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоо, тусгай мэдлэг, аргачлалыг шаарддаг байна. Энэ чиглэлээр манай улсад сүүлийн жилүүдэд олон төрлийн судалгааны ажлууд хийгдэж, чухал ач холбогдолтой санал зөвлөмжүүд боловсрогдож, хөтөлбүүд хэрэгжиж буйг тэмдэглэж байна. Харин энэ асуудалд хүний эрхийн талаас хандах, үйл ажиллагааг хүний эрхтэй холбох, хүний амин чухал эрхүүд хэрхэн хөндөгдөж буйг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргэж, шийдвэртэй арга хэмжээ авахуулах талаар онцгойлон анхаарах шаардлагатай болжээ. Илтгэлийн энэ хэсэг нь өмнө нь холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн хийсэн судалгаа, дүгнэлт дээр түшиглэсэн болно.

Энэ чиглэлээр олон хуулиуд батлагдан гарсан. Байгаль орчинг хамгаалах тухай (1996 он), Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай (1994 он), Усны тухай (1995 он), Ойн тухай (1995 он), Ой хээрийн түймрээс хамгаалах тухай (1996 он), Байгалийн ургамлын тухай (1995 он), Ургамал хамгаалын тухай (1996 он), Агаарын тухай (1995 он), Химийн хорт бодисоос хамгаалах тухай (1995 он), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай (2000 он), Аюултай хог хаягдыг импортлох тухай (2000 он) зэрэг хуулиудыг нэрлэж болно.

1.3.1. Агаарын бохирдол

1.3.1.1. Улаанбаатар хотын агаарыг дор дурьдсан 3 эх үүсвэрээс (БОТБ тайлан,2002) бохирдуулж байна:


а) дулааны цахилгаан станцууд

б) гэр хорооллын зуухны болон жижиг уурын зуухны дутуу шатсан утаа

в) автомашин болон бусад хөдөлгөөнт эх үүсвэр

Хотын агаарын бохирдлын түвшин нь бохирдлын эх үүсвэрийн байршил, тэдгээрийн хүч чадал, хаягдлын найрлага ба бүтэц, байр зүйн болон цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан хотын дүүргүүдэд харилцан адилгүй явц, тархалттай байдаг. Улаанбаатар хотын захын уулсын энгэр дагаж байрласан гэр хорооллын утаа униар нь орчныхоо агаарыг ихээхэн бохирдуулаад зогсохгүй голын хөндий дагаж харьцангуй нам дор газар байрласан хотын төв хэсгийн агаарыг бохирдуулах нэг эх үүсвэр нь болдог. Ялангуяа өвлийн улиралд уул, хөндийн салхины горимтой уялдан хотын захаас төв рүү чиглэсэн агаарын урсгалаар гэр хорооллын утаа униар сарнилгүй шилжин ирж тунаран, агаарыг бохирдуулах гол нөхцөлийг бүрдүүлдэг.


Улаанбаатар хотын агаарын чанарыг 4 суурин харуул дээр байнгын ажиглалт явуулан хянадаг байна. Сүүлийн жилүүдийн хотын агаарын чанарын өөрчлөлтийг сонирхвол:



Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн мэдээнээс (2003 он)

1.3.1.2. Хот суурин газрын агаарын бохирдлын хяналт шинжилгээг Улаанбаатараас бусад томоохон 17 хот суурин дахь 19 суурин харуул дээр явуулж, агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламжийг тодорхойлж байна.

Орон нутгийн хот суурин газрын агаарын бохирдлын төлөв байдлыг 2002 онд хийгдсэн хяналт-шинжилгээний дүнгээр зураг үзүүлбэл:



Томоохон хотуудын агаарын бохирдол

Эдгээр хотуудын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агуулламж 1-14 мкг/м^3, хамгийн их агуулламж 162 мкг/м^3-д (Дархан хот) хүрч, агаарт байж болох ХА-аас хэтэрсэн тохиолдол ажиглагдаагүй. Азотын давхар ислийн хувьд жилийн дундаж агуулламж 5 - 34 мкг/м^3, хамгийн их агуулламж 94 мкг/м^3 нь мөн Дархан хотод ажиглагдаж, 18 удаа хүлцэх агуулламжаас давсан бохирдол илэрсэн. Өвлийн улиралд Дархан хотын агаарын бохирдол өмнөх оныхоос ихэссэн байна. Дархан, Эрдэнэт, Багануур, Мөрөн, Улаангом хотуудын агаар дахь азотын давхар ислийн агууламж харьцангуй их байхад хүхэрлэг хийн агууламж Дархан, Шарын гол, Мөрөн, Багануур, Цэцэрлэг хотуудад их байна.

1.3.1.3. Дээр дурьдсанчлан Монгол Улсын хүн амтөвлөрсөн хот суурин газрын агаарын бохирдол дараах эх үүсвэрүүдээс үүсч байна.

а) дулааны цахилгаан станц

б) гэр хорооллын зуух болон бага оврын уурын зуух

в) автомашин болон бусад хөдөлгөөнт эх үүсвэр

г) хог хаягдал, үнсэн сан, лагийн талбай

д) агаарт бохирдуулагч бодис гаргадаг бусад эх үүсвэрүүд (шатахуун түгээх станц, ууршимтгай химийн бодис материал хэрэглэдэг үйлдвэр, үйлчилгээний газар гэх мэт)

Томоохон хот, суурин газарт хийсэн агаарын бохирдлын хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд агаар дахь гол бохирдуулагчид нь азотын давхар исэл, тоос, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг байна. Агаарын бохирдлын хувьд хамгийн их анхаарал татаж буй газар бол нийслэл хот болоод байна.

Улаанбаатар хотод 92000 (Байгаль орчны төлөв байдлын 2002 оны тайлан, УБ хот, 2003 он, 15 дугаар тал) орчим айл өрх гэр хороололд амьдарч тэдий тооны бага оврын зуух, пийшинд дулаан үйлдвэрлэж байна. Энд нийт 300000 орчим тонн нүүрс шатааж, энэ нь нийслэлийн агаарын бохирдлын нэлээд хувийг эзэлдэг. Амьсгалд шууд нөлөөлөх орчны бохирдол 80% нь болж байна. Гэр хороолол нь хамрах талбайн хувьд ч, хүрээлэн буй орчныг бохирдуулах нөлөөллийн хувьд ч нийслэл хотын бохирдлын томоохон эх үүсвэрийн тоонд зүй ёсоор тооцогдох болсон. Гэр хорооллын бага оврын зуухны нэгж хэмжээний түлш шатаахад үүсэх бохирдуулах нөлөө үйлчлэл нь илүү өндөр бөгөөд энэ нь:

-гэр хорооллын зуухны технологи шаардлага хангахгүй, хоцрогдсон

-нам өндрийн яндантай

-байнгын галлагаатай байх зэргээс шууд шалтгаалдаг.

Нүүрс болон мазут зэрэг хүхэр агуулсан эрдэс тосыг шатаахад ялгарах хүхэрлэг хий (SO_2)-н бохирдол 10-р сараас эхлэн дараа оны 3-р сар хүртэл хугацаанд эрс ихэсдэг.

Азотын ислүүд нь харьцангуй өндөр температурт шаталт явагддаг автомашин, цахилгаан станцаас болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ялгардаг. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод автомашины тоо нэмэгдэнтэй холбоотойгоор агаар дахь азотын давхар ислийн агууламж хотын төв хэсгээр жилээс жилд ихэсч байна.

Авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас агаарт хаягдаж байгаа бохирдуулах бодисын хэмжээ 1995 оноос мэдэгдэхүйц нэмэгдэж жил дараалан өссөөр иржээ. Энэ нь нэг талаас Улаанбаатар хотын автомашины тоо түргэн хурдацтай өсч хөдөлгөөний эрчим, замын ачаалал хэт ихэссэн, нөгөө талаас хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн техникийн байдал муу, парк хэт хуучирсан, техникийн үйлчилгээ засварын чанар хангалтгүй зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна.

Агаар бохирдуулах эх үүсвэрийг шалгасан дүнгээс үзэхэд улсын хэмжээний нийт эх үүсвэрийн тоо 495773, үүнээс суурин эх үүсвэр 344150, хөдөлгөөнт эх үүсвэр 125553 байна. 26070 эх үүсвэр нь гэмтэлтэй буюу ажиллагаагүй эх үүсвэр байна. Улсын хэмжээнд үнс, тос барих, хий цэвэрлэх төхөөрөмж 451, үүнээс бүрэн ажиллагаатай 372, засвар хийх шаардлагатай бүрэн ажилладаггүй 82 (давхардсан тоогоор) байв. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 686 шатахуун түгээх станц, 250 уурын зуух ажиллаж, арьс ширний анхан шатны боловсруулалт хийдэг 53, ноос, ноолуурын 36 (Байгаль орчны төлөө байдлын 2001 оны тайлан, УБ хот, 2002 он, 37 дугаар тал) үйлдвэр үйл ажиллагаа явуулж, үйлдвэрээс гарч байгаа хуурай хог хаягдал болох үс, ноос, малын арьсны захалгаа, год, шийр болон бусад хаягдал, лаг зэргийг хаях нэгдсэн цэг байхгүйгээс хаа дуртай газраа хаяж херс, үс, агаарыг бохирдуулж, хот орчимд хогийн цэгийг шинээр үүсгэж байна. Мөн тээвийн хэрэгслийн түлшний шаталтаас ялгарах хорт бодисын хэмжээг тогтоохоор 16 маркийн машиныг түүвэрлэн авч шалгалт хийхэд 43.7% буюу 105 (Байгаль орчны төлөө байдлын 2002 оны тайлан, 2003 он, 15-р тал) машины үгаарын хий, нүүрс үс тэрегчийн хэмжээ Монгол Улсын стандартаас хэтэрсэн, өндөр үзүүлэлттэй гарчээ.

Хөдөлгөөнт эх үүсвэрийн тоо сүүлийн 10 жилд 1.7 дахин, суудлын автомашины тоо хоёр дахин нэмэгдсэн байна. Улсын хэмжээний автомашины 52% (48120 автомашин) нийслэлд байна. Мөн нийслэлд байгаа машины насжилтаар нь авч үзвэл долоогоос дээш жил болсон машин 60 гаруй хувийг эзэлж, замын хөдөлгөөнд оролцож буй нэг хэрэгсэл гэхэд л хөгжингүй орны 70-80 машинаас гарах бохирдуулах бодисын хэмжээний хорт бодисыг гаргаж байна.

1.3.1.4. Хүн амын суурьшилт, хотжилттой холбоотойгоор нийслэл Улаанбаатар хотод орчны бохирдол нэмэгдэж, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл бүрдэхэд байна.

2002 онд ЭМЯ-ны ICP/HSE/4.3/001 төслийн хүрээнд ЭМЯ, түүний харьяа НЭМХ, Нийслэлийн эрүүл мэндийн хяналтын алба (Одоогийн Улсын мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэндийн хяналтын алба), БОЯ, БОШТЛ зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцон Нийслэлийн зарим дүүрэгт явуулсан судалгаагаар (Б.Бурмаа нар, 2003), тухайлбал Хан-Уул дүүрэгт агаар дахь тоосны агууламж болон хүн амын харшил өвчин (Rxy =0.5, p < 0.05; Rxy = 0.1, p < 0.05), 0-14 насны цочмог бронхитын өвчлөлийн хооронд шууд хамааралтайг тогтоосон бөгөөд өмнөх зарим судалгаагаар гаргасан хүүхдийн өвчлөл, агаарын тоосноос шууд хамаардаг гэсэн дүгнэлтийг давхар баталжээ. Мөн энэ судалгаагаар агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрс төрөгчийн дутуу ислийн агууламж болон хүүхдийн цочмог бронхит, архаг бронхит, үушгины үрэвслийн хооронд шууд хүчтэй хамаарал байгааг тогтоожээ.

Агаарын бохирдлын судалгаагаар (Н.Сайжаа нар, 2003) томоохон хотуудын агаарын бохирдуулагчийн нийлбэр түвшинг бохирдлын индексээр (P) үнэлэхэд Улаанбаатар хот хүчтэй бохирдолтой (P = 3.78), Дархан хот сул бохирдолтой (P = 2.12), Эрдэнэт (P = 0.96) болон Чойбалсан хотууд (P = 0.93) хүлцэх түвшинд байна гэдгийг тогтоожээ.

Амьсгалын замын өвчлөлийг насны бүлгээр авч үзвэл (Б.Алтанзагас нар, 2003) 0-4 (10 000 хүн амд 2821.12) болон 65- аас дээш насны хүмүүсийн (10000 хүн амд 1143.9) дунд хамгийн өндөр байгаа нь 16-19 насныхантай харьцуулахад 10.3 ба 4.2 дахин их байжээ. Амьсгалын замын өвчний гол шалтгаануудад хатгалгаа (26%), томуу (8%), гуурсан хоолойн хурц үрэвсэл (8%), үушигний архаг өвчнүүд (8%) болон гүйлсэн булчирхайн хурц үрэвсэл (7%) орж байна. Хатгалгаа, томуу, гуурсан хоолойн хурц үрэвсэлт өвчнүүдийн тохиолдол 0-4 насны хүүхдүүдийн дунд хамгийн их байгаа бөгөөд 16-19 насныхантай харьцуулахад харьцангуй эрсдэл нь 18.1, 14.1, болон 29.3 байна.

Агаарын бохирдолтын, ялангуяа хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судалсан судалгааныүд хүүхдүүдийн дундах амьсгалын замын эрхтний өвчлөл, түүний эсрэг эмийн хэрэглээ, болон эмэнэлэгт хандах хандлага ихэсч байгааг харуулж байна.


1.3.2. Ус, ундны усны бохирдол, хомсдол

1.3.2.1. 2002 оны хяналт шинжилгээний дүнгээр бохирдлын индексийг бодож, усны чанарын зэргийг тогтоон 6 ангиллаар үнэлгээ өгчээ. Бохирдлын индексийг бодохдоо бохирдуулах бодисын тархац, хор хөнөөлийн зэрэг, бохирдлыг тодорхойлогч болж чадах хүчин зүйлүүдийг нь үндэслэн усан дахь ууссан хүчилтөрөгч, хялбар исэлдэх органик бодис, эрдэс азот болон фосфор, хром, зэс зэрэг хүнд металл гэх мэт 6-аас доошгүй үзүүлэлтүүдийг сонгон жилийн дундаж агууламжийг нь MNS-4586-98 "Усны чанарын стандарт"-тай харьцуулан гаргасан байна (Байгаль орчны төлөө байдлын 2002 оны тайлан, 2003 он, 80-81 дүгээр тал).

Бохирдлын индексээр усны чанарыг үнэлсэн нь

Бохирдлын индекс	*Усны чанар*	
	Зэрэг	Ангилал
< 0.3	I	Маш цэвэр
0.31-0.89	II	Цэвэр
0.90-2.49	III	Бага бохирдолтой
2.50-3.99	IV	Бохирдолтой
4.00-5.99	V	Бохир
6<	VI	Маш бохир

Гадаргын усны чанарын үнэлгээ



Байгаль орчны төлөв байдлын 2002 оны тайлан, 2003 он, 80 дугаар тал

Дээрх үнэлгээгээр судалгаанд хамрагдсан нийт гол мөрөн, нуурын 86% нь "маш цэвэр", "цэвэр" үнэлгээнд хамрагдаж байна. Туул гол Сонгино харуул, Хиагт гол Алтанбулаг харуулын орчимд VI зэрэг буюу "маш бохир" гэж үнэлэгдэн эрдэс болон органик бодисоор ихээр бохирдсон байна. Туул голын ус Таван толгойн гүүр орчим арай дээрдэж, V зэрэг буюу "бохир" гэж үнэлэгдэн эрдэс азот, фосфор, хялбар исэлдэх органик бодисоор ихээхэн бохирдож, эдгээрийн жилийн дундаж агууламж хүлцэх агууламжаас 4-10 дахин давсан байна. Мөн Хангалын гол Эрдэнэт хотоос доош хэсэгт ихээхэн бохирдож V буюу "бохир" гэж үнэлэгдэн усан дахь эрдэс азот, зэс, хромын жилийн дундаж агууламж хүлцэх агууламжаас 1.3-10 дахин давсан байна.

III зэрэг буюу "бага бохирдолтой" үнэлгээнд багтаж байгаа голуудын усан дахь эрдэс азот ба фосфор, хялбар исэлдэх органик бодисын жилийн дундаж агууламж нь хүлцэх агууламжаас бага зэрэг давсан бохирдол илэрсэн байна.

Туул голын ус Уу-булангаас Сонсголон хүртэл хэсэгт харьцангуй цэвэр байжад Сонгинооос доош хэсэгт бохир ус цэвэрлэх байгууламжуудийн хаягдлын нөлөөгөөр зэс бохирдож, ялангуяа гол хөлдүү өвлийн саруудад усан дахь хялбар исэлдэх органик бодисын агууламж хүлцэх агууламжаас 10 дахин давж бохирдож байна. Улсын мэргэжлийн хяналтын газраас бохир ус цэвэрлэх байгууламж, бохир ус зайлуулах цооногуудад хийсэн хяналт, шалгалтын дүнгээс (Байгаль орчныг хамгаалах албаны тайлан, 2003) үзэхэд Улаанбаатар хотын нийт цэвэрлэх байгуулламжийн 68.2 хувь нь 1992 онд, 54.5 хувь нь 1997 онд хэвийн ажиллаж байсан бол 2001 оны байдлаар денгеж 37.4 хувь нь хэвийн ажиллаж байгаа гэж гарсан нь голын усны бохирдлын гол эх үүсвэр нь цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагаатай шууд холбоотойг харуулж байна. Үүний бас нэг баримт нь 2000 онд Төв цэвэрлэх байгууламжинд гарсан ослын улмаас 6.4 мянган м^3 бохир усыг шууд Туул гол руу хаяжээ. Энэ нь урсгал усанд байгнын бохирдуулагч хурдсыг бий болгож байгаа юм.

Аммонийн азотын хувьд ч мөн адил өвлийн саруудад бохирдол эрс ихэсч, хүлцэх агууламжаас 30 дахин давсан бохирдол илэрч байна. 2003 онд бохирдол өмнөх оноос нэмэгдэн нь нэг талаас цэвэрлэх байгууламжуудын ажиллагаа ихээхэн доголдсон, нөгөө талаас гол харьцангуй урсац багатай байснаас хамааралтай юм.

1.3.2.2. Ундны цэвэр ус нь хүн ам болон хүрээлэн байгаа орчны эрүүл байхын үндэс болдог. Ундны бохирдсон ус нь холер, гэдэсний хижиг зэрэг халдварт өвчний нянг тээх байдаг. Мөн ундны ус нь хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхүйц хими, физикийн болон радио идэвхит зүйлээр бохирдох явдал байдаг. Эрүүл ахуйн шаардлагын үүднээс ундны цэвэр ус нь хүүхэд эмэгтэйчүүд, ялангуяа хөдөөгийн хүн амд маш чухал юм. Ундны "цэвэр" буюу "ашуулгүй" ус гэсэн ойлголттой холбоотой нилээд асуудлууд байдаг. Усны чанар нь газар нутаг бурт харилцан адилгүй бөгөөд орчин үеийн төвлөрсөн хангамж ч гэсэн цэвэр ашуулгүй усаар бүрэн хангаж чадахгүй байгаа бэлэг.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр Үндэсний статистикийн газраас явуулсан "Хүүхэд хөгжил-2000" судалгаагаар (Үндэсний тайлан 2001 он, 27 дугаар тал) Монгол улсын хүн амын 60 хувь нь ундны цэвэр усаар хангагдсан дүн гарсан. Ундны цэвэр усны хангамжийн түвшин хот, хөдөөд ихээхэн ялгаатай байна. Хотын хүн амын цэвэр усны хангамж 91%-тай байхад хөдөөд денгеж 34% байна. Бүс нутгаар ч энэ үзүүлэлт ихээхэн ялгаатай. Говийн болон баруун бүсийн аймгуудын хүн амын 22-32% цэвэр усаар хангагдсан байхад Төвийн бүсийн хүн амын 84-97% нь хангагдсан байв (Хүүхэд хөгжил -2000 үндэсний тайлан, 2001 он, 67 дугаар тал). Улсын хэмжээгээр хүн амын 20% төвлөрсөн усан хангамжаар хангагдсан, 18% нь усан сангаас хэрэгцээний усаа авдаг. Төвийн аймгуудын хүн амын 84-97% нь ундны усны дээрх эх үүсвэрээр хангагдсан байна. Баруун болон Говийн аймгуудын ундны усны эх үүсвэрийн талаас илүү хувийг цөөрөм, гол горхи, булаг, эвэрхэн 10 орчим хувийг төвлөрсөн усан хангамж болон усан сан эзэлж байна.

Ундны усны хими, нян судлалын шинжилгээний дүн, хүн амын хоол боловсруулах эрхтэний өвчлөлийн хоорондын хамаарлын талаар Улаанбаатар хотын Хан-Уул дүүргэт Б. Бурмаа (2003) нарын 1999 онд явуулсан судалгаагаар ундны усан дахь аммиакийн агуулламж, хоол

боловсруулах эрхтэний өвчлөлийн хооронд шууд хүчтэй (Rxy = 0.7, p< 0.05) хамаарал илэрчээ. Мөн Ч. Нямрагчаа нарын Улаанбаатар хотод хийсэн өөр нэгэн судалгаагаар гэр хороллын хүн амын суулгалт халдварын өвчлөл, ундны усны хими, нянгийн бохирдлын хоорондох шууд дунд хамаарал (Rxy = 0.41, p< 0.05) илэрсэн нь ялангуяа гэр хорооолод ундны усны чанар эрүүл мэндийн шаардлагад тэр бүр нийцэхгүй байж болзошгүйг харуулж байна.

Монгол Улсын газар зүйн 4 бүс, хот хөдөөг төлөөлүүлэн 15 аймагт Үндны усны чанар, аюулгүй байдлын үнэлгээг хийсэн судалгаагаар (Х.Шүрэнцэцэг нар, 2003) хүн амын дунд ундны усны фторын агууламжийн ихсэлт болон багасалттай холбоотой үүсэх шүдний өвчин, усны чанар, нитраатас хамаарал хоол боловсруулах болон шээс, бэлгийн замын өвчлөл хамгийн өндөр тархалттай байгааг тогтоожээ.

Улаанбаатар хот болон аймгуудын эрүүл мэндийн хэлтэлүүд жил бүр үнд, ахуйн усанд хяналт шинжилгээг хийдэг бөгөөд Б. Золбоо нар (2003) дээрх албадын лабораториудад 1999-2001 онуудад хийгдсэн хими, нян судлалын шинжилгээнүүдийн үзүүлэлтийг нэгтгэж үнэлэлт, дүгнэлт өгчээ. Говьсүмбэр, Увс, Дархан, Төв, Баян-Өлгий, Сухбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Дорнод, Говь-Алтай, Дундговь, Хөвсгөл, Хэнтий аймгуудад сорьцын 0.9-50 хувьд хатуулагийн хэмжээ нормоос өндөр гарсан байна. Мөн дээрхи аймгуудад магнийн агууламж сорьцын 0.8-48 хувьд нормоос өндөр гарчээ. Төмрийн агууламж Дорнод, Хөвд, Увс, Хэнтий, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь аймгуудад сорьцын 2.7-36%-д нормоос өндөр гарсан байна.

Б.Золбоо нарын энэхүү судалгаагаар аймгуудын хэмжээнд усны нийт 2442 сорьцонд давхардсан тоогоор хими, физик, нян судлалын 10119 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 36.5% (3699) нь үндны усны шаардлага хангаагүйг тогтоожээ. Улсын хэмжээнд үндны усны 4296 эх үүсвэр байгааглаас ариун цэврийн хамгаалалтын бүсийг 27.9%-д тогтоосон, 93%-ийг паспортжуулсан байна.

Сүүлийн үед Улаанбаатар хотын дундуур урсан өнгөрдөг Туул гол зарим үед тасарч, хаврын гачиг үед нийслэлийн усан хангамжийн цооногуудын усны түвшин доошилж, улмаар усны хомсдол амсах үзэгдэл ажиглагдаг болжээ. Ер нь нийслэлийн усан хангамжийн 4 эх үүсвэр нь Туул голын көндий дагуу байрласан, энэ голтой шууд гидравлик холбоотой байдаг. Гол нь улирлын чанартай тэжээгддэг бөгөөд урсацын 60 гаруй хувийг бороо, цасны үе бүрдүүлдэг. Гэвч сүүлийн үед хүний үйл ажиллагаа, үрэлгэн хэрэглээнээс болоод усны нөөц багасч байгааглаас гадна хот улам бүр хүрээгээ тэлж, нэгэнт тогтоосон усны нөөц хүрэлцэхгүйд хүрч, 2010 оноос эхлээд Улаанбаатар хот усны гачаалд орж мэдэхээр байна (“Орчны бохирдлын төлөв байдал, хэрэгжих бүй арга хэмжээ” тайлан, 2003 он, 14 дүгээр тал).

1.3.3. Хөрсний бохирдол, хүн амд үзүүлэх сөрөг нөлөөлөл

1.3.3.1. Газрын хөрс нь агаар, усыг бодвол хөдөлгөөн багатай, нэг байрандаа удаан хугацаагаар оршин байдаг байгалийн тогвортой систем учраас тогоногенийн нөлөөллийн бүх хугацааны туршид ялгарч гарсан бохирдуулагч бодисуудыг еөртөө шингээж удаан хугацаагаар хадгалах чадвартайгаараа онцлог юм. Энэ учраас хөрсний бохирдлын судалгаа нь хот суурин газрын экологийн үнэлгээний салшгүй хэсэг болдог. Хот суурин газрын хөрсийг бохирдуулагч гол элемент нь агаарт цацагдсан хорт бодис, утаа тортог, газар дээрх хуурай, нойтон хог хаягдлаас үүсэлтэй.

Манай орны хувьд хөрсний бохирдлын судалгаа нилээд сайн хийгдсэн газар нь Улаанбаатар хот юм. Тус хотод орчны бохирдол үүсгэж байгаа гол эх үүсвэр нь жилд дунджаар 5 сая тонн нүүрс хэрэглэдэг дулааны цахилгаан станцууд, 250 гаруй уурын зуух, гэр хорооллын айл өрхүүд, 50 шахам мянган автомашинаас гарч буй утаа тортог, үнс хаягдал, үйлдвэрийн ба ахуйн хог хаягдал, хүний доторх болон хот тойрсон хогийн овоолгууд, автотехникийн шатах тослох материал борлуулах цэгүүд болж байна (Байгаль орчны төлөв байдлын 2002 оны тайлан, 15 дугаар тал).

Судалгааны дүнгээс үзэхэд Улаанбаатар хотын “Да хүрээ” техникийн захын тослох материал борлуулах талбай, хотын төвийн Бага тойруугийн засмал замуудын дагуу, зарим шатахуун түгээх, нөөцлөх газруудын хөрсөнд агуулагдах 11 хүнд элементийн дундаж ба хамгийн их агууламжийг хотын гаднах хөрсний агуулжтай харьцуулж үзэхэд никель, кобальт, ваннади 2-7 дахин, цайр, хром, молибден 2-14 дахин, харин хар тугалга, зэс, мышьяк, цагаан тугалга 2-42 дахин их агуулагдаж байна. Мөн хотын хойд болон зүүн хэсгээр байрлах гэр хорооллын хөрсөнд хар тугалга, зэс, цайр, никель зэрэг элементийн геохимийн аномаль илэрч байгаа ба энэ нь тухайн газруудад бохир усны нэгдсэн сүлжээ байхгүй, ахуйн хогийн замбараагүй олон цэгүүд байгаатай холбоотой юм. Эдгээр бохирдлын эмзэг хэсгүүдээс тооцвол Улаанбаатар хотын хөрсний ихэнх хэсэг нь өрөнхийдөө дунд ба бага бохирдолттой хэмжээнд байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын үндсэн голомтууд болох обьектууд нь орчныхоо агаарыг их хэмжээгээр бохирдуулсны улмаас хөрсийг бохирдуулах шалтгаан болж байна (Байгаль орчны яамны тогвортой көгжил, хүрээлэн буй орчны газрын судалгааны материал, 2003 он, 4 дүгээр тал).

1.3.3.2. Улаанбаатар хотын орчныг их хэмжээгээр бохирдуулж, хүн амын амьдрах нөхцлийг доройтуулж буй зүйлийн нэг нь хатуу хог хаягдал юм. Хот суурин газрын ойролцоо хог хаягдалд зориулсан төвлөрсөн хогийн цэгийн тоо жилээс жилд нэмэгдсээр байгаагаас гадна зориулалтын бус газарт хаясан хог хаягдал олон мянган га газрыг хамарч байна. Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод жилийн дунджаар нийт 452090 м^3 буюу 200 мянга орчим тн хог хаягдал ялгарууллж ямар нэгэн эргүүлэн боловсруулж ашиглалтгүйгээр байгальд хаягдаж байна (Байгаль

орчны яамны тогтвортой хөгжил, хүрээлэн бүй орчны газрын судалгааны материал, 2003 он, 4 дугаар тал).

Хотын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэдэг техник хэрэгсэл хуучирч эвдэрснээс парк ашиглалт 53 хувьтай, парк шинэчлэл сүүлийн жилүүдэд хийгдээгүйгээс зайлуулбал зохих хог хаягдлын 40 орчим хувийг зөөвөрлөж байна. Иймэ учраас хог хаягдал гудамж талбайд, ялангуяа гэр хорооллын орчим гуу, жалгуудаар хуримтлагдан үлдсээр байгаа юм. Томоохон хотуудад жерс бохирдуулдаг ноцтой эх үүсвэрүүдэд олон тоогоор бий болоод байгаа ШТС, шатах, тослох түүхий эд хадгалах баазууд, булан бүрт баригдах болсон авто үйлчилгээний цэгүүд, автомашины зогсоол, гараашууд, шатах, тослох материал борлуулдаг олон тооны худалдаачид, цэвэр усны нөөц, рашаан усны болон бусад экологийн эмзэг бүсэд баригдах болсон барилга байгууламж, арьс шир зэрэг үйлдвэрүүд, үйлчилгээ, ахуйн гаралтай хог хаягдал юм.

Улаанбаатар хотын хэмжээгээр гарч буй хог хаягдал (жилд)

№	Хог хаягдлын эх үүсвэр	$м^2$	тонн
1	Гэр хорооллоос	144.009	86.466
2	Орон сууцнаас	152.051	45.615
3	Гудамж, талбайн цэвэрлэгээнээс	15.442	6.117
4	Үйлдвэр, аж ахуйн газраас	75.977	30.391
5	Бусад	64.610	25.844
	Нийт	452.090	194.433

(Байгаль орчны төлөв байдлын 2001 оны тайлан, 2002 он, УБ хот, 45 дугаар хуудас)

1.3.3.3. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 686 ШТС, 250 уурын зуух ажиллаж, арьс ширний анхан шатны боловсруулалт хийдэг 53, нооц, нөөлөгчний 36 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, үйлдвэрээс гарч байгаа хүүрэй хог хаягдал болох ус, нооц, малын арьсны захаалгаа, тод шийр болон бусад хаягдал, лаг зэргийг хаяж нэгдсэн цэг байхгүйгээс хаа дуртай газраа хаяж хөрс, ус, агаарыг бохирдуулж, хот орчимд хогийн цэгийг шинээр үүсгэж байна.

Хөрсний бохирдол ихтэй газруудын нэг болох төмөр замын депод дизель түлшний алдагдлаас хөрс бохирдож улмаар гүний усны төвшинд хүрчээ. Толгойтын Нефть баазын хувьд ч нэвчсэн түлшний түрүүч өргөн далайцтайгаар доошилж 30м гүнд хүрч гүний усыг хэдийнээ бохирдуулаад байна.

1.3.3.4. Сүүлийн жилүүдэд хот суурин газарт хүн амын төвлөрөл нэмэгдсэний улмаас орчны агаар, ус, хөрсний бохирдол ихээсч байгалийн өөрөө цэвэршиж чанар алдагдаж байна. Үүнтэй холбогдуулан амьдрах орчны даац, уур амьсгалын хувьсал, өвөрмөлттэй холбон бохирдлын хэмжээг тодорхойлох, бохирдуулагч эх үүсвэрийн зохистой байршлыг тогтоох, ялгаруулж буй хаягдлыг багасгах, арилгах арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Хот суурин газрын ойролцоо хог хаягдал байрлуулахаар товлосон төвлөрсөн цэгийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаагаас гадна зориулалтын бус газар хаясан хог хаягдал олон мянган га газрыг хамарч хяналтаас гадуур газрын нөөц, орчныг бохирдуулж байна. Өнөөг хүртэл түс улсад байгаль орчинд халгүй, олон улсын жишигт нийцсэн хог хаягдлын нэгдсэн цэг байхгүй байна.

Харамсалтай нь энэ талаар агаар, усны адил байнгын мониторинг хийдэггүй, хөрс ашиглалтын хэм хэмжээг тодорхойлсон эрх зүйн үндэс от байхгүй байгаа нь ийм серег байдалд хүргэх үндэс болоод байна. Хөрсний шинжилгээний зардал өндөр, шууд бохирдлын үзэгдэх хэмжээ анзаарагддаггүй мэтийн шууд бус шалтгааныуд ч энд хамаарч байна.

1.3.3.5. Хөрсний, тэр тусмаа том хотуудын хөрсний бохирдол хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй байдал нь сэтгэл нэн түгшээсэн асуудлын нэг болжээ.

Н.Сайжаа нар (2003 он) "Монгол Улсын томоохон хотуудын хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх физик, хими, биологийн эрсдэлт хүчин зүйл, тэдгээрийн эрүүл ахуйн үнэлгээ" сэдэвт судалгааны ажлын хүрээнд томоохон хотуудын хөрсний бохирдлыг гол бохирдуулагчаар нь тодорхойлон харьцуулсан байна. Хөрсний нянгийн бохирдлыг харьцуулбал нянгийн еренхий тоогоор Дархан хотын хөрс, перфрингенс, гэдэсний булгийн савханцрын титрээр Улаанбаатар хотын хөрс хамгийн их бохирдолтой байна.

Улаанбаатар хотын хөрсөн дахь хар тугалгын дундаж хэмжээ 49.92 мг/кг буюу нормоос 2.4 дахин их, цайрын дундаж агуулламж 145.9 мг/кг буюу 2000 онд явуулсан энэ төрлийн судалгааныхаас 1.2 дахин их гарчээ. Эрдэнэт хотын хөрсөн дахь цайрын агуулламж 125.5 мг/кг буюу 1.1 дахин их, Дархан хотын хөрсөнд 149.5 мг/кг буюу 1.4 дахин их, хар тугалга нормоос хэтрээгүй байна. Чойбалсан хотын хөрсөн дахь хар тугалгын дундаж агуулламж 58.4 мг/кг буюу нормоос 2.8 дахин их гэж гарчээ.

Томоохон хотуудын хүн амын өвчлөлд суурьшил ахуйн орчны эрсдэлт хүчин зүйлүүдийн нөлөөллийн хувийг авч үзэхэд хөрсний бохирдолтоос үүсэх хар тугалга нь дагнасан буюу хавсарсан байдлаар нөлөөлж буй нь тогтоогджээ. Хоол боловсруулах замын өвчлөл үүсэхэд суурьшил ахуйн орчны хөрсөн дэх кобальт, хар тугалга, мөнгөн нь дагнасан буюу хавсарсан байдлаар нөлөөлж байсан байна.

Хот суурин газарт агаар, ус, хөрс бохирдуулагч гол бодисын нэг болох хар тугалга хүний биеийн бараг бүх эрхтэн тогтолцоонд серег нөлөө үзүүлдэг хортой бодис юм. Б.Бурмаа нарын (2002 он) хийсэн "Хүрээлэн бүй орчны хар тугалгын бохирдолт, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн түвшин, эрүүл ахуйн үнэлгээ, сэргийлэх арга" сэдэвт судалгаа Улаанбаатар хотод агаар, ус хөрсөнд агуулагдаж байгаа хар тугалганы хүүхдийн бойжилт, сэтгэхүйн хөгжил, эрүүл мэндэд үзүүлж буй серег нөлөөллийг их бүрнээр гаргажээ. Хүүхдийн бие махбодь насанд хүрэгчидтэй харьцуулбал хар тугалгыг амархан шингээж авдаг, өсөж хөгжих бүй тархи нь хар

тугалганы үйлчлэгч илүү ертөмтгий байдгийг олон орны эрдэмтдийн судалгаа харуулж байна.

Монгол Улсад ОХУ, БНХАУ-аас импортоор орж ирж байгаа бензин нь хар тугалганы агуулгатай бөгөөд өндөр хөгжилтэй орнуудад иймт төрлийн бензинийг ашиглах явдлыг хориглосон байдаг юм. Ц.Бат-Өлзий нарын судалснаар Автомашины бензины хар тугалгын 15% нь моторын ажиллагаанд зарцуулагдаж, 85 % нь хүрээлэн байгаа орчинд хаягдаг ажээ. Автомашин, ялангуяа хуучин автомашин орчныг илүү бохирдуулж байгаа бөгөөд зөвхөн 2001 оны Улаанбаатар хотын автомашины тооллогоор 70 гаруй хувь нь улсын стандартын шаардлагыг хангахгүй байгааг илрүүлжээ (БОТБ тайлан, 2001 он). 2003 оны байдлаар 500 гаруй төрлийн 59 мянга гаруй автомашин байгаагаас, 40.3 % үйлдвэрлэгдсэд 11-эс дээш жил болсон, 21 % нь 7-10 жил болсон хуучин загварын, түлш их зарцуулдаг тээврийн хэрэгслүүд эзэлж байна. 2003 оны техникийн үзлэгээр нийт 421616 автомашин (Ц. Банзрагч, 2004 он) орсноос үгүй их ялгарууль байгаа шалгаанаар 492 техникийн хэрэгсэл үзлэгт тэнцээгүй гэсэн дүн гарсан байна. Энэ дүнг Улаанбаатар хотод бүртгэлтэй хуучин тээврийн хэрэгслийн тоотой харьцуулахад дэндүү бага тоо гарч байна.

Улаанбаатар хотын хөрсөнд хар тугалгын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 4.5 дахин, агаарт 2.3 дахин их, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Сүхбаатар дүүргүүдэд хүрээлэн буй орчны хар тугалгын бохирдол ихтэй байна. Эдгээр дүүргүүдэд дулааны цахилгаан станцууд, авто паркууд байрладаг нь бохирдлын ихэсгэхэд нөлөөлдөг.

1.3.4. Байгалийн тэнцвэрт байдлын алдагдал гамшиг, үр урших

1.3.4.1. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны экологийн тэнцвэр алдагдаж байгаагын нөлөөгөөр сүүлийн жилүүдэд манай гариг ихэнх бүс нутагт байгалийн гамшгийн давтамж ихэсч тэдгээрийн үр дагавар, хор хөнөөл улам нэмэгдэж байна. Олон улсын хэмжээнд хүн амыг олноор хөнөөн сүйтгэх, тухайн орны эдийн засагт их хэмжээн хохирол учруулж болзошгүйд тооцогдсог 20 гаруй гамшиг, ослоос манай оронд 10 гаруй нь байнга тохиолдож байна. Тухайлбал, 1992-2002 онуудад их цас зуд 9 удаа, хүчтэй шороон шуурга 40 гаруй удаа, хүн, малын гоц аюулт халдварт өвчин 42 удаа, цацрагийн болон хүчтэй үйлчилгээтэй химийн хорт бодисын алдагдал 6 удаа болж, Налайхын уурхайн нуралт, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өмнөговь, Увс аймгийн төвийн уурын зуухны хөлдөлт, 3, 4-р цахилгаан станцын зогсолт, онгоцны 5 осол, сүйрэл зэрэг байгалийн болон үйлдвэрийн осол их тохиолдлоо. Эдгээр гамшиг, ослын улмаас 458 хүн амь насаа алдаж, 14.4 сая шахам мал хорогдож 380 гаруй тэрбум төгрөгний хохирол учирчээ (С.Батчулуун, 2004 он).

Хангай, говь хосолсон өргөн уудам нутагтай, бэлчээрийн мал аж ахуй, усалгаагүй газар тариалан эрхэлдэг манай орны хувьд өвөлдөө цас зуд, хавартаа салхи шуурга, ой хээрийн түймэр, зундаа ган, үер, намартаа их салхи, нойтон цас, хүйтэн бороо, шороон болон цасан шуурга зэлхэн жилийн 4 улиралд байгалийн гамшигт үзэгдэл давтагдаж түүнээс хүлээх хохирол буурахгүй байна.

Бэлчээрийн даац муудаж, хүн амын төвлөрөл ихэсч, ой модыг их хэмжээгээр сүйтгэн, ган, цөлжилтийн аюулыг ихэсгэж байгаа болон зах зээлийн харилцаанд шилжих явцад байгалийн гамшигтай тэмцэх эдийн засгийн бааз суларч, удирдлага зохион байгуулалт алдагдаж, ард иргэдийн, малчдын байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх уламжлалт арга ажиллагаа суларсан зэрэг нь байгалийн гамшгийн эрсдэл, хохирлыг нэмэгдүүлж байна.


1.3.4.2. Хот суурин газарт хот төлөвлөлт, нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөгдмэл бодлого байхгүй, зохицуулалт, эдийн засгийн чадавхи муугаас оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдсөөр байна.

Үүний нэг илрэл нь томоохон хот суурин газруудын явган хүн болон авто хөсөг зорчих зам харгуй өвлийн улиралд халтиргаа гулгаа ихтэй болдог явдал юм. Үүний улмаас хүмүүс ялангуяа, хүүхэд, хөгшчүүл илүүтэйгээр халтирч, гэмтэж бэртэх, автын осолд орох, улмаар амь насаа алдах явдал их хэмжээгээр гарч байна.

Улаанбаатар хотын Гэмтэл согог сэргээн засах клиникийн эмнэлгийн мэдээгээр 2001-2002 оны өвлийн улиралд зөвхөн хальтиргаа, гулгаанаас гэмтэн 2150 хүн ираалтай тусламжаар, 300 гаруй хүн удаан хугацаанд хэвтэж эмчлүүлжээ. Харин эдгээр тоо баримт 2003 онд нэмэгдэж ираалтай тусламж хүртэсн хүн 2280 буюу 6 хувиар, удаан хугацаанд хэвтэж эмчлүүлсэн хүн 408 буюу өмнөх оныхоос 36 хувиар нэмэгджээ.



Зөвхөн хотын гудамж талбайд хальтирч унаснаас 2002, 2003 онуудад яаралтай эмнэлгийн тусламжаар ирсэн хүмүүс тус бүр 0.8 ба 0.912 сая төгрөгийн зардал гарган эмчлүүлсэн бол 2002 онд удаан хугацаанд хэвтэн эмчлүүлсэн 300 хүн 16.8 сая төгрөг, 2003 онд 408 хүн 22.85 сая төгрөгийн зардал гарган, материаллаг баялаг, бие сэтгэл, цаг хугацаагаараа хохирч нөхөн сэргээгдсэн байна (С.Лхагвасүрэн, 2004 он).




Хальтиргаа, гулгаанаас гэмтэл авч яаралтай эмнэлгийн тусламж хүртсэн хүмүүсийн гэмтлийн төрлийг авч үзвэл биеийн дээд, доод мөчний хугаралтай хүмүүс зонхилох байрыг эзэлж байгаа бөгөөд удаах байрыг тархиндаа гэмтэл авсан хүмүүс эзэлжээ. Харин удаан хугацаагаар эмчлүүлсэн хүмүүсийн зонхилох хэсэг нь хөл хугарсан оноштой бөгөөд тархи гэмтсэн болон гар хугарсан хүмүүс тус тус удаалж байна. Мөч хугарсан болон тархиндаа гэмтэл авсан хүн дунджаар нэг сар гэрээр эсвэл эмнэлгээр эмчлүүлдэг бөгөөд хот төлөвлөлт, байгуулалтын муу стандарт, хэрэгжүүлэлт болон тохижилт, цэвэрлэгээний байгууллагын хэвийн бус ажиллагаанаас шалтгаалан өвлийн улиралд хот суурин газрын оршин суугчид байнгын гэмтэж, бартэх, авто хэрэгсэлд ертэж амь насаа алдах аюул заналд амьдарч байгаа нь эдгээр статистик мэдээнээс харагдаж байна.

1.3.4.3. Хүн ам шигүү суудаг хот суурингийн орчинтой холбоотой олон асуудлын нэгэн болох гудамжны дуу шуугианы түвшин ихэссэнээр хүний бие махбодийн еренхий өвчлөлийг нэмэгдүүлэх, физиологийн хариу урвал-сэтгэхүйн тааламжгүй нөлөө үзүүлдэг бөгөөд гадаад орчны шуугианы 60 хувийг тээврийн хэрэгслээс үүдэх шуугиан эзэлдэг нь эрдэмтдийн судалгаагаар нэгэнт тогтоогджээ.



Н.Сайжаа нар Монгол Улсын томоохон хотууд (Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Чойбалсан)-ын суурьшил ахуйн орчны эрсдэл үүсгэх физикийн хүчин зүйлүүдийг тогтоож, зөрүүл ахуйн үнэлгээ өгөх ажлын хүрээнд гудамжны чимээ шуугиан хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж буйг анхлан 1996 онд судалжээ. Шаталсан судалгааг 2000, 2003 онуудад (Ж. Купул нар, 2003 он) хийж Улаанбаатар хот болон бусад хотуудын хамгийн шуугиан ихтэй цэгүүдийг тогтоон дуу шуугианы стандартын түвшинтэй харьцуулан дүгнэлт гаргажээ.




Шуугианы эх үүсвэрүүд /давхардсан тоогоор/

Шуугианы түвшин Улаанбаатар хотод 1996 онд 71 дБ, 2000 онд баруун 4 замын ойролцоо 79-84 дБ болж нэмэгдсэн байх бөгөөд 2003 онд Улаанбаатар хотод дунджаар 80 дБ, Эрдэнэтэд 70.8 дБ, Дарханд 59дБ, Чойбалсанд 58 дБ байв. Улаанбаатар хотын гудамжны дуу шуугианы түвшин 2003 оны байдлаар Эрдэнэт, Дархан хотуудаас өндөр, ДЭМБ-ын зөвлөмжөөс (70 дБ) харьцуулахад 1.1 дахин их байлаа.

Энэ судалгааны хүрээнд том хотуудын оршин суугчдын дунд явуулсан асуумж судалгааны үр дүнгээс үзэхэд оролцогсдын 51.9% нь тухайн орчинд 15-аас дээш жил амьдарч байгаа бөгөөд 45-аас дээш настай (63.5%) хүмүүст шуугиан илүү нөлөөлж байгаа ба 84.4% нь автомашины дуу шуугиан бусад шуугианаас илүү их нөлөөлдөг гэж хариулжээ (Н.Сайжаа, 2003 он).

Дуу шуугианаас болж илрэх зовиуруудаас толгой өвдөх (46.6%), нойргүйдэх (22%), уур хүрэх (28.7%) зовиур зонхилж байна.



Шуугианы нөлөөллөөс үүсэх зовиур /хотуудаар/

1.4. Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн талаар

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг зохицуулж буй гол гол хуулиуд шинэчлэн өөрчлөгдөж зарим наастай өөрчлөлт шинэчлэлт орсон боловч бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал цорын ганц байдлаар шийдэгдсэнгүй. Нөгөө талаар хуулийг хэрэгжүүлж буй байгууллагууд өөрсдийн эрх хэмжээний дотор асуудлыг бүрэн шийдэхгүй байна.

1.4.1. Иргэний хуульд "бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд санаатай буюу санамсаргүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгах үүрэгтэй" гэж, Эрүүгийн хуульд "гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ" гэж тодорхойлжээ. Хууль тогтоомжийн өнөөгийн байдлыг судлан үзвэл зөвхөн эд хөрөнгийн бодитой хохирол, гарсан зардлыг төлүүлэх эрх зүйн орчин бүрдэж, харин амь насны, бие эрхтэний, сэтгэл санааны, эрхийн хохирол (эд хөрөнгийн бус)-ыг арилгах хууль, эрх зүйн орчин тедийлэн бүрдээгүй гэж үзэж болохоор байна.

Өнөөгийн хууль тогтоомжоор бусдын амь насыг хохироосон тохиолдолд зөвхөн талийгаачийг оршуулахтай холбоотой шууд зардал, талийгаачийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй этгээдэд дундаж цалин болон тэжээгчээ алдсаны тэтгэвэрийн зөрүүгээр нөхөн төлбөр олгох тедийгээр хязгаарлагдаж байна. Түүгээр ч үл барам энэ төрлийн хэргийн хохирол шийдвэрлэлтийг судлан үзэхэд лам, сүм хийдээр ном үншуулсны болон 21, 49 хоногийн хоног тараах ёслолтой холбоотой гарсан бодит зардлыг хүртэл шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байна.

Нийслэл хотод 2002 онд хянан шийдвэрлэсэн бусдыг санаатай алсан 56 хэргийн хохирол шийдвэрлэлтийг судлан үзэхэд 5 хэрэгт 21, 49 хоногийн зан үйл, ном үншуулсантай холбоотойгоор гарсан зардлуудыг шүүх "зан үйлтэй холбоотой" хэмээн хэрэгсэхүй болгожээ.

Эхнэр, нөхөр, үр хүүхэд, ойр дотнын хүнээсээ хагацан салсан хохирогчдын сэтгэл санааны хүнд гарз хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлдөг орчин бүрдээгүй, иргэд сэтгэл санааны хохирол нэхэмжилдэг ч түүнийг нь хэрэгсэхүй болгож шийдвэрлэдэг практик тогтсон байна.

1.4.2. Иргэний хуулиар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ сэлт тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөн төлбөр төлөхөөр хуульчлагдаж, энэ зүйл хэсгээр шүүхүүд нэлээд тооны өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэж байна. Үүнийг эд хөрөнгийн бус (сэтгэл санаа, нэр төрийн) гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгаж буй цорын ганц тохиолдол гэж үзэж болохоор байна. Бусдын нэр төрийг гутаасны төлөө мөнгө төлүүлэхээр шийдвэрлэж болж байхад бусдын амь насыг хохироосонтой холбоотой хохирлыг мөнгөн хэлбэрээр гаргахүй байгаар зөв гэж тайлбарлаж боломжгүй.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай УДШ-ийн 2000 оны 1 дугээр сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолоор нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирол хүлээсэн этгээдийн хохирлын хэмжээг мөнгөн илэрхийллээр тогтоох боломжгүй бөгөөд бие эрхтэний хохирол хүлээсэн этгээдэд шууд гарсан зардлыг, хохирогч нас барсан бол оршуулахтай холбоотой шууд зардлыг төлүүлж, харин нас барагчийн хоног тараах гэх мэт зан үйлтэй холбоотой зардлыг гэмт хэргийн улмаас учирсан хохиролд оруулж тооцохгүй байхаар удирдамж тайлбар өгчээ.

Түүнчлэн бусдын бие эрхтэнд санаатайгаар гэмтэл учруулсан тохиолдолд хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, эмчлүүлэх, сувилуулах, хиймэл эрхтэн хийлгэхтэй холбогдон гарсан шууд зардлыг төлүүлэхээр Иргэний хуульд заажээ.

Жил бүр гэмт хэргийн улмаас олон зуун иргэн амь насаа алдаж, бие эрхтэндээ бэртэл гэмтэл авч, бие эрхтэнээсээ хагацаж, байнгын тахир дутуу болж зовж шаналж байна. Гэтэл тэдэнд зөвхөн шууд гарсан зардлыг л төлүүлдэг хууль үйлчилж байна. Бусдыг байнгын тахир дутуу болгож, бие эрхтэнийх нь хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, зарим эрхтэнээс нь салгаж (гар хөлгүй, хараагүй болгох), гоо үзэмжинд нь засаршгүй шарх сорви үлдээсний төлөө сэтгэл санааны болон бие эрхтэний илүү хариуцлага тооцдог тогтолцоо зайлшгүй шаардлагатай байна.

1.4.3. Суулийн жилүүдэд манай улсад гарч байгаа гэмт хэргүүдийн дундаас иргэдийн өмчийн эсрэг гэмт хэрэг зонхилох хувийг эзэлж байна. Иргэдийн өмчийг хулгайлах, залилан мэхлэх, завших гэмт хэргийн улмаас учирч буй хохирол нь хэдэн зуун сая тооцогддог болсон. Эдгээр гэмт хэргүүдийг илрүүлэн зохих ял шийтгэлийг здлүүлдэг ч хохирол төлөгдөлтийн хувь хэмжээ тедийлэн сайн биш байна. Гэмт хэрэгтнийг илрүүлж хуулийн ял эзмлэл хүлээлгэхийн зэрэгцээгээр хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах ажилд хуулийн байгууллагын (хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх) анхаарлыг хандуулах шаардлагатай байна.

Шүүхийн статистик мэдээ судалгаанаас харахад гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлын хэмжээ жил дараалан өсөх хандлагатай болсон байна. Үүнийг дараах баримтаас харж болно.

Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол						
	Амь хохирсон	Хүнд гэмтэл	Хүндэвтэр гэмтэл	Хөнгөн гэмтэл	Иргэдэд	Улсад	Аж ахуйн нэгж, байгууллагад
2000	544	515	789	1812	3 тэрбум 249 сая	2 тэрбум 3 сая	457 сая
2001	476	520	726	2482	4 тэрбум 448 сая	1 тэрбум 281 сая	2 тэрбум 612 сая
2002	512	563	709	1681	4 тэрбум 502 сая	1 тэрбум 243 сая	956 сая

ХЭҮК, УДШ-ийн судалгааны төвтэй хамтарч бүсдыг санаатай алах, бүсдын биед санаатай гэмтэл учруулах, бүсдын өмчийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирол төлүүлэлтийн талаар судалгаа хийж үзэхэд хохирогчийн хохирлыг барагдуулахад шийдвэрлэх ач холбогдолтой арга хэмжээ болох хэрэгт холбогдогдын эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгө хамгаалахыг ЭБША-ны эхний үе шатнаас анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.

Бүсдыг санаатай алсан, бүсдын биед санаатайгаар гэмтэл учруулсан, иргэдийн өмчийг хулгайлсан, завшсан, залилсан зэрэг 519 хэрэгт судалгаа хийж үзэхэд хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд зөвхөн 33 гэмт хэрэгт холбогдогчийн эд хөрөнгө болон харилцах хадгаламжид байсан мөнгө хөрөнгийг битүүмжилж нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авч байсан байна.

Прокурорын хяналтын (ялын дүгнэлт бичих) буюу шүүхийн шатанд ч хөрөнгөө битүүмжилж болохоор хуульд тусгагдсан ч энэ хоёр шатанд хөрөнгө битүүмжилсэн тохиолдол гараагүй байна.

Бүсдыг санаатай алсан 56 хэрэгт нэг ч удаа хөрөнгө хамгаалаагүй, бүсдын биед хүнд гэмтэл учруулсан 105 хэрэгт хоёрхон удаа хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсан байв. Судалгаанд хамрагдсан бүх хэргийн дөнгөж 34.4 хувьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирол нь бүрэн төлөгдөж байсан байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны шийдвэр гүйцэтгэгчдийн (40 шахам хүн хамрагдсан) дунд санал асуулга явуулж, төлбөр төлөгчийн хөрөнгийг хамгаалах, битүүмжлэх ажиллагаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэр байдаг вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 72.2% нь бараг байдагүй гэж, 25.0% нь цөөвтөр гэж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд юуг анхаарах хэрэгтэй вэ гэсэн асуултанд 58.3% нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хамгаалах, битүүмжлэх гэж, 36.1% нь төлбөр төлөгчийн хаяг, оршин суугаа газрыг тодорхой болгоход анхаарах хэрэгтэй гэж хариулсан байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирогчийг хамгаалах, сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд дэмжих туслах, хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох, гэмт хэрэгтний нуугдмал хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө хамгаалах, битүүмжлэх ажиллагаа эхнээс нь эхэлж чанартай гүйцэтгэх зэрэг хохирол төлүүлэлтийн баталгааг хангахад ихээхэн анхаарах хэрэгтэй байна.

1.4.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль шинээр батлагдаж, шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаат тойргийн системд шилжүүлж, бодитойгоор биелүүлэхэд төлбөрөөс тодорхой хувиар шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулдаг шинэ тогтолцоонд шилжсэн. Шийдвэр гүйцэтгэчийн үйл ажиллагаанд ШШБЕГ-ын болон Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны мэдээ тайлангаас үзвэл шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаанд зарим наашаа ахиц ажиглагдсан байна. 2002 онд улсын хэмжээгээр 9417 хүнд холбогдох 9994.8 сая төгрөгний төлбөрийг бодитойгоор биелүүлж, бодит биелэлтийн хувь 35.6%-тай байсан бол 2003 онд 16380 хүнд холбогдох 32137.8 сая төгрөгний төлбөрийг биелүүлж бодит биелэлт 56.7%-д хүрчээ.

Түүнчлэн хорих ял эдэлж буй ялтнаас хохирол, төлбөрөө төлөх явдал өмнөх онуудад бараг байдаггүй байсан бол 2002 онд хорих ял эдэлж буй 565 ялтан 582.1 сая төгрөгийн төлбөр төлсөн тухай Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны мэдээнд тусгагдсан байна. Энэ нь хохирол төлбөрөө төлөөгүй ялтныг хугацаанаас нь өмнө тэнсэн сулладагүй болсон хуулийн өөрчлөлтийн эерэг үр дагавар гэж үзэж болно. Гэсэн хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт доогуур, жил бүр олон мянган хүн төлбөр, хохирлоо авч чадахгүй хохирсоор байна. 2003 оны ШШБЕГ-ын мэдээгээр 17.8 мянган хүнд холбогдох 16911.7 сая төгрөгний төлбөр төлөгдөөгүй байв.

1.4.5. Бүсдад гэм хор учруулж, шүүхийн шийдвэрээр хохирол төлбөр төлөх ёстой этгээд эрэгсэлээ тодорхой ажилгүй, тогтмол орлогогүй,

төлберийн чадваргүй байх нь хохирол төлбөр төлөгдөөгүй байх гол шалтгаан болж байна. Иймээс хохирогчын хохирлыг төрөөс урьдчилан төлж, дараа нь төлбөр төлөгчөөс гаргуулах зохицуулалтыг хийх шаардлагатай.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэгчийн ажлын норм, хэмжээг ч шинжлэх ухааны үндэстэй тогтоож, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах шаардлагатай байна.

Мэдээ судалгаанаас үзвэл нийслэл, Дорнод, Хөвсгөл, Орхон аймгуудад хамгийн их ачаалалтай байна. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албд 2003 онд 21187 гүйцэтгэх хуудсанд ажиллагаа хийсэн нь улсын хэмжээний гүйцэтгэх хуудасны 61.9 хувийг эзэлж, нэг гүйцэтгэгч жилд 385 гүйцэтгэх хуудсанд, ажлын 1 хоногт 1.5 гүйцэтгэх хуудсанд ажиллагаа хийж барагдуулахаар тооцоо гарчээ.

Шийдвэр гүйцэтгэгчдийн ачаалллыг судалж, норм хэмжээг зөв тогтоож, зарим ачаалал ихтэй тойргуудад шийдвэр гүйцэтгэгчдийн орон тоог нэмэгдүүлэх асуудлыг судалж үзэх шаардлагатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний үнийн дүнгээс 0.5-10 хувиар урамшуулна гэж заасан боловч энэ нь эрүүгийн хэргийн тогтоолоор гаргуулах төлбөрийг биелүүлэхэд хамаарахгүй байхаар тогтоосон байна.

Иймээс шийдвэр гүйцэтгэгчид ямар ч урамшуулал шагналгүй зүйлийг биелүүлэх сонирхол хэр байх нь ойлгомжтой.

1.5. Уул уурхайн салбарт ажиллагсдын эрхийн төлөв байдал

Монгол Улсын Засгийн газраас 1992 онд "Алт" хөтөлбөрийг батлан гаргаснаас хойш алт олборлох уурхайнуудын үйл ажиллагаа эрчимжиж, энэ салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн, тус чиглэлийн үйлдвэр компаниудын тоо ч өссөөр байна. 2002 оны эцэс гэхэд алтны 130 шахам аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, мөн онд уул уурхайн салбарт нийт 16394 хүн ажилласны 5190 хүн буюу 31.6% нь зөвхөн алтны уурхайнуудад ажиллаж байжээ (АМХЭГ, Геологи-Уул уурхайн салбарын 2002 оны үйл ажиллагааны тухай, ЗГХА, АМХЭГ). Үүгээр зогсохгүй хувираа гар аргаар ашигт малтмал олборлох боллоо.

2003 оны байдлаар гар аргаар алт олборлож байгаа иргэдийн тоог зарим сумдын Засаг дарга, алт олборлож буй аж ахуйн нэгжээс авсан мэдээнээс үзвэл, ойролцоогоор 30 мянга орчим хүн энэ төрлийн ажил эрхэлж, 2002 онд 50 гарүй кг алт олборлож Монгол Банкны эрдэнэсийн санд тушаасан байна (Гар аргаар ашигт малтмал олборлох тухай хуулийн төслийн танилцуулгаас).

Иймээс уул уурхайн албан болон албан бус салбарт ажиллагсдын хөдөлмөрлэхэй холбоотой эрхийн төлөв байдал ямар түвшинд байгаа, энэ чиглэлээр хүний эрх, ялангуяа хүний хөдөлмөрлөх эрхийн олон улсын суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан эрхийн талаарх судалгаа, хяналт шалгалтыг ХЭҮК-оос МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны оролцоотойгоор явуулсан болно.

Шалгалт судалгаанд алтны 20 уурхай, нүүрсний 8 уурхай, жонш, хайрганы зарим уурхайд ажиллагч 3800 гаруй хүн хамрагдсан ба гар аргаар алт олборлогсдын эрхийн талаар ч зарим мэдээллийг авсан болно.

15.1. Хөдөлмөрийн гэрээний агуулга нь ажилтны хөдөлмөрлөх эрхийн зарим шаардлагыг хангахгүй байгаагийн зэрэгцүүх хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх, хугацаат тохирох, гэрээг албан ёсны болгон нэг хувийг тухайн ажилтанд өгдөггүй зэрэг нийтлэг зөрчил байсаар байна. Тухайлбал, "Монгол Болгар-гео" УҮГ-ын Жаргалантын уурхайн ажилтан нартай байгуулсан хөдөлмөрийн гэрээний 1.8-д '... Захиргаа санал тавьсан нөхцөлд гэрээний хугацаа дуусгавар болно", гэрээний тайлбарт "Хэзрийн үйлдвэрлэлийн үед ажилтнуудыг орон суугаар хангах үүргийг захиргаа хүлээхгүй" гэсэн заалт оруулсан нь "Алтан Дорнод Монгол" ХК-ны хөдөлмөрийн гэрээний 1.7-д 3 сар хүртэл туршилтын хугацаа тогтоож сарын цалингийн 40 хувиар цалинжуулж туршилтын хугацаа дуусч, цаашид ажиллахаар болвол дутуу олгосон 60 хувийг нөхөн олгохоор заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна.

Түүнчлэн гэрээний гол нөхцөлийг ажил олгогч дангаараа санаачлан урьдчилан бичиж гарын үсэг зуруулдаг, улирлын чанартай ажилд ажилтантай хөдөлмөрийн гэрээг заавал 3 сараар байгуулж дахин сунгадаг, гэрээний нэг хувийг ажилтанд олгодоггүй зөрчил нийтлэг байна.

Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж байгаа өмнө дурьдсан байгуулагуудын хувьд ч хөдөлмөрийн гэрээнд албан тушаал /ажлын байр/-ын онцлогт тохируулан ажилтны эдлэх эрх, тэдэнд үүүлэх хөнгөлөлт, ажлын нөхцөл, хүлээх үүрэг, хариуцлага, өөр ажил тур орлон гүйцэтгүүлэх нөхцөл болзол, албан тушаалын онцлогийг харгалзан эд хөрөнгийн хязгаарлагдмал болон бүрэн хариуцлага хүлээлгэх үндэслэл, ажилтан нарын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар 2 талын хүлээх үүргийг тодорхой тусгаагүй дутагдал нийтлэг байна.

Зарим алтны уурхайнууд ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй ажил үйлчэгээ гэрээ байгуулан ажиллуулж, тэдний эдлэх эрх, хөнгөлөлтүүдийг хязгаарлан хохироосон явдал ч

байна. Тухайлбал, Өверхангай аймгийн Уянга сум дахь "Эрэл" ХХК-ний харъяа Өлтийн алтны уурхай ихэнх ажилтнаа ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллуулж байлаа.

Түүнчлэн шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудаас "Хөдөлмөрийн маргаан таслах комисс" байгуулан ажиллаж буй байгууллага "Шижир алт" ХХК-иас өөр алга байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн маргаан гарсан тохиолдол сүүлийн 2 жил гаруй хугацаанд бүртгүүлээгүй байгаа боловч ажилчдаас ирсэн өргөдөл, гомдлыг захирганы журмаар гол төлөв нэг талыг барьж шийдвэрлэсэн байх бэ үүнээс дүгнэлт хийхэд цаашид хөдөлмөрийн маргаан гарахгүй гэх үндэслэл байхгүй байна.

1.5.2. Судалгааны явцад 200 шахам хүнээс санал асуулга авахад "Алтан Дорнод Монгол", "Шижир алт" ХХК-ны зэрэг байгшын ажиллагаатай алтны үйлдвэрээс бусад уурхайд ажиллагсад 7 хоногт дунджаар 8-12 цаг илүү ажилладаг бөгөөд долоо хоногийн амралтын өдөр ажилласан хугацааны амралтыг биеэр нөхөн эдлүүлдэггүй, илүү цагийн хөлсийг ч олгодоггүй байна. Харин нүүрсний уурхай, жоншны үйлдвэрт ажиллагсад алтны үйлдвэр, уурхайд ажиллагсдыг бодвол илүү цаг харьцангуй бага ажилладж, ням гариг, нийтээр амрах баярын өдөр амардаг. Түүнчлэн ажилтны бууруу биш шалтгаанаар сул зогссон үед ажил олгоч сул зогсолтын олговор олгох байтал сул зогсолтын үед ажилчдыг амраадаг, бас хээрийн нөмэгдэл өгдөг тул илүү цагийн хөлс олгохгүй гэсэн хандлага ч байсан болно.

Улирлын чанартай ажилладаг алтны болон нүүрсний уурхайнуудад шөнийн цагийн нөмэгдэл, сул зогсолтын үеийн олговор олгогдохгүй байгаа нь хамтын гэрээгүй, сул зогсолтыг нарийн бүртгэж тооцдоггүй, ажил олгогч болон ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, цалин, нөмэгдэл хөлс, олговрын талаархи мэдлэг хомс байгаатай холбоотой байна.

Монгол улс 1969 онд нэгдэн орсон "Ижил хөдөлмөрт адил хөлс олгох тухай" Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 100 дугаар Конвенцид ижил хөдөлмөрт адил хөлс олгох, ижил хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил тэнцүү шан олгох тухай тусгайлан заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулинд эдгээр асуудал тодорхой тусгагдсан байдаг. Гэтэл энэ зарчим тэр бүр, алангуяа гадаадын хөрөнгө оруулалттай компанийд дээр хэрэгжихгүй байна.

"Алтан Дорнод Монгол" ХХК-ний Арнаймганы алтны үйлдвэрийн ОХУ-ын иргэн гагнуурчинд 320 ам.доллар өгч байхад Монгол улсын иргэн гагнуурчинд 175 ам.долларын цалин олгож байв.

Уул уурхайн үйлдвэр, байгууллагад ажлын онцлог гэдгээр голлон шалтгаалж Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг дордуулан ажилтны цалинг сард нэг удаа (тогтоосон өдөрт) өгөхээр хөдөлмөрийн дотсод журам, бүр хамтын гэрээндээ тусган хууль зөрчдөг хэвшил тогтсон байна. Түүгээр ч зогсохгүй хугацаандаа цалин тавьж чадахгүй байх зөрчил цөөнгүй гардаг байна. Тухайлбал, "Селигдария Монголия" ХХК-ны Өлзийт тохой дахь уурхайн зарим монгол ажилтан 3 сар ажиллаад цалин авааргүй тохиолдол ч гарч байжээ.

Судалгаанд хамрагдсан ажиллагсдын 52.0% нь долоо хоногийн амралтын өдөр болон илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг авааргүй эсвэл нөхөн амраагүй гэж хариулсан байна.

1.5.3. Уул уурхайн салбарт Хөдөлмөрийн хууль дахь амрах эрхтэй холбоотой зөрчлүүд их байна. Ихэнх уурхайнууд оргил ачааллынхаа үед хоёр ээлжээр ажиллахдаа нэг ээлжийг 10-12 цагаар буюу 12 цаг амарч, 12 цаг ажиллаж, долоо хоногт дунджаар 70-80 цаг ажилладаг гэсэн тооцоо гарч байна.

Зөвхөн алтны уурхайн албан салбарт ажиллаж байгаа 120 гаруй хүнээс авсан судалгаагаар өдерт 71.7% нь 8-аас дээш илүү цагаар ажилладаг бөгөөд 59.8% нь долоо хоногийн амралтын өдрүүдэд огт амардаггүй гэж хариулжээ (ХЭҮК-оос хийсэн анкетийн судалгааны тайлангаас).

Судалгаанд хамрагдагсдын долоо хоногийн нийт ажилласан цагийг судлахад Хөдөлмөрийн тухай хуульд заасан хэмжээнээс дунджаар 27-39 цагаар илүү ажилладаг байна.

Ингэж илүү цагаар ажиллуулдаг, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баяр, ёслолын өдөр ажиллуулаад нөхөн амраадаггүй шалтгаанаа уурхайн удирдлагууд тайлбарлахдаа алт оборлох үйл ажиллагаа нь дулааны улирал болох 4-10 дугаар сарын хооронд жилд 6-7 сарын хугацаатай ажиллаад хүйтний улиралд ажил нь үндсэндээ зогсдог учир энэ үед нөхөн амардаг гэж ярьж байсан. Энэ нь зарим талаар үндэстэй боловч уурхайн ажил зогсох үед ихэнх ажилтнуудыг мөнгөтэйгээр ээлжийн амралтыг олгохын оронд ажлаас нь шууд чөлөөлж, хөдөлмөрийн гэрээгээ цуцлаад явуулж буй нь ажилчдад хохиролтой юм.

Судалгаанд хамрагдагсдын (127 хүн) 61 хүн буюу 48.0% нь ээлжийн амралтаа биеэр эдэлдэг, 12 хүн буюу 9.4% нь нөхөн олговор авдаг, үлдсэн 54 хүн буюу 42.5% нь ээлжийн амралт ч авдаггүй, нөхөн олговор ч авдаггүй байна.

Зарим уурхайнууд улирлын чанартай ажил гээд ажиллагсдын ээлжийн амралт болон амралтын нөхөн олговрыг олгодоггүй амрах эрхийг нь зөрчиж байхад зарим уурхай ажилд ороод заавал 11 сар ажиллаж байж ээлжийн амралт олгох журам тогтоон түүнийгээ баримтлан ажилтан хүнийг бололцоотой үедээ амрах эрхийг хязгаарлаж байна.

1.5.4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хангах, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах талаар гарсан хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомж ашигт малтмал олборлодог үйлдвэр,

байгууллагад харилцан адилгүй түвшинд хэрэгжиж байна.

Зарим компануид ("Шижир алт", "Алтан Дорнод Монгол" ХХК, Бор-Өндөрийн болон Айргийн уулын үйлдвэр) ажлын байр нэмэгдүүлэх, ажиллагсдын ажлын болон ахуйн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангахад анхааран хөтөлбөр төлөвлөгөөтэй, тодорхой хөрөнгө зарцуулан ажиллаж байна. Тухайлбал, эдгээр үйлдвэр, компануид нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтан, их, бага эмч нарыг орон тоогоор ажилуулан, орон тооны бус зөвлөл, комисс байгуулж, сургалт зохион байгуулах, 3 шатны хяналт тавих, заавархилгаа өгөх ажлыг үндсэнд нь хэвшүүлсэн, машин механизм, тоног төхөөрөмжийн паспорт, баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөн, өргөж тээвэрлэх механизм, даралтат шугам хоолойд туршилт тохируулга, баталгаажилт хийлгэсэн, тоожийт, дуу чимээ, чичиргээг багасгах, гэрэлтүүлэг, ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын нөхцөлийг сайжруулах бололцоотой зарим арга хэмжээг авдаг болсон байна.

Гэвч бусад алтны уурхайнууд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд гарын үсэг зуруулах, ажлын гутал, хувцас, малгай, бээлий олгох, нормын сүү, тараг өгөх төдийгөөр хязгаарлаж байна. Машин, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах, паспорт, техникийн бусад баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөхгүй, өргөх тээвэрлэх хэрэгсэл, даралтат шугам хоолойн туршилт тохируулгын ажлыг орхигдуулж баталгаажилт хийлгэхгүй байх, шөнийн нөхцөлд орчны гэрэлтүүлэггүй ажиллах, цахилгааны холболт ил задгай, тоног төхөөрөмжийн хаалт, хамгаалалт бүрэн биш зэрэг аюулгүй ажиллагааны наад захын горим алдагдах явдал "Мон дулаан трейд", "Т энд Ч" ба "Одод" ХХК-ны алтны уурхайд илэрч байлаа.

Түүнчлэн "Мон дулаан трейд" ХХК-ын Ар Харчулуут, "Одод" ХХК-ны Бухтын алтны уурхайн шороон ордын карьерийн хэсэгт нуралтыг тооцсон шатлал үүсгээгүй, уурхайн хана огцом, өнцөг үүсгэж технологийн горим алдагдсан байв.

Ил аргаар задгай орчинд алт олборлож байгаа Өлтийн уурхайгаас бусад уурхайд тоожийтийг багасгах, чийгтэй өрөмдөлт, талбайг услах ажил от хийгдээгүй, "Ажнай хурд", "Өлт" гэх мэт олонхи уурхайд усан буучийн ажилладаг байр нар, салхи, халуун, хүйтэн, цас, бороонооос халхлагдах боломжгүй, засварын болон дизелийн цех нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.

Ихэнх уурхайнуудад ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл маш хангалтгүй байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан алтны уурхайд ажиллагсдын 30.7% нь өвөрдийн ажлын нөхцөлийг эрүүл ахуйн хувьд тохиромжгүй шороо, тоожийт ихтэй гээд дараахь нийтлэг зөрчил буюу бэрхшээл тохиолддог гэж хариулжээ.

- Гол төлөв гадаа ажилладаг учир хүйтэнд даарч, халуунд хэт халдаг;
- Шатах, тослох материалын үгаарын хийд хорддог;
- Байнга чийгтэй нөхцөлд ажилладаг;
- Дуу чимээ, чичиргээ ихтэй;
- Байнга босоогоор ажилладаг;
- Байшинд ажилладаг цөөн хэсэг нь агааржуулагч хангалттүй;

-Ахуйн байр хүйтэн, тохигүй зэрэг нь бидний эрүүл мэнд, хөдөлмөрийн бүтээмжинд сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Үүл уурхайн салбарын ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангаж, ажлын байрны нөхцөлийн онцлогоос хамаарч, түр амрах байр, ажлын тусгай гутал, хувцас болон хамгаалах янз бүрийн хэрэгслүүдээр хангаж, химийн хортой нөхцөлд ажилладаг ажилгсдыг хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангах ёстой байдаг (Хөдөлмөрийн тухай хуулийн 87, 90, 91 дүгээр зүйлүүд).

Ажлын гутал, хувцас, бээлийгээр нийт ажиллагсдын 70.4%-83.2%-ийг хангасан ба хамгаалах хэрэгсэл болох малгай, каскаар хангавал зохих уурхайн механизмын жолооч нарын 33.3%-ийг, гагнуурчдын 37.5%-ийг, засварчдын 40.0%-ийг, усан буучдын 40.0%-ийг хангасан байв. Ажлын байран дээр анхны түргэн тусламж үзүүлэх наад захын шаардлагатай эм, бэлдмэл, боох материалаар нийт судалгаанд хамрагдсан ажиллагсдын дөнгөж 34.4%-ийг хангаж байна.

Тэрчлэн уул уурхайн ажилд хүнийг ажилд авахдаа урьдчилан нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт оруулж, эрүүл мэндийн байдлыг тогтоож, ажиллаж байх явцад нь жилд нэгээс доошгүй удаа эмнэлгийн хугацаат үзлэгт хамруулж байх шаардлагатай байдаг (Хөдөлмөрийн тухай хуулийн 92.1., Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын А/206 тоот тушаалаар батлагдсан "Ажилтныг ажиллах явцад эрүүл мэндийн хугацаат үзлэгт оруулах ажил, үйлчилгээний жагсаалт"-ын 3.а). Гэтэл судалгаанд хамрагдсан нийт ажиллагсдын дөнгөж 26.0% нь шаардлагын дагуу эмнэлгийн урьдчилсан болон хугацаат үзлэгт орсон ба 24.4% нь анх ажилд ороход эмнэлгийн үзлэгт орж байжээ.

Зарим томоохон уурхайн салбарт хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг бүрэн хангаагүйгээс мэргэжлээс шалтгаалах өвчин гарсаар байна. Үүнийг тэдний дунд зонхилон тохиолдож байгаа 4 нэрийн өвчнөөр авч үзвэл:

Дээрх судалгаанд хамрагдсан алтны уурхайнуудад уг ажлыг хийхээс өмнө өвчилсөн хүмүүстэй харьцуулахад одоогийн энэ уурхайд ажиллаж байгаатай холбоотойгоор өвчилсөн бөөр,

шээсний замын өвчтэй хүний тоо 7.5 дахин их, үе мөчний өвчтэй хүний тоо 6.5 дахин их, зүрх судас, ядаргаа, нүд, чих, хамар, хоолойн өвчтэй хүний тоо 1.5 дахин тус тус их байгаа бөгөөд эдгээр өвчлөлүүд нь мэргэжлээс шалтгаалах өвчин болоод байна.


Энэ нь тэдний ажлын байрны нөхцөлтэй холбоотой задгай агаарт, цаг уурын хүйтэн, халуун ямар ч нөхцөлд ус, чийгтэй орчинд удаан хугацаагаар хэт ачаалалтай ажиллах, химийн хортой хийн утаа, тортог, тоосонцрын дунд ажилласнаас даарч, хөрөх, амьсгалын дээд замын үрэвсэлт өвчин болон мэргэжлээс шалтгаалах дээрх өвчнүүдээр өвчлөх хандлага их гардаг байна.

Энэхүү судалгаанд хамрагдсан өвчин эмгэгтэй хүмүүсийн 61.7 хувь нь мэргэжлээс шалтгаалж өвчилсөн, өвчний төрөл, шалтгаан, өвчлөгсдийн тоо, ажилласан жил, эрхэлж буй ажилтай нь шууд хамааралтайгаар нэмэгдэх хандлагатай байгаа нь анхаарал татаж байгаа юм.

Өвчлөлийн байдлыг ажилласан жилээр авч үзвэл:

Алтны уул уурхайн салбарт 3 хүртэл жил ажилласан буй нийт 81 хүнээс 26.5-31.1% нь өвчтэй байсан бол 4 ба түүнээс дээш жил ажилласан нийт хүмүүсийн дотор өвчтэй хүний эзлэх хувь 53.8-85.7% болтлоо өссөн байгаа нь АУА-ын өвчлөлийн байдалд тэдний эрхэлж буй ажил нөлөөлж байгааг баталж байна.

Өвчлөлийн байдал, ажилласан жилээр



Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн уулын болон баяжуулах үйлдвэр, бутлуурын цехэд дуу шуугиан, доргион, тоосонцор маш ихтэй боловч ихэнх ажилчид чихэвч, амны хаалт (маска)-аа зүүж хэвшээгүй байна. Тус үйлдвэрт одоогоор мэргэжлээс шалтгаалах өвчнөөр 310 гаруй хүн өвчилж хяналтанд байдаг бөгөөд эдгээрийн ихэнх нь Сүхбаатар аймгийн Бүрэн-Цогтын уурхайд ажиллаж байхдаа уг өвчнөөр өвчилсэн хүмүүс байв.

Ер нь судалгаанд хамрагдсан ихэнх уурхайнуудад ажиллаж буй хүмүүс хамгаалах хэрэгслээ хэрэглэдэггүйгээс болж мэргэжлээс шалтгаалах өвчинд нэрвэгдэх нэг гол шалтгаан болж байна. Зөвхөн "Шивээ-Овоо" ХК-ны хувьд л гэхэд нүүрсний уурхайн тооснийт 10 мг/м^3 байхаас бутлах хэсэгт 17 мг/м^3, уулын уурын зууханд 40 мг/м^3, мужааны өрөөнд 12 мг/м^3 байна. Дуу шуугиан 85 децибеллээс хэтрэхгүй байх ёстой атал тэжээгч бункерийн дээд хэсэг, бутлах болон токарийн хэсэг, засварын цех, нүүрсний уурхайн уурын зуух, мужааны өрөөнүүдэд 8-16.7 децибеллээр хэтэрсэн нь хэмжилтээр тогтоогдсон байна (Судлаачийн илтгэх хуудаснаас).

1.5.5. Гар аргаар ашигт малтмал олборлогсдын эрхийн төлөв байдал

1.5.5.1. Гар аргаар алт олборлогсод Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Увс зэрэг аймгуудад ихэвчлэн байгаа бөгөөд бүрэн бус мэдээгээр 30.6-42.1 мянган хүн байдаг гэсэн мэдээ бий ("Ашигт малтмал гар аргаар олборлолт, ажил олгогч эздийн байгууллагын үүрэг, оролцоо" сэдэвт семинарын материалаас).

Мөн тэрчлэн Налайх дүүрэгт албан бус салбарын чиглэлээр хувираа нүүрс олборлогсод ойролцоогоор 230-300 хүн, Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг сумдад жонш хувираа олборлогсод 500-800 хүн ажилладаг байна.

Манай судалгааны явцад ажиглагдсан хамгийн олон хувираа алт олборлогсод ажилладаг аймаг, сумд гэвэл: Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут сумдын орчимд 10

гаруй мянга, Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн алтны уурхайн орчимд 5000-6000 хүн, Төв аймгийн Заамар суманд 2500 орчим хүн тус тус гар аргаар алт олборлож байв.

Тус Комиссоос судалгаа явуулах үеэр Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг "Аман-Ус" гэдэг газарт 40 гаруй иргэд, мөн сумын нутаг "Улаан булаг" хэмээх газарт 30 гаруй өрхийн 100 шахам хүн, Бөмбөгөр сумын нутаг дахь "Адгийн худаг" хэмээх газарт 100 гаруй өрхийн 1000 орчим хүн, мөн сумын "Ар гашуун ус" гэдэг газарт 30 гаруй өрхийн 120 гаруй хүн, Өвөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн алтны уурхайн орчим 800 гаруй өрхийн 4000 гаруй хүн тус тус гар аргаар шороон ордоос алт олборлож байв.

Тэрчлэн Дорноговь аймгийн Айраг сумын хэд хэдэн газраас хувираа гар аргаар жонш олборлож байгаа 60 гаруй иргэдтэй уулзаж ярилцсан.

1.5.5.2. Албан бус салбарт ашигт малтмал олборлох болсон доорх үндэслэл, шалтгаан байгаа нь судалгаанаас харагдаж байна.

- Хувираа алт олборлогсдын дийлэнх болж байгаа малчид сүүлийн хэдэн жилийн ган зудын үршгаар малгүй болж улмаар нэн ядуу, ядуу иргэдийн эгнээнд шилжиж амьдралын эх үүсвэргүй болсон;
- Байгаль, цаг уурын бэрхшээл болон эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж газар тариалангийн ажил зарим газарт суларч зогсонги байдалд хүрсэн;
- Улсын үйлдвэр, аж ахуйн газрууд хувьчлагдсан болон тэдгээрт орон тоог багасгаж, цомхотгол хийгдсэн, зарим үйлдвэр, аж ахуйн газрууд хаагдсан зэргээс төв суурин газрын ажиллагсад бөөнөөр ажилгүй болсон;
- Төсөвт байгууллагын болон хувийн хэвшлийн байгууллагын зарим ажиллагсдын цалин, хөлс нь амьжиргааны ертийн өсөлтийг гүйцэхгүй буюу өдөр тутмын наад захын хэрэгцээг хангахгүй болсны улмаас ажилтай боловч ядуутар хүмүүс олширсон;
- Хөдөөгийн зарим айл, өрхүүд болон төв, суурингийн орлого багатай иргэд их, дээд сургуульд сурдаг оюутан хүүхдийнхээ сургалтын болон унаа, байр, бусад шаардлагатай зардлыг төлөх зайлшгүй хэрэгцээ байдгаас албан бусаар ашигт малтмал олборлох замаар мөнгө хуримтлуулах болсон.

Үүнээс гадна мөнай улсын ихэнх аймгуудад, ялангуяа төвийн, зүүн болон хангайн бүсийн аймгуудад ашигт малтмалын орд газар ихээхэн нээгдэж, түүнийг ашигладаг уурхай, компанид олноор ажиллах болсон байна.

Хувираа гар аргаар алт олборлогсод явуулын байдлаар ажилладаг бөгөөд тэдгээр иргэдийн 23.9% нь сумын төвөөс, 22.5% нь аймгийн төвөөс, 45.1% нь нийслэл, дүүргээс ирэгсэд байх ба 2.8% нь тогтмол суух орон гэргүй "тэнэмэл" хүмүүс байдаг байна. Тэдний 76.1% нь 4 ба түүнээс дээш ам бүл тэжээдэг бөгөөд өрхийн орлогынхоо 74.6%-ийг алт олборлолтоор бүрдүүлдэг байна (Судалгааны тайлангаас).

ГААО нь алт олборлолтоор сард доод тал нь 10,000 төгрөг, дээд тал нь 240,000 төгрөг, дундажаар 55 679.2 төгрөгийн орлого олж байна. Судалгаанд оролцсон нийт хүний 19.7% нь өрхийн амьжиргаандаа 30,000 төгрөг буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнийй, 15.5% нь түүнээс бага орлого тус тус оруулдаг байна.

Судалгаанд хамрагдсан гар аргаар алт олборлогч өрхийн нэг гишүүнд оногдож буй сарын орлогын түвшингээс үзэхэд 39.6% нь өрхийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой буюу ядуучууд байгаа ба 47.2% нь нэн ядуу амьдралтай иргэд байна.

Алт олборлолтоор олж буй сарын орлого

Орлого* төгрөгөөр	Хүний тоо	Хувь
30 000>	11	15,5
30 000	14	19,7
40 000-50 000	11	15,5
60 000-90 000	10	14,1
100 000<	7	9,9
Бүгд	53	74,6
Хариулаагүй	18	25,4
Дүн	71	100,0

1.5.5.3. Зөвхөн гар аргаар алт олборлогсдын ихэнх хувь буюу нийт судалгаанд хамрагдсан хүн амын 78.9% нь өдөрт 8-аас дээш цаг ажилладаг, 69.0% нь долоо хоногийн амралтын өдрүүдэд огт амардаггүй байна.

Гар аргаар алтны ил ордоос алт олборлох үйл ажиллагаа нь технологи ажиллагаа, ажлын байрны нөхцөлийн хувьд дараахь онцлогуудтай байна. Үүнд:

- Алт олборлолт нь хээрийн нөхцөлд задгай агаарт явагддаг тул улирал, цаг уурын таалажгүй нөлөөлөлд байнга өртдөг.

Технологийн нэг гол дамжлага бол олборлосон алтаа усаар угааж, тунгааж ялгах явдал байдаг тул Баянхонгор аймаг мэтийн ил задгай үс ховор газарт усаа холоос зөөж хэрэглэх явдал цөөнгүй гардаг. Нөгөөтэйгүүр, алт угаах үйл ажиллагаа усан орчинд явагддагтай холбоотой хүйтэн сэрүүний улиралд чийг авч амархан даарч хөрөх хандлага ихээр тохиолддог.



Усанд алтаа угааж байгаа нь . . .

- Хувираа ГААО-доД техник хэрэгсэл байдаггүйгээс гарын доорхи багажаар газар малтах, нүх ухах, шороо шигших, шороо зөөх, ус зөөх, чулуу бутлах зэргээр нэг хүн бараг 4-6 төрлийн биеийн хүчний хүнд хүчир ажлуудыг хийдэг байна.

Хувираа ГААО-доД албан ёсоор алт олборлох зөвшөөрөл байдаггүй, зөвшөөрөлтэй газар байдаггүйгээс аль алтны гарц ихтэй газар буюу аль эсвэл уурхайн компаний үзэмшил газарт "хулгайгаар" алт олборлодог. Мөн түүнчлэн ГААО нарт тавих хараа хяналт байдаггүйгээс алтны гарцаас хамааран дур мэдэн газрыг ухаж, нүхэлж газар доор алт олборлодог. Ингэж газар доор ажиллах нь цэвэр агаар дутагдах, хийн мандлын агаарын их даралт нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх, ялангуяа шороон ордтой газар доогуур ямар ч хамгаалалт бэхэлгээ хийлгүйгээр орж ажилласнаар шороонд дарагдаж осолдох явдал цөөнгүй гардаг байна. Уурхайн эдэлбэр газар хиймэл нуурын далантай ойролцоо алт олборлож буй ГААО далангийн шороог ухаж нүхэлснээс далан задарч хүчтэй ус олгойдон улмаар шороонд дарагдаж гэмтэж, нас барах тохиолдол ч бас цөөнгүй гардаг.

Баянхонгор аймагт сүүлийн 2 жилд алт олборлож байгаад 32 хүн шороонд дарагдаж, үүнээс 8 хүн нас барсан, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт сүүлийн 5 жилд алт олборлох үйл ажилчагаатай холбоотойгоор 35 хүн нас барж, 12 хүн тахир дутуу болсон байна. Төв аймгийн Заамар сумын нутагт ГААО-оос зөвхөн сүүлийн 2 жилд 15 хүн шороонд дарагдаж нас баржээ (судалгааны тайлангаас).

Үүнээс үзэхэд албан бус салбарт гар аргаар алт олборлох ажиллагаанд хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа туйлын хангалтгүй, хүмүүс олноороо амь насаа алдаж байна.

ГААО-ын эрүүл мэндэд ноцтой аюул учруулж буй зүйл бол мөнгөн усны асуудал болж байна.

Мөнгөн ус нь аюулын зэргээр химийн маш их хортой бодисын ангилалд багтдаг бөгөөд түүнтэй харьцаж ажилласнаар хүн мөнгөн усны архаг болон хурц хордлогод орж, улмаар бүх эрхтэн системийг нь гэмтээх аюултай байдаг. Гэтэл алтны үндсэн орд (чулуун орд)-д алт бариулах зорилгоор хүмүүс мөнгөн усыг их хэмжээгээр хэрэглэж байна.

Алтны үндсэн орд бүхий Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн 6 сумын уурхайд гар аргаар хувираа алт олборлодог иргэд, мухлагийн зарим худалдагч Бороо голын орчмоос түүх, таньдаг хүмүүстээ захиж авах зэргээр мөнгөн усыг олж авч, алт бариулахдаа хэрэглэдэг байна. Тэд мөнгөн усаар алт бариулахдаа ихэвчлэн гэр орондоо, заримдаа уурхай болон голын усанд алтаа мөнгөн усаар бариулдаг байна.

Ингэж технологийн бус, буруу аргаар мөнгөн усаар алт бариулж байгаагийн уршгаар алтны үндсэн ордод гар аргаар алт олборлодог 341 хүнээс түүвэр судалгаа болон дээж авч шинжилгээ хийхэд эдгээрт оролцогсдын 17% буюу 59 хүнд мөнгөн усны архаг хордлогын шинж тэмдэг илэрсний 17 нь хүүхэд байв. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн тал хувьд нь мөнгөн усны архаг хордлогын шинж тэмдэг лабораторийн шинжилгээгээр давхар батлагдсан байна. Ер нь судалгаанд хамрагдагсдын ихэнх нь буюу 67.9% нь мөнгөн усаар алт бариулж, ууршуулан хэрэглэж байжээ (НЭМ, Н.Сайжаа "Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад хувираа алт олборлож буй хүмүүсийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын байдал" судалгааны тайлангаас).

1.5.5.4. Алт олборлох үйл ажилагаанд нэгэнт үс зайлшгүй хэрэглэгддэг тул усны олдцоос хамаарч улирлын чанартайгаар зуны улиралд гар аргаар алт олборлохоор газар гаражас хүмүүс ихээр ирж, нэг газар олноор бөөгнөрөн суурьшлын орчныг үүсгэдэг. Энэ нь тэдгээр хүн амын эрүүл мэндэд дараахь сөрөг үр дагавруудтай байна.

- ГААО алт олборлох үйл ажиллагаатай холбоотой еөр еөр гаражас олноор ирж суурьшиж буй явдал нь янз бүрийн халдварт евчний үүсгэгчийг нэгээс нөгөөд зөөвөрлөж, улмаар тухайн орон нутагт гарч байгаагүй халдварт евчин, эмгэг шинээр гарах шалтгаан болдог. Ингэснээр ГААО-ын дунд нийт халдварт евчин ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлж болзошгүй байдаг.
- Зуны улиралд ялангуяа усны олдоц ховор газар ариун цэврийн байдал туйлын муу сахидгаас гэдэсний халдварт евчин ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг.
- Нутгийн хүмүүсийн ярьж байгаагаар зуны улиралд нэг газар ойролцоогоор 3000 гаруй хүн ам цугларч, суурьшиж барагсум, түүнээс тэм суурьшлын орчныг үүсгэдэг байна. Гэтэл дээрх хүн ам нь албан ёсны бүртгэлгүйгээс захиргааны ямар ч хараа хяналт байдаггүй тул суурьшлын орчин тойрныг тэдийгүй, байгаль орчныг ихээр бохирдуулж байна.
- Ийм суурьшлын орчинд бие засах газар, бохир ус, хог хаягдлаа хаяж, зайлуулах газар

байдаггүйгээс өөрсдийн амьдарч буй орчиндоо бие засах, бохир ус, хог хаягдлаар байгалийг маш ихээр бохирдуулж, улмаар тэнд амьдарч буй хүн ам нь ахуйн хавьтлаар янз бүрийн халдварт өвчнөөр өвчлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

- ГААО ямар ч зохион байгуулалт, хараа хяналтгүйгээр газрыг сэндийчлэн олон тооны гүнзгий нүх ухаж, түүнийгээ буцааж булж сэргээлгүй орхисноос өөрсдийн болон бусад хүн амьтны бие эрхтэнд гэмтэл учруулах, цаашилбал амь нас хохирч болох нөхцөлийг бүрдүүлж байна.



Өөрхангай аймгийн Уянга сумын Өлтийн дээд амны "Персийн булан"-гийн ГААО

1.5.5.5. Хувиараа гар аргаар байгалийн ашигт малтмалыг олборлох нь олон хүний хувьд амьжиргааны эх үүсвэр нь болж улмаар ийм үйл ажиллагаа олон аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарч, энэ нь хүний эрхийн төдийгүй байгаль орчин, нийгмийн хэв жүрмын нөхцөл асуудал болон ужгирсаар байхад энэ талаар төрийн зүгээс тодорхой бодлого, шийдвэрт арга хэмжээ авахгүй байгаа нь асуудлыг улам нөхцөй болгож байна.

ГААО-той холбоотой харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулсан боловч энэ хууль хэзээ гарах нь тодорхойгүй, нөхцөл байдал улам бэрхшээлтэй, олон иргэдийн амьдрал, хувь заяаг хөндсөөр байна.

ГААО-д учирч буй хамгийн том бэрхшээл бол алт олборлох үйл ажиллагаа явуулахад гаднаас байгньн дарамт шахалт үзүүлэх явдал байна. Тухайлбал, нийт судалгаанд хамрагдагсдын 76.1% нь гаднаас ямар нэг дарамт шахалт үзүүлдэг гэж хариулжээ.

Дарамт шахалтыг ихэвчлэн алтны уурхайн компаниуд, сумын засаг захиргаанаас үзүүлдэг бөгөөд мөн түүнчлэн өөр сумаас ирсэн болон хамт хувираа алт олборлож буй хүмүүс, нутгийн удирдлагаас ирж алт олборлож буй хүмүүс г.м. байгууллага, хүмүүсээс ихэвчлэн эзэмшлийн газраа харамлах, газраа булаацалдах, байгаль орчныг хамгаалах зэрэг шалтгааны улмаас дарамт шахалт үзүүлдэг байна.

Судалгаанаас харахад ГААО-д хамгийн их хэрэглэж байгаа дарамт шахалт бол алт олборлож буй газраас хөөх (нийт судалгаанд оролцогсдын 69.0%), ажлын багаж, хэрэгслийг хураах (64.8%), айлган сүрдүүлэх, баривчлах (50.7%) зэрэг арга хэлбэрүүд байна.

Дээрх дарамт шахалтын арга, хэлбэрүүд нь хүний халдашгүй чөлөөтэй байх, эрүүл байх эрхийг зөрчиж байгаа бөгөөд хамгийн ноцтой зөрчил нь зодох бөгөөд нийт судалгаанд оролцогсдын 42.3% нь ийм дарамтанд ямар нэг байдлаар орж байдаг байна. Гол төлөв алтны уурхайн компаниуд өөрсдийн компаний хамгаалагч цагдаа нараар зодуулж өөрсдийн эзэмшил газрыг хамгаалдаг байна.

Нутгийн засаг захирагаа ГААО-оос алт олборлох үйл ажиллагаатай нь холбоотойгоор хууль бусаар татвар авах (нийт судалгаанд хамрагдагсдын 31.0%) байдлаар мөн дарамт шахалт үзүүлдэг байна. Баянхонгор аймгийн Буугаган сумаңд алт олборлогч иргэдээс сард 3000 төгрөгийг хураан авдаг байна (Иргэн "Х"-ийн яриа).

Түүнээс гадна иргэд алтны илэрц сайтай нэгж талбайгаа болон олборлосон алтаа бусдад булаалгаж дээрэмдүүлдэг байна.

ХОЁР. ЭМЗЭГ БҮЛГИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

2.1. Үндэсний цөөнхийн эрхийн төлөв байдал

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг дэвсгэрт амьдарч байгаа "цаатан" хэмээх цөөнх иргэдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг судалсан юм.

Үндэсний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвермөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ (Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, Х.Виктор Кондэ, 102 дахь талд).

Судалгаа Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын баруун, зүүн тайгад амьдарч байгаа цаатан иргэдийг хамруулан хийсэн. Түүнчлэн Улаанбаатар хотод сурч байгаа цаатан гаралтай оюутнууд, Цагааннуур сумын дунд сургуульд суралцаж байгаа дунд сургуулийн сурагчдыг оролцуулав. Түүнээс гадна мал маллан амьдарч байгаа болон сумын төвд амьдардаг нэн ядуу, ядуу цаатан иргэд, сумын сургуульд багшилдаг цаатан гаралтай иргэдийг оролцуулсан. Анкет-сурвалжлагын аргаар тайгад амьдарч байгаа насанд хүрсөн иргэдийн 50 орчим хувиас судалгаа авсан. Ганцаарчилсан ярилцлагыг нийт 30 хүнтэй хийж, Цагааннуур сумын дунд сургуулийн багш нар, Улаанбаатар хотод их, дээд сургуульд суралцаж байгаа цаатан оюутнууд, цаатан, цаа буга судалдаг судлаач, эрдэмтэд болон цаатны төлөөлөл оролцсон нийт 3 бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан. Түүнчлэн Хөвсгөл аймгийн төв

Мөрөн хот болон Цагааннуур сумын Засаг даргын Тамгийн газар, холбогдох хэлтэс, албад дээр цаатан иргэдийн талаар гаргасан шийдвэр, хүн, амын болон малын тоо бүртгэл зэргээ баримт бичгийн судалгаа хийв. Судалгааны ажлын явцад цаатан иргэдэд чиглэсэн арга хэмжээ, хөтөлбөр, төслүүдтэй танилцлаа.

2.1.1. Цаатан иргэд нь Улаанбаатар хотоос 1000 гаруй км, Хөвсгөл аймгийн төвөөс 300 гаруй км, Цагааннуур сумын төвөөс 50-70 км алслагдсан, өндөр уулианд амьдардаг. Тадний амьдардаг газар нь дэлхийн бөмбөрцгийн хойт өргөрөгийн 52°-60°, уртрагийн 98°-102° хооронд орших Монгол улсын нутаг дэвсгэрийн хөвдөн бэлчээртэй, як сарьдаг уулууд юм. Энд өвлийн улиралд цельсийн хасах 29-53 хэм хүртэл хүйтэрч, зуны улиралд цельсийн нэмэх 12-23 хэм хүртэл дулаарна. Жилийн дундаж хур тунадас нь 320 мм хүрдэг. Уул нуруунууд нь далайн түвшнээс 2500-3500 метр өндөрт өргөгдсөн, эрс тэс уур амьсгалтай.

***2.1.2.** 1990-ээд оны үеэр цаатангуудад цааг нь хувьчилж, засгат төрөөс зориудаар авч хэрэгжүүлдэг тодорхой бодлого, үйлчилгээ үзүй болсноор тайгынхны амьдрал эрс хүндэрч, цаагаа олноор нядлах, цааны эврээ худалдах, ангын олзоор амьдрах зэрэг өнөө маргаашаа өнгөрөөн аргацаах байдалд шилжжээ. Цааны эврээ жил бүр хөрөөдөн авч амьдралаа залгуулсаар байгаа нь цааны өвчин ихсэхэд хүрээж буй бөгөөд цаа бугын үржил багасан, өвөрхийдөө жижэрч, дэвжаарч ирсэн байна. Мөн загас агнуурын аж ахуй татан буугдаж тэнд ажиллаж байсан цаатан иргэд эргэн тайгадаа гарснаар тайгын хүн ам ихэсч, цаа цөөрөх хандлага руу оржээ. Мөн түүнчлэн цааг хувьчлахдаа цаа бугын аж ахуйд үржилийн цааг авч үлдээгүй, цаа бугыг нэгэнт хувьчилсан гэдэг шалтгаанаар эрүүлжүүлэх болон бусад үржил селекцийн асуудалд анхаарал тавихаа больсон зэрэг хүчин зүйл цаа бугыг хорогдоход их нөлөөлсөн.*

2002 онд Цагааннуур суманд амьдарч байгаа цаатан иргэдийн судалгааг гаргажээ. Тус сумын 2 багт нийт 114 өрхийн 493 цаатан амьдарч байна. Хүйсийн хувьд 240 эрэгтэй, 255 эмэгтэй байна. Тэдгээрийн 39,9%-ийг 0-16 насны хүүхдүүд, 19,8%-ийг 17-25 насны залуучууд, 20,2%-ийг 26-35 насны хүмүүс, 15,2%-ийг 36-60 насны хүмүүс, 4,6%-ийг 60-аас дээш насны ахмадууд эзэлж байна.

2002 оны байдлаар зөвхөн тайгад амьдарч байгаа иргэд, тэдний цаа буга, малын судалгаа

No	Байршил	Өрх	Хүн	Үүнээс		Цаа	Монгол мал
				Эр	Эм		
1	Баруун тайга	22	110	51	59	385	427
2	Зүүн тайга	20	97	46	51	178	167
	Бүгд	42	207	97	110	563	594

2.1.3. Тайгын багийн засаг даргаас авсан мэдээгээр баруун тайгад 2002 онд нийт 385 цаа буга тоологдсон бол 2003 оны 8-р сард Улаанбаатараас очсон эрдэмтдийн тоолсноор баруун тайгад 512 цаа буга байсан байна. Ер нь цаа бугын жинхэнэ тоог гаргахад бэрхшээлтэй. 1990 онд 1000 цааны баяр тэмдэглэхэд цааны тоо толгой 1000 хүрээгүй байсан гэж мэтгэлцэх хүн ч байдаг. Цааны жинхэнэ тоо толгойг хэлдэггүй нь цаатнуудын сүсэг бишрэлтэй холбоотой ажээ.

2002 оны байдлаар баруун зүүн тайгад амьдарч байгаа нийт 42 өрх айлд 563 цаа тоологдсон гэж үзвэл нэг хүнд дунджаар 2.7 цаа ногдох болжээ. Энэ онд тайгад 3 өрх шинээр нэмэгдэж 45 өрх болсон бөгөөд 210 хүн амтай болжээ (Багийн Засаг даргын гаргасан мэдээнээс).

2.1.4. Цагааннуур сумын тайгад амьдарч байгаа нийт 42 өрхийн 14 өрх буюу 33% нь нэн ядуу, 38% нь ядуу нөхцөлд амьдарч байна. Амьдралын хүнд нөхцөл, амьжиргааны эх үүсвэрийн хомсдол нь цаа бугаа өсгөн үржүүлэх, маллах, хайрлах уламжлалд нь ч сергеер нөлөөлөх болсон. Үүний тод жишээ бол цөөхөн цаатай зүүн тайгын иргэд цаа бугынхаа цусан эврийг нь толгой дараалан авсан байхад баруун тайгын арай боломжтой өрхүүд цаа бугынхаа цусан эврийг бараг аваагүй байсан явдал юм.

Тайгад амьдарч байгаа цаатан ардуудад учирч байгаа өөр нэг гамшиг бол архидалт, тамхи татах муу зуршил юм. Үүнээс үүдэлд бие биенийхээ эрх чөлөөнд халдах, хүүд хөнгөн гэмтэл учруулах гэх мэт зөрчлүүд байнга гардаг байна. Энэ байдалд хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд их өртдэг.

2.1.5. Цаатан иргэдийн үндэсний цөөнхийн эрх болон бусад эрхийн хэрэгжилтийн төлөв байдал

2.1.5.1. Өөрийн соёл иргэншлээ хадгалан үлдэх эрх. Цаатан ардууд нь 3-4 метрийн урттай, том урц бол 28-32, жижиг урц бол 17-23 мод орсон, брезентээр бүрсэн уламжлалт сууцандаа цаг уурын хатуу ширүүн нөхцөлд өнөөг хүртэл амьдарсаар байна. Өмнө нь ангын болон цаа бугын арьс, модны холтосоор урцаа бүрдэг байсан бол 1970-аад оноос судалгаа явуулж байж, бүх урцыг брезентээр бүрэх болжээ.

Цаатан иргэдийн өөрийн соёл иргэншлийн гол онцлог баталгаа нь цаа бугатай салшгүй холбоотой. Гэтэл сүүлийн жилүүдэд цаа

буга эрс хорогдсон нь тайгад амьдарч байгаа цаатан иргэдийг талд бууж ирж, өөрсдийн уламжлалт амьдралын, өвөрмөц хэв маягаасаа татгалзахад хүргэж байна.

Социализмын үеийн цаатангуудыг төвлөрүүлж суурьшуулах гэсэн оролдлого нь цаатангуудын амьдралын хэв маяг, уламжлалтай зөрчилдөж, улмаар тайгыг эзгүйрүүлэхэд хүргэж байсан бол өнөөдөр тэдэнд чиглэсэн ямар ч бодлого байхгүй, тодорхой арга хэмжээгүй явж ирсэн нь энэ өвөрмөц амьдралын хэв шинжийг аяндаа мөхөж алга болох аюулд хүргэхээр байна.

Цаатан ардуудын бүсдаас онцгойрон харагддаг зан заншлын гол зүйлс гэвэл:

- гэр бүл болох /хуримлах, бэр буулгах/
- нас барагсдаа оршуулах /хүүхэд оршуулах/
- цаа сэтэрлэх
- ан авд мордох /онцолбол баавгай агнах/
- урц гэрээ барих
- нүүж суух зэрэг төрөхөөс эхлээд жам ёсоор хорвоог орхих үе хүртэлхи амьдралын хугацаанд давтах үйлүүд болно. Цаатан ардуудын амьдралын хэв хэвшил дотор эртний овгийн байгууллын үеийн үлбаа өнөө хэр хадгалагдсаар ирснийг тэдний зан үйлийг судалдаг гадаад, дотоодын эрдэмтэд ажиглан мэдээлж байна. Тухайлбал, 2002 онд зүүн тайгын 10 ерөнхий сэдэвт судалгаагаар тэд хүнсээ /махаа/ ав адилхан хуваан авч, яг нэг өдөр хүнсээ дуусгаж байгаа жишээ болно. Мөн нас барагсдаа оршуулах зан үйлээнд ч их эртний хэв шинж хадгалагдаж байгаа юм. Цаатан ардуудын эд өлөг, хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, эдийн соёлын бүхий л өв уламжлал нь өнөөдөр бараг бүрэн устан үгүй болж байна. Тэд орчин үеийн шаардлагаар арьсан ауе гутал, богцноосоо аажим салж байгаа шигээ хэл соёл, зан заншлаа мөн бөхөөн орхиж байна.

Социализмын үед орон нутгийг судлах музей байгуулсан байсан нь цаатан ардуудын соёл заншлыг олон нийтэд сурталчлах, ирээдүй хойч үедээ энэ өвөрмөц амьдрал, зан заншлыг хадгалан үлдээхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ. Гэвч одоо энэ музей хаагдаж, дотор нь байсан зарим үнэт үзмэрүүд байхгүй болсон тухай анх энэ музейг байгуулсан Цагааннуурын Загасны үйлдвэрийн дарга Батаа гуай ярьж байсан.

2.1.5.2. Өөрийн шашин шүтэх эрх. Цаатан ардууд нь бөөгийн шашин шүтсээр ирсэн. Социализмын үед бөө буух, удган зайран тодруулах нь хязгаарлагдмал байсан ч тэд шашин соёлоо хадгалсаар ирсэн юм.

Өнөөдөр баруун тайгад үе дамжсан онгодын ээзэн ер гаруй настай Сууян удган энх тунх амьдарч байна. Судалгааны явцад цаатан ардуудын ерх бүр урц гэрийн хойморт эцэг дээдсийн нь сүнс сүлд шингэсэн онгод шүтээнээ залсан байсан. Харин нэг овог удмын цаатангууд өөр өөрийн тахиж шүтдэг онгон газартай байдаг бөгөөд жилд 1-2 удаа очиж тахиж шүтэх ёс байдаг ажээ. Бидэнтэй уулзаж байсан улсын аварга цаачин Дагжий "Эцэг дээдсийн маань онгон Улаан-Уул сумын нутаг дахь хилийн зурваст ойрхон байдаг. Энэ онгон шүтээндээ очиход хилийн зөвшөөрөл авах гэж Улаан-Уул сум орох... Зөвшөөрөл өгөх хүмүүс нь байхгүй байх... Зөвшөөрөлгүй очоод тахиж шүтэх гэхээр хил зөрчигч хэмээн сэрдэгдэх гэх мэт бэрхшээл учирдаг тухайгаа ярьж байсан..." Өөр бусдаар бол өнөөдөр цаатан ардуудад итгэл үнэмшилтэй байх, өөрийн шашин шүтэх эрх нь зөрчигдөх, үүнээсээ үүдэж ялгаварлагдах явдал гардаггүй.

2.1.5.3. Төрөлх хэлээрээ ярих эрх. Цаатангууд тува, монгол хэлээр ярьдаг. Сумын дунд сургуульд тува хэлтэй боловсон хүчинг бодлоготойгоор бэлтгэж байсан. Одоогийн байдлаар цэцэрлэгийн багш 2, бага ангийн багш 2, дунд ангид хичээл заах тува хэл-уран зохиолын багш 1 бэлтгэгдсэн бөгөөд тэдгээрээс 3 нь сумынхаа сургуульд бага ангийн багшаар ажиллаж байна. Мөн тус сургуульд Тувагаас мэргэжилтэн багш нар урьж тува хэлний хичээл орж байсан. Тухайн үед цаатан хүүхдүүдэд тува хэл бичиг зааж байсан энэ сайхан уламжлал одоо алдагджээ. Өнөөдөр цаатан хүүхдүүдэд үндэстнийх нь хэл бичиг заах цөөн ч гэсэн мэргэжлийн багш байгаа ч орон нутгийнхны хайхрамжгүй байдал сургуулийн захиргааны хөөцөлдлөг дутагдсанаас болоод хичээлийн хөтөлбөрөөс хасагдсан байна.

Цаатан ардууд өнөөгийн байдлаар тува хэлээ зөвхөн хоорондын харилцааны түвшинд л ээзэмшсэн, ялангуяа хүүхдүүд тува хэлээр энгийн хэдэн үгээс цааш мэддэггүй байна. Дунд сургуульд тува хэлийг үзэхгүй байгаа нь төрөлх хэлээ мартахад хүргэж буйд ахмад хүмүүс сэтгэл нь ихэд эмзэглэж явдаг ажээ. Хэсэг цаатан ардын төлөөлөгчид төр засгийн удирдлагуудаа эх хэлийг нь дунд сургуулийн сурагчдад оруулдаг болгохоор хүсэлт уламжлаад байгаа бөгөөд УИХ-ын гишүүнээс 2005 оноос тува хэлийг Цагааннуур сумын сургуульд заалгах боломжтой тухай хариу өгчээ.


2.1.5.4. Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн хэрэгжилт. Хөдөлмөрийн чадвартай 272 хүний 58 буюу 21,2% нь ажилгүй. Зөвхөн 6,6% нь л төсвөт байгууллагад ажиллаж байгаа бөгөөд үлдсэн хүмүүс нь цаачин, малчин зэрэг ажил хөдөлмөр эрхэлж байна. Өнөх тотголцооны үед загас, агнуурын аж ахуйд олон цаатан ажиллаж, амьдрал ахуйгаа хангаж байсан. 1956 онд Цагааннуурын загасны үйлдвэр байгуулж анх 30-аад цаатан иргэдийг элсүүлж зохих материал, техник орчноор хангаж байсан байна. Гэтэл сүүлийн жилүүдэд төрөөс, орон нутгаас үндэсний цөөнх болсон дээрх иргэдэд чиглэсэн арга хэмжээ яваулахгүй болсон, цааны тоо толгой

үлэмж хорогдсон зэрэг нь тэднийг ядууруулж байна. 1999 онд "Цаа буга сан"-гаас "Цаачин" хоршоог байгуулж өгсөн боловч эргэлтийн хөрөнгө байхгүйн улмаас одоог хүртэл тодорхой ажил хийгээгүй байна.

2.1.5.5. Сурч боловсрох эрх. Цаатан иргэдийн боловсролын түвшин нэлээд доогуур байна. Тайгад тусгай дунд боловсролтой хүн хамгийн өндөр боловсролтойд тооцогддог. Тэдний дунд бага боловсролтой гэх боловч бичиг үсэг мэдэхгүй хүн тааралдаж байна. Дээд боловсролтой гэх хэдэн цаатан нь Цагаannуур сумын төвд амьдардаг. Бидний анкетын асуулга авсан цаатан иргэдийн дотор бүрэн бус дунд болон бага боловсролтой хүмүүс 64,8%-ийг эзэлж байсан.

Цагаannуур сумын 8 жилийн дунд сургууль нь 322 сурагчтай бөгөөд тэнд 93 цаатан иргэдийн хүүхэд сурапцаж байгаа нь нийт сурапцагчдын 28.3 хувийг эзэлж байна. Үүнээс 28 сурагч тайгаас, бусад 65 нь сумын төв болон тал нутагт мал маллан амьдарч байгаа цаатан гаралтай тува иргэдийн хүүхэд байна. Баруун, зүүн тайгад 0-16 насны 102 хүүхэд амьдарч байгаагаас сургуулийн насны бараг бүх эрэгтэй хүүхдүүд сургууль завсардан тайгадаа амьдарч байна. Тэнд томчуулыг даган цаа малпаж, ан авд мордож, тайгын хүнд хүчир бүхнийг туулж давахын зэрэгцээ, тамхи татах, архи уух зэрэг элдэв муу зуршилд эрт татагдан орж байна. Тайгад амьдарч байгаа 8-16 хүртэл насны нийт хүүхдээс 17 хүүхэд буюу 39.5 хувь нь сургууль завсардсан байна. "1997 онд сургуулийн насны цаатан хүүхэд 78 байгаагийн тал илүү хувь нь хувцас хунар, хоол унд, нөм дэвтэргүйгээс сургуулийн хаалга татах хувь дутаж . . . " байсан (эх сурвалж: М.Нямаа, "Тайгын гүнд хаягдсан цаатан, цаа хоёр", Ардын эрх сонин, 1997.5.12) тэр үетэй харьцуулахад сургууль завсардалт 10 гаруй хувиар буурсан байна. Энэ нь дараах тоон баримтаар баталгаажиж байна.

Цаатан иргэдийн боловсролын түвшин



2002 оны 1-р сарын 25-ны мэдээ, Тайгын багийн Засаг дарга Буянтогтох

Цаатан иргэдийн хүүхдүүдийн сургуульд элсэлт сүүлийн 5 жилээр:

Элсэлтийн он	1999-2000 он	2000-2001 он	2001-2002он	2002-2003 он	2003-2004 он
Тоо	8	8	14	21	14
Хувь	21.6	19.5	34.1	32.3	22.2

Цаатан иргэдийн хүүхдүүдийн 8-р анги төгсөлт сүүлийн 3 жилээр

Төгссөн он	2000-2001 он	2001-2002он	2002-2003 он	Нийт
Тоо	3	6	13	22
Хувь	27.2	42.8	46.4	38.8

Цаатан иргэдийн хүүхдүүдийн 9-р ангид элсэлтийн байдал сүүлийн 3 жилээр:

Дэвшин суралцсан он	2000-2001 он	2001-2002он	2002-2003 он	Нийт
Тоо	3	3	9	15
Хувь	100	50	69.2	73.0

/Цагаannуур сумын 8 жилийн дунд сургуулийн сургалтын менежер С.Дөшнөе, ниймгийн ажилтан М.Эрдэнэбат нарын хийсэн судалгааnaас/

Сургууль ортлоо тайгад амьдарч байгаад ирсэн Цаатан хүүхдүүдийн хувьд хэл ярианы хөгжил муутай, монгол хэлээр ойлгох, илэрхийлэх чадвар сул байдаг нь тэдний сурах идэвхи, сонирхол, сурлагын үзүүлэлтэд нөлөөлдөг. Цаатан хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжгүй, сургууль ортлоо тува, монгол хэлээр хольж ярьдаг орчинд амьдардаг. Тэд сургуульд дээрх хоёр хэлний аль алинаар нь ойр зуурын хэрэглээний түвшний мэдлэгтэй орж ирдэг байна. Сурч боловсрох эрхийг хангах баталгаа нь багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамж, сургалтын орчин юм. Цагаannуур сумын дунд сургууль нь 1998 онд шатсан бөгөөд "Цаа буга сан" төрийн бус байгууллагын санаачилга, хөрөнгө оруулалтаар баригдсан шинэ байранд 2000 оны 4-р сараас хичээллэх болсон. Гэвч сургуулийн номын сан байхгүй, сургуулийн байр болон дотуур байр нь гэрэл цахилгаангүй зэрэг нь сургалтын чанарт таагүй нөлөөлдөг. Сургуулийн дотуур байранд 65 хүүхэд өгсөн тєсвеер 100-гаад хүүхэд хооллодог. Тухайлбал, 2003 оны 1-р сард аймгийн Боловсрол соёлын газраас хийсэн хяналт шинжилгээгээр тус сургууль дараах үнэлгээг үзүүлж аймгийнхаа хэмжээнд сүүлээсээ 4-р байранд орсон байна

№	Үнэлсэн үзүүлэлт	Цуглуулах оноо	Цуглуулсан оноо
1.	Удирдлагын үйл ажиллагаа, зохион байгуулалт	7	4.14
2.	Сургалтын материаллаг болон бусад нөхцөл	5	2.88
3.	Багш ажилтны бүрэлдэхүүн, чанар	6.5	3.7
4.	Сургалтын чанар, үнэлэмж	10.5	3.7

/Хөвсгөл аймгийн ЕБС-удын хяналт шинжилгээний дүн, нэгтгэсэн:БСГ-ын арга зүйч М.Хишигхүү/

Тус сургуулийн бага ангийн багш нараас сүүлийн 5 жилд 4 багш аймгийн тэвд богино хугацааны сургалтад хамрагдсаны 3 нь 5 жилийн өмнө, 1 нь 2003-2004 оны хичээлийн жилийн 11-р сард хамрагджээ. Тус сургуулийн удирдлагын зүгээс төсөв, санхүүг хэмнэх нэрээр багш нарыг сурагчдын амралтаар цалингүй амраадаг зэрэг хөдөлмөрийн харицлааны зөрчил гардаг нь багш нарын бүтээлч үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна. /Цагааннуур сумын бага ангийн багш нартай хийсэн ярилцлагаас/ Цагааннуур сумын дунд сургуульд нийтдэх цаатан гаралтай бага ангийн 5 багш ажиллаж байна.

Сумын сургуулийн сургалтын чанар ханталтгүй байгаа нь тус сургуулийн сурагчид дээд шатны боловсрол эзэмшихэд сергөөр нөлөөлдөг. Улаанбаатар хотод сурч байгаа цаатан оюутнуудтай хийсэн бүлгийн ярилцлагын үеэр тэдэнд тохиолдлог бэрхшээлийг сонсоход 9-10-р ангид дэвшин суралцахаас эхлээд сурсан мэдсэн зүйл нь их голлогдог, үүний улмаас их, дээд сургуульд орсон ч гэсэн чанартай сайн сургалттай газар сурч чаддаггүй. Нэгэнт магадлан итгэмхлэл аваагүй сургууль элссэн тохиолдолд сургалтын төлбөрийн хөнгөлөлт, зээл олддоггүй. "Цаа буга сан" гэх мэт байгууллага, хувь хүмүүсээс сургалтын төлбөрөө төлүүлэгд сурах гэхээр энд амьдрах байр, хоол, хичээлийн хэрэгсэл авах мөнгө гэх мэт байнга бэрхшээл тохиолддог. Улаанбаатарт ямар нэгэн хамаатан садан байдаггүй учир хүүхдүүд 1-2 жил сураад сургуулиа орхиж нутаг буцахад хүрдэг хэмээн ярьж байсан.

2.1.5.6. Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх. Тайгын цаг агаарын хүйтэн, сэрүүн уур амьсгалаас хамаарч цаатангуудын дунд өвчлөлт элбэг байдаг. Хамгийн түгээмэл хэлбэрийн өвчлөлт бол цусны даралт ихсэх, нүдний өвчлөлт, үе мөч болон хоолойны ангина юм. Хүйтнээс хамаарч өвчлөлт ихэсдэг өвөл, хавар, намрын улиралд эмнэлгийн тусламж авахад хүндрэл байнга тохиолддог. Үчир нь зам 40-60 см цасаар хучигдаж, зам хаагддаг.

Эмнэлгийн тусламж авах нөхцөл, боломжийг зүүлбэл

Газрын нэр	Улирал	Сумын төвөөс	Очих унааны боломж			Эмнэлгийн тусламж авах боломж
			Морь	Цаа	Машин	
Зүүн тайга	Өвөл	35-40	+	+	+	өдөртөө
	Зун	50	+	-	-	2 хоног
Баруун тайга	Өвөл	50	-	+	+	4 хоног
	Зун	50	+	+	+ (1/2 зам)	2 хоног

Анкетын судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн ЭМД-ын талаарх мэдлэг, ойлголт түйлын хангалттүй байсан. Тэдгээс ЭМД-тай эсэхийг асуухад ЭМД-ын дэвтэртэй эсэхээ хэлэхээс биш, даатгалын хураамж төлсөн зүйл байхгүй байсан. Судалгааны явцад тэдний даатгалын дэвтийг үзэхийг хүссэн боловч ихэнхид нь байхгүй, сумын төвд байгаа гэж хариулж байсан. Энэ чиглэлээр сумын албан тушаалтнууд, эмнэлгийн эмч, ажилтнууд тодорхой ажил хийх хэрэгтэйг харуулж байсан. Сайн дурын даатгалд хамрагддаг хүмүүсийн хувьд төлберийн чадваргүйгээс үүдэзд зрүүл мэндийн даатгалгүй, түүнчлэн түргэн тусламж дуудахад шатахууны мөнгийг авдаг талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 13 хүн буюу 35% нь ярьж байлаа. Тушний мөнгийг эргүүлж төлөө гэж авдаг ч буцааж өгдөггүй ажээ. Нийт өрхийн 70% нь ядуу, нэн ядуу байдалд амьдарч байгаа, тэр дундаа сумын төвөөс алслагдсан эдгээр иргэдийн хувьд энэ байдал нь маш хүндээр туск байна. Тайгад өвчлөхөд тэр бүр сумын төв орж эмнэлэгт үзүүлээд байх боломжгүй, эм тариа байхгүй зэргээс үүдээд олон бэрхшээл тохиолдог талаар ярьцгааж байсан. Энэ оны 7-р сард их эмч тайгад очиж үзлэг хийсэн. Цаатан иргэд эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэгт хамрагддаггүй. Харин Франц эмч мэргэжилтнүүд энэ зун очиж цаатангуудыг эмнэлгийн үзлэгт хамруулж, эм тариа өгчээ. Цаатан ардууд эрт цагаас тайгад үргадаг ховор эмийн үргамал, ан амьтны эд эрхтэнг хэрэглэх замаар өөрсдийгөө эмчлэх нарийн ухаантай байжээ. Тухайлбал хоолой өвдөхөд булганы цес долоох, үушингы өвчтэй хүн вансэмбэрүү хэрэглэх гэх мэтээр ярьж байлаа. Гэвч мөн л энэ уламжлал нь нилээд алдагдаж, зарим нарийн ширийн зүйлээ мэдэх хүн үгүй болж эхэлжээ.

2.1.5.7. Эд мөнгөний тусламж авах эрх. 2002 оны 5-р сард гаргасан дүнгээр тайгад амьдарч цаатан өрхүүдийн 14 буюу 33% нь нэн ядуу, мөн 16 буюу 38% нь ядуу нөхцөлд амьдарч байна. Үүнийг Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын бүсэд хамаарч байгаа 7 сум, 1 тосгоны ядуурлын үзүүлэлттэй харьцуулахад ядуу өрх 16,7%, нэн ядуу өрх 6,3%-иар илүү байгаа нь цаатан иргэдийн амьдрал илүү хүнд байгааг давхар нотолж байна. Нийгмийн халамжийн сангаас тэдэнд үзүүлэх тусламж ханталтгүй, тэдний ядуурлаас бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө байдаггүй. Цаатангууд малтай бол амьдиргааны түвшин дээшилж болох тухай бас ярьж байсан. Гэтэл малжуулах төслийн хувьд 10-20 бодтой тэнцэх хэмжээний малтай айлд л мал өгдөг тул цаатангууд хамрагддаггүй. Ийм хэмжээний

малтай цаатан ерх үнэндээ ганц нэгээс хэтрэхгүй байна. Сүүлийн жилүүдэд төрийн бус байгууллага, гадаадын иргэд, олон улсын байгууллага гэх мэт газруудаас тэдэнд туслалцаа үзүүлэх болсон. Гэвч ихэнх тусламж нэг удаагийн шинжтэй байгаа нь үр нөлөө багатай юм. Сум орон нутгийн удирдлагуудын хайхрамжгүй хандлага ч энэ байдалд нөлөөлдөг. Тусламжийн үр дүнг тооцож, тэдний хэрэгцээг тодорхойлсон судалгаа байхгүй байна.

2.2. Эмээг булгийн иргэдийн нийгмийн хамгаалал, хуульд заасан тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхийн төлөв байдал

Нийгмийн хамгааллын салбарын хөгжилд 1994 онд батлагдсан Нийгмийн даатгалын багц хууль, 1995 онд батлагдсан Нийгмийн халамжийн багц хууль, 2001 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Эдгээр багц хууль хэрэгжиж эхэлснээр нийгмийн хамгаллын салбарын үндэс суурь тавигдсан гэж хэлэх үндэстэй.

Нийгмийн халамж. Нийгмийн нэн эмээг хэсэгт нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр тэтгэвэр, тэтгэмж болон хөнгөлөлт үйлчилгээнд:

- Өндөр настан, тахир дутуу иргэдийг асрамжийн газарт байрлуулан байнга асрамжлах, түүнчлэн ядуус болон гэр орончгүй иргэд, хүүхдийг хооллох, халуун усанд оруулах зэрэг тусламж үйлчилгээ;
- Орон байрны талбайн хэлс, эмнэлгийн тусламж үйлчилгээ, тэргэнцэр, сонсох аппаратын үнийг хөнгөлөх зэргээр өндөр настан, тахир дутуу болон бусад иргэдэд үзүүлэх хөнгөлөлт;
- Мөнгөн хэлбэрээр Нийгмийн халамжийн санхаас олгох тэтгэвэр, тэтгэмж, тухайлбал жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, олон хүүхэдтэй болон нярай хүүхдийн асаргааны, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгесний тэтгэмж, түүнчлэн нийгмийн даатгалын санхаас тэтгэвэр авах эрх үүсэзгүй иргэдэд олгох тэтгэвэр (тэтгэвэр тогтоогсон нөхцөл болзлыг хангаагүй) зэрэг мөнгөн тэтгэмжүүд багтана.

Ниймгийн даатгал. Энэхүү тогтолцоогоор тэтгэвэр, тэтгэмжийг ажил олгогч болон ажиллагсдын төлсөн шимтгэлийн орлогоор санхүүжүүлэн, шимтгэл төлж ажилласан хугацаа, нас зэрэг тодорхой нөхцөл, болзол хангасан иргэдэд олгож байна. Монгол Улсын ниймгийн даатгалын салбарт үндсэн таван сан хэрэгжиж байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ. Өөрийн оронд хөдөлмөрийн оновчтой зах зээл хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж байна. Энэхүү салбарт хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:

- Тахир дутуу иргэд, ахмад настан зэрэг эмээг булгийнхэнд хөдөлмөрийн болон мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагадаа тохирсон хөдөлмөр эрхлэх боломж олгох чиглэлээр тусгайлан тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Ажилгүй, мэргэжилгүй залуучуудад мэргэжил олгох;
- Ажилгүйчүүдэд зориулж нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
- Ажлын байр бий болгох зорилгоор жижиг зээл олгох;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжуулан дэмжих.

2.2.1. Ниймгийн халамжийн өнөөгийн байдал. Монгол Улсад ниймгийн халамжийн багц хууль анх 1995 онд батлагдан гарснаар ниймгийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа үзүүлбэл зохих бие даан амьдрах, өөртөө үйлчлэх чадваргүй эмээг бүлгийн иргэдийг тэр ивээлдээ авч, тэдний амьдралын баталгаагаа алдагдуулахгүй байх ниймгийн халамжийн тогтолцоог бий болгох зүйл үндэс бүрэлдсэн байна. 1997 онд "Ниймгийн халамжийн тухай хууль"-д, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 1998 онд "Ниймгийн халамжийн тухай хууль" шинэчлэгдэн батлагдснаар, ниймгийн халамжийн бие даасан удирдлага зохион байгуулалтын тогтолцоо бий болсон юм.

Ниймгийн халамжийн үндсэн үйл ажиллагаа нь халамж, асаргаа ниймгийн гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд үйл ажиллагааны чиглэл нь ч мөн энэ хоёр хэлбэрээр явагдаж байна. Ниймгийн халамжийн үйл ажиллагаат ниймгийн халамж үйлчилгээний төвүүд хэрэгжүүлдэг ба асрамжийн үйлчилгээг улсын болон орон нутгийн асрамжийн газрууд үйлцэгж байна.

Ниймгийн халамж, үйлчилгээний төвүүдэд ниймгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх нэн ядуу амьдралтай иргэн, бүтэн өнчин хүүхдийг түр хугацаагаар хооллох, хүмүүнлэгийн тусламжийн зүйлийг үйлчлүүлэгчдэд хуваарилан олгох үйл ажиллагаа явуулж байна. Улсын болон орон нутгийн асрамжийн газрууд улс, орон нутгийн төсвөөс шууд хуваарилсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу асрамжийн үйл ажиллагаанд зарцуулах, асруулагчийг тогтоосон стандарт жүрмын дагуу орон байр, хоол, хувцас, эм хэрэгслээр хангах, асруулагчдыг эмчлэн сувилах, бие эрхтнийг нөхөн сэргээхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөдрийн байдлаар Улсын ниймгийн халамжийн газар, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн ниймгийн халамж үйлчилгээний төв, 340 сумын ниймгийн халамжийн ажилтан, улсын болон аймгийн асрамж, ахмад настны амралт сувилалын газрыг оруулаад ниймгийн халамжийн байгууллагуудад ниитдэх 720 гаруй хүн ажиллаж байна.

Улсын төсвийн гүйцэтгэлийн тайланагаас үзвэл ниймгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 1997 онд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 7,0 тэрбум төгөрөг байсан бол 2002 онд 20,0 тэрбум төгөрөг болж есжээ. Ниймгийн халамжид зарцуулж байгаа нийт хөрөнгийн 95,4%-ийг улсын төвлөрсөн төсвөөс, 4,6%-ийг орон нутгийн төсвөөс тус тус гаргаж байна.

Ниймгийн халамжийн үйлчилгээг хүртэх гол хэрэглэгчид бол хүн амын эмээг хэсэгт хамрагдах ахмад настан, өнчин хүүхдүүд, тахир дутуу иргэд, нэн ядуу амьдралтай иргэд юм.

2.2.1.1. Ниймгийн халамжийн тэтгэвэр. Энэ тэтгэвэр нь ниймгийн даатгалын санхаас олгох

өндөр настны, тэжээгчээ алдсаны болон тахир дутуугийн тэтгэврээс агуулга, хэмжээгээрээ эрс ялгаварта й.

Халамжийн тэтгэвэр нь тухайн иргэнийг асарч халамжлах хүнгүй, амьдралын хүнд нөхцөлд орсон тохиолдолд улсын төсвөөс олгож байгаа мөнгөн туслалж юм. Уг тэтгэвэрийг ихэвчлэн хөдөлмөрлөж байгаагүй төрөлхийн тахир дутуу, хөдөлмөрлөх чадваргүй зэрэг шалтгаантай буюу ажилгүй байсан иргэд авдаг.

Энэ төрлийн тэтгэвэрт 1997 онд 23163 хүнд 1531,9 сая төгрөг зарцуулж байсан бол, 2002 онд 37303 хүнд 5853,3 сая төгрөг зарцуулжээ. Энэ тоо жил бүр улам өсөх хандлагатай байна. Судалгаанаас үзэхэд, нийгмийн халамжид хамрах хүний тоо 2005 онд 54,5 хувиар, зарцуулах көрөнгийн хэмжээ 2,4 дахин нэмэгдэх тооцоо гарсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийн төрөл, түүнд зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

	Тэтгэврийн төрөл	1997	1998	1999	2000	2001	2002	2003
1	Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй	460,3	394,0	523,7	538,0	491,0	481,4	500.9
2	Нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 нас хүрсэн эх (50 хүрсэн эцэг)	8,0	10,5	10,1	17,2	14,0	15,7	28.1
3	Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан тахир дутуу хүмүүст	222,3	224,8	471,7	616,6	635,1	804,5	1093.3
4	16 насанд хүрсэн төрөлхийн тахир дутуу болон 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон (хөдөлмөрлөх чадвар нь 50 буюу түүнээс дээш хувиар алдагдсан) хүнд	666,5	701,3	1239,1	1709,3	1864,2	2069,8	2791.1
5	Бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн	35,6	59,7	109,7	134,7	149,1	171,9	226.4
6	Хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтот ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон хүн	2,1	0,6	2,4	4,8	2,4	0,952	0.151
7	Тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд	137,2	198,9	388,7	566,2	658,9	822,0	1097.9
8	Хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтот ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад нас барсан иргэний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд	0,078	0,7	1,6	1,9	2,4	1,487	1
	ДҮН	**1531,9**	**1590,7**	**2747,0**	**3588,7**	**3816,0**	**5853,3**	**5739.1**

Сүүлийн 5 жилд нийгмийн халамжид зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3 дахин өсч, 4 хүн тутмын 1 нь ямар нэгэн байдлаар тэтгэвэр, тэтгэмж, туслалж хүртэж байгаа болов ч айл өрхийн амьжиргаанд дэзшлүүлэх нөлөөлөл нь бага байна. Иймээс, нийгмийн халамжийн үйлчилгээг нийгмийн эмзэг хэсэгт наад захын хэрэгцээгээ хангах, цаашид хөвийн амьдрах болоцоо олгох чиглэлээр өөрчлөн шинэчлэх явдал чухал юм. Үүнд, нийгмийн халамжийг голдуу бэлэн мөнгөөр

үзүүлж буй идэвхгүй хэлбэрийн дэмжлэг туслалцааг айл өрх, хувь хүний идэвхи санаачилга, сонголт дээр тулгуурласан олон талт үйлчилгээ болгон өөрчлөх шаардлагатай юм. Энэ өөрчлөлтийг хийснээр нийгмийн тусламж, дэмжлэг үйлчилгээг жинхэнэ эзэнд нь хүргэж тэтгэвэр, тэтгэмжээс гадна бусад төрлийн үйлчилгээ сонгох боломжтой болох юм.

Нийгмийн халамжийн тэтгэврийн төрөл, түүнд хамрагдсан хүний тоо

	Тэтгэвэрийн төрөл	1997	1998	1999	2000	2001	2002	2003
1	Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангүй нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй	6446	6181	6227	4720	4265	3729	3288
2	Нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 нас хүрсэн эх (50 хүрсэн эцэг)	131	136	125	150	103	132	161
3	Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан тахир дутуу хүмүүст	3293	3366	4642	5419	5890	7049	7686
4	16 насанд хүрсэн төрөлхийн тахир дутуу болон 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон (хөдөлмөрлөх чадвар нь 50 буюу түүнээс дээш хувиар алдагдсан) хүнд	10313	11250	12702	14277	16418	18112	19611
5	Бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн	602	822	966	1094	1265	1309	1445
6	Хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтот ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа алдаж тахир дутуу болсон хүн	28	9	24	37	9	7	1
7	Тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд	2349	3050	388	4911	5874	6962	7550
8	Хүний амь аврах, гоц аюулт халдварт өвчний голомтот ажиллах буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад нас барсан иргэний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд	1	12	16	16	19	3	6
	ДҮН	**23163**	**24826**	**28584**	**30624**	**33843**	**37303**	**39748**

2.2.1.2. Нийгмийн халамжийн тэтгэмж. Төрөөс хүн амд үзүүлж байгаа нийгмийн халамжийн өөр нэг үндсэн хэлбэр бол халамжийн тэтгэмж юм. Халамжийн тэтгэмжийг амьдралын нөхцөл байдлыг харгалзахгүй болзол, нөхцөлийг хангасан нийт хүмүүст олгож байгаа нь халамжийн гэсэн мөн чанар, агуулгыг алдагдуулж байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 1997 онд 557309 хүн хамрагдаж 3897,2 сая төгрөг зарцуулж байсан бол, 2002 онд 129417 хүнд 9506,2 сая төгрөг зарцуулсан тооцоо гарч байна. Хүүхэд асарсны тэтгэмж авч байгаа эхчүүдийн ихэнх нь ажилгүй, амьдралын бололцоогүй өрхийн эхчүүд зонхилж байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжийн төрөл, түүнд зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Үзүүлэлт		1997	1998	1999	2000	2001	2002	2003
Жирэмсний болон амаржсаны		1754,5	1881,3	1834,3	2269,4	3563,5	4254,1	4,189.6
Хүүхэд асарсаны тэтгэмж		1597,2	1760,4	2839,0	2866,7	327,6	4343,7	4,807.4
Үүнээс	Нэг хүүхдийн	1549,1	1727,5	2794,2	3207,8		4181,3	4,634.3
	Ихэр хүүхдийн	48,1	32,8	44,8	89,7		162,4	173.0
Олон хүүхэдтэй эхийн тэтгэмж				1580,8	688,9	508,6	704	798.1
Үүнээс	Нэг удаагийн			1383,8	335,0		568,3	
	5 ба түүнээс дээш хүүхэдтэйн	495,2	473,8	197,02	173,6		135,7	
Нярай хүүхдийн арчилгааны		40,1	68,1	63,3	89,2	62,2	112,0	145.9
Ихэр хүүхдийн тэтгэмж		4,2	4,2	11,1	14,9	13,1	12,96	11.8
Үүнээс	Хоёр хүүхдэд	4,2	4,2	11,1	12,9		12,9	11.8
	3 ба түүнээс дээш				0,1		0,06	
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний		6,5	12,0	15,7	38,2	48,2	76,0	96.7
Ганц бие ахмад настны оршуулгын тэтгэмж		0,3	0,2	0,55	1,5	1,9	3,5	4.3
ДҮН		**3897,2**	**3726,1**	**6344,8**	**5968,9**	**7495,1**	**9506,2**	**10054.0**

Нийгмийн халамжийн тэтгэмжийн төрөл, түүнд хамрагдсан хүний тоо

Үзүүлэлт		1997	1998	1999	2000	2001	2002	2003
Жирэмсний болон амаржсаны		70791	69029	47760	45986	5055,6	49301	51490
Хүүхэд асарсаны тэтгэмж		9327	40261	42591	31472	53881	57082	58365
Үүнээс	Нэг хүүхдийн	91322	39842	42103	53156		56207	57509
	Ихэр хүүхдийн	2205	419	488	725		875	856
Олон хүүхэдтэй эхийн тэтгэмж				63767	28712	20579	17542	35724
Үүнээс	Нэг удаагийн			34601	533,8		6664	
	5 ба түүнээс дээш хүүхэдтэйн	14357	14350	19166	15241		10878	
Нярай хүүхдийн арчилгааны		4289	5848	5290	3528	3298	4638	5862
Ихэр хүүхдийн тэтгэмж		357	362	341	444	327	325	297
Үүнээс	Хоёр хүүхдэд	357	362	341	325		324	297
	3 ба түүнээс дээш				2		1	
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний		92	218	282	367	43	492	638
Ганц бие ахмад настны оршуулгын тэтгэмж		12	4	11	29	36	37	40
ДҮН		**557309**	**450695**	**160042**	**110538**	**129107**	**129417**	**152416**

2.2.1.3. Нийгмийн халамжийн хөнгөлөлт. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, тахир дутуу иргэд, ядуу айл өрхэд зарим төрлийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлж байна. Энэ хөнгөлөлтөнд амьдралын хүнд нөхцөлд байгаа иргэдээс гадна төрийн албан тушаалд ажиллаж байсан ахмадууд, ардын болон гавьяат цолтон, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгарлалтад оролцсон ахмад настан болон түүнд амь үрэгдсэн дайчны эхнэр, нөхөр зэрэг тэтгэвэрт гарсан иргэдийн ихэнх нь хамрагдаж байгаа нь "халамжийн" гэх агуулга алдагдаж, нэмэгдэл урамшуулал, дэмжлэгийн чанартай болж байна.

Ахмад настанд олгож байгаа бусад хөнгөлөлт үйлчилгээ нь тэдний эрүүл мэндийг хамгаалах, амьдрал ахуйд нэмэр болохуйц халамжийн чанартай юм.

Нийгмийн халамжийн хуулийн дагуу тахир дутуу иргэдэд 15 төрлийн хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд энэ хөнгөлөлт нь тэдний амьдралд бага багаруй дэмжлэг тусалцаа болж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээний хамрах хүрээ өргөн, үзүүлж буй тусламж дэмжлэгийн хэмжээ хэт бага учраас айл өрхийн амьжиргаанд төдийлөн дэмжлэг болж чадахгүй байна. Уг сангаас өнөөдрийн байдлаар 48 төрлийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлж байгаагийн 21 нь нийгмийн эмзэг бүлгийнхэнд шууд хамааралгүй, иргэдийн эрхэлж байсан албан тушаал, дайн байлдааанд оролцсон байдал, байгуулсан гавьяа, зүтгэлтэй нь холбоотойгоор олгогдож байна. Хэдийгээр харьцангуй олон төрлийн тусламж үйлчилгээ байгаа боловч хөдөө орон нутагт нийтлэг байдлаар 4-8 төрөл нь хүрч байна. Түүгээр ч барахгүй зарим төрлийн дэмжлэг тусалцааг авааргүй хүн ч байна. Иймд нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэмжийн нэр төрөл, хэлбэрийг оновчтой болгох замаар ядуу болон нэн ядуу өрхийн амьжиргааг дэмжих, тэдгээр өрхийн гишүүдийн амьжиргаагаа бие даан авч явах чадавхийг сайжруулах нь нэн тэргүүний зорилго юм.

2.2.2. Тахир дутуу иргэд

2.2.2.1. Тахир дутуу иргэдийн тоо. Манай улс 115 гаруй мянган тахир дутуу иргэдтэй гэсэн тооцоо бий. Үүнд:

-оюуны хомсдолтой	- 16100
-хэл ярианы болон сонсох эрхтний согогтой	- 18975
-харааны согогтой	- 15295
-хөдөлгөөний эрхтний согогтой-	28980
-сэтгэцийн өвчлөлттэй	- 12880
-хавсарсан согогтой	- 15065
-бусад шалтгааны улмаас	- 8305

ХЭҮК-ын өнгөрсөн оны илтгэлд тахир дутуу иргэдийн эрхийн төлөв байдлыг анхлан хөндсөн ба зарим тоо мэдээ нь энд дурдагдаж буйтай зөрөх болно. Өнгөрсөн оны тоо мэдээг орон нутгаас, бүрэн бусаар авсныг анхаарна уу.

Өнөөдрийг хүртэл тахир дутуу иргэдийн талаарх төрийн бодлого тусламж үзүүлэх, нөхөн олговор олгох үндсэн дээр тулгуурлаж байна. Өөрөөр хэлбэл, улсаас тэдэнд тэтгэвэр, тэтгэмжийн хэлбэрээр өнгөн тусламж олгож, тэдний амьдралыг найдвартай эх үүсвэртэй болгоход бага анхаарч иржээ.

2.2.2.2. Нэгэнт тахир дутуу болсон иргэнд үзүүлэх хамгийн гол тусламж бол нөхөн сэргээх эмчилгээ юм. Гэтэл манай оронд нөхөн сэргээх эмчилгээний түвшин доогуур байгаагаас тахир дутуу иргэдийн дөнгөж 5%-ийг дахин хөдөлмөрийн чадвартай болгодог гэсэн тооцоо мэргэжлийн хүмүүс хийжээ.

Иргэдийг тахир дутуу болохоос урьдчилан сэргийлэн, тэдний эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр иж бүрэн арга хэмжээ авах, ялангуяа хөдөлмөрийн аюулгүй, эрүүл нөхцлийг бүрдүүлж, осол гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах нь тахир дутуу болсны дараа халамжилснаас илүү ач холбогдолтой юм. Гэтэл энэ ажил олигтой хийгдэхгүй, тодорхой үр дүнд хүрэхгүй байгаа нь гэмтэл согог, үйлдвэрлэлийн осол багасахгүй байх шалтгааны нэг болж байна. Экологи, эрүүл мэндийг хамгаалах, хүнд, хортой, аюулгүй ажлын байрны хөдөлмөр хамгаалалтыг сайжруулах талаар төрийн бодлого, эрх, зүйн, орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Түүнчлэн тахир дутуу болсны дараа эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүй, хөдөлмөрийн нөхөн сэргээх тогтолцоог шинэчлэх замаар өвчлөлт, бэртэлтийн үр дагаврыг багасгах, зарим тохиолдолд арилгах, тахир дутуу иргэдийг нийгэмд дасах явцыг хөнгөлөх, тахир дутуу иргэдэд бусад бүх иргэдийн нэгэн адил ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх бололцоогоор хангах нь нийгмийн хамгааллын арга хэмжээний нэг хэсэг юм.

2.2.2.3. Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлт. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас тахир дутуу хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал эрүүл хүмүүстэй харьцуулахад хоёроос гурав дахин бага байгаат тэмдэглэсэн байна. Ажил эрхэлж байгаа тахир дутуу хүмүүсийн хувьд албан тушаал доогуур, үнэлгээ багатай ажлын байраар хангагдсан байдаг нь түгээмэл юм.

Тахир дутуу хүмүүсийн амьдрал ахуйд туслах нийгмийн бодлого, арга хэмжээ юун түрүүнд тэдэнд таарч тохирох ажлын байр бий болгох, нийгэм хамт олны дунд амьдруулж, ажиллуулах арга замыг олох шаардлагатай байна. Улсын хэмжээгээр 115 мянга гаруй тахир дутуу иргэн байдгийн 21.4 мянга нь хөдөлмөр эрхлэх

боломжтой атал денгээ 7 мянга нь ажил эрхэлдэг байна. Судалгаанаас үзэхэд, "Төр засаг танд ямар үйлчилгээ үзүүлж чаддаггүй вэ?" гэсэн асуултанд тэдний дотроос хамгийн олон хүн "Ажлын байраар хангадаггүй" хэмээн хариулсан байна. Тахир дутуу иргэд ажил эрхлэх боломж бага байдгийн гол шалтгаанд:

- Осолд орох магадлал ихтэй
- Хөдөлмөрийн бүтээмж муу
- Ажлын байр хүрэлцээгүй

гэж хариулжээ.

Үүнээс үзэхэд зах зээлийн харилцааны нөхцөлд тахир дутуу хүмүүсийг ажлаар хангах болондоо улам бүр муудаж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, тэдэнд зориулсан ажлын байр бий болгох нь нэмэгдэл зардалтай, гаргасан зардлаа нөхөх бэрхшээлтэй гэдэгтэй холбогдох шалтгааныг олон байна. Энд төрийн дэмжлэг, буяны байгууллагын оролцоо зэрэг олон зүйл хэрэгтэй нь ойлгомжтой.

2.2.2.4. Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийг 2-оос доошгүй жил, үүнээс сүүлийн 9 сар нь тасралтгүй шимтүүл төлсөн даатгуулагч авах эрх эдэлж байна. Сарын тэтгэмжийн хэмжээ нь даатгуулагчийн авч байсан цалин хөлс болон шимтүүл төлсөн хугацаанаас хамаарна.

Одоогийн энэ мөрдөж байгаа тогтолцоо нь олон улсын стандартаас наад зах нь 3 нөхцөлөөр доогуур байна. Нэгдүгээрт, ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаа нь хэтэрхий "хатуу" шалгуур бөгөөд үүнээс болж ажилгүй болсон олон даатгуулагч тэтгэмж авч чадахгүйд хүрч байна. Хоёрдугаарт, 5-аас доош жил ажилласан даатгуулагчдад олгох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын стандарт болох дундаж цалингийн 50% доогуур байна. Гуравдугаарт, тэтгэмж олгох хугацаа ажлын 76 хоног байгаа нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Конвенцид 6 сараас доошгүй гэж заасан хугацаанаас доогуур байгаа юм.

ГУРАВ. ХҮНИЙ ЭРХИЙН АНХААРАЛ ТАТАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

3.1. Хуулийн байгууллагын үйл ажиллагаа ба хүний эрх

3.1.1. Эрүү шүүлт бол хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил төдийгүй хамгийн аюултай гэмт хэрэг юм.

УИХ 2000 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг дорломжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийг (цаашид "Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенци" гэх) соёрхон батаслан.

Уг Конвенцийн 1 дүгээр зүйлд "Эрүүдэн шүүх гэж төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэх бүй этгээд өөрөө эсхүл түүний едөөн хатгаснаар буюу ил далд зөвшөөрлөөр хэн нэг этгээдийг өөрөөс нь буюу гурав дахь этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэх бүй хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие махбодь, сэтгэл санааны хүчьд санаатайгаар хүчтэй евтөх, шаналгах аливаа үйлдлийг ойлгоно" гэж эрүү шүүлтийг тодорхойлсон. Энэхүү тодорхойлолтоос үзэхэд:

- Эрүүдэн шүүх гэдэгт бие махбодь, сэтгэл санааг евтгэх, эсхүл тарчлаан зовоох зэрэг үйлдлүүд орно.
- Эрүү шүүлт нь зөвхөн биеийг евтгэх үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй зовоох үйлдэл нэг адил хамрагдана.
- Энэхүү үйл ажиллагаа нь зориуд санаатай байх ёстой.
- Үйлдэл нь хэн нэг этгээдээс мэдээлэл авах эсхүл хэрэг хүлээлгэх зорилготой байна.
- Энэ зөрчлийг төрийн албан хаагч, тушаалтан үйлддэг байна.

3.1.1.1. Уг Конвенцид манай улс нэгдэж ороод таван жилийн хугацаа енгөрч буй боловч олон улсын энэ чухал баримт бичгийг олон нийтэд, ялангуяа хуулийн байгууллагын албан тушаалтнуудад суртачлах, ийм үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөө бүхий арга хэмжээг авах (Конвенцийн 2 дугаар зүйлд заасан үүрэг) улмаар дотоодын хууль тогтоомждоо эрүү шүүлтийг хориглох, гэм бурууташд хариуцлага хүлээлгэх тогтолцоо бий болгох талаар хангалттүй хандаж ирсний төмдэглэж байна.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон Эрүүгийн хуульд "Эрүүдэн шүүх" гэсэн үг хэллэг огт дурьдагдаагүй бөгөөд "Мэдүүлэг өгөхийг албадах" гэсэн 251 дүгээр зүйлийн диспозицид энэхүү үйлдлийн гол гол шинжүүдийг тусгаагүй болно. Түүнчлэн Конвенцийн 4 дүгээр зүйлийн эрүү шүүлт нь онц аюултай гэмт хэрэг гэдгийг харгалзах тухай заалтыг хууль тогтоогч Эрүүгийн хуульд тусгаагүй юм. Эрүү шүүлтийн улмаас хохирогч амь насаа алдах, онц их хэмжээний хохирол учрах зэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд орхигдуулсан.

ЭБШХ-д хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь дорломжилж болохгүй (ЭБШХ-ийн 10.4 дүгээр зүйл) гэж заасан. Харин эрүүдэн шүүж, хэрцгий хандаж гаргуулж авсан мэдүүлэг, баримт сэлтийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэхэн яаж авч үзэх, үнэлэх, нотлох баримтад тооцох эсэх талаар ЭБШХ-д тодорхой заалт байхгүй.

Энэ Конвенцид (15 дугаар зүйл) "ороцоогч улс бүр эрүүдэн шүүх замаар гаргуулсан болох нь тогтоогдсон мэдүүлгийг эрүүдэн шүүсэн хэрэгт яллагдаж буй этгээдийн эсрэг ийнхүү мэдүүлэг гаргуулсны нотолгоо болгохоос бусад тохиолдолд ашиглахгүй байх явдлыг хангана" гэж заасныг хууль тогтоогч шинэ ЭБШХ-д анхааран авч үзээгүй. ЭБШХ-д "хэрэг бүртгэгч, мөрдөн

байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно" (ЭБШХ-ийн 16.3), "нотлох баримтыг цуглуулахдаа ... бусдын нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно" (ЭБШХ-ийн 92.4) гэж тус тус заасан боловч эдгээр хориглолтыг зөрчвэл нэгэнт авчихсан, хавтаст хэрэгт орчихсон мэдүүлгийг хэргийг шийдвэрлэхэд хэрхэн авч үзэх, үнэлэх, улмаар нотлох баримтанд тооцох эсэх талаар ЭБШХ-д заагаагүй орхисон байна.

Гэтэл эрүү шүүлтийн арга ажиллагаа, түүнтэй холбоотой хүний эрхийн зөрчил нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад түгээмэл гарч байна. Эрүүдэн шүүх нь хэрэг хүлээлгэхээр шууд тулгаж, бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийллийг албан тушаалтны зүгээс үзүүлэхээс эхлээд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчтай хамт хоригдогсдоор нь шахалт дарамт үзүүлэх, дэглэж тарчлаах, хорих өрөө тасалгаа сэлгүүлэн хорихоос авахуулаад урьдчилан хорих байрны нөхцөл, ахуй хангамж, эргэлт үүлзалт хүртэл олон асуудалтай холбогдодог.

3.1.1.2. Сүүлийн жилүүдэд нийслэлд гарсан гэмт хэрэгт холбогдогсод, нэн ялангуяа дуулиан шуугиан ихтэй хэрэгт холбогдогдыг Төв аймаг, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн болон Зүүнхараагийн урьдчилан хорих байранд аваачиж хорьдог хууль бус арга ажиллагаа ихээхэн гарах болсон.

Одоо зарим аймгуудад энэхүү буруу, хууль бус арга ажиллагаа "халдварлаж", хоорондоо сэжигтэн, яллагдагчдыг сэлгүүлэн хорих болов. Тухайлбал, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн урьдчилан хорих байранд хүмүүсийг сэлгүүлэн хорьж бүй талаар өргедэл гомдол гарах болсон. Увс аймгийн Цагдаагийн хэлтсийн мерден байцаагч өмчийн хэрэгт холбогдсон эмэгтэй Ц-г 300 километрийн алсад орших Баян-Өлгий аймгийн урьдчилан хорих байранд хорьсон байв.

Сэжигтэн, яллагдагчийг орон нутгаас нь алс хол аваачиж хорих нь тэдний хууль ёсны эрх ашигт сергеор нөлөөлж, сэтгэл зүйн хувьд хүнд даramt учруулж буйгаараа эрүү шүүлтийн нэг илрэл болно. Ингэж хоригдсон сэжигтэн, яллагдагч нь хүссэн цагтаа өмгөөлөгчтэйгээ уулзаж, зөвлөгөө авах, хамт байцаалт өгөх боломжгүй болж, терөл терегсдэтэйгээ уулзах, эргэлт авах, хэрэгт нь хэнялт тавьж буй прокурорт санал гомдол гаргах боломж ч үгүй юм.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд "албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно" гэж заасныг ийм арга ажиллагаа нь шууд зөрчиж байна.

ЭБШХ-ийн 180 дугаар зүйлд "мерден байцаалтыг үг гэмт хэрэг гарсан газар явуулна" гэж заасан. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь мерден байцаах үйл ажиллагааны нэг хэсэг мөн тул сэжигтэн, яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг мерден байцаалт явуулж буй газрын харьяаны урьдчилан хорих байранд хэрэгжүүлэх ёстой.

3.1.2. Хууль зүй, дотоод хэргийн сайд, ХЭҮК-ын даргын батилсан удирдамжийн дагуу 2003 оны эцсээр улсын хэмжээнд цагдан хорих байруудад нэгдсэн үзлэг хийж дүнг нэгтгэн гаргав.

Монгол Улс 1997 онд сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай /цаашид СЯАСЦХШБ тухай хууль гэх/ хуулийг батлан гаргаж мердсеер 7 жил болж байна. Энэ хуулиар анх удаа цагдан хорих байрны стандарт шаардлагыг үндэсний хэмжээнд тогтоож өгснөөрөө чухал ач холбогдолтой болсон. Сүүлийн жилүүдэд цагдан хорих байрны харьяалал өөрчлөгдөж, цагдан хорих зөвшөөрлийг шүүгч өгдөг болсон. Цагдан хорих байрны ахуй нөхцөл тун хангалттүй, хууль хэрэгжихгүй байгаа талаар байнга шүүмжлэгдэг боловч наашталй өөрчлөлт тэр бүр гарахгүй байгаа нь анхаарал татаж байна.

3.1.2.1. Цагдан хорих байруудын барилгын байршил, ашигласан хугацаа, зориулалт. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 22 цагдан хорих байрны анхны зориулалтыг судалж үзэхэд хоёроос бусад нь анхнаасаа шорон, цагдан хорих байрны зориулалтаар баригдсан байр байна. Харин Дундговь аймгийн цагдан хорих байр нь авто машины гражийн зориулалттай байгыг, Говьсүмбэр аймгийн цагдан хорих байр нь хуучин оросын цэргийн англий эмнэлгийн байрыг засварлаж цагдан хорих байр болгон ашиглаан байна. Энэ хоёр байр нь Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулинд заасан заалт шаардлагад илүү нийцэн байрууд байна.

Цагдан хорих байруудыг ашиглалтын хугацаагаар нь авч үзвэл Архангай аймгийн хорих байр 26 жил, Завхан аймгийн хорих байр 22 жил, Төв аймгийн хорих байр 20 жил буюу хамгийн удаан хугацаагаар ашиглагдсан, 12 аймгийн хорих байр нь 10-20 жил, 7 аймгийн хорих байр нь 10 хүртэл жил ашиглагдсан байрууд байна. Үзлэгийн дүнгээс үзвэл ашиглалтын хугацаа нь дуусч ашуулгай байдалд орсон байр одоогоор байхгүй боловч засвар үйлчилгээ хийх зайлшгүй шаардлагатай байрууд цөөн бус байна. Ялангуяа Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймгийн хорих байрууд нилээд хуучирч муудан засвар үйлчилгээ хийх шаардлагатай болжээ.

Барилгын хийцийн хувьд 8 аймгийн байр нь төмөр бетонон хийцтэй, 14 аймгийн байр нь тоосго, блокон хийцтэй байна.

Цагдан хорих байруудын байршлыг судалж үзэхэд 8 аймгийн урьдчилан хорих байр газрын дор буюу байшингийн подвальд байрлалтай, 3 аймгийн урьдчилан хорих байр хагас подвальд байрлалтай, 11 аймгийн байр 1-р

давхарт байрлалтай байна. Аймгуудын урьдчилан хорих байрууд нь ямар байрлалтайгаас үл хамаарч бүгд ижил зохион байгуулалттай, бүх өрөө нь гадна орчин уруу харсан цонх салхивчүүй баригдсан.

Нийслэлийн урьдчилан хорих төв болон бүх аймгуудын хорих байрууд нь бүгд 431 өрөөтэй бөгөөд түүний дөнгөж 41 (10 хувь) өрөө нь гадна орчин уруу харсан цонхтой байна. Өрөөнүүд нь голдоо байрлалтай 2 талаараа коридортой баригдсанаас ихэвчлэн өрөөний 3 хана нь битүүмжлэгдсэн, коридор уруугаа харсан төмөр хаалгатай төмөр хаалга нь дээд хэсгээрээ гэрэл тусгах төмөр сараалжтай, дунд хэсэгттээ хяналтын шагайвартай хийгдсэн. Харин зарим аймгууд агаарын солилцоог нэмэгдүүлэх зорилгоор хаалганы доод хэсэгт нэмэлт нүх гаргасан байна. Коридор нь жижиг цонхтой боловч энэ нь агаарын солилцоо явагдах, өрөөг гэрэлтүүлэх боломжгүй.

Иймээс СЯАСЦХШБ тухай хуулийн 13-р зүйлд заасанаар хорих өрөөнүүдийг цонхтой, агааржуулах салхивчтай болгон өөрчлөн засварлах боломж түйлын хязгаарлагдмал болсон байна.

3.1.2.2. Хорих байрны багтаамж, агааржуулалт, гэрэлтүүлэг. Нийслэл болон бүх аймгийн хорих байрууд (431 өрөө нь) нь нийтдээ 4957,3 квадрат метр талбайтай болно. Үзэлгэ хийгдэх үед нийт хорих байранд 1674 хүн хоригдож байсан. Хорих байрны талбайг нийт хоригдож байгаа хүний тоонд харьцуулж үзэхэд нэг хүнд дунджаар 2,9 квадрат метр талбай оногдож байв.

Нийслэлийн цагдан хорих төвд (Ганц худагт) үзэлгэ хийх үед 798 хүн хоригдож байсан. Тус төв нь 1086 хүн хүлээн авах багтаамжтай гэсэн боловч шалгалтын явцад 8 кв.м талбайтай өрөөнд 5 хүн, 18 кв.м талбайтай өрөөнд 7-8 хүн хоригдож нэг хүнд оногдох талбай хуульд заасан хэмжээнээс бага байсан. Үүнээс үзвэл хорих байр багтаамжтай боловч хүмүүсийг нэг өрөөнд олноор нь хуульд заасан хэмжээг хэтрүүлж хорьдог байна. Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Ховд, Хөвсгөл зэрэг 12 аймгийн хорих байрны ачаалал ихдэж нэг хүнд 2.5 кв.м-ээс бага талбай оногдож байсан байна. Цагдан хоригдож байгаа хүний тоо одоогийн байгаагаас ихэсвэл хорих байрны ачаалал хэтрэх магадлалтай аймгууд ч цөөнгүй байна. Тухайлбал, Дорноговь аймгийн цагдан хорих байр үзэлгийн үед 26 хүнтэй байсан ба заасан үед 60-80 хүн хоригдож тухай дурьдсан байна. Хамгийн их хүн хоригдож байгаа аймгуудыг нэрлэвэл Орхон аймаг 103, Төв аймаг 94, Дархан-Уул 82, Дорнод 69, Хөвсгөл 58 хүнтэй байсан.

Хууль заасанаар цагдан хорих байрууд нь агааржуулах техөөремжтэй, салхивчтай байх ёстой. Хуулийн энэхүү шаардлага хорих байруудад хамгийн хангалттүй байна. Байгалийн агаар орох цонхтой, цонхондоо салхивчтай хорих байр байхгүй. Бүх хорих байруудад коридороосоо төмөр хаалгаар дамжин агаар орох нөхцөлтэйгээр баригдсан ба зарим байрны коридор нь ч огт цонхгүй, цонхтой ч гэсэн цонх нь том биш байна. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар ийм байрлалтай баригдсан байр нь агаарын солилцоо хэвийн явагдах ямар ч боломжгүй юм. Хорих байруудын коридорын цонхыг өвлийн улиралд онгойлгох боломжгүй байдаг тул үргэлж түгжээтэй байна. Иймээс одоогийн үйл ажиллагаа явуулж буй хорих байруудад агааржуулах тоног техөөремж зайлшгүй хэрэгтэй байна. Энэ талаар хуульд ч тодорхой заалт тусгагдсан. Зөвхөн Төв, Дорнод, Дархан-Уул, Өмнөговь, Ганц худгийн хорих байруудад агааржуулах тоног техөөремж байдаг боловч тэдгээр нь байгаа ажилладагүй, тодорхой цаг хугацаагаар тур ажилгүйдаг.

Нийслэлийн цагдан хорих төв (Ганц худаг)-д агааржуулах тоног төхөөремжийг сэргээн засварлаж ажилд оруулж өдерт 3 удаа 30 минутаас доошгүй хугацаагаар ажиллуулдаг байна. Гэхдээ энэ нь бүх өрөөнд агаарын солилцоо явагдах шаардлагыг бүрэн хангадаггүй. Иймээс шалгалтын явцад зарим өрөөнөөс авсан агаарт байгаа нянгийн тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс 1,5-2,1 дахин их гарсан болно.

Дорноговь аймгийн хорих байранд мэргэжлийн хяналтын шалгууллагаас хэмжилт хийж үзэхэд 1 $м^3$ агаарт байгаа нянгийн тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс 3-10 дахин их гарсан. Бусад аймгуудын хорих байруудад ч мэргэжлийн байгууллагуудаас дүгнэлт гаргаж үзэхэд 1 $м^3$ агаарт байгаа нянгийн тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс бүгд их байсан. Энэ нь агааржуулалт шаардлага хангахгүй байгаатай шууд холбоотой. Ховд аймгийн хорих байранд агааржуулалт от байхгүйгээс агаарын бүх өрөөний таазнаас усан дусал дусалж байдаг.

Үзэлгэгэр хорих байрны гэрэлтүүлгийн тухай асуудлыг анхаарч үзсэн болно. Бүх хорих өрөөнүүдийн 41 нь буюу денгөж 9,5 хувь нь байгалийн гэрэл тусах боломжтой байна. Иймээс бүх хорих өрөөний 90,5 хувьд нь өдер шөнийн 24 цагт шаардлага хангахуйц зохиомол гэрэлтүүлэг шаардлагатай юм.

Хорих өрөөнүүдийн зохиомол гэрэлтүүлгийн байдлыг судалж үзэхэд зарим нь өрөөн дотроо гэрэлтүүлэгтэй, зарим нь хаалганы дээд хэсгийн сараалжны гадна гэрэлтүүлэгтэй хоёр янз байна. Хорих өрөөн дотроо гэрэлтүүлэгтэй өрөө 80, өрөөний хаалганы дээд хэсгээр гаднаас нь гэрэл тусгасан өрөө 351 байна. Хаалганы дээд хэсгээр буюу өрөөний гаднаас гэрэл тусгасан өрөөний гэрэлтүүлэг бүгд шаардлага хангадаггүй. Эдгээр механик гэрэлтүүлгийн талаар мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулж үзэхэд гэрэлтүүлгийн хүчин чадал байвал зохих доод хэмжээнээс байнга доогуур гарсан байна. Гаднаас нь гэрэл тусгасан өрөөнүүд байнгын харанхуй бүрэнхий байдалтай. Тэгээд ч энэхүү гэрэл чийдэн нь байнга асаалттай байдаг гэдэг нь тун ч эргэлзээтэй юм. Гэрэлтүүлгийн иймэрхүү нөхцөл байдал хоригдогсдын хараа муудах, бие сульдах зэргээр хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг талаар мэргэжлийн байгууллага зөвлөж байна. Хорих өрөөнүүдийн гэрэлтүүлгийн нөхцөл байдалд дүгнэлт хийж ядахдаа өрөөний

гэрэлтүүлгийг гадна нь бүс дотор нь оруулах шаардлагатай байна.

3.1.2.3. Хорих байрны халаалт, усан хангамж, чийглэг, унтаж амрах нөхцөл, бусад хангамж. СЯАСЦХШБ тухай хуулийн 13, 24-р зүйлүүдэд "Хорих байр нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана. Хорих байр нь 18 хэмээс багагүй дулаантай байна" гэж заасан.

Хорих байрны дээрх нөхцөлд хорих байны ор, наар, хучлага дэвсгэр, дулаан, чийглэг зэрэг үзүүлэлтүүд хамаарна. Хорих байруудын 14 нь нэгдсэн халаалтын системд холбогдсон, 8 нь өөрийн бие даасан халаалттай боловч ихэнхи хорих байрууд өрөөн дотроо халаалтын төхөөрөмжгүй эвхэн коридороосоо халах боломжтой. Үзэгдэх явдлаар байдал 9 хорих байрны халуун эвдүүрэгдэх доод хэмжээнээс ихээхэн доогуур байсан нь тогтоогдсон. Тухайлбал, Завхан аймгийн хорих байр +5°, Баян-Өлгий аймгийн хорих байр +6,9° +11,2°, Өвөрхангай аймгийн хорих байр +9°+14°, Булган аймгийн хорих байр +03°+15°, Ховд аймгийн хорих байр +14°+15°, Дундговь аймгийн хорих байр +13°+15°, Увс аймгийн хорих байр +15° дулаантай гарсан байна. Цагдан хорих байр нь халаалтын хувьд хангалттүй учраас өвлийн цагт коридорын цонхыг онгойлгож салхи оруулах агааржуулах боломж байдаггүй. Иймээс хорих байранд эвгүй үнэр орох, чийгшилт ихсэх, агаарын бохирдол нэмэгдэх гол нөхцөл болдог.

Улсын хэмжээний бүх хорих байрны 431 өрөөний 375 өрөө нь модон наартай, бүгд цементэн шалтай. Зарим аймгийн хорих байруудад унтаж амрах нөхцлийг нь дээшлүүлж төмөр болон модон ороор хангах ажил хийж эхэлсэн. Бүх хорих байруудыг хүрэлцэхүйц хэмжээний көнжил гудсаар хангагдсан гэж үзэж болохоор байна.

Хорих байны чийглэг нь 55-60 хувь байх ёстой гэж хуульд заасан боловч энэ шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байна. Улсын хэмжээний хорих байны 50%-ийнх нь чийглэг нь хуульд заасан хэмжээнээс их, 23,8%-ийнх нь чийглэг хуульд заасан хэмжээнээс доогуур, 26,2%-ийнх нь чийглэг хуульд заасан хэмжээнд байна гэсэн дүн гарсан. Тухайлбал Архангай аймгийн хорих байны чийглэг зөвшөөрөгдөх хэмжээнээс 1,5-2 дахин их, Дорноговь аймгийнх 79-90%, Говь-Алтай аймгийнх 75-90%, Завханых 85%, Булганых 65-70%, Дундговийнх 65-70%, Увсынх 79%, Ховдынх 70%-тай байсан байна. Завханы хорих байрны таазнаас бороо цасны ус гоождог, Ховд аймгийн ихэнхи өрөөний таазанд усан дусал бий болсон байжээ.

Хорих өрөөн дотроо ахуйн хэрэгцээнд хэрэглэх цэвэр устай хорих байр үндсэндээ байхгүй байна. Ганц худаг, Төв аймгийн хорих байр өрөөн дотроо бие засах зориулалттын суултууртай ба үүнд зориулсан усыг тодорхой цагийн хуваариар шахдаг бөгөөд энэ нь үндны болон ахуйн журмаар хэрэглэх боломжгүй ус байна.

Хорих байрны нэг нөхцөл нь бие засах газар, ариун цэврийн өрөө, усанд орох газар байдаг. Төв аймаг болон Ганц худгийн хорих байруудын өрөөн дотроо бие засах газартай, 6 аймгийн хорих байрны бие засах газар нь гадаа байрлалтай, 14 аймгийн хорих байр дотроо нэгдсэн бие засах газартай байна. Гадаа болон нэгдсэн бие засах газартай хорих ангиудын тухайд хоригдогсод шаардлагатай үедээ бие засах газар очих боломж муутай, зарим /Булган аймаг/ үед ундааны савандг өрөөн дотроо бие засдаг тухай хоригдлууд ярьсан байна. Өрөөн дотроо бие засах нь агаар бохирдуулах, үнэр гарах нөхцөлийг бүрдүүлдэг нэг эх үүсвэр юм.

Одоогийн байдлаар 15 аймгийн хорих байр хоригдогдыг халуун усанд оруулах боломжоор хангагдсан ба бусад 7 аймагт ийм боломжгүй юм. Завхан аймгийн хорих байр халуун усанд орох боломж байтугай гар нүүрээ угаах зориулалтын өрөөгүй байна.

СЯАСЦХШБ тухай хуулинд хоригдсон эзтэгэд нь хүнсний болон нэн хэрэгцээтэй зүйлээ бэлнээр худалдан авч хэрэглэх эрхтэй, хорих байны захиргаа нь ахуйн болон эмнэлэг ариун цэврийн төлбөртэй үйлчилгээ явуулж болно гэж заасан. Энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Ганц худаг болон зарим аймгийн хорих байны захиргаа санаачилга гаргасан байна. Үзэгдийн дүнгээс үзвэл 11 хорих байр төлбөртэй үйлчилгээ явуулах боломжтой болжээ. Ганц худаг дахь цагдан хорих ангийн захиргаа хоригдогсдын болон ар гэрийнх нь хүсэлтээр хоригдогсдод нэрийн данс нээж төлбөртэй үйлчилгээ явуулж байгаа бө үзлэг явагдах үед 136 хоригдол нэрийн данс нээлгэж шаардлагатай зүйлээ худалдан авч үйлчүүлж байсан. Цаашид хүнсний болон ахуйн хэрэгцээний төлбөртэй үйлчилгээг бүх аймгийн хорих байруудад бий болгох шаардлагатай байна. Цагдан хорих байны дотоод журамд ч хүнсний бүтээгдэхүүн, ариун цэвэр ахуйн хэрэглээний зүйлс, ном хэвлэл, захидал, цахилгаан, үсчин гоо сайхны төлбөртэй үйлчилгээ явуулж болно гэж заасан байна.

Зарим аймгийн хорих байрууд зохих хэмжээний нимтэй, сонин хэвлэл захиалж өрөөгөөр дамжуулж уншуулдаг байна. Харин Дархан-Уул, Дундговь, Завхан, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгийн хорих байрууд өвөрсдийн гэсэн ном хэвлэлгүй байсан байна.

Бүх хорих байрууд өглөө цай, талх, өдөр, орой халуун хоол өгдөг гэж тайлбарлажээ. Үзлэгийн явцад хоолноор гачигдсан эцэж тураалд орсонноцтой зөрчил гараагүй. Зарим аймгуудын хорих байрны хоолонд мэргэжлийн хяналтын газар хэмжилт хийж үзэхэд хоолны илчлэг зохих түвшинд хүрээгүй, тухайлбал Завхан аймгийн хорих байрны хоолны илчлэгийг шалгаж үзэхэд 801,1 ккал гарсан байна. Ганц худгийн хорих байрны захиргаа хоригдогсдын хоолны илчлэгтээ ЭМЯ-ны харьяа НЭМХ-гээр сар тутам дүгнэлт гаргуулж баримтжуулсан ба хоолны илчлэг нь байвал зохих хэмжээнд байсан байна.

Зарим аймгийн цагдан хорих байр мэргэжлийн эмчийн орон тоогүй учир хоригдогсдод эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, байрны эрүүл ахуйн талаар хяналт тавих боломж нөхцөл хүндрэлтэй байдаг тухай санал шүүмжлэл гарч байсан байна.

3.2. Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийн төлөв байдал

3.2.1. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-ийн арвандөрөвдүгээр зүйлд "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэж заасан.

Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 7.2-д "Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хоригломо";

7.4. Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашныхь нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй;

7.5. Энэ хуулийн 7.4-т заасныг зөрчиж асуулт тавьсан тохиолдолд ажилтан түүнд хариулах үүрэгтэй гэж заасан.

Мөн хуулийн 141.1.3-д "Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, эрэгтэй, эмэгтэй, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварласан, хязгаарласан, давуу байдал тогтоосон, иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлоготой холбоогүйгээр ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, ак ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр шүүгч торгох"-оор заасан.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 4.2.4-д иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх;

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль (2002 он)-ийн 5.1.3-д "албан хаагчийг зөвхөн мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн үр чадварын үндсэн дээр нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох, ажлын үр дүнг нь бодитойгоор үнэлэх", 14.1-д "Хуульд зааснаас бусад төсвийн байгууллага, албан тушаалтанд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 14.1.8. ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халах, энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг зөрчих", 17.1.12-д "ажилтныг ажилд томилох, өөрчлөх, халах, түүнд урамшуулал олгохдоо энэ хуулийн 5.1.3-т заасан зарчмыг баримтлах" гэж заасан.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (1992 он)-ийн 10 дугаар зүйлд хороо, сум, дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэх, уг нэр дэвшигчийг дээд шатны Засаг дарга томилох журмыг заасан. Үүний дотор нэр дэвшигчийг томилохоос татгалзах тухай заалт бий боловч татгалзах үндэслэл нь тодорхой тусгагдаагүй.

3.2.2. Аж ахуйн нэгж, байгууллага, түүнийг хууль ёсоор төлөөлөх албан тушаалтнууд нь иргэнийг ажилд авахдаа ажил үүргийн онцлог шаардлагатай нь огт холбоогүй, хүний хувийн шинж төрх, байдалд тулгуурласан шалгуурууд үндэслэн Хөдөлмөрийн хууль тогтоомжоор иргэнд адил тэгш боломж болгон олгосон эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл хууль бусаар давуу байдал тогтоох зэргээр ялгаварлан гадуурхлыг бий болгох явдал цөөнгүй байна.

2003 оны 9-12-р сарын хугацаанд "Өдрийн сонин", "Өнөөдөр" сонинуудад нийтлэгдсэн "Ажилд авах тухай" зар мэдээг судалж үзэхэд, сул чөлөөтэй болон шинээр бий болсон ажлын байрандаа бусдыг авч ажиллуулах тухай ажил олгогч нар зарлахдаа иргэдийг хувийн шинж байдлаар нь илэрхий ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэгэнд нь хууль бусаар давуу эрх

ілгосон шинжтэй шаардлага тавих нь түгээмэл болсон нь харагдаж байна.

Нэгэн банкны харилцагчийн зөвлөх гэсэн зүл орон тоон дээр ажилтан шалгаруулж авах зар дээр "гадаад имидж сайн, 168 см-ээс дээш биеийн эндертэй хүнийг", мөн нэгэн банкны салбарын захирлаар "зөвхөн 38 хүртэлх насны хүнийг" авахаар (Өдрийн сонин, 2003 оны 283 дугаарт) зарласан байх жишээтэй. Иймэрхүү хандлага нь аль хэдийнээ бүх хэвлэл мэдээллээс олж болно.

3.2.3. Иргэдээс ирж буй өргөдөл, гомдол болон үзэсгэлэнгийн судалгаа, хяналт шалгалтын дүнгээс үзэхэд хөдөлмөрийн хүрээн дэх ялгаварлан гадуурхалт нь дараах байдлаар илэрч байна.

Ажилтныг улс төрийн үзэл бодол, намын харъяаллаар нь ялгаварлаж ажлаас нь халах, зөрчлээс нь олонтаа гарах болсон ба иймэ байдал УИХ болон орон нутгийн сонгуулийн дараа түгээмэл байдаг. Энэ талаар ХЭҮК-ын 2002 оны илтгэлд дурьдагдаж байсан. УИХ-ын сүүлийн хоёр сонгуулийн (1996 он ба 2000 он) дараа төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийн тоог сонгуулийн өмнөх оныудтай харьцуулахад (1995 он ба 1999 он) 2-5 дахин их байв (Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, УБ, 2002 он, 38 дугаар тал).

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр зохицуулалтын албаны дарга ажилтай байсан "Б" 2001 оны 2-р сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны удирдлагад хандаж ирүүлсэн өргөдлээ "УИХ, орон нутгийн сонгуулийн дараа нийт аймгийн хөдөлмөр зохицуулалтын албадын дарга нарын 50 хувь нь өөрчлөгдсөн. Тэдний оронд илүү хүмүүс тавигдах учиртай. Гэтэл байдал тийм биш байна. Иймд шинэ 15 хүн шүүгаараа илүү гэдэгт дүгнэлт гаргаж өгөөч" гэж хүсчээ. Түс яамны өгсөн хариу албан бичигт 6 хүний хувьд ажлаас өөрчилсөн шалтгааныг дурьдаад, бусад 9 хүний хувьд ямар нэг тайлбар хийгээгүй байв. Иймэрхүү тодорхойгүй өөрчлөлт, халалт нь цаанаа ямар нэг ялгаварлалыг агуулж байгаг нь нийтэд нэгэнт ойлгомжтой болсон билээ. Улс төрийн үзэл бодол, намын харъяаллаар ялгаварлах явдалд аль нэг намын гишүүн, намын дэмжигчдээс гадна намын гишүүн бус иргэд ихээхэн өртөгдөс хандлага ажиглагдаж байна. 2000 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулиас хойшхи хугацаанд яам, агентлаг, төр, захиргааны бусад байгууллагад ажиллаж байгаад халагдаж чөлөөлөгдсөн 3638 хүний 94.1 хувь (3422) нь нам бүсчууд байжээ. Тэгвэл аймаг, нийслэлийн төр, захиргааны байгууллагад ажиллаж байгаад халагдаж чөлөөлөгдсөн 3595 хүний 68 хувь нь (2515) нам бүсчууд байна (Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийн судалгааны тайлангаас 2003 он).

Иймхүү нам бүсчуудыг халж чөлөөлснөөр бий болсон сул чөлөөтэй орон тоон дээр улс төрийн үзэл бодол нэгт нөхдөө авч ажиллуулж буй нь ялгаварлан гадуурхаж, нөгөө хэсэгт нь хууль бусаар давуу эрх олгох бололцоо бий болдог. Энэ бололцоо нь өөр бусад намынхныг халж чөлөөллөө гэсэн шүүмжлэлээс зайлсхийхэд нь бас тус дөхөм болдог талтай.

Удирдах албан тушаал эрхэлж байгаа хүмүүс түүн дотроо улс төрийн албан тушаалтны дунд нэг намын нөхдөө дэмжиж ажилд оруулах, албан тушаал ахиулах явдал багагүй гарч байгаа нь мөн л ялгаварлал гадуурхлын илрэл яах аргагүй мөн. ХНХЯ-ны сайдад 2001 оны 1 дүгээр сарын 10 ба 17-нд УИХ-ын нэр бүхий хоёр гишүүнээс ирүүлсэн албан бичигт "иргэн "Б" нь манай намын ... дугаар үүрийн товчооны гишүүн бөгөөд УИХ-д сонгогдох ажилд минь идэвхитэй оролцон тул яамандаа ажилд ороход нь туслах"-ыг хүсч бичжээ.

Намын гишүүний харъяаллаар нь төрийн албанд ажиллах эрхийг нь шууд хязгаарласан тохиолдол ч гарч байна. Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргад нэр нь зохих жүрмаар дэвшин олонхийн санал авсан "Г", түүний дараа нэр нь дэвшсэн "Ц" нарыг аймгийн Засаг дарга нь "өөр намын" гээд батламжлахаас татгалзсан, Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргад нэр нь дэвшсэн "Г"-г "өөр намын гишүүн" гэсэн үндэслэлээр батламжлахгүй гэж Хэнтий аймгийн Засаг дарга татгалзаж байв.

3.2.4. Хөдөлмөр эрхлэлтэнд ялгаварлан гадуурхаж байгаа бас нэг зонхилох илрэл бол үндэслэлгүйгээр насны хязгаар тавих явдал юм. Ажилд шалгуулан авах зарлалд насны хязгаар тавьж, албан байгууллага, компанийд эмэгтэйчүүдийн хувьд 40-өөд насны эмэгтэйчүүд, 50-иад насны эрэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байв.

Шивээ-Овоогийн нүүрний уурхай дотоод журмын 5.2-д "Сонгон шалгаруулалтад дараах шалгуурыг үндэслэнэ" гээд 5.4. 5.5-д: "Үнэнч шударга, ажилчид 18-35 настай, инженер техникийн ажилтан 45 хүртэл настай ..." гэж заасныг хүнийг насаар ялгаварлан гадуурхаж буй нэг хэлбэр гэж үзэх үндэстэй байна.

3.2.5. Ижил хөдөлмөрт адил цалин хөлс өгөх зарчмыг зөрчих нь хөдөлмөр эрхлэлт дэх ялгаварлалын нэг нөхтой илрэл юм. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийд дээр яг адилхан ажил хийж буй монгол ажилчин болон гадаадын ажилтанд ихээхэн зөрүүтэй хөлс олгож байгаа тухай зарим өргөдөл гомдлыг шалгахад үндэслэлтэй байв. ОХУ-ын хөрөнгө оруулалттай алт олборлодог нэгэн компанийг монгол болон орос гагнуурчны цалингийн зөрүү 145 ам. доллар, машины жолоочийн цалингийн зөрүү 155 ам. доллар болж байлаа (Үүл уурхайн салбарт хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчмууд болон Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан эрхийн хэрэгжилтийн төлөв байдалд хийсэн шалгалт, судалгааны тайлангаас, 2003 он).

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Илтгэлтэй холбогдуулан дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. УИХ "Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль"-ийг 1994 онд батласнаас хойш арван жилийн хугацаа өнгөрөхөд зөвхөн торгуулийн хэмжээг нэмэх төдий өөрчлөлтийг (1995 онд) хийснийг эс тооцвол ямар ч өөрчлөлт ороогүй байна. Гэтэл иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн нэг илрэл нь болсон тайван жагсаал цуглаан хийх шаардлага хэрэгцээ есөн нэмэгдэж, үүнтэй холбоотойгоор эрх зүйн шинэ зохицуулалтыг шаардсан олон асуудлууд урган гарч, энэ хууль нь нийгмийн харилцаа, хэрэгцээнээс хоцорчээ. Иймд уг хуулийг шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. Одоогийн хуулийн олон зүйл, заалтыг эргэн авч үзэх шаардлагатай байгаагийн зэрэгцээ, "цуглаан"-гэдэг ойлголтыг хэт өргөн хүрээтэй тодорхойлсноос болж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх бусад арга хэрэгслийг (өлсгөлөн, суулт, ажил хаялт гэх мэт) хамруулахад хүргэж байна. Түүнчлэн жагсаал, цуглааныг зохион байгуулахад олгож буй зөвшөөрлийн систем, хугацаа, зөвшөөрөл олгох эрх бүхий субьект, уг хуульд хамрагдахгүйгээр зохион байгуулагддаг жагсаал, цуглааныг үргэлжлүүлэх эрэн авч үзэх шаардлагатай байна.

Хоёр. Орчны бохирдол, байгалийн тэнцлийн алдагдал нь нийтийн эрхийг хурцаар хөндөж байна.

- Юуны өмнө байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг зөрчигчидтэй хийх тэмцлийг чангатгаж, үйл ажиллагаа нь орчин тойрондоо хортой, аюултай нөлөөлөлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгсдэд тавих технологи, горим, цэвэрлэгээний хяналт шалгалтыг тогтмолжуулж, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх;
- Орчны бохирдлын түвшинд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах, байгалийн баялгийг ашиглах зөвшөөрлийн явцыг нээлттэй, олон нийтийн хяналтын доор хийх механизмыг бий болгох;
- Нийслэл хот болон томоохон хотууд дахь агаар, орчны бохирдолтын мэдээг олон нийтэд зориулан тогтмол өгч байх;
- Орчны бохирдлыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн гамшигтай тэмцэх эрх зүйн орчныг эдийн засгийн, нийгмийн болон бусад хөшүүрэг, урамшууллын механизмтай уялдуулан боловсронгуй болгох;
- Хот суурин газарт өвлийн улиралд цас, мөс цэвэрлэх ажиллах хүч, техник хангамжийг нэмэгдүүлэх, замын эвдрэл гэмтэл, хальтиргаа гулгаанаас болж осол аваарт өртөх, гэмтэж бэртэхэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох;
- Дэвшилтэт техник, цэвэр технологийг орчны бохирдол ихэвч үүсгэдэг дэд бүтцийн салбаруудад нэвтрүүлэх.

Гурав. Бүсдын хууль бус үйлдлийн улмаас амь нас, бие эрхтэнээрээ хохирох, сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол учрахад нөхөн төлүүлэх, үнэлүүлэх боломж, нөхцөл, шалгуурыг хууль тогтоомжид тусгаж өгөх.

Дөрөв. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх:

- Уул уурхайн нийт албан салбаруудад Хөдөлмөрийн хууль тогтоомжийн заалт болон ОУХБ-ын холбогдох конвенцийн хэрэгжилтийн байдалд улсын хэмжээнд үзэлг явуулж арга хэмжээ авах;
- Уул уурхайн салбарт ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулахын зэрэгцээ улирлын чанартай үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн ажилтны ажиллагаүй хугацааны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хураамжийг цалин хөлсний доод хэмжээгээр тооцож ажил олгогч төлж байх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн 46.3-д заасныг ашигт малтмал олборлох үйлдвэр, уурхайд чанд мөрдүүлэх арга хэмжээ авах, хувиараа гар аргаар ашигт малтмал олборлогсдыг нийгмийн даатгалд

хамруулах оновчтой хэлбэрийг сонгож хэрэгжүүлэх;

Хөдөлмөрийн тухай хуулийг цаашид боловсронгуй болгож, зарим нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тухайлбал,

- Хөдөлмөрийн харилцааны насаар ялгаварлах хандлага байсаар байгаа учир Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд "энэ хууль болон холбогдох хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хүнийг насаар ялгаварлахыг хориглоно" гэсэн хэсэг нэмж оруулах. Үндэс угсаатаар ялгаварлан цалин хөлсийг ялгаатай өгч байгаат зогсоох зорилгоор Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7.2-т заасныг баталгаажуулахын тулд мөн хуулийн 49.2-т "... эрэгтэй, эмэгтэй ажилтанд ..." гэсний дараа "болон үндэс, угсаатаар ялгаварлахгүйгээр ..." гэсэн үгс нэмж оруулан найруулах. Тэрчлэн дээрх хуулийн 7 дугаар зүйлийн заалтыг баталгаажуулах зорилгоор мөн хуулийн 128 дугаар зүйлд "энэ хуулийн 7 дугаар зүйлд заасныг зөрчсөнтэй холбоотой маргаан" гэсэн хэсэг нэмэх.
- Хамтын гэрээ, хэлэлцээрийг ажил олгогч заавал байгуулах шаардлагагүй гэж үздэгээс хамтын гэрээтэй холбоотой зөрчил түгээмэл байгааг анхаарч Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д "... аж ахуйн нэгж, байгууллагын бизнес төлөвлөгөө батлахаас өмнө ..." гэсний дараа "заавал" гэсэн үг нэмэх нь зүйтэй гэж үзэж байна.

ОУХБ-ын конвенци, Хөдөлмөрийн тухай хуулийг олон нийтэд, алангуяа аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтнуудад ойлгуулж, таниулах, сургалт, семинар зохион байгуулж, удирдах ажилтнуудын энэ талын мэдлэгийг дээшлүүлэх;

Тав. Цаатан иргэдийн аж амьдрал, эрхийн байдлыг дээшлүүлэх талаар цаашдаа дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

- Малжуулах, ядуурлыг бууруулах төсөлд цаатангуудыг хамруулж, аж төрөх байнгын орлогын эх үүсвэртэй болгох;
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын дунд сургуулийн цаатан сурагчдад төрөлх хэлийг нь заах;
- Цаатан залуучууд дээд боловсрол эзэмшихийг дэмжих тусгай хөтөлбөр боловсруулах (сургалтын төлбөр, дотуур байрны зардал, бичиг хэрэг, хоолны хангамж гэх мэт);
- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.2.3-д зааснаар цаа бугын удмын санг хамгаалах, эрүүлжүүлэх, тоо толгойг өсгөх ажлыг зохион байгуулах.

Зургаа. Эмзэг бүлгийн нийгмийн хамгааллыг дээшлүүлэхэд дараах зүйлд анхаарлаа хандуулах шаардлагатай юм.

- Ядуурал нь ажилгүйдэлтэй шууд холбоотой байгаа учраас Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж "ядуучуудын хөдөлмөр эрхлэлт" гэсэн сан байгуулах;
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлын тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ажилгүйдлын даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлогыг дэмжихэд болон ажилгүйчүүд, ажилгүйдэлд өртөж болзошгүй ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд зарцуулдаг болгох.

Долоо. Хуулийн байгууллагын үйл ажиллагааны тухайд

- Урьдчилан хорих бүх байруудад аттестатчлал явуулж, хуулийн шаардлага, стандарт хангаагүй байруудыг засварлах, боломжгүй хэсгийг нь хаах хүртэл арга хэмжээ авах;
- Сэжигтэн, яллагдагчийг орон нутгаас нь өөр газарт шилжүүлэн хорьдог хууль бус арга ажиллагааг таслан зогсоох эдгээр санал зөвлөмжийг гаргав.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ

АМХЭГ	Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газар
АУА	Алтны уурхайн ажиллагсад
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОТБ	Байгаль орчны төлөв байдал
БОШТЛ	Байгаль орчны шинжилгээний төв лаборатори
БОЯ	Байгаль Орчны Яам
БСГ	Боловсрол, соёлын газар
ГААО	Гар аргаар алт олборлогчид
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МЗХ	Монголын Залуучуудын Холбоо
МоАХ	Монголын Ардчилсан Холбоо
МҮЭ	Монголын Үйлдвэрчний Эвлэлүүд
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
НЭМХ	Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэн
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
СЯАСЦХШБТХ	Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УМХГ	Улсын Мэргэжлийн Хяналтын газар
УДШ	Улсын Дээд Шүүх
УҮГ	Улсын үйлдвэрийн газар

ҮЭ	Үйлдвэрчний Эвлэл
ХА	Хүлцэх агууламж
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХЗБХ	Хууль Зүйн Байгууллын Хороо
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШТС	Шатахуун түгээх станц
ШШБЕГ	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хаяг: "**Төрийн Мэдээлэл**" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 3296 i2

☎ 329487

Индекс 14003

Хэвлэлийн хуудас 6